



Ирээд Намайг дага

Аароны санваар 2017

Өсвөр үеийнхэнд зориулсан суралцах материал

ХӨРВӨЛТИЙН төлөө ЗААХ ба СУРАЛЦАХ

Аароны санваар 2017

© 2016 он Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Англи эхийн зөвшөөрөл: 5/16

Орчуулгын эрх: 5/16

Come, Follow Me: Learning Resources for Youth, Aaronic Priesthood 2017-ын орчуулга

Mongolian

13569 363

Энэ гарын авлагын тухай

Энэхүү гарын авлага дахь хичээлүүд нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сургаалын үндсэн зарчмуудыг тайлбарласан бүлгүүдээс бүрддэг. Хичээл бүр нь өсвөр үеийнхний асуултууд дээр болон хариултуудаа олоход нь тэдэнд туслах сургаалын зарчмууд дээр голлон төвлөрсөн юм. Хичээлүүд нь сургаалаас та өөрөө суралцсанаар сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлдээд улмаар залуу эрэгтэйчүүдэд идэвхтэй сурах нөхцөлийг бүрдүүлж өгөх арга замуудыг төлөвлөхөд тань туслахаар зохион байгуулагдсан болно.

Сурах тоймууд

Жагсаасан гарчгууд дахь сургаалын сэдэв бүрд нэг сарын дотор зааж багтаааргүй олон сурах тоймууд бий. Энэ бүлэгт ямар зүйлийг онцлон анхаарч, аль сэдэвт хэчнээн цаг зориулахыг шийдэхдээ залуу эрэгтэйчүүдийн асуултууд ба сонирхдог зүйлст тулгуурлахын хамт Ариун Сүнсний удирдамжийг дагаарай.

Эдгээр тойм нь таны хэлэх үгс болон хийх зүйлийг нэг бүрчлэн заахгүй. Эдгээр хөтөлбөр нь сургалыг эхлээд өөрөө сурахад мөн зааж байгаа залуу эрэгтэйчүүдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн заахаар бэлтгэхэд тань туслахаар зориулагдсан юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлд

Залуу эрэгтэйчүүдэд эдгээр сурах тоймд байгаа зарчмуудыг ойлгоход нь туслахын тулд та өөрөө эдгээр зарчмыг ойлгож, үүний дагуу амьдардаг байх ёстой. Тоймд дурдсан судруудыг болон бусад тарааж өгөх материалуудыг судалж, залуу эрэгтэйчүүдэд ач холбогдолтой эсвэл сүнслэгээр нөлөөлөх хэлсэн үгс, түүх, жишээнүүдийг хайж олоорой. Тэгээд сурах тоймыг ашиглан, залуу эрэгтэйчүүдэд эдгээр үнэнийг олж нээх, тэдгээрийн тухай гэрчлэлтэй болох, сурсан зүйлийнхээ дагуу амьдрахад нь туслах арга замуудыг төлөвлөөрэй.

Хамтдаа зөвлөлд

Залуу эрэгтэйчүүдийн талаар чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, бусад удирдагч, багш нартай зөвлөлд. Тэд бусад газруудад—гэртээ, семинар болон Ням гарагийн ангидаа юу сурч байна вэ? Энэ нь заах бэлтгэлд тань хэрхэн нөлөөлөх вэ? (Хэрэв ярилцлагын үеэр эмзэг сэдэв хөндөгдсөн бол нууцыг хадгална уу.)

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаар үзэж болно

Та эдгээр хичээлүүдтэй холбогдох нэмэлт материалуудыг болон заах санаануудыг lds.org/youth/learn интернэт хаягаар орж, үзэж болно. Интернэт дэх хичээлүүд нь дараах зүйлсийг агуулдаг:

- Амьд бошиглогч, төлөөлөгчдийн болон сүмийн бусад удирдагчдын хамгийн сүүлд заасан зүйлсийг тавьсан интернэт хаягууд. Эдгээр интернэт хаяг нь үргэлж шинэчлэгдэж байдаг тул та байнга орж, үзэж байгаарай.
- Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлдэх болон өсвөр үеийнхэнд заахад ашиглаж болох видео бичлэг, зураг болон мөн мэдээллийн бусад хэвлэмэл зүйлсийг олж үзэж болох интернэт хаягууд.
- Өсвөр үеийнхэнд хөрвөгдөхөд нь туслах ур чадварыг тань дээшлүүлэхэд зориулагдсан үр нөлөөтэй сургаалын загварыг харуулсан видео бичлэгүүд.

Гарчиг

1 Нэгдүгээр сар: Бурхан Тэргүүтэн

- 3 Би Тэнгэрлэг Эцэгээ хэрхэн мэдэж авах вэ?
- 8 Бид Бурхан Тэргүүтэний мөн чанарын тухай юу мэддэг вэ?
- 13 Есүс Христ яагаад миний амьдралд чухал байр суурь эзэлдэг вэ?
- 18 Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?
- 22 Би хэн бэ? Би хэн болж чадах вэ?

27 Хоёрдугаар сар: Авралын төлөвлөгөө

- 29 Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлэхэд миний үүрэг хариуцлага юу вэ?
- 32 Авралын төлөвлөгөө гэж юу вэ?
- 36 Мөнх бус байдлын өмнөх амьдралд юу тохиолдсон бэ?
- 40 Амьдралын зорилго юу вэ?
- 44 Яагаад хийж буй сонголтууд маань чухал вэ?
- 48 Яагаад бидэнд саад бэрхшээл тулгардаг вэ?
- 52 Ойр дотны маань хэн нэгэн нас барахад би тайвшралыг хэрхэн олох вэ?
- 56 Би яагаад бие махбодоо Ариун сүм шиг байлгах хэрэгтэй вэ?

61 Гуравдугаар сар: Есүс Христийн Цагаатгал

- 63 Би Аврагчийн Цагаатгалаар ирдэг адислалуудыг хүлээн авахад нь бусдад хэрхэн туслах вэ?
- 67 Есүс Христийн Цагаатгал гэж юу вэ?
- 70 Есүс Христэд итгэх гэдэг нь юу гэсэн үг вэ?
- 75 Наманчлах гэж юуг хэлдэг вэ?
- 79 Ач ивээл гэж юу вэ?
- 83 Би яагаад бусдыг уучлах хэрэгтэй вэ?
- 86 Амилалт гэж юу вэ?
- 89 Сорилт бэрхшээл тулгарсан үед Аврагч надад хэрхэн тусалж чадах вэ?

93 Дөрөвдүгээр сар: Урвалт ба сэргээлт

- 95 Би Христэд ирэхэд бүхнийг хэрхэн урьж чадах вэ?
- 99 Сэргээлт яагаад шаардлагатай байсан бэ?
- 104 Санваар хэрхэн сэргээгдсэн бэ?
- 108 Сэргээлтэд Иосеф Смит ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
- 112 Анхны үзэгдэл яагаад чухал вэ?
- 115 Яагаад бидэнд Мормоны Ном хэрэгтэй вэ?

119 Тавдугаар сар: Бошиглогчид ба илчлэлт

- 121 Судруудыг судлах нь яагаад чухал байдаг вэ?
- 125 Амьд бошиглогчдыг сонсон, дагах нь яагаад чухал байдаг вэ?
- 129 Би хэрхэн хувийн илчлэлтээ хүлээн авах вэ?
- 133 Би залбирлаа хэрхэн илүү утга учиртай болгох вэ?
- 137 Би гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?
- 141 Ерөнхийлөгч Монсон Аароны санваартнуудад юу заасан бэ?
- 145 Патриархын адислал надад хэрхэн тусалж болох вэ?

151 Зургаадугаар сар: Санваар ба санваарын түлхүүрүүд

- 153 Зохистой байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ?
- 159 Санваар гэж юу вэ?
- 163 Санваарын түлхүүрүүд гэж юу вэ?
- 168 Аароны санваартан миний үүргүүд юу вэ?
- 171 Би яагаад номлолд үйлчлэх ёстой вэ?
- 176 Сүмийн удирдагчдаа дэмжинэ гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

181 Долоодугаар сар: Ёслолууд ба гэрээнүүд

- 183 Би бусдыг ариун ёслолын утга учиртай туршлагатай болоход нь хэрхэн тусалж чадах вэ?
- 186 Миний амьдралд ёслолууд яагаад чухал вэ?
- 191 Миний амьдралд гэрээнүүд яагаад чухал вэ?
- 195 Би баптисм хүртэхдээ ямар гэрээ хийсэн бэ?

- 200 Би Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээн авдаг вэ?
- 204 Ариун сүмийн ёслолууд яагаад чухал вэ?
- 208 Санваарын тангараг ба гэрээ гэж юу вэ?
- 212 Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь ямар утга учиртай вэ?

217 Наймдугаар сар: Гэрлэлт ба гэр бүл

- 219 Би гэр бүлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?
- 224 Ариун явдал яагаад чухал вэ?
- 229 Ариун сүмд гэрлэх нь яагаад чухал вэ?
- 233 Гэр бүл яагаад чухал вэ?
- 237 Болзох талаарх Сүмийн жишгийг дагах нь яагаад чухал вэ?
- 240 Зөв шударга нөхөр, эцэг хүн болохын тулд одооноос би өөрийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?
- 245 Гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргүүд нь хэрхэн харилцан бие биенээ нөхөн гүйцээдэг вэ?

251 Есдүгээр сар: Зарлигууд

- 253 Би хэрхэн энэ дэлхий дээр дэлхийнхнээс өөрөөр амьдрах вэ?
- 258 Миний хэлж ярьж байгаа зүйлс надад болон эргэн тойронд минь байгаа хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?
- 263 Би порнографыг хэрхэн эсэргүүцэж чадах вэ?
- 269 Бид яагаад мацаг барьдаг вэ?
- 272 Бидэнд яагаад хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгал хэмээн тушаасан бэ?
- 278 Бид яагаад аравны нэгийг төлдөг вэ?
- 283 Шударга байх нь яагаад чухал вэ?

287 Аравдугаар сар: Христтэй илүү адил болох нь

- 289 Би бусдад хэрхэн үйлчлэх вэ?
- 292 Би хэрхэн Христтэй илүү адил болох вэ?
- 297 Би хэрхэн Христийнхтэй адил хайрыг хөгжүүлж чадах вэ?
- 302 Би хэрхэн илүү тэвчээртэй байж сурах вэ?
- 307 Талархалтай байх нь яагаад чухал вэ?

313 Арваннэгдүгээр сар: Сүнслэг ба материаллаг байдлын хувьд бие даах нь

- 315 Боловсрол эзэмшиж, ур чадвараа хөгжүүлэх нь надад яагаад чухал вэ?
- 319 Бие даасан байдалтай байна гэдэг нь юу гэсэн үг вэ?
- 324 Би хөрвөгдөж байгаа эсэхээ хэрхэн мэдэх вэ?
- 328 Ажиллаж хөдөлмөрлөх нь яагаад сайн мэдээний чухал зарчим болдог вэ?
- 332 Их Эзэн яагаад намайг эрүүл байгаасай хэмээн хүсдэг вэ?
- 337 Ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг хангах Их Эзэний арга зам юу вэ?
- 343 Би тулгарсан бэрхшээл, асуудлуудаа шийдэх арга замыг хэрхэн олох вэ?

347 Арванхоёрдугаар сар: Хожмын өдрүүдэд Бурханы хаант улсыг байгуулах нь

- 349 Би одоо хэрхэн номлогч байж чадах вэ?
- 352 Би хэрхэн илүү сайн гэрийн багш болох вэ?
- 355 Тэнгэрлэг Эцэг намайг сүнслэг бэлгүүдээ хэрхэн ашиглаасай гэж хүсдэг вэ?
- 359 Би Христэд төвлөрсөн гэр оронтой болохын тулд хэрхэн бэлтгэх вэ?
- 363 Би Сүмийн шинэ гишүүдэд туслахын тулд юу хийж чадах вэ?
- 367 Би идэвх султай найзуудаа Сүмдээ эргэн ирэхэд нь хэрхэн туслах вэ?
- 371 Сион гэж юу вэ?
- 374 Би Их Эзэний ажлыг яаравчлуулахад хэрхэн оролцож чадах вэ?

379 ХАВСРАЛТ

Чуулгын цуглааны хөтөлбөр

Цуглааныг тэргүүлэгч _____ Огноо _____

Цуглааныг хөтөлгөч (чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн) _____

Цуглаанд оролцох

чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн

Ажил хэрэг (Үйл ажиллагаа, үйл явдлууд, ажил үүрэг хуваарилалт)

Хүмүүст ажил үүргийг нь заах (Санваарын үүргүүдээ хэрхэн гүйцэтгэх талаар хамтдаа зөвлөлдөх болон тайлбарлах)

Хуваалцахыг урих (Чуулгын гишүүд ямар туршлагатай вэ? Сайн мэдээний ямар зарчмуудыг тэд ажиглаж, сурч байна вэ? Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа тэд юу сурч байна вэ? Бусдад зааснаараа тэд ямар туршлага хуримтлуулж байна вэ?)

Хамтдаа суралц

Чуулгын зөвлөгч эсвэл чуулгын гишүүн

Энэ долоо хоногийн сайн мэдээний ярилцлага: _____

Багш: _____

Тодорхой ажил хийхийг амла

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн

- Юу сурсан талаараа гэрчлэлээ хуваалц.
- Чуулгын гишүүдийг хамтдаа суралцсан зарчмуудынхаа дагуу амьдрахад мөн дараагийн долоо хоногийн цуглаандаа бэлдэж ирэхэд урь.

Сүнсний удирдамжийн дагуу:

- Ярилцсан зарчмуудын талаар санал бодлоо хуваалц.
- Сурсан зүйл дээрээ үндэслэн өөрөө юу хийхээр төлөвлөж байгаа тухайгаа хуваалцаад чуулгын гишүүдийг мөн энэ талаар хуваалцуул.
- Чуулгын гишүүдийг дараагийн долоо хоногийн ярилцлагад бэлдэхэд урь.

Хаалтын залбирал: _____

Нэгдүгээр сар: Бурхан Тэргүүтэн

*“Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд бид итгэдэг”
(Итгэлийн Тунхаг 1:1).*

Энэ бүлгийн тоймууд нь залуу эрэгтэйчүүдэд Бурхан Тэргүүтэний гишүүдийн мөн чанарыг ойлгоход мөн Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Тэдний нэг бүрийн үүргийн тухай ойлгоход нь туслах болно. Энэхүү мэдлэг нь тэдэнд Бурханы хөвгүүдийн хувьд өөрсдийн тэнгэрлэг мөн чанар ба зорилгоо илүү сайн ойлгоход нь тусална.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг Ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын дараах тоймыг та энэ бүлэгт оруулан, зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би Тэнгэрлэг Эцэгээ хэрхэн мэдэж авах вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Бид Бурхан Тэргүүтэний мөн чанарын тухай юу мэддэг вэ?

Есүс Христ яагаад миний амьдралд чухал байр суурь эзэлдэг вэ?

Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?

Би хэн бэ? Би хэн болж чадах вэ?

Багшид зориулсан зөвлөмж

Энэхүү цуврал хичээлийн туршид та Бурханы нэрс нь ариун нандин гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануулж болно (С ба Г 63:61-ийг үзнэ үү). Эдгээр нэрийг хүндэтгэл бишрэлтэй хэрэглэхэд тэднийг урамшуулан дэмж.

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Залбирч, судруудыг судал,” 14–15, 38–39, 62–63-р
хуудас

“Сургаальг ойлго,” 18–20, 42–44, 66–68-р хуудас



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

БУРХАНЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ НЬ

Би Тэнгэрлэг Эцэгээ хэрхэн мэдэж авах вэ?

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд биднийг Өөртэйгөө ойр байгаасай гэж хүсдэг. Тэр бидэнд Өөрт нь хандан залбирах боломжийг өгсөн бөгөөд бидний залбирлыг сонсож, мөн хариулах болно хэмээн амласан. Судруудаас, хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралцсанаар мөн Түүний хүслийг дагаснаар, Түүнтэй илүү адил болохыг хичээх явцдаа бид Түүний тухай мэдэж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Тэнгэрлэг Эцэгийг хэрхэн мэдэж болохыг судруудаас мөн бусад материалуудаас суралцах зуураа, Тэнгэр дэх Эцэг тэдэнд хайртай мөн Өөрт нь тэднийг ойр байгаасай гэж хүсдэг гэдгийг мэдрэхэд нь залуу эрэгтэйчүүдэд тусалж болох зүйлсийг эрж хайгаарай.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ ямар харьцаа холбоотой байдгаа бодоорой. Түүнтэй хэдийд илүү ойр дотно байх мэт санагдсан бэ? Та юу хийж байхдаа Түүнтэй илүү ойр байгаагаа мэдэрсэн бэ?

Бурхантай илүү ойр байхын тулд залуу эрэгтэйчүүд ямар зүйлсийг хийж болох вэ? Тэд эдгээр зүйлсийг хэр сайн хийж байна вэ? Бурханд итгэх итгэлээ мөн гэрчлэлээ нэмэгдүүлэхэд нь тэдэнд та хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Иохан 17:3 (Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн)

1 Иохан 2:3–5 (Хэрвээ бид Бурханы тушаалуудыг сахивал Түүнийг мэдэх болно)

1 Иохан 4:7–8 (Бусдыг хайрлах нь Бурханыг мэдэхэд бидэнд тусална)

2 Нифай 32:9; Инос 1–7; Алма 34:17–28; 37:37 (Залбирал нь биднийг Тэнгэрлэг Эцэгт илүү ойр дотно болоход тусалж чадна)

Мозая 4:9–12 (Хаан Бенжамин, Бурханы талаарх мэдлэгээ хэрхэн өсгөхийг тайлбарласан байдаг)

Мозая 5:13 (Бурханд үйлчлэх нь, Түүнийг илүү сайн мэдэхэд бидэнд тусалдаг)

Алма 30:44 (Бүх зүйл Бурхан оршдогийг нотолдог)

С ба Г 88:63 (Бид Бурхан руу ойртох тусам, Тэр бидэнтэй ойр байх болно)

М.Рассэл Баллард “Эцэг мөн Хөвгүүд: Гайхалтай харилцаа,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2009 оны 11 сар, 47–50

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 14–15, 38–39, 62–63

Видео бичлэгүүд: “Тэр намайг мэддэг”, “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг нэг өгүүлбэр болгон дүгнэн хэлэхийн тулд залуу хөвгүүн бүрээс нэг үг хэлэхийг хүс. Тэдний өгүүлбэрийг самбар дээр бич.
- Бишопын зөвшөөрөлтэйгөөр, чуулганы гишүүдийн нэгнийх нь аавыг, эцэг хүн байх тухай хуваалцахыг урь. Аав нь хүүгийнхээ талаар юу боддогоо мөн хүү нь амьдралдаа юунд хүрээсэй гэж хүсдэгээ мөн түүнд амжилтанд хүрэхэд нь хэрхэн туслахыг хүсч байдаг талаараа ярьж болох юм. Энэ аавын хэлсэн зүйлийг Тэнгэр дэх Эцэг тэдний талаар ямар бодолтой байдагтай харьцуулахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

Заахад туслах арга

Үргэлж залбирч мөн судраас тогтмол суралцахыг залуу эрэгтэйчүүдэд урамшуулах нь Тэнгэрлэг Эцэгтэй харьцах холбоогоо бэхжүүлэхэд нь тэдэнд туслах хамгийн үр дүнтэй арга байж болох юм.

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго бол залуу эрэгтэй бүрд хувийн залбирал болон судраас суралцахыг нь хэвшил болгоход туслах явдал юм. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө бичих цагийг чуулгын цуглааны үеэр залуу хөвгүүдэд гаргаж өгөөрэй. Өөрсдийн төлөвлөгөөг нэг нэгэнтэйгээ, хойшид чуулгын цуглаанууд дээр хуваалцахад нь дэмж мөн хувийн залбирал болон судраас суралцах нь тэдний Бурхантай харьцах холбоог хэрхэн хүчирхэгжүүлж байгаа талаар хуваалцахыг хүс.

- Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын төлөвлөгөөний дагуу, залуу эрэгтэйчүүд хувийн судраас суралцах цагийг төлөвлөчихсөн байж болох юм. Энэ хичээл нь залуу эрэгтэйчүүдийн хувьд төлөвлөгөөнийхөө дагуу юу хийж байгааг мөн судраас

суралцсаны үр дүнд юу сурч байгаа талаараа хуваалцах зохистой цаг байж болох юм (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* 14–15, 38–39, 62–63-р хуудсыг үзнэ үү). Хэрэгцээтэй бол тэд төлөвлөгөөгөө өөрчилж болно. Тэдний залбирах мөн судраас суралцах хэвшил нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ харьцах тэдний харьцааг хэрхэн дээшлүүлсэн талаар хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Сайн мэдэх хэн нэгнийхээ талаар бодохыг залуу эрэгтэйчүүдээс урь. Тэр хүнийг сайн таньж мэдэхийн тулд тэд юу хийсэн бэ? Тэнгэрлэг Эцэгийг мэдэх нь Түүний *тухай* сайн мэдэж авахаас ямар ялгаатай вэ? гэж тэднээс асуу. Дараах судруудын эшлэлүүдийг самбар дээр бичээд залуу эрэгтэйчүүдээс уг судруудыг уншаад, Тэнгэрлэг Эцэгийгээ хэрхэн илүү сайн мэдэж авах арга замыг олж тодорхойлохыг хүс. Иохан 2:3–5; 4:7–8; Мозая 4:9–12; 5:13; Алма 30:44. Залуу эрэгтэйчүүдээс юу сурснаа мөн эдгээр судруудын зөвлөмжийг дагаснаар Тэнгэрлэг Эцэгт хэрхэн ойртсон тухайгаа хуваалцахыг хүс.

- “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” видео бичлэгийг үзүүлэн, үүнд харуулсан туршлагууд нь Тэнгэрлэг Эцэгийг илүү сайн мэдэж авахад залуу эрэгтэйчүүдэд болон бусад хүмүүст хэрхэн тусалж байгааг анхаараарай гэж хэл. Бурханы өмнө хүлээсэн үүргээ

биелүүлэх нь тэдний Түүнтэй харьцах харилцааг хэрхэн бэхжүүлдэг талаар залуу эрэгтэйчүүдийн санаа бодлыг асууж ярилц.

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч М.Рассэл Баллардын “Эцэг мөн Хөвгүүд: Гайхалтай харилцаа” яриандаа өгсөн гурван саналыг уншихыг урь (эсвэл “Эцэг мөн Хөвгүүд” видео бичлэгийг үзүүл). Эдгээр зүйлсээс хийснээр эцэгтэйгээ илүү ойр дотно болсон үе байгаа юу? Ахлагч Баллардын зөвлөгөөг Тэнгэрлэг Эцэгтэйгээ харьцах харьцаандаа хэрэгжүүлж болох арга замуудын талаар хуваалцахыг тэднээс хүс.

- Өнөө үеийн залуу эрэгтэйчүүдийн бусадтай харилцдаг арга замуудын талаар ярилц. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хэрхэн харилцдаг вэ? Тэр бидэнтэй хэрхэн харилцдаг вэ? Бид Түүнтэй харьцах харилцаагаа сайжруулахын тулд юу хийж болох вэ? Залбирлын талаар бичигдсэн дараах судруудыг уншихыг залуу эрэгтэйчүүдээс хүс: 2 Нифай 32:9; Инос 1:1–7; Алма 34:17–28; 37:37. Сурсан зүйлээ хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс. Залбирал болон Тэнгэрлэг Эцэгийг мэдэж авах хоёрын хоорондох холбоо нь юу вэ? *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номныхоо 15 (диконууд), 39 (багш нар), 63-р хуудсыг (пристүүд) гарган, өдөр тутмын залбирлаа сайжруулахын тулд төлөвлөгөө гаргахыг залуу эрэгтэйчүүдэд уриал.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа хайртай байсан бөгөөд тэдний төлөө залбирч мөн тэдэнд байнга үйлчилдэг байсан. Тэрээр тэдэнтэй хамт байх боломжийг ямагт олж мөн тэдэнд хайраа илэрхийлдэг байлаа. Тэр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан. Өөрийн хайрыг залуу хөвгүүдэд илэрхийлэх арга замуудыг хайж мөн Тэнгэр дэх Эцэг тэдэнд ямар их хайртай болохыг ойлгож, мэдрэхэд нь тэдэнд туслах арга замуудыг эрэлхийл.

Видео бичлэг: “Аврагчийн арга барилаар сайн мэдээг заах нь”

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд ямар сэтгэгдэлтэй байна вэ? Тэнгэрлэг Эцэгийг хэрхэн мэдэж авч чадахыг тэд ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно. Тэрээр:

- Хувийн залбирлаа илүү үр дүнтэй болгох төлөвлөгөөнөөсөө хуваалцаж болно. дараагийн цуглаан дээр энэ нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ харьцах харьцааг нь хэрхэн дээшлүүлсэн талаар хуваалцахаар бэлдсэн байхыг залуу эрэгтэйчүүдэд хэлж урамшуул.
- Өнөөдөр төлөвлөсөн зүйлээ хэрэгжүүлж мөн чуулгын

Сонгосон материалууд

М.Рассэл Баллард, “Эцгүүд ба хөвгүүд: Гайхалтай харилцаа” хэлсэн үгээс авсан эшлэлүүд. Ensign ба Лиахона 2009 оны 11-р сар, 47–50

Аароны санваартнууд та нар энэхүү гурван энгийн зүйлсийг хийснээр аавтайгаа одоо байгаагаасаа илүү сайхан харилцаатай болно гэдэгт би итгэж байна.

Нэгдүгээрт аавдаа итгэж найд. Тэр төгс төгөлдөр биш, гэхдээ тэр чамд хайртай мөн чамд муу зүйлийг хэзээ ч хийхгүй. Түүнтэй ярилцаж бай. Өөрсдийн бодол сэтгэгдэл, хүсэл мөрөөдөл, айдас түгшүүрийнхээ талаар түүнтэй хуваалц. Амьдралын чинь талаар илүү ихийг мэдэх тусам аав чинь санаа тавьдаг зүйлсийг чинь илүү сайн ойлгон мөн сайн зөвлөгөөг өгөх боломжтой байх болно. Чи аавдаа итгэж найдах юм бол тэрээр чиний итгэлд урамшиж чамайг ойлгон туслахаар илүү их хичээх болно. Эцэг хүний хувьд, аав чинь чиний өмнөөс удирдамжийг хүлээн авах эрхтэй. Түүний өгөх зөвлөгөө нь чамд хайртай, чамайг мэддэг хүний зүрх сэтгэлийн үгс байх болно. Аав чинь чамайг баяр хөөртэй, амжилттай явахыг юунаас ч илүү хүсдэг. Тийм хүнд итгэхгүй байж болно гэж үү? Хөвгүүд минь, аавдаа итгээрэй.

Хоёрдугаарт аавынхаа амьдралын талаар сонирх. Түүний ажил, сонирхол, зорилгуудынх нь талаар асуу. Тэрээр одоо хийж байгаа ажлаа яагаад сонгосон юм бол? Чиний насан дээр тэр ямар хүүхэд байсан бэ? Ээжтэй чинь анх яаж танилцсан

бэ? Та нар эцгийнхээ талаар илүү ихийг мэдэж авснаар түүнийг илүү сайн ойлгох болно. Аавыгаа ажигла. Аав чинь ээжтэй чинь яаж харилцаж байгааг ажигла. Тэрээр Сүмийн дуудлагаа хэрхэн гүйцэтгэдийг ажигла. Тэр бусадтай хэрхэн харьцаж байгааг ажигла. Түүнийг зөвхөн ажиглаж, сонссоноор түүний талаар ямар их зүйлсийг мэдэж болох нь чиний гайхширлыг төрүүлэх болно. Аавынхаа талаар юуг мэдэхгүйгээ бодож олоод түүнээс энэ тухай асууж мэд. Түүнээс илүү их зүйлийг сурснаар түүнийг хайрлах хайр ба түүгээр бахархах сэтгэл нэмэгдэж, та нар аавыгаа илүү сайн ойлгох болно. Хөвгүүд минь, аавынхаа амьдралын талаар сонирхоорой.

Гуравдугаарт ааваасаа зөвлөгөө авахыг хүс. Үнэнийг хэлэхэд, чамайг зөвлөгөө авахыг хүссэн хүсээгүй аав чинь зөвлөгөө өгөх байх, гэхдээ чи зөвлөгөө авахыг хүсэх юм бол энэ нь илүү сайн зүйл болдог. Сүмийн үйл ажиллагаа, хичээлүүд, найз нөхөд, сургууль, болзоо, спорт болон өөр бусад сонирхлынхоо талаар түүнээс зөвлөгөө авахыг хүс. Сүмийн үүрэг даалгавар, номлолд бэлтгэх талаар мөн гаргах ёстой шийдвэр болон сонголтуудынхаа талаар ааваасаа зөвлөгөө хүс. Хүнээс зөвлөгөө хүсэх нь өөр ямар ч аргаас илүү хүндлэл үзүүлдэг. Яагаад зөвлөгөө хүсч байна вэ гэвэл “Таны мэддэг зүйлс болон амьдралын туршлагаудад тань би талархаж байна, мөн таны санал болон зөвлөгөөнүүдийг чинь би үнэлдэг” гэдгийн илэрхийлэл болдог. Үүнийг хүүгээсээ сонсох нь аав хүний хувьд ямар сайхан билээ.



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Бид Бурхан Тэргүүтэний мөн чанарын тухай юу мэддэг вэ?

Бурхан Тэргүүтэнд Бурхан Мөнхийн Эцэг, Аврагч Есүс Христ болон Ариун Сүнс багтдаг. Бурхан Тэргүүтэний гишүүд тусдаа биетэй, тусдаа үүрэг хариуцлагатай хэдий ч, нэгдмэл зорилготой юм. Тэд Тэнгэрлэг Эцэгийн бурханлаг авралын төлөвлөгөөг тохиолгон авчрахад төгс эв нэгдэлтэй байдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч уншаарай. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Эхлэл 1:26–27 (Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн)

Матай 3:13–17 (Христийн баптисмын үеэр Бурхан Тэргүүтэний бүх гишүүд байсан)

Иохан 17:21; С ба Г 20:28 (Бурхан Тэргүүтэний гишүүд нэг мэт нэгдмэл байдаг)

Үйлс 7:55–56; Иосеф Смитийн түүх 1:14–17 (Стефан, Иосеф Смит нар Эцэг, Хүү хоёр бол хоёр тусгай биес болохыг хардаг)

С ба Г 130:22–23 (Эцэг, Хүү хоёр бие махбодтой, харин Ариун Сүнс бие махбодгүй)

Итгэлийн тунхаг 1:1 (Бид Бурхан Тэргүүтэний гурван гишүүнд итгэдэг)

Боид К.Пакэр “Тэрч” *Ensign* эсвэл *Лиахона* 2014 оны 5-р сар,

Робэрт Д.Хэйлс “Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг мэдэж авах нь мөнх амь мөн” *Ensign* ба *Лиахона*, 2014 оны 11-р сар, 80-82

Жэффри Р.Холланд “Цорын ганц үнэн Бурхан ба Түүний илгээсэн Есүс Христ” *Ensign* эсвэл *Лиахона* 2007 оны 11-р сар, 40–42

“Бурхан Эцэг,” “Ариун Сүнс,” “Есүс Христ,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 59–61, 81–84, 87–89

Видео бичлэг: “Сэргээлт”; мөн *Doctrine and Covenants Visual Resources DVD*

Бурхан Тэргүүтнийг ойлгох нь өөрийгөө хэн болохыг мэдэхэд тань яаж тусалдаг вэ? Бурхан Тэргүүтний тухай бидний мэдлэг бусад шашны итгэлээс юугаараа өөр байдаг вэ?

Бурхан Тэргүүтний мөн чанарыг ойлгох нь залуу эрэгтэйчүүдэд хэрхэн туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын нэг гишүүнийг цуглаанд ирэхдээ өнгөрсөн хичээлээр сурсан зүйлийнхээ талаар хоёр минутын дүгнэлт бэлтгэж ирэхэд урь.
 - Залуу эрэгтэйчүүдээр өөр итгэл бишрэлтэй хүнд Бурхан
- Тэргүүтэний гурван өөр гишүүний тухай заалган жүжигчлэн тоглуул. Тэд ямар судруудыг ашиглах вэ? Яагаад энэ мэдлэг маш чухал гэж тэд бодож байна вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд Бурхан Тэргүүтэний мөн чанарыг ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг эсвэл түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Хичээлийн нэг хэсгийг заах чуулгын гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ төлөвлөгөөн дэх Бурхан Тэргүүтэний тухай судалж мөн заах үүргийнхээ дагуу хийж болох юм (“Сургаалыг ойлгох нь” 18, 42 эсвэл 66-р хуудсыг үзнэ үү).
- Бурхан Тэргүүтэний тухай Христийн бусад шашны итгэлийн талаар Ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн үгийг чуулгаараа хамтдаа унш (“Цорын ганц үнэн Бурхан ба Түүний илгээсэн Есүс Христ” хэлсэн үгээс). “Сэргээлт” видео бичлэгийн Анхны Үзэгдэл хэсгийг эсвэл Анхны Үзэгдэл зургийг (Сайн мэдээний уран

Заахад туслах арга

Та залуу эрэгтэйчүүд сургаалын талаар юуг мэддэг бас юуг мэдэх шаардлагатай байгааг нь олж тогтоохын тулд энэ хэсгийн сурах үйл ажиллагааг ашиглаж болно. Шаардлагатай бол хичээлийнхээ төлөвлөгөөг тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөхөд бэлэн бай.

зургийн ном 90) залуу эрэгтэйчүүдэд үзүүл. Иосеф Бурхан Тэргүүтэний тухай юуг ойлгож авсан бэ? Түүний ойлгосон зүйлс нь Христийн бусад шашнаас юугаараа ялгаатай байсан бэ? Түүний ойлгосон энэ зүйл яагаад чухал вэ? Эдгээр туршлага нь Иосефийн өөрийнх нь итгэдэг байсан зүйлсийг хэрхэн өөрчилсөн гэж залуу эрэгтэйчүүд бодож байна бэ?

- Залуу эрэгтэйчүүдийг энэ хичээлийн тоймд санал болгосон судруудын жагсаалтаар ханга. Залуу эрэгтэй бүрийг эдгээр судрын нэгийг судалж, Бурхан Тэргүүтэн болон өөрийнхөө тэнгэрлэг мөн чанарын талаар суралцсан зүйлүүдээ тодорхойлоход тэднийг урь. Сурсан зүйлүүдээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Энэхүү мэдлэг нь тэдний өдөр тутмын сонголтуудад хэрхэн нөлөөлдөг вэ? Залуу эрэгтэйчүүдийг эдгээр эшлэлийн жагсаалтыг судруудынхаа завсар хадгалж, Бурхан Тэргүүтэний тухай бусдад заахдаа үүнийгээ ашиглахад нь урамшуулан дэмж.

- Дараах асуултуудыг бичсэн цаасыг залуу эрэгтэй бүрд өг: Аврагчийн Эцэгтэйгээ харилцах харилцааг та нар хэрхэн дүрслэх вэ? Эцэг, Хүү хоёр ямар арга замаар нэгдмэл байдаг вэ? Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ? Ахлагч Робэрт Д.Хэйлсийн “Тэнгэрлэг Эцэг ба

Түүний Хүү Есүс Христийг таньж мэдэх нь мөнх амь мөн” хэлсэн үгийг уншиж, сонсож эсвэл үзэхдээ эдгээр асуултын талаар тунгаан бодоход тэднийг урь. Тэдэнд хариултаа бичих цаг өгч дараа нь бичсэн зүйлсээ хуваалцахад урь.

- Чуулгыг гурван бүлэг болгон хувааж бүлэг бүрд Бурхан Тэргүүтэний нэг гишүүнийг хувиарлан өгөөд *Итгэлдээ үнэнч байх нь* (59–61, 32–35 ба 87–89-р хуудсыг үзнэ үү) номноос эсвэл ерөнхийлөгч Боид К.Пакэрын “Гэрч” хэлсэн үгийг уншихыг даалга. Тэдэнд Бурхан Тэргүүтэний хувиарлан авсан гишүүнийхээ зан төлөв, үүргийнх нь тухай бусад бүлгийнхэндээ заах хангалттай цаг өг. Тэдэнд чуулгын гишүүддээ заах боломжийг олго.

- Энэ тоймд санал болгосон ерөнхий чуулган дээр хэлсэн үгүүдийн нэгийг нь жижиг хэсгүүдэд хуваа. Чуулгын гишүүн бүрд нэг хэсгийг (эсвэл чуулга нь хэдэн гишүүнтэйгээс хамааран бүлгүүдэд) оноож өг. Самбар дээр “Бурхан Тэргүүтэний талаар бид юу мэддэг вэ?” гэж бич. Хариултуудаа олохдоо эдгээр хэлсэн үгийг ашиглаж мөн хариултуудаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Бурхан Тэргүүтэний үнэн мөн чанарыг ойлгох нь яагаад чухал вэ? (Иохан 17:3-ыг үзнэ үү).

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэд Бурхан Тэргүүтэний тухай илүү сайн ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бурхан Тэргүүтэний гишүүдийн талаар мөн Иосеф Смитээр дамжуулан Тэдний тухай үнэнүүд сэргээгдсэнд талархалтай байдаг тухай гэрчлэлээ хуваалцана.
- Өнөөдөр чуулгын цуглаан дээр сурсан зүйлээ бусадтай хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч хүмүүсээс тунгаан бодож, гүнзгий мэдрэмж төрүүлэх асуултуудыг асуудаг байсан. Тэрээр тэдний хариултыг чин сэтгэлээсээ сонсож, итгэлтэй байдалд нь баясдаг байсан. Тэрээр тэдэнд асуулт асуух боломж олгож мөн сэтгэгдлийг нь сонсдог байв. Залуу эрэгтэйчүүдийг Бурхан Тэргүүтэний тухай илүү сайн ойлгоход нь туслах ямар асуулт та асууж болох вэ? Тэдний хариултыг сонирхож байгаагаа хичээлийн явцад та хэрхэн харуулж болох вэ?

Видео бичлэг: “Юу заахаа тодорхойл”

Сонгосон материалууд

Жэффри Р.Холланд, “Цорын Ганц Үнэн Бурхан ба Түүний илгээсэн Есүс Христ,” хэлсэн үгээс авсан эшлэл Ensign ба Лиахона 2007 оны 11-р сар, 40–42

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь орчин үеийн Христэд итгэгчдийн адилаар Бурхан, Есүс болон Ариун Сүнсэнд итгэдэггүй гэсэн ямар ч шүүмжлэл нь бидний Христэд өгсөн амлалтын талаарх тайлбар биш, харин Шинэ Гэрээний дараах Христэд итгэгчдийн түүхээс өөр байж мөн Есүсийн Өөрийнх нь сургаалд заагдсаны дагуу Бурхан Тэргүүтэний талаарх бидний үзэл бодлыг өөрөөр хэлбэл (үнэн зөв гэж би нэмж хэлмээр) хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм. Одоо би Шинэ Гэрээний дараах Христэд итгэгчдийн түүхийн талаар тайлбарлах нь зүйтэй байхаа.

МЭ 325 онд Ромын эзэн хаан Константин Бурханы “эцэг, хүү, ариун сүнсний гурамсан холбоо” гэж их яригддаг асуудлыг, мөн бусад зүйлсийг хэлэлцүүлэхээр Никаегийн Зөвлөлийг дуудан хуралдуулжээ. Сүмийн санваартнууд, гүн ухаантнууд, нэр хүндтэй Сүмийн албан тушаалтнуудын мэтгэлцээнээс (дахиад 125 жил, гурван том зөвлөлийн дараа) [Константинопл, МЭ 381; Ефес, МЭ 431; Калседон, МЭ 451 онд] Атанашины шашны тодорхойлолт гэх мэтийн сүүлд нь дахин боловсруулсан хэлбэртэй Наясийн шашны тодорхойлолт буюу Христэд итгэгчдийн итгэлийн үндсэн сургаалуудын анхны албан ёсны тодорхойлолт гарч ирсэн ажээ. Шашны тодорхойлолтын эдгээр олон янзын хувьсалууд мөн хувилбарууд мөн зуунуудын турш гарч ирэх бусад нь—Эцэг, Хүү,

Ариун Сүнс гурвыг бие махбодгүй, бүхнээс хүчтэй мөн агуу, цаг хугацаа, орон зайнаас тусгаар оршдог, байнгын, нэгдмэл, мөнхөд хамтдаа байдаг, мэдэх аргагүй, бие, биеийн эрхтнүүд эсвэл сэтгэлийн хөдлөл зэрэг нь байдаггүй, орон зай, цаг хугацаанаас хамааралгүй оршдог гэж тодорхойлжээ. Шашны эдгээр тодорхойлолтуудад гурван гишүүнийг салангид хүмүүс боловч нэг биетэн, “эцэг, хүү, ариун сүнсний гурамсан нууц” гэж ихэвчлэн дурдсан байдаг. Тэд гурван тусдаа хүмүүс, гэхдээ гурав биш нэг Бурхан. Энэ гурван хүн нь тааж боломгүй байдаг ч, нэг Бурхан нь өөрөө тааж боломгүй нэгэн билээ.

Тэнгэрлэг байдлын талаарх ойлголт нь үнэхээр тааж боломгүй зүйл гэдэг дээр бид биднийг шүүмжлэгчидтэй санал нэгддэг. Сүмээр далимдуулан Бурхан биесийг ийм ойлгомжгүй тодорхойлсон нь дөрөвдүгээр зууны нэгэн ламыг: “Би гаслан зовлонд уналаа! Тэд миний Бурханыг надаас авчихлаа, . . . би одоо хэнийг дээдлэн шүтэх эсвэл хэнд хандан залбирахаа мэдэхээ болилоо” хэмээн уулга алдахад хүргэжээ. [Овэн Чадвикаас эш татав, *Western Asceticism* (1958), 235.] Бид хэрхэн адил болохыг хичээх гэдгийг бодож үзэлгүйгээр, тааж боломгүй мөн мэдэх аргагүй Тэр нэгэнд итгэн, хайрлан, шүтэх вэ? Тэнгэр дэх Түүний Эцэгтээ хандсан Есүсийн залбирал болох “цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” гэдгийг бид юу гэж ойлгох вэ? [Иохан 17:3; тодотгол нэмсэн.]



Есүс Христ яагаад миний амьдралд чухал байр суурь эзэлдэг вэ?

Есүс Христ бидний Аврагч байхаар сонгогдсон. Түүний Цагаатгалын ачаар бид амилуулагдаж, наманчилж, нүглээсээ уучлагдан Тэнгэрлэг Эцэгийн оршихуй руу буцах боломжтой болдог. Аврагч биднийг нүглээс аврахаас гадна сорилт бэрхшээлтэй үед маань амар амгалан ба хүч чадлыг өгдөг. Тэрээр бидэнд төгс жишээ үзүүлдэг. Түүний сургаал энэ амьдрал болон дараагийн амьдрал дахь аз жаргалын эх булаг юм.

Есүс Христ яагаад таны хувьд чухал вэ? Тэр таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

Есүс Христийн үүргийг ойлгох нь залуу эрэгтэйчүүдийн хувьд яагаад чухал вэ? Тэдний амьдралд Есүс чухал гэдгийг ойлгоход нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч, уншаарай. Залуу эрэгтэйүүдэд Есүс Христ яагаад чухал болохыг заахад танд юу тусалж чадах вэ?

Матай 10:1 (Есүс Христ төлөөлөгчдөдөө санваарын хүчийг өгөв)

Иохан 6:38 (Есүс Христ Эцэгийнхээ хүслийг биелүүлэхээр ирсэн юм)

Иохан 8:12; 3 Нифай 11:11 (Есүс Христ дэлхийн гэрэл ба амь мөн)

Иохан 14:6 (Есүс Христ бол зам, үнэн, амь мөн)

2 Нифай 2:3–9; 9:5–12 (Лихай, Иаков нар Есүс Христийн Цагаатгалын тухай гэрчлэв)

3 Нифай 27:14–16 (Есүс Христ Цагаатгалаараа дамжуулан биднийг нүгэл ба үхлээс аварсан юм)

3 Нифай 27:27 (Есүс Христ бол бидний даган дуурайх жишээ мөн)

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл” *Ensign* 2000 оны 4-р сар, 2–3 (Итгэлдээ үнэнч байх нь, 87–89; Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, 106-аас үзнэ үү)

Хосе А.Тэхэйра, “Их Эзэнийг эрэлхийлэх нь,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 83

Даллин Х.Өүкс, “Есүсийн сургаал,” *Ensign* эсвэл *Liahona*, 2011 оны 11-р сар, 90–93

Жэффри Р.Холланд, “Эхний агуу зарлиг” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 11-р сар

Видео бичлэг: “Гэмээ наманчилсан нь”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдэд өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлсээ санахад нь туслахын тулд самбар дээр нэг эсвэл түүнээс олон асуулт бич. зүйлсийг дүгнэхийг хүс. Христийн үүрэг ба зорилгын тухай дүрсэлсэн үгс ба өгүүлбэрийг олохыг тэднээс хүс. Энэхүү жагсаалтаас тэд Есүс Христийн тухай юу сурсан бэ? Бидний төлөө Түүний хийсэн зүйлсийг дүгнэсний дараа тэд Түүний тухай ямар бодолтой байна вэ?
- Залуу эрэгтэйчүүдийг Сэдэвчилсэн удирдамжаас “Есүс Христ” гэдэг үгийг олж, энэ гарчиг доор бичсэн

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд яагаад Есүс Христ бидний амьдралд чухал байр суурь эзэлдэг болохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын гишүүдийг ахлагч Хосе А.Тэхэйрагийн “Их Эзэнийг эрэлхийлэх нь” хэлсэн үгийг уншаад, Есүс Христийг эрэлхийлэх хүмүүст ахлагч Тэхэйрагийн амласан адислалуудыг олж мэдэхэд урь. Тэднийг энэ хэлсэн үгээс олж мэдсэн зүйлээ мөн Аврагчийг өдөр тутмын амьдралынхаа чухал хэсэг болгохын тулд хувь хувьдаа юу хийж байгаагаа хуваалцахад урь. Та нар энэ ярилцлагын нэг хэсэг болгон ахлагч Тэхэйрагийн хэлсэн үгэндээ зөвлөсөн энгийн хэвшлүүдийг хамтдаа судалж болно. Залуу эрэгтэйчүүдийг Христтэй илүү ойр байхын тулд хичээл дээр ярилцсан зөвлөмжүүдээс нэгийг сонгож ашиглах зорилго тавихад урь.

Заахад туслах арга

“Та шаардлагагүй зүйлс нуршин ярьж, өөрийн бодол санааг дэндүү их илэрхийлэхгүй байх ёстой. Эдгээр үйлдэл нь суралцагчдын сонирхлыг бууруулдаг юм. Зааж буй хүмүүсээ зөв чиглэлд явуулах зөвлөгөө өгдөг суралцах аяны хөтөч хэмээн өөрийгөө бод (*Teaching, No Greater Call* [1999], 64).

- Хичээлийн нэг хэсгийг заах чуулгын гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ төлөвлөгөөн дэх Цагаатгалын тухай судалж мөн заах үүргийнхээ дагуу хийж болох юм (“Сургаалыг ойлго” сэдвийн 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).

- Ахлагч Даллин Х.Өүксийн “Есүсийн сургаал” хэлсэн үгийн “Бидний төлөө Түүний хийсэн зүйлс” дэд гарчиг дахь хэсгийг уншина уу. Эмэгтэйн “Тэр миний төлөө юу хийсэн юм бэ?” гэдэг асуултад залуу эрэгтэйчүүд юу гэж хариулж болох вэ? Уг хэлсэн үгийн дараах есөн дэд гарчгийг самбар дээр бич (“Дэлхийн амьдрал”-аас “Цагаатгал” хүртэлх). Залуу эрэгтэйчүүд эдгээр дэд гарчгаас нэг эсвэл түүнээс олон дэд гарчгийг сонгон авч, Есүс Христ тэр эмэгтэйн төлөө юу хийсэн болохыг заахын тулд нэгээс хоёр өгүүлбэр бэлтгэхийг санал болго. Тэд ахлагч Өүксийн хэлсэн үг, холбогдох судрууд (энэхүү тоймд санал болгосон), өөрсдийн туршлага болон гэрчлэлээ ашиглаж болно. Бэлтгэсэн зүйлсээ хуваалцахыг тэднээс хүс.

- Хэсэг залуу эрэгтэйгээс 2 Нифай 2:3–9 -оос Есүс Христ тэдний төлөө юу хийсэн болохыг олж уншихыг хүс. Үлдсэн залуу эрэгтэйчүүдээс 2 Нифай 9:6–10-аас хэрэв Есүс зорилгоо биелүүлж чадаагүй бол ямар үр дагавар гарах байсныг олж уншихыг хүс. Дэлхийн юу нь өөр байх байсан бэ? Та Аврагчийг хайрладаг хайраа хуваалцаж мөн залуу эрэгтэйчүүдээс үүний тухай хуваалцахыг урь.

- Аврагч хүмүүст тусалж байгаа зургийг үзүүл (*Сайн мэдээний уран зургийн ном* 36–60-ыг үзнэ үү). Залуу

эрэгтэйчүүдийг Аврагч тэдэнд болон тэдний гэр бүлийнхэнд мөн таньдаг хүмүүст хэрхэн тусалж байсан тухай тунгаан бодож, энэ тухай хуваалцах цөөн хэдэн минут олго. Аврагчийн тухай юу мэдэрдэг тухайгаа хуваалцахад урь. Залуу эрэгтэйчүүдээс “Есүс Христ миний амьдралд хичнээн чухал болохыг би бусдад хэрхэн харуулж чадах вэ?” гэдэг асуултын талаар тунгаан бодохдоо Ахлагч Жэффри Р.Холландын “Эхний агуу зарлиг” хэлсэн үгийн сүүлийн дөрвөн догол мөрийг уншихыг хүс. Тэднийг өөрсдийн бодлыг бичиж тэмдэглэхэд урь. Хэрэв тэд хүсвэл бичсэн зүйлсийнхээ талаар хуваалцаж болно.

- “Reclaimed” видео бичлэгийг үзүүл. Уг видео бичлэгээс залуу эрэгтэйчүүд Есүс Христ тэдний төлөө юу хийж чадах тухай юу сурах вэ? Тэд өөрсдийгөө уучилж чадахгүй байгаа бас Аврагчийн тусалцааг авах боломжгүй гэж боддог хүмүүст энэхүү видео бичлэгийн захиасыг ашиглан яаж тусалж чадах вэ? Тэд ямар судруудаас хуваалцаж болох вэ? (жишээлбэл Исаиа 1:18; Алма 36:3, 27; Ифер 12:27; С ба Г 58:42–43-ыг үзнэ үү).

- Аврагчийн зургийг үзүүлж, дараах асуултуудыг самбар дээр бич: “Есүс гэж хэн бэ?” “Тэр бидний төлөө юу хийсэн бэ?” “Тэр амьд гэдгийг бид яаж мэддэг вэ?” Залуу эрэгтэйчүүдийг эдгээр асуултын хариултуудыг “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”-ээс эсвэл дууны номоос хайж олоход урь. Олж мэдсэнээ хуваалцахыг тэднээс хүс. Есүс Христийн тухай гэрчлэл нь тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдыг итгэлээр үйлдэж мөн Түүний заасан үнэний дагуу амьдрахыг уриалдаг. Тэрээр тэдэнд хүчирхэг туршлагаудаар дамжуулан сурах боломжийг өгсөн. Залуу эрэгтэйчүүд Есүс Христийг амьдралынхаа нэг хэсэг болгохын чухлыг олж харахад нь туслахын тулд та юу хийж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Есүс Христ тэдний амьдралд яагаад чухал болохыг тэд ойлгодог уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцаж болно. нэгний амьдралыг хэрхэн адисалж болох тухай тунгаан бодож, гэрчлэлээ хуваалцахад нь урамшуулан дэмжиж болно.
- Чуулгын гишүүдийг Аврагчийн тухай гэрчлэл нь тэдний мэддэг хэн

Сонгосон материалууд

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг бид дурсан тэмдэглэхдээ Түүний зүйрлэшгүй амьдрал, агуу цагаатгагч золиослолын хэмжээлшгүй хүч нь үнэн бодитойг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон хойшид амьдрах бүх хүнд ийм хүчтэй нөлөөг өөр хэн ч үзүүлэхгүй юм.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан ч аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд баптисм хүртэж ад үзэгдсэн ч “сайныг үйлдэж явлаа” (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол энх амгалан болон сайн санааны захиас байлаа. Тэрээр хүн бүхнийг Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг хүсч байлаа. Тэрбээр Палестины замуудаар алхан өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгон, үхэгсдийг босгож явлаа. Бас мөнхийн үнэнүүд, мөнх бус байдлын өмнөх амьдралд бид оршин амьдарч байсан нь үнэн болохыг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго, ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын өсөн хөгжих боломжуудын тухай заадаг байв.

Тэрбээр ариун ёслолыг Өөрийн агуу цагаатгагч золиослолын сануулагч болгон бий болгосон юм. Түүнийг баривчилж, хилс хэрэгт буруутган, хилэгнэсэн олны шаардлагыг биелүүлэхийн тулд Калварид загалмайд дүүжлэн цаазаар авах ял оноосон билээ. Тэрээр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн юм. Дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа болон амьдрах бүх хүнд Түүний агуу бэлэг зориулагдсан юм.

Бүх хүн төрөлхтний түүхэнд гол суурийг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлээгүй бас Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч мөн.

Тэрээр булшнаас босч ирэн, “нойрсогсдоос анхны үр жимс болсон юм” (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэн мөнх бус үйлчлэлийнхээ үед хайрладаг байсан хүмүүс дээрээ очжээ. Тэр бас эртний Америк дахь “өөр хонин сүрэг” (Иохан 10:16)-тэй үйлчилсэн юм. Өнөөгийн дэлхийд Тэрбээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, өнө эртнээс амлагдсан “цагийн дүүрнийг” (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

Бошиглогч Иосеф Амьд Христийн тухай “Түүний мэлмий галын дөл лүгээ адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн дуу хоолой нь агуу их ус хуйлрах мэт байв, бүр Иеховагийн дуу хоолой өгүүлэн;

Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3-4) хэмээн бичжээ.

Бошиглогч бас Түүний тухай “Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.

Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” (С ба Г 76:22-24) гэж тунхагласан юм.

“Элч нар болон эш үзүүлэгчдийн . . . суурин дээр босгогдсон бөгөөд Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болох” (Ефес 2:20) Түүний санваар, Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг бид хариуцлагатайгаар, хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.

Тэрбээр нэгэн өдөр дэлхий дээр эргэж ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. “Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ” (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан, Эздийн Эзэн болж захиран хаанчлах бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөн Түүнийг шүтэн бишрэх болно. Бид бүгд өөрсдийн үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсох болно.

Бид зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд Есүс бол Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд байгаа аугаа Иммануел Хаан мөн. Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал, итгэл найдвар болой. Түүний зам бол энэ дэлхийд аз жаргал хийгээд ирэх дэлхийд мөнх амьдрал өөд хөтөлдөг зам мөн. Юутай ч зүйрлэшгүй бэлэг болох тэнгэрлэг Хүүгийнх нь төлөө Бурханд талархал өргөө.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ

Thomas M. Monson
James E. Faust

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА

Boyd K. Packer
Robert D. Anderson
Neal A. Maxwell
Russell M. Nelson
Ollin A. Dahl

M. Russell Ballard
Joseph B. Wirthlin
Richard G. Scott
Scott D. Hall
Jeffrey R. Holland
Henry B. Eyring



Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?

Ариун Сүнс үнэнийг гэрчилдэг юм. Тэр бол хувийн гэрчлэл ба илчлэлтийн эх үндэс мөн. Тэрээр биднийг шийдвэр гаргахад удирдан чиглүүлж мөн сүнслэг болон бие махбодын аюул ослоос хамгаалдаг. Түүнийг Тайтгаруулагч хэмээн нэрлэдэг ба Тэрээр бидний айдсыг үргээж, бидэнд найдвар төрүүлж чадна. Бид нүглээ наманчлан, авралын ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүдээ сахихдаа Түүний хүчээр дамжуулан ариусдаг билээ. Санваартнууд үр дүнтэй үйлчлэхийн тулд Ариун Сүнсний өдөөлтийг сонсон, дагах нь амин чухал байдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та Ариун Сүнсний тухай эдгээр судар, материалыг судлахдаа Ариун Сүнс тэдний амьдралд ямар чухал үүрэгтэй болохыг ойлгоход нь туслахын тулд юу заах ёстойгоо мэдэхээр Түүний удирдамжийг эрэлхийл.

Иохан 14:16–27 (Тайтгаруулагч бидэнд зааж мөн бүх зүйлийг сануулж чадна)

Иохан 15:26; С ба Г 42:17; Мосе 1:24 (Ариун Сүнс нь Эцэг Хүү хоёрын тухай гэрчилдэг)

Галат 5:22–23 (Паул Сүнсний үр жимсийн тухай дүрсэлдэг)

2 Нифай 32:5 (Ариун Сүнс бидэнд бидний хийх ёстой зүйлсийг харуулдаг)

3 Нифай 27:20 (Би Ариун Сүнсийг хүлээн авснаар ариусдаг)

Моронай 8:26 (Ариун Сүнс биднийг найдвар ба хайраар дүүргэдэг)

Моронай 10:5 (Ариун Сүнс бидэнд үнэнийг заадаг)

Робэрт Д.Хэйлс, “Ариун Сүнс,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 92–94

Ларри Р.Лорэнс, “Надад юу дутагдаж байна вэ?,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 17

Хэнри Б.Айринг, “Таны хамтрагч Ариун Сүнс,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 96

Та Ариун Сүнсний үүргийг ойлгоход туслах ямар туршлагаас тэдэнтэй хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүд Сүнсний өдөөлтийг таньж мэдэн, дагах нь яагаад чухал байдаг вэ? Ариун Сүнсний нөхөрлөлд тэнцэхүйц зохистой мөн Түүнийг эрэлхийлдэг болоход нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээ санаж байгаа нэг зүйлийнхээ талаар бодох хугацааг тэдэнд олго. Тэдний хариултыг өнөөдрийн хичээлтэй хэрхэн холбож болохыг бод.
- Тэднийг Ариун Сүнсний нөлөөг мэдэрсэн туршлагаасаа бичихэд урь. Тэд Түүний нөлөөг хүлээн авахын тулд юу хийсэн бэ? Түүний нөлөө юуг өөрчилсөн бэ? Тохиромжтой бол хэд хэдэн залуу эрэгтэйгээс өөрсдийн туршлагыг хуваалцахыг хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд Ариун Сүнсний үүргийг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг эсвэл түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Залуу эрэгтэй бүрийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Таны хамтрагч Ариун Сүнс” хэлсэн үгийн нэг хэсгийг судлаад, Ариун Сүнсний тухай сурсан зүйлээ чуулгатай хуваалцахаар бэлтгэхэд урь. Залуу эрэгтэйчүүд мөн Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдаг жишээг харахын тулд ахлагч Ларри Р.Лорэнсийн “Надад юу дутагдаж байна вэ?” хэлсэн үгийг судалж болно. Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Айринг, ахлагч Лорэнс нарын дүрсэлсэн арга замтай төстэй арга замаар Ариун Сүнс өөрсдөд нь тусалж байсан туршлагаасаа хуваалцахад урь.
- Хичээлийн нэг хэсгийг заах чуулгын гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ төлөвлөгөөн дэх Ариун Сүнсний тухай судалж мөн заах үүргийнхээ дагуу хийж болох юм (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Залуу эрэгтэйчүүдийг дараах судруудыг уншаад, Ариун Сүнсний үүргийг олж тогтоон мөн Түүний нөлөө тэднийг хэрхэн адисалдаг тухай хуваалцахад урь. Иохан 14:26; 15:26; Галат 5:22–23; 2 Нифай 32:5; 3 Нифай 27:20. Залуу эрэгтэйчүүд мөн ахлагч Роберт Д.Хэйлсийн “Ариун Сүнс” хэлсэн үгийг Ариун Сүнсний

Заахад туслах арга

“Та заахаар бэлдэж байхдаа зарим нэг зарчмыг онцлон заахаар сүнс-лэгээр өдөөгдөж болох юм. Та зарим нэг санааг хэрхэн үр дүнтэй танилцуулах тухай ойлголтыг авч болох юм. Та мөн амьдралын жирийн нэг үйл явцаас хичээл дээр заах жишээ болон сүнс-лэг туршлагуудыг олж авч чадна. Хичээлдээ ямар нэг хүнийг урьж оролцуулахаар та сүнс-лэгээр өдөөгдөж болно. Та тэдэнтэй хуваалцаж болох өөрийн туршлагыг эргэн санаж ч болох юм (*Teaching, No Greater Call* [1999], 48).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч маань шавь нар-таа заахдаа энгийн түүх, сургаалт үлгэр болон амьдралын туршлагаас заадаг байв. Залуу эрэгтэйчүүд Ариун Сүнсний үүргийг ойлгож мөн тантай адил туршлагыг хүлээн авах зохистой байхыг эрэлхийлэхийг хүсэх хувийн ямар туршлагаасаа та хуваалцаж чадах вэ?

үүргийг мэдэж авахаар судалж болно. Залуу эрэгтэйчүүдийг амьдралд нь Ариун Сүнсний нөлөө хэрэгтэй үеийг жагсаан бичихэд урь. Ариун Сүнс тэдэнд хийх ёстой зүйлийг нь хэзээ үзүүлэх нь чухал вэ? Хэзээ тэд Ариун Сүнсний гайтгаруулах нөлөөг мэдрэх шаардлагатай байдаг вэ? Та Ариун Сүнсний тусламжийг хүлээн авсан туршлагаасаа хуваалцаж болно.

- Энэхүү тоймд жагсаасан видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, энд Ариун Сүнсээр дамжуулан удирдамж хүлээн авах тухай юу гэж заасан болохыг анхааран үзэхийг хүс. Сурсан нэг зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэй бүрээс асуу. Үүний дараа Жюли Б.Бэк эгчийн хэлсэн дараах үгийг самбар дээр бич. “Хувийн илчлэлт хүлээн авч, үүний дагуу амьдрах чадвар бол энэ амьдралд эзэмших ёстой хамгийн

чухал чадвар юм. Ийм чадварыг эзэмшсэн бол бид хэзээ ч унахгүй, харин үүнийг эзэмшээгүй бол бид хэзээ ч амжилтанд хүрч чадахгүй (“Тэдгээр өдрүүдэд Би боолууд, шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсээ цугтана,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 4-р сар, 11). Тэднээс энэхүү эшлэлийн тухай юу гэж бодож байгаага мөн Сүнснийг даган, зохистой амьдрах талаар бодож байгаа зүйлээ бичиж тэмдэглэхийг хүс. Ариун Сүнсний нөхөрлөлийг бүрэн дүүрэн эрэлхийлэхийн тулд юу хийж чадах тухайгаа эргэцүүлэн бодоход тэднийг дэмж.

- Залуу эрэгтэйчүүдийг Сүмийн дуулал болон Хүүхдийн дуу номноос Ариун Сүнс бидэнд тусалдаг тухай нэг дууллыг олохыг хүс. Сонгосон дууллынхаа мөрөөс уншихыг тэднээс хүс. Чуулгын гишүүд нэг дууллыг хамтдаа дуулж болно.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэд Ариун Сүнсний үүргийг ойлгодог уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Боломжтой бол тэрээр чуулгын цуглаан дээр ярилцсан арга замуудын нэгийг ашиглан, ариун Сүнсний нөлөөг мэдэрсэн туршлагаасаа хуваалцаж болно.
- Чуулгын залуу эрэгтэйчүүдийг Ариун Сүнсний нөхөрлөхүйц зохистой байж, үүнийг эрэлхийлэхэд урьж болно.

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Таны хамтрагч Ариун Сүнс,”
Ensign, 2015 оны 11-р сар, 104–105 эсвэл 2015 оны
10-р сарын Ерөнхий чуулган, 96–100-аас эш татав

Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгах гэдэг нь өдөр тутмын амьдралдаа Ариун Сүнсний удирдамж, зааврыг авч байна гэсэн үг юм. Жишээ нь, Сүнс бидэнд хилэнцийг үйлдүүлэх уруу таталтыг эсэргүүцэхийг сэрэмжлүүлж болно.

Тиймээс Их Эзэний үйлчлэгчид ариун ёслолын цуглаанд Бурханыг шүтэн бишрэх бидний хүслийг өсгөн нэмэгдүүлэхийг хичээдэг шалтгааныг харахад хялбар байдаг. Хэрэв бид ариун ёслолоос итгэлтэй хүртвэл Ариун Сүнс биднийг болон бидний хайртай хүмүүсийг улам хүчтэй, нэмэгдэн ирж буй уруу таталтаас хамгаалах болно.

Ариун Сүнсний нөхөрлөл нь сайн сайхан зүйлсийг илүү сэтгэл татам болгон, уруу таталтын хүчийг сулруулдаг. Зөвхөн энэ нь бидэнд Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгахар зохистой байх шийдвэр гаргахад хангалттай үндэслэл болох юм.

Ариун Сүнс биднийг нүгэл хилэнцийн эсрэг хүчирхэгжүүлдгийн адил, бидэнд үнэн, худлыг ялгах хүчийг мөн өгдөг. Хамгийн чухал үнэнийг зөвхөн Бурханаас ирэх илчлэлтээр бататгах боломжтой. Үүнд хүмүүн бидний ямар ч тайлбар

эсвэл биеийн мэдрэхүйг ашиглах нь хангалтгүй. Бид хамгийн мэргэн ухаантай нь ч гэсэн ухаалгаар далдлан нууцалсан худал хуурмагаас үнэнийг ялгахад бэрх болсон цаг үед амьдарч байна.

Их Эзэн, Аврагчийн сорвинд хүрч, Түүний амилалт бодитой гэдгийг нотлохыг хүссэн Өөрийн төлөөлөгч Томас “Есүс түүнд, чи намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!” (Иохан 20:29) хэмээн айлдан, илчлэлт бол илүү найдвартай нотолгоо гэдгийг заасан байдаг.

Бурхан руу, гэртээ буцаж очих замыг тэмдэглэдэг үнэнүүдийг Ариун Сүнс баталж өгдөг. Бид ойн цоорхой руу очин; Эцэг, Хүү хоёр залуу Иосеф Смиттэй ярьж байгааг харах боломжгүй. Түүнчлэн амласны дагуу Елиа ирэн, өнөө үед амьд бошиглогч Томас С.Монсон эрхийг нь атган, хэрэглэж байгаа санваарын түлхүүрүүдийг өгсөн болохыг батлах ямар ч бодит нотолгоо, логик тайлбар байхгүй.

Ариун Сүнсийг хүлээн авах эрхтэй Бурханы охинд эсвэл хүүд үнэний баталгаа ирдэг. Бид ямар ч үед худал юм уу хуурмаг зүйлтэй тулгарч болох учраас эргэлзээ төрүүлэхгүйн тулд Үнэний Сүнсний нөлөөг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгах хэрэгтэй юм.”



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Би хэн бэ? Би хэн болж чадах вэ?

Бид бол Түүний дүр төрхөөр бүтээгдсэн, Түүнтэй адил хаан байх боломжтой, Тэнгэрлэг Эцэгийн хөвгүүд юм. Бид санваарын үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардах онцгой авьяас бэлэг хүлээн авсан. Хэн гэдгээ таньж мэдэх нь биднийг амьдралын зорилготой болгож, зөв шийдвэрүүд гаргахад тусалдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судлаарай. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Дуулал 82:6; Үйлс 17:28–29; Еврей 12:9; С ба Г 76:24 (Бид Бурханы хүүхдүүд)

Матай 25:14–30 (Талантын тухай сургаалт үлгэр)

Лук 15:4–6, 11–32; Иохан 3:16; С ба Г 18:10–15 (Бодгалийн үнэ цэн агуу юм)

Моце 1:4–22 (Моце Бурханы хүү гэдгээ мэдэж авсан нь)

Доналд Л.Холлстром, “Би Бурханы хүүхэд,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 10–12

Дэйл Г.Рэнланд, “Хожмын үеийн гэгээнтнүүд шантралгүй хичээсээр байдаг,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 43

Дийтр Ф.Угдорф, “Дөрвөн нэр,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 5-р сар, 58–61

“Би Бурханы хүүхэд,” *Сүмийн дуулал*, 58-р дуу

Бурханы хөвгүүн гэдгээ мэдэх нь таны бодол санаа болон үйлдэлд хэрхэн нөлөөлдөг вэ? Танд Бурхан ямар авьяас, бэлэг өгсөн бэ? Та зааж буй залуу эрэгтэйчүүдээ адислахын тулд Түүний өгсөн авьяас, бэлгийг хэрхэн ашиглаж болох вэ?

Та өөрсдийн тэнгэрлэг чадварыг таньж мэдэхэд залуу эрэгтэйчүүдэд хэрхэн тусалж чадах вэ? Үүнийг ойлгосноор зөв шийдвэр гаргахад нь тэдэнд хэрхэн туслах вэ? Таны заадаг залуу эрэгтэйчүүдэд ямар онцгой авьяас, чадвар байдаг вэ? Эдгээр авьяас, чадвараа бусдыг адислахын тулд ашиглахад нь та тэднийг хэрхэн дэмжиж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс хамгийн чухал юу сурсан бас үүнийгээ хэрхэн хэрэгжүүлсэн тухайгаа хуваалцах хоёр залуу эрэгтэйг урь.
- Самбар дээр дараах асуултуудыг бич. “Би Тэнгэрлэг Эцэгийн тухай

юу мэдэх вэ?” “Энэ нь миний хэн болох мөн хэн болж чадах тухай юу заадаг вэ?” “Энэ мэдлэг маань миний бодол санаа ба үйлдэлд хэрхэн нөлөөлдөг вэ?” Тэдэнд эдгээр асуултыг тунгаан бодох цаг өгч мөн тэднийг самбар дээр өөрсдийн хариултыг бичихийг урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд өөрсдийн тэнгэрлэг мөн чанарыг болон ур чадвараа таньж мэдэхэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонго.

- Бурхантай адил болоход тэвчээр мөн шаргуу хичээл зүтгэл шаардагддаг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгоход нь туслах энгийн үйл ажиллагааны талаар бод. Энэ үйл ажиллагаа нь амжилттай гүйцэтгэхэд хэд хэдэн удаа оролдож үзэхийг шаарддаг байх хэрэгтэй. Жишээлбэл, залуу эрэгтэйчүүд хогийн сав руу харалгүй, ямар нэгэн зүйл шидэж оруулах гэж ахин дахин хичээж болно. Энэ үйл ажиллагаа нь бидэнд шаргуу хичээл зүтгэлийн талаар ямар сургамж өгч байна вэ? Бид энэхүү үйл явцыг Тэнгэрлэг Эцэгтэй адил болохтой хэрхэн уялдуулж ойлгох вэ? Залуу эрэгтэй бүрийг үйл ажиллагаанаас сурсан зүйлийг нь харуулж буй өгүүлбэрүүдийг ахлагч Дэйл Г.Рэнландын “Хожмын үеийн гэгээнтнүүд шантралгүй хичээсээр байдаг” хэлсэн үгээс олж мэдээд, хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг Мосе 1:4–7-г уншаад, Мосе өөрийнхөө тухай юу сурсан болохыг олоход урь. 12-р шүлгээс Мосегийн сурсан зүйлийг сорих гэж Сатан юу хийсэн болохыг тэднээр олуул. 13–22-р шүлгийг хамтдаа унш. Энэ түүхээс өөрсдийнхөө талаар, Тэнгэрлэг Эцэг болон Аврагчийн тухай мөн дайсны талаар юу сурсан талаараа хуваалцахыг тэднээс хүс. Тэдэнд энэхүү мэдлэг тус болох ямар нөхцөл байдлуудтай тэд тулгардаг вэ? Энэ ярилцлагын үеэр “Би бол Бурханы хүү” видео бичлэгийг үзүүлж болно.

- Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийнхөө нэр хоч эсвэл амьдралынх нь туршид тэднийг нэрлэж болох нэрсийн жагсаалт гаргахыг хүс. Эдгээр нэр нь тэдний талаар юу өгүүлж байна вэ? Хамгийн чухал нэг эсвэл хоёр нэрийг сонгохыг тэднээс

Заахад туслах арга

“Таны заадаг хүмүүсийн амьдралд заадаг материалын тань тоо биш, харин үзүүлэх нөлөө нь илүү чухал байдаг. Дэндүү олон санааг нэг дор заах нь суралцагчдыг залхаадаг эсвэл төөрөгдүүлдэг учраас нэг юм уу хоёр гол зарчим дээр төвлөрөх нь үр дүнтэй байдаг (*Teaching, No Greater Call* [1999], 99).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ мэддэг байсан ба тэдний хэн болж чадахыг ч мөн мэддэг байсан. Тэрээр өсөж хөгжихөд нь тэдэнд туслах онцгой арга замуудыг мэддэг байсан. Тэднийг зовж, цөхрөнгөө барахад Тэрээр хэзээ ч тэднийг орхилгүй, харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа. Та залуу эрэгтэйчүүдэд зааж байхдаа тэдний хэн болох мөн хэн болж чадах талаар тунгаан бодож, тэнгэрлэг чадавхаа ашиглахад нь туслах арга замуудыг олох хэрэгтэй.

хүс. Чуулгыг дөрвөн бүлэг болгон хуваарилаад, бүлэг бүрд ерөнхийлөгч Угдорфын “Дөрвөн нэр” хэлсэн үгэн дэх нэг гарчгийг уншихыг даалга. Тэд мөн ахлагч Доналд Л.Холлстромын “Би Бурханы хүүхэд” хэлсэн үгийн аль нэг хэсгийг уншиж болно. Бүлэг бүрээс сурсан зүйлээ мөн энэ нь хэрхэн тэдний амьдралтай холбогдож байгааг чуулгатай хуваалцахыг хүс. Энэ үйл ажиллагааны нэг хэсэг болгон залуу эрэгтэйчүүд “Би Бурханы хүүхэд” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 58-р хуудас) дууллыг дуулж болно.

- Чуулгын гишүүдийг “Бидний жинхэнэ мөн чанар” видео бичлэгийг үзэхэд (эсвэл 1 Иохан 3:1–3;

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэд өөрсдийгөө хэн болохыг мөн хэн болж чадахаа ойлгож байна уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бид бол Бурханы хүүхдүүд гэдэг гэрчлэлээ хуваалцаж мөн энэ гэрчлэл нь түүний үйлдлийг хэрхэн удирдан чиглүүлдэг тухай тайлбарлаж болно.
- Залуу эрэгтэйчүүдийг авьяас бэлгээ ашиглан, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг адислах нэг арга замын тухай бодоход урь.

С ба Г 84:37–38; 88:107; 132:20 гэсэн судруудыг уншихад) мөн тэдэнд чухал санагдсан зүйлсээ бичиж тэмдэглэхэд урь. Өөрсдийн бичсэн зүйлсийг хуваалцан, яагаад үүнийг бичсэн тухайгаа тайлбарлахыг тэднээс мөн хүс. Тэд эдгээр судар, видео бичлэгээс өөрсдийн хэн болох мөн хэн болж чадах талаар юу сурсан бэ? Энэ мэдлэг нь сонголт хийхэд тэдэнд хэрхэн нөлөөлөх вэ? Энэхүү ярилцлагаараа ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн хэлсэн дараах үгийг хуваалцаж болно. “Сайн мэдээний загвар нь биднийг урагш удирдаж, улам агуу амжилтын төлөө бүр дээшээ, бурханлаг байдал руу чиглүүлэхэд оршдог.

Сонгосон материалууд

Дийтр Ф.Угдорф, “Дөрвөн нэр,” Ensign, 2013 оны 5-р сар, 58–60 эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 70–74

Өнөөдөр би та бүхэнд, дэлхий даяарх санваар атгагчдад хамааралтай хэмээн миний итгэдэг дөрвөн нэрний талаар яримаар байна. Эдгээр нэр нь Бурханы мөнхийн төлөвлөгөөнд дэх бидний хувь хүн бүрийн үүрэг болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн санваар атгагчдын хувьд бидний нөөц бололцоог таньж мэдэхэд тусалдаг юм.

Тэнгэрлэг Эцэгийн Хүү

Хамгийн чухал арга замаар бид бүгдийг тодорхойлдог нэг нэр бол *Тэнгэрлэг Эцэгийн хүү*. Амьдралд бид хэн ч байсан, юу ч хийдэг байлаа гэсэн үнэхээр Бурханы сүнсэн хүүхдүүд гэдгээ хэзээ ч мартаж өгсгүй. Бид энэ дэлхийд ирэхээсээ өмнө Түүний хүүхдүүд байсан ба үүрд Түүний хүүхдүүд байх болно. Энэхүү энгийн үнэн нь бидний өөрсдийгөө болон ах, эгч, дүү нараа мөн амьдралыг үзэх үзлийг өөрчлөх ёстой. . . .

Одоо ах нар аа, үүнийг Бурханы төгс төгөлдөр байдалтай харьцуулбал, мөнх бус бид эв дүйгүй хөлд орж байгаа хүүхдээс ялимгүй илүү юм. Гэхдээ бидний хайрт Тэнгэрлэг Эцэг биднийг Өөртэйгөө илүү адилхан болгохыг хүсдэг ба хайрт ах нар минь, бас энэ нь бидний мөнхийн зорилго байх ёстой. Биднийг агшин зуур биш, харин нэг нэг алхам хийн, ахиж дэвшсээр Түүнтэй адилхан болно гэдгийг Бурхан мэддэг. . . .

Есүс Христийн шавь

. . . Христийг чин сэтгэлээсээ дагахыг хүссэн бүхэн Түүний *шавь* хэмээн нэрлэгддэг. Хэдийгээр

бид хэн ч төгс төгөлдөр биш гэдгийг мэддэг ч жишгээ бууруулах, өгөгдсөн боломжоо бүрэн ашиглахгүй байх, нүглээ наманчлахаа хойшлуулах, эсвэл бидний Хаан, Багшийнхаа илүү сайн, төгс, цэвэр ариун дагалдагч болж хөгжихөөс татгалзах шалтгааны улмаас энэ нэрээ ашиглаж чадахгүйд хүрдэг. . . .

Ах нар аа, шавь байна гэдэг нь насан туршдаа Аврагчийг дагах аялал юм. Бидний Бетлехемээс Голгот хүртэлх буюу төрөхөөс үхэх хүртэлх замд шавь байх аялаа зогсоох олон шалтаг гарч ирэх болно. Заримдаа энэ аян зам маань бидний хүсэж байснаас ч их зүйлийг шаардах мэт санагддаг. Гэхдээ санваартан ах бидний хувьд загалмай маань үүрэхэд хүнд байсан ч гэсэн Гэтэлгэгчээ дагах зоригтой байх ёстой. . . .

Сүнсийг эдгээгч

Ах нар аа, хэрвээ бид Их Эзэн Есүс Христийг үнэхээр дагадаг бол бид гурав дахь буюу *сүнсийг эдгээгч* гэдэг нэрийг хүлээн авах ёстой. Бурханы санваарт томилогдсон бид “бусдыг эдгээх”-ээр дуудагдсан (“Lord, I Would Follow Thee,” *Hymns*, дугаар 220).

Бүтээх, засах, хүчирхэгжүүлэх, өргөх, мөн бүрэн бүтэн болгох нь бидний ажил. Бидний үүрэг бол Аврагчийн жишээг даган, тэдгээр зовж шаналсан хүмүүст хүрэх явдал мөн. . . .

Энэ бол Аароны болон Мелкезедек санваартны аль алинд хамаарах санваартан бидний хамгийн анхны мөн хамгийн чухал үүрэг, хариуцлага юм. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ нь биднийг зөвхөн итгэх үед л адисалдаг бус, харин үүгээр амьдрах үед илүү их адисалдаг. . . .

Сонгосон материалууд

Мөнх амьдралыг залгамжлагч

Бидний дөрөв дэх нэр биднийг энэ нэрсийн жагсаалтын маань хамгийн эхэнд аваачна. Бид Тэнгэрлэг Эцэгийн хөвгүүдийн хувьд Түүнд байгаа бүх зүйлийн *өв залгамжлагчид* юм.

“Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг.

Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь бас мөн. Христтэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм” [Ром 8:16–17].

Хайрт ах нар минь, үүнийг бодоод үзээрэй. Бид Христтэй хамт өв залгамжлагчид юм.”

Хоёрдугаар сар: Авралын төлөвлөгөө

“Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу—бөлгөө” (Мосе 1:39).

Авралын төлөвлөгөөг ойлгох нь сүнслэгээр сурахын үндэс суурь юм. Аль нь мөнхийн ач холбогдолтой хийгээд аль нь үгүй вэ гэдгийг ялган салгахын тулд сайн мэдээний талаар болон мөнх бус амьдралын талаар залуу эрэгтэйчүүдийн сурсан бүх зүйл нь авралын төлөвлөгөөний ухагдахуун дээр төвлөрөх ёстой. Залуу эрэгтэйчүүд авралын төлөвлөгөөг жинхэнээр нь ойлгох юм бол илүү агуу зорилготой амьдарна. Тэд зовлон зүдгүүр, саад бэрхшээлээ өсч хөгжих боломж хэмээн харах болно. Тэд сонголт хийхдээ түр зуурын сэтгэл ханамжаас илүү мөнхийн үр нөлөөг харах болно. Тэд аз жаргал, баяр баясгаланг олж чадна.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын дараах тоймыг та энэ бүлэгт оруулан, зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлэхэд миний үүрэг хариуцлага юу вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Авралын төлөвлөгөө гэж юу вэ?

Мөнх бус байдлын өмнөх амьдралд юу тохиолдсон бэ?

Амьдралын зорилго юу вэ?

Хийж буй сонголтууд маань яагаад чухал вэ?

Бидэнд яагаад саад бэрхшээлүүд тулгардаг вэ?

Ойр дотны маань хэн нэгэн нас барахад би тайвшралыг хэрхэн олох вэ?

Би яагаад бие махбодоо ариун сүм шиг байлгах хэрэгтэй вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Санваарын үүргүүд,” 23, 46–47, 70–71-р хуудас

“Христэд ирэхэд бүхнийг урь,” 28–29, 52–53, 76–77-р
хуудас

“Сургаалыг ойлго,” 18–20, 42–44, 66–68-р хуудас



ХОЁРДУГААР САР: АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлэхэд миний үүрэг хариуцлага юу вэ?

Тэнгэрлэг Эцэг маань Өөрийн ажил болон алдар сууг “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) явдал хэмээн хэлсэн. Санваартны хувьд бид өөрсдийгөө зохистой байлгаж, санваарын үүргүүдээ биелүүлснээр Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр үүрэгт санваарын ёслолуудыг гүйцэтгэх, бусдад үйлчлэх, бүгдийг Христэд ирэхэд урих зэрэг нь багтдаг.

Санваарынхаа үүргийг биелүүлж байхад тохиолдсон туршлагаадаа бод. Хичээл зүтгэлийн тань үр дүн юу байсан бэ? Тэнгэрлэг Эцэгийг төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь та хэрхэн тусалсан бэ?

Залуу эрэгтэйчүүдийг санваарынхаа үйлчлэлээр дамжуулан бусдыг адисалж байхыг та хэзээ харсан бэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр материалыг судалж байхдаа Ариун Сүнсийг сонс. Залуу эрэгтэйчүүд үүргээ биелүүлснээр Бурханд хэрхэн туслахад суралцах, үүний тулд юу хийж болохыг тунгаан бод.

Мосе 1:39 (Хүүхдүүдээ өргөмжлөх нь Бурханы ажил мөн алдар суу юм)

С ба Г 20:46–60, 75–79; 84:111; 107:68 (Аароны санваарын үүргүүд)

С ба Г 38:42 (Санваартнууд цэвэр, зохистой байх ёстой)

Видео бичлэг: “Бүгдийг Христэд ирэхийг урих нь”

Видео бичлэг: “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь”

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, 22 (диконы үүргүүд), 46–47 (багш нарын үүргүүд), 70–71 (присгийн үүргүүд)

“Тэргүүн Зөвлөлөөс өсвөр үеийнхэнд өгсөн захиас,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, (2011), ii–iii

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаагаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Залуу эрэгтэйчүүдийг “Тэргүүн Зөвлөлөөс өсвөр үеийнхэнд өгсөн захиас”-ыг уншиж мөн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх үүргээ биелүүлэхэд нь тэдэнд тусалж болох Тэргүүн Зөвлөлийн зөвлөгөөг олж мэдэхэд урь. Санваарын үүргүүд эдгээр үүрэгт нь хэрхэн тусалдаг вэ?
- Баптисм хүртээгч Иоханы зургийг үзүүл (Сайн мэдээний уран зургийн цуглуулга, 35-ыг үз), тэгээд тэр Аврагчийн замыг бэлтгэхийн тулд юу хийснийг асуу (Матай 3-ыг үз). Чуулгын гишүүдээс санваарынхаа үүргийг гүйцэтгэж байхдаа Аврагчийн эргэн ирэх замыг хэрхэн бэлтгэж байгааг нь асуу.

Хамтдаа суралц

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөөнүүд

Чуулгын цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ хийсэн төлөвлөгөөгөө бичих цаг гарга.

Доорх үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдийг санваарын үүрэг бүрээ биелүүлэх нь Тэнгэрлэг Эцэгийг төлөвлөгөөгөө биелүүлэхэд хэрхэн тусалдгийг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Залуу эрэгтэй бүрийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын “Санваартны үүргүүд” хэсгээс (22, 46–47, 70–71-р хуудас) үйлдлийг заасан үг, хэлц үгсийг олж, доогуур нь зурахад урь. Залуу эрэгтэйчүүдээс Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлэхэд үүрэг бүр хэрхэн тусалж байгааг тайлбарлахыг хүс. Залуу эрэгтэйчүүд бусдын санваарын үйлчлэлээр дамжуулан хэрхэн адислагдсан бэ? Бусдын санваарын үйлчлэлээр адислагдсан ямар жишээг тэд харсан бэ?
- Чуулгаараа Сургаал ба Гэрээ 20:46–60-ыг давт. Залуу эрэгтэйчүүдийг гэр бүлийн гишүүн хийгээд найз нөхдөө оролцуулан бусдыг Христэд ирэхэд урих үүргээ хэрхэн биелүүлсэн туршлагаасаа хуваалцахыг урь. Тэд Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлэхэд хэрхэн тусалж байна вэ? Тэднийг сайн мэдээг хуваалцах боломжуудыг үзүүлсэн жүжигчилсэн тоглолт хийхэд урь. Жишээлбэл: “Найз чинь чамаас яагаад ням гарагт хөл бөмбөг тоглодоггүй мөн кофе

юмуу цай уудаггүйг асууж байна.” Хэрэв тэдний зорилго сайн мэдээг хуваалцах байсан бол тэд найзынхаа асуултанд хэрхэн хариулж болох вэ? *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо хуудас 29, 51, 73 руу хандаад сурсан зүйл дээрээ үндэслэн төлөвлөгөө гаргахад урь.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдийн нэгийг юмуу хоёуланг үзүүл. Залуу эрэгтэйчүүдээс видео бичлэгт санваарын ямар

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаар хуваалцахыг хүс. Тэд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхэд өөрсдийнх нь үүрэг юу болохыг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бусад чуулгын гишүүд санваарын үйлчлэлээр дамжуулан Бурханы төлөвлөгөөг биелүүлэхэд тусалж байгааг харсан жишээнүүдээс хуваалцаж болно.
- Чуулгынхаа гишүүдийн хамт санваарын үүргээ илүү сайн биелүүлэхэд юу хийж чадах талаараа зөвлөлд.

үүргүүдийг үзүүлсэн хийгээд санваарын үүргүүд нь Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлэхэд хэрхэн тусалж болохыг олж мэдэхийг хүс (санваарын үүргүүдийн товчлолыг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын хуудас 22, 46–47, 70–71-ийг үз). Тэд эдгээр үүргээ биелүүлж байхдаа ямар туршлагуудыг олж авсан бэ? Үүргээ биелүүлэх нь Бурханы төлөвлөгөө гүйцэлдэхэд тусалдгийг ойлгох нь яагаад чухал вэ? Энэ ойлголт тэднийг үүргээ биелүүлэх байдалд хэрхэн нөлөөлөх вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нарынхаа төлөө залбирч, тэдэнд үргэлжлүүлэн үйлчилж байлаа. Тэрээр тэдэнтэй хамт байх боломжийг ямагт олж мөн тэдэнд хайраа илэрхийлдэг байлаа. Танд Аароны санваартан нэгэнтэй хамт санваарын үйлчлэл хийх боломж олон гарах болно. Эдгээр мөчид таны хийж байгаа зүйлс Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөө биелэгдэхэд хэрхэн тусалж байгааг хуваалц.



Авралын төлөвлөгөө гэж юу вэ?

Тэнгэрлэг Эцэг биднийг Өөртэй нь адилхан болгох төлөвлөгөө бэлдсэн. Авралын төлөвлөгөөнд Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, түүнчлэн сайн мэдээний бүх хууль, ёслол, сургаалууд багтдаг. Энэ төлөвлөгөө нь биднийг Цагаатгалаар дамжуулан төгөлдөржиж, бүрэн дүүрэн баяр баясгаланг хүлээн авч мөн Бурхантай хамт мөнхөд амьдрахыг боломжтой болгодог.

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг мэдэх нь энэ амьдрал дахь таны сонголтуудад хийгээд хэтийн төлөвт хэрхэн нөлөөлж байна вэ? Авралын төлөвлөгөөний аль хэсгийг та илүү их сурахыг хүсч байна вэ?

Авралын төлөвлөгөөний тухай ойлголт нь чуулгын гишүүдийг санваарын үүргээ илүү сайн биелүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалуудыг залбиралтайгаар уншаарай. Юу залуу эрэгтэйчүүдийг авралын төлөвлөгөөг ойлгоход туслах вэ?

1 Коринт 15:20–22 (Бүх хүмүүс үхнэ) Алма 40:11–14 (Хүмүүсийн үхлийн дараах байдал)

Еврей 12:9 (Бурхан бол бидний сүнсэн Эцэг)

С ба Г 76:30–113 (Алдар суугийн хаант улсуудын тодорхойлолт)

Илчлэлт 20:12–13; 2 Нифай 9:10–11; Алма 5:15–21 (Бүх хүмүүн амилж, Бурханы шүүлтийн өмнө зогсоно)

Томас С.Монсон, “Амьдралын Уралдаан,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 90–93

2 Нифай 2:22–25 (Адамын уналт нь мөнх бус байдлыг авчирсан)

“Авралын төлөвлөгөө,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 9–12

Алма 34:32–33 (Энэ амьдрал бол наманчлах цаг юм)

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдийг өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа нэг үг буюу хэлц үгийг бичээд, түүнийгээ чуулгынхантайгаа хуваалцахыг урь.
- Бүтээлт, Уналт, Цагаатгалыг төлөөлсөн гурван зураг эсвэл

төлөөлөн орлож болох зүйлсийг авчир (жишээ нь Бүтээлтийг төлөөлүүлэн шавар, Уналтанд алим, Цагаатгалд ариун ёслолын аяга байж болно). Залуу эрэгтэйчүүдээс эдгээр үйл явдлуудын талаар юу мэдэх хийгээд тэдэнд яагаад чухал болохыг хуваалцахыг хүс.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр чуулгын гишүүдийг авралын төлөвлөгөөний тухай сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахыг урь. Тэр авралын төлөвлөгөөний тухай сурч, заахыг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлго” хуудас 18, 42, 66-г үз).
- Хэдэн өдрийн өмнө урьдчилаад чуулгын хэдэн гишүүдийг авралын төлөвлөгөөний аль нэг хэсгийг (мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус амьдрал, сүнсний дэлхий гэх мэт) ангид заахаар *Миний сайн мэдээг номло* юмуу *Итгэлдээ үнэнч байх нь номноос бэлдэж ирэхийг хүс*. Авралын төлөвлөгөөг төлөөлсөн дүрслэлийг самбар дээр зураад (жишээлбэл, *Миний сайн мэдээг номло*, 59), залуу эрэгтэй бүрийг өөрсдийн дааж авсан сэдвээ заахад урь. Залуу эрэгтэйчүүдээс авралын төлөвлөгөөний тухай мэдэх нь

тэдний амьдралд ямар өөрчлөлтийг бий болгож байгааг асуу.

- Энэ тоймд байгаа судрын нэг юмуу хэд хэдэн хэсгээс уншихыг залуу эрэгтэй бүрд даатга. Түүнээс өөрийнхөө хэсгийг уншаад, энэ нь авралын төлөвлөгөөний аль хэсгийг зааж байгааг тодорхойлохыг хүс. Түүнийг өөрийн уншсан хэсгээс юу сурснаа хуваалцахыг урь. Авралын төлөвлөгөөний тухай мэдэх нь бидний өөрсдийгөө харах байдалд хэрхэн нөлөөлдөг вэ? бусдыг? бидний эргэн тойронд байгаа дэлхийг?
- Чуулгаараа Алма 12:30 болон Алма 42:13–15-ыг унш. Залуу эрэгтэйчүүдийг авралын төлөвлөгөөг дүрслэхэд ашигласан үг хэллэгийг олохыг урь. Эдгээр үг хэллэгүүд нь төлөвлөгөөний тухай юу заадаг вэ? “Хүмүүсийн зүрх сэтгэл тэднийг сүйрүүлэх болно,” видео бичлэгийг

Заахад туслах арга

“Таны сүнслэг бэлтгэл сурах уур амьсгалыг илүү сайн бүрдүүлэхэд тусалдаг. Та сүнслэгээр бэлтгэгдсэн байх юм бол амар амгалан, хайр болон хүндэтгэл бишрэлийн сүнсийг авчирна. Таны зааж байгаа хүмүүс мөнхийн үнэ цэнэтэй зүйлсийн тухай эргэцүүлж, ярилцахдаа илүү амар амгаланг мэдэрнэ” (*Teaching, No Greater Call* [1999], 79).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч зааж байсан хүмүүстээ гүнзгий тунгаан бодох асуултуудыг тавьдаг байсан. Тэр тэдний хариултыг чин сэтгэлээсээ сонирхдог байв. Та залуу эрэгтэйчүүдийг сайн мэдээний үнэний тухай гүнзгий тунгаан бодоход тусалж чадах асуултуудыг хэрхэн ашиглаж чадах вэ?

үзүүлээд, залуу эрэгтэйчүүдээс авралын төлөвлөгөөний тухай мэдлэг ахлагч Рассэл М.Нэлсонг хэрхэн адисалсныг асуу. Залуу эрэгтэйчүүдийг энэ мэдлэг нь тэднийг хэрхэн адисалсан арга замуудыг хуваалцахыг урь.

- Чуулга дахь бүх гишүүд *Итгэлдээ үнэнч байх нь* номтой эсэхийг шалгаад, залуу эрэгтэй бүрд нэгээс гурвын хоорондох дугаарыг өг. Нэг гэсэн дугаарыг хүлээн авсан залуу эрэгтэйчүүдийг *Итгэлдээ үнэнч байх нь* номын мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай (хуудас 10); хоёр дугаартай залуу эрэгтэйчүүдийг мөнх бус амьдралын тухай (хуудас 11); мөн гурав дугаарыг авсан залуу эрэгтэйчүүдийг үхлийн дараах амьдралын тухай (хуудас 11) чадах бүхнээ сурахыг хүс.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаар хуваалцахыг хүс. Тэд авралын төлөвлөгөөг илүү сайн ойлгодог болсон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Авралын төлөвлөгөөг ойлгох нь хэрхэн биднийг илүү сайн санваартан байхад урамшуулдаг тухай ярилцлагыг удирд.
- Чуулгын гишүүдийг авралын төлөвлөгөөний талаарх талархалаасаа хуваалцахыг хүс.

Авсан дугаарынхаа дагуу бүлгүүд болж ажиллан, сурсан зүйлсийнхээ талаар товч дүгнэлтийг бэлтгэж, чуулгынхаа бусад гишүүдэд танилцуулахыг тэднээс хүс. Залуу эрэгтэйчүүдээс авралын төлөвлөгөөний тухай мэдлэг тэдэнд байхгүй бол амьдрал нь ямар байхыг төсөөлөхийг хүс.

- Залуу эрэгтэйчүүдээс ерөнхийлөгч Томас С.Монсоны “Амьдралын уралдаан” хэлсэн үг болон судруудыг ашиглан дараах асуултуудын нэгэнд хариулт бэлтгэхийг хүс: Бид хаанаас ирсэн бэ? Бид яагаад энд байгаа вэ? Энэ амьдралын дараа бид хаашаа явах вэ? Тэднийг өөрсдийнхөө хариултыг өөр итгэлтэй найздаа ярьж байгаа мэтээр хариулахыг хүс. Эдгээр асуултуудын хариултуудыг мэдэх нь яагаад чухал вэ?

Сонгосон материалууд

“Авралын Төлөвлөгөө”-нөөс эш татав. Итгэлдээ үнэнч байх нь (2004), 115–17

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Дэлхийд мэндлэхээсээ өмнө та Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд Түүний сүнсэн хүүхдүүдийн нэг болон амьдарч байсан. Энэхүү мөнх бус байдлын өмнөх амьдралд та Тэнгэрлэг Эцэгийн бусад сүнсэн хүүхдүүдийн хамтаар зөвлөгөөнд оролцсон. Зөвлөгөөнөөр Тэнгэрлэг Эцэг Өөрийн аз жаргалын агуу төлөвлөгөөг танилцуулсан юм (Абрахам 3:22–26-г үз).

Аз жаргалын төлөвлөгөөнд нийцүүлэн мөнх бус байдлын өмнөх Есүс Христ, Эцэгийн Сүнснүүдийн Анхны Хүү нь Аврагч байхаар гэрээ байгуулсан юм (Моисе 4:2; Абрахам 3:27-г үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагасан хүмүүст дэлхий дээр ирж мөнх бус байдлын туршлага эзэмшин, өсч хөгжин, улмаар мөнх амьдралд хүрэх боломжийг олгосон юм. Бурханы өөр нэг хүү, Люцифер тэрхүү төлөвлөгөөний эсрэг босч, “хүмүүний эрхийг эрэлхийлсэн” юм (Моисе 4:3). Тэрээр Сатан болж, дагалдагчдынхаа хамт тэнгэрээс хөөгдсөнөөр, бие махбодтой болж, мөнх бус байдлын туршлагыг эзэмших боломжгүй болсон юм (Моисе 4:4; Абрахам 3:27–28-г үзнэ үү).

Мөнх бус байдлын өмнөх амьдралд та өөрийгөө таньж хөгжүүлсэн мөн сүнсэлг чадвар бололцоогоо нэмэгдүүлсэн. Сонгох эрхийн бэлгээр адислагдсан бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг

дагах зэрэг чухал шийдвэрүүд гаргасан. Эдгээр шийдвэр нь тэр үед таны амьдралд нөлөөлсөн бөгөөд одоо ч мөн адил нөлөөлдөг. Таны мэдлэг чадвар өсч, үнэнийг эрэлхийлэхэд суралцсан бөгөөд та өсөлт хөгжилтөө цааш нь үргэлжлүүлж болох энэ дэлхийд ирэхээр бэлтгэсэн юм.

Мөнх бус амьдрал

Та одоо мөнх бус амьдралаар амьдарч байна. Таны сүнс бие махбодтой нэгдсэнээр, мөнх бус байдлын өмнөх амьдралд бидэнд боломжгүй байсан арга замаар өсч, хөгжих боломж танд нээгдсэн юм. Оршин байх энэхүү хэсэг бол Христэд ирэхээр сонгож, мөнхийн амьдралын төлөө зохистой байхаар бэлтгэж, өөрийгөө нотлон харуулахад суралцах цаг хугацаа юм. Түүнчлэн энэ нь үнэнийг олох, авралын төлөвлөгөөний талаар гэрчлэлтэй болоход нь бусдад тусалж чадах танд зориулсан цаг хугацаа мөн.

Үхлийн дараах амьдрал

Таныг нас барахад сүнс тань сүнсний дэлхийд очиж, амилуулалтыг хүлээдэг. Амилуулалтын үед таны сүнс, бие хоёр эргэн нэгдэж мөн та шүүгдэж, алдар суугийн хаант улсад орох болно. Таны өвлөн авах алдар суу таны хөрвөлтийн байдал болон Их Эзэний зарлигуудад хэр зэрэг дуулгавартай байснаас хамаарах болно. Энэ нь “Есүсийн гэрчлэлийг хүлээн авсан” төлөв байдлаас хамаарна (С ба Г 76:51; мөн 74, 79, 101-ийг үзнэ үү).



Мөнх бус байдлын өмнөх амьдралд юу тохиолдсон бэ?

Бид төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгтэйгээ амьдарч байсан. Бид Түүний сүнсэн хүүхдүүд юм. Тэнгэрт болсон зөвлөлгөөнд Эцэг маань бидэнд Өөрийн авралын төлөвлөгөө болон Есүс Христ бидний Аврагч байхаар сонгогдсоныг танилцуулсан билээ. Сатан бидний сонгох эрхийг үгүй хийснээр төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахыг эрэлхийлсэн бөгөөд тэр дагалдагч нартайгаа хөөгдсөн юм. Бид Эцэгийнхээ төлөвлөгөөг хүлээн авч Есүс Христийг дагахаар сонгосон.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судрууд болон суралцах материалуудыг залбиралтайгаар судал. Та чуулгынхаа цуглаанд юу хуваалцмаар санагдсан бэ?

Иеремиа 1:5; Алма 13:3 (Санваартнууд дэлхий эхлэхээс өмнө дуудагдаж, сонгогдсон)

Илчлэлт 12:9–11; Мосе 4:1–4 (Сатан хүмүүний сонгох эрхийг устгахыг эрэлхийлснээр хөөгдсөн)

Абрахам 3:22–26 (Бидний өмнөх амьдралд хийсэн сонголт биднийг дэлхий дээр ирэх боломжтой болгосон)

“Авралын төлөвлөгөө,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 9-12

Амьдралдаа хийсэн сонголтуудынхаа тухай бод. Эдгээр сонголтуудад тань таны мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай мэдлэг хэрхэн нөлөөлсөн бэ? Таны сонголтууд мөнхийн хувь тавиланд тань хэрхэн нөлөөлөх вэ?

Залуу эрэгтэйчүүд амьдралыг нь мөнхөд адислах ямар сонголтуудыг одоо хийж байна вэ? Ямар сонголтууд тэдний мөнхийн хувь тавиланд эсрэгээр нөлөөлөх вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдийг өнгөрсөн долоо хоногийн цуглаанаас санаж байгаа судраа хуваалцахыг урь. Тэднийг үүнээс юу сурсан тухайгаа ярихыг хүс.
- Залуу эрэгтэйчүүдээс өмнө нь хийсэн аливаа зөв сонголтууд болон

эдгээр шийдвэр нь тэдний амьдралыг хэрхэн адисалсан тухай бодож, хуваалцахыг хүс. Тэгээд тэднээс төрөхөөсөө өмнө хийсэн сонголт нь юу байсныг нэрлэхийг хүс. Энэ сонголт тэдний амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр чуулгын гишүүдийг мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэй бүрийг дараах судраас нэгийг уншихыг хүс: Иеремиа 1:5; Алма 13:3; Абрахам 3:22–23. Залуу эрэгтэйчүүдийг эдгээр судруудаас мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай сурдаг үнэнүүдийг олохыг урь. Мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай үнэнүүд нь бидний мөнх бус амьдралыг харах байдалд хэрхэн нөлөөлөх вэ?
- Залуу эрэгтэйчүүдээс мөнх бус амьдралд хүмүүст тохиолддог зарим сорилтуудыг жагсаахыг хүс. Тэднийг мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай *Итгэлдээ үнэнч байх нь* номноос уншаад (хуудас 13–14), эдгээр сорилтуудтай учирсан хүмүүст туслах үнэнүүдийг олоход урь. Тэднийг олсон зүйлээ хуваалцахыг урь. Залуу эрэгтэйчүүдээс

эдгээр үнэнүүдийг мэдэх хэрэгтэй хэн нэгний тухай бодохыг хүсээд, тэдэнд авралын төлөвлөгөөний тухай гэрчлэлээ хуваалцах аргуудыг бодоход урамшуул.

- Залуу эрэгтэйчүүдээс Мосе 4:1–2-ыг уншаад Тэнгэр дэх зөвлөлгөөнөөс Аврагч, Сатан хоёрын тухай сурсан зүйлүүдээ олохыг хүс. Шүлэг 3–4-өөс бид Сатаны үйлдлийн үр дүнгийн талаар юу сурдаг вэ? Энэ зөрчилдөөн өнөөдөр дэлхий дээр хэрхэн үргэлжилж байгаа вэ? Энэ зөрчилдөөн дэх Аврагчийн үүрэг юу вэ? Бидний үүрэг юу вэ? Залуу эрэгтэйчүүдийг Аврагч болон Эцэгийнхээ төлөвлөгөөг дагах Түүний хүслийн талаарх сэтгэгдлээ илэрхийлэхийг урь.

Заахад туслах арга

“Маргаан дэгдээх буюу эмзэг сэдвүүдийг хөндсөн асуултуудыг асуухгүй байхад анхаар. Эргэлзээг бий болгох юмуу засахын аргагүй ярилцлага руу хөтлөх асуултуудыг бүү асуу. Таны асуултууд суралцагчдыг итгэл болон хайрын нэгдмэл байдал руу хөтлөх хэмжээнд байхад анхаар” (*Teaching, No Greater Call* [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа ойлгуулахын тулд энгийн түүхүүд, сургаалт зүйрлэлүүд болон амьдралд тохиолдсон жишээнүүдээс хуваалцаж байлаа. Энэ хичээл нь амьдралыг тань өөрчилсөн сонголтуудынхаа жишээнүүдээс хуваалцах боломжийг танд олгох болно. Залуу эрэгтэйчүүд ямар туршлагауд хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд мөнх бус байдлын өмнөх амьдралыг илүү сайн ойлгодог болсон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ангийн гишүүдээс хичээлийн үед төрж байсан бодол санаа, сэтгэгдлээ хуваалцахыг урь. Тэдний гэр бүл эсвэл чуулгыг адислах юуг хийхээр тэд сүнслэгээр өдөөгдсөн бэ?
- Заагдсан зүйлийн тухай гэрчлэлээ хуваалц.

Сонгосон материалууд

“Авралын Төлөвлөгөө”-нөөс эш татав. Итгэлдээ үнэнч байх нь (2004), 115–17

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Дэлхийд мэндлэхээсээ өмнө та Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд Түүний сүнсэн хүүхдүүдийн нэг болон амьдарч байсан. Энэхүү мөнх бус байдлын өмнөх амьдралд та Тэнгэрлэг Эцэгийн бусад сүнсэн хүүхдүүдийн хамтаар зөвлөгөөнд оролцсон. Зөвлөгөөнөөр Тэнгэрлэг Эцэг Өөрийн аз жаргалын агуу төлөвлөгөөг танилцуулсан юм (Абрахам 3:22–26-г үз).

Аз жаргалын төлөвлөгөөнд нийцүүлэн мөнх бус байдлын өмнөх Есүс Христ, Эцэгийн Сүнснүүдийн Анхны Хүү нь Аврагч байхаар гэрээ байгуулсан юм (Моисе 4:2; Абрахам 3:27-г үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагасан хүмүүст дэлхий дээр ирж мөнх бус байдлын туршлага эзэмшин, өсч хөгжин, улмаар мөнх

амьдралд хүрэх боломжийг олгосон юм. Бурханы өөр нэг хүү, Люцифер тэрхүү төлөвлөгөөний эсрэг босч, “хүмүүний эрхийг эрэлхийлсэн” юм (Моисе 4:3). Тэрээр Сатан болж, дагалдагчдынхаа хамт тэнгэрээс хөөгдсөнөөр, бие махбодтой болж, мөнх бус байдлын туршлагыг эзэмших боломжгүй болсон юм (Моисе 4:4; Абрахам 3:27–28-г үзнэ үү).

Мөнх бус байдлын өмнөх амьдралд та өөрийгөө таньж хөгжүүлсэн мөн сүнслэг чадвар бололцоогоо нэмэгдүүлсэн. Сонгох эрхийн бэлгээр адислагдсан бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагах зэрэг чухал шийдвэрүүд гаргасан. Эдгээр шийдвэр нь тэр үед таны амьдралд нөлөөлсөн бөгөөд одоо ч мөн адил нөлөөлдөг. Таны мэдлэг чадвар өсч, үнэнийг эрэлхийлэхэд суралцсан бөгөөд та өсөлт хөгжилтөө цааш нь үргэлжлүүлж болох энэ дэлхийд ирэхээр бэлтгэсэн юм.



Амьдралын зорилго юу вэ?

Энэ амьдралдаа бид бие махбодыг хүлээн авч Бурханы зарлигуудыг дагах эсэхээ харуулахаар соригддог. Мөнх бус байдал дахь сорилт бэрхшээлүүд нь биднийг Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адилхан болоход туслахын тулд өгөгдсөн.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Танд чуулгатай юу хуваалцамаар санагдсан бэ?

Та хэрхэн энэ амьдралд баяр баясгаланг олдог вэ? Ямар туршлагууд танд сүнслэгээр өсөхөд тусалсан бэ?

Залуу эрэгтэйчүүд Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адилхан болохын тулд юу хийж байна вэ?

2 Нифай 2:25 (Бид баясгалантай байхын тулд бүтээгдсэн)

Алма 12:24; 34:32; 42:4 (Энэ амьдрал бол соригдох, мөн Бурхантай уулзахдаа бэлтгэх цаг юм)

3 Нифай 12:3–12 (Аврагч хэд хэдэн бурханлаг зан чанарыг нэрлэв)

3 Нифай 12:48 (Тэнгэрлэг Эцэг биднийг Өөр шигээ төгс болохыг хүсдэг)

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11 сар, 129

Томас С.Монсон “Гэрийнхээ зүг аюулгүй удирдагдах нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 67-69

Дийтр Ф.Угдорф, “Харууслууд ба шийдвэрүүдийн талаар,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 11-р сар, 21–24

Гари И.Стивэнсон, “Таны дөрвөн минут,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 84–86

“Авралын төлөвлөгөө,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 115–116

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр юу сурснаа хуваалцахыг хүс. Хичээл тэдний амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Сурсан зүйл нь тэдэнд юуг өөрөөр хийхэд тусалсан бэ? Тэдний хийсэн үйлдлээс ямар адислалууд ирсэн бэ?
- Дунд хэсэгт нь зангидсан уяаг үзүүл. Зангилаа нь энэ амьдралыг, зангилааны нэг талд байгаа хэсэг мөнх бус байдлын өмнөх амьдралыг, харин үлдсэн хэсэг тэр чигээрээ мөнх бус байдлын дараах амьдралыг илэрхийлж байгааг тайлбарла. Чуулгын цуглааны үед үүнийг үзүүлэн таниулах материал болгон ашиглаж болно.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд амьдралын зорилгын талаар суралцахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Залуу эрэгтэйчүүдийг энэ агуулгын дагуу судраа судлаад, мөнх бус байдлын зорилгын талаар юу сурснаа хуваалцахад урь (тэд мөн *Итгэлдээ үнэнч байх нь*, 115–116–р хуудаснаас хайж болно). Энэ зорилгыг мэдэх нь хэрхэн тэдний хийх сонголтуудад нөлөөлөх вэ?
- Залуу эрэгтэйчүүдийг 3 Нифай 12:3–12 дээрх ерөөлүүдийг уншаад, Тэнгэрлэг Эцэгийн биднээс мөнх бус амьдралынхаа турш хөгжүүлэхийг хүсэж байгаа зан чанаруудыг олж мэдэхийг хүс. Эдгээр зарчмыг хэрэгжүүлдэг өөрийн мэддэг хүмүүсийг эсвэл судар дээрх хүмүүсийн тухай бодохыг тэднээс хүс. 3 Нифай 12 дээрх Аврагчийн заасан сургаалууд нь хэрхэн Бурханы хөвгүүдийн хувьд өөрсдийн зорилгыг ойлгоход бидэнд тусалдаг вэ?
- Залуу эрэгтэй бүрд “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” эсвэл ерөнхийлөгч Томас С.Монсоны “Тэрийнхээ зүг аюулгүй удирдагдах нь” хэлсэн үгийн хувийг тарааж өг. Чуулгын гишүүдээс унших зуураа Бурханы хөвгүүдийн хувьд амьдралынх нь зорилгын талаар тэдэнд зааж буй үг хэллэгүүдийг тэмдэглэж авахыг хүс. Залуу эрэгтэйчүүдээс тэмдэглэсэн үгсээ хуваалцаж, яагаад энэ нь тэдний хувьд ийм утга учиртай байгааг тайлбарлахыг хүс.
- Залуу эрэгтэй бүрийг ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Харуусал ба шийдвэрүүдийн талаар” хэлсэн

Заахад туслах арга

“Суралцагчдын анхаарлыг хичээлд хандуулахын тулд нүдээрээ харьцах аргыг хэрэглэ. Та тэдний нүд рүү хараад заахад, таны анхаарал хичээлийн материалд бус харин зааж байгаа хүмүүс дээр төвлөрөх болно. Тэднийг сэтгэгдлээ хуваалцаж, асуулт тавьж байхад нүд рүү нь харж сонсох нь тэдний ярьж байгаа зүйл танд сонирхолтой байгааг мэдэхэд тэдэнд тусалдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 71).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нараа гэрчлэхэд урьсан. Жишээлбэл, Тэр шавь нараасаа “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” гэж асуусан. (Матай 16:15). Та залуу эрэгтэйчүүдээс сүнслэг асуултууд асууснаар тэдний хариултууд гэрчлэлээ хуваалцах боломжууд болж болно.

үгэнд дурдагдсан харууслуудын нэгний талаар уншихыг хүс. Өөр харууслын талаар уншсан хэн нэгийг чуулгаасаа олохыг түүнээс хүс. Тэднийг сурсан зүйлсээ бие биетэйгээ хуваалцахад урьж, цөөн хэдэн залуу эрэгтэйг чуулгын гишүүдтэй хуваалцахад урь. Эдгээр харууслыг өөрсдийнхөө амьдралд байлгахгүйн тулд тэд юу хийх хэрэгтэйг бодож үзэхийг тэднээс хүс.

- Чуулгын хагасыг бишоп Гари И.Стивэнсоны “Таны дөрвөн минут” хэлсэн үгэн дэх Ноэлл

Пикус-Пэйсийн талаар, нөгөө хагасыг энэ хэлсэн үгэн дэх Тора Брайтын талаар уншихыг хүс. Эдгээр түүхээс амьдралын зорилгын талаар сурсан зүйлсээ бие биетэйгээ хуваалцахыг тэднээс хүс. Бишоп Стивэнсоны хэлсэн үгийн үлдсэн хэсгийг уншаад, ирээдүйнхээ чухал ёслолуудад эсвэл амьдралынхаа хамгийн чухал үед буюу “дөрвөн минутандаа” хэрхэн бэлдэж байгаа талаар тунгаан бодох цөөн хэдэн минутыг залуу эрэгтэйчүүдэд өг. Залуу эрэгтэйчүүдийн заримыг бодлоо хуваалцахад урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлсийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд амьдралын зорилгыг илүү сайн ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно. Тэрээр:

- Заагдсан зүйлийн талаар гэрчлэлээ хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдийг чуулгын цуглааны турш хүлээн авсан аливаа сэтгэгдэл дээрээ үйлдэхэд нь урамшуулан дэмжиж болно.

ГЭР БҮЛ ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба арванхоёр төлөөлөгчийн зөвлөлийнхөн бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бүх хүн төрөлхтөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрлэг Эцэг Эхийн хайртай сүнслэг охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралд сүнслэг охид хөвгүүд Бурханы Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширч, мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвсхийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүддээ “өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээсэн зарлиг нь хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал, түүний ач холбогдлын чухлыг бид батлан хэлж байна.

Эхнэр нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв

юм” (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлд төрж, гэрлэлтийн тангарагаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж, хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Хувь хүн тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөлдөө шаардлагатай үед туслан дэмжих ёстой.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө очиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замуудыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг 1995 оны 9 сарын 23-нд Юта мужийн Солт Лейк хотноо болсон Ерөнхий Нийгмийн Халамжийн бүлгийн чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.



Яагаад хийж буй сонголтууд маань чухал вэ?

Тэнгэрлэг Эцэг бидэнд өөрсдийнхөө төлөө сонгож, үйлдэх чадварыг буюу ёс суртахууны сонгох эрхийг өгсөн билээ. Бид сонголт хийх эрх чөлөөтэй ч сонголтынхоо үр дагаврыг сонгож чадахгүй юм. Зөв сонголт нь удаан үргэлжлэх аз жаргал, мөнх амьдрал руу хөтөлнө. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгээс асуувал, Тэр бидэнд ухаалаг сонголт хийхэд тусална.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч, судал. Та залуу эрэгтэйчүүдэд ухаалаг сонголт хийхийн чухал ач холбогдлыг ойлгоход юу тусална гэж бодож байна вэ?

Амьдралдаа гаргасан маш чухал шийдвэрүүдээ тунгаан бод. Танд болон бусдад эдгээр шийдвэр хэрхэн нөлөөлсөн бэ? Та тэднээс юу сурсан бэ?

Та залуу эрэгтэй бүрийн төлөө залбирахдаа тэдний хийж байгаа шийдвэрүүдийг эргэцүүлэн бод. Тэдгээр шийдвэр нь одоо болон ирээдүйд тэдэнд хэрхэн нөлөөлөх вэ?

Иошуа 24:15 (Бид Их Эзэнд үйлчлэхийг сонгож болно)

Иохан 14:15 (Бидний сайн сонголтууд Тэнгэрлэг Эцэгээ гэсэн хайр, хүссэнийг нь биелүүлэхсэн гэсэн бидний хүслийг харуулдаг)

2 Нифай 2:16, 27; Хиламан 14:30–31 (Бид өөрсдийнхөө төлөө сонгож мөн үйлдэх эрх чөлөөтэй)

Моронай 7:14–15 (Сайн, муугийн хооронд шүүх нь бидэнд өгөгдсөн болно)

Томас С.Монсон, “Сонголтууд,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 69

Даллин Х.Өүкс, “Тариачны сургаалт зүйрлэл,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 16–19

Рассэлл М.Нэлсон, “Мөнхийн ач холбогдолтой шийдвэрүүд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 11-р сар, 106–109

Д.Тодд Кристоффэрсон, “Үүрд чөлөөт байж, өөрсдийнхөө төлөө үйлд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 11-р сар, 16–19

Рандалл Л.Ридд, “Сонгогдсон үеийнхэн,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар, 56–58

“Сонголт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 12–13

“Сонгох эрх ба хариуцлага,” болон “Хөгжим ба бүжиг,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2001), 2–3, 22–23

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар

(судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Нэг саваан дээр “Сонголт,” нөгөө саваан дээр “Үр дагавар” гэж бичээд, хийсэн сонголт бүр үр дагавартай гэдгийг үзүүлэхэд ашигла (зарим үед эерэг, зарим үед сөрөг). Та нэг залуу эрэгтэйд учирч болох сонголтын талаар дүрслэн хэлэхдээ,

түүнээс савааг барихыг хүс. Уг залуу эрэгтэй тэрхүү сонголтын үр дагаврыг дүрслэн хэлж болно. Сонголт маань бидний амьдрал, гэр бүл, санваарын үйлчлэлд хэрхэн нөлөөлж болохыг ярилц.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд сонгох эрхийн тухай сургаалыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Чуулгын нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэр үүнийг сонгох эрхийн тухай сурч, заа хэмээх Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ нэг хэсэг болгон хийж болно (“Сургаальг ойлго,” 18, 42 юм уу 66-р хуудас).

- Залуу эрэгтэй бүрийг “Сонгох эрх ба хариуцлага” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос дор бүрнээ уншиж, өөрт нь нөлөөлсөн хэсгээс хуваалцахад урь. Үүний дараа чуулгын гишүүд уг номноос өөр нэг жишгийг сонгож аваад, энэ жишигтэй хамааралтай өөрсдийн хийсэн сонголт, эдгээрээс ирсэн адислалуудыг хуваалцаж болно.

Жишээ нь тэд “Хөгжим ба бүжиг” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номноос уншиж, зохисгүй хөгжим ба бүжгээс зайлсхийх зөвлөгөөг дагаснаар хүлээн авсан адислалуудаа хуваалцаж болно.

- Залуу эрэгтэй бүрд ахлагч Даллин Х.Өүксийн “Тариачны сургаалт зүйрлэл” эсвэл ерөнхийлөгч Томас С.Монсоны “Сонголтууд” хэлсэн үгсийн хэсгээс өг. Залуу эрэгтэйчүүдийг дор бүрнээ уншаад, дараа нь гүн сэтгэгдэл төрүүлсэн зүйлсийг хуваалцахад урь. Тэд үүнийг жижиг бүлгүүдэд хуваагдан эсвэл чуулгаараа хийж болно. Тэд бидний итгэл үнэмшил ба үйлдлийн үр дагаврын

Заахад туслах арга

“Таныг асуулт тавьсны дараа суралцагчид хэдэн секунд чимээгүй байвал санаа зовох хэрэггүй. Өөрийнхөө асуултад өөрөө бүү хариул, харин суралцагчдад хариултаа бодох хугацаа өг. Хэдий тийм ч, хэт удаан дуугүй байх нь тэднийг асуултаа ойлгоогүйг илэрхийлж байгаа тул та асуултаа өөрчлөн дахин тавих хэрэгтэй (*Teaching, No Greater Call* [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа ойлгуулахын тулд энгийн түүх, сургаалт зүйрлэл, амьдралын бодит жишээ-нүүдээс хуваалцдаг байлаа. Энэ хичээл нь амьдралыг тань өөрчилсөн сонголтуудынхаа жишээнүүдээс хуваалцах боломжоор таньг хангах болно. Залуу эрэгтэйчүүд ямар туршлагаудыг хуваалцаж болох вэ?

талаар юу мэдэж авсан бэ? Тэдний сурсан зөвлөгөө илүү сайн сонголт хийхэд хэрхэн тусалж чадах талаар ярилцахад тэднийг урь.

- Ангийн шалан дээр скоч эсвэл олсоор “V” үсэг бүтээ. Нэг залуу эрэгтэйг “V” хэлбэр гаргасан скоч эсвэл олсны нийлсэн үзүүрээс эхлээд, хоёр салааны үзүүр хүртэл дээр нь хөлөө нэг нэгээр нь тавин, алхахыг хүс. Аяндаа тэрээр туузны аль нэг талыг сонгож алхах хэрэгтэй болно. Энэ туршлагаас сонголтын талаар юу сурснаа тайлбарлахад залуу эрэгтэйчүүдийг урь. Залуу эрэгтэйчүүдийг ахлагч Рассэлл М.Нэлсоний “Мөнхийн ач холбогдолтой шийдвэрүүд” хэлсэн үгийн эхний догол мөрийг уншиж, үүнээс санахыг хүсэж байгаа хэсгээ тодорхойлоход урь. Ахлагч Нэлсоний “Шийдвэрүүд нь хувь заяаг тодорхойлдог” хэлсэн үг, эсвэл түүний хэлсэн бусад үг биелэгдсэнийг

хэрхэн олж харснаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- Залуу эрэгтэй бүрийг сонголт хийж байгаа хэн нэгэн хүний жишээг судраас олоход урь (жишээлбэл, тэд 1 Нифай 3:1–8 болон 1 Нифайн аль нэг хэсэг дэх Нифайн сонголттой Лемен, Лемүел хоёрын сонголттой харьцуулж болно). Эдгээр сонголт ямар үр дагавартай байсан бэ? Эдгээр сонголт бусдад хэрхэн нөлөөлсөн бэ?

- Энэ хичээлд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүл. Ангийн гишүүдийг видео бичлэг дээрх залуу эрэгтэйчүүдийн хийсэн сонголтын үр дагаврыг олж мэдэхэд урь. Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс. Хийсэн сонголтууд нь тун их нөлөөлсөн туршлагаудаасаа хуваалцахад тэднийг урь. Залуу эрэгтэй бүрийг энэ тойм дээрх судруудаас нэгийг уншаад, энэ нь ирээдүйд зөв сонголт хийхэд түүнд хэрхэн туслах талаар хуваалцахад урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд сонгох эрхийн талаарх сургаалыг илүү сайн ойлгосон уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Хийсэн сайн сонголтуудынхаа жишээнээс хуваалцаж, тэдгээр сонголт гэр бүлд нь төдийгүй өөрийнх нь мөн бусдын амьдралд хэрхэн нөлөөлснийг тайлбарлаж болно. Мөн ангийн бусад гишүүнийг хуваалцахад урьж болно.

- Ангийн гишүүдийг итгэлтэй санваартан байхад нөлөөлдөг сонголтуудынхаа талаар дүгнэхэд урьж болно. Мөн үргэлжлүүлэн сайжруулах арга замуудыг төлөвлөхөд тэднийг урамшуулан дэмжиж болно.

Сонгосон материалууд

“Сонгох эрх ба хариуцлага,” Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 2–3

Тэнгэрлэг Эцэг та нарт муугаас сайныг ялгах чадвар мөн өөрийнхөө төлөө сонголт хийх эрхийг өгсөн. Амьдрал хэмээх бэлгээс гадна амьдралаа удирдах эрх нь Бурханы хамгийн агуу бэлгүүдийн нэг юм. Дэлхий дээр байх хугацаандаа та нар Бурханы зарлигуудыг дагаж, Түүнд хайраа үзүүлэхээр сонгох эрхээ ашиглах эсэхээ шалгуулдаг. Сонгох эрхээ зөвөөр ашиглахад тань Ариун Сүнс та нарыг удирдах болно.

Та нар хийсэн сонголтуудынхоо хариуцлагыг хүлээдэг. Гэр бүлийнхэн, найз нөхөд тань сонгох эрхээ буруугаар ашиглаж байсан ч, Бурхан та нарт санаа тавьж, зөв сонголтуудыг хийхэд тань туслах болно. Та ганцаараа үлдсэн байлаа ч, Бурханы хүслийг дагахад шийдэмгий зоригтой бай. Та нар үүнийг хийх аваас бусдад сайн үлгэр жишээ болох болно.

Хэдийгээр та нар чөлөөтэйгөөр сонгох эрхтэй ч сонголтынхоо үр дагаваруудыг нь сонгож чадахгүй. Та нарын хийсэн сонголтын бодит үр дүнгийн хувьд тэдгээр нь сайн эсвэл муу үр дагаварыг дагуулдаг. Зарим нүгэлтэй зан төлөв дэлхийнхний хувьд сайн сайхан зүйл байж болох ч иймэрхүү сонголтууд та нарын

өсөлтөд саад болж, сэтгэлийн шаналгаа, гуниг зовлон руу хөтөлдөг. Зөв сонголт байнгын аз жаргал мөн мөнхийн амьдрал руу хөтөлнө. Жинхэнэ эрх чөлөө дуулгавартай байдлыг сонгосноор ирдэг; дуулгаваргүй байдлыг сонгосноор эрх чөлөөгөө алддаг гэдгийг санацгаа.

Та нар Тэнгэрлэг Эцэгийн өгсөн авьяас чадварыг хөгжүүлэх үүрэгтэй. Та нар авьяас чадвараа юунд ашигласан, цаг хугацаагаа хэрхэн зарцуулсныхаа төлөө Түүний өмнө хариуцлага хүлээнэ. Өөрийн хүслээр олон сайн зүйлсийг хийхээр сонго.

Рассэлл М. Нэлсоны “Мөнхийн ач холбогдолтой шийдвэрүүд” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Ах, эгч нар аа, бид өдөр болгон ямар нэгэн шийдвэр гаргадаг билээ. Ерөнхийлөгч Томас С. Монсон “шийдвэрүүд хувь заяаг маань тодорхойлж байдаг” гэж бидэнд заасан. Шийдвэр гаргах эрх чөлөөгөө зөв ашиглаж сурах нь одоо болон мөнхөд сүнслэгээр өсөн дэвжихэд тань зайлшгүй хэрэгтэй юм. Суралцахад хэзээ ч залуудахгүй, өөрчлөгдөхөд хэзээ ч хөгшдөхгүй. Бурхан бидэнд мөнхөд өсч хөгжих хүслийг суулгасан тул бид суралцах мөн өөрчлөгдөх эрмэлзэлтэй байдаг. Шинэ өдөр эхлэхэд мөнхийн ач холбогдолтой шийдвэрүүд гаргах боломж бидэнд ирдэг билээ.



Яагаад бидэнд саад бэрхшээл тулгардаг вэ?

Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөний нэг хэсэг болгон энэ мөнх бус амьдралдаа саад бэрхшээлийг туулах ёстой юм. Зарим тохиолдолд саад бэрхшээл нь бидний эсвэл бусдын хийсэн буруу сонголтын үр дүнгээс болж ирдэг. Бусад зовлон зүдгүүр нь зүгээр л мөнх бус амьдралын жам ёсны хэсэг юм. Хэдийгээр тэдгээр нь хэцүү ч сорилтууд биднийг сүнслэгээр өсөж, Есүс Христтэй илүү адилхан болоход тусалдаг.

Амьдралд тохиолдож байсан сорилтуудынхаа тухай бод. Ийм хэцүү үед Аврагч та нарыг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?

Таны зааж байгаа зарим залуу эрэгтэй аль хэдийн ноцтой сорилт бэрхшээлтэй тулгарсан байж магад. Тэд бүгд амьдрал дээр сорилттой тулгарсан үед тусламж хүлээн авахын тулд Аврагчийн нигүүлсэлд найдах хэрэгтэй болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, суралцах материалыг залбирч судлаарай. Судалж байхад чинь ямар сэтгэгдэл төрсөн бэ?

2 Нифай 2:11 (Бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй)

Мозая 23:21 (Бурхан бидний итгэлийг сорихын тулд саад бэрхшээл өгдөг)

Ифер 12:27 (Биднийг даруу болгохын тулд Бурхан бидэнд сул доройг өгдөг)

С ба Г 101:1–9 (Зарим саад бэрхшээл нь бидний хийсэн муу сонголтуудын улмаас ирдэг)

С ба Г 121:7–8; 122:4–9 (Зовлон зүдгүүр нь бидэнд туршлага суулгаж, бидний сайн сайхны төлөө байдаг.)

Даллин Х.Өүкс, “Бүх зүйлд сөрөг тал байх хэрэгтэй,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 103–106

Коичи Аояаги, “Зам дээрээ зогсогтун,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 123–125

Томас С.Монсон, “Би чамайг хаяхгүй мөн орхихгүй,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 11-р сар, 85–87

Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Саад тотгор,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 152–156

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг давтаж мөн энэ долоо хоногийн хичээлийг танилцуулахын тулд эдгээр санаанаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглээрэй.

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногт сурсан нэг зүйлээ бодоод, түүнийгээ бичиж, ангий-хантайгаа хуваалцахыг хүс. Энэ долоо хоногийн хичээлүүдийг танилцуулах эхлэл болгон үүнийг ашигла.

- Чуулгаараа ахлагч Нийл Л.Андэрсэны ярьсан салхи шуурга

ихтэй нөхцөл байдалд ургаж буй модны тухай унш (“Сүнслэг шуурганууд” хэлсэн үг). Энэ адилтгал нь залуу эрэгтэйчүүдэд зовлон бэрхшээлийн талаар юу зааж байна вэ? Тэднийг уг хэлсэн үгийг уншиж, сүнслэг шуургыг давж гарахад туслах зөвлөгөөг олж харахад урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд чуулгын гишүүдэд саад бэрхшээлийн зорилгын тухай суралцахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч Коичи Аоягийн “Зам дээрээ зогсогтун” хэлсэн үгээс түүний машины ослын талаар ярьсан, догол мөрөөр эхэлж буй түүхийг уншихад урь. Яагаад бид энэ амьдралдаа зовлон бэрхшээлтэй тулгардаг талаар энэ түүх залуу эрэгтэйчүүдэд юу зааж байна вэ? Зовлон бэрхшээл туулахдаа өөрөө эсвэл гэр бүлийнх нь хэн нэгэн гишүүн өсөж хөгжсөн эсвэл хүчирхэгжсэн тухай туршлага хуваалцахад нэг залуу эрэгтэйг урьдчилан урих талаар бодож үзээрэй. Тэр гэр бүлийнхээ түүхээс энэ зарчмыг заах нэг түүхийг хуваалцаж болно.

- Залуу эрэгтэй бүрээс өөрт нь эсвэл гэр бүлийнх нь хэн нэг гишүүнд тохиолдоод байгаа сорилтыг бичихийг хүс. Яагаад бидэнд саад бэрхшээл тохиолддог тухай суралцахын тулд энэ тойм дахь судруудыг эсвэл мэддэг судраа олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Тэднийг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Энэ судар тэдний бичсэн сорилтыг давахад тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

- “Итгэлдээ үнэнч байх нь” товхимлын Саад тотгор гарчгийн доорх эхний хоёр догол мөрийг хамтдаа унш. Саад бэрхшээл Тэнгэрлэг

Заахад туслах арга

“Та тэнд байгаа хүн бүрийн царайг харж байхаар, мөн тэнд байгаа бүх хүн таны царайг харж байхаар өрөөн дэх сандлуудаа байрлуул” (Teaching, No Greater Call [1999], 71).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн номлолд зааж, гэрчлэхэд судруудыг ашигладаг байлаа. Энэ хичээлд зовлон зүдгүүртэй үед Аврагч биднийг хэрхэн хүчирхэгжүүлдгийг заасан олон хүчирхэг судар агуулагдсан байгаа. Залуу эрэгтэйчүүд тэдгээр судрыг судалж, ярилцахад Ариун Сүнс тэдгээрийн үнэнийг гэрчилнэ.

Эцэгийн төлөвлөгөөнд ямар үүрэгтэй вэ? Ангийн гишүүн бүрд *Итгэлдээ үнэнч байх нь* товхимол дээрх саад бэрхшээлийн талаарх үлдсэн гурван хэсгээс нэгийг даалгаж өгөөд, тухайн хэсгээс сурсан зүйлээ ангийнхаа үлдсэн хүүхдүүдэд заахаар бэлтгэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэднийг уншсан зүйлд нь хамааралтай түүх, хувийн туршлагаасаа хуваалцахад урамшуулан дэмж.

- Самбараа голлож хуваагаад нэг баганых нь дээд хэсэгт “Бидэнд яагаад сорилтууд тохиолддог вэ?” гэж бичээд, нөгөө баганых нь дээд хэсэгт “Бидний амьдралд хэрхэн сорилт бэрхшээл тулгарч болох вэ?” гэж бич. Ерөнхийлөгч Томас

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд яагаад саад бэрхшээл тохиолддогийг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулгын гишүүдийн зовлон зүдгүүртэй байгаа бусад хүнд туслахын тулд санваарынхаа үүргийг хэрхэн биелүүлж чадах тухай ярилцлагыг удирдаж болно. Тэд *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын “Бусдад үйлчил” хэсэг дээр өөрсдөд

С.Монсоны “Би чамайг хаяхгүй мөн орхихгүй” эсвэл ахлагч Даллин Х.Өүксийн “Бүх зүйлд сөрөг тал байх хэрэгтэй” хэлсэн үгсийг жижиг хэсгүүдэд хувааж, залуу эрэгтэй бүрд унших хэсэг өг. Залуу эрэгтэйчүүдээс эдгээр асуулгын хариулыг олж мэдээд, самбарын тохирох баганд хариултуудаа бичихийг хүс. Залуу эрэгтэйчүүд энэ хэлсэн үгсээс ямар ойлголттой болсон бэ?

- Бишопын зөвшөөрөлтэйгөөр, залуу эрэгтэйчүүдийн эцгүүдийг сорилтоо даван туулахад нь Есүс Христ хэрхэн тусалсан тухай ангитай хуваалцахад урь. Тэд тохиолдсон саад бэрхшээлээсээ юу сурсан бэ? Ярилцлагын нэг хэсэг болгон, судраас хуваалцахыг эцгүүдээс хүс.

нь туслах төлөвлөгөөнүүдийг тэмдэглэж болно.

- Аврагч зовлон зүдгүүртэй үед нь түүнийг хэрхэн хүчирхэгжүүлж байсан тухай гэрчлэлээ хуваалцаж болно.

Сонгосон материалууд

“Саад тотгор,” Итгэлдээ үнэнч байх нь (2004),
152-оос эш татав

Тэнгэрлэг Эцэгийн гэтэлгэлийн төлөвлөгөөний нэг хэсэг учраас та нар мөнх бус байдалд саад тотгорыг туулдаг. Хүнд сорилт, урам хугаралт, гуниг гутрал, өвчин хийгээд сэтгэлийн зовлон нь амьдралын хүнд хэсэг боловч та Их Эзэнд хандвал тэдгээр нь сүнсний өсөлт, өөрчлөлт хийгээд хөгжил рүү удирдана.

Саад тотгор нь янз бүрийн эх сурвалжаас шалтгаалан гардаг. Магадгүй та дуулгаваргүй байдал болоод бардам зангийнхаа үр дагаврын улмаас хүнд сорилтуудтай тулгарч болно. Зөв шударга амьдрал эдгээр хүнд сорилтыг зайлуулж чадна. Бусад сорилт амьдралд байх ёстой бөгөөд заримдаа тэдгээр нь таныг зөв шударга амьдарч байхад ч ирж болно. Жишээ нь: Хайртай хүмүүс тань өвчин зовлонтой эсвэл тодорхой бус байдалд орох эсвэл нас барах цагт хүнд сорилт бий болдог. Саад тотгор заримдаа бусдын буруу сонголт, зүрх зүсэм үгс хийгээд үйл хөдлөлөөс болж үүсдэг.

Томас С.Монсон, “Би чамайг хаяхгүй мөн орхихгүй,”
Ensign, 2013 оны 11-р сар, 85, 87 эсвэл 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 97, 98-аас эш татав

Ах, эгч нар аа, зовлон, гашуудал туулалгүй амьдарсан нэг ч хүн үгүй мөн хүмүүний түүхэнд үймээн самуун, гаслан зовлон тохиолдоогүй нэг ч мөч байхгүй гэж хэлэхэд үнэнээс нэг их гажихгүй байх.

Амьдрал биднийг ганц сайн сэгсрэхэд “Яагаад заавал намайг гэж?” хэмээн асуумаар үе тохиолддог. Заримдаа хонгилын үзүүрт сүүмийх ч гэрэл харагдахгүй; шөнийн харанхуйг арилгах нар хэзээ ч дахин мандахгүй юм шиг санагдах үе ирнэ. Ийм үед мөрөөдөл замхран алга болох үеийн гансрал, найдвар алдагдах үеийн цөхрөл хоёроос өөр юу ч үлдээгүй мэт санагддаг. Библид

гардагчлан “Гилеадад ямар ч гавар байхгүй гэж үү?” хэмээх цөхрөлийн үгсийг бид бувтнадаг.” [Иеремиа 8:22]. Бид хэнд ч хэрэггүй, уй гашууд дарагдсан, ганцаардсан нэгэн болон хувирна. Бидэнд тохиолдоод байгаа золгүй явдлуудаа гутранги үзэлтний томруулдаг шилээр харах хандлага ч ажиглагддаг. Асуудлаа шийдэх гэж яаран, тэнгэрлэг зан чанар болох тэвчээртэй зан гаргах хэрэгтэй гэдгээ бид мартдаг билээ.

Бидэнд тохиолдох бэрхшээл тэсвэр тэвчээрийг маань сорьсон жинхэнэ шалгалт болдог. Бууж өгөх үү эсвэл эцэст нь хүрэх үү? гэдэг хамгийн чухал асуултад бид өөрсдөө л хариулах ёстой. Бидний зарим маань асуудлаа шийдэж чадахгүй, бууж өгдөг. Харин эцэст нь хүрнэ гэж амьдралынхаа төгсгөл хүртэл хичээсээр байхыг хэлнэ. . . .

Бидэнд хязгааргүй баяр баясал өгдөг Тэнгэрлэг Эцэг маань биднийг ирэх зовлон бэрхшээлтэйгээ нүүр тулан, тэдгээрийг ялан дийлснээр илүү ихийг сурч, хөгжиж, улам хүчирхэг болдог гэдгийг маань мэддэг. Биднийг гансруулан, хамаг тэвчээрийг барж, зүрх үхүүлэм уй гашуут мэдрэх үе ирнэ гэдгийг бид мэддэг. Гэхдээ ийм бэрхшээлүүд нь биднийг илүү чадварлаг болгож, бидэнд Тэнгэрлэг Эцэгийн заасны дагуу амьдралаа өөрчлөх боломжийг олгон, биднийг өөрчилдөг билээ. Бид байснаасаа хамааргүй илүү болж, бидний ойлголт тэлж, бусдыг илүү их хайрлах чадвартай мөн өмнөхөөсөө илүү хүчтэй гэрчлэлтэй болцгоодог юм.

Бидний зорилго бол цөхрөлтгүй урагшилж, даван туулах явдал юм. Тийм ээ. Гэхдээ бид бас жаргал, зовлонг туулах явцдаа сүнсээ хүчирхэгжүүлэх ёстой билээ. Хэрэв бидэнд даван гарах ёстой бэрхшээл, шийдэх ёстой асуудлууд байгаагүйсэн бол бид хэзээ ч өөрчлөгдөхгүй хэвээрээ үлдэж, мөнх амийг авах зорилгодоо ер ойртолгүй эсвэл үл ялиг л ойртсон байх байсан юм.



Ойр дотны маань хэн нэгэн нас барахад би тайвшралыг хэрхэн олох вэ?

Үхэл бол авралын төлөвлөгөөний амин чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү их адилхан болохын тулд бид үхлийг үзэж, төгс болоод амилсан биеийг хүлээн авах ёстой. Бид үхэл бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг мөн Есүс Христ Цагаатгалаараа үхлийг ялсан гэдгийг ойлгосноор хайртай нэгнээ нас барахад найдвар, амар амгаланг хүлээн авч чаддаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судлаарай. Та сурч байхдаа ямар мэдрэмжийг хүлээн авсан бэ?

Та эсвэл таны мэдэх хэн нэгэн хүн хайртай хүмүүсээ нас барахад хэрхэн найдвараа олж авч байсан бэ? Ямар судар эсвэл зарчмууд тусалсан бэ?

Зарим залуу эрэгтэйчүүд хайртай нэгнээ нас барахыг аль хэдийн харж, мэдэрсэн байж болно. Хэзээ нэгэн өдөр тэдэнд бүгдэд нь ийм зүйл тохиолдох болно. Тэдэнд тусалж болох юуг тэд мэдээсэй хэмээн та хүсэж байна вэ?

Мозая 16:7–8 (Есүс Христийн амилалт үхлийн өргөсийг авч хаяна)

Мозая 18:8–10; С ба Г 81:5 (Бид тайтгарал хэрэгтэй байгаа тэдгээр хүмүүсийг тайтгаруулна)

Алма 11:42–45 (Аврагчийн амилалтын учир бид бие махбодоо эргүүлэн авах болно)

Алма 28:12; С ба Г 42:45–46 (Бид нас барсан хүмүүсийнхээ хойноос гашууддаг ч Их Эзэнд нас барсан тэдний хувьд үхэл нь амттай байх болно)

Алма 40:11–14 (Биднийг үхсэний дараа ч сүнс маань амьдарсаар байна)

С ба Г 137:5–10 (Иосеф Смит өөрийн ах Алвин болон бяцхан хүүхдүүд

мөн бусад хүмүүсийг селестиел хаант улсад харжээ)

С ба Г 138 (Сүнсний дэлхийн талаарх ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн үзэгдэл)

Томас С.Монсон “Хатагтай Паттон—түүх үргэлжилж байна,” *Ensign* эсвэл *Луахона*, 2007 оны 11-р сар, 21–24; мөн “Биднийг дахин уулзтал” видео бичлэгийг үзнэ үү.

Рассэл М.Нэлсон, “Үхлийн хаалгууд,” *Ensign*, 1992 оны 5-р сар, 72–74

Шэйн М.Бөүэн, “‘Би амьд учраас, та нар ч мөн амьд,’” *Ensign* эсвэл *Луахона*, 2012 оны 12-р сар

Видео бичлэгүүд: “Бид нар гэр бүл хэвээрээ л байна,” “Тэр чамд тусламжийг өгнө”

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Сурч байгаа зүйлийнхээ үр дүн болгон юу хийхэд залуу эрэгтэйчүүдийг урьсан бэ? Сурч байгаа зүйлсээ амьдралд хэрэгжүүлэх нь тэдэнд болон гэр бүл найз нөхдөд хэрхэн нөлөөлж байгааг хуваалцахад тэднийг урь.
- Өөрийнхөө эсвэл хэн нэгний хайртай хүн нь нас барсны дараа амар амгаланг олсон тухай тохиолдлоос хуваалц. Залуу эрэгтэйчүүдийг туршлагаасаа хуваалцахыг урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд үхлийн дараах амьдралын талаар ойлгож мэдэхэд нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг үхлийн талаарх асуулт, бодол, айдсуудаа бичиж, хариултыг нь энэ тоймын судруудаас эсвэл ахлагч Рассэл М.Нэлсоны “Үхлийн хаалгууд” хэлсэн үгээс мэдэж авахад урь. Үхлийг ялахад бидэнд туслах Аврагчийн үүргийг тодотгосон тодорхой судар хийгээд мэдэгдлүүдийг тэмдэглэж авахад тэднийг урамшуул. Тэднийг юу сурснаа хуваалцахыг хүс. Бидний төлөө Аврагчийн хийсэн зүйлийн талаарх сэтгэгдлээ хуваалцахад тэднийг урь.
- “Тэр чамд тусламжийг өгнө” видео бичлэгийг үзүүлэн, юу тэдний сэтгэлийг хөдөлгөсөн талаар хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Видео бичлэгийг үзсэний дараа хэрэв хүн бүр видео бичлэг

Заахад туслах арга

“Хичээл эхлэхээс өмнө самбар дээр бичсэн асуултууд суралцагчдад хичээлийн өмнө уг сэдвийн талаар бодож эхлэхэд тусалдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 93).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч хүмүүсээс тунгаан бодож, гүнзгий мэдрэмж төрүүлэх асуултуудыг асуудаг байсан. Та тунгаан бодож, илчлэлт хүлээн авахаар эрэлхийлэхэд залуу эрэгтэйчүүдийг хэрхэн урьж чадах вэ? Та тэдэнд хувийн мэдрэмжүүдээ хуваалцахад аюулгүй гэдгийг мэдрэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

дээрх залуу хөвгүүний олж мэдсэн зүйлийг мэддэг байсан бол дэлхий ямар өөр байж болох байсан талаар ярилц.

- Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Хатагтай Паттон—түүх үргэлжилж байна” хэлсэн үгээс хатагтай Паттоны тухай түүхийг хуваалцах эсвэл “Биднийг дахин уулзтал” видео бичлэгийг үзүүл. Залуу Томас Монсоноос хатагтай Паттоны асуусан асуултад тэд хэрхэн хариулах байсныг асуу. Ангиараа Мозая 18:8–10 болон Сургаал ба Гэрээ 81:5-ыг унш. Хайртай нэгнээ алдсан гэр бүлүүдэд тайтгарал, тусламж болон бусад санваарын үйлчлэлийг үзүүлдэг санваартнуудын үүрэг хариуцлагын талаар ярилц. Та бишопын зөвлөлийн гишүүнийг энэ ярилцлагад оролцоход урьж болно.

- Чуулгын нэг хэсгийг ахлагч Шэйн М.Бөүэний “‘Би амьд учраас та нар ч амьд’” хэлсэн үгээс Рамирээ эгчийн тухай түүхийг харин нөгөө хэсгийг ахлагч Бөүэны хүү Тайсоны түүхийг уншихад урь. Тэд

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд дотны хэн нэгэн нь нас барахад хэрхэн тайтгарлыг олж болохоо ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно.

- Тэр хайртай нэгнээ саяхан алдсан хэн нэгэнд үйлчлэл үзүүлэхийн тулд чуулгын гишүүд юу хийж болох тухай ярилцлагыг удирдаж болно.

хайрладаг байсан хэн нэгэн нь нас барахад хэрхэн тайтгарлыг олж мөн бусдыг хэрхэн тайтгаруулах тухай юу сурснаа хуваалцахыг тэднээс хүс. Залуу эрэгтэйчүүдийг хайртай нэгнээ алдахад тохиолдсон ямар нэгэн туршлагаасаа хуваалцахад урь. Тайтгарлыг олоход тэдэнд цагаатгал болон авралын төлөвлөгөөний тухай мэдлэг нь хэрхэн тусалсан бэ? Хэрэв тохиромжтой бол өөрт тохиолдсон туршлагаасаа хуваалц.

- Ангиа хоёр бүлэг болгон хуваарил. Нэг бүлгээр нь Сургаал ба Гэрээ 137:5–10-ыг мөн нөгөө бүлгээр нь Сургаал ба Гэрээ 138:57–58-ыг уншуул. Бид нас барсны дараа болдог зүйлсийн талаар эдгээр судруудад юу зааж байгааг бүлэг бүлгээрээ ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Дараа нь чуулгаараа дотны хүнээ алдсан хэн нэгэнд энэхүү мэдлэг нь хэрхэн тусалж болохыг ярилц. Энэ мэдлэг нь гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил хийх бидний үүрэг хариуцлагатай хэрхэн холбогдох вэ?

Сонгосон материалууд

Томас С.Монсоны “Хатагтай Паттон—Түүх үргэлжилсээр байна” хэлсэн үгээс эш татав. Ensign ба Лиахона 2007 оны 11-р сар, 21–24

Эхлээд би та нарт Артурын тухай ярья. Тэр буржгар шар,үстэй, маш том биетэй, үргэлж инээмсэглэж явдаг хүүхэд байв. Тэрээр ангийнхаа бүх хөвгүүдээс өндөр нь байв. 1940 онд Дэлхийн II-р Дайн болж ихэнх Европыг хамарсан тэр үед Артур цэрэг татлагын офицеруудыг мэхлэн 15-хан насандаа тэнгисийн цэрэгт элсэж оржээ. Артур болон бусад хөвгүүдэд дайн гэдэг нь гайхалтай адал явдал байлаа. Тэнгисийн цэргийн дүрэмт хувцастай тэрээр ямар сайхан харагдаж байсныг би санаж байна. Насанд хүрчихсэн ч байсан болоосой эсвэл жоохон ч гэсэн өндөр байсан ч болоосой, тэгсэн бол бид нар ч гэсэн цэрэгт элсэх байсан юм хэмээн бид хичнээн их хүсч байсан гээч.

Залуу нас бол амьдралын хамгийн онцгой цаг үе юм. Лонгфеллоу бичихдээ:

Залуу нас ямар сайхан бэ!

Хэчнээн оргилуун санаа, хүсэл эрмэлзлэл, мөрөөдлөөр залуу нас гэгээрнэ вэ!

Эхлэлүүдийн ном, Төгсгөлгүй түүх,

Эмэгтэй болгон баатар мөн эрэгтэй болгон найз!

[“Morituri Salutamus,” *The Complete Poetical Works of Henry Wadsworth Longfellow* (1883), 259.]

Артурын ээж зочны өрөөний цонхоо гоёсон цэнхэр одоор их бахархдаг байж билээ. Энэ нь байшингийн хажуугаар өнгөрсөн хүн болгонд түүний хүү эх орныхоо цэргийн дүрэмт хувцсыг өмсөөд, эх орноо хамгаалж байгааг харуулсан бэлгэдэл байв. Түүний гэрийн хажуугаар өнгөрөх болгонд тэрээр хаалгаа онгойлгон намайг гэртээ урьж Артураас сүүлд ирсэн захиаг уншуулдаг байв. Түүний нүд нь нулимсаар бүрхэх үедээ намайг үргэлжлүүлэн

чангаар уншихыг хүсдэг байв. Артур бол бэлэвсэн эхийнхээ амь амьдрал нь байлаа.

Би одоо ч гэсэн хатагтай Паттоны хатуужсан гар нь захиагаа дугтуйд нь болгоомжтойхон хийж байдгийг сайн санадаг. Энэ гар ажилсаг хүний гар билээ. Хатагтай Паттон нь хотын төвд байдаг оффис цэвэрлэдэг эмэгтэй байлаа. Ням гаригаас бусад бүх өдрүүдэд тэрээр сойз, хувин хоёроо гартаа бариад, буурал үсээ ардаа чангахан боочихсон, ажилдаа ядарсан мөр нь насны эрхээр бөгтийгөөд явган хүний замаар алхаж явдаг байв.

1944 оны гуравдугаар сард дайн улам ширүүсэж байх үед Артур USS *Dorsey*-гаас сөнөөгч USS *Уайт Плейнс*, онгоц тээвэрлэгч рүү шилжив. Өмнөд Номхон Далайн Сайпанд байхад нь усан онгоц нь дайсны халдлагад өртөв. Артур далайд живсэн хүмүүсийн дунд байжээ.

Цэнхэр од нь Паттоны гэрийн урд цонхон дээр байсан нандин газраасаа авагдсан байв. Түүний оронд цэнхэр одыг төлөөлж байсан тэр хүн нь дайнд үрэгдсэний тэмдэг болгон алтан одоор сольсон байлаа. Хатагтай Паттоны амьдралын гэрэл нь алга болов. Тэрээр гуниг зовлон мөн гүн уйтгарт автсан.

Зүрх сэтгэлдээ залбирсаар би Паттоны гэрийн танил замаар ямар тайтгарлын үгс хэлдэг юм билээ хэмээн гайхширан очлоо.

Хаалга онгойв. Хатагтай Паттон намайг өөрийн хүүгээ мэт гэврэн авлаа. Гашуудаж шаналсан эх бид хоёр өвдөг сөгдөн залбирав.

Биднийг өндийн босох үед хатагтай Паттон миний нүд рүү хараад: “Томми, би аль ч сүмийн гишүүн биш харин чи сүмийн гишүүн. Артур дахин амьдрах уу, надад хэлж өгөөч?” гэв. Би түүнд бүх чадлаараа Артурыг үнэхээр дахин амьдрах болно хэмээн гэрчилсэн билээ.



Би яагаад бие махбодоо Ариун сүм шиг байлгах хэрэгтэй вэ?

Бидний бие махбодь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Тэдгээр нь биднийг мөнх бус байдлаа мэдэрч, Түүнтэй илүү адилхан болохоор үргэлжлүүлэх боломжийг олгодог Тэнгэрлэг Эцэгийн бэлэг юм. Энэ мэдлэг нь бидний өөрийн биед хандах хандлага, Тэнгэрлэг Эцэг болон өөрсдийнхөө тухай ямар мэдрэмжтэй байгаад нөлөөлдөг. Бид биедээ Бурханы ариун сүм мэт хандах юм бол бие махбодын, оюун санааны мөн сүнслэг адислалуудыг хүлээн авна.

Биеэ Бурханы сүм мэт байлгаснаар та ямар адислалуудыг хүлээн авсан бэ? Өөрийн болон бусдын амьдралыг ажигласнаар биеийн тань ариун нандин байдлын тухай ойлголт хэрхэн өсч байна вэ?

Өөрийн биеийг Бурханаас ирсэн нандин бэлэг мэт байлгахыг хичээснээр ямар сорилтуудтай залуу эрэгтэйчүүд учирч байна вэ? Тэдний биедээ хандах байдал нь санваарын хүчтэй нь хэрхэн холбогдож байна вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судруудыг болон материалуудыг залбиралтайгаар уншаарай. Сүнс таныг залуу эрэгтэйчүүдтэй юу хуваалцахыг урамшуулж байна вэ?

Эхлэл 39:1–21; Даниел 1:3–21
(Жозеф, Даниел хоёр өөрсдийн биед хүндэтгэл үзүүлдэг)

1 Коринт 6:19–20; С ба Г 93:33–35
(Бид Бурханы Ариун сүм)

С ба Г 88:15–16 (Сүнс ба бие нь хүмүүний бодгаль мөн)

С ба Г 130:22; Мосе 6:9 (Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн)

Гордон Б.Хинкли, “Хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” *Ensign*, 11 сар, 2000, 50–53

Видео бичлэгүүд: “Мормон Мустанг,” “Ариун явдал: Хязгаарлалтууд нь юу вэ?”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдэд өнгөрсөн долоо хоногийн хичээлээс юу сурсныг нь сануул. Тэдэнд ярилцсан зүйлсийнх нь талаар ямар нэгэн асуултууд, бодлууд байна уу?
- Ариун сүмийн зургийг үзүүлээд, залуу эрэгтэйчүүдийг ариун сүмийн тухай бодоход ямар үгс орж ирдэг талаар бичихийг урь. Эдгээр үгсийн эсрэг үгс нь юу вэ? Залуу эрэгтэйчүүдээс биеэ Бурханы ариун сүм шиг байлгахын тулд тэднээс юу хийхийг санал болгосон талаар хуваалцахыг хүс.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь ангийн гишүүдийг тэдний бие ариун нандин гэдгийг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг буюу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэй бүрд энэ тойм дээрх судрын хэсгүүдийн нэгийг уншихыг хүс. Залуу эрэгтэйчүүдийг судрын хэсгүүдээ судлаад биеэ яагаад ариун байлгах тухай юу сурснаа нэг өгүүлбэрээр нэгтгэн дүгнэхийг хүс. Тэднээс бие махбод, оюун санаагаа цэвэр байлгахын тулд юу хийж чадахаа хуваалцахад урь.
- Энэ тоймд санал болгосон хэлсэн үгсээс нэг хэсгийг уншихыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэгээд залуу эрэгтэйчүүд тус бүрд нь бие махбодын ариун байдлын тухай богино хэмжээний хичээл бэлдэх цөөн хэдэн минутыг өг. Тэднийг хувийн туршлага хийгээд гэрчлэлийнхээ хамт богино хэмжээний эшлэлийг хэлсэн үгээс ашиглахад урамшуул.
- Ангиараа 1 Коринт 6:19–20 болон С ба Г 93:33–35-ыг унш. Залуу эрэгтэйчүүдээс бидний бие Бурханы ариун сүмтэй адил байж чадах жагсаалт гаргахыг хүс. Өсвөр үеийнхэнд өөрсдийнхөө биеийг ариун сүм шиг авч явахад тохиолдож байгаа сорилтуудын талаар ярилцахыг урь. Тэд эдгээр сорилтуудыг даван туулахын тулд юу хийж чадах вэ?
- Ангийг хос хосоор нь хуваа. Хосуудын нэгийг Эхлэл 39:1–21 болон Даниел 1:3–21-ийг уншихыг даалга (эдгээр түүхийн зургийг Сайн мэдээний уран зургийн цуглуулганы 11, 23-аас үз). Тэднээс Жозеф, Даниел нар өөрсдийн биеэ хүндэтгэж байгааг үзүүлсэн арга замуудыг олуулж, юу олсноо бие биетэйгээ хуваалцахыг хүс. Тэд Жозеф, Даниел хоёрын жишээг хэрхэн дагаж чадах вэ?
- Залуу эрэгтэйчүүдийг Залуучуудын бат бөх байдлын төлөө номын гарчгийг гаргаад оюун санаа болон

Заахад туслах арга

“Тодорхой сэдэв дээр хэлэгдсэн бүх зүйлсийг заахаас зайлсхий. Таны зааж байгаа хүүхдүүд энэ сэдвийн талаар зарим ойлголтыг аль хэдийн олж авсан байж болно. Таны хичээл тэдэнд энэ сэдвийн талаар сурч болох цорын ганц цаг биш гэдгийг санаарай” (Teaching, No Greater Call [1999], 99).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заасан хүмүүсээ хайрласан. Тэр тэдний хэн болох мөн хэн болж чадахыг мэддэг байв. Тэр зөвхөн тэдэнд зориулсан арга замуудаар тэднийг өсгөх онцгой аргуудыг олсон. Зовж цөхөрсөн үед нь Тэрээр хэзээ ч тэднийг орхилгүй харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа. Залуу эрэгтэйчүүдийг Аврагч шиг хайрлаж мөн үйлчлэхийн тулд та юу хийж чадах вэ?

биеэ цэвэр байлгахтай холбоотой жишгүүдийг олоход урь. Чуулгыг бүлгүүдэд хуваагаад тэдгээр хэсгүүдээс судлуулж, “Би өөрийн биеийг яагаад Ариун сүм шиг байлгах хэрэгтэй вэ?” гэсэн асуултын хариултуудыг олуул. Эдгээр жишгийн дагуу амьдрахын тулд юу хийж чадахаа хуваалцахыг тэднээс хүс.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдийн нэгийг үзүүл. Залуу эрэгтэйчүүдийг биеэ цэвэр байлгахын чухлыг тайлбарлахаар видео бичлэгт хэрэглэсэн зүйрлэлийг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд биеийнхээ ариун нандин байдлын талаар илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бие махбодтойгоо хүндэтгэлтэй харьцсанаар ирэх адислалуудын тухай гэрчилж болно.
- Ангийн гишүүдтэй хамт Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын “Эрүүл мэнд” (хуудас 31–34) хэсгийг ажиллахаар төлөвлө.

олоод ярилцахыг урь. Тэд видео бичлэгт зааж байгаа жишгийн дагуу амьдрахад бие биенээ зоригжуулахын тулд тэд юу хийж чадах вэ?

- Залуу эрэгтэйчүүдээс “Хувцаслалт ба гадаад төрх” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номноос авч ашиглан “Даруу байдлын талаарх Их Эзэний жишиг юу вэ?” гэх зэрэг асуултанд хариулахыг хүс. “Тэдгээр жишгүүдийг дагах нь яагаад чухал вэ?” ба “Бидний даруу байдал биеийнхээ ариун нандин байдлыг хүндэтгэж байгааг хэрхэн үзүүлдэг вэ?”

Сонгосон материалууд

“Хувцаслалт ба гадаад төрх,” Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 6–8

Таны бие махбодь бол ариун юм. Бие махбодио хүндэлж, ямар ч байдлаар бохирдуулж болохгүй. Бие махбодь тань ямар их үнэ цэнэтэй болохыг мэддэгээ хувцаслалт болон гадаад төрхөөрөө харуулж чадна. Та нар Есүс Христийн дагалдагч бөгөөд Түүнд хайртай гэдгээ харуулж чадна.

Бурханы Бошиглогчид Түүний хүүхдүүдэд даруу хувцаслахыг үргэлж зөвлөдөг. Та үсээ сайхан засуулж, даруухан хувцасласан байвал Ариун Сүнсний нөхөрлөлийг урьж, эргэн тойрныхоо хүмүүст сайн нөлөө үзүүлж чадна. Та нарын хувцаслалт, гадаад төрх та нарын болон бусад хүмүүсийн үйлдэлд нөлөө үзүүлдэг.

Хэзээ ч хувцаслалтынхаа жишгийг бууруулж болохгүй. Онцгой үйл явдлуудад ч даруухан бус хувцаслаж болохгүй. Даруу бусаар хувцаслах үедээ та нар Бурханы охид, хөвгүүдийн шинж чанараа алддаг. Ингэснээр та нар өөрсдийн бие махбодио бусдын анхаарлыг татаж, хөнгөн хийсвэр байхад ашиглаж байна гэсэн үг юм.

Даруу бус хувцас гэдэг нь аливаа бариу, нимгэн гэрэлтсэн эсвэл бусад ил задгай маягийн хувцаснууд юм. Залуу эмэгтэйчүүд богинохон шорт юмуу банзал, хүйс далдалдаггүй цамц мөн мөрөө далдлаагүй эсвэл урдаа юм уу ардаа

урт оноотой хувцас өмсөхөөс зайлсхийх ёстой. Эрэгтэйчүүд ч бас гадаад төрхөндөө даруу байдлыг эрхэмлэх ёстой. Залуу эрэгтэй ба эмэгтэйчүүд хувцаслалт ба үс засалгандаа дэндүү онцгой эсвэл зүй зохисгүйгээр хайхрамжгүй байхаас зайлсхийж, цэвэр бөгөөд нямбай аятайхан хувцаслах ёстой. Мөн тэд спортоор хичээллэх үедээ ч зохистой даруухан хувцаслах ёстой. Дэлхийн хувцасны загвар өөрчлөгддөг боловч Их Эзэний жишгүүд өөрчлөгддөггүй.

Шивээс шивүүлж мөн биеэ цоолж өөрсдийн үзэмжийг бүү гутаа. Залуу эмэгтэйчүүд хүсвэл ганцхан хос ээмэг зүүвэл зохистой.

Сүмийн цуглаан болон үйл ажиллагаанд зөв зохистой хувцаслаж, Их Эзэнийг мөн өөрийгөө хүндэлдэг болохоо харуул. Ялангуяа ариун ёслолын цуглаанд энэ нь маш чухал юм. Залуу эрэгтэйчүүд ариун ёслолыг түгээх ёслолд оролцоходоо хүндэтгэлтэй хувцаслах ёстой.

Хэрэв та нар зохистой хувцаслах талаар сайн мэдэхгүй бол удирдамж авахын тулд бошиглогчдын үгсийг судалж, эцэг эх болон удирдагчдаасаа тусламж хүсч болно. Та нарын одоогийн хувцаслалт болон гадаад төрх тань ариун сүмд очиж, Бурхантай нандин гэрээнүүдийг хийхэд тань бэлтгэх болно. Хэрэв би Их Эзэний дэргэд байгаа бол гадаад төрх байдалдаа сэтгэл зовохгүй байж чадах уу? гэж өөрөөсөө асуу.

Гуравдугаар сар: Есүс Христийн Цагаатгал

*“Болгоогтун та нар Христийн цагаатгалын ... хүчинд найдахыг би та нарт хэлье:”
(Моронай 7:41).*

Энэ хэсэг дэх хичээлүүд нь “Христэд ирж ... түүний авралаас мөн түүний гэтэлгэлийн хүчнээс хүртэхэд” (Омнай 1:26) залуу эрэгтэйчүүдэд туслах болно. Та энэ хэсгийг зааснаар наманчлал ба Цагаатгалаар дамжуулан санваарын үүргүүдээ биелүүлэхдээ хэрхэн цэвэр ариун бөгөөд зохистой байхыг ойлгоход тэдэнд тусалж чадна. Түүнчлэн Аароны санваартнуудын хувьд ариун ёслолын болон баптисмын ёслолуудыг гүйцэтгэх үедээ Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад нь бусдад туслах ариун үүргээ ухамсарлахад тэдэнд тусалж чадна.

Та Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг Ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын дараах тоймыг энэ бүлэгт оруулан, зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би Аврагчийн Цагаатгалаар ирдэг адислалуудыг хүлээн авахад бусдад хэрхэн тусалдаг вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүрэг)

Есүс Христийн Цагаатгал гэж юу вэ?

Есүс Христэд итгэх гэдэг нь ямар утгатай вэ?

Наманчлах гэж юу гэсэн үг вэ?

Ач ивээл гэж юу вэ?

Би яагаад бусдыг уучлах хэрэгтэй вэ?

Амилалт гэж юу вэ?

Сорилт бэрхшээл тулгарсан үед Аврагч надад хэрхэн тусалж чадах вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Санваарын ёслолуудыг гүйцэтгэ,” 24–25, 48–49,
72–73-р хуудас

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас



Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би Аврагчийн Цагаатгалаар ирдэг адислалуудыг хүлээн авахад нь бусдад хэрхэн туслах вэ?

Аароны санваартнууд нь Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад нь бусдад туслах ариун үүрэгтэй. Тэд ариун ёслолыг бэлтгэж гүйцэтгэх, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлуудыг хийх, бүхнийг Христэд ирэхэд урих зэргээр үүргээ гүйцэтгэдэг.

Ариун ёслолыг бэлтгэх, гүйцэтгэх эсвэл түүнээс хүртэх үед таны сэтгэл ямар байдаг вэ? Яагаад ариун ёслол танд чухал байдаг вэ?

Залуу эрэгтэйчүүд ариун ёслолын талаар юу гэж боддог вэ? Тэд ариун ёслолыг гүйцэтгэхэд илүү сайн бэлтгэхийн тулд юу хийж болох вэ? Та тэднийг энэхүү чухал үүргийнхээ талаар юут ойлгоосой хэмээн хүсдэг вэ? Аароны санваартнууд Цагаатгалын адислалуудаа хүлээн авахад нь бусдад өөр ямар аргаар тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Цагаатгалын адислалуудаа хүлээн авахад нь бусдад туслах үүргээ ойлгоход залуу эрэгтэйчүүдэд ямар судрууд болон Сүмийн удирдагчдын хэлсэн ямар үгс тусалж чадах вэ?

Лук 22:19–20; 3 Нифай 18:1–11 (Есүс Христ ариун ёслолыг тогтоосон)

С ба Г 20:76–79 (Аароны санваартнууд ариун ёслолыг гүйцэтгэдэг)

С ба Г 38:42 (Санваартнууд ёслолуудыг гүйцэтгэх зохистой байх ёстой)

Обадиа 1:21 (Бид Сион уулан дээрх аврагчид байх болно)

Бойд К.Пакэр, “Цагаатгал,” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 11-р сар, 75–78

“Ариун ёслол,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 25–26

“Сионы уулан дээр аврагчид болох нь,” *Сүмийн ерөнхийлөгчдийн заасан сургаалаас: Иосеф Смит* (2011), 531–542

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж буй ямар нэг зүйлийг хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэдэнд ямар асуулт байна вэ? Тэд сурч мэдсэн зүйлийнхээ дагуу хэрхэн амьдарч байна вэ?
- “Цагаатгалын адислалуудыг хүлээж авахад нь би бусдад хэрхэн туслах вэ?” асуултын хариултаа самбар дээр жагсаан бичихэд чуулгын гишүүдийг урь.

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго нь Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад нь бусдад туслахын тулд санваарын үүргүүдээ хэрхэн биелүүлэх ёстойг ойлгоход залуу эрэгтэй бүрд туслах явдал мөн. Чуулгын гишүүд энэ хичээлийн нэг хэсэг болгож Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номдоо санваарын ёслолуудыг хүндэтгэлтэйгээр гүйцэтгэх төлөвлөгөө гаргах ёстой. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо сүм дээр авчрахыг чуулгын цуглааны өмнө залуу эрэгтэйчүүдээс хүс. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх талаар ямар туршлага хуримтлуулж байгаагаа чуулгын дараагийн цуглаанууд дээр хуваалцахад тэднийг урь.

- Нэг залуу эрэгтэйг Аврагчийн ариун ёслол гүйцэтгэж байгаа зургийг ангийнхандаа үзүүлэхэд урь (Сайн мэдээний уран зургийн ном, 54-ийг үзнэ үү). Зураг дээр дүрсэлсэн үйл явдлыг болон Аароны санваартнууд өнөөдөр ариун ёслолыг гүйцэтгэхдээ Есүс Христийг хэрхэн төлөөлснийг тайлбарлахыг түүнээс хүс. Ариун ёслолыг бэлтгэж, гүйцэтгэх үед тэдэнд ямар мэдрэмж төрж байсныг залуу эрэгтэйчүүдээс асуу.
- Сургаал ба Гэрээ 20:76–79, Лук 22:19–20, 3 Нифай 18:1–11-ийг хоёр хоёроороо уншихад залуу

эрэгтэйчүүдийг урь. Ариун ёслолын талх, ус юуг төлөөлдөг; санваартнууд ариун ёслолыг бэлтгэж, гүйцэтгэхдээ хэнийг төлөөлдөг тухай ярилцахыг тэднээс хүс (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, 24-ийг үзнэ үү). Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо “Ажилла” хэсгийг гаргаж (25, 49, 73-р хуудас), ярилцсан зүйл дээрээ үндэслэн, төлөвлөгөө гаргахад залуу эрэгтэйчүүдийг урь. Эцэг эхээсээ эсвэл удирдагчдаасаа дараах зүйлийг асуухад тэднийг урамшуулан дэмж. Ариун ёслол таны хувьд ямар ач холбогдолтой вэ? Ариун ёслолыг хамгийн чухал зүйл

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөөнүүд

Чуулгын цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдэд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөө гаргах цаг гаргаж өг. Энэ төлөвлөгөө хувь хүнийх боловч чуулгын гишүүд төлөвлөгөөнийхөө талаар бие биедээ санал бодлоо хэлж болно.

байлгахад туслахын тулд Аароны санваартны хувьд би юу хийж болох вэ? Эдгээр асуултын хариулыг болон гаргасан төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцад ямар туршлага хуримтлуулснаа дараагийн чуулгын цуглаан дээр хуваалцахад чуулгын гишүүдийг урь.

- Сургаал ба Гэрээ 38:42-ыг чуулгаараа уншиж, энэ шүлэг Цагаатгалын бэлгэдлүүд бүхий “савнуудтай” ажилладаг хүмүүст хэрхэн хамаатайг ярилц (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, 48-ыг үзнэ үү). Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, тэд санваараа ашиглахын тулд цэвэр ариун байх ёстой шалтгаануудыг олж мэдэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо “Ажилла” хэсгийг гаргаж (25, 49, 73-р хуудас), сурч мэдсэн зүйл дээрээ үндэслэн, төлөвлөгөө гаргахад тэднийг урь.

- Ариун ёслолын залбирлуудыг уншин, эдгээр залбирал дахь гэрээнүүдийг олж, гэрээнүүд нь юу гэсэн утгатай болохыг тайлбарлахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ямар үгс тэдэнд онцгой ач холбогдолтой вэ? (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, 72-ыг үзнэ үү). Ариун ёслол гүйцэтгэж байгаа хүмүүсийн зан харьцаа, биеэ авч яваа байдал нь цугларагсдад хэрхэн нөлөөлдөг вэ? Залуу эрэгтэйчүүд *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номныхоо “Ажилла” хэсгийг гаргаж,

уншин (25, 49, 73-р хуудас), сурч мэдсэн зүйл дээрээ үндэслэн, төлөвлөгөө гаргахад суралцагчдыг урь.

- Ариун сүмийн ёслолуудыг хийлгэлгүй нас барсан өвөг дээдсийнхээ зургийг харуул эсвэл залуу эрэгтэйчүүдээс өвөг дээдсийнхээ зургийг авчрахыг хүс. Тэдгээр нас барагсдад Цагаатгалын адислалуудаас хүртэхэд нь хэрхэн тусалж болох талаар ярилцахыг хүс. “Харин тэд Сион уулан дээр хэрхэн аврагчид болох вэ?” гэж эхэлсэн догол мөрийг залуу эрэгтэйчүүдээр судлуул. (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2011) 41-р бүлгээс). Сион уулан дээр аврагч байх нь гэдэг нь ямар утгатай болох талаар ярилц. Сион уулан дээрх аврагчдын хувьд залуу эрэгтэйчүүдийг тохиолдож байсан туршлагуудаасаа хуваалцахыг хүс.

- Гэрлийг төлөөлөн харуулж болох ямар нэг зүйлийг (жишээ нь: чийдэнгийн шил, гар чийдэн гэх мэт) хичээл дээр авчир. Ерөнхийлөгч Боид К.Пакэрын “Цагаатгал” хэлсэн үгийн эхэн дэх түүхийг тэдэнтэй хуваалцаж, бусдад гэрэл байх гэдэг нь юу гэсэн утгатайг бодоход залуу эрэгтэйчүүдийг урь. Бид тусламж хэрэгтэй хүмүүст хэрхэн “доод гэрэл” нь байж болох тухай бодол санаагаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Бид санваарын үүргээ биелүүлж байгаа үед хэрхэн доод гэрэлтэй адилхан байдаг вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч тухайн нөхцөл байдал бүрд шавь нартаа үлгэр жишээ үзүүлэн, халамжлан хүмүүжүүлэгч нь болж, тэдэнтэй хамт залбирч мөн хэрхэн залбирахыг тэдэнд заадаг байв. Тэрбээр тэднийг хайрлан, үйлчлэх замаар хайр ба үйлчлэлийн тухай заадаг байлаа. Та өөрийн заадаг зарчмуудаар хэрхэн үлгэр дуурайл үзүүлж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд санваартнуудын хувьд Цагаатгалын адислалуудаа хүлээн авахад нь бусдад хэрхэн тусалж болохоо ойлгодог уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалд илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа хүн цуглааныг хаана. Тэрээр:

- Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номонд өөрийн бичсэн төлөвлөгөөг болон үүнийг биелүүлэх шийдвэр төгс байгаагаа хуваалцаж болно.
- Сүм дээр хүрч ирэх боломжгүй хүмүүст ариун ёслолыг (бишопын удирдлаган дор) чуулгын гишүүд хэрхэн гүйцэтгэж болох тухай ярилц.



Есүс Христийн Цагаатгал гэж юу вэ?

Цагаатгал бол гэм нүгэл, сорилт бэрхшээл, үхэл хагацлыг даван туулахад бидэнд туслахын тулд Есүс Христийн хийсэн золиослол юм. Есүсийн цагаатгагч золиослол Гетсеманий Цэцэрлэг болон Калварийн загалмай дээр тохиосон юм. Тэрбээр бидний нүглийн төлөөсийг төлж, Өөр дээрээ үхлийг авсан ч амилсан. Цагаатгал бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын хайрын дээд илрэл билээ.

Та Цагаатгалын тухай хэрхэн гэрчлэлтэй болсон бэ? Цагаатгал амьдралыг чинь хэрхэн адисалсан бэ?

Цагаатгалын тухай залуу эрэгтэйчүүд юу ойлгосон бэ? Цагаатгалын тухай тэд судруудаас юуг нээж олон, бие биедээ юуг зааж болох вэ? Цагаатгалын төлөөх талархлыг тэд хэрхэн мэдэрч, харуулж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Цагаатгал тэдний амьдралд ямар ач холбогдолтойг ойлгоход ямар материалууд залуу эрэгтэйчүүдэд туслах вэ?

Матай 26–27 (Есүс Христ Гетсеманид загалмай дээр бидний нүглийн төлөөсийг төлж, бидний өвчин эмгэгийг Өөр дээрээ авсан)

Матай 28:1–10 (Есүс Христ Амилалтаараа дамжуулан үхлийг ялсан)

2 Нифай 9:6–16 (Есүс Христ Өөрийн Цагаатгалаар дамжуулан нүгэл, үхэл хоёрыг ялсан)

Алма 7:11–13 (Есүс Христ бидний өвчин эмгэг, төгс бус байдал, нүгэл хилэнцийг Өөр дээрээ авсан юм)

Томас С.Монсон “Тэр амилсан!” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 67

Линда К.Бөртэн “Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл бидний зүрхэнд бичигдсэн үү?” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 11-р сар

“Есүс Христийн Цагаатгал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 91–97

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс нэг асуултыг (хичээлийн нэрийг) самбар дээр бич. Энэ асуултанд хариулахад тусалсан юуг тэд өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсныг нь чуулгын гишүүдээс асуу. Сурсан зүйлийнхээ дагуу амьдралын тулд тэд юу хийсэн бэ?
- Цагаатгалын үйл явдлуудыг дүрсэлсэн зургуудыг үзүүлж (Аврагч Гетсеманий цэцэрлэгт зовсон нь, Түүнийг цовдолсон болон Амилсан нь гэхчилэн; *Сайн мэдээний уран зургийн ном*, 56–59-ийг үзнэ үү), эдгээр үйл явдлын тухай мэддэг зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Цагаатгалын тухай асууаа хүссэн асуултаа бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэдний асуултуудыг цуглуулж, хэрэв тохиромжтой гэж үзвэл асуултуудыг чанга унш. Хичээлийн турш асуултынхаа талаар эргэцүүлэн бодоход залуу эрэгтэй бүрийг урамшуулан дэмж. Хичээлийн төгсгөлд асуултуудынхаа хариултыг хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

Ангийн гишүүдээс үр ашигтай асуултууд асууж, хариулахаасаа өмнө тунгаан бодох цагийг гаргаж өгсөн үед тэд хичээлд идэвхтэй оролцдог. Чуулгын гишүүдэд тунгаан бодох цаг гаргаж өгөхийн тулд самбар дээр асуултуудыг бичих буюу чуулгын гишүүдээр хариултыг нь цаасан дээр бичүүлж болно (*Teaching, No Greater Call* [1999], 68–70-ыг үзнэ үү).

Доорх үйл ажиллагаа бүр нь Есүс Христийн Цагаатгалыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Энэ хичээлийн аль нэг хэсгийг заахад чуулгын нэг гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Цагаатгалын тухай сурч мэдэх болон заах төлөвлөгөөний нэг хэсэг болгон биелүүлж болно (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү). Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн “Тэр Амилсан!” хэлсэн үгийг уншихыг та түүнд зөвлөж болно.
- Матай 26–28 дахь Аврагчийн амьдралын сүүлчийн хэдэн цагт болсон нэг үйл явдлыг авч үзэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс (Гетсеманид зовон шаналсан, Христээс урвасан болон Цовдолт, Амилалт гэх зэрэг). Залуу эрэгтэйчүүд эдгээр үйл явдлуудаас Аврагч болон Түүний Цагаатгалын тухай юу мэдсэн бэ? Аврагч тэдний төлөө юу хийсэн талаар ямар бодол дүгнэлттэй байгаагаа хуваалцахад чуулгын цөөн гишүүнийг урь.
- “Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл бидний зүрхэнд бичигдсэн үү?” гэдэг Линда К.Бөртэний хэлсэн үгээс Цагаатгалын зарчмуудын нэгийг уншихад залуу эрэгтэй бүрийг урь. Мөн энэ зарчмын тухай уншсан хэн нэгнийг олохыг тэднээс хүсээд, олж мэдсэн зүйлийнхээ

тухай ярилцан, өөрийнхөө амьдралын эсвэл таньдаг хүмүүсийнхээ амьдралын жишээнүүдийг хосоор хуваалцахад тэднийг урь. Ярилцсан зүйлээ чуулгын үлдсэн хэсэгтэй хуваалцахыг хос бүрийн нэг гишүүнээс хүс.

- 2 Нифай 9:6–16-г уншиж, Цагаатгалын хэрэгцээний тухай зааж байгаа шүлгүүдийг олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Сонгож авсан шүлгүүдээ болон тэдгээр нь юу зааж байгааг хуваалцах цагийг хэдэн залуу эрэгтэйчүүдэд гаргаж өг. Бурханд итгэдэггүй хэн нэгэнд захидал бичиж, Цагаатгал яагаад чухал болох, бидэнд яагаад Аврагч хэрэгтэйг тайлбарлахдаа эдгээр шүлгүүдийг ашиглахад тэднийг дэмж. Бичсэн захидлаа хоорондоо хуваалцахыг тэднээс хүс.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Цагаатгалыг илүү сайн ойлгож чадсан уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалд илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Гэр бүл болон найз нартаа Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад нь туслахын тулд юу хийж болох тухайгаа бичиж, хуваалцахад чуулгын гишүүдийг урь.

- Залуу эрэгтэйчүүдийн заримаас нь Алма 7:11–13-ыг, бусдаас нь Библийн лавлах дахь ач ивээлийн тухай уншихыг хүс. Цагаатгал тэдний амьдралыг хэрхэн адисалсан тухай сурч мэдсэн зүйлээ хуваалцахад тэднийг урь. Цагаатгалын хүч бидний нүглийн төлөөсийг төлснөөс гадна бидэнд хэрхэн тусалсан бэ? Залуу эрэгтэйчүүдийг хэн нэгэн Цагаатгалаар дамжуулан хүчирхэгжсэн амьдралынхаа туршлагаас эсвэл судруудын жишээнээс хуваалцахыг хүс.

- Энэ хэсэгт жагсаасан видео бичлэгүүдээс нэгийг эсвэл хэд хэдийг үзсэний дараа санал бодлоо бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Есүс Христийн Цагаатгалд яагаад талархалтай байдгаа хуваалцахыг тэднээс хүс.

Аврагчийн арга барилгаар заах нь

Аврагч Өөрийн үүрэг зорилгыг заахын тулд судруудыг ашигладаг байв. Тэрээр судруудын тухай өөрсдөө тунгаан бодохыг хүмүүст заадаг байв. Есүс Христийн Цагаатгалыг ойлгоход судруудыг ашиглахад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд та юу хийж болох вэ?



Есүс Христэд итгэх гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бид аврагдахын тулд итгэлээ Их Эзэн Есүс Христ дээр төвлөрүүлэх ёстой. Есүс Христэд итгэнэ гэдэг нь Түүнд итгэж, зарлигуудыг нь дагана гэсэн үг юм. Итгэл бишрэл гэдэг бол зүгээр нэг идэвхгүй итгэхээс илүү чухал зүйл мөн. Бид итгэлээ үйлдлээрээ болон амьдралын хэв маягаараа харуулдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Итгэлийн тухай судрууд болон бусад эх сурвалжийг судлахдаа, Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд туслах зүйлсийг эрж ол.

Еврей 11:4–9, 17–29; Ифер 12:11–22 (Итгэлээ харуулсан хүмүүсийн жишээ)

Иаков 1:5–6; 2:14–20 (Итгэл бол итгэл ба үйлдэл юм)

Алма 32:21, 26–43 (Итгэл бол үнэн боловч харагддаггүй зүйлсэд найдах явдал мөн)

Моронай 7:33–41 (Гайхамшгууд итгэлээр үйлдэгддэг)

Нийл Л.Андэрсэн, “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 54–57

Рассэлл М.Нэлсон, “Итгэлээ харуул,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Итгэл,” *Итгэлдээ үнэнч байх нь*, 117–120

Та Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн хөгжүүлсэн бэ? Залуу эрэгтэйчүүдэд итгэлээрээ үйлдэхэд нь сүнслэгээр нөлөөлж болох ямар туршлагуудыг та тэдэнтэй хуваалцаж чадах вэ?

Таны заадаг Аароны санваартнууд Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн ашигладаг вэ? Тэд итгэлээ бэхжүүлэхийн тулд юу хийж байна вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа аль болох олон зүйлийг 30 секундэд багтаан бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс. Бичсэн зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Та итгэлийн тухай сэдвийг заахдаа тэдний жагсаалтыг хэрхэн ашиглаж болох вэ?
- Энгийн завь зураад, дээр нь “Итгэл” гэж бич. Хоёр сэлүүрийн

нэгэн дээр “Итгэл,” нөгөө дээр нь “Үйлдэл” гэж бич. Хэрэв завь ганцхан сэлүүртэй бол хэрхэхийг тэднээс асуу. Хэрэв бид итгэдэг зүйлээ үйлдлээр харуулахгүй бол бидний итгэлд юу тохиолдох вэ? Итгэл гэж юу болох, энэ зураг итгэлтэй хэрхэн холбоотойг ойлгоход чуулгын гишүүдэд туслахын тулд судруудыг эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь* (117–120-р хуудас) товхимлыг ашигла.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь Есүс Христэд итгэлтэй байна гэдэг нь юу гэсэн утгатайг ойлгоход чуулгын гишүүн бүрд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь төлөвлөгөөнийхөө дагуу итгэлийн тухай сурч мэдэх болон заах төлөвлөгөөний нэг хэсэг болгон биелүүлж болно (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Залуу эрэгтэйчүүдийг Иаков 2:14–20-ийг уншихад урьж, Иаков итгэл ба үйлдлийн хоорондын харилцааны талаар заахын тулд ямар жишээнүүд ашигласан болохыг олж тогтоо. Иаковын итгэлийн тухай зааж буй зүйлийг өөрийн үгээр нэгтгэн дүгнэхийг цөөн суралцагчаас хүс. Ахлагч Нийл Л.Андэрсэны “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг”

эсвэл ахлагч Рассэлл М.Нэлсоний “Итгэлээ харуул” хэлсэн үгээс итгэлээ үйлдлээрээ харуулсан хүмүүсийн жишээг олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Тэднээс олж мэдсэн зүйлсээ хуваалцаж, итгэлээ хэрхэн харуулж болох талаар ярилцахыг хүс.

- Есүс Христэд итгэх итгэл дээрээ үйлдсэн түүхийг судраас олохыг залуу эрэгтэй бүрээс хүс (жишээ нь: Египетээс Гарсан нь 14:19–28; Матай 8:5–13; Еврей 11:4–9, 17–29; Ифер 12:11–22; 1 Нифай 4). Тэд өөрсдөө эсвэл таньдаг хэн нэгэн нь Есүс Христэд итгэх итгэлээ ашигласан туршлагын тухай бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Судраас уншсан түүх болон өөрийн бичсэн

Заахад туслах арга

“Судруудаас заах үед суралцагчдаас ямар нэг онцгой зүйл эрж олохыг хүсэх нь чухал ашиг тустай байдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 55).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч “Миний сургаал
минийх биш, харин
Намайг Илгээгчийнх”
(Иохан 7:16) гэж хэлсэн
байдаг. Тэрбээр Эцэгээ-
сээ сурсан сургаалыг заа-
даг байлаа. Та зөв сургаал
зааж байгаагаа хэрхэн
бататгах вэ? (*Teaching,
No Greater Call*, 52–53-ыг
үзнэ үү.)

туршлагыг хуваалцахад бүх залуу
эрэгтэйг урь. Тэд үүнийг жижиг
бүлгүүдээр эсвэл чуулгаараа хамт-
даа хийж болно.

- Итгэл гэж юу вэ? Есүс Христэд
итгэх итгэлтэй байна гэдэг нь юу
гэсэн үг вэ? Би итгэлээрээ хэрхэн
амьдрах вэ? Би итгэлээ хэрхэн өсгөж
байна вэ? гэсэн асуултуудыг самбар
дээр бич. “Итгэлдээ үнэнч байх нь”
товхимол дахь “Итгэл” гарчигтай
хэсгүүдээс чуулгын гишүүн бүрд
нэгийг хуваарилж өг. Даалгасан
хэсгээ, түүний дотор судрын эшлэ-
лүүдийг уншиж, самбар дээрх
асуултуудын хариултыг эрж олоход
залуу эрэгтэйчүүдийг урь. Хариул-
таа самбар дээр бичиж, сурч мэдсэн
бусад зүйлээ чуулгатай хуваалцахад
тэднийг урь.

- Матай 17:20-ийг уншихыг залуу
эрэгтэйчүүдээс хүсч, уулыг итгэ-
лээр нүүлгэх гэдэг нь юу гэсэн

*Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Есүс Хри-
стэд итгэлтэй байх гэдгийн утгыг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй
байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалд илүү их цаг зарцуулах
шаардлагатай юу?*

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Есүс Христэд итгэх итгэлтэй байх
гэдэг нь юу гэсэн үг болох тухай
мөн энэхүү итгэлээрээ юу хийхээр
төлөвлөж байгаа тухай бодол санаа-
гаа хуваалцаж болно.

утгатайг тэднээс асуу. Бишоп
Ричард К.Эйжлийн хэлсэн дараах
үгийг хуваалц: “Газар дээрх жин-
хэнэ уулыг нүүлгэхийг би хэзээ ч
хараагүй. Харин итгэлийн ачаар
уулс лугаа адил эргэлзээ, цөхрөлийг
итгэл найдвар ба өөдрөг үзлээр
халж, ор мөргүй болтол арилгахыг
би харсан. Итгэлийн ачаар уулс
лугаа адил нүглийг наманчлал
ба уучлалаар халахыг би харсан.
Түүнчлэн итгэлийн ачаар уулс
лугаа адил өвчин зовлонг амар
амгалан, итгэл найдвар хийгээд
талархлаар солихыг би харсан.
Тийм ээ, уулс нүүлгэгдэхийг би хар-
сан” (“Итгэл- Сонголт бол чинийх,”
Ensign эсвэл *Liahona*, 2010 оны
11-р сар, 33). “Цэвэр бөгөөд энгийн
итгэл” видео бичлэгийг үзүүлж,
итгэлийн ачаар нүүлгэгдсэн уулсыг
олохыг (эсвээс өөрийнхөө туршла-
гыг хуваалцахыг) залуу эрэгтэйчүү-
дээс хүс.

- Тэдний итгэл санваарын үйлчлэлд
нь хэрхэн харагддаг тухай ярилцаж
болно.

Сонгосон материалууд

“Итгэл” хэсгээс авсан эшлэл Итгэлдээ үнэнч байх нь (2004), 54–56

Их Эзэн Есүс Христэд итгэх нь

Таныг аврал руу хөтлөхөд таны итгэл Их Эзэн Есүс Христ дээр төвлөрсөн байх ёстой (Үйлс 4:10—12; Мозая 3:17; Моронай 7:24—26; Итгэлийн Тунхаг 1:4-ийг үзнэ үү). Та Түүнийг амьдардаг гэдэгт мөн Түүний мөн чанарын талаар зөв бодолтой байж, Түүний хүслийн дагуу амьдрахыг хичээж байгаа мэдлэгтэй байгаадаа итгэлтэй байх аваас Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж чадна.

Есүс Христэд итгэх итгэлтэй байна гэдэг нь Түүнд бүрэн дүүрэн итгэх—Түүний хязгааргүй хүч, оюун билэг болон хайранд итгэнэ гэсэн утгатай юм. Энэ нь Түүний сургаалд итгэх итгэлийг бас хамруулдаг. Энэ нь та Түүний ойлгодог бүх зүйлсийг ойлгохгүй боловч итгэж байна гэсэн үг юм. Тэрээр таны бүх өвчин зовлон, шаналал, доройтлуудыг чинь туулсан учраас таныг өдөр тутмынхаа бэрхшээлүүдийг хэрхэн даван туулахад хэрхэн туслахаа мэддэг гэдгийг сана (Алма 7:11—12; С ба Г 122:8-ыг үзнэ үү). Тэрээр “ертөнцийг ялсан” (Иохан 16:33) бөгөөд таны мөнх амьдралыг хүлээн авах замыг бэлтгэсэн юм. Та Түүний гуйлтыг санаж чадваас Тэр үргэлж чамд туслахад бэлэн байдаг: “Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай” (С ба Г 6:36).

Итгэлээр амьдрах нь

Итгэл гэдэг нь сохор итгэл бишрэлээс хамаагүй илүү зүйл юм. Та итгэлээ амьдарч байгаа байдал—үйлдлээрээ дамжуулан илэрхийлдэг.

“Хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд шаардлагатай болох аливаа

зүйлийг хийх хүчтэй байх болно” гэж Аврагч амласан (Моронай 7:33). Есүс Христэд итгэх итгэл таныг Түүний төгс жишээг дагахад зоригжуулж чадна (Иохан 14:12-ыг үзнэ үү). Итгэл тань таныг сайн үйлс бүтээх, зарлигуудыг дагах болон нүглээ наманчлахад хөтөлж чадна (Иаков 2:18; 1 Нифай 3:7; Алма 34:17-г үзнэ үү). Итгэл тань таныг уруу таталтыг даван туулахад тусалж чадна. Алма хүү Хиламандаа “тэдэнд чөтгөрийн уруу таталт болгоныг, Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг заа” хэмээн зөвлөсөн билээ (Алма 37:33).

Их Эзэн итгэлийн тань дагуу амьдралд тань агуу гайхамшгуудыг бүтээх болно (2 Нифай 26:13). Есүс Христэд итгэх итгэл нь Түүний Цагаатгалаар сүнсний болон бие махбодын эдгээлтийг хүлээн авахад тусалдаг (3 Нифай 9:13–14-ийг үзнэ үү). Сорилтын цаг тулгарахад бэрхшээлтэй урам зоригтойгоор нүүр тулж, урагш алхах хүч чадлыг итгэл танд өгч чадна. Тэр ч байтугай ирээдүй тодорхой бус санагдахад Аврагчид өгсөн итгэл тань танд амар амгаланг өгч чадна (Ром 5:1; Хиламан 5:47-г үзнэ үү).

Итгэлээ хөгжүүлэх нь

Итгэл нь Бурханаас ирдэг бэлэг боловч итгэлээ улам бат бөх байлгахын тулд арчилж тордох ёстой. Итгэл бол яг л гарын тань булчинтай адил байдаг. Хэрэв та дасгал хийн хөгжүүлбэл энэ нь улам л хүчтэй хатуу болдог. Хэрэв булчингаа тоохгүй орхивол энэ нь унжийж сул болдог.

Итгэлийн бэлгийг Тэнгэрлэг Эцэгт хандан Есүс Христийн нэрээр залбирснаар хөгжүүлж чадна. Та Эцэгтээ талархалаа илэрхийлж, Түүнээс өөртөө болон бусдад хэрэгтэй адислалыг гуйвал Түүнд ойртох болно. Цагаатгал нь таныг

Сонгосон материалууд

нигүүлслийн төлөө залбирах боломжтой болгосон Аврагч руу хөглөх болно (Алма 33:11-ийг үзнэ үү). Та мөн Ариун Сүнсний намуухан удирдамжийг хүлээн авах чадвартай болно.

Зарлигуудыг сахиснаар та өөрийн итгэлээ хүчирхэгжүүлж чадна. Бурханаас авсан бүхий л

адислалуудын адил итгэлийг хувийн дуулгавартай байдал болон зөв шударга үйлдлээр дамжуулан олж авч мөн өсгөн нэмэгдүүлж болдог. Хэрэв та итгэлээ боломжтой гэх хамгийн өндөр түвшинд хүргэн хөгжүүлэн баяжуулахыг хүсвэл байгуулсан гэрээнүүдээ сахих хэрэгтэй.



Наманчлах гэж юуг хэлдэг вэ?

Бидэнд наманчлах боломж олгохын тулд Есүс Христ бидний нүглийн төлөө шийтгэл хүлээсэн. Наманчлал бол биднийг Бурханд улам ойртуулдаг зүрх сэтгэл, оюун санааны өөрчлөлт юм. Нүглийг орхиж, уучлагдахын төлөө Бурхан руу эргэх нь наманчлал мөн. Наманчлал нь Бурханыг хайрлах хайр, Түүний зарлигуудыг дуулгавартай дагах чин сэтгэлийн хүслээр өдөөгддөг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон бусад эх сурвалжийг залбирч судал. Наманчлахад чинь юу сүнслэгээр нөлөөлсөн бэ?

Наманчлах талаар та ямар туршлага хуримтлуулсан бэ? Та хувь хүний нүглийн тухай ярихгүйгээр, наманчлах нь Тэнгэрлэг Эцэгт улам ойртоход тусалдаг тухай хэрхэн хуваалцаж болох вэ?

Зарим залуу эрэгтэй зохисгүй байдалтайгаа тэмцэж байж болох юм. Энэ нь итгэлтэй санваартнуудын үйлчлэх чадварт нөлөөлөх болно. Та тэдний асуудалд мэдэрэмтгий хандаж, наманчлах хүсэлтэй болоход нь туслахын тулд Сүнсийг хэрхэн урьж болох вэ?

Исаиа 1:18 (Бид наманчлалаар дамжуулан нүглээсээ ариусан цэвэршиж чадна)

Ром 3:23; 1 Иохан 1:8 (Бид бүгд нүгэл үйлддэг)

Алма 19:33 (Наманчлал зүрх сэтгэлийг өөрчилдөг)

Алма 36:6–24 (Алма наманчилж, Аврагчийн ач ивээлээр дамжуулан уучлагдсан)

Алма 39:8 (Бид нүглээ Бурханаас нууж чаддаггүй)

С ба Г 58:42–43 (Бид наманчлахын тулд нүглээ хүлээж, дахин нүгэл үйлдэхгүй байх ёстой)

Дийтр Ф.Угдорф, “Тэр таныг мөрөн дээрээ тавиад, гэртээ авчрах болно,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 114

“Наманчлал,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 28–29

Аллэн Д.Хэйни, “Хэнд итгэсэнэ санагтун,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 117–119

Д.Тодд Кристоффэрсон, “Наманчлалын бурханлаг бэлэг,” *Ensign* эсвэл *Liahona*, 2011 оны 11-р сар, 38–40

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногт сурсан ямар нэг зүйлийг нь сануулах зураг зурж, зурсан зүйлийнхээ тухай хамтран ярилцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Нэг залуу эрэгтэйн гарыг урагш сунгуулан, хоёр гарт нь хүнд юм бариулж зогсоогоод, чуулгын гишүүдийг нүгэл хэрхэн хүнд ачаатай адил болох тухай ярилцуул. Ярилцах үедээ, хүнд юм барин зогсож байгаа залуу эрэгтэйн хоёр гар дээр илүү хүнд зүйл нэмж тавь. Гар дээрх юмсыг нь аваад, нүгэл болон наманчлалын тухай энэхүү үзүүлэнт хичээлээс юу сурснаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь наманчлах гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын нэг гишүүнийг ахлагч Аллэн Д.Хэйнигийн хэлсэн “Хэнд итгэснээ санагтун” хэмээх үгийн эхэн хэсэгт гардаг түүхийг эсвэл ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн “Тэр таныг мөрөн дээрээ тавиад, гэртээ авчрах болно” хэмээх үгэнд гардаг Фрауэнкирхег сэргээн босгосон тухай эсвэл алдагдсан хонины сургаалт зүйрлэлийг хуваалцахад бэлдэж ирэхэд урь. Та эдгээр түүхийг өгүүлдэг видео бичлэгүүдийг үзүүлж болно. Түүхүүд бидэнд наманчлалын талаар юу зааж байна вэ? Хэлсэн үгсээс наманчлалын талаарх өгүүлбэрүүдийг жижиг цаасан дээр тэмдэглэж ав. Залуу эрэгтэйчүүдийг нэг өгүүлбэр сонгон авч, юу ойлгож мэдсэнээ эхлээд хамтрагчтайгаа, дараа нь ангийнхантайгаа хуваалцахад урь. Ойлгож мэдсэн зүйл дээрээ үндэслэн өөрчлөх хэрэгтэй гэж санагдсан зүйлсийнхээ талаар бодох цагийг тэдэнд гаргаж өг.
- Энэ хичээлийн аль нэг хэсгийг заахад чуулгын нэг гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд наманчлалын тухай сурч мэдэх болон заах төлөвлөгөөний нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлго,” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Чуулгын бусад гишүүнийг харж байхад ямар нэг зүйлийг нуухыг нэг хөвгүүнээс хүс. Чуулгын өөр нэг гишүүнээс нуусан зүйлийг нь олохыг хүс. Энэ жишээ Бурханаас нүглээ нуух гэж оролдвол юу болдгийг хэрхэн зааж байна вэ? (Алма 39:8-ыг үзнэ үү). Хэн ч нүглээ Бурханаас нууж чадахгүй гэдгийг бидэнд заадаг судрын ямар түүхийг

Заахад туслах арга

“Сурах үйл ажиллагаанд суралцагч гол үүрэг гүйцэтгэх ёстой. Хэрэв багш сурах үйл ажиллагааны од болж, гол үүрэг гүйцэтгэн, үргэлж өөрөө л яриад байвал, энэ нь үнэн хэрэгтээ ангийн гишүүдийн сурах үйл явцад саад учруулж байгаа хэрэг юм” (Асаел Д.Вудрафф, *Teaching, No Greater Call* [1999], 61).

залуу эрэгтэйчүүд хуваалцаж болох вэ? (жишээ нь: Иона 1–2; 2 Самуел 11–12; Үйлс 5:1–11-ийг үзнэ үү).

Дараах асуултуудыг жижиг бүлгүүд болж ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Үүнд: Хүмүүс нүглээ нуухыг оролддог ямар жишээ байна вэ? Нүглээ нууж чадахгүй гэдгийг ойлгоход нь хэн нэгэнд туслахын тулд та юу гэж хэлэх вэ?

- Алмагийн болон Мозаягийн хөвгүүдийн зургийг өргөж харуулан (*Сайн мэдээний уран зургийн ном*, 77-г үзнэ үү), тэдний наманчлалын түүхийг товчхон ярих нэг хүнийг урь (Алма 36:6–24-ийг үзнэ үү). Алма 36:13, 17–20, 23–24-ийг ганцаарчлан уншиж, энэ шүлгүүд дэх наманчлалын зарчмуудыг олон, олж мэдсэн зүйлээ жижиг бүлгүүд болон хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Наманчлалын зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд хийж болох ямар нэг зүйлийн тухай бодож, бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Наманчлах гэдэг нь юу болохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаалд илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах ёстой. Тэрээр:

- Өөрийн бодол санааг хуваалцаж, Аврагчийн тухай болон наманчлах гэдэг нь ямар утгатай талаар бодол санаагаа хуваалцахыг чуулгын гишүүдээс хүсэж болно.

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь “Наманчлал” хэсгийг судал эсвэл энэ хэсэг дэх зөвлөмж болгосон хэлсэн үгсээс тодорхой хэсгийг сонгож авахад залуу эрэгтэй бүрийг урь. Залуу эрэгтэйчүүдээс онцгой чухал зүйлүүдийг тэмдэглэж, хуваалцахыг хүс. Наманчлалын талаарх өөрсдийн асуултыг нэрээ тавилгүйгээр бичихийг тэднээс хүс. Эдгээр асуултандаа хариулахыг бишпоосоо хүсэж, наманчлал нь санваарын хүчтэй хэрхэн холбоотой болохыг хуваалц.*

- “Within Bounds” видео бичлэгийг үзүүл. Чуулгын гишүүдийн хагасыг наманчлалын талаар энэ видео бичлэгээс юу сурч болохыг мөн нөгөө хагасаас бидэнд наманчлахад туслах бишопын үүргийн талаар олж мэдэхэд урь. Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс. Гаргасан алдааныхаа тухай бишоптоо ярихаас эмээдэг найзууддаа тэд юу гэж хэлэх бол?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдыг итгэлийнхээ дагуу үйлдэж, Өөрийн заадаг үнэнүүдийн дагуу амьдрахад урьдаг. Хүчирхэг туршлагаудаас суралцах боломжийг Тэрбээр тэдэнд олгодог. Өдөр бүр наманчлахаас ирдэг хүч чадлыг залуу эрэгтэйчүүд амьдралдаа олж харахад туслахын тулд та юу хийж болох вэ?

Сонгосон материалууд

“Наманчлал,” Залуучуудын бат бөх байдлын төлөө 28–29

Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно—болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно. Сургаал ба Гэрээ 58:43

Аврагч бидний гэм нүглүүдийн өмнөөс зовон шаналж, бидний төлөө Өөрийн амийг өгсөн. Энэ агуу золиослолыг Цагаатгал гэдэг. Та нарыг нүглээ наманчлах үед Цагаатгалаар дамжуулан та нар өршөөлийг хүлээн авч, нүглээсээ ариусан цэвэршиж чадна.

Наманчлал гэдэг нь буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөхөөс илүү утга учиртай юм. Энэ нь оюун ухаан, зүрх сэтгэлийн өөрчлөлт юм. Нүглийг орхиж, уучлалын төлөө Бурхан руу эргэх нь наманчлал юм. Наманчлал нь Бурханыг хайрлах хайр, Түүний зарлигуудыг дуулгавартай дагах чин сэтгэлийн хүслээр өдөөгддөг.

Сатан та нарт нүглээ наманчлах боломжгүй гэж бодуулахыг хүсдэг ч энэ нь туйлын худлаа зүйл юм. Хэрэв та нар даруусч, наманчлахад шаардлагатай хүч чармайлтыг гаргавал Аврагч та нарт өршөөлийг амалсан. Хэрэв та нар гэм нүгэл үйлдсэн бол хэр хурдан наманчилна, төдийчинээ хурдан өршөөл уучлалаас ирэх амар амгалан, баяр баяслыг олох болно. Та нар наманчлалыг хойшлуулах аваас адислал, боломж мөн сүнслэг

удирдамжаа алдах болно. Магадгүй та нар өөрсдийгөө гарахад хэцүү нүгэлт байдалд оруулж, эргэж гарах гарцаа олоход бүр хэцүү болгоно.

Зарим хүмүүс ариун сүмд орох, номлолд явахаасаа өмнө наманчилна гэж бодон санаатайгаар Бурханы тушаалуудыг зөрчдөг. Иймэрхүү санаатайгаар үйлдсэн нүгэл нь Аврагчийн Цагаатгалыг тохуурхаж байгаа хэрэг юм.

Та нар наманчлахын тулд та нар гэм нүглээ Их Эзэний өмнө хүлээх хэрэгтэй. Үүний дараа өөрийн гомдоосон хүмүүсээс уучлал эрж, болчимгүй үйлдлээрээ сэвтээсэн харилцаагаа сэргээ. Наманчлах үедээ та эцэг эхийнхээ тусламж зөвлөгөөг хүсээрэй. Бэлгийн харьцааны гэм нүгэл болон садар самуун зүйлсийг хэрэглэсэн ноцтой гэм нүглүүдийг бишопын өмнө буруугаа хүлээх хэрэгтэй. Бишоптойгоо чин шударга бай. Наманчлахад чинь тэр чамд тусална. Бишоптойгоо ямар гэм нүглийн талаар ярилцах ёстойгоо мэдэх хэрэгтэй бол эцэг эхээсээ эсвэл бишопоосоо асууж болно.

Наманчлал болон өршөөлийг хүлээн авахад шаардлагатай зүйлсийг хийхэд та нар Цагаатгалын хүч болон Бурханы хайрыг өөрсдөө мэдэх болно. Та нарт агуу хүч чадлыг авчрах Их Эзэн Есүс Христийн амар амгаланг мэдэрч, Түүнтэй илүү адилхан болно.



Ач ивээл гэж юу вэ?

Ач ивээл бол Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бидний хүлээж авдаг бурханлаг тусламж хийгээд хүч чадал юм. Бид ач ивээлээр дамжуулан нүгэл, үхэл хоёроос аврагддаг. Түүнээс гадна ач ивээл бол биднийг өдрөөс өдөрт хүчирхэгжүүлж, эцсээ хүртэл тэвчихэд бидэнд тусалдаг боломж олгогч хүч мөн. Бид Их Эзэний ач ивээлийг бүрэн хүлээж авахын тулд өөрсдөө их хичээж чармайх шаардлагатай.

Ач ивээл гэдэг нь таны хувьд юу гэсэн утгатай вэ? Та амьдралыг тань өөрчлөхөд тусалсан Есүс Христийн хүчийг хэрхэн мэдэрсэн бэ?

Залуу эрэгтэйчүүд ач ивээлийн тухай юу мэддэг вэ? Амьдралдаа буй ач ивээлийн хүчийг ойлгоход нь та тэдэнд хэрхэн тусалж болох вэ? Залуу эрэгтэйчүүд санваарын үүргүүдээ биелүүлэхээр хичээхэд ач ивээл тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ач ивээлийг ойлгоход тань ямар судрууд болон бусад эх сурвалж тусалсан бэ? Ач ивээлийг тэдэнд ойлгуулахын тулд та залуу эрэгтэйчүүдтэй юуны тухай хуваалцах хэрэгтэй гэж боддог вэ?

Ефес 2:8–9; 2 Нифай 25:23 (Бид ач ивээлээр аврагдана)

Филиппой 4:13; Иаков 4:6–7 (Есүс Христийн ач ивээл бидэнд хүч чадал өгдөг)

Моронай 10:32–33 (Ач ивээл биднийг Христээр төгөлдөржүүлж чадна)

Библийн лавлах, “Ач ивээл”

Дийтр Ф.Угдорф, “Ач ивээлийн бэлэг,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 95–99

Дэвид А.Бэднар, “Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Ач ивээл,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 41–43

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Хичээлд ямар нэг зүйл эсвэл зураг авчирч, энэ нь өнгөрсөн долоо хоногт сурч мэдсэн зүйлтэй нь ямар холбоотой болохыг залуу эрэгтэйчүүдээс асуу. Тэд сурч мэдсэн зүйлээ ашиглан өнгөрсөн долоо хоногт юу хийсэн бэ?
- Ач ивээлийн тухай юу мэддэгийг нь залуу эрэгтэйчүүдээс асуу. Ач ивээл гэдгийг тэд юу гэж ойлгодог вэ? Тэд ач ивээлийг амьдралдаа, санваарын үйлчлэлдээ хэрхэн харсан бэ? Тэд ач ивээлээр аврагдах болно гэдэгт итгэдэг үү? Ач ивээлийн тухай тэд юу асуудаг вэ? Та энэ ярилцлагын нэг хэсэг болгон энэ хэсгийн эхэн дэх ач ивээлийн тодорхойлолтыг хуваалцаж болно.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь ач ивээлийн тухай сургаалыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Самбар дээр онгорхой хаалга, цонх зурж, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Ач ивээлийн бэлэг” хэлсэн үгийн эхлэлийг судлахдаа, ач ивээлийг эдгээр зүйлтэй хэрхэн харьцуулсныг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүсэх талаар бодож үзээрэй. Энэ хэлсэн үгийн үлдсэн хэсгүүдийг залуу эрэгтэйчүүдэд хувааж өгөөд, уг хэсгээсээ ач ивээлийн талаар сурсан зүйлээ нэг өгүүлбэрт багтаан бичээд, хуваалцахыг хүс. Тэд Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү хоёрын ач ивээлийг хүртэхийн тулд юу хийх ёстой вэ?
- Хэдэн өдрийн өмнөөс чуулгын нэг гишүүнийг Матай 11:28–30 болон ахлагч Дэвид А.Бэднарийн “Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд” хэлсэн үгийг судлан, Аврагчийн буулгыг өөрсөд дээрээ авна гэдэг нь ямар утга учиртай болохыг судлахыг хүс. Чуулгын цуглаан дээр ирэхдээ сурсан зүйлийнхээ талаар мөн Есүс Христтэй харилцах бидний харилцааг буулга нь хэрхэн төлөөлж болох тухай ярилцлага өрнүүлэх бэлтгэлтэй ирэхийг хүс. Аврагчийн ач ивээлийг ойлгоход нь чуулгын гишүүдэд туслах хэсгийг ахлагч Бэднарийн хэлсэн үгээс хуваалцахад түүнийг урамшуул.
- Энэ хичээлд өгөгдсөн судруудын талаар товч дүгнэлтээ бичиж, өрөөний хана болгон дээр нэг дүгнэлт байрлуул. Судруудаас нэгийг уншихыг залуу эрэгтэй бүрд даалган, дараа нь уншсан судрынхаа товч дүгнэлтийг олж, дэргэд нь очиж зогсохыг хүс. Эдгээр судраас ач ивээлийн тухай мэдсэн зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс

Заахад туслах арга

“Аль нэг асуултад ... хэрхэн хариулахыг мэдэхгүй үе танд тохиолдож болно. Ийм үед зүгээр л мэдэхгүй гэдгээ хэлээрэй. Бас хариултыг олж мэдэхийг хичээнэ гэж хэлж болох юм. Эсвээс асуултын хариултыг олоход суралцагчдыг урьж, олж мэдсэн зүйлээ дараагийн хичээл дээр илтгэхэд тэдэнд цаг гарган өгч болно” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

хүс. Ач ивээлийн ямар нотолгоог тэд амьдралаасаа олж хардаг вэ? Тэд эдгээр судраас ямар жишээ бодож болох вэ?

- Библийн лавлах болон *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлоос ач ивээлийн тухай уншихдаа сурч мэдсэн зүйлсийн жагсаалт гаргахад чуулгын гишүүн бүрийг урь. Жагсаалтаасаа ямар нэг зүйлийг хуваалцаж, яагаад энэ нь залуу эрэгтэйчүүдэд чухал болохыг тайлбарлахыг тэднээс хүс. Бурханы ач ивээл буюу тусламжийг хүлээн авсан хүмүүсийн зургийг (*Сайн мэдээний уран зургийн ном* эсвэл *Сүмийн аль нэг сэтгүүлээс*) олоход тэднийг урьж,

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд ач ивээлийн сургаалыг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалд илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ач ивээлийн тухай гэрчлэлээ хуваалцаж болно.

- Аврагчийн ач ивээл чуулгын гишүүдэд санваарын үүргээ илүү үр

эдгээр хүний тухай олж мэдсэн зүйлээ хосоороо эсвэл жижиг бүлгүүд болж ярилцахыг тэднээс хүс. Үүнтэй төстэй ямар туршлагыг тэд өөрсдийнхөө амьдралаас хуваалцаж болох вэ?

- Модны мөчрийг чуулгын цуглаанд авчирч, Аврагч Иохан 15:1–10-т ач ивээлийн тухай заахдаа мөчрийг хэрхэн ашигласныг олж мэдэхэд залуу эрэгтэйчүүдийг урь. Тэд эдгээр шүлгээс ач ивээлийн тухай ямар ойлголт авсан бол? Чуулгын нэг гишүүнээс ач ивээлийн тухай сурч мэдсэн зүйлээ чуулгын бусад гишүүнд товчхон ярьж өгөхөд авчирсан мөчрөө ашиглахыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагчдаа Өөрийн сургаалыг заахын тулд тэдний амьдралд өдөр бүр үлгэр дуурайл үзүүлдэг байсан нь сургаалыг ойлгоход тэдэнд тусалдаг байлаа. Тэрээр хүмүүст ойлгоход амархан энгийн түүх, сургаалт зүйрлэл ба амьдралын жишээнүүдийг ашигладаг байв. Та залуу эрэгтэйчүүдэд ач ивээлийн тухай заахдаа амьдралын жишээнүүдийг болон ач ивээл тэдний амьдралд хэрхэн биеллээ олж байгаа жишээг хэрхэн ашиглаж болох вэ?

Сонгосон материалууд

“Ач ивээл” хэсгээс Итгэлдээ үнэнч байх нь (2004), 77–78

Ач ивээл гэдэг үг нь судруудад хэрэглэгдсэнээр бол Их Эзэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бидний хүлээн авдаг тэнгэрлэг тусламж хийгээд хүч чадалтай холбоотой юм. Төлөөлөгч Петр биднийг “Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөх” ёстой гэдгийг заажээ (2 Петр 3:18).

Ач ивээлээр аврагдах нь

Хүн бүр Уналтын улмаас зуурдын үхлийг үзэх болно. Аврагчийн цагаатгах золиослол нь ач ивээлийг боломжтой болгосон учраас бүх хүмүүс амилуулагдаж, үхэшгүй байдлыг хүлээн авна (2 Нифай 9:6–13-ыг үзнэ үү). Гэвч амилуулалт дангаараа Бурханы оршихуй дахь мөнх амьдралыг хүлээн авахад биднийг тэнцэхүйц болгохгүй. Бидний нүгэл хилэнц биднийг цэвэр бус, Бурханы оршихуйд амьдрахад нийцэхгүй болгодог бөгөөд “бидний хийж чадах бүхний дараа” биднийг цэвэршүүлж, төгс болгохын тулд бидэнд Түүний ач ивээл хэрэгтэй (2 Нифай 26:23).

“Бидний хийж чадах бүхний дараа” хэмээх хэлц нь Их Эзэний бүрэн дүүрэн ач ивээлийг хүлээн авах ба Түүнтэй хамт амьдрахад зохистой болгогдоход биднээс хичээл зүтгэлийг шаарддаг гэсэн утгатай юм. Их Эзэн биднийг Түүнд итгэх итгэлтэй байх, нүглээ наманчлах, баптисм хүртэх, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах мөн эцсээ хүртэл тэвчихийг багтаасан Түүний сайн мэдээг дагахыг зарлигласан (Иохан 3:3–5; 3 Нифай 27:16; Итгэлийн Тунхаг 1:3–4-ийг үзнэ үү). Бошиглогч Моронай Аврагчид очих мөн Түүний сургаалуудыг дагаваас бидний хүлээн авах ач ивээлийн тухай бичжээ:

“Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно; мөн хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс аваас, та нар Бурханы хүчийг явч үгүйсгэж чадахгүй.

“Мөн тэрчлэн, хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс, мөн түүний хүчийг эс үгүйсгэх аваас, тэгвэл Бурханы ач ивээлээр та нар Христээр, өөрсдийг тань нүглийн ангижралд хүргэх, Эцэгийн гэрээн дэх Христийн цусны урсалтаар ариусгагдсан билээ, тиймээс та нар ариун, толбогүй болно” (Моронай 10:32–33).

Амьдралынхаа туршид ач ивээлийг хүлээн авах нь

Таны туйлын авралд ач ивээл хэрэгтэйгээс гадна энэхүү хүч нь амьдралд тань өдөр бүр хэрэгтэй. Та Тэнгэрлэг Эцэгтээ хичээл зүтгэл, даруу төлөв байдалтайгаар ойр дотно болох аваас Тэрээр ач ивээлээрээ дамжуулан таныг өргөн, хүчирхэгжүүлэх болно (Сургаалт Үгс 3:34; 1 Петр 5:5; С ба Г 88:78; 106:7–8-ыг үзнэ үү). Түүний ач ивээлд найдах нь танд таныг зөв шударгаар өсөж, хөгжих боломжийг олгодог. Есүс Өөрөө “Мөн тэрээр эхлээд бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй, харин тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлж байлаа;” (С ба Г 93:13). Ач ивээл нь Бурханы хаант улсыг, өөрийн хүч чадлаар үзүүлж чадахгүй үйлчлэлийг бий болгоход туслах боломжоор хангадаг (Иохан 15:5; Филиппой 4:13; Еврей 12:28; Иаков 4:6–7-г үзнэ үү).



Би яагаад бусдыг уучлах хэрэгтэй вэ?

Бид нүглийнхээ уучлалыг хүлээн авахын тулд бусдыг уучлах хэрэгтэй. Бусдыг уучлах нь уур хилэн, гомдол, өш хонзонг даван туулах боломжийг бидэнд олгодог. Уучлал нь сүнсний шархыг эдгээж, зөвхөн Бурханы өгч чадах амар амгалан ба хайрыг авчирдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бусдыг уучилснаар тэдний амьдралд олон адислал ирэх болно гэдгийг ойлгоход ямар судрууд залуу эрэгтэйчүүдэд туслах вэ?

Матай 5:44; С ба Г 64:9–11 (Бүх хүнийг уучлахыг бидэнд зарлиг болгосон билээ)

Гордон Б.Хинкли, “Өршөөл,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 11-р сар, 81–84

Матай 6:14–15; 18:21–35 эсвэл “Дал дахин долоон удаа уучил” видео бичлэг (Бид өршөөлийг хүлээн авахын тулд бусдыг уучлах ёстой)

Дийтр Ф.Угдорф, “Нигүүлсэнгүй сэтгэлт хүмүүс нигүүлслийг олдог” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 70–76

Лук 23:34 (Есүс Христ Өөрийг нь цовдолсон хүмүүсийг уучилсан юм)

Та бусдыг уучилснаар юу сурч мэдсэн бэ? Хэн нэгнийг уучилсан нь амар амгалан ба хайрыг мэдрэхэд танд тусалсан тухай бодно уу?

Бусдыг уучлах хэрэгтэйгээ ойлгосон ямар туршлага залуу эрэгтэйчүүдэд байна вэ? Өөрийгөө уучилж сурах талаар тэдэнд юу хэрэгтэй байна вэ? Залуу эрэгтэйчүүд амар амгаланг мэдрэхийн тулд бусдыг уучилж сурахад нь та хэрхэн тусалж болох вэ?

Анхааруулга: Хэрэв залуу эрэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн тохиолдолоо уучлах тухай асуулт асуувал бишоп болон салбарын ерөнхийлөгчөөсөө зөвлөгөө авахыг тэдэнд зөвлө.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн хичээлээс юуг залуу эрэгтэйчүүд санаж байна вэ? Тэднийг юу хийхэд урьсан бэ? Тэд сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлэх талаар ямар туршлагатай болсон бэ?
- Хэн нэгнийг уучлах хэрэгтэй болсон үеийнхээ тухай бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэднийг хүсвэл энэхүү туршлагаасаа хуваалцахыг урь. Үр дүнд нь юу болсон бэ? Хэрэв тэд түүнийг уучлаагүй бол байдал ямар байх вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь бусдыг уучлахын ач холбогдлыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгыг бүлгүүд болгон хувааж, бүлэг бүрийг энэ тоймд буй хэлсэн үгс эсвэл та өөрийн сонгосон хэлсэн үгсээс уншихад урь. Хэлсэн үгсээс тэдэнд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн хэсгүүдээ тэмдэглэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэмдэглэсэн зүйлээ хуваалцаж, энэ нь яагаад тэдэнд чухал болохыг тайлбарлахад тэднийг урь.
- Матай 18:23–35 (эсвэл “Дал дахин долоон удаа уучил” видео бичлэгийг үзүүл) дахь хатуу сэтгэлт боолын тухай сургаалт зүйрлэлийг хамт уншин, түүний анд нөхөр болох нөгөө боолын өрийг хооронд нь харьцуулж, дүгнэлт хийхэд залуу эрэгтэйчүүдэд тусал (Библийн лавлагаас “Жин ба хэмжүүр”-ийг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүд уучлалын тухай энэ сургаалт зүйрлэлээс юу сурсан бэ? Бусдыг уучлахын ач холбогдлыг заадаг (энэ тоймд санал болгосонтой адил) өөр судруудыг олж, хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.
- Залуу эрэгтэйчүүдээс судруудахь бусдыг уучилж буй хүмүүсийн талаарх жишээнүүдийг хооронд нь харьцуулахыг хүс. Та Египетийн Иосеф (Эхлэл 45:1–7-г үзнэ үү), Нифай болон түүний ах нар (1 Нифай 7:21-ийг үзнэ үү), загалмай дээрх Есүс Христ (Лук 23:34-ийг үзнэ үү) болон бусад жишээг нэгтгэн дүгнэж болно. Ялангуяа гэр бүлийн гишүүдээ уучлах нь яагаад чухал вэ? Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, залуу эрэгтэйчүүдээс сэтгэгдлээ хуваалцахыг хүс. Тэд уучлалын өөр ямар жишээнүүдийг хуваалцаж болох вэ?

Заахад туслах арга

“Хичээлийн ихэнх цагийг лекц уншиж өнгөрүүлэн, асуулт бүхэнд өөрөө хариулдаг багш нар суралцагчдын хичээлд оролцох хүслийг бууруулдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

- Аврагч уучлалын тухай бусдад заасан ямар нэг зүйлийг судруудаас олж, олж мэдсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс (жишээ нь, Матай 5:44; 6:14–15; 18:22–23-ыг үзнэ үү). Бусдыг уучилснаар ирдэг амар амгалангийн тухай туршлагаа хуваалцахыг тэднээс хүс.

- Дараах асуултуудыг цаасан дээр бичиж, чуулгын гишүүн бүрд өг: Бид яагаад өөрсдийгөө болон хүн

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд бусдыг уучлахын ач холбогдлыг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаалд илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Өөрийн уучлах хэрэгтэй хэн нэгний тухай бодож, түүнийг уучлах шийдвэр гаргахад чуулгын гишүүдийг урамшуулан дэмж.

бүрийг уучлах хэрэгтэй вэ? Тухайн хүн уучлагдах ёстой эсвэл үгүй юү гэдгийг шийдэх цорын ганц хүн нь яагаад Их Эзэн байдаг вэ? Бусдыг уучлахгүй байх нь яагаад маш том нүгэл байдаг вэ? Сургаал ба Гэрээ 64:9–11-ийг уншиж, өөрийн асуултыг тунгаан бодоход залуу эрэгтэй бүрийг урь. Дараа нь өөрсдийн бодол мөн ойлгож мэдсэн зүйлсээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- Сурч мэдсэн зүйлээ гэрийнхэнтэйгээ хуваалцахад чуулгын гишүүдийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч тухайн нөхцөл байдал бүрд шавь нартаа үлгэр жишээ үзүүлэн, халамжлан хүмүүжүүлэгч нь болж, тэдэнтэй хамт залбирч мөн хэрхэн залбирахыг тэдэнд заадаг байв. Тэрбээр тэднийг хайрлан, үйлчлэх замаар хайр ба үйлчлэлийг тэдэнд заадаг байлаа. Тэр бусдыг хэрхэн уучлахыг тэднийг уучилснаараа заадаг байв. Та өөрийн заадаг зарчмуудаар хэрхэн үлгэр дуурайл үзүүлж болох вэ?



Амилалт гэж юу вэ?

Есүс Христийн Цагаатгалын ачаар бүх хүн амилуулагдах болно. Бидний бие сүнстэйгээ төгс бөгөөд үхэшгүй байдалд эргэн нэгдэх болно. Бид амилалтыг ойлгож, энэ тухай гэрчлэлтэй болсноор амьдралдаа тохиолдох сорилт бэрхшээлийг даван туулж, амжилт болон итгэл найдвар, хэтийн төлөвтэй болж чадна.

Амилалтын тухай та юу мэддэг вэ? Бид өнөө үеийн судраас амилалтын тухай юу мэддэг вэ?

Залуу эрэгтэйчүүд амилалтын тухай ямар ойлголттой байдаг вэ? Амилалтын тухай гүнзгий мэдлэгтэй байх нь бие махбодынхоо талаарх тэдний үзэл бодолд хэрхэн нөлөөлж болох вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Залуу эрэгтэйчүүдэд амилуулалтын тухай заахад та ямар судрууд болон бусад эх сурвалжийг ашиглаж болох вэ? Юуг тэдэнтэй хуваалцах хэрэгтэй гэж та боддог вэ?

Лук 24 (Есүс Христийн Амилалт)

1 Коринт 15 (Аврагч үхлийг ялсан учраас бид бүгд амилуулагдах болно)

Алма 11:41–45 (Амилалтаар бидний сүнс, бие хоёр дахин нэгдэж, бид шүүгдэхэд бэлэн болно)

Алма 40–41 (Алма амилалтыг хүү Кориантондоо тайлбарлажээ)

Томас С.Монсон, “Тэр амилсан!” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 87–90).

Томас С.Монсон, “Хатагтай Паттон—Түүх үргэлжилж байна,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 21–24

Д.Тодд Кристоффэрсон “Есүс Христийн Амилалт” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 5-р сар

Видео бичлэг: “Тэр амилсан”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээр судалсан судраа нээхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэр судрынхаа тухай, тэндээс юу сурч мэдсэнээ, үүний сургаалуудаар амьдрахын тулд юу хийх гэж байгаагаа хуваалцахад нь цөөн суралцагчийг урамшуулан дэмж.
- Христийн Амилсны баярыг хэрхэн тэмдэглэдгийг нь залуу эрэгтэйчүүдээс асуу. Христийн Амилсны баярын зарим бэлгэдэл юу вэ? Эдгээр бэлгэдэл амилалтын тухай тэдэнд юу заадаг вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь амилалтыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- 1 Коринт 15-аас амилалтын тухай зарим хэсгийг сонгож ав. Судрын хэсгүүдийг цөөн хүнтэй бүлгүүдээр эсвэл ганцаарчлан уншуулж, амилалтын талаар мэдсэн зүйлээ хураангуйлан дүгнэхэд залуу эрэгтэйчүүдийг урь (жишээ нь, 1–8-р шүлгийг “Амилалтын гэрчүүд байдаг” хэмээн хураангуйлан дүгнэж болно). Амилалтын тухай эдгээр үнэнийг залуу эрэгтэйчүүд мэдэх нь яагаад тэдэнд чухал гэж та бодож байна вэ?
- Сүмийн гишүүн биш найз нь хайртай хүнээ алджээ гэж төсөөлөн бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүдийн хагасыг Алма 40-ийг нөгөө хагасыг Алма 41-ийг уншихад урь. Эдгээр бүлгээс амилалтын тухай найз нартайгаа хуваалцаж болох сургаалуудын жагсаалт хийхийг тэднээс хүс. Дараа нь жагсаалтаа ангийн үлдсэн хэсэгтэй хуваалцахад тэднийг урь.
- Чуулгаараа судар дээрх Аврагчийн Амилалтын гэрч болсон хүмүүсийг жагсааж бич. Залуу эрэгтэйчүүдийг өөр бусад жишээг олохын тулд ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлсэн “Есүс Христийн Амилалт” үгийг уншихад урь. Тэднийг судар дээрх эдгээр гэрчийн гэрчлэлийг олж уншихад урамшуулан дэмж (зарим тайлбарыг ахлагч Кристоффэрсоны хэлсэн үгэнд тайлбарласан байгаа). Бид эдгээр гэрчээс Аврагч болон Түүний Амилалтын талаар юу сурч байна вэ? Та Аврагчийн Амилалтын талаар гэрчлэлээ хуваалцаад, чуулгын хэдэн гишүүнийг гэрчлэлээ хуваалцахад урь.

Заахад туслах арга

“Та олон төрлийн сурах үйл ажиллагааг ашиглах юм бол суралцагчид сайн мэдээний зарчмуудыг сайн ойлгож, энэхүү мэдлэгээ удаан хугацаанд хадгалах болно. Анхааралтайгаар сонгож авсан заах арга нь аливаа зарчмыг илүү тод, илүү сонирхолтой, ой ухаанд урт удаан хугацаанд хадгалагдахаар болгож чадна” (*Teaching, No Greater Call* [1999], 89).

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ Өөрийн үүрэг зорилгын тухай заахад судруудыг ашигладаг байв. Тэр шавь нартаа судруудын тухай өөрсдөө тунгаан бодож, асуултууддаа хариулахад ашиглахыг заадаг байв. Залуу эрэгтэйчүүд судруудыг судалснаар Бурханы төлөвлөгөөг ойлгож мөн үүнээс ирдэг адислалуудыг хүлээн авахад нь та тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

- Сүмийн ерөнхийлөгчдийн сургаал номын хэд хэдэн хувийг тарааж өгөөд (эсвэл хэдэн бүлгийг сонгож хувилах), хожмын үеийн бошиглогчдын заасан амилалтын тухай сургаалуудыг олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Олж мэдсэн зүйлээ ангитай хуваалцахыг тэднээс хүс.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд амилалтын талаар илүү сайн ойлголттой болсон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалд илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаах болно. Тэрээр:

- Амилалтын тухай гэрчлэлээ хэлнэ.
- Амилалтын тухай улам их зүйлийг судалж, судрын тэмдэглэлдээ

- Амилалтын тухай дууллиудыг олоход залуу эрэгтэйчүүдийг урь (дууллын номын төгсгөл дэх сэдвийн индексийг үзнэ үү). Дууллиудаас заримыг нь ангиараа дуул. Дууллын зүүлт тайлбар дахь судруудыг харж, тэдгээр нь юуны тухай зааж байгааг ярилц.

бичин, сурч мэдсэн зүйлээ чуулгынхантайгаа хуваалцахыг чуулгын гишүүдэд урь.



Сорилт бэрхшээл тулгарсан үед Аврагч надад хэрхэн тусалж чадах вэ?

Аврагч цагаатгагч золиослолынхоо нэг хэсэг болгон бидний өвчин зовлонг Өөр дээрээ авсан билээ. Тэрбээр бидний сорилт бэрхшээлүүдийг биеэр амссан учраас бидэнд хэрхэн туслахыг мэддэг. Хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлээ ашиглавал, Тэр бидэнд хүч чадал өгч, бидний ачааг хөнгөлөх болно.

Өөртөө тохиолдож байгаа сорилт бэрхшээлүүдийн талаар бод. Та Цагаатгалаар дамжуулан хүч чадлыг хэрхэн хүлээн авсан бэ?

Чуулгынхаа залуу эрэгтэйчүүдийн талаар бод. Тэдэнд ямар сорилт бэрхшээл тулгарч байна вэ? Та хувийн ямар туршлага, судар, хэлсэн үгийн эшлэлүүдийг тэдэнтэй хуваалцахыг хүсэж байна вэ? Залуу эрэгтэйчүүдэд бие биетэйгээ хуваалцаж болох хувийн туршлага байна уу?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлтгэх явцдаа эдгээр материалыг болон хэрэгцээ гарсан үед Аврагчид хандахад тань тусалсан бусад материалыг залбирч судлаарай.

Матай 11:28–30; Филиппой 4:13; 1 Нифай 17:3; Хиламан 5:12; С ба Г 19:23; С ба Г 68:6 (Есүс Христ бидэнд хүч чадал өгч бидний ачааг хөнгөлдөг)

Мозая 23:12–16; 24:8–17 (Их Эзэн Алмагийн хүмүүсийн ачааг хөнгөлөхийн тулд тэднийг хүчирхэгжүүлсэн билээ)

Исаиа 53:3–5; Алма 7:11–13 (Есүс Христ зовлонг өөрийн биеэр туулсан учир бидний зовлонг ойлгодог)

Нийлл Ф.Марриотт, “Зүрх сэтгэлээ Бурханд зориулах нь,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 14–16

Даллин Х.Өүкс, “Есүс Христийн Цагаатгалаар хүчирхэгжсэн,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 50–53

“Саад тотгор,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 152–156

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурч мэдсэн зүйлийнхээ талаар ярихыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Сурч мэдсэн зүйлээ үйлдэл болгон хэрэгжүүлсэн туршлагаа хуваалцах цагийг тэдэнд гаргаж өг.
- Чуулгын гишүүн бүрд цаас өгч, одоо өөрт нь тулгараад байгаа сорилтын талаар бичихийг тэднээс хүс. Сорилт бэрхшээл тулгарсан үед Есүс Христ тэдэнд хүч чадал хэрхэн өгдгийг тунгаан бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Цагаатгалын сургаалыг мэдсэний ачаар, тохиолдсон сорилт бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх бодлоо бичихэд тэднийг урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад татан оруулах сайн арга юм” (*Teaching, No Greater Call* [1999], 72).

Доорх үйл ажиллагаа бүр нь сорилт бэрхшээл тулгарсан үед Цагаатгал тэдэнд хэрхэн тусалдгийг ойлгоход чуулгын гишүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Энэ хичээлийн аль нэг хэсгийг заахад чуулгын нэг гишүүнийг урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цагаатгалын тухай сурч мэдэх болон заах төлөвлөгөөний нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлго,” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Чуулгыг жижиг бүлгүүдэд хуваа. Энэ тойм дахь судруудаас бүлэг бүр нэг эсвэл түүнээс олныг уншиж, сурч мэдсэн зүйлээ хураангуйлан дүгнэж, чуулгынхантайгаа хуваалц. Эдгээр судраас сурч мэдсэн зүйл нь тохиолдсон сорилт бэрхшээлийг даван туулахад тэдэнд хэрхэн тусалсан тухай бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Хэрэв бичсэн зүйлээ хуваалцах хүсэлтэй байвал залуу эрэгтэйчүүдийг дэмж. Та өөрийнхөө туршлагыг бас хуваалцаж болно.
- Мозая 24:8–17-г хамтдаа унш. Алмагийн болон түүний хүмүүсийн туршлагаас сурч мэдсэн зүйлсээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Бишопын зөвшөөрөлтэйгөөр, тэдний аавуудын заримыг хичээл дээр ирж, сорилт бэрхшээл тохиолдсон үед Аврагч тэдэнд хэрхэн хүч чадал өгсөн тухай хуваалцахыг урь.
- “Бурхан биднийг өргөн дэмжих болно” видео бичлэгийг үзүүл. Видео бичлэгийн эхэнд ахлагч Робэрт Д.Хэйлсийн тавьсан асуултад залуу эрэгтэйчүүд хэрхэн хариулах бол? Бритни өөрт нь тохиолдсон хүнд сорилтыг даван

туулах хүч чадлыг олохын тулд юу хийсэн бэ? Тохиолдсон сорилт бэрхшээлүүдийг даван туулахад Бритнигийн үлгэр жишээг дагаж болох арга замуудын тухай тунгаан бодоход залуу эрэгтэйчүүдийг урь.

- Нийлл Ф.Марриотт эгч охиноо нас барахад, энэ байдлыг хэрхэн даван туулсан тухай түүхийг уншиж эсвэл үзэхэд залуу эрэгтэйчүүдийг урь (“Зүрх сэтгэлээ Бурханд зориулах нь” хэлсэн үгээс). Унших юм уу үзэх үедээ дараах асуултыг тунгаан бодохыг тэднээс хүс: Цагаатгал Нийлл Ф.Марриотт эгчид хүнд сорилтыг даван туулахад нь хэрхэн тусалсан бэ? Бодол санаагаа хуваалцахад тэднийг урь. Одоо тулгараад байгаа сорилт бэрхшээлийнхээ тухай бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд Цагаатгалаас хэрхэн хүч чадал олж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Цагаатгал сорилт бэрхшээл тохиолдсон үед нь хэрхэн тусалж болохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаалд илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Цуглаан хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Сорилт бэрхшээлийг даван туулахад Аврагч түүнд хэрхэн тусалсан туршлагаа хуваалцаж, сорилт бэрхшээл тохиолдсон үед Аврагчид найддаг байх хүслийг чуулгын гишүүдэд төрүүлэх хэрэгтэй.

- Залуу эрэгтэйчүүдийг хүмүүст тулгардаг зовлон зүдгүүр, гай зовлонгийн жагсаалт гаргахад урь (зарим жишээг олохын тулд ахлагч Квинтин Л.Күкийн “Хувь хүний амар амгалан бол зөв шударга байдлын шагнал мөн” хэлсэн үгийн эхний долоон догол мөрийг эсвэл ахлагч Даллин Х.Өүксийн “Есүс Христийн Цагаатгалаар хүчирхэгжсэн” хэлсэн үгийн III хэсгийг үзэхэд урь). Тэдгээр нь өөрийн биеэр зовлон зүдгүүрийг даван туулж буй найзад тань хэрхэн туслах вэ? Залуу эрэгтэйчүүдэд дээрх хоёр үгийн хэсгүүдээс өгч, найздаа хэрхэн тусалж болох талаар бодол санаагаа хуваалцахыг хүс. Түүнчлэн та “Авирах уул” видео бичлэгийг үзүүлж, тэднийг бодол санаагаа хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Сорилт бэрхшээл тулгарсан үед Аврагч биднийг хэрхэн хүчирхэгжүүлдэг тухай заадаг хүч нөлөө ихтэй олон судар энэ хичээлд байгаа. Залуу эрэгтэйчүүд эдгээр судрыг судалж, ярилцахад Ариун Сүнс тэдэнд эдгээр судрын үнэнийг гэрчлэх болно.

Сонгосон материалууд

Нийл Ф.Марриот, “Зүрх сэтгэлээ Бурханд зориулах нь,” *Ensign*, 2015 оны 11-р сар, 31 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 14–15-аас эш татав

Би нөхөр, хүүхдүүдийнхээ хамт гэр бүлдээ “Бүх зүйл сайхан болно” гэсэн уриаг сонгосон юм. Гэхдээ хүнд бэрхшээлүүд тохиолдож, хариулт хурдан ирэхгүй байх үед бид хэрхэн нэг нэгэндээ энэ үгийг хэлэх билээ?

Сэргэлэн цовоо, зөв зохистой охин Жеоржиагаа 21 настайдаа унадаг дугуйн ослоос болж хүнд гэмтэн, эмнэлэгт хэвтэх үед бид гэр бүлээрээ “Бүх зүйл сайхан болно” гэж хэлж байсан. Би охинтойгоо хамт байхаар Бразиль дахь номлолоосоо АНУ дахь Индиана мужийн Индианаполис руу шууд нисэх үедээ гэр бүлийнхээ урианд итгэж байсан. Гэсэн ч онгоц газардахаас хэдхэн цагийн өмнө хайрт охин маань энэ хорвоог орхисон юм. Уй гашуу, цочирдол гэр бүлийг маань нөмөрсөн энэ үед бид яаж нэг нэгэн рүүгээ хараад, “Бүх зүйл сайхан болно” гэж хэлсэн хэвээр байж чадсан бэ?

Жеоржиаг нас барсны дараа бидний зүрх сэтгэл шаналж, үнэхээр хүнд байсан ба өнөөдөр ч бидэнд гашуудах үе байдаг. Гэхдээ бид хэн ч үнэндээ үхдэггүй гэсэн ойлголтод л түшиглэж

байв. Жеоржиагийн зуурдын бие биднийг орхиход бидэнд тун хэцүү байсан ч түүний сүнс амьд гэдэгт, хэрэв ариун сүмийн гэрээгээ итгэлтэй сахивал түүнтэй хамт үүрд амьдарна гэдэгт бид итгэж байлаа. Өөрсдийн Гэтэлгэгчид болон Түүний Амилалт, санваарын хүч, мөнхийн лацдан холболтод итгэх итгэл нь бидэнд уриагаа итгэл дүүрэн хэлэх боломжийг өгдөг. . . .

Гэр бүлийн уриа маань “Бүх зүйл одоо сайхан болно” гэж хэлээгүй. Энэ нь одоогийн үр дүнгээс илүү мөнхийн үр дагаварт найдах бидний найдварын тухай юм. “Хичээнгүйлэн судлагтун, үргэлж залбирагтун, мөн итгэлтэй байгтун, мөн та нарын сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно” [С ба Г 90:24] хэмээн сударт гардаг. Энэ нь бүх зүйл сайн гэсэн үг биш боловч даруу, итгэлт хүмүүсийн хувьд эерэг, сөрөг зүйлс хоёулаа тэдний сайн сайхны төлөө хамтдаа ажиллаж, Их Эзэний цаг хугацаанд биелдэг. Бид Иовыг хүнд хэцүү үедээ Бурхан “өвтгөдөг бөгөөд шархыг боож өгдөг, Тэрээр шархлуулдаг бөгөөд Түүний мутар эдгээдэг” [Иов 5:18] гэдгийг мэдэн хүлээж байсан шиг Түүнийг хүлээдэг. Номхон дөлгөөн зүрх сэтгэл нь зовлон бэрхшээлийг хүлээн авч, ирээдүйд эдгээгдэж бүрэн бүтэн болох цаг хугацааны хүлээлтийг зөвшөөрдөг билээ.

Дөрөвдүгээр сар: Урвалт ба сэргээлт

“Бибээр сайн мэдээний бүрэн байдлаа өөрийн үйлчлэгч Иосефын гараар урагш илгээсэн” (С ба Г 35:17).

Энэ бүлгийн тоймууд нь Их урвалт ба Есүс Христ Өөрийн сүмийг болон сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг бошиглогч Иосеф Смитээр дамжуулан хэрхэн сэргээсэн тухай ойлгоход залуу эрэгтэйчүүдэд тусална. Мөн тэд сэргээлтийн чухал үйл явдлуудын талаар суралцаж, эдгээр нь тэдний амьдралд хэрхэн нөлөөлсөн болохыг олж мэднэ.

Аароны санваартнууд нь сайн мэдээг хуваалцан, Христэд ирэхэд бүхнийг урих үүрэгтэй байдаг. Энэхүү хэсгээс суралцсанаар тэд одоо болон ирээдүйд бүрэн цагийн номлогч болсны дараа ч сэргээлтийн захиасыг тодорхой бөгөөд хүч чадалтайгаар заах болно.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг Ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын дараах тоймыг та энэ бүлэгт оруулан, зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би Христэд ирэхэд бүхнийг хэрхэн урьж чадах вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Сэргээлт яагаад шаардлагатай байсан бэ?

Санваар хэрхэн сэргээгдсэн бэ?

Сэргээлтэд Иосеф Смит ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?

Анхны үзэгдэл яагаад чухал вэ?

Бидэнд яагаад Мормоны Ном хэрэгтэй вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Христэд ирэхэд бүхнийг урь,” 28–29, 52–53,
76–77-р хуудас

“Сургаальг ойлго,” 18–20, 42–44, 66–68-р хуудас



Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би Христэд ирэхэд бүхнийг хэрхэн урьж чадах вэ?

Сэргээгдсэн Сүм үүсгэн байгуулагдсан өдөр Их Эзэн Аароны санваартнуудад Христэд ирэхэд бүхнийг урих үүрэг өгчээ (С ба Г 20: 59-ийг үзнэ үү). Аароны санваартнууд энэхүү үүргээ биелүүлэх аваас сэргээгдсэн сайн мэдээний адислалуудыг Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд авчирдаг. Ингэснээр тэд гэрчлэлээ хүчирхэгжүүлэн, амьдралынхаа турш номлогч байхад өөрсдийгөө бэлтгэдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон суралцах материалуудыг залбирч судлаарай. Та сурч байхдаа ямар мэдрэмжийг хүлээн авч байна вэ?

Хүмүүсийг сайн мэдээний талаар суралцахад урьсан ямар туршлага танд байдаг вэ? Таныг Христ рүү ирэхэд бусад хүмүүс хэрхэн тусалсан бэ?

Аароны санваартай олон залуу эрэгтэй Христэд ирэхэд нь бусдыг урих санваарын үүргээ мэддэггүй. Тэднийг энэ ариун үүргээ ойлгон, хэрэгжүүлэхэд нь та хэрхэн тусалж чадах вэ? Найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ сайн мэдээг хуваалцахад тэдэнд юу сүнслэгээр нөлөөлөх вэ?

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 28–29, 52–53, 76–77

1 Тимот 4:12 (Итгэгч хүмүүсийн жишээ бол)

Алма 17:2–3 (Мозаягийн хөвгүүд сайн мэдээг хуваалцахад өөрсдийгөө бэлдэв)

Моронай 10:32–33 (Христэд ирэх Моронайн урилга)

С ба Г 4 (Их Эзэнд үйлчлэхэд биднийг тэнцүүлэх зан чанарууд)

С ба Г 20:46–59 (Аароны санваартнууд Христэд ирэхэд бүхнийг урих үүрэгтэй)

С ба Г 42:6 (Сайн мэдээг Сүнсний хүчээр номло)

М.Рассэлл Баллард, “Эцсийн үр дүнг үзэх хүртэл хамт явах,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар

Ричард Г.Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар

“Номлогчийн хувьд миний зорилго юу вэ?” *Миний сайн мэдээг номло* (2004), 1–15

Видео бичлэг: “Христэд ирэхэд бүхнийг урь”

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн ярилцлагаас санаж байгаа зүйлийнхээ талаар хуваалцахыг тэднээс хүс. Тэд яагаад үүнийг санаж байгааг асуу. дурдсан санваарын үүргүүдийн талаар суралцахад урь. Цөөн залуу эрэгтэйг гэр бүл, идэвх султай найз эсвэл өөр итгэлтэй найзтайгаа сургаальг хуваалцсан туршлагаасаа ярихад урь. Үр дүн нь ямар байсан бэ?
- Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 20:59-ийг нээлгэж энэ шүлэгт

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго бол залуу эрэгтэй бүр Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хэн нэгэнтэй хуваалцах санваарын үүргээ биелүүлэх төлөвлөгөө гаргахад нь туслах юм. Чуулгын цуглааны үеэр Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө бичих цаг залуу эрэгтэйчүүдэд гаргаж өгөөрэй. Тэднийг төлөвлөгөөгөө бусадтайгаа хуваалцахад мөн дараа дараагийн чуулгын цуглаанууд дээр бусад хүмүүсийг Христэд ирэхэд урьсан туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

- “Христэд ир” эсвэл “Над уруу ир” гэсэн үгстэй судруудыг олоход залуу эрэгтэйчүүдийг урь (Матай 11:28; Моронай 10:32; С ба Г 20:59-ийг үзнэ үү). “Христэд ир” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Бусад хүмүүсийг Христэд ирэхэд нь урихад сүнслэгээр нөлөөлөх юуг тэд эдгээр шүлгээс сурч байна вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь 28-ыг үзнэ үү. Залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо “Ажилла” гэсэн хэсгийг гарган (29, 53, 77-р хуудсыг) хэн нэгнийг Христэд ирэхэд нь урих төлөвлөгөөгөө гаргахад урь.

Заахад туслах арга

“Суралцагчдын хэлэх зүйлсийг анхааралтай сонсож бай. Таны жишээ тэдэнд нэг нэгнийгээ анхааралтай сонсож сурахад туслах болно. Хэн нэгний хэлсэн зүйлийг та ойлгохгүй байвал “Би сайн ойлгосонгүй ээ. Дахиад тайлбарлаж өгөхгүй юү?” эсвэл “Хэлсэн зүйл дээрээ жишээ гаргаж болох уу?” гэх мэтээр асууж болно” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

- Сургаал ба Гэрээ 20:53-г хамтдаа уншаад гэрийн багш нар “сүмийг ямагт харж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх” арга замуудыг жагсаан бич. Залуу эрэгтэйчүүд гэрийн багшийн үүргээ хэрхэн илүү сайн биелүүлэх вэ? Ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийг урьж авчран, хэрхэн сайн гэрийн багш байх талаар үг хэлүүлж болно (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* 52 эсвэл 76-г үзнэ үү.) Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо (55 эсвэл 77-р хуудсыг) “Ажилла” гэсэн хэсгийг нээн, илүү сайн гэрийн багш болох төлөвлөгөө гаргахад урь.

- Чуулгын гишүүдэд Аммоны зургийг үзүүлэн, леменчүүдэд Аммон зааж байгаа түүхийг товчхон дүгнэж хэл (Алма 17–19-ийг үзнэ үү). Энэ түүхийг Кориантоны туршлагатай харьцуул (Алма 39:1–11-г үзнэ үү). Таны үлгэр жишээ сайн мэдээг бусдад заах чадварт тань хэрхэн нөлөөлдөг вэ? (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, 28-ыг үзнэ үү.) Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо 29-р хуудсыг нээн, сайн үлгэр жишээ үзүүлснээр сайн мэдээг хуваалцах төлөвлөгөө гаргахад нь залуу эрэгтэйчүүдийг урь.

- Дараах үгсийг самбар дээр бич: “Урилга өгөөд араас нь шалгаагүй бол _____ адил.” Чуулгын гишүүдээс ахлагч М.Рассэлл Баллардын “Эцсийн үр дүнг үзэх хүртэл хамт явах” хэлсэн үгийг судалж, энэ өгүүлбэрийн дутуу үгсийг нөхөх эшлэлийг эрж хайхыг хүс. Өгүүлбэрийн дутуу үгсийг нөхөж болох өөр ямар зүйрлэлийг чуулгын гишүүд бодож байна вэ? Бусдыг Христэд ирэхийг урих үедээ эцсийн үр дүнг үзэхийн чухлыг ойлгоход нь туслах ямар зүйлсийг тэд уг хэлсэн үгээс олж мэдсэн бэ?

- “Христэд ирэхэд бүхнийг урь” видео бичлэгийг үзүүлж, чуулгаа өсч хөгжихөд Аароны санваартнууд хэрхэн тусалж байгааг анхааран үзэхийг хүс. Тэд өөрсдийн чуулгадаа үүнтэй төстэй ямар зүйлсийг хийж болох талаар ярилц. Чуулгын гишүүн бүрд ахлагч Ричард Г.Скоттын “Би та нарт жишээ үзүүлсэн юм” хэлсэн үгийн хэсгийг өг. Бусдыг Христэд ирэхийг урих хичээл зүтгэлд нь туслах зарчим эсвэл зөвлөгөөг уг хэлсэн үгээс олохыг чуулгын гишүүдээс хүс. Тэднээс сурсан зүйлээ хуваалцахыг хүс.

Аврагчийн арга барилгаар заах нь

Аврагч хүмүүсийг өөрсдийн сурсан үнэнүүдийн талаар гэрчлэхийг урьсан. Ийн гэрчлэхэд Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрдэг юм. “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” гэж Тэр асуусан. “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” хэмээн Петр хариулав. Түүнийг ийн хариулахад гэрчлэл нь хүчирхэгжив (Матай 16:15–16). Сайн мэдээг хуваалцах нь чуулгын залуу эрэгтэйчүүдийн гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?

Сэдэвтэй холбоотой өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлээр сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь туслах Мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд Христэд ирэхэд бүхнийг урих санваарын үүргээ ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо “Ажилла” хэсэгт (29, 53, 77-р хуудас) өөрийнхөө төлөвлөгөөг бичихэд урьж болно.*
- Идэвх султай гишүүдийг чуулгын цуглаанд оролцон, сүмдээ эргэн ирэхэд нь дэмжихийн тулд юу хийж болох тухай чуулгын гишүүдтэй зөвлөн ярилцаж болно.



Сэргээлт яагаад шаардлагатай байсан бэ?

Мөнх бус амьдралынхаа номлолын үеэр Есүс Христ Өөрийн Сүмийг санваарын эрх мэдэлтэйгээр үүсгэн байгуулсан. Түүний Сүмийг үнэн сургаал зааж, илчлэлт хүлээн аван, судрууд дээр тэмдэглэн бичдэг бошиглогч, төлөөлөгчид удирддаг байв. Харин төлөөлөгчдийг нас барсны дараа санваарын эрх мэдэл дэлхийгээс авагдаж, илчлэлт ирэхээ больж, амин чухал сургаалууд алдагдаж эсвэл буруугаар тайлбарлагдаж эхэлсэн. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Есүс Христийн үүсгэн байгуулсан Сүм сэргээгдсэн юм.

Урвалтын ямар нөлөөнүүдийг та нар энэ дэлхий дээр харсан бэ? Сайн мэдээний сэргээлт та нарыг яаж адисалдаг вэ?

Урвалт ба сэргээлтийн талаар залуу эрэгтэйчүүд юуг мэдэх шаардлагатай вэ? Урвалт ба Сэргээлтийн талаарх ойлголт нь тэдэнд яаж туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалыг залбирч судлаарай. Сэргээлт маш чухал гэдгийг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд юу тусална гэж та бодож байна вэ?

Ефес 4:11–14; Итгэлийн Тунхаг 1:6 (Сүм өнөө үед Аврагчийн үеийн Сүмтэй ижил зохион байгуулалттай байдаг)

Исаиа 29:13–14; Амос 8:11–12; 2 Тесалоник 2:3; 1 Нифай 13:24–29 (Урвалтын үр уршгаар Сүм алдагдсан байсан)

С ба Г 1:17–23, 30 (Иосеф Смитээр дамжуулан Есүс Христ Өөрийн Сүмийг сэргээсэн)

Иосеф Смит—Түүх 1:6–20 (Иосеф Смитийн Анхны үзэгдэл)

Д.Тодд Кристоффэрсон, “Сүм яагаад хэрэгтэй вэ?,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 101–105

Робэрт Д.Хэйлс, “Сэргээлт болон Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь: Миний мутар чам дээр байх болно” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 11-р сар, 88–92

“Урвалт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 200–201

“Сайн мэдээний сэргээлт,” *Итгэлдээ үнэнч байх нь*, 160–164

Миний сайн мэдээг номло (2004), 37–40, 49

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Нэг залуу эрэгтэйг өнгөрсөн долоо хоногт сурсан ямар нэг зүйл нь түүнийг гэртээ, сургууль дээрээ эсвэл найзуудтайгаа байхад хэрхэн нөлөөлсөн тухай хуваалцахад урь.
- Сэргээлт бидэнд яагаад хэрэгтэй тухай заахдаа ямар нэг зүйлийг ашигла (Засч янзлах боломжгүй ч орлуулах боломжтой нэг эвдэрсэн зүйл гэх мэт). Сэргээлт яагаад хэрэгтэй байдаг тухай бусдад заахад ашиглах ямар зүйлийг тэд санал болгож чадах вэ?

Заахад туслах арга

“Та ярьж буй хүнийг сонсож байгаагаа харуулахын тулд сонирхож байгаагаа илтгэх ёстой. Та хичээлийн материал эсвэл анги доторх аливаа зүйлсийг биш харин ярьж буй хүн рүү харах хэрэгтэй. Түүний яриаг таслахгүйгээр бодол санаагаа илэрхийлэхэд нь та урамшуулан дэмжих ёстой. Та түүнийг сонсож дуусалгүйгээр зөвлөгөө өгөх эсвэл шүүмжлэхээс зайлсхийх хэрэгтэй” (Teaching, No Greater Call [1999], 66).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь сайн мэдээний Сэргээлт яагаад чухал болохыг ойлгоход тусална. Сүнсний өдөөлтийг даган, чуулгадаа хамгийн сайн тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Сүм яагаад хэрэгтэй вэ?” хэлсэн үгийг судалж, хожмын өдрүүд дэх Сүмийн сэргээлт ба үүргүүдийн талаарх ойлголтуудыг хайж олоход урь. Та бас хэдэн залуу эрэгтэйг сэргээгдсэн Сүмд яагаад талархалтай байдаг тухай хуваалцахаар урьдчилан бэлдэж ирэхэд урьж болох юм. Та бишопын зөвшөөрөлтэйгөөр, ангидаа саяхан баптисм хүртсэн гишүүнийг Сүмийн тухай болон сэргээгдсэн сайн мэдээний талаар гэрчлэлийг нь хуваалцуулахаар урьж болно.
- Чуулгын нэг гишүүнийг энэ хичээлийн хэсгийг заахад урь. Тэрээр үүнийг заахдаа “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын төлөвлөгөөнийхөө нэг

хэсэг болгон Урвалт ба Сэргээлтийн тухай зааж болно (“Сургаалыг ойлго,” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).

- Чуулгын гишүүдийг хоёр бүлэгт хуваан эхний бүлгээс Есүс Христ хэрхэн Өөрийн Сүмийг байгуулсан, энэ нь урвалтын үед хэрхэн алга болсон тухай заахыг хүс. Харин хоёр дахь бүлгээс Сэргээлтийн тухай заахыг хүс. Тэдэнд “Миний сайн мэдээг номло” (37–40, 49-р хуудас), “Итгэлдээ үнэнч байх нь” (200–201, 160–164-ийг үзнэ үү) мөн энэхүү сургалтын тоймд санал болгосон судруудыг өг. Та эдгээр даалгаврыг чуулгын цуглаанаас хэд хоногийн өмнө тэдэнд өгч болно.
- Залуу эрэгтэй бүрд Урвалт ба Сэргээлтийн тухай нэг судар даалган өг (суралт тоймд санал болгосон

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд сайн мэдээний сэргээлт чухал гэдгийг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Сэргээлт яагаад чухал байсныг мөн энэ нь түүний хувьд яагаад чухал болохыг хэлж болох юм.
- Чуулгын гишүүдийг сурсан зүйлсийнхээ тухай сэтгэгдлээ хуваалцахад урьж болно.

судруудаас). Судруудаас сурсан зүйлээ дүрсэлсэн зураг зураад, чуулгынхаа гишүүдтэй хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Сайн мэдээ сэргээгдсэнээр бид ямар адислалууд хүлээн авсан тухай чуулгаараа ярилц.

- Ахлагч Роберт Д.Хэйлсийн “Сэргээлт болон Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь: 'Миний мутар чам дээр байх болно' ” хэлсэн үгэнд дурдсан хүмүүсийн нэрийг (Виллям Тандэл, Иоханэс Гутэнбэрг эсвэл Мартин Лютер гэх мэт. Нэг нэрийг нэг суралцагчид өгнө.) залуу эрэгтэйчүүдэд өг. Уг хүн дэлхийг Сэргээлтэд бэлдэхийн тулд юу хийсэн тухай ахлагч Роберт Д.Хэйлсийн хэлсэн үгээс олохын тулд үүнийг унших эсвэл үзэхийг тэднээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэрээр хүмүүст судруудын талаар өөрсдөө бодож, судруудаас асуултынхаа хариултыг олохыг заасан. Залуу эрэгтэйчүүд өөрсдийн асуултуудад судруудаас хариулт олоход нь та хэрхэн тусалж чадах вэ?

Сонгосон материалууд

Итгэлдээ үнэнч байх нь номын “Урвалт” хэсгээс эш татав. (2004), 200–201

Хувь хүн буюу бүлэг хүмүүс сайн мэдээний зарчмуудаас татгалзвал, тэд урвалтын байдалд ордог.

Өргөн тархсан урвалтын үеүд дэлхийн түүхийн туршид тохиосоор ирсэн билээ. Зөв шударгаар хэсэг хугацаанд амьдарсны дараа хүмүүс ёс бус байдал руу эргэдэг. Нэг жишээ бол Аврагч өөрийнхөө Сүмийг зохион байгуулсны дараа тохиосон Их Урвалт юм. Аврагч болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа, хүмүүс сайн мэдээний зарчмуудыг гуйвуулж, Сүмийн зохион байгуулалт болон санваарын ёслолуудыг эрх мэдэлгүйгээр өөрчилжээ. Энэхүү ёс бус хэрэг дэлхийгээр тархсаны улмаас Их Эзэн санваарын эрх мэдэл болон түлхүүрүүдийг дэлхийгээс татан авсан юм.

Их Урвалтын үед хүмүүст амьд бошиглогчдын бурханлаг удирдамж байсангүй. Олон сүм байгуулагдсан ч тэдэнд Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христийн тухай үнэн мэдлэг рүү хүмүүсийг удирдах санваарын хүч байсангүй. Ариун судруудын зарим хэсгүүд алдагдаж, мөн тэдгээрийг гуйвуулж байв. Хэнд ч Ариун Сүнсний бэлэг өгөх болон санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл байсангүй. Энэ урвалт нь Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайрт Хүү хоёр 1820 онд Иосеф Смитэд үзэгдэн сайн мэдээний бүрэн байдлын сэргээлтэйг эхлүүлэх хүртэл үргэлжилсэн юм.

Бид эдүгээ Есүс Христийн сайн мэдээ сэргээгдсэн цаг үед амьдарч байна. Өнгөрсөн цаг үед байсан Сүмүүдтэй адилгүй нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дахин их урвалтад автагдахгүй. Энэ Сүм дахин хэзээ ч устгагдахгүй гэдгийг судрууд заадаг билээ (С ба Г 138:44; мөн Даниел 2:44-ийг үзнэ үү).

Итгэлдээ үнэнч байх нь номын “Сайн мэдээний сэргээлт” хэсгээс эш татав. (2004), 160–164

Есүс Христ дэлхий дээр байхдаа, өөрийн Сүмийг дагалдагчдынхаа дунд үндэслэн байгуулсан. Түүний цовдлолт болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа дэлхий даяар тархсан урвалтын улмаас сайн мэдээний бүрэн байдал дэлхийгээс авагдсан билээ. (“Урвалт” хэсгийг үзнэ үү). Олон эрэгтэй, эмэгтэй хүн Их Урвалт тохиосон олон зууны туршид сайн мэдээний үнэний бүрэн байдлыг эрэлхийлсэн боловч, тэд үүнийг олж авах боломжгүй байсан юм. Хэдийгээр олон хүн Аврагч болон Түүний сайн мэдээний талаар чин сэтгэлээсээ номлож байсан ч, тэдний хэнд нь ч үнэний бүрэн байдал болон Бурханы санваарын эрх мэдэл байсангүй.

Их Урвалт нь сүнсний хувьд харанхуй үе байсан ч, бид одоо “Христийн алдрын сайн мэдээний гэрлийг” хүртэж чадах цаг үед амьдарч байна (2 Коринт 4:4; мөн С ба Г 45:28 –ыг үз). Сайн мэдээний бүрэн байдал сэргээгдэж, Есүс Христийн үнэн Сүм дэлхий дээр дахин оршин тогтнож байна. Бусад ямар ч байгууллагыг энэ Сүмтэй харьцуулах аргагүй юм. Энэ бол өөрчлөлтийг авчрахын төлөө сайн санаат эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн чадах бүхнээ хийсний үр дүнд бий болсон шинэчлэлтийн үр дүн биш. Энэ бол Есүс Христийн зохион байгуулсан Сүмийн сэргээлт юм. Энэ бол Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайрт Хүүгийн ажил билээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд та бараг хоёр мянгаад жилийн турш дэлхий дээр байхгүй байсан тэдгээр адислалуудыг хүлээн авах боломжтой юм. Та баптисм ба гишүүний баталгааны ёслолуудаар дамжуулан нүглийнхээ ангижралыг хүлээн авч, Ариун Сүнсний байнгын нөхөрлөлтэй байж

Сонгосон материалууд

чадна. Та сайн мэдээний энгийн, бүрэн байдлаар амьдарч, Бурхан Тэргүүтэний мөн чанар, Есүс Христийн Цагаатгал, дэлхий дээрх амьдралын зорилго хийгээд үхлийн дараах амьдралын үнэн бодит байдлын тухай мэдлэгийг олж авч чадна. Та энэ цаг үед Бурханы хүслийг заадаг амьд

бошиглогчдоор удирдуулах давуу эрхтэй. Ариун сүмийн ёслолууд нь удирдамж хийгээд амар амгаланг хүлээн авах, мөнх амьдралд бэлтгэх, гэр бүлтэйгээ үүрд мөнхөд лацдан холбуулах болон нас барсан өвөг дээдсийнхээ төлөө авралын ёслолуудыг хийлгэх боломжийг танд олгох болно.



Санваар хэрхэн сэргээгдсэн бэ?

Эрт үед санваарын эрх мэдлийг атгаж байсан хүмүүс Иосеф Смитийн толгой дээр гар тавин санваарыг сэргээсэн билээ. 1829 оны 5-р сард Иохан Баптист Аароны санваарыг сэргээн мөн удалгүй Аврагчийн анхны төлөөлөгчид болох Петр, Иаков, Иохан гурав Мелкизедек санваарыг сэргээсэн. 1836 оны 4-р сарын 3-нд Мосе, Елиа, Елиас нар бусад санваарын түлхүүрийг сэргээсэн.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбирч судлаарай. Санваарын сэргээлтийн юу нь танд сүнслэг урам зоригийг өгдөг вэ?

Та санваарын сэргээлтийн талаарх гэрчлэлийг хэрхэн хүлээн авсан бэ? Энэ гэрчлэл танд санваарын үйлчлэлээ хийхэд хэрхэн нөлөөлсөн бэ?

Залуу эрэгтэйчүүд санваарын сэргээлтийн тухай юу мэддэг вэ? Санваарын эрх мэдлийн талаарх гэрчлэлтэй болоход тэдэнд ямар туршлагауд нь нөлөөлсөн бэ?

Еврей 5:4; Итгэлийн Тунхаг 1:5 (Санваар хүлээн авахын тулд хүмүүн нь Бурханаар дуудагдах ёстой)

С ба Г 110 (Мосе, Елиа болон Елиас нар санваарын нэмэлт түлхүүрүүдийг сэргээв)

С ба Г 1:20 (Хүн болгон Их Эзэний нэрээр ярьж болохын тулд сайн мэдээ сэргээгдсэн юм)

Дэвид А.Бэднар “Тэнгэрийн хүч чадал” *Ensign* эсвэл *Лиахона* 2012 оны 5-р сар, 48–51 (“Санваарын эрх мэдэл ба хүч” видео бичлэгийг мөн үзнэ үү)

С ба Г 2 (Елиа санваарыг илчлэх болно; Эцгүүдэд нь өгөгдсөн амлалтууд хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгадаг болно)

Жэффри А.Холланд “Бидний хамгийн онцгой шинж чанар” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 5-р сар, 43–45.

С ба Г 13; Иосеф Смитийн Түүх 1:68–72 (Иохан Баптист Аароны санваарыг сэргээсэн)

Видео бичлэг: “Санваарын сэргээлт”

С ба Г 27:12–13 (Петр, Иаков, Иохан нар Мелкизедек санваарыг сэргээсэн)

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Цөөн хэдэн залуу эрэгтэйг өнгөрсөн долоо хоногт сурсан чухал үнэний талаар дүгнэн, нэг өгүүлбэр самбар дээр бичихэд урь.
- Чуулгадаа өөрийн санваарын эрх мэдлийн шугамаа хуваалцаж, үүний тухай тайлбарла (эсвэл нэг залуу эрэгтэйг өөрийн санваарын эрх мэдлийн шугамын талаар ярихад урь). Санваарын эрх мэдлийн шугам нь залуу эрэгтэйчүүдэд санваарын сэргээлтийн тухай юуг зааж байна вэ? (Мелкизедек санваартнууд эрх мэдлийн шугамаа lineofauthority@ldschurch.org руу э-мэйл илгээн, хүсэлт гаргаж болно.) Эрх мэдлийн шугам дээр буй хүмүүсийнхээ тухай олж мэдэх талаар бод. Санваарын хүч чадлаа хүндэтгэхэд хүргэх юуг та сурсан бэ?

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь чуулгын гишүүдэд санваарын сэргээлтийг илүү сайн ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын нэг гишүүнийг хичээлийн хэсгийг заахад урь. Тэрээр үүнийг заахдаа “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” төлөвлөгөөнийхөө нэг хэсэг болгон санваарын сэргээлтийн тухай зааж болно (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсууд).
- Санваарын сэргээлтийг харуулсан зургийг ил тавь (Сайн мэдээний уран зургийн цуглуулга, 93–95-г үзнэ үү). Эдгээр үйл явдалд чухал байр суурь эзлэх хүмүүсийг тэднээр нэрлүүл (Иосеф Смит, Иохан Баптист, Елиа гэх мэт). Эдгээр үйл явдлын тухай өгүүлсэн судруудыг унш (энэхүү тоймд санал болгосон гэх мэт) мөн тэдэнд ямар нэг асуух зүйл байгаа эсэхийг лавла. Залуу эрэгтэй бүрээс санваар түүнийг хэрхэн адисалсан тухай хуваалцахыг хүс.
- Залуу эрэгтэйчүүдээс санваарыг хүлээн авч байхдаа ямар зүйл мэдэрсэн тухайгаа хуваалцахыг хүс.

Заахад туслах арга

“Зааж буй сэдвийн талаар хэд хэдэн хүн саналаа илэрхийлэх хүсэлтэй байвал та ‘Бид эхлээд таны саналыг дараа нь дараагийн хүний саналыг сонсьё’ хэмээн хэлж болно. Ингэж хэлбэл тэд саналаа хэлэх боломж гарна гэдгийг ойлгон хичээл эмх журамтай болно” (Teaching, No Greater Call [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нарынхаа чадварыг харж, тэдэнд сурч, хөгжихөд нь туслах онцгой арга замуудыг олсон юм. Залуу эрэгтэй бүрд санваарын сэргээлтийн гэрчлэлтэй болоход нь туслах онцгой боломж танд байна. Энэ гэрчлэл нь тэднийг мөн гэрбүлийг нь болон бусад хүмүүсийг мөнхөд адисалж чадна.

- Залуу эрэгтэйчүүдэд ахлагч Жэффри А.Холландын “Бидний хамгийн онцгой шинж чанар” хэлсэн үгийг хуваан өг. Өөр өөрсдийн авсан хэсгээс “Санваар хэрхэн хүртээсэн бэ?” болон “Яагаад санваарыг ийм аргаар өгсөн бэ?” гэдэг асуултуудад хариулт олж уншихыг хүс. Энэ ярилцлагаараа залуу эрэгтэйчүүдийг Еврей 5:4 ба Итгэлийн Тунхаг 1:5-г уншихыг урь. Аароны

санваартнууд санваарын сэргээлтийн тухай мэддэг байх нь яагаад чухал вэ?

- Ахлагч Дэвид А.Бэднэрын аавынх нь асуусан асуултуудын тухай ярилц (“Тэнгэрийн хүч чадал” хэлсэн үгийг 2012 оны 5-р сарын *Ensign* эсвэл *Liahona*-гаас уншихыг урь). Бид санваар атгадаг учраас дэлхийн бусад эрэгтэйчүүдээс юугаараа өөр байх ёстой вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд санваарын сэргээлтийн тухай илүү сайн ойлголт авсан уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Санваарын сэргээлтийн тухай бодлоосоо хуваалцах эсвэл бусдыг энэ талаар хуваалцахад урь.

- Чуулгын гишүүдийг санваарын сэргээлтийн тухай бусдад заах тойм гаргахад урь (“Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” 18, 42, 66-р хуудсууд).

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднэрын “Тэнгэрийн хүч” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2012 оны 5 - р сар, 48–51

Би итгэлтэй эцэг эхийн гэрт өссөн. Ээж маань Бурханы хаант улс болон Сүмийн төлөө бүх зүйлээ золиосолсон анхдагчдын үр удам байв. Харин аав маань Сүмийн гишүүн биш байсан бөгөөд залуу байхдаа Католик сүмийн санваартан болохыг хүсдэг байлаа. . . .

Хөвгүүн байхдаа би долоо хоног бүр ааваасаа хэзээ баптисм хүртэх вэ гэж асуудаг байв. Намайг ийн шалгаах бүрд тэрээр “Дэвид, би ээжийн чинь юм уу эсвэл чиний төлөө эсвэл хэн нэгний төлөө Сүмд нэгдэхгүй ээ. Харин Сүмд орох нь зөв гэж мэдэрсэн үедээ л Сүмд нэгдэх болно” хэмээн бат итгэлтэйгээр бас хайраар дүүрэн хариулдаг байлаа.

Арван хэдэн настай байхад маань энэ явдал тохиолдож билээ. Бид ням гарагийн цуглаанаас дөнгөж ирсний дараа би ааваасаа хэзээ баптисм хүртэх гэж байна хэмээн дахин асуулаа. Тэр инээмсэглээд, “Надаас баптисм хүртэх талаар чи л дандаа асуух юм. Харин өнөөдөр би чамаас нэг зүйл асууя” гэв. Бид энэ тухай одоо л нэг ярих нь дээ хэмээн би баярласан юм!

“Дэвид ээ, танай сүм санваарыг дэлхийгээс авагдсан боловч тэнгэр элч нар бошиглогч Иосеф Смитэд сэргээж өгсөн гэж заадаг тийм үү?” гэж аав асуулаа. Би тиймээ гэж хариулав. Тэгтэл аав маань “долоо хоног бүр санваартнуудын цуглаан

дээр бишоп болон санваарын удирдагчид ах нараас гэрийн багшаа хийж, санваарын үүргээ биелүүлэхийг гуйж тэдэнд байнга сануулдаг. Хэрэв Бурханы санваарыг танай Сүмд үнэхээр сэргээсэн юм бол яагаад үүргээ биелүүлэхдээ танай сүмийн олон ах манай сүмийн ах нараас ялгагдахгүй байгаа юм бэ?” гэж асуув. Би юу гэж хариулахаа мэдэхгүй байлаа. Аавдаа хэлэх хангалттай хариулт надад байгаагүй юм.

Аав маань манай тойргийн зарим нэг эрэгтэйчүүдийн алдаа, дутагдлыг хараад тэнгэрлэг эрх мэдлийн тухай Сүмийн бодит байдлыг шүүмжилсэн нь буруу гэж би боддог. Гэвч Бурханы ариун санваарыг атгадаг хүмүүс бусад хүмүүсээс өөр байх ёстой гэсэн түүний санаа зөв байлаа. Санваар атгадаг эрэгтэйчүүд бусад эрэгтэйчүүдээс илүү гэсэн үг биш ээ. Гэхдээ тэд жирийн хүмүүсээс илүү ихийг хийх ёстой. Санваар атгадаг эрэгтэйчүүд нь санваарын эрх мэдлийг хүлээн аваад зогсохгүй Бурханы хүчийг дамжуулахад зохистой мөн итгэлтэй байх хэрэгтэй. “Их Эзэний сав тээгчид та нар цэвэр ариун байгтун” (С ба Г 38:42).

Санваарын эрх мэдэл болон санваарын хүчийн талаар ааваасаа сурсан зүйлээ би хэзээ ч мартаагүй. Аавтайгаа ийнхүү ярилцсан нь надад “сайн хүү болох хүслийг төрүүлсэн юм. Сэргээгдсэн сайн мэдээнээс суралцах явцад нь би аавдаа сайн үлгэр жишээ болохыг хүсч байлаа. Би зүгээр л сайн хүү байхыг хүссэн юм. Өөрийнх нь эрх мэдлийг атгагч биднийг хэзээ ч хаана ч шударга, журамтай, сайн хөвгүүд байхыг Их Эзэн хүсдэг.



ДӨРӨВДҮГЭЭР САР: УРВАЛТ БА СЭРГЭЭЛТ

Сэргээлтэд Иосеф Смит ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?

Олон зууны турш байсан урвалтын дараа Их Эзэн Өөрийн Сүм болон сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн билээ. Иосеф Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан анхны үзэгдлээр сэргээлт эхэлсэн түүхтэй. Их Эзэн бошиглогч Иосефоор дамжуулан Мормоны Ном болон бусад судруудыг өгч, санваарын эрх мэдлийг сэргээн, Өөрийн Сүмийг байгуулсан юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та эдгээр судар ба материалуудаас залбирч судлах явцдаа залуу эрэгтэйчүүдтэй юуны тухай хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Таны амьдралд Иосеф Смитийн амьдрал ба зорилго хэрхэн нөлөөлсөн бэ? Та Иосеф Смитийн талаарх гэрчлэлээ хэрхэн олж авсан бэ?

Залуу эрэгтэйчүүд бошиглогч Иосеф Смитийн тухай гэрчлэлтэй юү? Энэхүү гэрчлэлээ бэхжүүлэхэд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

2 Нифай 3:3–25 (Эртний бошиглогчид Иосеф Смитийн бошиглогч, үзмэрч байх зорилгыг урьдчилан хардаг)

С ба Г 35:17–18 (Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг сэргээсэн)

С ба Г 76:22–24 (Есүс Христийн талаарх Иосеф Смитийн гэрчлэл)

С ба Г 135:3 (Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн бидэнд нэмэлт судрыг өгсөн)

Иосеф Смит—Түүх 1:11–25 (Бурхан Эцэг ба Есүс Христ, Иосеф Смитэд үзэгддэг)

Нийл Л.Андэрсэн, “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 54–57

Нийл Л.Андэрсэн, “Иосеф Смит,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 11-р сар, 28–31

Лорэнс И.Корбриж “Бошиглогч Иосеф Смит,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 5-р сар

“Иосеф Смит,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 89–90

Видео бичлэг: Иосеф Смит: Сэргээлтийн бошиглогч

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг давтаж, энэ долоо хоногийн хичээлийг танилцуулахын тулд эдгээр санаанаас сонгох эсвэл өөрийн санааг ашиглаарай:

- Нэг залуу эрэгтэйг самбар дээр өмнөх долоо хоногт сурсан зүйлээ дүрслэн зурахад урь. Бусад залуу эрэгтэйчүүдээр түүний зурсан зүйлийг таалга.
- Чуулгын цуглаанаас хоёр гурван долоо хоногийн өмнө, залуу эрэгтэйчүүдийг Ахлагч Нийл Л.Андэрсэний “Бошиглогч Иосеф Смитийн талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй болцгоогоорой. Бошиглогчийн талаар сайнаар дурсагдах болно гэсэн Моронайн бошиглолын үгс биелэхэд та нарын дуу хоолой

туслах болтугай” хэмээх даалгаврыг хүлээн авахад урь. Найзуудтайгаа болон гэр бүлийнхэнтэйгээ Мормоны Номын судруудыг, “Иосеф бол Бурханы мутар дахь зэмсэг байсан гэдгийг хүлээн зөвшөөрөн” хуваалц гэсэн Ахлагч Андэрсэний зөвлөгөөг дагахыг залуу эрэгтэйчүүдэд уриал. “Иосеф Смит” *Ensign* эсвэл Лиахона, 2014 оны 11-р сар, 30-р хуудсыг үзнэ үү. Чуулгын цуглааны эхэнд, Иосеф Смитийн гэрчлэлийг уншаад төрсөн бодлоо болон тэднийг сонгосон судруудаа хуваалцахыг хүс.

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь Сэргээлтэд оруулсан Иосеф Смитийн үүргийг ойлгоход тэдэнд тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын гишүүдээс өөр шашинтай нэг найз нь “Танай Сүмд Иосеф Смит яагаад ийм чухал байдаг юм бэ?” гэж асууж байна гэж төсөөлөхийг хүс. Энэ асуултын тохирох

хариултуудыг “Иосеф Смит: Сэргээлтийн бошиглогч” видео бичлэгээс эсвэл ахлагч Корбриж Лорэнсийн “Бошиглогч Иосеф Смит” хэлсэн үгээс хайж олоход

Заахад туслах арга

“Хичээл эхлэхээс өмнө самбар дээр бичсэн асуултууд суралцагчдыг уг сэдвийн талаар хичээл эхлэхээс өмнө бодож эхлэхэд тусалдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 93).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдыг итгэлээр үйлдэж, мөн Өөрийн заасан үнэний дагуу амьдрахыг уриалсан. Өөрийн бүх сургаалдаа Тэрээр, дагагчид нь бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Иосеф Смитийн талаарх залуу эрэгтэйчүүдийн гэрчлэл нь тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн харагдах ёстойг ойлгоход нь та тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

тэднийг урь. Та Иосеф Смитийн тухай шүүмжлэлүүдэд хэрхэн хариулахаа мэдэж авахад нь тэдэнд туслахын тулд ахлагч Нийл Л.Андэрсэны “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг” хэлсэн үгэн дэх “Шударга асуултууд” гэсэн гарчигтай хэсгийг уншиж болно.

- Их Эзэний Иосеф Смитээр дамжуулан бидэнд өгсөн зүйлсийг жагсаан бичихэд чуулгын гишүүдийг урь. Жагсаалтаа бичихэд нь туслахын тулд тэднийг Сургаал ба Гэрээ 135:3 ба *Итгэлдээ үнэнч байх нь* номын 114–115-р хуудсыг уншихыг хүс. Их Эзэний Иосеф Смитээр дамжуулан хийсэн ажлын улмаас бидний амьдрал яаж өөрчлөгдсөн бэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд сайн мэдээний Сэргээлтэд Иосеф Смитийн гүйцэтгэсэн үүргийг ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Иосеф Смит өөрийнх нь амьдралд ямар чухал болох тухай бодлоо хуваалцаж, чуулгын бусад гишүүдийг энэ талаарх бодлоо хуваалцахад урина.

- Залуу эрэгтэйчүүдийг Иосеф Смит—Түүх 1:7–20-г уншаад анхны үзэгдлээр дамжуулан Иосеф Смитийн сурсан үнэнүүдийг олж мэдэхэд урь. Иосеф Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн тухай, өөрийнхөө болон дайсныхаа тухай юу мэдэж авсан бэ? Эдгээр үнэнийг бид өнөө үед ойлгох нь яагаад чухал вэ?

- “Иосеф Смит: Сэргээлтийн бошиглогч” видео бичлэгийг үзүүлж, бошиглогч Иосеф Смитийн талаар сурсан эсвэл тэдний сэтгэлийг хөдөлгөсөн зүйлсийг хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Иосеф Смит бол бошиглогч гэсэн гэрчлэлийг та өөрөө хэрхэн хүлээн авсан тухайгаа хуваалцах талаар бодож үзээрэй.

Сонгосон материалууд

Итгэлдээ үнэнч байх нь номын “Иосеф Смит” хэсгээс (2004), 114–115

1820 оны хавар 14 настай Иосеф Смит Есүс Христийн үнэн Сүмийг хайж байхдаа “Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дугвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5; мөн Иосеф Смит-Түүх 1:11–12-ыг үзнэ үү) хэмээх Библийн нэг хэсгээс уншсан билээ. Энгийн, тууштай итгэлтэйгээр залуу Иосеф Смит судрын тэрхүү хэсэг дэх зөвлөгөөг дагасан юм. Тэр ойн цоорхойд ганцаараа очиж, ямар сүмд элсэхээ мэдэхийн тулд залбирсан билээ. Залбирлынх нь хариуд Бурхан Эцэг, Есүс Христ хоёр түүнд үзэгдсэн. Олон зүйлс дундаа, тэдгээр сүмүүдээс алинд нь ч нэгдэж болохгүйг Тэд түүнд хэлэв. (Иосеф Смит-Түүх 1:13–20-ийг үзнэ үү.)

Зөв зохистойгоо нотлон харуулснаар Иосеф Смит Бурханы бошиглогч байх тэнгэрлэг үүргийг хүлээн авсан ажээ. Түүгээр дамжуулан Их Эзэн Мормоны Номыг авчрах, санваарыг

сэргээх, сайн мэдээний эрхэм чухал үнэнүүдийг илчлэх, Есүс Христийн үнэн Сүмийг зохион байгуулах, ариун сүмийн ажлыг үндэслэн бий болгох зэрэг агуу бөгөөд гайхамшигт ажлуудыг гүйцэлдүүлсэн билээ. 1844 оны 6-р сарын 27-нд Иосеф ах Хайрумын хамт зэвсэглэсэн дээрэмчдийн халдлаганд өртөн алагдсан. Тэд өөрсдийн гэрчлэлийг цусаараа лацадсан юм.

Та нар сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээ хуваалцахдаа Иосеф Смитийн бурханлаг үүргийн тухай гэрчлэлээ мөн хуваалцах хэрэгтэй. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн үнэн зөв байдал нь Анхны үзэгдэл болон Бошиглогч Иосеф Смитэд өгсөн Их Эзэний бусад илчлэлтүүдийн үнэн зөв байдал дээр тулгуурладаг. Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч Жон Тэйлорын бичсэнээр “Их Эзэний бошиглогч хийгээд үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүсийг эс тооцвол үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм” (С ба Г 135:3).



ДӨРӨВДҮГЭЭР САР: УРВАЛТ БА СЭРГЭЭЛТ

Анхны үзэгдэл яагаад чухал вэ?

1820 оны хавар Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христ хоёр Бошиглогч Иосеф Смитэд үзэгдсэн билээ. Энэхүү үзэгдэл нь сайн мэдээний сэргээлтийн эхлэл байсан бөгөөд энэ нь Есүс Христийн амилалтаас хойш тохиосон хамгийн чухал үйл явдал болжээ. Иосеф Смитийн даруухан залбирал сайн мэдээний үнэн, санваарын эрх мэдэл ба авралын ёслолуудын сэргээлт рүү хөтөлсөн. “Тэрхүү илчлэлт нь Бурхан мөн Түүний бурханлаг мөн чанарын талаарх бүхий л [асуултуудад] хариулдаг. ... Бидэнд өгөгдсөн эрх мэдлээс бид Тэр хүмүүнд хэчнээн их анхаарал тавьдгийг харах боломжтой байдаг. Агуу үйлсийн ирээдүй нь тодорхой болсон бөгөөд эдгээр болон бусад гайхамшигт үнэнүүд нь тэрхүү тэнгэрлэг анхны үзэгдлээр бүгд маш тодорхой болсон юм”.

Иосеф Смит Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христийг харсан гэдэг гэрчлэлийг та хэрхэн хүлээн авсан бэ? Энэ гэрчлэлийг хүлээн авснаар таны амьдрал хэрхэн адислагдсан бэ? Анхны үзэгдэл таны хувьд яагаад чухал вэ?

Анхны үзэгдлийн талаар судлах нь танай чуулгын залуу эрэгтэйчүүдийн гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлэх вэ? Та залуу эрэгтэйчүүдэд энэхүү агуу үйл явдлыг чухал гэдгийг ойлгоход нь хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та хичээлээ бэлдэж байхдаа эдгээр судруудыг болон өөрийн сонгосон бусад материалуудаа залбиралтайгаар судлаарай. Таны заадаг залуу эрэгтэйчүүдэд юу заах нь хамгийн чухал гэж та бодож байна вэ?

Иосеф Смит—Түүх 1:11–19, 24–25

Видео бичлэг: “Сэргээлт”

Дийтр Ф.Угдорф “Анхны үзэгдлийн үр жимс” Ensign эсвэл Лиахона, 2005 оны 5-р сар, 36–38

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүн бүрд өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа нэг зүйлээ нэрлэх боломжийг олго.
- Чуулгын гишүүдтэй Иосеф Смитийн анхны залбирал дууллыг

дуул (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу 14-р хуудас). Залуу эрэгтэйчүүдийг Иосеф Смитийн тухай болон Бурхан Эцэг, Есүс Христ хоёртой уулзсан түүний туршлагын талаарх бодлоо хуваалцахад урь.

Хамтдаа суралц

Чуулгын гишүүд Иосеф Смитийн анхны үзэгдлийн тухай сурахад дараах бүх үйл ажиллагаа тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Анхны үзэгдлийн үр дүнд хүлээн авсан адислалуудынхаа заримаас бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Анхны үзэгдлийн үр жимс” хэлсэн үгийн сүүлчийн 10 догол мөрийг уншихдаа анхны үзэгдлийн өөр бусад адислалуудыг олохыг тэднээс хүс. Олж уншсан зүйлийнхээ талаар болон анхны үзэгдэл яагаад чухал гэж боддог тухайгаа хуваалцахад тэднийг урь.
- Иосеф Смитийн Түүх 1:7–20 дээр байгаа Иосеф Смитийн анхны үзэгдлийн тухай хамтдаа унш. Иосефын туршлагаас бидний сурч болох үнэнүүдийг олж уншихыг тэднээс хүс (жишээлбэл: Эцэг, Хүү хоёр жинхэнэ амьд, хоёр тусдаа хүн, Сатан болон түүний хүч чадал ч бас бодит гэвч Бурханы хүч чадал илүү агуу, Бурхан бидний залбирлыг сонсдог, илчлэлт одоо ч өгөгдсөөр байгаа гэх мэт). Нэг залуу

эрэгтэйгээс үнэнүүдийг самбар дээр бичихийг хүс. Эдгээр үнэн нь өөр бусад шашны итгэлээс юугаараа өөр байдаг вэ? Эдгээр үнэнийг мэдээгүй бол бидний амьдрал хэрхэн өөр байх байсан бэ?

- Залуу эрэгтэйчүүдийг Иосеф Смит—Түүх 1:11–19, 24–25-г дор бүрнээ уншаад, Иосеф Смитийн анхны үзэгдэл ба Иосефын гэрчлэлийн талаар тунгаан бодоход урь. Анхны үзэгдэл хүн төрөлхтний түүхэнд яагаад чухал байр суурь эзэлдэг тухай тунгаан бодохыг тэднээс хүс. Яагаад энэ нь бидний хувьд чухал вэ? Анхны үзэгдэл хэчнээн чухал тухай гэрчлэлээ хуваалцан, тэднийг энэ талаар бодол ба гэрчлэлээ хуваалцахад урь.
- Бурхан Эцэг ба Есүс Христ хоёр газар дэлхий дээр хүмүүст Өөрсдийгөө харуулсан тухай судрын түүхүүдийг тоймлон уншихыг урь

Заахад туслах арга

“Хэрэв хэн нэгэн хүн тэднээс хичээл дээр сурсан зүйлээс нь асуувал тэд юу гэж хариулах вэ? гэж залуу эрэгтэйчүүдээс асуу”.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагч нараа Түүний сургаалын үнэнийг бусдад заахад урьдаг байсан. Тэд Түүний сургаалын үнэнийг заахад Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрдэг байв. Та залуу эрэгтэйчүүдийг нэг нэгэнтэйгээ гэрчлэлээ хуваалцахад нь хэрхэн дэмжиж болох вэ?

(Матай 3:13–17; Үйлс 7:54–60; 3 Нифай 11:3–10 гэх мэт). Та эдгээр үйл явдлын тухай зургуудыг үзүүлж болно (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга* 35, 63, 82 гэх мэт). Үйл явдал нэг бүрийг тоймлон дүгнэхийг тэднээс хүс. Үүний дараа тэднийг Иосеф Смит Түүх 1:17-г уншихыг

хүс (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 90-г үзнэ үү). Иосеф Смитийн анхны үзэгдэл эдгээр түүхтэй юугаараа төстэй байна вэ? Юугаараа онцлог байна вэ? Яагаад анхны үзэгдэл тэдний хувьд чухал байдаг тухай хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд Иосеф Смитийн анхны үзэгдлийн талаар илүү сайн ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаалыг дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Анхны үзэгдэл чухал болох талаар өөрийн бодол санааг хуваалцана.
- Өнөөдөр сурсан зүйлээ найз нөхөд ба гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахад чуулгын гишүүдийг урина.



Яагаад бидэнд Мормоны Ном хэрэгтэй вэ?

Мормоны Ном өнөө үед зориулан бичигдсэн. Энэ нь Есүс Христийн тухай гэрчилдэг бөгөөд Түүний сайн мэдээгээр дүүрэн байдаг. Мормоны Ном Урвалтын үед алдагдсан үнэнүүдийг сэргээсэн. Мормоны Ном бол “манай шашны тулгуурын чулуу, түүнчлэн ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” хэмээн Иосеф Смит заасан юм (Мормоны Номын удиртгал).

Мормоны Номыг судалж байсан туршлагынхаа талаар бод. Яагаад Мормоны Ном танд чухал байдаг вэ?

Мормоны Ном залуу эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ? Тэд Мормоны Номын талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж болох вэ? Өнөө үед тулгарч буй сорилт бэрхшээлүүдээ даван туулахад Мормоны Ном тэдэнд хэрхэн туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалыг залбиралтайгаар уншаарай. Залуу эрэгтэйчүүдийг Мормоны Номын хүч чадлыг мэдрэхэд нь та хэрхэн тусалж чадах вэ?

Езекиел 37:15-17 (Библи, Мормоны Ном хоёр хамтдаа нэг зүйл юм.)

1 Нифай 13:40; 2 Нифай 3:12 (Мормоны Ном нь үнэ цэнэтэй үнэнүүдийг сэргээн, буруу сургаалуудыг үгүйсгэдэг)

2 Нифай 25:23, 26; 33:10–11 (Мормоны Номыг бичсэн хүмүүс Есүс Христийг гэрчилдэг)

2 Нифай 29:7–11 (Бурхан олон үндэстний хүүхдүүдтэйгээ ярьдаг гэдгийг Мормоны Ном харуулдаг)

С ба Г 20:8–16; 42:12 (Мормоны Ном Есүс Христийн сайн мэдээг бүрэн дүүрэн агуулдаг)

Мормоны Номын гарчиг ба удиртгал

Кэвин В.Пийрсон, “Модны дэргэд үлд,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 104–106

Жэффри А.Холланд, “Бодгалийн аюулгүй байдал,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2009 оны 11-р сар, 88–90

Тэд Р.Каллистэр, “Мормоны Ном—Бурханаас өгөгдсөн ном,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2011 оны 11-р сар, 74–76

Видео бичлэг: “Мормоны Ном: Төлөөлөгчийн танилцуулга” (татаж авах боломжгүй)

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Цөөн хэдэн залуу эрэгтэйг өнгөрсөн долоо хоногийн хичээлээс юу тэдэнд хамгийн онцгой санагдсан тухай хуваалцахад урь.
- Чуулгаараа хамтран цамхгийн шаантаг чулууг зур (“Миний сайн мэдээг номло” номны 117-р хуудсыг үзнэ үү). Иосеф Смит Мормоны Номыг яагаад манай шашны шаантаг чулуу хэмээн хэлснийг тайлбарлахыг залуу эрэгтэйчүүдээс хүс (Мормоны Номын удиртгалыг үзнэ үү).

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь чуулгын гишүүдийг Мормоны Ном хэчнээн чухал болохыг ойлгоход тусална. Сүнсний нөлөөг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын гишүүдийг ахлагч Жэффри Р.Холландын “Бодгалийн аюулгүй байдал” эсвэл ахлагч Кэвин В.Пийрсоний “Модны дэргэд үлд” хэлсэн үгийг судалж, Мормоны Номын талаарх болон энэ нь яагаад маш чухал байдаг талаарх ойлголтуудыг хайж олоход урь. Та залуу эрэгтэйчүүдийг уг хэлсэн үгсээс зарим хэсгийг эсвэл Мормоны Номон дахь дуртай судруудаа хуваалцахад урьж болно. Та бас тэднийг Мормоны Номын талаарх гэрчлэлүүдээ бичиж мөн хуваалцахад урамшуулан дэмжиж болно.
- Залуу эрэгтэй бүрийг энэхүү тойм дээр жагсаасан судруудаас нэгийг эсвэл Мормоны Номын гарчгаас уншин, “Яагаад бидэнд Мормоны Ном хэрэгтэй вэ?” гэдэг асуултад хариулт олохыг хүс. Тэднийг хариултаа самбар дээр бичихэд урь. Самбар дээр бичсэн хариултуудаас илүү ихийг мэдэхийг хүссэн нэг хариултыг сонгон, сонгосон хариултаа бусадтайгаа хуваалцахыг тэднээс хүс.
- Мормоны Номын талаар тэдний найзуудад байж болох асуултуудын тухай бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ахлагч Тэд Р.Каллистэрийн “Мормоны Ном— Бурханаас өгөгдсөн ном” хэлсэн үгээс тэд юу хуваалцаж болох вэ? Найзыгаа Мормоны Ном уншихад урих дадлага хийхийг чуулгын гишүүдээс хүс. Мормоны Ном гэдэг нь юу болох бас бидэнд яагаад хэрэгтэй байдаг талаар тэд хэрхэн тайлбарлах вэ? Тэд Мормоны Номын ямар

Заахад туслах арга

“Нэг хүн судраас чанга уншиж, бусад нь түүнийг даган уншихад та тэднийг дэмжих ёстой. Уншсан зүйлээсээ ямар нэг тодорхой зарчим эсвэл санааг олж, сонсоход тэднийг урь. Тэдэнд уншихаасаа өмнө уг судрын хэсгийг олж нээх цаг олго. Хэрэв уг хэсэгт ойлгоход хэцүү үг хэллэг байгаа бол уншихаасаа өмнө тэдгээрийг тайлбарлаж өг. Ангид сайн уншиж чаддаггүй суралцагч байгаа бол ээлжлэн уншуулахын оронд чанга унших нэг хүнийг томил” (Teaching, No Greater Call [1999], 56).

шүлгүүдээс хуваалцах вэ? Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ гэдгийг тэд хэрхэн тайлбарлах вэ? Залуу эрэгтэйчүүдийг “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номынхоо 29, 53 эсвэл 77-р хуудсыг нээн, Мормоны Номыг уншихыг урих хэн нэгний нэрийг бичихэд урь.

- Залуу эрэгтэй бүрийг өөрсдөд нь чухал санагддаг Мормоны Номын нэг судар эсвэл тэдний амьдралд нөлөө үзүүлсэн нэг хэсгийг олоход урь. Чуулгын гишүүдийг хоёр эсвэл гурван хүнтэй жижиг бүлгүүдэд хуваан, сонгосон судраа хуваалцан,

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан тухайгаа хуваалцахыг хүс. Яагаад Мормоны Ном чухал болохыг тэд ойлгодог уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Цөөн залуу эрэгтэйг яагаад Мормоны Ном бидэнд хэрэгтэйг болон энэ нь үнэн гэдгийг хэрхэн мэдсэн тухай гэрчлэлээ хуваалцахад урьж болно.

яагаад энэ судар түүний хувьд чухал байдаг тухай мөн энэ хэсэгтэй холбоотой туршлагаасаа хуваалцахыг хүс. Цөөн залуу эрэгтэйг энэ тухай нийт чуулгынхантайгаа хуваалцахад урь. Эдгээр туршлага нь бидэнд Мормоны Ном чухал гэдгийг хэрхэн зааж байна вэ?

- Тэднээс “Яагаад бидэнд Мормоны Ном хэрэгтэй вэ?” гэдэг асуултад хариулан бичихийг хүс. Тэднээр бичсэн зүйлсийнх нь талаар хуваалцуул. Мормоны Ном байхгүй байсан бол тэдний амьдрал ямар байх байсан бэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч хүмүүсийг сайн мэдээний үнэнүүдэд суралцахын тулд итгэлийнхээ дагуу үйлдэхэд урьдаг байсан. Тэрээр “Гуйгтун. Та нар хүлээн авна” хэмээн заасан (Иохан 16:24). Залуу эрэгтэйчүүд Мормоны Номын тухай гэрчлэлтэй болоход эсвэл энэхүү гэрчлэлээ хүчирхэгжүүлэхээр эрэлхийлэхдээ энэ арга замыг дагахад нь та тэднийг хэрхэн дэмжиж чадах вэ? (Моронай 10:3–5-ыг үзнэ үү.)

Сонгосон материалууд

Тэд Р.Каллистэрын “Мормоны ном—Бурханаас өгөгдсөн Ном” хэсгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2011 оны 11 –р сар, 74–76

Гэхдээ Есүс Христийн талаар заадаг Библи байхад Мормоны Ном байх нь яагаад чухал юм бэ? Бүгдээрээ Библиээс заадаг атлаа яагаад дэлхий дээр ийм олон Христийн шашны урсгал байдаг талаар та гайхаж байсан уу? Учир нь тэд Библийг өөр өөрөөр тайлбарладаг. Тэд ижил тайлбарладаг байсан бол дэлхий дээр нэг л сүм байх байсан. Их Эзэн ийм олон урсгалтай байхыг хүсдэггүй бөгөөд Төлөөлөгч Паул “нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм” (Ефес 4:5) хэмээн тунхагласан. “Нэгэн нэгдмэл байхад туслахын тулд Их Эзэн гэрчүүдийн талаар тэнгэрлэг хуулийг өгсөн. Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүр батлагдах болно” (2 Коринт 13:1).

Библи, Мормоны Ном хоёулаа Есүс Христийг гэрчилдэг байхад яагаад хоёр дахь гэрч ийм чухал вэ? Дараах жишээ та бүхнийг илүү сайн ойлгоход тусалж болох юм. Цаасан дээрх нэг цэгийг дайруулан хэдэн шулуун зураас зурж болох вэ? Хариулт нь тодорхойгүй бөгөөд тоо томшгүй байх болно. Тэр цэгийг Библи гээд, тэдгээр зуу зуун шулуун зураасыг тэдгээр олон сүмийн Библийн өөр өөр тайлбарууд хэмээн төсөөлье.

Харин тэр цаасан дээр Мормоны Номыг төлөөлөн дахиад нэг цэгийг зуръя. Библи болон Мормоны

Номыг төлөөлсөн энэ хоёр цэгийг дайруулан хэдэн шулуун зураас зурж болох вэ? Хариулт нь зөвхөн нэг зураас. Христийн сургаалыг зөвхөн энэ хоёр судар л нэгэн адилаар гэрчилдэг.

Дахин хэлэхэд, Мормоны Ном нь Библийн заадаг сургаалуудыг батлах, тодотгох, нэгтгэх гэрчийн үүрэгтэй бөгөөд ингэснээр бид “нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм”-тай байх болно. Жишээ нь Аврагч Никодемд “хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” (Иохан 3:5) хэмээн тунхагласан байдаг ч зарим хүн баптисм нь аврагдахад тийм чухал гэж үү хэмээн эргэлздэг. Харин Мормоны Номонд “итгэлтэйгээр наманчилж, мөн түүний нэрээр баптисм хүртэх ёстойг тэрээр бүх хүмүүнд зарлигласан билээ, эс бөгөөс тэд Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй” хэмээн баталж энэ талаар бүрэн шийдвэртэй хариултыг өгсөн юм (2 Нифай 9:23).

Агуу жишээ болох Аврагч маань “[Тэр] голын уснаас тэр даруй гарав” (Матай 3:16) хэмээн баптисм хүртэх жишээг Библи дээр үзүүлсэн байдаг ч өнөө үед дэлхий дээр баптисмыг олон аргаар хүртээсээр байна. Тэр эхлээд усанд ороогүй байж уснаас гарна гэж үү? Баптисмын талаар аливаа зөрчилдөөн гаргуулахгүйн тулд “та нар тэднийг усанд бүрэн дүр” хэмээн баптисм хүртэх зөв арга замыг Мормоны Номонд бичсэн байдаг (3 Нифай 11:26).

Тавдугаар сар: Бошиглогчид ба илчлэлт

“Бурханы илчилсэн бүгдэд, эдүгээ Түүний илчилж буй бүгдэд бид итгэдэг мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид илчлэх болно гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:9).

Энэхүү бүлгийн тойм нь залуу эрэгтэйд судруудаар болон амьд бошиглогч ба дагалдагчдаар дамжуулан мөн тэдний зүрх сэтгэл, оюун ухаанд Ариун Сүнсээр ирэх хувийн илчлэлтээр дамжуулан Их Эзэн түүнтэй ярих үед Түүний дуу хоолойг ялган таньж сурахад нь туслах болно. Судрууд нь санваартнуудад өгсөн “мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн анхаарал тавих” мөн “Бурханы амнаас урагш гардаг үг бүрээр амьдрах” зарлигийг агуулдаг (С ба Г 84:43–44). Энэхүү бүлэгт та чуулгын гишүүддээ Бурханы үгийг хайрладаг болсноор энэхүү зөвлөгөөг дагахад нь тэдэнд туслах болно.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг Ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын дараах тоймыг та энэ бүлэгт оруулан, зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Судруудыг судлах нь яагаад чухал байдаг вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Амьд бошиглогчдыг сонсон, тэднийг дагах нь яагаад чухал байдаг вэ?

Би хувийн илчлэлтээ хэрхэн хүлээн авах вэ?

Би залбирлаа хэрхэн илүү утга учиртай болгох вэ?

Би гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?

Ерөнхийлөгч Монсон Аароны санваартнуудад юу заасан бэ?

Патриархын адислал надад хэрхэн тусалж болох вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон, үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Залбирч, судруудыг судал,” 14–15, 38–39, 62–63-р
хуудас

“Сургаальг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас



ТАВДУГААР САР: БОШИГЛОГЧИД БА ИЛЧЛЭЛТ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Судруудыг судлах нь яагаад чухал байдаг вэ?

Судрууд Бурханы үгийг агуулдаг. Хожмын үеийн бошиглогчид хувиараа болон гэр бүлээрээ судруудыг өдөр бүр судлахыг бидэнд зөвлөдөг. Судруудыг судалснаар бид Тэнгэрлэг Эцэг мөн Есүс Христийг мэдэж, сорилтуудыг эсэргүүцэх хүчийг авч мөн бэрхшээлүүдээр дамжин хүчирхэгжих болно.

Судруудыг судалснаар таны амьдрал хэрхэн адислагдсан бэ? Та залуу эрэгтэйчүүдтэй ямар туршлагаасаа хуваалцаж болох вэ?

Судрын ямар шүлэг танай чуулгын залуу эрэгтэйчүүдийн хувьд ач холбогдолтой гэж та бодож байна вэ? Залуу эрэгтэйчүүдийг судар судлахаа илүү учир утгатай, үр дүнтэй болгоход туслах юуг та хийж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба материалуудыг залбирч судал. Судар судлахын ач холбогдлыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд юу тусална гэж та үзэж байна вэ?

Иошуа 1:8; 2 Тимот 3:16–17; 1 Нифай 15:24; 2 Нифай 32:3; Алма 17:2–3; Хиламан 3:29–30; С ба Г 18:33–36; 21:4–6; 84:85 (Судруудыг судалснаас ирэх адислалууд)

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 14–15, 38–39, 62–63

Бойд К. Пакэр, “Сүнслэг хамгаалалтын түлхүүр,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар

Ричард Г. Скотт, “Судрын адислалууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11-р сар, 6–8

Д. Тодд Кристоффэрсон, “Судрын хүч” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 32–35

“Судрууд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 175–176

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ньномоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдийг өнгөрсөн долоо хоногийн ярилцлагаар сурч мэдсэн болон хуваалцсан зүйлийг төлөөлөх ямар нэгэн зүйлийн талаар бодохыг урь. Энэ зүйл нь тэдний сурч мэдсэн зүйлтэй ямар холбоотойг тайлбарлахыг тэднээс хүс.
- Залуу эрэгтэйчүүдийг хоёр хоёроороо болж өөрсдийн дуртай судруудынхаа нэгийг чуулгынхантай хуваалцахад урь. Тэдэнд судрыг чухал ач холбогдолтой гэсэн ямар туршлага байгааг хуваалц. Эдгээр туршлагаас судруудын ач холбогдлын талаар залуу эрэгтэйчүүд юу мэдэж авсан бэ?

Заахад туслах арга

“Заах тэдний зүрх сэтгэлд нь сайн мэдээг хүргэхийн тулд Сүнс байх хэрэгтэй (2 Нифай 33:1; С ба Г 42:14-ийг үзнэ үү). Тийм учраас Сүнсийг урьж, хичээлд зөв уур амьсгал бий болгох арга барилыг та нар ашиглах хэрэгтэй” (Teaching, No Greater Call [1999], 91).

Хамтдаа суралц

Энэхүү хичээлийн зорилго бол судраас тогтмол судлах хэвшил тогтоох эсвэл хүчирхэгжүүлэх төлөвлөгөө хийхэд залуу эрэгтэйчүүдэд туслах явдал юм. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө бичих цагийг чуулгын цуглааны үеэр залуу эрэгтэйчүүдэд гаргаж өгөөрэй. Төлөвлөгөөгөө өөр хоорондоо хуваалцахад тэднийг дэмжиж, төлөвлөгөөгөө хэрхэн биелүүлсэн тухай туршлагаасаа чуулгын цаашидын цуглаанууд дээр хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдээс Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо 14 юм уу 38-р хуудсыг нээхийг хүс. Чуулгын гишүүн бүрд эдгээр хуудсууд дээрх судрын эшлэлүүдээс нэгийг оноон өг (энэхүү тоймд жагсаасан судруудыг үзнэ үү). Чуулгын гишүүдийг судруудыг судлахад бид хэрхэн хандах ёстойг харуулах үгсийг мөн бид судруудыг судалснаар ирдэг адислалуудыг хайж олон, хуваалцахад урь. Судар тогтмол судлах дадал хэвшилтэй болох эсвэл ийм хэвшилтэй бол улам сайн болгох төлөвлөгөө хийхэд тэднийг урь (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, 15, 39 эсвэл 63-р хуудсуудыг үзнэ үү).
- Залуу эрэгтэй бүрээс дараах асуултуудаас нэгийг тунгаан бодохыг хүс: Судар судлах нь зарлигуудыг дагахад маань хэрхэн нөлөөлдөг вэ? Судар судлах нь гэр бүлийнхэнтэйгээ харьцах харилцаанд маань хэрхэн нөлөөлдөг вэ? Судар судлах нь Бурхантай харьцах харилцаанд маань хэрхэн нөлөөлдөг вэ? Залуу эрэгтэйчүүдийг өөрсдийн бодлыг чуулгынхантай хуваалцахыг хүс (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын 62-р хуудсыг үзнэ үү). Тэднийг 15, 39, эсвэл 63-р хуудсыг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос уншаад хувиараа судар илүү сайн судлах төлөвлөгөө гаргахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг энэхүү тоймд санал болгосон үгсийн нэг хэсгийг уншихад урь. Судруудын талаар мөн судар судлахаас ирдэг адислалуудын талаар сурсан зүйлээ хуваалцахыг тэднээс хүс. Тэд өөрсдийн амьдралд судар судлахын үр нөлөөг харсан уу?

- Энэ тоймд зөвлөмж болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзэхэд эсвэл Итгэлдээ үнэнч байх нь товхимлын (175–176-р хуудсууд) “Өдөр бүр судар судлахын ач холбогдол” хэсгийг уншихад залуу эрэгтэйчүүдийг урь. “Судар судлах нь миний хувьд яагаад чухал вэ?” гэсэн асуултын

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Судруудыг судлах нь яагаад чухал болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Хувийн судар судлах төлөвлөгөөнийхөө талаар чуулгынхантай хуваалцаж болно.
- Ирэх долоо хоногуудын чуулгын цуглаанаар чуулгын гишүүдийг

хариуг олохыг тэднээс хүс. Тэднийг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Судар хэрхэн судалдаг туршлагаасаа хуваалцахыг хэдэн залуу эрэгтэйгээс хүс. Судар хэрхэн судалдаг тухай туршлагаас нь хуваалцуулахын тулд нэг эцгийг эсвэл тойргийн нэг гишүүнийг бишопын зөвшөөрөлтэйгөөр урихыг бод.

- *Миний сайн мэдээг номло* номын 28-30-р хуудсууд дээрх суралцах үйл ажиллагаануудаас нэгийг сонгож, уг үйл ажиллагааг нэг, нэгээрээ эсвэл хамтарч хийхэд залуу эрэгтэйчүүдийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байсан. Тэрээр хүмүүст судруудын талаар бодож, асуултынхаа хариултыг олоход тэдгээрийг ашиглахыг заасан. Залуу эрэгтэйчүүдийг асуултуудынхаа хариултыг олохын тулд судруудыг ашиглахад нь та хэрхэн тусалж болох вэ?

Сонгосон материалууд

Итгэлдээ үнэнч байх нь номын “Судрууд” хэсгээс эш татав (2004), 175–79

Өдөр бүр судраас судлахын ач холбогдол

Судрын үндсэн зарчим нь Христийн тухай гэрчилж, Түүнд ирж, мөнх амьдралыг хүлээн авахад бидэнд туслах явдал мөн (Иохан 5:39; 20:31; 1 Нифай 6:4; Мозая 13:33–35 –г үз). Бошиглогч Мормон гэрчлэхдээ:

“Тийм ээ, чөтгөрийн бүх башир аргыг мөн урхи мөн арга залиг нь тасчин хуваах, амьд хүчирхэг, мөн ёс бусыг үйлдэгчдийг залгихаар бэлтгэгдсэн зовлонгийн үүрдийн ангал дээгүүр гарах давчуу бөгөөд нарийн замаар Христийн хүмүүнийг удирдах Бурханы үгэн дээр тулгуурлахыг хүсэх хэн боловч тулгуурлаж---

“Мөн тэнгэрийн хаант улсад, Бурханы баруун мутар талд, Абрахамтай, мөн Исаактай, мөн Иаковтай хамт, мөн бидний бүх ариун эцэг өвгөдийн хамт, цаашид гарахгүйгээр суухаар өөрсдийн бодгалиудыг, тийм ээ, үхэшгүй бодгалиудаа байрлуулж болохыг бид харж болно” (Хиламан 3:29–30).

Хожмын үеийн бошиглогчид биднийг өдөр бүр хувиараа болон гэр бүлтэйгээ хамт судраас судлахыг зөвлөдөг. Нифай ах нараа урамшуулж байсан шиг өнөөдөр амьдралдаа эртний хүмүүсийн нандин шастирыг олж, судруудыг өөрсөдтөйгөө адилтгахад тэд биднийг урамшуулан дэмждэг

(1 Нифай 19:23–24 –г үзнэ үү). Тэд биднийг “судруудыг судалж” (Иохан 5:39) мөн “Христийн үгэн дээр хуримлахыг” (2 Нифай 32:3) уриалдаг.

Энэ зөвлөгөөг дагаснаар та их ашиг тусыг олох болно. Судраас өдөр бүр, үр дүнтэй судлах нь Ариун Сүнсний шивнээг сонсоход тань туслах болно. Энэ нь таны итгэлийг хүчирхэгжүүлж, уруу таталтаас хамгаалж мөн Тэнгэрлэг Эцэг ба Түүний Хайрт Хүүд илүү ойр байхад тусалдаг.

Судраас хувиараа суралцах төлөвлөгөө боловсруул. Өдөр бүр судраас суралцах тодорхой цаг гаргах талаар бод. Уншиж байх үедээ Сүнсний өдөөлтөд анхаарч, анхааралтай унш. Тэнгэрлэг Эцэг таныг юу сурч, юу хийхийг хүсч байгааг мэдэхийн тулд Түүнээс асуу.

Судруудаа, ялангуяа Мормоны Номыг амьдралынхаа турш үргэлжлүүлэн унш. Та амьдралынхаа өөр өөр үеүдэд судруудын эрдэнэсийг судлахдаа шинэ утга санаа, хэрэгжүүлэх зүйлүүдийг олж дахин дахин нээж илрүүлэх болно.

Хэрвээ та гэрлэсэн бол өдөр бүр гэр бүлтэйгээ судраас судлах цаг гаргаарай. Энэ нь хэцүү байж болох ч, гайхалтай бөгөөд мөнхийн үр дүнг өгөх болно. Сүнсний удирдамжийн дагуу гэр бүлийнхээ хэрэгцээнд нийцүүлэн судар уншихаар төлөвлө. Бяцхан хүүхдүүдэд судар уншиж өгөхөөс бүү эмээ. Ариун цэдгүүдийн хэл нь бяцхан хүүхдүүдэд ч хүрэх хүчтэй.



Амьд бошиглогчдыг сонсон, дагах нь яагаад чухал байдаг вэ?

Бид Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг бошиглогч, үзмэрч мөн илчлэгчид хэмээн батлан дэмждэг. Тэдний заасан зүйлс Их Эзэний хүслийг тусгадаг. Тэд бидэнд Их Эзэний заавар, сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгдөг. Бид тэдний зөвлөгөөг сонсон дагах үед аюулгүй байдал, амар амгалан, сүнслэг хүч чадлаар адислагддаг.

Та нар амьд бошиглогчдын ямар зөвлөгөөг амьдралдаа хэрэгжүүлсэн бэ? Уг зөвлөгөөг дагаснаар та хэрхэн адислагдсан бэ?

Амьд бошиглогчдын талаар гэрчлэлтэй байх нь чуулгын тань залуу эрэгтэйчүүдийн хувьд яагаад чухал вэ? Өнөөдөр тэднийг удирдах амьд бошиглогчидтой байгаа нь ямар их боломж болохыг ойлгоход та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юу хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Амос 3:7; С ба Г 1:4, 37–38; Мосе 6:26–38 (Их Эзэн Өөрийн бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг)

С ба Г 21:1, 4–7 (Их Эзэн бошиглогчийг дагадаг хүмүүст агуу адислал амласан)

Роналд А.Расбанд, “Сүмийн удирдагчидтайгаа хамт зогсох нь,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 31–34

Дэвид А.Бэднар, “Миний нэрийг гэрчлэхээр сонгогдсон,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 126–130

М.Рассэлл Баллард, “Завиндаа үлдэж, чанга зууран барь!” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 11-р сар, 89–92

Кэрол Ф.Макконки, “Бошиглогчдын үгсийг дагаж амьдарцгаая,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 87–89

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн нь чуулгын цуглааныг хөтлөн явуулна. Тэрээр чуулгын үйл ажиллагааны талаар хамтдаа ярилцаж, санваарын үүргийнх нь талаар тэдэнд зааж (судруудаас болон “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номноос), зөвлөхийг эсвэл өөр нэг чуулгын гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урин залуу эрэгтэйчүүдийг удирддаг. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг удирдагчдын цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын

ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс түлхүүр үгийг сонгон, чуулгын нэг гишүүнээр энэхүү үгийг дүрслэн хэлүүлж, бусад гишүүнийг уг үгийг таахад урь. Чуулгынхнаас өнгөрсөн хичээл дээр энэ үг яагаад чухал байсныг тайлбарлахыг хүс.
- Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын зургуудыг харуул (*Ensign* эсвэл *Лиакона* сэтгүүлийн Ерөнхий чуулганы хэсэг дээрх зургууд гэх мэт). Эдгээр эрэгтэй нь бошиглогч, үзмэрч мөн илчлэгчид юм хэмээх гэрчлэлээ хуваалц. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын нэг гишүүнээс сонссон ямар захиасыг залуу эрэгтэйчүүд санаж байна вэ?

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Бид заахаасаа өмнө сургаалыг зөв ойлгосон гэдэгтээ итгэлтэй байхын тулд судруудыг болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг мөн хичээлийнхээ материалуудыг гүйцэд судлах хэрэгтэй”.

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд амьд бошиглогчдыг дагахын ач холбогдлыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Залуу эрэгтэй бүрд энэхүү тоймд санал болгосон судруудаас нэгийг оноон өгч, бидэнд бошиглогч хэрэгтэй байдгийн шалтгааныг мөн бошиглогчийг дагаснаар ирэх адислалуудыг хайхыг тэднээс хүс. Тэднийг өөрсдийн бодлыг хуваалцахад урь.
- Амьд бошиглогчийг гол гатлах хөтөчтэй адилтгасан ахлагч Баллардын хэлсэн үгийг хэсэгчлэн уншиж, гол гатлах хөтчийн бошиглогчтой адил зүйлүүдийг жагсаан бич. Бошиглогч, төлөөлөгчдийг дагах нь яагаад чухал болохыг бусдад заахдаа ашиглаж болох ижил төстэй зүйрлэлийн талаар бодож мөн хуваалцахад ангийн гишүүдийг урь.
- Кэрол Ф.Макконки эгчийн “Бошиглогчдын үгсийг дагаж амьдарцгаая” хэлсэн үгэн дэх дараах мэдэгдлийг ангийнхантай хуваалц: “Дэлхийн жишгээр бол, бошиглогчийг дагах нь нийтэд өргөн

дэлгэрээгүй бөгөөд улс төрийн хувьд буруу эсвэл нийгмээр хүлээн зөвшөөрөгдөөгүй зүйл юм. Гэвч бошиглогчийг дагах нь үргэлж зөв байдаг” (*Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 87–89). Бошиглогчийг дагадаггүй хүмүүс ямар шалтгаан хэлдэг вэ? Бошиглогчийг дагахыг нь болиулахыг хичээж буй хэн нэгэнд хандан хэлж болох зүйлсийг хайн, Макконки эгчийн хэлсэн үгийн үлдсэн хэсгийг судлахад ангийн гишүүдийг урь. Олж мэдсэн зүйлсээ хуваалцахыг тэднээс хүс.

- Чуулгын гишүүдийг өөр сүмд явдаг найз нь тэднээс “Та нарт яагаад бошиглогч байдаг вэ?” хэмээн асууж байна гэж төсөөлж

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Амьд бошиглогчдыг сонсон, тэднийг дагах нь яагаад чухал байдаг талаар тэд ойлгосон уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Амьд бошиглогчдын тухай болон тэднийг дагах тухай мэдэж авах боломжийн талаар юу бодож байгаагаар хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдээс бошиглогчийг дагасан тухайгаа мөн энэ нь тэдний амьдралд хэрхэн нөлөөлсөн талаар туршлагаасаа хуваалцахыг хүсэж болно.

бодоход урь. “Бошиглогч хүн ямархуу байдаг вэ?” эсвэл “Бошиглогч та нарт юу гэж хэлдэг вэ?” Залуу эрэгтэйчүүд юу гэж хариулах бол?

- Ахлагч Дэвид А.Бэднарийн “Миний нэрийг гэрчлэхээр сонгогдсон” эсвэл ахлагч Роналд А.Расбандын “Сүмийн удирдагчидтайгаа хамт зогсох нь” хэлсэн үгийг хамтдаа унш. Бошиглогчийг дагахын ач холбогдлын талаар сурч мэдсэн зүйлээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Ерөнхийлөгч Томас С.Монсоны хамгийн сүүлийн чуулган дээр хэлсэн үгсийн гарчгийг тэдэнтэй хамт харж, өнөө үеийн талаар бошиглогч бидэнд юу сэрэмжлүүлж байгааг ярилц.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг байсан хүмүүсээсээ асуудаг байсан бөгөөд асуулт тавих боломжийг тэдэнд олгодог байв. Та залуу эрэгтэйчүүдээс амьд бошиглогчдын тухай илүү сайн ойлгоход нь туслах юуг асууж болох вэ? Та тэдний хариултыг сонирхож байгаагаа хэрхэн харуулж болох вэ?

Сэдэвтэй холбоотой өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлээр сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь туслах Мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

Сонгосон материалууд

М.Рассэлл Баллард, “Завиндаа үлдэж, чанга зууран барь!” Ensign, 2014 оны 11-р сар, 89 эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 101-ээс эш татав

Саяхан манай найз Юта мужийн урд зүгт орших Колорадо голоос Катаракт хавцал руу хүүтэйгээ аялсан юм. Уг хавцал 23 км урттай бөгөөд ширүүн голын аюултай байж болох боргиогоороо алдартай.

Тэд адал явдалт аялалдаа бэлтгэж, Үндэсний дархан цаазат газрын үйлчилгээний вэбсайт дахь түгээмэл тохиолддог, нууцлаг аюул ослын талаар болон хувийн бэлэн байдлыг хэрхэн хангах талаар анхааралтай судалжээ.

Аялын эхэнд голын туршлагатай хөтчүүдийн нэг нь аюулгүй байдлын чухал заавруудыг тайлбарлахдаа голын боргио дундуур аюулгүй аялахад анхаарах гурван дүрмийг онцгойлон хэлж өгсөн юм. “Нэгдүгээр дүрэм: Завиндаа үлдэх! Хоёрдугаар дүрэм: Аврах хантаазыг үргэлж өмсөх! Гуравдугаар дүрэм: Хоёр гараараа

чанга зууран барих!” Мөн тэрээр “Хамгийн чухал нь нэгдүгээр дүрэм буюу завиндаа үлдэх гэдгийг санаарай” гэж дахин онцлон хэлэв.

Тэдний адал явдал надад мөнх бус аяллыг санагдуулдаг. Бидний ихэнх нь амьдралд тохиолдох тогтмол устай үеийг талархан өнгөрөөдөг. Гэхдээ зарим үед бидний амьдралд бие махбод, сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудлууд гарах, хайртай хүнээ алдах, мөрөөдөл, итгэл найдвар маань замхран одох, тэр байтугай зарим маань амьдралын асуудал, асуулт, эргэлзээ дунд итгэлээ алдах гэх мэт Катаракт хавцал руу 23 км үргэлжилсэн голын боргиотой зүйрлэмээр асуудлууд тохиолдох нь бий.

Их Эзэн амьдралын гол уруудан, зорьсон газраа хүрэхэд маань туслуулахын тулд завь, аврах хантааз мэтийн зайлшгүй хэрэгтэй зүйлсийг болон удирдамж, аюулгүй байдлын зааварчилгаа зэргийг нинжин сэтгэлээр өгдөг туршлагатай голын хөтчийг бидэнд өгсөн.



Би хэрхэн хувийн илчлэлтээ хүлээн авах вэ?

Бидний хүн нэг бүр нь өөрсдийн амьдралыг удирдах хувийн илчлэлт авах онцгой эрхтэй билээ. Хувийн илчлэлтээ хүлээн авахын тулд бид зөв зохистой амьдарч, судруудыг судлан, тунгаан бодож, бэлтгэх хэрэгтэй. Хэрэв бид эрэлхийлж мөн гуйвал Бурхан Өөрийн хүслийг Ариун сүнсээр дамжуулан илчлэх болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлдэж байхдаа эдгээр судар болон материалыг залбирч судлаарай. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Хаадын дээд 19:9–12; Хиламан 5:30; С ба Г 6:14–16, 23; 8:2–3; 11:12–14 (Ариун Сүнс бидэнтэй ярьдаг арга замууд)

Иохан 14:26–27 (Ариун Сүнс бидэнд бүх зүйлийг санахад мөн амар амгаланг мэдрэхэд тусалдаг)

Ифер 2–3; С ба Г 9:7–9 (Хувийн илчлэлт таныг тунгаан бодож мөн судалсны дараа ирдэг)

Хэнри Б.Айринг “Илчлэлт үргэлжлэн ирсээр байгаа,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 70–73

Ричард Г.Скотт “Хувийн амьдралдаа илчлэлт, сүнсний удирдамжийг хэрхэн авах вэ” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 45–47

Дэвид А.Бэднар “Илчлэлтийн Сүнс” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 87–90

“Сүнсний өдөөлтийг ялган танихад суралцахуй” *Миний Сайн Мэдээг Номло* (1999), 96–97

“Илчлэлт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 140–144

Та хувийн илчлэлт хүлээн авснаа хэрхэн мэддэг вэ? Хувийн илчлэлтээ таньж сурах нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?

Хувийн илчлэлтээ хэрхэн хүлээн авахаа ойлгох нь залуу эрэгтэйчүүдэд яагаад чухал вэ? Аароны санваартнуудад санваарын үүргээ биелүүлэхэд нь хувийн илчлэлт хэрхэн тусалж чадах вэ? Хувийн илчлэлтээ таньж сурахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ньномос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээл нь залуу эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Тэд суралцсан зүйлсээсээ ямар зүйлийг өөрөөр хийсэн бэ? Тэдний үйлдлүүдээс ямар адислалууд ирсэн бэ?
- Самбар дээр “_____ үедээ хувийн илчлэлт хүлээн авдаг гэдгийг би мэддэг.” Залуу эрэгтэйчүүдээс энэ өгүүлбэрийг хэрхэн гүйцээж болохыг асуу. Хичээлийн туршид тэднийг энэхүү өгүүлбэрийг тунгаан бодож, үүнд хариултаудыг нэмж олохыг урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь хувийн илчлэлтээ хэрхэн хүлээн авахыг ойлгоход нь чуулгын гишүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юмуу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Илчлэлт үргэлжлэн ирсээр байгаа” хэлсэн үгийн эхний гурван догол мөрийг хамтдаа унш. Тэдэнд эсвэл тэдний таньдаг хэн нэгэнд хувийн илчлэлт хэрэгтэй байгаа хэдэн нөхцлийг жагсаан бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Айрингийн хэлсэн үгээс уншиж эсвэл үзэж мөн сурсан зүйлсээ хуваалцахад урь. Хувийн илчлэлт эрэлхийлэхийн тулд юу хийж болохоо тунгаан бодоход тэднийг урь.
- Самбар дээр энэ тоймд санал болгосон судрын эшлэлүүдийг бич. Залуу эрэгтэй бүрд үүний нэгийг оноон өгч, Ариун Сүнс бидэнтэй хэрхэн харилцдаг талаар юу зааж байгааг тодорхойлохыг тэднээс хүс. Тэдний олсон зүйлүүдийг судрын эшлэл тус бүрийн хажууд залуу эрэгтэйчүүдээр самбар дээр бичүүл. Ариун Сүнс тэдэнтэй эдгээр арга замын нэгээр ярьсан туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд ер нь санваарын үүргээ биелүүлэхэд нь тэднийг удирдах хувийн илчлэлтийг эрэлхийлж эсвэл хүлээн авч байсан уу? Та бас өөрийн туршлагаасаа хуваалцаж болно.
- Залуу эрэгтэй бүрд *Миний Сайн Мэдээг Номло* гарын авлагын 96–97-р хуудсан дээрх хүснэгтийг хувилж өг. Залуу эрэгтэйчүүдийг

Заахад туслах арга

“Ангийнхны анхаарлыг татахаар хичээж буй багш сэтгэл хөдөлгөм түүх хичээлдээ ашиглахыг хүсдэг байж болох юм. Эх сурвалж нь тодорхойгүй, Сүм даяар дахин дахин яригддаг түүхүүд нэлээд хэд хэд байдаг. ... Тэдгээр нь заах хэрэгсэл биш бөгөөд тогтвортой байдал ба гэрчлэл нь сэтгэл хөдөлгөм түүхүүд дээр суурилдаггүй билээ.”.

хүснэгтийг болон Ариун Сүнсний бидэнтэй харилцдаг тодорхойлолтыг дүгнэн харахад урь. Хүснэгтэд тодорхойлсон мэдрэмж, бодол эсвэл сэтгэгдлийн аль нэг нь тохиолдож байсан үеийнхээ талаар бичихэд тэднийг урь. Цөөн хэдэн залуу эрэгтэйг бичсэн зүйлсээ чуулгын бусад гишүүнтэй хуваалцахад урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд хувийн илчлэлтээ хэрхэн авах талаар ойлгосон уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр дахин цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Эрэлхийлж, хүлээн авсан хувийн туршлагаасаа хуваалцаж болно.
- Хувийн илчлэлтээ эрэлхийлснээр санваарын үйлчлэлээ сайжруулж болох арга замуудыг хайхад чуулгын гишүүдийг урьж болно.

- *Миний Сайн Мэдээг Номло* номын 100–102-р хуудсан дээрх суралцах үйл ажиллагаануудаас нэгийг сонгож, уг үйл ажиллагааг тус тусдаа жижиг бүлэг болон эсвэл хоёр хоёроороо хуваагдаж хийхэд залуу эрэгтэйчүүдийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн дагалдагчдыг итгэлээр үйлдэж мөн Өөрийнх нь заасан үнэнүүдийн дагуу амьдрахад урьдаг. Тэрээр Өөрийн дагалдагчдыг суралцах хүчирхэг туршлагауудаар хангаж, бүхий л зүрх сэтгэлээрээ сайн мэдээг дагахад нь туслахад анхаардаг байсан. Та залуу эрэгтэйчүүдэд итгэлтэй байж мөн сурсан үнэнүүдийнхээ дагуу амьдрахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Сэдэвтэй холбоотой өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлээр сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь туслах Мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднарын “Илчлэлтийн сүнс” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2011 оны 5 –р сар, 87–90

Илчлэлтүүд нь зүүд, үзэгдэл, тэнгэрлэг элч нартай ярилцах, сүнслэг өдөөлт зэрэг олон арга замаар дамжин ирдэг. Зарим илчлэлтийг шууд, хүчтэй хүлээн авдаг бол зарим нь алгуураар ирдэг. Миний тайлбарласан гэрлийн тухай хоёр туршлага илчлэлтийн үндсэн хоёр хэв маягийг илүү сайн ойлгоход бидэнд тусална.

Харанхуй өрөөнд гэрэл асаах нь Бурханаас ямар нэгэн захиасыг тэр даруй, бүрэн дүүрнээр, нэг дор хүлээн авахтай адил юм. Бидний ихэнх нь илчлэлтийн энэ хэв маягийг чин сэтгэлийн залбирлын хариултаар эсвэл Бурханы хүссэн цагт Түүний тааллын дагуу бидэнд шаардлагатай удирдамж буюу хамгаалалтаар хангагдах зэргээр мэдэрсэн. Ийм шууд, хүчтэй илчлэлтийн дүрслэлүүдийг судруудад мөн Сүмийн түүхэнд өгүүлсэн байдаг бөгөөд бидний амьдралд ч тохиолдсон байдаг. Үнэхээр ийм хүчит гайхамшгууд тохиодог билээ. Гэхдээ илчлэлтийн энэ хэв маяг нь тийм ч нийтлэг тохиолддоггүй.

Мандах нарны алгуур нэмэгдэх туяа нь Бурханаас “шат шатаар, дүрэм дүрмээр” өгөгдөх захиастай адил юм (2 Нифай 28:30). Ихэнх тохиолдолд илчлэлт нь бага багаар бидний хүсэл, зохистой байдал, бэлтгэлийн дагуу ирдэг. Тэнгэрлэг Эцэгээс ирэх ийм харишцаа нь эцэстээ “тэнгэрээс буух шүүдэр лугаа адил [бидний сүнсэн дээр]

намуухан буух болно (С ба Г 121:45). Илчлэлтийн энэ арга зам нь нийтлэг тохиолддоггүй бөгөөд Нифай Лебенээс гуулин ялтсуудыг амжилттай авахаас өмнө хэдэн хэдэн удаа оролдлого хийдэг (1 Нифай 3–4 -г үзнэ үү). Хамгийн сүүлд нь “хийвэл зохих зүйлүүдийг [тэр] урьдаас мэдэхгүй” (1 Нифай 4:6) байсан ч Сүнсээр Иерусалим руу хөтлөгдсөн (1 Нифай 4:6). Нифай уран хийцтэй усан онгоц хэрхэн барихыг шууд нэг дор сураагүй ч Их Эзэн “усан онгоцны дүнз модыг ямар маягаар бэлтгэхийг цагаас цагт [түүнд] үзүүлж байсан бөлгөө” (1 Нифай 18:1).

Сүмийн түүх болон бидний хувийн амьдралд “шат шатаар, дүрэм дүрмээр” илчлэлт хүлээн авах Их Эзэний энэхүү хэв маягийн жишээнүүд олон байдаг. Жишээлбэл, Бошиглогч Иосеф Смитэд сэргээгдсэн сайн мэдээний гол үнэнүүд ойн цоорхойд шууд нэг дор бүгд өгөгдөөгүй. Эдгээр үнэ цэнэтэй эрдэнэсүүд зөв цагт, нөхцөл байдал зохистой үед илчлэгдэж байсан. . . .

Сүмийн гишүүд бид гайхамшигтай, үр нөлөөтэй сүнслэг илэрхийлэлтийг онцгой чухалчлан, талархахаа мартаж, Ариун Сүнсээр гүйцэлдүүлэх түүний ажлын ердийн хэв маягийг анхааралгүй өнгөрөх хандлагатай байдаг. Хэсэг хугацааны дараа, эцэст нь хүссэн хариулт эсвэл бидэнд хэрэгтэй удирдамжийг бүрдүүлэн батлах, жижиг бөгөөд өсөн нэмэгдэх сүнслэг мэдрэмжийг хамгийн “энгийн байдал”-аар (1 Нифай 17:41) хүлээн авах нь биднийг “зорилгоос алсуур хайх” (Иаков 4:14) байдалд хүргэдэг.



Би залбирлаа хэрхэн илүү утга учиртай болгох вэ?

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд биднийг Өөртэйгээ залбирлаар дамжуулан харьцаж байгаасай хэмээн хүсдэг. Бид залбирах үедээ зүрх сэтгэлдээ юу мэдэрч байгаагаа Тэнгэрлэг Эцэгт хэлэх хэрэгтэй. Бид учир утгагүй үг, хэллэгийг давтаж хэлэх хэрэггүй. Чин сэтгэлийн залбирлаар дамжуулан бид Тэнгэрлэг Эцэгт ойр байгаагаа мэдрэх болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлтгэх үедээ эдгээр материалыг залбирч судал. Залуу эрэгтэйчүүдийг залбирлын талаар юуг олж мэдээсэй хэмээн та хүсч байна вэ?

Лук 22:41–42; Хиламан 10:5; С ба Г 46:30–31 (Залбирах үедээ бид Бурханы хүслийг эрэлхийлэх хэрэгтэй)

Хэнри Б.Айринг, “Санваар ба хувийн залбирал,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 70–73

3 Нифай 14:7; С ба Г 9:7–8 (Залбирал нь итгэл, хүчин чармайлттай хавсрах ёстой)

Дэвид А. Бэднар, “Итгэлээр асуу” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2008 оны 5-р сар, 94–97

3 Нифай 17–19 (Есүс Христ нифайчуудтай хамт залбирч, залбирлын талаар заасан)

Дэвид А. Бэднар “Үргэлж залбир,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 41–44

Моронай 10:3–5 (Итгэл, чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр залбир)

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 38

Библийн лавлах “Залбирал,” 752–53

“Залбирал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 101–106

Танд залбирлын талаар ямар нэг онцгой туршлага байгаа юу? Эдгээр туршлага нь Тэнгэрлэг Эцэгтэй харилцах талаар танд юу заасан бэ? Та залбирлаа илүү утга учиртай болгохын тулд юу хийсэн бэ?

Танай чуулгын залуу эрэгтэйчүүд залбирч байхыг та хэзээ сонссон бэ? Тэднийг залбирлаа илүү утга учиртай болгоход та хэрхэн тусалж чадах вэ? Тэнгэрлэг Эцэгтэй хэрхэн харьцахаа ойлгох нь тэдэнд одоо ба ирээдүйд хэрхэн туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлээ төлөөлүүлэх зураг зурж, зургуудаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Сурснаа хэрэгжүүлэх юуг тэд хийсэн бэ? Тэдэнд сурсан зүйлийнхээ талаар асуулт эсвэл нэмэлт санаанууд байна уу?
- Залуу эрэгтэйчүүдээс бид бусдадтай харьцдаг арга замуудыг жагсаан бичихийг хүс. Эдгээр харилцааны аргууд нь бидний Тэнгэрлэг Эцэгтэй харьцах харилцаатай юугаараа төстэй вэ? Тэдгээрийн ялгаа юу вэ? Залуу эрэгтэйчүүдэд залбирлын талаар ямар асуултууд байна вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд залбирлаа хэрхэн илүү утга учиртай болгохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Та ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Санваар ба хувийн залбирал” хэлсэн үгнээс чуулгынхаа залуу эрэгтэйчүүдэд хамгийн чухал гэж бодож байгаа түүхийг эсвэл богино эшлэлүүдийг сонгоно уу. Эдгээр түүхээ эсвэл эшлэлээ жижиг жижиг цаасан дээр бичнэ үү. Залуу эрэгтэйчүүдийг эдгээр цааснаас нэгийг сонгож, чуулгынхандаа уншиж өгөхийг хүс мөн энэ нь юуны тухай зааж байгаа талаар хэлэлцүүлэг удирдан явуул. Залбирал тэдний санваарын үйлчлэлд хэрхэн тусалж чадах вэ? Залбирлаар дамжуулан санваарын үйлчлэл тань адислагдаж байсан туршлагаа хуваалцах талаар бодож үзээрэй. Эсвэл залуу эрэгтэйчүүдийг үүнтэй төстэй туршлагуудаа хуваалцахад урь.
- Сүнслэг нөлөө бүхий залбирлын жишээг судруудаас олоход (хэрэв шаардлагатай бол энэхүү суралцах тоймд зөвлөмж болгосон судруудыг тэднээр уншуул). Олж мэдсэн зүйлээ болон залбирлын талаар энэ жишээнээс сурсан зүйлээ хуваалцахыг тэднээс хүс.
- Залбирлын талаарх судар уншихад залуу эрэгтэйчүүдийг урь (энэхүү тоймд санал болгосон судруудаас). Залбирлын талаарх судраас мөн өөрсдийн болон бусдын амьдралаас сурсан зарчмын жишээг бич. Чуулгын өөр нэг гишүүнтэй бичсэн зүйлээ хуваалц. Өөрсдийн залбирлыг илүү утга учиртай болгоход туслах юуг залуу эрэгтэйчүүд бие биенээсээ суралцсан бэ?

Заахад туслах арга

“Хэн нэг нь асуултад хариулж, санаа бодлоо хуваалцсаны дараа бусдад нь нэмж хэлэх зүйл байвал хэлэхийг эсвэл өөр бодол санаатай бол хуваалцахыг хүсээрэй. Хэн нэгэн асуулт асуух үед өөрөө хариулахын оронд бусдаас асуугаарай. Жишээ нь: Та “Энэ асуултад хариулах хүн байна уу?” гэж асууж болох юм.”

- Чуулгын залуу эрэгтэй бүрд ахлагч Дэвид А. Бэднанийн хэлсэн үгээс энэхүү тоймд санал болгосон нэг хэсгийг өг. Бидний залбирлыг илүү утга учиртай болгоход туслах, ахлагч Бэднанийн өгсөн зөвлөгөөний доогуур зурахад тэднийг урь. Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэднийг хэн нэгэнд залбирахыг зааж байна хэмээн төсөөлөхөд урь. Тэд юуг мөн хэрхэн заах байсан бэ? Зааж байгаа байдлаар дүрд тоглох аргыг ашиглаж болно.
- Залуу эрэгтэй бүрийг *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлын 101–102-р

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд залбирлаа хэрхэн илүү утга учиртай болгохыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Тогтмол залбирах дадал хэвшил тогтоох төлөвлөгөөгөө хуваалцаж болно.
- Залбирлын хүчийг заасан хувийн туршлагаасаа хуваалцаж болно.

хуудасны залбирлын зарчмуудаас нэгийг эсвэл Библийн лавлах дээрх залбирлын талаарх тэмдэглэгээг судлахыг хүс. Тэднийг юу сурснаа чуулгадаа заахад урь. Заах үедээ тэднийг өөрсдийн жишээнээс хуваалцахад урамшуул.

- Чуулгаараа 38-р хуудасны сурах үйл ажиллагааг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номоос хий. Чуулгын цуглаан дээр залуу эрэгтэйчүүдэд тогтмол залбирдаг хэвшилтэй болох төлөвлөгөө бичих эсвэл боловсруулах хугацаа өг (15, 39 эсвэл 63-ыг үзнэ үү).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ хайрлаж, тэдний төлөө залбирдаг байсан. Бид заадаг хүмүүсээ таньж мэдэн, хайрлах үедээ хүн бүрийн нэрийг хэлэн, тэдний төлөө болон тэдэнд тулгарч байгаа сорилтуудыг даван туулахын төлөө мөн боломжуудын төлөө залбирдаг.

Сонгосон материалууд

Ахлагч Дэвид А.Бэднарын “Үргэлж залбир” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2008 оны 11 –р сар, 41–44

Энгийнээр тодорхойлбол: залбирал бол дэлхий дээрх Түүний хөвгүүд, охид Тэнгэрлэг Эцэг-тэйгээ харилцах харилцаа юм. “Бурхан бидний хувьд хэн болохыг ойлгосон дарууд (тухайлбал, Бурхан бол бидний Эцэг, бид бол түүний хүүхдүүд мөн), залбирал маань бидний зүрхний угаас гарч эхэлдэг” (Bible Dictionary, “Prayer,” 752).

Эцэгт хандан Хүүгийн нэрээр үргэлж залбирч байхыг бидэнд зарлиг болгосон билээ (3 Нифай 18:19–20-ийг үзнэ үү). Бид зөв, сайн зүйлийн төлөө, Бурханы таалалд нийцүүлэн чин сэтгэлээсээ залбирвал, адислагдаж, хамгаалагдан, удирдагдах болно гэсэн амлалтыг өгсөн билээ (3 Нифай 18:20; С ба Г 19:38 –г үзнэ үү). . . .

Өглөөний залбиралд бидэнд өөрсдийнхөө зан төлөв, биеэ авч яваа байдал болон сүнслэг өсөлтийн талаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ зөвлөх шаардлагатай зүйлс байж болох юм. Бид хүлээн авсан адислалуудынхаа төлөө зохих ёсоор талархал илэрхийлсний дараа өөрсдийнхөө хүчээр хийж чадахгүй байгаа зүйлсийг хийхэд ухаарал, чиглэл, тусламж гуйдаг. Жишээ нь, бид залбирахдаа дараах зүйлсийг хийж болно:

- Хамгийн хайртай хүмүүстээ хатуу буюу эелдэг бус, эвгүй үг хэлсэн тохиолдлуудаа эргэцүүлэн бод.
- Хийх ёстой гэж мэддэгийнхээ дагуу үйлддэггүй гэдгээ хүлээн зөвшөөр.
- Эгэл хүнээ орхихыг чин сэтгэлээсээ хичээхгүй байгаадаа мөн сул талынхаа төлөө гэмшин харамс.
- Амьдралынхаа хэв маягийг Аврагчтай илүү бүрэн дүүрэн нийцүүлэхээр шийд.

- Улам сайн ажиллаж, улам сайн хүн болохын төлөө хүч чадлыг гуй.

Ийм залбирал нь бидний өдөр тутмын сүнслэг бэлтгэлийн гол хэсэг юм.

Тусламж, удирдамж байнга авч байхын төлөө, “Бүх бодол санаа чинь Их Эзэнд чиглэсэн байг” (Алма 37:36) хэмээн Алмагийн зөвлөсөн шиг—бид залбирлаа өдрийн турш зүрх сэтгэлдээ тээж явдаг билээ.

Хатуу үг хэлчихмээр байсан ч, хэлээ хазаад өнгөрсөн, уурлаж уцаарламаар санагдсан ч биеэ бариад өнгөрсөн тийм өдрүүд бидэнд байдаг. Бид тэнгэрлэг тусламж, хүч чадлыг ойлгож, залбирлынхаа хариуг даруухнаар танин мэддэг. Бид ойлголт ухаарлын энэхүү агшинд талархлын залбирлыг чимээгүй өргөдөг билээ.

Орой болоход бид дахин өвдөг сөгдөн, Эцэгтээ эргэн тайлагнадаг. Бид тухайн өдөр болж өнгөрсөн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэж, хүлээн авсан адислалууд болон тусламжийн төлөө зүрх сэтгэлийн талархлаа илэрхийлдэг. Бид наманчилж мөн Их Эзэний Сүнсний тусламжтайгаар маргааш нь илүү сайнаар үйлдэх арга замуудыг мэддэг. Тийнхүү бидний оройн залбирал нь өглөөний залбирал дээр тулгуурлагдан, үргэлжлэл нь болдог юм. Үүний хамт бидний оройн залбирал маргааш өглөөний залбирлын утга учиртай бэлтгэл болдог билээ.

Өглөө, оройн залбирал тэрчлэн эдгээрийн хоорондох бүх залбирал нь хоорондоо холбоогүй, салангид тусдаа үйл явдлууд биш, харин тухайн өдрийн турш, тэр ч байтугай, олон жилийн турш хоорондоо нягт холбоотой байдаг. Энэ бол “үргэлж залбир” (Лук 21:36; 3 Нифай 18:15, 18; С ба Г 31:12) гэсэн судруудын зөвлөгөөг бид хэрхэн биелүүлдгийн жишээ мөн. Ийм утга учиртай залбирлууд нь Бурхан өөрийн итгэлтэй хүүхдүүдэд зориулан нөөцлөн хадгалсан хамгийн дээд адислалуудыг хүртэх зэмсэг юм.



Би гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?

Гэрчлэл бол Ариун Сүнсээр өгөгддөг, үнэний сүнслэг гэрч юм. Сүмийн гишүүний хувьд бид өөрсдийн гэсэн гэрчлэлтэй болох ариун нандин боломж, үүрэг хариуцлагатай байдаг. Хэрэв бид судалж, залбирч, сайн мэдээний дагуу амьдарснаар гэрчлэлтэй болохыг эрэлхийлвэл Ариун сүнс бидэнд сайн мэдээ бол үнэн юм гэдгийг мэдэхэд тусална.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Залуу эрэгтэйчүүдийг гэрчлэлтэй болоход юу сүнслэгээр урамшуулна гэж та үзэж байна вэ?

Иохан 7:16–17 (Хэрэв бид Их Эзэний хүслийг биелүүлбэл гэрчлэлтэй болно)

1 Коринт 2:9–13; Алма 5:45–46; С ба Г 8:2–3 (Ариун сүнс үнэнийг гэрчилдэг)

Иаков 1:5; 1 Нифай 10:17–19; 15:11; 3 Нифай 18:20; Моронай 10:3–5 (Гэрчлэл олж авахын тулд бид асууж мөн эрэлхийлэх ёстой)

Мозая 26:3; Алма 12:11 (Гэрчлэлтэй болоход тулгарах бэрхшээлүүд)

С ба Г 9:7–9 (Бид асуухаасаа өмнө өөрсдөө суралцах ёстой)

Дийтр Ф.Угдорф, “Гэрэл ба үнэний талаар гэрчлэл хүлээн авах нь” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 20–23

Жэффри Р.Холланд “Их Эзэн, би итгэнэ” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 5-р сар

Квинтин Л.Күк “Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 11-р сар, 6–9

Крэг К.Кристэнсэн, “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 50–52

“Гэрчлэл” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 178–180

Та хэрхэн гэрчлэлтэй болсон бэ? Нөхөр, эцэг, санваартан мөн Христийн дагалдагчийн хувьд таны гэрчлэл таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

Чуулгад тань байгаа залуу эрэгтэйчүүдийн гэрчлэлүүдийн талаар та юу мэдэх вэ? Хүчирхэг гэрчлэлтэй байх нь одоо болон ирээдүйд тэдний амьдралд хэрхэн нөлөөлөх вэ? Та гэрчлэлүүдээ хүчирхэгжүүлэхэд нь чуулгын гишүүдээ хэрхэн урамшуулан дэмжиж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг давтаж, энэ долоо хоногийн хичээлийг танилцуулахын тулд эдгээр санаанаас сонгож эсвэл өөрийн санааг ашиглаарай:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй холбоотой зарчмыг хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Та ярилцлагыг эхлүүлэхийн тулд өөрт тохиолдсон туршлагаадаас нэгийг хуваалцаж болох юм.
- Чуулгаараа ахлагч Крэг К.Кристэнсэний гэрчлэл болон улаан модыг харьцуулсан “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ” хэлсэн үгийг унш. Хэрэв боломжтой бол, улаан модны зураг авч ирж, энэ мод хэдхэн миллиметрийн урттай үрнээс ургадгийг тайлбарла. Энэ харьцуулалт нь гэрчлэлээ хүчирхэгжүүлэх талаар юу зааж байгааг хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь өөрсдийн гэрчлэлээ хэрхэн олж авах талаар суралцахад нь чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Чуулгын нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэр үүнийг Бурханы өмнө хүлээсэн үүрэг төлөвлөгөөн дэх залбирал болон хувийн илчлэлтийн тухай сурч, заахын нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлгох нь,” 18, 42 эсвэл 66-р хуудас).
- Залуу эрэгтэйчүүдийн заримыг 1 Нифай 10:17–19-ийг уншиж, үлдсэн хэсгийг нь Алма 5:45–47-г уншихад урь. Өөрсдийн гэрчлэлээ олж авахын тулд Нифай болон Алма юу хийсэн бэ? Залуу эрэгтэйчүүд эдгээр жишээнээс өөр юу сурч чадах вэ? Тэд өөр ямар жишээнүүдийг судруудаас олж чадах вэ?

Заахад туслах арга

Ихэнх тохиолдолд таны заах зүйлс хичээлийн цагт багтаааргүй их байдаг. Ийм тохиолдолд та заах хүмүүстээ хамгийн тустай материалуудыг сонгох хэрэгтэй болдог (*Teaching, No Greater Call* [1999], 98).

Гэрчлэлүүдийг хүчирхэгжүүлсэн туршлагаадаа хуваалцахад тэднийг урь. Тэд эдгээртэй адил илүү их туршлагаудыг эрэлхийлэхийн тулд юу хийж чадах вэ?

- Залуу эрэгтэй бүрд ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Гэрэл ба үнэний гэрчийг хүлээн авах нь” хэлсэн үгийн гол хэсгүүдийн нэгийг судлахыг даалга. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф гэрчлэлтэй болох талаар юу зааж байгааг хайхад залуу эрэгтэйчүүдийг урьж мөн олсон зүйлээ хуваалцахыг хүс. Самбар дээр “Гэрчлэлтэй болох нь _____-тай адил” гэж бич. Хэдэн залуу эрэгтэйг самбар дээр гарч, энэ өгүүлбэрийг хэрхэн гүйцээснээ хуваалцахад урь.
- Залуу эрэгтэй бүрийг гэрчлэлээ олж авч мөн хүчирхэгжүүлдэг арга

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд хэрхэн гэрчлэлтэй болох талаар ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр дахин цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Удирдаж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлүүлнэ. Тэрээр:

- Хүн бүр сайн мэдээний тухай өөрийн гэсэн гэрчлэлтэй болохын ач холбогдлын талаар гэрчлэлээ хуваалцаж болно.
- Чуулгын бусад гишүүнийг гэрчлэлээ хуваалцахад урьж болно.
- Чуулгын гишүүдийг гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд хийж чадах зүйлийнхээ талаар бодоход урьж болно.

замуудыг эсвэл биднийг гэрчлэлтэй болоход саад болдог зүйлүүдийг олохын тулд энэ тоймд байгаа судруудын нэгийг уншихад урь. Тэднийг санаа бодлоо хуваалцсаны дараа гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд нь чуулгын бусад гишүүнд тусалж чадах арга замуудын талаар бодохыг тэднээс хүс. Тэд гэр бүлийнхэндээ болон сургуулийнхаа найзуудад хэрхэн тусалж чадах вэ?

- Ахлагч Квинтин Л.Күкийн “Танар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” хэлсэн үгийн 9, 10-р догол мөрийг уншихдаа гэрчлэлийг сулруулж болох зүйлс мөн гэрчлэлийг хүчирхэгжүүлэх арга замуудыг жагсаан бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс. Тэдний жагсаалтаас аль нэгийг нь харуулах туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагчдаа үнэнийг гэрчилдэг байхад урьдаг байсан бөгөөд тэднийг гэрчлэхэд Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрсэн юм. Чуулгынхаа залуу эрэгтэйчүүд болон тэдний амьдралын туршлагаудын талаар бодож үз. Заасныхаа дараа залуу эрэгтэйчүүдэд сайн мэдээний үнэнүүдийн талаар албан ба албан бус аль ч нөхцөлд гэрчлэлүүдийг нь хуваалцуулах боломжуудыг эрж хай.

Сэдэвтэй холбоотой өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлээр сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь туслах Мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

Сонгосон материалууд

Крэг К.Кристэнсэн, “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ,” *Ensign*, 2014 оны 11-р сар, 51–52 эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 61-ээс эш татав

Зарим хүн унтраалга гэрлийг асаадаг эсвэл унтраадаг гэдэгтэй гэрчлэлийг адилтгаж, танд гэрчлэл байдаг, аль эсвэл огт байдаггүй гэж боддог. Амьдрал дээр гэрчлэл нь өсөлт хөгжлийн олон үе шатыг дамжин ургадаг модтой илүү адилхан. Дэлхий дээрх хамгийн өндөр моддын зарим нь Нэгдсэн Улсын баруун талд орших Улаан модны үндэсний хүрээлэнд байдаг. Та эдгээр аварга модны ёроолд зогсоод, мод тус бүр өчүүхэн жижиг үрээс ургасан гэж бодвол үнэхээр гайхалтай санагдана. Бидний гэрчлэл ч бас үүнтэй адил юм. Бидний гэрчлэл цорын ганц сүнслэг туршлагаас эхэлж болох ч тасралтгүй арчлан тордсоны үр дүнд болон олон сүнслэг үйл явдал тохиолдсоны үр дүнд цаг хугацаа өнгөрөх тусам улам бүр өсөж хөгждөг билээ.

Иймээс бошиглогч Алма гэрчлэлээ хэрхэн хөгжүүлдэг тухай тайлбарлахдаа мод болглоо өсөж, томрон ургадаг үрийн тухай ярьсанд гайхах хэрэггүй. Тэрээр “Хэрэв та нар зүрх сэтгэлд тань үр суулгагдаж болохын тулд зай тавьж өгвөөс, болгоогтун, хэрэв энэ нь үнэн үр, эсвээс энэ нь сайн үр аваас, . . . хэрэв та нар итгэлгүй байдлаараа . . . үүнийг зайлуулахгүй аваас, . . . энэ нь та нарын цээжинд өсөж эхлэх болно; мөн та нар эдгээр өсөлтийг мэдрээд та нар өөрсдөдөө—Энэ нь сайн үр, өөрөөр хэлбэл үг нь сайн байх ёстой, учир нь энэ нь бодгалийг минь тэлж эхлэв; тийм ээ, энэ нь

ойлголтыг минь гэгээрүүлж эхлэв хэмээн хэлж эхлэх болно” [Алма 32:28] гэж хэлсэн байдаг.

Гэрчлэл нь Бурханы үг үнэн болохыг бидэнд харуулдаг ариун нандин гэгээрлээр болон итгэл үнэмшлийг өгөгч мэдрэмжүүдээр ихэвчлэн эхэлдэг. Эдгээр мэдрэмж хэчнээн сайхан байлаа ч гэсэн, энэ бол дөнгөж эхлэл юм. Газраас анхны бяцхан нахиа соёолон гарч ирэх тэр үеэс эхлэн улаан мод ургаж эхэлдэг шиг, гэрчлэлээ өсгөн хөгжүүлэх таны ажил дуусаагүй байна. Хэрэв бид анхны энэ сүнслэг өдөөлтүүдийг үл тоомсорлон, судруудыг байнга судлах, залбирах зэргээр тэдгээрийг арчлан тордож, сүнслэг туршлагыг илүү шаргуу эрэлхийлэхгүй л бол бидний мэдрэмж сарнин бүдгэрч, гэрчлэл маань алга болно.

Алма үүнийг: “Хэрэв та нар уг модонд хайнга хандаж, мөн үүний арчилгааны талаар эс бодвоос болгоогтун энэ нь үндэслэхгүй байх болно; мөн нарны илч тусаж, мөн түүнийг шарж төөнөхөд үндэсгүйн учир хатан хувхайрч, мөн та нар үүнийг сугалж, тэгээд үүнийг хаях болно” [Алма 32:38] хэмээн дүрсэлжээ.

Ихэнх тохиолдолд бидний гэрчлэл мод хэрхэн ургадаг шиг, байнгын бөгөөд шаргуу хүчин чармайлтын үр дүнд аажим аажмаар, бидэнд бараг мэдэгдэхгүйгээр өсөж хөгждөг. Алма “Тэвч хэрэв та нар үгийг арчилбал, тийм ээ, үүнийг ургаж эхлэхэд модыг арчилж, өөрийн агуу шаргуу итгэл хийгээд тэвчээрээр үүнийг хүсэн хүлээх аваас, энэ нь үндэслэх болно; мөн болгоогтун энэ нь үүрдийн амьдралд хүргэх мод байх болно” [Алма 32:41] гэж амласан билээ.



Ерөнхийлөгч Монсон Аароны санваартнуудад юу заасан бэ?

Санваартнуудын хувьд бидний тангараг ба гэрээний нэг хэсэг бол амьд бошиглогчид зэрэг Их Эзэний үйлчлэгчдийг хүлээн авах мөн Их Эзэний амнаас гарч буй үг бүрийн дагуу амьдрах явдал юм (С ба Г 84:36, 44-ийг үзнэ үү). Ерөнхийлөгч Монсон Аароны санваартнууд нь үүргээ биелүүлэх хүсэлтэй мөн зохистой байх ёстой гэж заасан. Тэрээр биднийг зөв шударга зарчмын төлөө зогсох шаардлагатай үед ганцаараа ч гэсэн зогсохыг урамшуулсан. Тэрээр биднээс эргэн тойрныхоо хүмүүсийг адислах мөн тэдэнд үйлчлэхийн тулд санваараа хэрхэн ашиглахаа ойлгодог байгаасай хэмээн хүсдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ерөнхийлөгч Монсоны санваартнуудад хандан саяхан хэлсэн үгсийг залбирч судал. Үүнд:

“Ариун итгэмжлэл,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 68.

“Тэрийнхээ зүг аюулгүй удирдагдах нь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 11-р сар, 67–69

“Санваар бол ариун нандин бэлэг,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 74–76

“Хүчтэй бөгөөд зоригтой бай,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Зарлигуудыг сахь,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 69–71

Та нар ерөнхийлөгч Монсоноос санваарын үйлчлэлийн талаар юу сурсан бэ? Түүний сургаал, үлгэр жишээг та нар хэрхэн хэрэгжүүлсэн бэ?

Ерөнхийлөгч Монсон саяхны чуулганаар санваартнуудын хувьд залуу эрэгтэйчүүдэд хандан юу гэж хэлснийг чуулгын тань залуу эрэгтэйчүүд мэдэж байгаа юу? Ерөнхийлөгч Монсоны захиасууд залуу эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг ойлгоход тэдэнд туслахын тулд та юу хийж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Залуу эрэгтэйчүүдийг хоёр хоёроор нь хуваарил. Тэднээс өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж буй зүйлээ бие биетэйгээ хуваалцахыг хүс.
- Чуулгаараа “Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлэх нь” номын “Санваарын үүргүүд” хэсгийг дахин уншаад, самбар дээр үүргүүдээ бич (23, 46–47 эсвэл 70–71-р хуудсуудыг үзнэ үү). Ерөнхийлөгч Монсон эдгээр үүргийн талаар юу заасан бэ? Энэхүү хичээлийн үеэр, залуу эрэгтэйчүүдээр тэдний санваарын үүргүүдийн талаар ерөнхийлөгч Монсоны заасан зүйлээс сурсан зүйлийг нь самбар дээр нэмж бичүүл.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд чуулгын гишүүдийг ерөнхийлөгч Томас С.Монсоны санваартнуудад хандан хэлсэн саяхны захиасуудыг судлахад туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Залуу эрэгтэй бүрд ерөнхийлөгч Монсоны санваартнуудад хандан хэлсэн үгсээс нэгийг хувиран өг (энэхүү тоймд санал болгосон хэлсэн үгсийг үзнэ үү). Хэлсэн үгэнд яригдсан нэг түүхийг олоод, үүнийгээ чуулгын гишүүддээ өөрийн үгээр ярихад мөн санваарын үйлчлэлийн талаар юу зааж байгааг хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.
- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Монсоны саяхны хэлсэн үгсээс нэгийг сонгон уншаад, санаж явахыг хүссэн хэсгийг хайхад урь. Залуу эрэгтэй бүрд нэг жижиг карт өгөөд, үүн дээр тэрхүү хэсгийг нь бичүүл. Чуулгын гишүүдийг бичсэн хэсгээ хуваалцан, яагаад үүнийг сонгосноо тайлбарлахыг хүс.
- Санваарын үйлчлэлийн талаар ерөнхийлөгч Монсоны ашигладаг судруудыг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Эдгээр судраас сурсан зүйлээ бие биетэйгээ хуваалцахад тэднийг урь. Санваарын тухай заадаг бусад судрыг олохын тулд хуудасны зүүлт тайлбарыг ашиглахад

Заахад туслах зөвлөмж

“Тодорхой нэг хичээл дээр ярьж болох бүх зүйлийг заахаас зайлсхий.

Таны зааж буй хүмүүс үүний талаар тодорхой ойлголтыг аль хэдийн авсан байж болно. Таны хичээл тэдний тухайн хичээлийн талаар суралцах ганц цаг хугацаа биш юм гэдгийг санаарай.”

тэднийг урамшуул. Тэд хэрхэн олж мэдсэн зүйлээ санваарын үүргээ биелүүлэхдээ хэрэгжүүлэх вэ?

- Чуулгын гишүүдийн тал хувийг нь ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгсээс нэгийг сонгон санваартнуудаар хийлгэхийг хүссэн зүйлсийг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэдэнд өгсөн ерөнхийлөгч Монсоны захиасуудын талаар тэд сурч мэдсэн үү? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү хугацаа зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ерөнхийлөгч Монсоны тухай бодлоо хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдийг сурсан зүйлийнхээ талаар сэтгэгдлээ хуваалцахад урьж болно.
- Чуулгын гишүүдийг өнөөдөр сурсан зүйл дээрээ үндэслэн *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын “Санваарын үүргүүд” хэсэг дээрх төлөвлөгөөг хийхэд эсвэл сайжруулахад урьж болно.

олоход урь. Нөгөө хэсэг гишүүдээс түүний амласан адислалуудыг энэхүү хэлсэн үгнээс олохыг хүс. Сурсан зүйлээ хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс. Тэд түүний зөвлөгөөг санваарын үүргээ биелүүлэхдээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Бүхий л нөхцөлд Аврагч бидний жишээ мөн багш байсан юм. Тэрээр тэдэнтэй хамт залбирснаар залбирахыг заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шигээ бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэр заасан. Тэрээр Өөрийн зааж байгаа аргаар сайн мэдээгээ заахыг тэдэнд заасан. Та санваартны хувьд чуулгын залуу эрэгтэйчүүддээ хэрхэн үлгэр жишээ үзүүлэгч бөгөөд зөвлөгч нь байж чадах вэ?

Сэдэвтэй холбоотой өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлээр сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь туслах Мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

Сонгосон материалууд

Томас С.Монсон, “Хүчтэй бөгөөд зоригтой бай,”
Ensign, 2014 оны 5-р сар, 67 эсвэл 2014 оны 4-р
сарын Ерөнхий чуулган, 87

Би Дэлхийн II-р дайнд Нэгдсэн Улсын тэнгисийн цэрэгт алба хааж байхдаа эрэлхэг гавьяа, баатарлаг явдал, эр зоригийн үлгэр жишээнүүдийг харж байсан. Хэзээ ч мартагдамгүй нэгэн тохиолдол бол манай Сүмийн гишүүн биш, залбирахдаа санаа зовдоггүй, 18 настай нэгэн цэргийн энгийн зориг юм. Заримдаа танхай этгээдүүд тохуурхаж, үл итгэгчид шоолдог байсан ч хорооны 250 эрэгтэйгээс орой бүр орныхоо дэргэд өвдөг сөгддөг ганц хүн бол тэр цэрэг байсан. Тэрээр толгойгоо бөхийлгөн, Бурханд хандан залбирдаг байв. Тэр үүнд хэзээ ч эргэлзэж байгаагүй юм. Тэр хэзээ ч шантарч байгаагүй. Тэр зоригтой байсан.

Саяхан би энэхүү дотоод зоригоор дутсан нэг хүний тухай сонслоо. Нэг найз маань нөхөртэйгөө хамт тойрогтоо сүнслэг бөгөөд итгэл өсгөхүйц ариун ёслолын цуглаанд оролцсон тухайгаа надад хэлсэн юм. Аароны санваарын пристийн албанд томилогдсон нэгэн залуу эрэгтэй сайн мэдээний үнэнүүдийг болон зарлигуудыг сахих үед ирдэг баяр баясгалангийн талаар үг хэлсэн нь танхимд сууж байсан хүн бүрийн зүрхэнд хүрчээ. Тэрээр индэр дээр зогсож байхдаа хүчтэй, сэтгэл хөдлөм гэрчлэл хуваалцсан бөгөөд цагаан цамц, зангиатай, нямбай, цэвэрхэн харагдаж байжээ.

Тэр өдрийнхөө орой уг эмэгтэй нөхөртэйгөө хамт гадуур явж байгаад хэдхэн цагийн өмнө өөрсдийг нь сүнслэгээр урамшуулсан нөгөө залуу эрэгтэйг олж харсан байна. Гэвч энэ удаад тэрээр явган хүний зам дээр зохисгүй хувцаслачихсан, тамхи татаад явж байв. Миний найз, түүний нөхөр хоёрын урам маш их хугарч, гунигтай болсноор барахгүй, түүнийг ариун ёслолын

цуглаан дээр байснаасаа яаж ийм хурдан тэс өөр хүн болж чадсан юм бол гэж эргэлзэн гайхжээ.

Томас С.Монсон, “Гэрийнхээ зүг аюулгүй удирдагдах нь,” Ensign, 2014 оны 11-р сар, 68 эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 76

Санваартнуудын хувьд бид хэцүү цаг үед дэлхийд ирсэн юм. Бид хаа сайгүй зөрчилдөөн болж буй ээдрээтэй дэлхийд амьдарч байна. Улс төрийн далд явуулга улс үндэстнүүдийн тогтвортой байдлыг үгүй хийж, дарангуйлагчид эрх мэдлийг гартаа авч, нийгмийн зарим хэсэг нь байнга дарлагдаж, боломжуудаа алдаж, бүтэлгүйтлийн мэдрэмжтэй хоцорч байна. Хүмүүний цэцэрхэл бидний чихэн дээр хангинаж, нүгэл хилэнц биднийг хүрээлэн бүсэлж байна.

Бидний үүрэг хариуцлага бол Тэнгэрлэг Эцэгийн бидэнд бэлдсэн бүх алдар суут адислалуудыг хүлээж авахуйц зохистой амьдрах явдал юм. Биднийг хаана ч явсан санваар хамт байдаг. Бид ариун газруудад зогсож байна уу? Та нарт эсвэл та нарын санваарт харшлах газруудад орж эсвэл тийм үйл ажиллагаануудад оролцож, өөрсдийгөө болон санваараа эрсдэлд оруулахаас өмнө үр дагаврыг нь бодож үзээрэй.

Бурханы санваарт томилогдсон бид өөрчлөлт хийж чадна. Бид хувийн цэвэр ариун байдлаа хадгалж, санваартаа хүндэтгэлтэй хандсанаар бусад хүний дагах зөв шударга үлгэр жишээ болдог. Төлөөлөгч Паул “Харин чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дуурайл бол” [1 Тимот 4:12] хэмээн анхааруулжээ. Тэрээр бас Христийн дагалдагчид “дэлхийд гэрэл мэт үзэгдэх” [Филиппой 2:15] ёстой гэж бичсэн байдаг. Зөв шударга байдлын үлгэр жишээ үзүүлэх нь улам харанхуй болж буй дэлхийг сайн сайхнаар гэрэлтүүлж чадна.



Патриархын адислал надад хэрхэн тусалж болох вэ?

Патриархын адислал бол бидэнд зориулсан хувийн илчлэлт юм. Хэрэв бид итгэлтэй байвал патриархын адислал бидэнд өөрсдийн чадвар болон хүлээн авч болох адислалуудаа ойлгоход туслах болно. Энэ нь бидний амьдралыг удирдан чиглүүлэх амлалт, сануулга, анхааруулгыг агуулдаг. Энэ нь түүнчлэн Тэнгэрлэг Эцэг бидний хүн нэг бүрийг мэддэг мөн санаа тавьдаг гэдгийг мэдэхэд бидэнд тусалдаг.

Хэрэв та патриархын адислалаа авсан бол энэ нь таны амьдралыг хэрхэн удирдан чиглүүлсэн бэ? Энэ нь хүнд хэцүү цаг үед тань хэрхэн тусалсан бэ? Энэ нь танд хэрхэн сүнслэгээр нөлөөлсөн бэ?

Патриархын адислал нь таны зааж буй залуу эрэгтэйчүүдийн амьдралд ямар арга замаар удирдамж болж чадах вэ? Тэдний хувьд Израилын угсаан дахь өөрсдийн гарал угсааг мэдэх нь яагаад чухал вэ? Патриархын адислалаа авахаар бэлтгэхэд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлдэж байхдаа эдгээр судар болон материалыг залбирч судлаарай. Таны зааж буй залуу эрэгтэйчүүдэд хамгийн ихээр туслах зүйл юу байна гэж та бодож байна вэ?

Алма 16:16–17; 3 Нифай 17:2–3
(Бид Их Эзэнээс удирдамж хүлээн авахын тулд зүрх сэтгэлээ бэлтгэх хэрэгтэй)

3 Нифай 20:25–27 (Израилын угсаа дэлхийн гэр бүлүүдийг адисалдаг)

С ба Г 82:10; 130:20–21 (Адислалууд дуулгавартай байдал дээр тулгуурладаг)

Хэнри Б.Айринг, “Өндөр зорилго тавихад нь хүүхдүүддээ тусал”
Ensign эсвэл *Лиахона*, 2012 оны 11-р сар, 60–67

Бойд К.Пакэр “Өсвөр үеийнхэнд өгөх зөвлөгөө” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11-р сар, 16–19

Карлос А.Годой, “Их Эзэнд бидэнд зориулсан төлөвлөгөө бий!” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 96–98

“Патриархын адислалуудын тухай”
New Era 2004 оны 3-р сар, 32–35;
эсвэл *Лиахона*, 2004 оны 3-р сар, 18–21

“Патриархын адислалууд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 111–113

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг давтаж, энэ долоо хоногийн хичээлийг танилцуулахын тулд эдгээр санаанаас сонгож эсвэл өөрийн санааг ашиглаарай:

- Залуу эрэгтэйчүүдэд өнгөрсөн долоо хоногийнх нь хичээлийг сануулахын тулд ямар нэгэн зүйл эсвэл зураг үзүүл. Тэд сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлэх талаар ямар туршлагатай болсон бэ? Тэдэнд хичээлийн сэдвийн талаар ямар нэгэн асуулт эсвэл тайлбар байгаа эсэхийг тэднээс асуу.
- “Патриархын адислал надад хэрхэн тусалж болох вэ?” гэж самбар дээр бич. Энэ асуултад хариулахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Хичээлийн үеэр энэ асуултыг дахин авч үзэж болно. Ярилцлагынхаа нэг хэсэг болгож ахлагч Карлос А.Годойд амьдралынхаа чухал шийдвэрийг гаргахад патриархын адислал нь түүнд хэрхэн тусалсан тухай түүхийг хуваалцах талаар бодож үз. (“Их Эзэнд бидэнд зориулсан төлөвлөгөө бий!” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 11-р сар, 96–98-ыг үзнэ үү).

Хамтдаа суралц

Заахад туслах зөвлөмж

“Хэн нэг нь асуулт асуусан үед өөрөө хариулахын оронд бусдыг хариулахад урих талаар бодож үзээрэй. Тухайлбал: Энэ сонирхолтой асуулт байна. Та нар энэ тухай юу гэж бодож байна? эсвэл хэн нэг нь энэ асуултад хариулах уу? гэж та асууж болох юм.” *Teaching, No Greater Call* (1999), 67.

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд патриархын адислалын талаар суралцахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Нэг эсвэл түүнээс дээш тооны залуу эрэгтэйг патриархын адислал хүлээн авсан туршлагынх нь талаар хуваалцахыг урь (эсвэл өөрийн туршлагаасаа хуваалц). Патриархын адислалууд нь тэдэнд хэрхэн тусалдаг вэ? (Чуулгынханд патриархын адислалуудын агуулгын тодорхой хэсэг нь ариун нандин байдаг бөгөөд хуваалцах ёсгүйг сануул.) “Патриархын адислалуудын тухай” нийтлэлийн хувийг нэг асуултад нэг хариулт байхаар хэсгүүдэд хуваан хайчил. Чуулгын гишүүн бүрийг нийтлэлийн хуваасан нэг хэсгийг сонгон, асуулт хариултыг чуулгынхантай хуваалц. Залуу эрэгтэйчүүдэд өөр ямар асуултауд байна вэ?
- Бишопын зөвшөөрлөөр чуулгынхантай патриархын адислалын талаар ярилцахаар гадасны патриархыг урь. Залуу эрэгтэйчүүд өөрсдөдөө буй аливаа асуултаа патриархаас асуухад нь тэднийг дэмж.

- Патриархын адислалын талаар өөрсдөдөө байгаа аливаа асуултуудаа бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Чуулгаараа Итгэлдээ үнэнч байх нь номны 149–151-р хуудсууд дээрээс хариултаа хай.

- Чуулгаараа, патриархын адислалын талаар ерөнхийлөгч Боид К.Пакэрын хэлсэн “Өсвөр үеийнхэнд өгөх зөвлөгөө” үг эсвэл адислалаа хүлээн авсан талаарх түүхийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Патриархын адислалуудын талаар тэд илүү сайн ойлгож мэдсэн үү? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцууулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг удирдсан чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Патриархын адислалаа хүлээн аваагүй байгаа чуулгын гишүүдийг бэлтгэхийн тулд тодорхой ямар нэгэн зүйл хийхэд урина.

“Өндөр зорилго тавихад нь хүүхдүүддээ тусал” хэлсэн үгээс унш. Залуу эрэгтэйчүүдээс патриархын адислал тэдэнд туслах арга замуудыг танихыг мөн тэд юу олж мэдсэнээ хуваалцахыг хүс.

- Энэхүү тоймд санал болгосон судруудыг уншихыг залуу эрэгтэйчүүдэд уриалан тэднийг патриархын адислалын талаар судар болгоны зааж байгаа зүйлийг хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч чуулгын тань залуу эрэгтэйчүүдийг мөн тэдний хэн болж чадахыг мэддэг. Чуулгын тань гишүүн бүрээр хийлгэх ажил Түүнд байгаа бөгөөд ажлаа хийж дуусгахад нь Тэр тэдэнд туслахыг хүсдэг. Та патриархын адислалуудын талаар ярьж байхдаа тэднийг хайрлах Аврагчийн хайрын талаар залуу эрэгтэйчүүдэд хэрхэн зааж чадах вэ?

Сонгосон материалууд

“Патриархын адислалын тухай” хэлсэн үгээс эш татав. New Era, 2004 оны 5-р сар, 32–35; эсвэл Лиахона, 2004 оны 3-р сар, 18–21

Патриархын адислал гэж юу вэ?

Патриархын адислал нь үндсэн хоёр зорилготой. Нэгдүгээрт, патриарх таны удам угсааг өөрөөр хэлбэл, таныг Израилын аль овогт харьяалагддагийг сүнсний удирдамжаар тодорхойлдог. Хоёрдугаарт, патриарх бошиглолын суу бэлгээр удирдагдан, зөвхөн танд хамаатай адислал, амлалт, анхааруулга, зөвлөгөөг хэлж өгдөг. Хэрэв та итгэлээ бодитой болгож, зөв шударга амьдрах юм бол таны хүлээж авч болох адислалууд болон амжилт ололтыг тань патриархын адислал хэлж өгч болно.

Удам угсаа яагаад чухал вэ?

Сүмийн гишүүн бүр Израилын арванхоёр овгийн нэгэнд нь харьяалагддаг. Израилын шууд угсааны биш хүмүүс баптисмаар дамжин Израилын угсаанд “үрчлэгддэг.” Арванхоёр овгийн алинд харьяалагдаж байгаага мэдэх нь тухайн овог бүрд хамаарах адислалууд болон үүрэг зорилгуудыг бидэнд боломжтой болгодог бөгөөд энэ нь таны амьдралд ашиг тустай удирдамж болдог. Иаковын хөвгүүд дээ (овог бүрийн тэргүүн) өгсөн адислалуудыг Эхлэл номын 49-р бүлгээс олж уншиж болно.

Хэн патриархын адислалыг авч болох вэ?

Гишүүн болоод хэдэн жил болсноос үл хамааран Сүмийн зохистой бүх гишүүд патриархын адислал авах эрхтэй бөгөөд адислалаа авч болно.

Би патриархын адислалаа авахад хэдэн настай байх ёстой вэ?

Энд тодорхой заасан нас гэж байхгүй ч, уг адислалын ариун утга учрыг ойлгож мэдэхээр хангалттай насанд хүрсэн байх ёстой.

Адислалыг хэрхэн өгдөг вэ?

Патриарх таны толгой дээр гараа тавьж, сүнсний удирдамжаар адислал өгдөг. Энэ танд зориулсан илчлэгдсэн удирдамж байх болно. Тэгээд та адислалаа насан туршдаа уншиж судалж болохын тулд үүнийг танд бичгээр хэвлэн өгдөг. Таныг адислалаа гэж үрэгдүүлсэн тохиолдолд хувилж өгөх үүднээс таны патриархын адислалын нэг хувийг Сүм хадгалдаг.

Би патриархын адислалаа хэрхэн авах вэ?

Бишоптойгоо ярилцлагын цаг тохир. Бишоп таныг патриархын адислалаа хүлээн авахад бэлэн болсон эсэхийг тодорхойлж зөвшөөрлийн бичиг өгөх эсвэл адислалаа хүлээн авахад бэлтгэхэд тань туслах болно. Та зөвшөөрлийн бичиг хүлээж аваад патриархтай холбоо барьж, цаг тохирох хэрэгтэй. Бишоп эсвэл патриархаасаа тантай эцэг эх юмуу өөр хэн хамт байж болохыг асуу. Товлосон цагтаа зөвшөөрлийн бичгээ авч очоорой.

Би өөрийгөө бэлэн гэдгээ яаж мэдэх вэ?

Патриархын адислал авах хүсэл нь танд зориулсан Бурханы хүслийг мэдэх мөн үүний дагуу амьдрах хүслээс үүдэлтэй юм. Сониуч зангаар юм уу бусдын шахалтаар патриархын адислал авах нь зөв шалтгаан биш. Патриархын адислал авахад бэлэн болсон эсэхийг тодорхойлоход бишоп туслах болно.

Сонгосон материалууд

Би хэрхэн бэлтгэх вэ?

Та Их Эзэнд ойр байхын тулд боломжтой бүхнийг хийх ёстой. Залбирал, мацаг барилт, судраас судлах, тунгаан бодох, наманчлах нь тусална. Ариун зүйлийн төлөө дэлхийн зүйлүүдийг ардаа үлдээх хэрэгтэй.

Миний адислал дахь амлалтууд хэдийд биелэгдэх вэ?

Зарим үед патриархын адислал бидний дэлхийн өмнөх амьдралын зарим зүйлсийг илчилдэг. Гэвч энэ нь ихэнхдээ одоогийн болон ирээдүйн амьдралд бидний баримтлах удирдамж байдаг. Адислалууд нь мөн чанараараа мөнхийн юм. Иймээс патриархын адислал мөнх бус амьдралын дараах боломжуудыг заасан байж болно.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Зургаадугаар сар: Санваар ба санваарын түлхүүрүүд

“Бурханы хаант улсын түлхүүрүүд дэлхий дээр хүмүүнд итгэмжлэгдсэн болой” (С ба Г 65:2).

Энэ бүлгийн тоймууд нь залуу эрэгтэй бүрд “өөрийн үүргийг мэдэж, ... томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллахад нь” (С ба Г 107:99) туслах болно. Энэ хэсэгт та санваараа зохистой ашиглах замаар Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг хэрхэн адислах боломжтойг ойлгоход нь чуулгынхаа гишүүдэд тусалж чадна.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд та доорх “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” тоймыг энэ бүлэгт оруулан зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Зохистой байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Санваар гэж юу вэ?

Санваарын түлхүүрүүд гэж юу вэ?

Аароны санваартан миний үүргүүд юу вэ?

Би яагаад номлолд үйлчлэх ёстой вэ?

Сүмийн удирдагчдаа дэмжинэ гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны вэбсайт танд туслах болно. Эдгээр
тоймд багтсан олон үйл ажиллагааг мючелийн үйл
ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу эрэгтэйчүү-
дийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг бататгахын
тулд тохиромжтой үйл ажиллагаануудыг сонгож
мөн төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн зөвлөл-
тэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Зохистой амьдар” 16–17, 40–41, 64–65-р хуудас

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас

“Санваарын үүргүүд” 22–29, 46–53, 70–77-р хуудас



Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Зохистой байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ?

Санваарын эрх мэдлийг томилолтоор дамжуулан өгдөг ч санваарын хүч нь хувь хүнээс итгэл, дуулгавартай байдал, зөв шударга зан чанар болон хичээл зүтгэлийг шаарддаг. Бид санваарын эрх мэдлийг гар тавилтаар хүлээн авдаг ч гэсэн хэрэв дуулгаваргүй, зохисгүй эсвэл үйлчлэх хүсэлгүй аваас санваарын хүчгүй байх болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та заахаар бэлтгэхдээ эдгээр судар болон бусад материалыг залбирч судал. Та юуг залуу эрэгтэйчүүдтэй хуваалцахаар сүнслэгээр нөлөөлөгдсөн бэ?

С ба Г 38:42 (Санваартнуудад цэвэр ариун байхыг зарлигласан)

Дэвид А.Бэднар, “Тэнгэрийн хүчнүүд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 5-р сар, 48–51

С ба Г 121:34–46 (Санваарын хүч нь тухайн хүний зөв шударга байдлаас хамааралтай)

“Зохистой амьдар,” *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* (2010), 16–17 (диконууд), 40–41 (багш нар), 64–65 (пристүүд)

Рассэлл М.Нэлсон, “Санваарын хүчний үнэ цэн,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 122–125

Видео бичлэгүүд: “Өөрсдийгөө ариусга”; “Санваарын хүч болон санваарын эрх мэдэл”

Нийл Л.Андэрсэн, “Санваар дахь хүч,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 11-р сар

Санваарын эрх мэдэл, санваарын хүч хоёр ямар ялгаатай вэ? Зохистой байдал нь яагаад санваарын хүчтэй байх урьдчилсан нөхцөл болдог вэ?

Зохистой байдал, санваарын хүч хоёр хоорондоо ямар холбоотойг ойлгоход нь та Аароны санваартнуудад хэрхэн тусалж болох вэ? Залуу эрэгтэйчүүд санваарын хүчээ алдаж болох ямар уруу таталттай тулгардаг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй холбоотой туршлагаа хуваалцахаар бэлтгэж чуулгын цуглаандаа ирэхийг хэдэн залуу эрэгтэйгээс хүс.
- Ангийн гэрлийг унтраахыг нэг залуу эрэгтэйгээс хүс. Цахилгаан эрчим хүчгүй бол чийдэнгийн шил ямар хэрэгтэй вэ? Энэ нь санваартан хүнд ямар хамаатай байж болох вэ? Сургаал ба Гэрээ 121:36–37-г уншиж, зөв шударга байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдгийг залуу эрэгтэйчүүдээс асуу.

Заахад туслах арга

Судруудаас заахдаа суралцагчдад ямар нэгэн зүйлийг харуулах юм уу сонгох нь тустай байдаг” (Teaching, No Greater Call [1999], 55).

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго нь тэдний зохистой байдал санваарынх нь хүчинд хэрхэн нөлөөлдгийг ойлгоход залуу эрэгтэй бүрд туслах явдал мөн. Чуулгын гишүүд энэ хичээлийн хэсэг болгон Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь жишгүүдийг судалж, тэдгээрийн дагуу амьдрах төлөвлөгөөгөө Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номондоо гаргаж ажиллах ёстой. Чуулгын цуглааны өмнө залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо сүм дээр авчрахад урь. Чуулгын дараагийн цуглаанууд дээр төлөвлөгөөгөө биелүүлэх талаар хийж байгаа ажлынхаа тухай хуваалцахад тэднийг урь.

- Залуу эрэгтэйчүүдэд санваарын хүчний үнэ цэнийн талаар мэдэж авахад нь туслахын тулд янз бүрийн зүйлсийг авчирч, эдгээр зүйл тус бүр ямар үнэ цэнтэй болохыг тэднээс асуу. Яагаад зарим зүйл бусдаасаа илүү их үнэ цэнтэй байна вэ? Бидний амьдралд ямар зүйлс хамгийн их үнэ цэнтэй байдаг вэ? Тэдгээрийн төлөө бид ямар төлөөс төлөх хэрэгтэй вэ? Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний “Санваарын хүчний үнэ цэн” үгийг уншаад, санваарын хүчийг ашиглахын тулд тэр биднийг ямар төлөөс төлөх ёстой гэж хэлснийг олж мэдэхэд урь. Тэр санваартнуудын өмнөөс юунд санаа зовдог вэ? Тэр биднээс юу юуг хийхэд бэлэн байгаа тухай асуусан бэ?

- Сургаал ба Гэрээ 38:42; 121:34–46-г уншаад, дараах асуултуудад хариулахад залуу эрэгтэйчүүдийг урь. Нүгэл санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ? Санваарыг ашиглах явдлыг удирддаг ямар зарчмууд байдаг вэ? Санваарын хүчийг удирдах зарчмуудыг хэрэгжүүлэхэд үлгэр жишээ үзүүлдэг санваартнуудын тухай ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь. (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* товхимлыг үзнэ үү.) *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо “Ажилла” хэсэг рүү (17, 41, 65-р хуудсууд) очиж, *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдийг судалж, дагаснаар санваартаа илүү зохистой амьдрах төлөвлөгөө хийхийг тэднээс хүс.

- Чуулгын нэг гишүүнийг Иосеф Потифарын эхнэрийг эсэргүүцсэн тухай түүхийг яриулахаар (Эхлэл 39, 41-ийг үзнэ үү) мөн Давид уруу таталтанд бууж өгсөн тухай түүхийг (2 Самуел 11–12-ыг үзнэ үү) яриулахаар өөр нэг гишүүнийг урь. Эдгээр түүх нь санваарын хүч, хувийн зохистой байдал хоёр хоорондоо ямар холбоотой байдаг талаар юу зааж байгааг чуулгаараа ярилц. Иосеф зөв шударга байсныхаа ачаар хэрхэн адислагдсан бэ? Давид эмгэнэлтэй байдлаасаа зайлсхийхийн тулд юу хийж болох байсан бэ? (*Бурханы өмнө хүлээсэн*

үүргээ биелүүлэх нь, 64-р хуудсыг үзнэ үү.) *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо “Ажилла” хэсгийг уншиж, (17, 41, 65-р хуудсууд) санваартаа тэнцэхээр улам зохистой амьдрах төлөвлөгөө гаргахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- “Зохистой байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ?” гэсэн асуултыг самбар дээр бичээд, энэ асуултын хариултуудыг хуваалцахад чуулгын гишүүдийг урь. “Бид ариун санваарын хүчийг мэднэ” гэсэн үгээр эхэлсэн ахлагч Нийл Л.Андэрсэны “Санваар дахь хүч” хэлсэн үгийн долоон догол мөрийг уншихдаа тэднийг энэ асуултын хариултыг бодоход урь. Санваарын хүчтэй байхад хувийн зохистой байдал хэрхэн нөлөөлдөг тухай залуу эрэгтэйчүүд ямар бодолтой байдаг вэ? Ямар зүйлс бидний санваарын хүчийг хязгаарлаж болох вэ? Бид илүү их санваарын хүчтэй байхын тулд юу хийж болох вэ?

- Ахлагч Дэвид А.Бэднэрийн “Тэнгэрийн цонхнууд” хэлсэн үгээс уншихдаа эсвэл “Санваарын хүч ба санваарын эрх мэдэл” видео бичлэгийг үзэхдээ зохистой байдал болон санваарын хүчний талаар тэдэнд заасан үгсийг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэгээд олж мэдсэн зүйлээ чуулгатай хуваалцахад тэднийг урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Зохистой байдал санваарын хүчинд хэрхэн нөлөөлдгийг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаалд илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч үгээр болон үлгэр жишээгээр зааж, Өөрийгөө дагахад биднийг урьдаг билээ. Та нар Есүс Христийн үлгэр жишээг дагаж, атгадаг санваарынхаа дагуу зохистой амьдардаг бол хүч ба эрх мэдэлтэйгээр зааж чадна.

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно.

- Тэрээр Залуучуудын бат бөх байдлын төлөө номон дээрх жишгүүдийг судалж, хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөгөө чуулгын гишүүдтэй хуваалцаж болно. Мөн тэрээр ирэх долоо хоногуудад

чуулгын гишүүд төлөвлөгөөнүүдээ биелүүлснээр санваар атгахуйц зөв зохистой амьдрахад нь хэрхэн тусалж байгаа талаар хуваалцахад чуулгын гишүүдийг урина гэдгээ тайлбарлан хэлж болно.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднарын “Тэнгэрийн хүч чадал” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2012 оны 5 –р сар, 48–51

Санваар бол хүн төрөлхтний авралын төлөө үйлдэхийн тулд хүмүүнд өгөгдсөн Бурханы дэлхий дээрх эрх мэдэл юм (Спэнсэр В.Кимбаллын “Абрахамын үлгэр жишээ” –г үз, Ensign, 1975 оны 6 –р сар, 3). Хүмүүний бодгалийг аврахын тулд Их Эзэн эрэгтэйчүүдээр дамжуулан үйлдэх эрхийг санваар гэдэг. Эртний болон эдүгээ үеийн Есүс Христийн Сүмийн гол онцлог бол Түүний эрх мэдэл юм. Тэнгэрлэг эрх мэдэлгүйгээр үнэн Сүм оршин тогтнох боломжгүй.

Жирийн эрэгтэйчүүдэд санваарын эрх мэдэл өгөгддөг бөгөөд санваарыг хүлээн авахад дадлага туршлага эсвэл боловсрол чухал биш харин зохистой бөгөөд хүсэлтэй байх хэрэгтэй.

“Сайн мэдээг номлох хийгээд үүний ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглолоор, эрх мэдэл бүхий тэдний гар тавилтаар Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг” хэмээн санваарын эрх мэдлийг хүлээн авах арга замыг заасан билээ. Хөвгүүд мөн насанд хүрсэн эрэгтэйчүүд санваарын эрх мэдэл болон санваарын албыг санваарын зохих түлхүүрийг атгадаг удирдагчдын томилсон санваартнаас хүлээн авдаг.

Энэхүү ариун эрх мэдлийг эзэмшдэг санваар атгагч нь санваарыг Бурханы ариун хүсэл, бодол, зорилготой нийцүүлэн ашиглах ёстой. Санваар нь хувиа хичээх байдалтай нийцэхгүй. Харин санваарыг бусдад үйлчилж, тэднийг адисалж, хүчирхэгжүүлэхэд ашигладаг. . . .

Бид санваарын үүрэг хариуцлагаа хамгийн сайнаараа биелүүлэх цагт санваарын хүчээр адислагдана. Санваарын хүч нь эрчүүд болон хөвгүүдээр дамжуулан үйлдэх Бурханы хүч бөгөөд хувь хүний итгэлтэй, дуулгавартай, тууштай, зөв шударга байдлаас ирдэг юм. Хөвгүүн буюу эрэгтэй хүн санваарын эрх мэдлийг гар тавилтаар хүлээн авдаг ч хэрэв тэрээр дуулгаваргүй, зохисгүй, үйлчлэх хүсэлгүй байх аваас санваарын хүчгүй байх болно.

“Санваарын эрхүүд нь тэнгэрийн хүчтэй салшгүй холбоотой байдаг, мөн . . . тэнгэрийн тэрхүү хүч нь зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө.

“Тэдгээр нь бидэнд хүртээгддэг байж болох нь, энэ нь үнэн бөлгөө; харин бид нүглээ далдахыг оролдоход, эсвээс бардамналаараа, хоосон санаархлаараа сайрхах, эсвээс хүмүүний үрсийг хянах, эзэгнэх, эсвээс албадахад, болгоогтун, тэнгэр өөрийгөө татан авдаг буюу; Их Эзэний сүнс гашууддаг болой; мөн энэ буцаан татагдахад, тэр хүний санваарт эсвээс эрх мэдэлд Амен” (С ба Г 121:36–37; тодотгол нэмсэн).

Ах нар аа, санваарын эрх мэдлийг хүлээн авсан боловч санваарын хүчийг авахад шаардлагатай зүйлсийг хийхгүй байхыг Их Эзэн хүлцдэггүй. Санваарын эрх мэдэл ба хүч нь Бурханыг төлөөлөх сүнслэг хүч чадал ба түүний ажлыг хийх зөвшөөрөл гэсэн үг юм. Залуу ч бай настай ч бай бүх санваартнуудад эдгээр нь шаардлагатай.

Сонгосон материалууд

Нийл Л. Андэрсэний “Санваар дахь хүч” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Ариун санваарын хүч нь итгэл, Ариун Сүнс, сүнслэг бэлгүүдээс салангид тусдаа ажилладаггүй гэдгийг бид мэднэ. Судрууд дээр “Бурханы бэлгүүдийг та нар үгүйсгэхгүй байхыг би та нарт ухуулж байна, учир нь тэдгээр нь олон. . . . Мөн уг бэлгүүд хүртээгдэх өөр өөр замууд буй, гэвч хаана ч мөн юунд ч үйлдэгч нэг л Бурхан байдаг” хэмээн анхааруулсан байдаг [Моронай 10:8].

Зохистой байдал

Санваарын ёслолуудыг гүйцэтгэх болон хүлээн авахад зөв зохистой байдал чухал гэдгийг бид мэддэг. Линда К. Бертон эгч “санваарын хүчийг амьдралдаа урихад зөв шударга байдал маш чухал юм” хэмээн хэлсэн байдаг [Линда К. Бертон “Санваар: Эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд сайн сайхныг авчрахын тулд ашиглагдах ариун итгэмжлэл (Priesthood: ‘A Sacred Trust to Be Used for the Benefit of Men, Women, and Children)’” (Бригам Янгийн Их Сургуулийн эмэгтэйчүүдийн чуулган дээр хэлсэн үг, 2013 оны 5-р сарын 3)]. [

Жишээлбэл, дэлхий даяар тархаж буй тахал болох порнографын талаар бодоод үз. Их Эзэний зөв зохистой байдлын жишиг нь санваарын ёслолууд гүйцэтгэж байгаа хүмүүст порнограф үзэхийг огт зөвшөөрдөггүй. Аврагч:

“Нууц жигшүүрт хэргүүдээ . . . наманчлагтун” [3 Нифай 30:2].

“Нүд бол биеийн дэнлүү мөн. . . . Харин нүд чинь муу бол бүтэн бие чинь харанхуйгаар дүүрэн байх болно” [Матай 6:22–23].

“Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” хэмээн хэлсэн байдаг [Матай 5:28; мөн Алма 39:9-ийг үзнэ үү].

Ахлагч Дэвид А. Бэднарын хэлснээр зохисгүйгээр ариун ёслолыг адислах, түгээх эсвэл санваарын бусад ёслолуудад оролцох мөн өвчтөнийг адислах нь Бурханы нэрийг дэмий хоосон авч буй хэрэг юм [Дэвид А. Бэднарын *Сургаалд үйлдэх нь* номыг үзнэ үү (2012), 53]. Зохисгүй санваартан ёслолуудыг гүйцэтгэхээс татгалзах мөн эхний алхам болгон наманчилж, дахин зарлигуудын дагуу амьдрах мөн залбирч, бишоптоо хандах ёстой.



Санваар гэж юу вэ?

Санваар бол Тэнгэрлэг Эцэгээс өгөгдсөн эрх мэдэл, мөнхийн хүч чадал юм. Бурхан санваараар дамжуулан тэнгэрүүд болон дэлхий ертөнцийг бүтээсэн ба мөн эдгээрийг захирдаг юм. Энэхүү хүчээр дамжуулан Тэрээр Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэж, өргөмжилдөг. Тэрээр зохистой санваартнуудад авралын ёслолуудыг үйлдэх эрх мэдлийг өгдөг билээ. Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхэд эдгээр ёслолыг хүлээн авч чадах ба санваарын хүч чадал хийгээд адислалуудаас хүртэж чадах юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Хичээлд бэлтгэхдээ дараах судар ба материалуудыг залбирч судал. Та чуулгынхантай юуг хуваалцах хэрэгтэй гэж сүнслэгээр нөлөөлөгдөж байна вэ?

Матай 3:1–6; 28:19; Иохан 15:16
(Санваартнууд сайн мэдээг номлодог)

Үйлс 3:1–8; Иаков 5:14–15 (Санваартнууд өвчтэй болон зовж зүдэрсэн хүмүүст эдгээх адислал өгдөг)

Еврей 5:4 (Санваартнууд Бурханаас дуудагддаг)

3 Нифай 11:12; 18:1–5; С ба Г 107:20 (Санваартнууд ёслолуудыг гүйцэтгэдэг)

С ба Г 20:38–67 (Санваартнуудын үүргүүд)

С ба Г 65:2; 124:123 (Санваартнууд Сүмийг удирдахад тусалдаг)

С ба Г 121:34–46 (Санваарын хүч ба эрх мэдэл нь зөвхөн зөв шударга ёсны зарчмаар хэрэгждэг)

Томас С.Монсон, “Санваар бол ариун нандин бэлэг,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 74–76.

Дийтр Ф.Угдорф, “Санваартан хүний баяр баясгалан” *Ensign* эсвэл *Лиакхона* 2012 оны 11-р сар, 57–60

М.Рассэлл Баллард, “Энэ нь Миний ажил болон Алдар суу бөлгөө,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 18–21

“Санваар,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 166–71

Видео бичлэгүүд: “Санваарын адислал нь бүх хүнд боломжтой,” “Бурханы хүч,” “Санваарын адислалууд”

Санваар амьдралыг тань хэрхэн адисалсан бэ? Та санваарынхаа талаар залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж болох ямар туршлага хуримтлуулсан бэ?

Залуу эрэгтэй бүр санваарын тухай юу мэддэгийг нь олж мэдэхийн тулд та чуулгын цуглааны өмнө юу хийж болох вэ? Тэд санваарыг ашиглах талаар ямар туршлагатай вэ? Энэ нь таньг заах зүйлээ сонгоход хэрхэн нөлөөлж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын

ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээр сурч мэдсэн зүйлээ хуваалцах бэлтгэлтэйгээр чуулгын цуглаанд ирэхийг нэг залуу эрэгтэйгээс хүс. Өөрийн бодол санаа, гэрчлэлийг хуваалцахад түүнийг урамшуулан дэмж.
- Өөр шашинтай нэг найз нь, “Санваар гэж юу вэ?” гэж асууж байгаагаар жүжигчлэн тоглох ярилцлага өрнүүлэхэд залуу эрэгтэйчүүдийг урь. Тэд санваарыг юу гэж тайлбарлах вэ? Тэд ямар туршлагаудыг хуваалцаж чадах вэ? Энэ бүлгийн эхэнд байгаа догол мөрийг тэдэнтэй хуваалцаж эсвэл “Санваарын адислал нь бүх хүнд боломжтой” видео бичлэгийг үзэж, мөн тэд санваарын талаар өөр ямар үнэнийг нэмж сурсныг тэднээс асуу.

Хамтдаа суралц

Заах санаа

“Зөвхөн хичээл дуусах үед биш, Сүнсний өдөөлт ирсэн хэдийд ч гэрчлэлээ хуваалц. Заадаг хүмүүстээ гэрчлэлээ хуваалцах боломж олго” (*Teaching, No Greater Call* [1999], 45).

Дараах үйл ажиллагаа бүр нь санваар гэж юу болохыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгыг бүлгүүд болгон хувааж, бүлэг бүрд ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн “Санваар бол ариун нандин бэлэг” үгэн дэх түүхүүдээс нэгийг уншуулахаар хуваарил. Бүлэг бүрээс уншсан түүхээ дүгнэн, чуулгынханд ярьж өгөхийг мөн ерөнхийлөгч Монсон энэ туршлагаасаа санваарын талаар юу сурсан талаар хуваалцахыг хүс. Санваарын талаарх залуу эрэгтэйчүүдийн гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн ямар туршлагауд тэдэнд байдаг вэ?
- Энэ хичээлийн нэг хэсгийг заахад чуулгын нэг гишүүнийг урь. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь төлөвлөгөөнийхөө дагуу санваар ба санваарын түлхүүрүүдийн тухай тэрээр энэ хичээлийг хэсэг болгон зааж болно (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Чуулгыг жижиг бүлгүүд болгон хуваарил. Бүлэг бүрд хичээлийн тоймд санал болгосон судруудаас нэгээс илүүг өгч, тэдгээр судраас санваартнуудын үүрэг хариуцлагыг

эрж олохыг тэднээс хүс. Санваарын үүрэг хариуцлагаа гүйцэтгэж буй хүмүүсийн зургийг *Сайн мэдээний зургийн цуглуулгаас* олж, уг үйлчлэлээр дамжуулан бусад хүн хэрхэн адислагдаж байгааг тайлбарлахыг тэднээс хүс. Санваарын үүргээ гүйцэтгэсэн туршлагаасаа хуваалцаж, тэдний үйлчлэл бусдад хэрхэн нөлөөлөхийг тайлбарлахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- Самбар дээр “Санваарын ачаар та нарын амьдралд ямар адислалууд ирсэн бэ?” гэж бичээрэй. Залуу эрэгтэйчүүдийг энэ асуултыг тунгаан бодож, хариултаа хуваалцахад урь. Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдийн нэгийг үзүүлж эсвэл ахлагч Рассэлл М.Баллардын “Энэ нь Миний ажил болон алдар суу бөлгөө” хэлсэн үгийн эхний 9 догол мөрийг хамтдаа унш. “Санваар гэж юу вэ?” болон “Санваар биднийг хэрхэн адисалдаг вэ?” гэх мэт асуултын хариултыг олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Санваар

гэр бүлийг нь хэрхэн адисалсан түүхийг өдрийн тэмдэглэлдээ эсвэл *Миний гэр бүл* дэвтэртээ бичиж тэмдэглэхийг залуу эрэгтэйчүүдэд урамшуул. Тэд эцэг эх болон гэр бүлийнхээ гишүүдээс тусламж хүсч болно.

- Санваарын ачаар адислагдсан хүмүүсийн жишээг судруудаас олоход залуу эрэгтэйчүүдийг урь (тэд санаа авахын тулд хичээлийн энэ тоймд санал болгосон судруудыг үзэж болно). Судруудаас олсон жишээгээ бас санваарын хүчийг гэрчилсэн хувийн туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн “Санваартан хүний баяр баясгалан” үгийн сүүлчийн хэсгийн эхний дөрвөн догол мөрийг чуулгаараа унш. Ерөнхийлөгч Угдорф санваарын талаар ямар бодолтой байна вэ? Санваар эзэмших гэдэг нь юу гэсэн үг болох талаар санал бодлоо хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэл хүлээлгэн, тэднийг бэлтгэж, бусдад заах, бусдыг адислах болон үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг тэдэнд даалгадаг байлаа. Бусдад үйлчлэх байдал нь залуу эрэгтэйчүүдийн амьдралын нэг хэсэг болж, санваарын сургаалд хөрвөгдөхөд нь тэдэнд та хэрхэн тусалж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлсийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд санваарыг илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- Санваарын тухай мөн энэ нь амьдралд нь ямар нөлөө үзүүлж байгаа тухай санал бодлоо хуваалцана.

- Өнөөдрийн хичээлээс сурч мэдсэн зүйлээ гэр бүлийн гишүүн буюу найзтайгаа хуваалцах даалгаврыг чуулгын гишүүдэд өгнө.

Сонгосон материалууд

Итгэлдээ үнэнч байх нь номын “Санваар” хэсгээс эш татав (2004), 166–71

Санваарын чуулгууд

Санваарын чуулга нь ижил санваарын албыг хашдаг зохион байгуулалттай хэсэг ах нарын бүлэг юм. Чуулгын үндсэн зорилго нь бусдад үйлчлэх, эв нэгдлийн болон ах дүүгийн барилдлагааг бий болгож, нэг нэгэндээ сургаал, зарчим, үүргүүдийг зааварчлах учиртай.

Чуулгууд нь Сүмийн бүхий л түвшинд оршдог. Сүмийн ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд

Тэргүүн Зөвлөлийн чуулгыг бүрдүүлдэг. Арванхоёрын төлөөлөгч нь мөн чуулгыг бүрдүүлдэг. Ерөнхий эрх мэдэлтэй болон бүсийн эрх мэдэл бүхий Далууд аль аль нь чуулгуудад зохион байгуулагдсан байдаг. Гадасны ерөнхийлөгч бүр гадасны дээд санваартнуудаас бүрдсэн Дээд санваарын чуулгыг тэргүүлдэг. Тойрог эсвэл салбар бүр ерөнхийдөө ахлагч, санваартан, багш болон диконуудын чуулгуудтай байдаг. Дээд санваартнууд тойрог дотроо зохион байгуулагдаж, Дээд санваарын бүлэгтээ үйлчилдэг.



Санваарын түлхүүрүүд гэж юу вэ?

Санваарын түлхүүрүүд гэдэг нь Тэнгэрлэг Эцэг Өөрийнх нь санваарыг дэлхий дээр ашиглахад удирдуулахаар санваарын удирдагчдадаа өгсөн эрх мэдэл юм. Есүс Христ санваарын бүх түлхүүрийг атгадаг. Сүмийг удирдахад шаардлагатай “энэ эрин үеийн түлхүүрүүд” нь Иосеф Смитэд өгөгдсөн юм (С ба Г 110:16-г үзнэ үү). Өнөө үед Тэргүүн Зөвлөл мөн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд тэдгээр түлхүүрийг атгадаг. Санваарын түлхүүрүүдийг түүнчлэн Далын ерөнхийлөгчийн зөвлөлд; ариун сүм, номлол, гадас болон дүүргүүдийн ерөнхийлөгчид; бишопууд; салбарын ерөнхийлөгчид; Аароны санваарын чуулгын ерөнхийлөгчдийг оролцуулан чуулгын ерөнхийлөгчдөд өгдөг юм.

Өөрийн мэддэг санваарын удирдагчдынхаа тухай бод. Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүсийг дэмжих нь танд яагаад чухал вэ? Сүмийн удирдагчдыг дэмжсэн талаар залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж болох ямар туршлага танд байдаг вэ?

Сүм дэх санваарын түлхүүрүүдийн ач холбогдлыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд та юу хийж болох вэ? Чуулгын ерөнхийлөгч чуулгынхаа гишүүдийн амьдралыг адислахын тулд санваарын түлхүүрүүдээ ашиглахад нь та хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба суралцах материалуудыг залбирч судлаарай. Санваарын түлхүүрүүдийг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд юу туслах вэ?

Матай 16:18–19 (Петрт Бурханы хаант улсын түлхүүрүүд амлагдсан юм)

Мозая 25:19 (Сүмийг байгуулах эрх мэдлийг Мозая Алмад өгсөн билээ)

С ба Г 65:2 (Сайн мэдээг дэлгэрүүлэхэд санваарын түлхүүрүүд зайлшгүй чухал)

С ба Г 124:123, 142–143 (Ерөнхийлөгчид үйлчлэлийн ажлыг удирдах санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг)

С ба Г 132:7 (Сүмийн ерөнхийлөгч бол санваарын бүх түлхүүрийг ашиглах эрх мэдэл олгогдсон дэлхий дээрх цорын ганц хүн мөн)

Гари Э.Стивэнсон, “Санваарын түлхүүр ба эрх мэдэл хаана байна вэ?” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 68–71.

Даллин Х.Өүкс, “Санваарын түлхүүрүүд ба эрх мэдэл,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 5-р сар

“Санваарын түлхүүрүүд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 168–169

Видео бичлэгүүд: “Үүргээсээ суралц”; “Санваарын түлхүүрүүдийн сэргээлт”; “Санваар нь үйлчлэх боломж юм”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа ямар нэг зүйлийг болон энэ долоо хоногийн үйл ажиллагаанд нь энэ зүйл хэрхэн нөлөөлснийг хуваалцахад хоёр залуу эрэгтэйг урь.
- Дараах жишээг ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь: Хэрэв та нар сүмээс хол газар амралтанд явж байхдаа гэр бүлийнхэндээ ариун ёслолыг гүйцэтгэн, түгээж болох уу?

Энэ ярилцлагын нэг хэсэг болгож дараахтай адил асуултуудыг тунгаан бодож, мөн хариулахыг тэднээс хүс: Санваарын түлхүүрүүд гэж юу вэ? Сүмд хэн түлхүүрүүдийг атгадаг вэ? *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлын 168-169-р хуудсан дээрх “Санваарын түлхүүрүүд” хэсгийг унших үедээ эсвэл “Санваарын түлхүүрүүдийн сэргээлт” видео бичлэгийг үзэх үедээ хариултуудыг эрэлхийлэхийг тэдэнд уриал.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь санваарын түлхүүрүүд гэж юу болохыг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын цуглаанд бэлтгэх явцдаа “Санваар нь үйлчлэх боломж юм” видео бичлэгийг үзэхийг чуулгын ерөнхийлөгчөөс хүс. Чуулгын цуглааны явцад санваарын

түлхүүрүүдийг эзэмшинэ гэдэг нь юу гэсэн үг болох талаар сурсан зүйлээ хуваалцахыг түүнээс хүс. Тэрээр санваар болон санваарын түлхүүрүүдийн талаар сурч, заахыг

Заах санаа

“Хариултыг нь судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын зөвлөгөөнөөс олох шаардлагатай тийм асуултуудыг асуу” (*Teaching, No Greater Call* [1999], 62).

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь төлөвлөгөөнийхөө нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).

- Дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич: Матай 16:18–19; С ба Г 124:123, 142–43; С ба Г 132:7. Судар бүрийг уншиж, санваарын түлхүүрүүдийн талаар эдгээр шүлгээс мэдсэн зүйлээ нэг өгүүлбэрт багтаан хураангуйлж бичихэд чуулгын гишүүдийг урь. Залуу эрэгтэй бүрээр хураангуйлсан өгүүлбэрүүдээс нь нэгийг чангаар уншуулж, ямар судрыг хураангуйлсныг бусад залуу эрэгтэйчүүдээс асуу. Өнөөдөр дэлхий дээр санваарын түлхүүрүүд байгаа нь тэдэнд яагаад чухал болохыг чуулгын гишүүдээс асуу.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд санваарын түлхүүрүүдийн талаар илүү сайн ойлголттой болсон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Удирдаж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлүүлнэ. Тэрээр:

- Санваарын түлхүүрийг атгах үүрэг хариуцлагын талаар сэтгэгдлээ хуваалцаж болно.
- Өнөөдөр сурсан зүйлээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахад чуулгын гишүүдийг урьж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн Сүмийг удирдан чиглүүлэх удирдагчдыг дуудаж адисалдаг билээ (Матай 10:1–5-ыг үзнэ үү). Та чуулгын гишүүдэд үйлчилж, туслахаар дуудагдсан хүмүүст талархалтай байхад нь хэрхэн тусалж болох вэ?

Видео бичлэг: “Дагалдах асуултуудыг тавих нь”

Сонгосон материалууд

Даллин Х.Өүкс, “Санваарын түлхүүрүүд ба эрх мэдэл,” *Ensign*, 2014 оны 5-р сар, 49–50 эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 68–69

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон эмэгтэйчүүдийн хуралдаан дээр үг хэлж байхдаа “Бид бүгдийн санваарыг илүү сайн ойлгох хүсэл маань нэмэгдээсэй гэж найдаж байна” гэжээ [Линда К.Бертон, “Priesthood: ‘A Sacred Trust to Be Used for the Benefit of Men, Women, and Children’” (Бригам Янгийн Их Сургуулийн эмэгтэйчүүдийн чуулган дээр хэлсэн үг, 2013 оны 5-р сарын 3), 1; se.byu.edu/cw/womensconference/transcripts.Php]. Энэ хэрэгцээ нь бидэнд ч бас хамаарах бөгөөд би санваарын түлхүүрүүд болон эрх мэдлийн тухай үүнийг үргэлжлүүлэн ярих болно. . . .

Бидний эрэлхийлж байгаа ойлголт нь санваарын түлхүүрүүдийн тухай ойлголтоос эхэлдэг. “Санваарын түлхүүрүүд бол санваарын удирдагчдад Түүний санваарыг [атгагчдад] дэлхий дээр хэрэглэх, удирдах, хянах, засаглах Бурханаас олгосон эрх мэдэл юм” [*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 2.1.1]. Сүмд хийгдэж байгаа бүх үйлдэл, ёслол нь тэрхүү үйл ажиллагаа ёслолуудын түлхүүрийг атгадаг нэгний шууд эсвэл шууд бус зөвшөөрлийн дагуу гүйцэтгэгддэг. Ахлагч М.Рассэлл Баллардын тайлбарласнаар: “Санваарын түлхүүрүүдийг атгагчид нь . . . өөрсдийн удирдлаган дор итгэлтэй үйлчилж байгаа бүгдэд санваарын эрх мэдлийг ашиглаж, санваарын хүчийг хэрэглэх боломжийг олгодог” [*“Men and Women in the Work of the Lord,” New Era*, 2014 оны 4-р сар, 4; *Луахона*, 2014 оны 4-р сар, 48; мөн *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 138-ыг үзнэ үү].

Санваарын эрх мэдлийн хэрэгжүүлэлтийг хянахад санваарын түлхүүрүүдийн үүрэг нь нэг талаар өргөн хүрээтэй, нөгөө талаар хязгаартай байдаг. Санваарын эрх мэдэл, адислалыг Бурханы бүх хүүхдэд боломжтой болгосноор энэ үүрэг өргөн хүрээтэй байдаг бол хэнд санваарын эрх мэдэл өгөх, албадыг хэн хэн атгах мөн эрх мэдэл болон хүчийг хэрхэн өгөхийг удирдсанаар хязгаартай байдаг. Жишээлбэл, санваар атгагч хүн өөрийн алба юм уу эрх мэдлийг түлхүүр атгагч нэгнээр зөвшөөрөгдөхөөс өөрөөр хэн нэгэнд өгч чадахгүй. Тэрхүү зөвшөөрөлгүйгээр ёслол нь хүчин төгөлдөр болохгүй. Үүгээр санваартан нь албаасаа үл хамааран, зохих түлхүүрүүдийг атгасан нэгнээс зөвшөөрөл авалгүйгээр гэр бүлийнхээ гишүүнийг томилох юм уу гэртээ ариун ёслолыг адисалж чадахгүйг тайлбарладаг.

Миний энд тайлбарлан үзүүлэх ариун сүмийн ерөнхийлөгчийн атгадаг түлхүүрүүдийн дор ариун сүмд эгч нарын хийдэг ариун нандин ажлуудаас гадна санваарын албанд томилогдсон хүн л санваарын ёслолыг гүйцэтгэнэ. Мөн зөвшөөрөгдсөн санваарын ёслолууд бүр нь Сүмийн тайланд бүртгэгддэг.

Эцэст нь, энэ санваарын эзэн болох Их Эзэн Есүс Христ санваарын бүх түлхүүрийг атгадаг. Тэрээр мөнх бус хүмүүст ямар түлхүүрүүд өгөгдөх хийгээд энэ түлхүүрүүд нь хэрхэн ашиглагдахыг тодорхойлдог. Бид Көртландын ариун сүмд Иосеф Смитэд бүх түлхүүр өгөгдсөн гэж боддог ч судар дээр өгөгдсөн бүгд “энэ эрин үеийн түлхүүрүүд” (С ба Г 110:16) байсан гэдгийг хэлдэг. Олон жилийн өмнөх Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл дэлхий дээрх хүмүүнд өгөгдөөгүй өөр

Сонгосон материалууд

түлхүүрүүд байдаг ба эдгээрт бүтээлт, амилуулалтын түлхүүрүүд багтдаг гэдгийг сануулсан.

Санваарын түлхүүрүүдийг ашиглахад тавигдсан тэнгэрлэг хязгаарлалт Сүмийн захиргааны асуудлууд дээрх шийдвэрүүд болон санваарт нөлөөлөх шийдвэрүүдийн хоорондох чухал ялгааг тайлбарладаг. Сүмийг тэргүүлж байдаг Тэргүүн Зөвлөл, Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёрын

чуулгын зөвлөл Сүмийн барилгуудын байршил, номлолд үйлчлэх нас зэрэг Сүмийн бодлого, журмуудад хамаатай олон шийдвэр гаргахаар итгэмжлэгдсэн байдаг. Хэдийгээр эдгээр удирдах эрх мэдэлтэн энэ эрин үед хүмүүнд өгөгдсөн бүх түлхүүрийг атгаж ашигладаг ч санваарыг зөвхөн эрэгтэй хүн атгах ёстой гэсэн тэнгэрлэгээр тогтоогдсон загварыг өөрчлөх эрхгүй.



Аароны санваартан миний үүргүүд юу вэ?

Санваарт томилогдсон эрэгтэй бүр “өөрийн үүргийг мэдэж,” “...бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг” (С ба Г 107:99) хэмээн Их Эзэн хэлсэн билээ. Аароны санваартан бид санваарын ёслолуудыг гүйцэтгэн, бусдад үйлчилж, бүхнийг Христэд ирэхэд урих ёстой.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба материалуудыг залбирч судал. Залуу эрэгтэйчүүдэд үүргээ ойлгоход нь туслах юуг та тэдэнтэй хуваалцаж болох вэ?

С ба Г 20:46–59; 84:111 (Аароны санваартнууд ёслолуудыг гүйцэтгэж, Христэд ирэхэд бүхнийг урьдаг)

Хэнри Б.Айринг, “Та нар уг ажилд ганцаараа биш,” *Ensign* эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 80–83

С ба Г 84:33–34; 107:99 (Аароны санваартнууд үүргүүддээ суралцаж, тэдгээрийг итгэлтэйгээр биелүүлдэг байх ёстой)

Хэнри Б.Айринг, “Санваартан эрэгтэй,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар

С ба Г 107:68 (Аароны санваартнууд материаллаг зүйлсийг зохицуулахад нь бишопт тусалснаар бусдад үйлчилдэг)

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 22–23, 46–47, 70–71

Аароны санваарыг анх авахад ямар санагдаж байсан тухайгаа бод. Энэхүү эрх мэдэлтэй байна гэдэг нь таны хувьд юу гэсэн үг байсан бэ? Санваартай болсон нь бодол санаа, үйлдлүүдэд чинь хэрхэн нөлөөлсөн бэ?

Аароны санваартнуудын олонх нь ариун ёслолыг гүйцэтгэх үүргээ мэддэг ч бусдад үйлчлэх, Христэд ирэхэд бүхнийг урих үүргээ мэдэхгүй байж болох юм. Залуу эрэгтэйчүүдэд санваарын бүх үүргээ мэддэг байж, тэдгээрийг биелүүлэхэд туслахын тулд та юу хийж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэдэнд ямар асуултууд байна вэ? Тэд өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлсэн үү?
- “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номонд зөвлөмж

болгосон “Санваарын ёслолуудыг гүйцэтгэх,” “Бусдад үйлчлэх,” “Бүх хүнийг Христэд ирэхэд урих” гэсэн санваарын гурван үүргийг самбар дээр бич. Хичээлийн явцад энэ жагсаалтыг ашиглаж, залуу эрэгтэйчүүдийн хэлсэн бусад үүргийг жагсаалтад нэмж оруул.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь Аароны санваарын үүргүүдээ ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонго:

- Залуу эрэгтэйчүүдийг Тэнгэрлэг Эцэгээс тусламж хүлээн авч байсан туршлагаасаа цаасан дээр бичихэд урь. Цааснуудыг саванд хийн, дундаас нь нэгийг сонгож, ангийнхандаа уншиж өгөхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Түүнчлэн тэд ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Та нар уг ажилд ганцаараа биш” хэлсэн үгэн дэх түүхийг бичээд, саванд хийж болно. Эдгээр түүх, туршлага нь Их Эзэн тэдний санваарын үйлчлэлд хэрхэн тусалдаг тухай ямар зүйлийг залуу эрэгтэйчүүдэд зааж байна вэ?
- Чуулгын зарим гишүүн Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь төлөвлөгөөнийхөө “Санваарын

үүргүүд” (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, 23–29, 46–53, 70–77-р хуудсуудыг үзнэ үү) дээр ажиллаж байж болно. Тэднээс нэг юм уу хоёрыг нь туршлагаасаа хуваалцахад урь.

- С ба Г 20:46–59 ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (22-23, 46–47, 70–71-р хуудсуудыг) номоос санваарын үүргүүдийн тухай уншихад залуу эрэгтэйчүүдийг урь. Санваарын үүргүүдээ олж мэдэн, самбар дээр жагсаан бичихийг тэднээс хүс. Урьд нь мэддэггүй байсан санваарын ямар үүргүүдийг мэдсэнийг залуу эрэгтэйчүүдээс асуу. Тэд эдгээр үүргээ биелүүлэхийн тулд юу хийж болох вэ?

Заахад туслах арга

“Та заахаар бэлтгэх үедээ залбирвал, зарим нэг зарчим дээр онцгой анхаарал хандуулах хэрэгтэй хэмээн сүнслэгээр нөлөөлөгдөж болох юм. Тодорхой санаануудыг хэрхэн хамгийн үр өгөөжтэй заах талаар ойлголттой болж болно. Хичээл заахад тань туслах жишээ, үзүүлэнт хичээл, сүнслэг нөлөө бүхий амьдралын энгийн түүхүүд санаанд тань орж ирж болох юм. Хичээлд тань туслах хэн нэгэн тодорхой хүнийг урих санаа төрж болно. Хуваалцаж болох хувийн туршлагаа та нар санаж ч болно”.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа бүх талаараа үлгэр дуурайл үзүүлж, тэдний халамжлан хүмүүжүүлэгч болдог байлаа. Тэр тэдэнтэй хамт залбирдаг байснаараа хэрхэн залбирахыг тэдэнд заадаг байв. Тэр тэднийг хайрлаж, тэдэнд үйлчилснээр бусдыг хайрлаж, үйлчлэхийг тэдэнд заадаг байлаа. Тэр Өөрийнхөө арга барилаар сайн мэдээг хэрхэн заахыг тэдэнд заадаг байв. Аврагчийн заадаг арга барилаар тэдэнд сайн мэдээг зааснаар үүргээ биелүүлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд тусал.

- Судруудыг судалж, санваарын үүргүүдээ биелүүлдэг байсан хүмүүсийн жишээг олоход залуу эрэгтэйчүүдийг урь (жишээ нь, Матай 3:1–6, 13–17; Иаков 1:18–19; Алма 15:16–18; 3 Нифай 18:1–5). Судрын жишээ бүр нь *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын дараах төрлүүдийн алинд нь хамаарахыг тогтоо (“Санваарын ёслолуудыг гүйцэтгэх,” “Бусдад үйлчлэх,” “Бүх хүнийг Христэд ирэхэд урих”). Эдгээр судар дахь хүмүүс санваарын үйлчлэлээр дамжуулан хэрхэн адислагдсан бэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд өөрсдийн санваарын үүрэг хариуцлагыг илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Цуглааныг хөтөлж байгаа чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн цуглааныг хаана. Тэрээр:

- “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номынхоо “Санваарын үүргүүд” хэсгийн аль нэгнээр нь төлөвлөгөө гаргаж, төлөвлөсөн зүйлээ бие биетэйгээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.
- Санваарын үүргүүдийн талаар мэдсэн ямар нэг зүйлээ гэр бүлийнхээ аль нэг гишүүнтэй хуваалцах даалгаврыг чуулгын гишүүдэд өг.



Би яагаад номлолд үйлчлэх ёстой вэ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Зохистой, чадвартай залуу эрэгтэй бүр номлолд үйлчлэхээр бэлтгэх ёстой. Бидэнд үй олон адислалыг үргэлж өгч байдаг Их Эзэн биднээс санваарын үүрэг, хариуцлагаа биелүүлэхийг маш ихээр хүсэн хүлээдэг. Залуу эрэгтэйчүүд ээ, номлогч болж үйлчлэхэд бэлтгэхийг би та бүхэнд зөвлөж байна” гэж хэлсэн (“Биднийг дахин уулзтал” *Ensign* эсвэл *Лиахона* 2010 оны 11-р сар, 5–6).

Та өөрөө эсвэл таньдаг хэн нэгэн тань бүрэн цагийн номлолд үйлчилсэн тухай бод. Номлолд үйлчилсний ачаар ямар адислалууд амьдралд тань ирсэн бэ?

Залуу эрэгтэйчүүд сайн мэдээг бусадтай хуваалцах ямар туршлагатай болсон бэ? Номлолд үйлчлэх хүслийг нь нэмэгдүүлэхэд Аароны санваартнуудад туслахын тулд та юу хийж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба суралцах материалуудыг залбиралтайгаар судлаарай. Номлолын үйлчлэлд бэлтгэхэд нь залуу эрэгтэйчүүдэд юу сүнслэг нөлөө үзүүлж чадна гэж та боддог вэ?

Матай 28:19–20; С ба Г 50:13–14; 88:81 (Бид сайн мэдээг хуваалцах үүрэгтэй)

С ба Г 4 (Биднийг Их Эзэнд үйлчлэхэд тэнцэхээр болгодог зан чанарууд)

С ба Г 18:9–16 (Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу юм)

Нэйл Л.Андэрсэн “Хоёрдахь ирэлтэд дэлхийг бэлтгэх нь” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 49–52; мөн “Номлолын тань өдөр” видео бичлэгийг үзнэ үү.

В.Кристофер Уоддэл “Насан туршийн боломж” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11-р сар, 50–52

Видео бичлэг: “Номлолын ажил: Санваарын үүрэг”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс аль болох олон зүйлийг санахыг хичээж, санасан зүйлсээ бичиж тэмдэглэхэд нэг минут орчим хугацаа зориулахыг залуу эрэгтэй бүрээс хүс. Бичсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс.
- Залуу эрэгтэйчүүдийг бүлгүүд болгон хувааж, “Би яагаад бүрэн цагийн номлолд үйлчлэх ёстой вэ?” гэсэн асуултын хариултуудыг ярилц. Бүлэг бүрээс нэг хүнийг бүлгийнхээ хариултуудаас хэдийг самбар дээр бичихэд урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь тэд яагаад номлолд үйлчлэх ёстойг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг Сургаал ба Гэрээ 18:9–16-г тус тусдаа уншиж, “Их Эзэн санваартнуудад яагаад сайн мэдээг хуваалцах үүргийг хариуцуулсан бэ?” гэсэн асуултад хариулахад урь. Энэ асуултын хариултыг чуулгатайгаа хуваалцахад тэднээс хэдийг нь урь. Бодгалийн үнэ цэнэ яагаад Бурханы мэлмийд агуу байдаг вэ? Залуу эрэгтэйчүүд чуулгатай сайн мэдээг хуваалцсаны үр дүнд ямар туршлагатай болох вэ?
- Энэ тоймд санал болгосон судруудаас нэгийг эсвэл нэгээс олныг хамтдаа уншиж, хэрэв хүн бүр сайн мэдээний тухай мэддэг байж, түүгээр амьдардаг бол дэлхий хэрхэн өөр байх байсан гэж боддогийг нь залуу эрэгтэйчүүдээс асуу. Бид сайн мэдээгээр амьдарч байгаа үед дэлхий дэх ямар асуудал, сорилт бэрхшээлүүд шийдвэрлэгдэж болох вэ? Сайн мэдээний ачаар амьдрал тань хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Ахлагч Нийл Л.Андэрсэний “Хоёрдахь Ирэлтэд дэлхийг бэлтгэх нь” хэлсэн үгэн дэх Сид Гойнгийн туршлагыг чуулгаараа унш. Залуу эрэгтэйчүүдэд номлолд явахад нь саад учруулж болох зарим зүйлсийг жагсаан бичихийг чуулгын

Заахад туслах арга

Чадварлаг багш “Өнөөдөр би хичээл дээрээ юу хийх билээ?” гэж боддоггүй эсвэл “Өнөөдөр миний сурагчид хичээл дээр юу хийх билээ?” “Өнөөдөр би юу заах билээ?” гэж асуудаггүй, харин “Сурагчдадаа хэрэгтэй зүйлийг нээж мэдэхэд нь би тэдэнд хэрхэн туслах билээ?” хэмээн асуудаг (Виржина Х.Пийрс *Teaching, No Greater Call* [1999], 61).

гишүүдээс хүс. Энэ жагсаалтыг номлолын үйлчлэлээс ирдэг агуу адислалуудтай харьцуулж үзэхэд тэдэнд тусал.

- Энэхүү суралцах тоймын нэрний асуултыг самбарт бич. Чуулгын гишүүдийг Сургаал ба Гэрээ 4:2–4-ийг эсвэл Ахлагч Рассэл М.Нэлсоны дараах үгсийг уншиж, энэ асуултын хариуг олоход урь: “Номлолд үйлчлэх шийдвэр нь номлогчийн сүнслэг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахад урь. Тэд яагаад номлолд үйлчлэх ёстойгоо ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэхийн тулд одоо юу хийж байгаагаа хуваалцаж болно.
- Дараагийн хэдэн сарын дотор Сургаал ба Гэрээ 4-ийг цээжлэх зорилго тавьж ажиллахыг чуулгын бүх гишүүнээс хүсэж болно.
- *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь ном (87–88-р хуудас) дахь бүрэн цагийн номлолд бэлтгэх үйл ажиллагаануудын нэгийг хийхэд чуулгын гишүүдийг урь.*

амьдралд, эхнэр буюу нөхөрт нь, үр хүүхэд хойч үеийнхэнд нь нөлөөлөх болно. Үйлчлэх хүсэл нь тухайн хүний хөрвөлт, зохистой байдал, бэлтгэлийн зүй ёсны үр дүн мөн” (“Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!” *Ensign* эсвэл *Лиакхона* 2012 оны 11-р сар). Номлолын үйлчлэл амьдралыг нь хэрхэн адисалсан тухай чуулгатай хуваалцахад буцаж ирсэн номлогчийг бишопоос зөвшөөрөл авч урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нараа итгэлээрээ үйлдэж, Өөрийнхөө заасан үнэнүүдээр амьдрахад урьдаг байлаа. Өөрсдийнхөө туршлагаас суралцах боломжийг Тэрбээр шавь нартаа олгодог байлаа (Лук 5:1–11-ийг үзнэ үү). Бүрэн цагийн номлолд үйлчлэх хүсэлд нь урам дэм өгөх юуг одоо залуу эрэгтэйчүүд хийж болох вэ?

Сонгосон материалууд

Нийл Л.Андэрсэн “Дэлхийг хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь” хэлсэн үгээс эш татав. *Ensign* эсвэл Лиахона 2011 оны 5 –р сар, 49–52

Рагби гэдэг спортыг сонирхогчид Шинэ Зеландын “Оол Блэкс” буюу “Тас хар” багийг андахгүй. Уг нэр нь тэдний өмсгөлөөс үүдэлтэй бөгөөд рагбигийн хамгийн алдартай баг юм. [stats.allblacks.com –г үзнэ үү.] Шинэ Зеландад “Оол Блэкс” багт тоглохоор сонгогдоно гэдэг нь америк хөл бөмбөгийн аварга багт тоглох эсвэл хөл бөмбөгийн Дэлхийн Цомын аварга багт тоглохтой адил юм.

Сидни Гөинг ах 1961 онд 18 настай Аароны санваартан байхдаа Шинэ Зеландын рагбигийн од болж эхэлсэн. Тэр маш чадварлаг тоглогч байсан учир олон хүн түүнийг дараа жил үндэсний “Оол Блэкс” шигшээ багт сонгогдоно гэж таамаглаж байв.

Мэргэжлийн рагбигийн зиндаа ахих чухал мөчид 19 настай Сид рагбиг орхиж номлолд явна гэдгээ мэдэгдсэн юм. Зарим хүн түүнийг галзуурсан, зарим нь түүнийг тэнэг гэж хэлж байлаа. [Боб Ховитт, *Super Sid: The Story of a Great All Black* (1978), 27.] Тэд ийм алтан боломж ахиж хэзээ ч ирэхгүй гэж халаглаж байлаа.

Сидийн хувьд орхиж байгаа зүйл нь биш харин ирээдүйн боломж, үүрэг хариуцлага нь чухал байсан юм. Тэр Их Эзэн Есүс Христийн үнэнийг тунхаглахаар амьдралынхаа 2 жилийг зориулах санваарын үүрэгтэй байсан. Энэхүү үүргээ биелүүлэхэд нь түүнийг юу ч, бүр үндэсний шигшээ багт тоглон нэр хүндтэй болох явдал ч зогсоогоогүй юм. [Phone conversation with President Maxwell Horsford, Kaikohe New Zealand Stake, Mar. 2011.]

Тэрээр Канадын Баруун Номлолд үйлчлэх дуудлага хүлээн авч, одоогоос яг дөчин найман

жилийн өмнө энэ сард 19 настай ахлагч Сидни Гөинг Шинэ Зеландыг орхиж Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогч болж байлаа.

Номлолдоо тохиолдсон нэг түүхийг Сид надад ярьж билээ. Орой болж хамтрагчтайгаа гэр рүүгээ харих үедээ дахиад нэг айлаар орохоор шийдэв. Гэрийн эзэн тэднийг гэртээ урихад ахлагч Гөинг болон хамтрагч нь тэдэнтэй Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцжээ. Номлогчид тэдэнд Мормоны Ном бэлэглэв. Гэрийн Эзэн Мормоны Номыг шөнөжингөө уншсан бөгөөд 10 хоногийн дотор Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувдыг уншиж дуусгажээ. Хэдэн долоо хоногийн дараа гэр бүлээрээ баптисм хүртсэн гэнэ. [Phone conversation with Elder Sidney Going, Mar. 2011.]

“Оол Блэкс” багийн оронд номлолыг сонголоо гэж үү? хэмээх асуултад Сид: “Бусдыг сургаалд авчирснаас ирэх адислал нь ямар ч золиослолоос илүү байдаг” гэж хариулсан ажээ. [E-mail correspondence from Elder Sidney Going, Mar. 2011.]

Сидни Гөингийн номлолын дараа юу болсон талаар та нар сонирхож байгаа байх л даа. Хамгийн чухал нь тэрээр хайрт гэргий Коллийнтайгаа гэрлэж, таван сайхан хүүхэдтэй, олон ач зээ нартай болсон. Тэрээр амьдралынхаа турш Тэнгэрлэг Эцэгт итгэн найдаж, зарлигуудыг нь дагаж, бусдад үйлчилжээ.

Харин рагбигийн хувьд гэвэл номлолынхоо дараа Сид Гөинг “Оол Блэкс”-ын түүхэн дэх хамгийн агуу тоглогчдын нэг болж 11 улирал тоглосон бөгөөд олон жил багийн ахлагчаар тогложээ. [stats.allblacks.com/asp/profile.asp?ABID=324 –г үз.]

Сонгосон материалууд

Сидни Гөинг хэр зэрэг сайн тоглогч байсан юм бол? Тэр үнэхээр сайн байсан учир түүнийг Ням гарагт тоглохгүй гэхэд бэлтгэл болон тэмцээний хуваарийг түүний цагт тохируулан өөрчилж байжээ. [Phone conversation with President Maxwell Horsford, Kaikohe New Zealand Stake, Mar. 2011.] Тэрээр үнэхээр сайн байсан тул Английн Хатан хаан түүний рагбид оруулсан хувь нэмрийг нь үнэлжээ. [1978 онд Сидни Гөинг –ийн рагби спортод оруулсан хувь нэмрийг үнэлэн МВЕ (Member of the Order of the British Empire) Британий Эзэнт Гүрний Одонгоор шагнасан. (Ховитт, *Супер Сид*, 265 –г үз.)] Тэрээр

үнэхээр гарамгай байсан болохоор түүний тухай “Супер Сид” хэмээх ном хүртэл бичигдсэн юм.

Энэхүү нэр хүнд болон амжилт Сидийн номлолын дараа ирээгүй бол яах байсан бол? Энэ Сүмийн номлолын үйлчлэлийн нэгэн гайхамшиг бол Сид болон түүнтэй адил мянга мянган номлогч “Би номлол хийснээр юу авах вэ?” биш харин “Би юу өгч чадах вэ?” гэж асуудагт байгаа юм.

Та нарын номлол бол хүмүүсийг Христэд авчирч Аврагчийн хоёр дахь ирэлтэд бэлтгэх ариун үйлчлэл байх болно.



Сүмийн удирдагчдаа дэмжинэ гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Сүмийн гишүүд бидний хувьд Их Эзэний үйлчлэл хийлгэхээр дуудсан хүмүүсийг дэмжих боломжтой байдаг. Бид ерөнхий эрх мэдэлтэн, Сүмийн албан тушаалтан, Аароны санваарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийг оролцуулан тойрог, гадсан дахь удирдагч бүрийг дэмжиж байгаагаа илэрхийлж, гараа өргөдөг. Удирдагчдаа дэмжинэ гэдэг нь зөвхөн гар өргөх төдий зүйл биш бөгөөд тэднийг дэмжин тусалж, тэдний төлөө залбирч, өгөх үүрэг даалгавар хийгээд дуудлагыг хүлээн авч, зөвлөгөөг нь сонсож, тэднийг шүүмжлэхээс зайлсхийнэ гэсэн үг юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Чуулгын гишүүдийг Сүмийн удирдагчдаа дэмжихэд юу урамшуулан дэмжих вэ?

Египетээс Гарсан нь 17:8–12 (Аарон, Хур хоёр Мосегийн гарыг өргөсөн нь)

С ба Г 21:1–6; 124:45–46 (Их Эзэний үйлчлэгчдийн дуу хоолойг сонсдог хүмүүс адислагдах болно)

Нифай 18:9-14; С ба Г 84:23–25 (Удирдагчдаа эсэргүүцсэн хүмүүсийн жишээ)

Хаадын Дээд 17:8-16; Хаадын дэд 5:8-14 (Удирдагчдаа дэмжсэн хүмүүсийн жишээ)

Хэнри Б.Айринг, “Бурханаас дуудагдаж, хүмүүсээр дэмжигдсэн,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 6-р сар, 4–5

Жэймс И.Фауст, “Дуудагдагсад ба сонгогдогсад,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 11-р сар, 53–55

Рассэлл М.Нэлсон, “Бошиглогчдыг дэмжин батлах нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 74-77

Та Сүмийн удирдагчдыг дэмжихийн тулд юу хийдэг вэ? Та үүнийг хийснээрээ хэрхэн адислагдсан бэ?

Аароны санваартнууд бишоп эсвэл чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд зэрэг Сүмийн удирдагчдыг дэмжиж байгааг та хэзээ харсан бэ? Тэд бие биетэйгээ ямар туршлага хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногт суралцсан зүйлсээ хэрэгжүүлэхийн тулд юу хийснийг асуу. Тэдэнд ярилцсан зүйлсийнх нь талаар ямар нэгэн асуулт эсвэл санаа бодол байна уу?
- Энэ хичээлийн нэрийг самбар дээр бичээд, дэмжих гэдэг үгтэй

ижил утгатай үгсийг бодож олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Дараа нь тэднийг чуулгынхаа ерөнхийлөгчийн зөвлөлийг оролцуулан тойргийн удирдагчдын нэрсийг самбар дээр жагсааж бичихэд урь. Залуу эрэгтэйчүүд тэдгээр хүнийг дэмжихийн тулд юу хийж байна вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь Сүмийн удирдагчдыг дэмжих гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоход чуулгын гишүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Чуулгын цуглааны өмнө залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Расселл М.Нэлсоний “Бошиглогчдыг дэмжин батлах нь” хэлсэн үгийг уншаад, үүнээс ерөнхийлөгч Томас С.Монсонг дэмжин батлахад юу тэдэнд сүнслэгээр нөлөөлсөн талаар хуваалцахаар бэлдэж ирэхэд урь.
- Чуулгыг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрд ерөнхийлөгч Жэймс И.Фаустын “Дуудагдагсад ба сонгогдогсад” хэлсэн үгээс, эсвэл Сургаал ба Гэрээ 124:45-46-р шүлгээс хэсэгчлэн хуваарилж өг. Тэднээс удирдагчдаа дэмждэг хүмүүст амлагдсан амлалтыг болон дэмждэггүй хүмүүст өгөгдсөн анхааруулгыг

олж уншихыг хүс. Тэднийг олсон зүйлээ хуваалцаж, уг үгнээс эдгээр адислал ба анхааруулгыг харуулж буй түүхүүдийг хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг дор дороо Египетээс Гарсан нь 17:8-12-ыг уншаад, уг түүхийг өөрийн үгээр товчлон ярьж өгөхийг тэдний нэгээс хүс. Бид Сүмийн удирдагчдаа дэмжихтэй энэ түүх хэрхэн холбогдож байна вэ? Чуулгынхаа ерөнхийлөгчийг болон бусад удирдагчаа дэмжих үед бид Аарон, Хур хоёртой юугаараа адил байдаг вэ?
- Судраас Лемең, Лемүел хоёр (1 Нифай 18:9-14-ийг үзнэ үү),

Заахад туслах арга

“Суралцагчдыг асуултуудад хариулахад бэлтгэхэд нь туслахын тулд та тэдэнд ямар нэгэн зүйлийг унших юмуу үзүүлэхээсээ өмнө тэдний хариултыг сонсоно гэдгээ хэлж болно. ... Жишээ нь, та ‘Намайг энэ хэсгийг уншиж байхад үүний юу нь та нарын сонирхлыг татсан тухай хуваалцахын тулд сонсоорой’ гэх юмуу, ‘Энэ судрыг уншиж байхад, Их Эзэн итгэлийн тухай бидэнд юу хэлж байгааг ойлгож байгаа эсэхээ шалгаарай’ гэж хэлж болно” (Teaching, No Greater Call [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн шавь нарт итгэж, тэднийг бэлтгэж, мөн бусдад зааж, үйлчлэх чухал хариуцлагуудыг тэдэнд өгсөн юм. Тэрээр энэхүү замаар Өөрийн сайн мэдээнд илүү гүн гүнзгий хөрвөхөд тэдэнд тусалсан. Та Аароны санваартнуудын зөвлөхийн хувьд Аврагчийн жишээг хэрхэн дагаж чадах вэ?

эсвэл Израилийн хүүхдүүд (С ба Г 84:23-25-ыг үзнэ үү) гэх мэт удирдагчаа эсэргүүцсэн хүмүүсийн жишээг олоход залуу эрэгтэйчүүдийн заримыг урь. Үлдсэн залуу эрэгтэйчүүдийг Зарефатын бэлэвсэн эхнэр (Хаадын Дээд 17:8-16-г үзнэ үү), эсвэл Нааман (Хаадын Дэд 5:8-14) гэх мэт удирдагчаа дагасан хүмүүсийн жишээг олохыг хүс. Тэднээс олсон түүхээсээ хуваалцаж, Сүмийн удирдагчдаа хүндэтгэх эсвэл эсэргүүцэхийн үр дагаврын талаар юу зааж байгааг тайлбарлахыг хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд Сүмийн удирдагчдыг дэмжих гэдэг нь ямар утгатайг ойлгож байна уу? Тэдэнд ямар мэдрэмж эсвэл сэтгэгдэл төрсөн бэ? Тэдэнд өөр нэмэлт асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Удирдаж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлүүлнэ. Тэрээр:

- Тухайн үед тэргүүлэхээр дуудагдсан санваарын удирдагчдын талаар санал бодлоо хуваалцаж болно.
- Сүмийн удирдагчдаа бүрэн дүүрэн дэмжихийн тулд чуулгын гишүүд юу хийж болох тухай товч ярилцлага хөтлөн явуулж болно.

“Бурханаар дуудагдаж, хүмүүсээр дэмжигдсэн нь” өгүүллийг уншин, Сүмийн удирдагчдаа дэмжих арга замын талаарх жишээнүүдийг олоход урь. Сүмийн сэтгүүлүүдийг авчирч, Сүмийн удирдагчдыг дэмжих арга замуудыг харуулж буй зургуудыг олж, хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Чуулгынхаа ерөнхийлөгчийн зөвлөлийг, мөн бусад удирдагчаа дэмжихийн тулд залуу эрэгтэйчүүд юу хийдэг вэ? Хэн нэгэн хүн удирдагчийг нь шүүмжилж байгааг сонсох юм бол тэд юу хэлж болох вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Бурханаас дуудагдаж, хүмүүсээр дэмжигдсэн” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиакхона, 2012 оны 6-р сар, 4–5

Олон жилийн өмнө 18 настай нэг оюутан Их Эзэний үйлчлэгчдийг дэмжин батлах гэдэг нь юу гэсэн үг болохыг надад харуулсан юм. Би өдийг хүртэл түүний даруухан үлгэр жишээгээр адислагдсан хэвээр байгаа билээ.

Тэр коллежид дөнгөж элсэж орсон байв. Тэрээр нэгэн сайн их сургуульд сурахаар гэрээсээ хол явахаасаа жил хүрэхгүйн өмнө баптисм хүртсэн юм. Тэнд би бишпоор үйлчилж байлаа. ...

Тэр надтай миний албан тасалгаанд уулзахыг хүссэн юм. “Хоёул хамт залбиръя, би залбирч болох уу?” гэж түүнийг асуухад би их гайхаж билээ. ...

Тэр бишоп Бурханаас дуудагдсаныг би мэднэ хэмээн өөрийн гэрчлэлээр залбирлаа эхэллээ. Хийх ёстой сүнсний агуу үр нөлөөтэй зүйлсийг бишопт хэлж өгнө үү хэмээн тэр Бурханаас гуйлаа. Бишоп өөрийнх нь хэрэгцээг сайн мэдэж байгаа бөгөөд түүнд хэрэгтэй зөвлөгөөг өгнө гэдгийг мэдэж байгаагаа тэр Бурханд хэлэв.

Түүнийг залбирлын үгээ хэлж байх үед түүнд аюул учрах юм шиг надад санагдав. Үргэлж залбирч, зарлигуудыг сахь, бүү ай хэмээх энгийн мөртлөө маш тодорхой зөвлөгөөг би түүнд өгсөн.

Сүмд нэг жил болсон залуу өөрийнх нь дэмжин баталсан бөгөөд хүмүүсийн итгэл, залбирлаар тэднийг удирдахаар дуудагдсан удирдагчдад Бурхан хэрхэн ханддагийг үлгэр жишээгээр заалгасан байлаа. Тэр залуу Сүм дэх нийтийн дэмжлэгийн хуулийн хүчийг

надад харуулсан юм (С ба Г 26:2-ыг үз). Их Эзэн Өөрийн үйлчлэгчдийг илчлэлтээр дууддаг ч, үйлчлэхээр дуудагдсан хүмүүс нь тэднийг дэмжин баталсны дараа л тэд үйлчилж эхэлдэг.

Бид дэмжин батлах санал өгснөөрөө хүндтэй амлалт өгдөг. Энэ нь Их Эзэний үйлчлэгчдийн төлөө, Тэр тэднийг удирдан, тэдэнд хүч чадал өгч байхын төлөө залбирах амлалт юм (С ба Г 93:51-ийг үз). Тэд дуудлагынхаа дагуу үйлчлэх бүрдээ Бурханаас сүнсний удирдамж авдаг байхыг бид хүсэн хүлээж, үүний төлөө залбирахаа амладаг (С ба Г 1:38-ыг үз).

Бид энэхүү амлалтаа зүрх сэтгэлдээ байнга шинэчилж байх ёстой. Ням гарагийн ангийн багш тань Сүнсээр заахыг хичээхдээ тангтай л адил ангийнхаа өмнө алдаа гаргаж болно. Гэвч та сүнсний удирдамжийг мэдрэх хүртлээ түүнийг тэвчээртэйгээр анхааралтай сонсож чадна. Цаг хугацаа өнгөрөх тусам танд улам цөөн алдаа ажиглагдаж, Бурхан тэр багшийг дэмжиж байгааг та мэдэх болно.

Бид хэн нэгнийг дэмжихээр гараа өргөхдөө Их Эзэн тэр хүнээр хийлгэх ажилд нь бүх талаар тусалж, дэмжинэ хэмээн амладаг. Манай хүүхдүүдийг бага байхад эхнэр маань тойргийнхоо бага насны хүүхдүүдэд заахаар дуудагдаж билээ. Би эхнэрээ дуудлагад нь дэмжихээр гараа өргөсөн төдийгүй бас түүний төлөө залбирч, түүнд тусалж байх зөвшөөрөл хүссэн. Эмэгтэйчүүдийн хийдэг ажил, хүүхдүүдийг хайрладаг Их Эзэний хайрын тухай тэр үед сурсан зүйлс маань манай гэр бүлийг болон эхнэрийн минь амьдралыг өдий хүртэл адисалсаар байгаа билээ.

Сонгосон материалууд

Бишопьгоо олон жилийн өмнө дэмжин баталсан өнөөх залуутай би саяхан ярилцсан. Их Эзэн болон хүмүүс түүнийг номлогчийн, гадасны ерөнхийлөгчийн, тэрчлэн аавын дуудлагад нь дэмжин баталсныг би мэдсэн. Бидний ярианы төгсгөлд тэрээр, “Би одоо ч гэсэн таны төлөө өдөр бүр залбирдаг” гэж билээ.

Бидэнд үйлчлэхээр Бурханаар дуудагдсан хэн нэгний төлөө бид өдөр бүр залбирч чадна.

Үйлчлэлээрээ биднийг адисалсан хүнд бид талархал илэрхийлж чадна. Бидний дэмжин баталсан хэн нэгэнд сайн дурынхан хэрэгтэй болбол бид түүн рүү очиж чадна.¹

Их Эзэний үйлчлэгчдийг Түүний хаант улсад өргөн дэмждэг хүмүүсийг Түүний юутай ч зүйрлэшгүй хүч урам хайрлан дэмжих болно. Энэ адислал бид бүгдэд хэрэгтэй.

Долоодугаар сар: Ёслолууд ба гэрээнүүд

“Ёслолуудад ... бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг” (С ба Г 84:20).

Энэхүү бүлгийн тоймууд нь залуу эрэгтэйчүүдэд санваарын ёслолууд ба гэрээнүүдийг ойлгоход тусална. Энэ бүлгээс олж авсан туршлагауд нь тэдэнд аль хэдийн хийсэн гэрээнүүддээ болон ирээдүйд хүлээн авах ёслолууд болох Мелкизедек санваар болон ариун сүмийн ёслолуудад илүү талархалтай, хүндэтгэлтэй хандахад тусална. Үүнээс гадна аароны санваартнууд нь сайн мэдээний ёслолуудыг ойлгох нь онцгой хэрэгцээтэй байдаг. Учир нь тэд ариун ёслол, баптисмын ёслолуудыг гүйцэтгэх мөн Аароны санваарын албанд бусдыг томилох зэрэг ёслолуудыг гүйцэтгэхээр дуудагддаг.

Энэ сард сонгох тоймууд:

Би бусдыг ариун ёслолын утга учиртай туршлагатай болоход нь хэрхэн тусалж чадах вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Миний амьдралд ёслолууд яагаад чухал вэ?

Миний амьдралд гэрээнүүд яагаад чухал вэ?

Би баптисм хүртэхдээ ямар гэрээнүүд хийсэн бэ?

Би Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээн авдаг вэ?

Ариун сүмийн ёслолууд яагаад чухал вэ?

Санваарын тангараг ба гэрээ гэж юу вэ?

Есүс Христийн нэрийг өөр дээрээ авна гэдэг нь ямар утга учиртай вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон, үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны вэбсайт танд туслах боломжтой.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд ч бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон төлөвлөхдөө чуулгын ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Санваарын ёслолуудыг гүйцэтгэ,” 24–25, 48–49,
72–73-р хуудас

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас



Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би бусдыг ариун ёслолын утга учиртай туршлагатай болоход нь хэрхэн тусалж чадах вэ?

Ариун ёслолын талаар суралцсанаар ариун ёслол нь тэдний хувьд ямар утга учиртайг тунгаан бодож мөн сурч байгаа зүйлийнхээ талаар бусдад заах арга замуудыг төлөвлөснөөр энэхүү хичээлд өөрсдийгөө сүнслэгээр бэлтгэхэд чуулгын гишүүдийг урамшуулан дэмж. Наад зах нь долоо хоногийн өмнөөс бэлтгэж эхлэхийг уриад, дараа нь долоо хоногийн дундуур чуулгын гишүүдэд сануулахаар холбоо барих нь хамгийн үр дүнтэй байх болно.

Би Ариун ёслолыг өөрийнхөө хувьд хэрхэн илүү утга учиртай болгох вэ? хэмээх ням гаргийн хичээлийн тойм нь энэхүү хичээлд зориулсан сайн бэлтгэл болж чадна. Та чуулгын гишүүдийн ням гаргийн ангийн багштай зохицож болох бөгөөд тэд ням гаргийн анги дээрээ ариун ёслолын талаар суралцсаны дараа үүний талаар хэлэлцүүлэг явуулахаар төлөвлөж болно.

Аврагч дагалдагчдаа Түүнийг дурсан санах мөн ариун гэрээнүүдээ долоо хоног бүр шинэчлэх арга зам болгон ариун ёслолыг танилцуулсан юм. Ариун ёслол нь бидний өмнөөс хийгдсэн Цагаатгал болох Есүс Христийн бие махбод болон цусны золиослолыг бэлгэддэг. Эдгээр шалтгаанаар ариун ёслолын цуглаан нь хамгийн ариун нандин байдаг ба энэ нь хүндэтгэл бишрэлийн тусгал бөгөөд хүчирхэг сүнслэг шинэчлэлийн цаг байх ёстой. Бид аароны санваартны хувьд цугларсан гишүүдэд ариун ёслолын сүнслэг туршлага олж авахад нь туслах боломж байдаг. Бидний зохистой байдал, үлгэр жишээ болон гэрчлэл маань тэдний туршлагад нөлөөлж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Чуулгын цуглаан болохоос хэдэн өдрийн өмнө чуулгын гишүүдийг ариун ёслолын талаар бусдад заахдаа ашиглаж болох богино хэмжээний тойм бэлдэхэд мөн чуулгын цуглаандаа тоймуудаа авчрахад тэднийг урь. (Чуулгын гишүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь төлөвлөгөөндөө гэрээ болон ёслолуудын талаар суралцаж мөн заахдаа үүнийгээ оруулж болно. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх* нь 18, 42, 66-р хуудас.)

Чуулгын гишүүд тоймоо бэлтгэж байхдаа “Always Remember Him” видео бичлэг үзэж болно. Аврагч ариун ёслолыг танилцуулах үедээ өгсөн зорилгыг хайж, Матай 26:26–28-ыг болон түүний дотор зүүлт тайлбар болон Библийн лавлах хэсгээс үүнтэй холбоотой Иосеф Смитийн орчуулгыг мөн 3 Нифай 18:1–12-ыг уншихыг тэднээс хүс.

Тоймоо боловсруулж байхдаа тэд дараах асуултуудыг бодож үзэж болно:

- Ариун ёслолын зорилго юу вэ? Энэ нь юуг бэлгэддэг вэ?
- Бид хэрхэн Аврагчийг үргэлж дурсан санаж чадах вэ?
- Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
- Ариун ёслолоос хүртэхийн тулд бид хэрхэн өөрсдийгөө илүү сайн бэлтгэж болох вэ?
- Ариун ёслолыг адисалж байхдаа Аароны санваартнууд хэрхэн Аврагчийг төлөөлж чадах вэ?

Чуулгын цуглааныг хөтлөн явуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл пристийн чуулгын бишопын туслах) чуулгын цуглааныг удирдана. Чуулгын цуглааны хөтөлбөрөө урьдчилан бэлдэх нь тустай байх болно.

Суралцах үйл явцаа эхэл

Энэ долоо хоногийн хичээлийг заахдаа эдгээр санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүдийг цуглааны эхэнд ариун ёслолын залбирлыг С ба Г 20:77, 79 чимээгүй уншиж, ариун ёслолын дуртай дууллынхаа үгсийг бодох хэдэн минут зарцуулахад урина уу.
- Сургаал ба Гэрээ 11:21; 12:8; 42:14 гэх мэт судруудыг чуулгаараа тоймлон харж, Христийнхтэй адил заах зарчмуудыг товч дүгнэ. Өнөөдөр ариун ёслолын талаарх мэдрэмжүүдээ хуваалцахдаа эдгээр зарчмыг санахад чуулгын гишүүдийг урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Ариун ёслолын талаар бэлтгэсэн тоймуудаасаа нэг нэгэндээ (жижиг бүлэг болгон эсвэл чуулгаараа) заахад чуулгын гишүүдийг урь. Үүнийг хийснийх нь дараа гэрчлэлээ хуваалцаж байхдаа мэдэрсэн зүйлүүдээ ярилцахад нь тэднийг урь. Сурсан зүйлээ бусадтай хуваалцах нь яагаад чухал вэ?

Хэрэв залуу эрэгтэйчүүдийн зарим нь тоймоо бэлтгээгүй бол чуулгын цуглаан дээрээ “Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ” хэсгийн дор байгаа удирдамжийн дагуу бэлтгэх цаг гаргаж өг. Боломжтой бол тэдний заримд нь сурсан зүйлүүдээ бие биетэйгээ хуваалцах цаг олго.

Үйлдэхэд урь

Чуулгын гишүүдийг сурсан зүйлээ хуваалцахад нь урамшуулан дэмжихийн тулд дараах санаануудыг бодож үзнэ үү:

- Чуулгын гишүүн бүрийг ариун ёслолын сургаалын талаарх ойлголт болон гэрчлэлээ хуваалцаж болох хүмүүсээ тодорхойлоход урь. Жишээ нь: Өөрийн гэр бүл, идэвх султай чуулгын гишүүн, Залуу эмэгтэйчүүд, Хүүхдийн хэсгийн анги эсвэл гэрийн багшаар айлчилж очдог гэр бүлүүддээ зааж болно. Чуулгын гишүүн бүрээс хэнийг сонгосноо чуулгадаа хэлэхийг хүс. Гэрчлэлээ биечлэн хуваалцахаас гадна чуулгын гишүүд бас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хуваалцаж болно гэсэн санааг санал болгож болно.
- Чуулгын гишүүд тойргийнхоо цөөн хэдэн гэр бүл дээр зочилж очин, ариун ёслолын талаар заах боломжтой цагийг тохир. (Бишопын зөвлөлийн гишүүн эсвэл тойргийн

номлолын удирдагчид, шинэ хөрвөгчид, зарим сүмийн гишүүн гэр бүл эсвэл ариун ёслолын цуглаандаа тогтмол оролцдоггүй гэр бүлүүд гэх мэт ийм айлчлал хэрэгтэй байгаа гэр бүлүүдийг сонгоход тань тусалж болох юм.) Чуулгын ерөнхийлөгчийн тусламжтайгаар, чуулгын гишүүдийг хамтрал болгон зохион байгуулж, хамтрал бүрийг эдгээр гэр бүлийн нэгэнд айлчлан очиход томил. (Боломжтой бол долоо хоногийн турш чуулгын үйл ажиллагааг эдгээр айлчлалтай холбох хуваарь гарга. Өсвөр үеийнхний үйл ажиллагаанууд вэбсайт дээрх Сурсан зүйлээ бусадтай хуваалцах нь хэсгийг үзнэ үү.) Хэрэв айлчлах боломж хязгаарлагдмал бол чуулгын гишүүд гэр бүлдээ заахаар томилогдож болно.

Дараагийн чуулгын цуглаанд чуулгын гишүүдийг туршлагаа хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэдэг байсан бөгөөд тэдэнд бусдад үйлчилж, заах боломжийг олгодог байсан. Чуулга дахь залуу эрэгтэйчүүд нь ариун ёслолын талаар сурч байгаа зүйлсээ бусдад зааснаар хэрхэн адислагдах вэ?



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Миний амьдралд ёслолууд яагаад чухал вэ?

Ёслол нь сүнслэг утга учир бүхий ариун нандин, албан ёсны үйлдэл юм. Ёслолууд нь санваарын эрх мэдлээр, санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүсийн удирдлага дор гүйцэтгэгддэг. Ёслолууд нь бидэнд өөрсдийгөө хэн болохыг мөн Бурханы өмнө хүлээсэн үүргээ санахад маань тусалдаг. Эдгээр нь бидэнд Христ рүү ирж, мөнх амьдралыг хүлээн авахад тусалдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч, судал. Ёслолууд чухал гэдгийг ойлгоход тэдэнд туслахын тулд та залуу эрэгтэйчүүдтэй юу хуваалцах хэрэгтэй гэж бодож байна вэ?

Та сайн мэдээний ямар ёслолуудыг хүлээн авсан бэ? Эдгээр адислал таны амьдралыг хэрхэн адисалсан бэ? Эдгээр нь танд яагаад чухал вэ?

Залуу эрэгтэйчүүд ямар ёслолуудыг хүлээн авсан байгаа вэ? Тэд ямар ёслолуудыг хүлээн авахаар бэлтгэж байгаа вэ? Тэд яагаад сайн мэдээний ёслолууд чухал гэдгийг ойлгох хэрэгтэй вэ?

Матай 3:13–17 (Есүс Христийн баптисм)

Үйлс 19:1–6 (Баптисмаа буруу хүртсэн хүмүүст Паул дахин баптисм хүртээв)

3 Нифай 11:21–26 (Есүс Христ баптисм хүртээх эрх мэдлийг өгч, зөв журмыг заадаг)

Моронай 8:10–12 (Мормон баптисмын тухай заадаг)

С ба Г 84:19–21 (Санваарын ёслолуудад бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг)

Итгэлийн тунхаг 1:3–5 (Ёслолууд нь авралд зайлшгүй шаардлагатай)

Дэвид А.Бэднар, “Нүглүүдийнхээ ангижралыг үргэлж хадгал,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 45–48

Гари Э.Стивэнсон, “Таны дөрвөн минут,” *Ensign* эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 13–16

“Санваарын ёслолууд ба адислалууд,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.1

“Ёслолууд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 152–156

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өсвөр үеийнхэнд өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй холбоотой зураг эсвэл эд зүйл үзүүлээд, энэ нь тэр хичээлтэй ямар холбоотой болохыг тайлбарлахыг хүс. Тэд сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ?
- Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийн мэдэх сайн мэдээний бүх ёслолыг жагсаан бичихийг хүс. Тэгээд жагсаалтаас аль аль ёслол нь өргөмжлөлд шаардлагатай болохыг олж тогтооход тэдэнд тусал.Тэнгэрлэг

Эцэг яагаад бидэнд эдгээр адислалыг өгсөн бэ? Ёслолууд шаардлагагүй гэж хэлэх хэн нэгэнд залуу эрэгтэйчүүд хэрхэн хариулах вэ? (Хэрэв залуу эрэгтэйчүүдэд санаа авах шаардлага гарвал *Итгэлдээ үнэнч байх нь товхимол дахь “Ёслолууд”* эсвэл ахлагч Дэвид А.Бэднарийн “Нүглүүдийнхээ ангижралыг үргэлж хадгал” хэлсэн үгэн дэх “Ариун Сүнс ба санваарын ёслолууд” гарчигтай хэсгийг харж болно.)

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр чуулгын гишүүдэд ёслолууд яагаад чухал болохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Ахлагч Дэвид А.Бэднарийн “Нүглүүдийнхээ ангижралыг үргэлж хадгал” хэлсэн үгийн “Ёслолуудаар дамжуулан нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, хадгалж үлдэх нь” гарчигтай хэсэгт баптисм, гар

тавьснаар хүртээх Ариун Сүнсний бэлэг, ариун ёслол зэрэг ёслолын адислалыг дүрсэлсэн байдаг. Эдгээр ёслол бидэнд хэрхэн тусалж болох талаар суралцахад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд залуу эрэгтэй

Заахад туслах арга

“Та заахаар бэлтгэхдээ хичээл бүрд заах олон янзын арга барил ашиглах ёстой. Энэ нь нэг хичээлдээ сайхан өнгөтэй зурагт хуудас эсвэл ханын зураг ашиглах, өөр нэг хичээлд самбар дээр асуултын жагсаалт бичих зэрэг энгийн зүйлүүд байж болдог” (*Teaching, No Greater Call* [1999], 89).

бүрийг нэг ёслолыг сонгоод, энэ хэсгээс суралцсан бүхнээ жагсаахад урь. Дараа нь залуу эрэгтэйчүүдийг суралцсан зүйлээ зураг ашиглах, тоглоом тоглуулах зэрэг бүтээлч арга замаар чуулгынхандаа заахад урь.

- Ямар нэг чухал зүйл хийсэн үг хэлэхээр уригдсан зочин эсвэл залуу эрэгтэйг хийсэн зүйлийнх нь шаардлага юу байсныг мөн тэднийг хэрхэн биелүүлснээ хуваалцахад урь (Скаутын шагнал авсан, хичээлдээ амжилт гаргасан эсвэл жүжгийн дүрд тоглохоор амжилттай шалгарсан гэх мэт зүйл байж болно). Дараа нь залуу эрэгтэйчүүдийг ахлагч Гари Э.Стивэнсоны “Таны дөрвөн минут” хэлсэн үгээс “Олимпийн тамирчдын хувьд” гэж эхэлсэн догол мөрийг уншихад урь. Ёслолууд нь үг хэлэгч зочин эсвэл залуу эрэгтэйн хуваалцсан шаардлагуудтай хэр төстэй байна вэ? Мөн та ёслолуудын тухай өөр юу заасныг олж мэдэхийн тулд ахлагч Стивэнсоны хэлсэн үгийн үлдсэн хэсгийг уншиж болно.
- Залуу эрэгтэйчүүдийг “Санваарын хүчинд итгэх итгэл” видео бичлэгийг үзэхэд урь. Тэднээс дурдагдсан ёслолуудыг болон ёслол бүрд оролцсоноор бидний хүлээн авдаг адислалыг самбар дээр жагсааж бичихийг хүс. Өсвөр үеийнхнийг эдгээр ёслолын аль нэгийг хүлээн авсан эсвэл хэн нэгний хүлээн авахыг харсан (эсвэл эцгийн

адислал, эрүүл мэндийн адислал гэх мэт ёслолууд) туршлагаасаа хуваалцахад урь. Эдгээр туршлага нь тэднийг хэрхэн хүчирхэгжүүлж мөн адисалсан бэ?

- Чуулгаараа ёслолуудыг гүйцэтгэх дөрвөн шаардлагын тухай *Гарын авлага 2-ын 20.1* хэсгийг давтаж үз. Залуу эрэгтэйчүүдийг 3 Нифай 11:21–26-г уншаад, эдгээр шаардлага нь Аврагчийн дүрсэлсэн баптисмтай хэрхэн нийцэж байгааг олж мэдэхэд урь. Ариун ёслолыг гүйцэтгэх нь эдгээр дөрвөн шаардлагад хэрхэн нийцдэг вэ? Эдгээр шаардлагыг хангаагүй байж ёслолыг гүйцэтгэвэл юу болох вэ? Бусдад ёслолуудын тухай заахаар бэлтгэх явцдаа эдгээр шаардлагыг мэддэг байх нь яагаад чухал талаар залуу эрэгтэйчүүдээс асуу.
- Залуу эрэгтэйчүүдийг өөр шашинтай хэн нэгэнд баптисмын тухай зааж байгаа бөгөөд тэр хүн “би өөрийнхөө сүмд аль хэдийн баптисм хүртсэн” гэж хэллээ гэж төсөөлөхөд урь. Залуу эрэгтэйчүүд уг хүнд яагаад баптисм дахин хүртэх хэрэгтэйг нь хэрхэн эвтэйхэн ойлгуулж болох вэ? Тэд ямар судар, туршлагуудаас хуваалцах вэ? Та тэдэнд шаардлагуудыг жагсаасан Гарын авлага 2-ын *20.1-р хэсэг*; Матай 3:13–17; Үйлс 19:1–6; 3 Нифай 11:21–26; Моронай 8:10–12-ыг санал болгож болно. Боломжтой бол, бүрэн цагийн номлогчдыг урьж авчран, сонирхогчдодоо ёслолууд

яагаад чухал болох талаар хэрхэн тайлбарладаг туршлагаасаа хуваалцахад урь (эхлээд бишопоос зөвшөөрөл аваарай).

- Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын хэлсэн дараах үгийг чуулгатай хуваалц. “Ёслолууд нь сануулагч болдог. Ариун ёслолын жинхэнэ зорилго бол биднийг

мартахаас сэргийлж, санан дурсахад тусалдагт оршдог” (*Teachings of Spencer W. Kimball*, ed. Edward L. Kimball [1982], 112). Залуу эрэгтэйчүүдээс сайн мэдээний ёслолуудыг жагсаан бичихийг хүсэж, (Итгэлдээ үнэнч байх нь номын 99–100-р хуудсан дээрх зүйлсийг) мөн эдгээр ёслол бүр бидэнд юуг санахад тусалдаг талаар ярилц.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ёслолуудын ач холбогдлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол эсвэл сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Сайн мэдээний ёслолуудын тухай бодлоо хуваалцаж болно.
- Ариун нандин ёслолуудыг гүйцэтгэхийн тулд сүнслэгээр өөрсдийгөө бэлтгэх талаар товчхон хэлэлцүүлгийг удирдан явуулж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ хайрладаг мөн тэдний төлөө залбирдаг байсан (Иохан 17-г үзнэ үү). Та чуулгынхаа залуу эрэгтэйчүүдийг хайрлаж, дэмждэг гэдгээ хэрхэн харуулж болох вэ?

Сонгосон материалууд

Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010) номын “Ерөнхий зааврууд” хэсгээс эш татав. 20.1

20.1 Ерөнхий зааврууд

Ёслол нь баптисмын нэгэн адил санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин зан үйл юм. Баптисм, гишүүний баталгаа, Мелкизедек санваарын томилолт (эрэгтэйчүүдийн хувьд), ариун сүмийн хишиг болон лацдан холболтын ёслолууд нь хариуцлага хүлээх чадвартай бүх хүмүүсийн өргөмжлөлд шаардлагатай юм. Эдгээрийг аврах ёслолууд гэдэг. Аврах ёслолуудыг хүлээн авахын тулд гэрээнүүдийг Бурхантай хийдэг.

Авралын ёслолуудыг гүйцэтгэхэд зохих түлхүүрүүдийг эзэмшдэг санваарын удирдагч эсвэл эдгээр түлхүүрийг эзэмшдэг хүний удирдлага дор байгаа санваарын удирдагчийн зөвшөөрөл шаардлагатай. Хүүхдэд нэр өгч адислах, нутаглуулах газар адислах, патриархын адислал өгөх, ариун ёслол бэлтгэх, адислах, түгээхэд бас ийм зөвшөөрөл шаардлагатай. Мелкизедек санваартнууд санваарын удирдагчаас зөвшөөрөл авахгүйгээр, тосыг ариулан адислаж, өвчтэй хүмүүсийг адислан, эцгийн болон тайтгаруулах адислал, зөвлөгөө өгч болно.

Ёслолууд болон адислалуудыг гүйцэтгэдэг ах нар зохистой амьдарч, Ариун Сүнсээр удирдагдахыг хичээж, өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй. Ёслол, адислал бүр нь дараах шаардлагуудыг хангах ёстойг анхааран, тэд үүнийг хүндэтгэлтэйгээр гүйцэтгэх ёстой:

1. Үүнийг Есүс Христийн нэрээр гүйцэтгэх ёстой.
2. Санваарын эрх мэдлээр гүйцэтгэх ёстой.
3. Тусгайлан заасан үг хэллэг, ариулан адисласан тос зэргийг хэрэглэн, зохих дүрэм журмаар гүйцэтгэх ёстой.
4. Энэ бүлгийн заавруудын дагуу шаардлагатай бол зохих түлхүүрүүдийг эзэмшдэг тэргүүлэх эрх мэдэлтэн (ихэвчлэн бишоп болон гадасны ерөнхийлөгч) ёслол болон адислалд зөвшөөрөл олгох ёстой.

Ёслол, адислалуудыг хянаж буй санваарын удирдагчид гүйцэтгэж байгаа хүн нь санваарын шаардагдах эрх мэдэлтэй, зохистой байн, мөн зохих дүрэм журмыг мэдэж, баримталж байгаа байдлыг анхаарна. Ёслол болон адислалыг хүндэтгэлтэйгээр, сүнслэгээр хийхийг удирдагчид эрэлхийлнэ.



Миний амьдралд гэрээнүүд яагаад чухал вэ?

Бид баптисм хүртэж, санваарт томилогдож, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авснаар гэрээ байгуулдаг. Гэрээ бол Бурхан ба Түүний хүүхдүүдийн хоорондох ариун нандин зөвшилцөл юм. Бурхан онцгой нөхцөлүүдийг тогтоосон бөгөөд бид эдгээрийг дагах аваас Тэрээр биднийг адисална хэмээн амласан. Бид гэрээ хийж, түүнийг сахиснаар Бурханы амласан адислалуудыг хүлээн авах зохистой болдог. Бид гэрээгээ сахихгүй бол адислал хүлээн авахгүй. Хийсэн гэрээ маань бидний хийх сонголтыг чиглүүлж мөн уруу таталтаас хамгаалдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, суралцах материалыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдийг гэрээнүүд хийж, сахих хүсэлтэй болоход хэрхэн тусалж чадах вэ?

Египетээс гарсан нь 19:5; С ба Г 35:24; 90:24 (Бид гэрээнүүдийг сахихад адислалууд ирдэг)

Мозая 5; Алма 46:10–37 (Мормоны Номонд гардаг хүмүүс гэрээ хийж, сахиж байгаа жишээнүүд)

С ба Г 82:10 (Биднийг дуулгавартай байвал Их Эзэн үүрэг хүлээдэг)

Рассэлл М.Нэлсон, “Гэрээнүүд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11-р сар, 86–89

Жэффри А.Холланд, “Гэрээнүүдийг сахих нь: Номлолд үйлчлэх хүмүүст өгсөн захиас,” *New Era*, 2012 оны 1-р сар, 2–5; эсвэл *Лиахона*, 2012 оны 1-р сар, 48–51

Д.Тодд Кристоффэрсон, “Гэрээний хүч чадал,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2009 оны 5-р сар, 19–23

“Гэрээ,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 81

Та гэрээнүүдийг хийж, сахиснаар хэрхэн адислагдсан бэ? Таны хийсэн гэрээ шийдвэр гаргахад тань нөлөөлсөн үе бий юү?

Та залуу эрэгтэйчүүдийг өмнө нь хийсэн ба ирээдүйд хийх гэрээнүүдээ сайн ойлгоход хэрхэн тусалж чадах вэ? Гэрээнүүдийн мөн чанар хийгээд чухал гэдгийг ойлгох нь залуу эрэгтэйчүүдийг илүү зөв шударга амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн хичээлийн тухай бодоод, ээлж ээлжээрээ уг хичээлээс сурсан зүйлээ дүгнэн нэг өгүүлбэрээр товчхон хуваалцахыг хүс. Тэд сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ?
- Нэг залуу эрэгтэйг ангийн өмнө гарч ирэхийг урь. Гэрээ гэж юу болохыг үзүүлэхийн тулд түүний хийх нэг энгийн үйлдлийн хариуд нэг энгийн амлалт өг (жишээ нь, Итгэлийн тунхгийг чээжээр хэлбэл,

нэг жижиг зүйлээр шагнана гэж амла). Хэрэв тэр хийхээр сонговол, түүнд үйлдлээ хийж дуусгах боломж олгон, та ч бас амлалтаа биелүүл. Залуу эрэгтэйчүүдэд гэрээ гэж юу болохыг олж тодорхойлоход туслаад (ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлсэн үгийн гурав дахь догол мөрийг үзнэ үү), энэхүү жишээ бидний Бурхантай хийдэг гэрээтэй юугаараа адил эсвэл юугаараа өөр болох талаар тайлбарлахыг тэднээс хүс.

Заахад туслах арга

“Та ярьж буй хүнийг сонсож байгаагаа харуулахын тулд сонирхож байгаагаа илэрхийлэх ёстой. Та хичээлийн материал эсвэл анги доторх аливаа зүйлс рүү биш, харин ярьж буй хүн рүүгээ харах хэрэгтэй. Түүний яриаг таслахгүйгээр бодол санаагаа илэрхийлэхэд нь та урамшуулан дэмжих ёстой. Та түүний яриан дундуур зөвлөгөө өгөх эсвэл шүүмжлэхээс зайлсхийх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 66).

Видео бичлэг: “Зургуудыг ашиглах нь”

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь бид яагаад гэрээнүүд хийдгийг ойлгоход чуулгын гишүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэр үүнийг сонгох эрхийн тухай сурч, заахын тулд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөөнийхөө нэг хэсэг болгон хийж болно (“Сургаалыг ойлго,” 18, 42, 66-р хуудас).
- Өөр шашин шүтлэгтэй найздаа гэрээнүүдийн талаар тайлбарлахыг оролдож байна хэмээн залуу эрэгтэйчүүдээр төсөөлүүл. Тэднийг “Итгэлдээ үнэнч байх нь” номын *Гэрээ* бүлгийг эсвэл энэхүү тоймд жагсаасан судруудаас уншаад, гэрээний талаар найздаа тайлбарлахад бэлдэхийг урь. Нэг нэгэндээ зааж дадлага хийж, гэрээнүүд

яагаад тэдэнд чухал болохыг тайлбарлахыг тэднээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг Мозая 5-ыг бие даан судлаад, гэрээнүүд хийх, сахих талаарх хэсгүүдийг тэмдэглэхэд урь. Тэмдэглэсэн зүйлүүдээ самбар дээр бичихийг тэднээс хүс. Самбар дээр “_____ учраас гэрээнүүдийг сахих нь надад чухал байдаг” хэмээн бич. Залуу эрэгтэй бүрийг энэ өгүүлбэрийг гүйцээн бичихэд урь.
- Ахмад Моронайн эрх чөлөөний туг өргөж буй зургийг үзүүл (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 79-ийг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдээс зургийн зарим нэг хэсгийг

тайлбарлаж, уг зурагт дүрсэлсэн түүхийг товчхон ярихыг хүс (Алма 46:10–37-г үзнэ үү). Нифайчууд ямар гэрээнүүд хийсэн бэ (20–22-р шүлгийг үзнэ үү)? Өөрсдөд нь аюул нүүрлэж байсан ч хүмүүс яагаад эдгээр гэрээг хийхээр сонгосон бэ? Тэдний гэрээнүүд тулааны үр дүнд хэрхэн нөлөөлсөн бэ? Залуу эрэгтэйчүүдээс хийсэн гэрээнүүдээ жагсаан бичихийг хүс. Эдгээр гэрээ нь тэдэнд саад бэрхшээл, уруу таталтыг даван туулахад хэрхэн тусалсан бэ?

- Ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Гэрээнүүдийн хүч” хэлсэн үгийн эхэн дэх түүхийг унш, үз эсвэл сонс. Гай гамшиг тохиоход Памелад гэрээнүүд нь хэрхэн тусалсан бэ? Залуу эрэгтэй бүрд хэлсэн үгийн үлдсэн хэсгүүдийг даалган өгөөд, “Хийсэн гэрээнүүд маань намайг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд гэрээнүүдийн тухай илүү сайн ойлгож мэдсэн үү? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Түүний хувьд гэрээ хийнэ гэдэг нь ямар утга учир агуулж буй талаар хуваалцаж болно.
- Чуулгын бусад гишүүнийг гэр бүлийн гишүүнээсээ сурсан зүйлийнхээ тухай хуваалцахад урамшуулан дэмжиж болно.

хэрхэн хамгаалж, хүчирхэгжүүлэх вэ? гэдэг асуултад хариулт хайж олоход урь. Олсон хариултаа хуваалцахыг тэднээс хүс. Хийсэн гэрээнүүдээсээ хүч чадал эсвэл хамгаалалт олж болох, ирэх долоо хоногт тулгарч болох нөхцөл байдлуудын талаар ярилц.

- Самбар дээр “Гэрээнүүд” ба “Номлолын ажил” гэж бич. Залуу эрэгтэй бүрийг ахлагч Жэффри Р.Холландын “Гэрээнүүдийг сахих нь: Номлолд үйлчлэх хүмүүст өгсөн захиас” хэлсэн үгийн нэг хэсгийг уншихад урь. Тэднээс гэрээнүүд ба номлогчийн ажлын хоорондын холбоог олохыг хүс. Ахлагч Холландын захиасаас сурсан зүйлээ бие биетэйгээ хуваалцахад тэднийг урь. Түүний зөвлөгөө тэднийг бүрэн цагийн номлолд үйлчлэхээр бэлтгэхэд хэрхэн нөлөөлөх вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагчдаа итгэлээ хөгжүүлж, Түүний заасан үнэнүүдийн дагуу үйлдэхэд урьсан (Лук 18:18-25-ыг үзнэ үү). Та залуу эрэгтэйчүүдийг ёслол, гэрээнүүдэд оролцож, зөв шударга үйлсээрээ гэрээнүүдээ хүндлэн сахихад хэрхэн тусалж чадах вэ?

Сонгосон материалууд

Д. Тодд Кристоффэрсоны “Гэрээнүүдийн хүч чадал” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2009 оны 5-р сар, 19–23

2007 оны наймдугаар сарын 15-нд Перуд маш хүчтэй газар хөдлөлт болж далайн эргийн Писко ба Чинча хэмээх хоёр хот бүрэн сүйрсэн билээ. Сүмийн бусад олон удирдагчид ба гишүүдийн нэгэн адилаар Чинча хотын Балконсито салбарын ерөнхийлөгч Венесло Конде гэр орон нь эвдэрсэн хүмүүст тэр даруй тусалж эхэлсэн.

Газар хөдлөлт болсноос хойш дөрөв хоногийн дараа Далын ахлагч Маркус Б.Нэш Сүмийн халамжийн ажлыг зохион байгуулахад туслахаар Чинчад очоод ерөнхийлөгч Кондетой уулзсан байна. Тэднийг эвдрэл сүйрэл ба нэрвэгдэгсдэд хэрхэн тусалсан талаар ярилцаж байх үед ерөнхийлөгч Кондегийн эхнэр Памела нэг хүүхдээ гэвэрсээр иржээ. Ахлагч Нэш Конде эгчээс хүүхдүүд нь ямархуу байгааг асуухад тэрээр Бурханы авралаар бүгд аюулгүй сайн байгаа хэмээн инээмсэглэн хариулав. Ахлагч Нэш түүнээс өөрийнх нь гэр орны талаар асуув.

“Байхгүй болсоон” хэмээн Конде эгч энгийнээр хэлэв.

“Танай эд хогшил, тавилгууд чинь яасан бэ?” гэж түүнийг асуухад

“Бүх юмс маань байшингийн нурангид даруулсан” гэж Конде эгч хариулав.

“Тэгээд та энэ тухай ярихдаа инээмсэглээд байх юм” хэмээн ахлагч Нэшийг хэлэхэд

“Тийм ээ, би залбираад, амар амгаланг олсон” гэж тэр хариулжээ. Бидэнд хэрэгтэй бүхэн маань байгаа гэв. Бидэнд нэг нэг маань, хүүхдүүд маань байна. Бид ариун сүмд лацдуулсан. Бидэнд энэхүү гайхамшигтай Сүм бас Их

Эзэн маань байгаа. Их Эзэний тусламжтайгаар бүхнийг бид дахин сэргээж чадна” гэжээ.

“Гэрээ” Итгэлдээ үнэнч байх нь (2004), 44

Гэрээ нь Бурхан, хүн буюу бүлэг хүмүүсийн хоорондох ариун нандин хэлэлцээр юм. Бурхан тодорхой нөхцлүүдийг тогтоодог бөгөөд тэдгээрийг дагавал биднийг адисална хэмээн амладаг. Бид гэрээнүүдээ сахиагүй бол адислалуудыг хүлээн авч чадахгүй. Мөн зарим тохиолдолд бид дуулгаваргүй байснаа үр дагавар болох шийтгэлийг амсдаг.

Санваарын бүх авралын ёслолыг гэрээнүүд дагалддаг. Жишээ нь: та баптисм хүртэхдээ гэрээ байгуулдаг бөгөөд ариун ёслолоос хүртэх бүрдээ тэрхүү гэрээг шинэчилдэг (Мозая 18:8–10; С ба Г 20:37, 77, 79-ийг үзнэ үү). Хэрэв та Мелкизедек санваарыг хүлээн авсан бол та санваарын амлалт мөн гэрээнд ордог билээ (С ба Г 84:33–44-ийг үзнэ үү). Ариун сүмийн хувийн хишиг хүртэх болон лацдуулан холбох ёслол нь мөн нандин гэрээнүүдийг агуулдаг.

Их Эзэнтэй хийдэг гэрээнүүдээ үргэлж санан, эрхэмлэж бай. Тэгэх аваас та хийх бүх зүйлдээ зарлигдуулах нь шаардлагагүй юм (С ба Г 58:26–28-ыг үзнэ үү). Та Ариун Сүнсээр урамшуулагдаж болох ба Христийн удирдан чиглүүлэлт нь таны мөн чанарын нэг хэсэг болно. Их Эзэний амласан ёсоор та нар “баяр хөөрийг авчирдаг, мөнхийн амьдралыг авчирдаг тэрхүү нууцууд хийгээд амар амгалангийн зүйлүүдийг мэдэж болохын тулд илчлэлт дээр илчлэлт, мэдлэг дээр мэдлэг хүлээн авах болно” (С ба Г 42:61). Энэхүү тэнгэрлэг удирдамжаас ирэх ариусгалыг мэдэрч баясах нь таны хамгийн агуу найдвар байх ёстой; эдгээр адислалыг алдахаас та хамгийн ихээр айх ёстой.

Нэмэлт эшлэлүүд: Иеремиа 31:31–34; Мозая 5; Моронай 10:33; С ба Г 82:10; 97:8; 98:13–15



Би баптисм хүртэхдээ ямар гэрээ хийсэн бэ?

Бид баптисм хүртэхдээ Бурхантай гэрээнд ордог. Бид өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авч, Түүнийг үргэлж дурсан санаж, Түүний тушаалуудыг сахиж, Түүнд эцсээ хүртэл үйлчилнэ хэмээн амладаг. Тэнгэрлэг Эцэг бидэнд гишүүний баталгаа, Ариун Сүнсний бэлгээр дамжуулан нүглийн ангижралыг амладаг. Бид ариун ёслолоос хүртэх бүрдээ энэхүү гэрээгээ шинэчилдэг.

Та баптисмынхаа талаар юу санаж байна вэ? Таны баптисмын гэрээнүүд амьдралд тань хэрхэн нөлөөлсөн бэ?

Залуу эрэгтэйчүүдэд баптисмынхаа гэрээг илүү сайн ойлгоход нь та хэрхэн тусалж болох вэ? Эдгээр гэрээгээ сахих хичээл зүтгэлээ өсгөхөд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Залуу эрэгтэйчүүдийг баптисмынхаа гэрээг санаж мөн сахихад ямар судар, материал туслах вэ?

Иохан 3:5; 2 Нифай 31:4–13, 17 (Мөнхийн авралыг хүлээн авахын тулд баптисм зайлшгүй шаардлагатай)

Мозая 18:8–10; С ба Г 20:37 (Бид баптисм хүртэхдээ үүрэг амлалт авдаг)

Хюго Монтоя, “Соригдож, уруу татагдсан ч тусламж хүлээн авсан,” *Ensign*, эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 53–55.

Робэрт Д.Хэйлс, “Баптисмын гэрээ: Хаант улсад, Хаант улсынх байх нь,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 6–9

Кэрол М.Стэфэнс, “Бидэнд баярлах агуу шалтгаан буй,” *Ensign* эсвэл *Лианоха*, 2013 оны 11-р сар

“Таны баптисмын гэрээ,” “Баптисмын амлагдсан адислалууд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 45–48

Видео бичлэг: “Адилхан өмсгөл”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүн бүрээр дараах өгүүлбэрийг гүйцээн бичүүл: _____ учраас өнгөрсөн долоо хоногийн хичээлээр сурсан зүйлс надад маш чухал байлаа. Тэд сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ?
- Баптисмын зураг үзүүл (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 103–4 гэх мэт). Баптисмынхаа тухай тэр өдөр юу мэдэрч байсан тухайгаа хуваалц. Баптисмд оролцож эсвэл гэрчилж байсан туршлагаасаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Баптисм хүртэхдээ хийсэн гэрээнүүдээ самбар дээр жагсаан бичихийг тэднээс хүс. Тэднийг хичээл дээр баптисмын тухай сурсан зүйлээ хичээлийн туршид уг жагсаалтад нэмж бичихэд урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд баптисмынхаа үед хийсэн гэрээнүүдээ ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг Мозая 18:8–10-ыг уншихад урь. Тэд баптисм хүртэхдээ бусдад хэрхэн хандах тухай өгсөн амлалтынхаа талаар юу мэдэж авсан бэ? Бие биенийхээ ачаанаас хэрхэн үүрэлцэж болох талаар суралцахад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд тэднийг бүлгүүдэд хуваагаад, бүлэг бүрд ахлагч Хюго Монтоягийн “Соригдож, уруу татагдсан ч тусламж хүлээн авсан” хэлсэн үгийн нэг хэсгийг судлуулахаар оноож өг. Бүлэг бүрийг сурсан зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад урь. Бүлэг бүр сурсан зүйлийнхээ танилцуулгыг хийж, боломжтой бол хувийн туршлагаасаа хуваалцаж эсвэл тухайн зарчмыг заадаг судрын түүхийг ярьж болно.
- Ангийнхаа нэг гишүүнийг энэ хичээлийн нэг хэсгийг заахад урь. Тэр сонгох эрхийн тухай сурч, заахын тулд *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номынхоо төлөвлөгөөгөө биелүүлэх нэг хэсэг болгон, хийж болно (“Сургаалыг ойлго,” 18, 42, 66-р хуудас).
- Энэхүү тоймд санал болгосон судруудыг олж уншихад залуу эрэгтэйчүүдийг урь. Тэднээс баптисмынхаа үед хийсэн амлалтуудаа тэмдэглэж, олсон зүйлээ самбар дээр бичихийг хүс. Бид амлалтуудаа хэрхэн сахидаг вэ? Самбар дээр бичсэн амлалтуудын жишээг үзүүлдэг хүмүүсийн тухай хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс (судрууд дахь хүмүүс

Заахад туслах арга

“Сайн багш нар зааж байгаа хүмүүсийнхээ сурсан зүйл ба өсөлт хөгжлөөр сайрхдаггүй. Тэд үр суулгаж, арчилдаг цэцэрлэгчтэй адил сурах хамгийн сайн орчин нөхцөлийг бий болгохыг л хичээдэг. Дараа нь тэдний заасан хүмүүс ахиц дэвшил гаргахад, Бурханд талархлаа илэрхийлдэг билээ” (*Teaching, No Greater Call* [1999], 62).

Видео бичлэг: “Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийн гол санааг тодорхойлох нь”

байж болно). Эдгээр амлалтыг бие-
лүүлснээр залуу эрэгтэйчүүд хэрхэн
адислагдсан бэ?

- Залуу эрэгтэйчүүдээр “Итгэлдээ
үнэнч байх нь” номын *Таны баптис-
мын гэрээ* хэсгийг уншаад, баптисм
хүртэхдээ өгдөг бидний амлал-
туудыг олуул. “Ижилхэн өмсгөл”
видео бичлэгийг үзэхэд эсвэл Кэрол
М.Стэфэний “Бидэнд баярлах агуу
шалтгаан буй” хэлсэн үгийн эхэн
дэх түүхийг уншихад залуу эрэгтэй-
чүүдийг урь. Баптисмын гэрээндээ
хүндэтгэлтэй ханддаг хүмүүсийн
тухай жишээнүүдийг эрж олохыг
тэднээс хүс. Чуулгын гишүүдэд сур-
сан зүйлийнхээ тухай хуваалцах цаг
гаргаж өгөөрэй. Баптисмын гэрээгээ
бүх газарт, бүх цаг үед хэрхэн бүрэн
дүүрэн сахих талаар ярилцлага
хөтлөн явуулахад чуулгын ерөнхий-
лөгчийг урь.

- Аврагчийн баптисмын зургийг
зүүлээд (*Сайн мэдээний уран*

зургийн цуглуулга 35-ыг үзнэ үү),
чуулгын нэг гишүүнээс 2 Нифай
31:4–10-ыг уншихыг хүс. Есүс Христ
Эцэгтэйгээ хийсэн гэрээгээ хэрхэн
сахисныг дүрсэлсэн судруудын
жишээг хуваалцахад залуу эрэг-
тэйчүүдийг урь (тэд *Сайн мэдээний
уран зургийн цуглуулга*, 36–48-аас
санаа авч болно). Аврагчийн үлгэр
жишээг дагахаар хичээсэн туршла-
гаасаа хуваалцахад тэднийг урь.

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч
Робэрт Д.Хэйлсийн “Баптисмын
гэрээ: Хаант улсад хаант улсынх
байх нь” хэлсэн үгээс “Баптисмын-
хаа үеэр бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ
гэрээ хийдэг” гэсэн хэсгээс эхлээд
гурван догол мөрийг уншихад урь.
Баптисм хүртэхдээ хийдэг гэрээ-
нийхээ тухай уншаад, энэ талаар
самбар дээр бичихийг тэднээс хүс.
Баптисм хүртсэнээр бидний амьд-
рал хэрхэн өөрчлөгддөг вэ? Энэ нь
залуу эрэгтэйчүүдийн амьдралыг
хэрхэн өөрчилсөн бэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр ганцаар залбирч,
мацаг барин, заахад
Өөрийгөө бэлтгэдэг байв.
Тэр ганцаараа байхдаа
Эцэгийнхээ удирдам-
жийг эрэлхийлдэг байсан
(3 Нифай 19:19–23-ыг үзнэ
үү). Та гэрээ, ёслолуудын
тухай залуу эрэгтэйчүү-
дэд заахдаа Ариун Сүнс-
ний нөлөөг дагана уу.

*Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд баптис-
мын гэрээнүүдийг илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй
байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах
шаардлага байна уу?*

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Түүнд баптисмын гэрээ нь сан-
ваараа хүндэлж явахад нь хэрхэн
тусалдаг тухай бодлоо хуваалцаж
болно.

- Баптисмынхаа гэрээнд илүү
итгэлтэй байхын тулд хийх ёстой
эсвэл хийх ёсгүй ямар нэг зүйл
тэдэнд байгаа юу гэдгээ олж мэдэ-
хэд тэднийг урьж болно.

Сонгосон материалууд

“Таны Баптисмын Гэрээ” Итгэлдээ үнэнч байх нь. (2004), 46–48

Та баптисм хүртсэнээр Бурхантай гэрээ байгуулсан юм. Та өөр дээрээ Есүс Христийн нэрийг авч, Түүний зарлигуудыг даган, Түүнд эцсээ хүртэл үйлчлэхээ амласан юм (Мозая 18:8–10; С ба Г 20:37-г үзнэ үү). Ариун ёслол хүртэх болгондоо та уг гэрээгээ шинэчилдэг билээ (С ба Г 20:77, 79).

Есүс Христийн нэрийг Өөр дээрээ авах нь. Есүс Христийн нэрийг өөр дээрээ авснаар та өөрийгөө Түүнийх хэмээн үздэг. Та амьдралдаа Түүнийг болон Түүний ажлыг эхэнд тавьдаг. Та өөрийн хүслийг эсвэл дэлхийн заадаг зүйлийг бус харин Түүний хүслийг эрэлхийлдэг.

Мормоны Номонд хаан Бенжамин Аврагчийн нэрийг өөрсөд дээрээ авах нь яагаад чухал байдгийг ийн тайлбарладаг:

“Түүгээр аврал ирэх үүнээс өөр нэр гэж үгүй; тиймийн тул та нарыг амьдралынхаа төгсгөлийг хүртэл дуулгавартай байхаар Бурхантай гэрээнд орсон та нар бүгдийг Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн аваасай хэмээнэ.

Мөнхүү улиран тохиох дор үүнийг хийсэн нь Бурханы баруун гар талд олдох болно, учир нь тэрээр өөрийн нэрлэгдсэн нэрээ мэдэх болно; учир нь тэрээр Христийн нэрээр нэрлэгдэх болно.

“Мөнхүү улиран тохиох дор Христийн нэрийг өөр дээрээ авахгүй хэн боловч өөр ямар нэгэн нэрээр нэрлэгдэх ёстой; тиймийн тул, тэрээр Бурханы зүүн гар талд өөрийгөө олох буюу” (Мозая 5:8–10).

Зарлигуудыг сахих нь. Таны баптисмын гэрээ бол дэлхийгээс өөрийгөө тусгаарлан, “мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн” Бурханы гэрч болж, Бурханы хаант улс руу очих амлалт мөн (Мозая 18:9). Бурханы гэрч болон зогсох таны хичээл зүтгэлд таны хэлдэг мөн хийдэг бүх зүйл хамрагдана. Үргэлж Их Эзэний зарлигуудыг санаж мөн сахихын төлөө хичээ. Өөрийн бодол санаа, үг яриа болон үйлдлээ цэвэр ариун байлга. Кино, зурагт, интернет, дуу хөгжим, ном, сонин сэтгүүл гэх мэт хэвлэл мэдээлэл, үзвэр үйлчилгээг үзэж, харах, сонсохдоо болгоомжтой хандаж, зөвхөн урамшуулан дэмжих тэрхүү зүйлсийг сонгоорой. Даруухан хувцасла. Мөнхийн зорилгод хүрэхэд тань дэмжих найз нөхдийг сонго. Ёс суртахуунгүй байдал, садар самуун, мөрийтэй тоглоом, архи, тамхи болон хууль бус мансууруулах бодис зэргээс зайлсхий. Ариун сүмд ороход зохистой бай.

Их Эзэнд үйлчлэх нь. Дэлхийн зүйлсээс өөрийгөө тусгаарла гэдэг зарлиг нь бусдаас өөрийгөө тусгаарла гэсэн үг биш юм. Баптисмын гэрээний нэг хэсэг бол Их Эзэнд үйлчлэх бөгөөд та бусад хүмүүст үйлчилснээрээ Түүнд хамгийн сайнаар үйлчилж байна гэсэн үг юм. Бошиглогч Алма баптисмын гэрээний тухай заахдаа: бид “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд” мөн “гашуудахад . . . тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах” (Мозая 18:8–9) ёстой гэж хэлсэн. Бусадтай харьцахдаа Есүс Христийн жишээг даган бүх хүмүүст сайхан сэтгэлээр хандан хүндэтгэлтэй бай.

Сонгосон материалууд

Кэрол М. Стэфэнсийн “Бидэнд баярлах агуу шалтгаан буй” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиана, 2013 оны 11-р сар

Хадам аав маань насан өөд болоход манай гэр бүлийнхэн цугларч, хүндэтгэл үзүүлэхээр ирсэн хүмүүстэй мэндэлж байлаа. Оройжингоо би гэр бүлийнхэн болон найзуудтайгаа уулзах үедээ хадам ээжийг маань “Грэнни” гэж дууддаг 10 настай ач хүү Портэр маань түүний ойролцоо л байгаад байхыг нь үе үе ажигласан юм. Заримдаа тэр ард нь зогсож, заримдаа түүнийг ажиглаад зогсож байв. Нэг удаа би түүнийг хадам ээжтэй минь хөтлөлцөн зогсож байхыг ч харсан. Мөн би түүнийг хадам ээжийн хажууд зогсож, гарыг нь атган, тэврэхийг нь ч харж байлаа.

Түүнээс хойш хэдэн өдрийн турш би уг явдлын талаар мартаж чадахгүй байлаа. Өөрийнхөө ажигласан зүйлийн талаар Портэрт захиа илгээх бодол надад төрөв. Би түүн рүү имэйл явуулж, өөрийн харж мэдэрсэн зүйлийн тухай бичсэн. Баптисм хүртэх үедээ хийсэн гэрээнийх нь тухай Портэрт сануулж, Мозаягийн 18-р бүлэг дэх:

“Мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн байв;

“Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, мөнх амьдралыг авч болохын тулд . . . буюу—

“ . . . Хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юулж болохын тулд, та нар түүнд

үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?” гэсэн Алмагийн үгсээс эш татсан юм [Мозая 18:8–10].

Баптисм хүртэхийг хүсэж байсан тэд үргэлжид, бүх л амьдралынхаа турш бусдад үйлчилснээр Их Эзэнд үйлчлэх хүсэлтэй байх хэрэгтэй гэж Алма тэдэнд зааж байсныг би Портэрт тайлбарласан! Тэгээд би: “Чи өөрөө мэдсэн үү, үгүй юү мэдэхгүй, гэхдээ Грэннид санаа тавьж мөн хайраа харуулсан явдал чинь гэрээгээ сахиж байгаа хэрэг юм шүү. Бид өдөр бүр нэг нэгэндээ найрсаг хандан, хайраа үзүүлж мөн халамжилснаар гэрээгээ сахидаг. Гэрээгээ сахигч байгаагийн чинь төлөө би чамаар бахархаж байгаагаа хэлмээр байсан юм! Баптисм хүртэхдээ хийсэн гэрээгээ сахих юм бол чи санваарыг хүртэх бэлтгэлтэй байх болно. Энэхүү нэмэлт гэрээ нь чамд бусдыг адисалж, тэдэнд үйлчлэх илүү олон боломжийг олгох бөгөөд ариун сүмийн гэрээнд бэлтгэхэд чинь туслах болно. Надад маш сайн үлгэр жишээ үзүүлсэнд баярлалаа! Гэрээг сахигч байх нь ямар байдгийг харуулсанд чинь баярлалаа!” гэж бичсэн юм.

Портэр хариуд нь “Эмээ, захиа бичсэнд баярлалаа. Би Грэнниг тэврэх бүрдээ гэрээгээ сахиж байна гэдгээ мэдээгүй ч зүрх сэтгэлдээ халуун дулааныг мэдэрч мөн маш сайхан санагдаж байсан шүү. Энэ бол зүрх сэтгэлд минь байсан Ариун Сүнс гэдгийг би мэднэ” гэж бичсэн байлаа.

Ариун Сүнсний бэлгээр дамжин ирдэг “түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгана” [С ба Г 20:77]— гэсэн амлалттай Портэр гэрээ сахихыг холбож ойлгосныг хараад би зүрх сэтгэлдээ бас халуун дулааныг мэдэрч байсан.



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Би Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүлээн авдаг вэ?

Бид баптисм хүртсэнийхээ дараа гишүүнээр батлагддаг. Энэхүү ёслолын үеэр бидэнд “Ариун Сүнсийг хүлээн авна уу” хэмээн хэлдэг. Энэ нь бид хүсэлтэй байж, Ариун Сүнсийг амьдралдаа урин мөн тушаалуудыг итгэлтэйгээр сахих аваас Ариун Сүнс бидний мөнхийн хамтрагч байна гэсэн үг юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ариун Сүнс амьдралынх нь турш тусалж, адислах болно гэдгийг залуу эрэгтэйчүүд ойлгоход ямар судрууд болон хэлсэн үгс туслах вэ?

Үйлс 8:14–17; С ба Г 33:15; Итгэлийн тунхаг 1:4 (Ариун Сүнсний бэлэг гар тавилтаар хүртээгдэнэ)

1 Нифай 2:9–20 (Нифай Ариун Сүнсийг хүлээн авахуйц байхын жишээ юм)

1 Нифай 15:1–11 (Тушаалуудыг дагахгүй аваас Ариун Сүнсийг хүлээн авч чадахгүй)

1 Нифай 16:14–29; 18:8–22; Алма 37:38–46 (Лианоагийн жишээ)

С ба Г 20:77 (Ариун ёслолоос хүртсэнээр бид гэрээнүүдээ шинэчилж мөн үргэлж Сүнстэй байж чадна)

С ба Г 121:45–46 (Бид энэрэлтэй, ариун журамтай байх аваас Ариун Сүнс бидний байнгын хамтрагч байх болно)

Хэнри Б.Айринг, “Таны хамтрагч Ариун Сүнс,” *Ensign* эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 104-107

Дэвид А.Бэднар, “Ариун Сүнсийг хүлээн авна уу,” *Ensign* эсвэл *Liahona*, 2010 оны 11-р сар, 94–97

“Ариун Сүнсний үүргүүд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 32

Ариун Сүнсний бэлэг таныг хэрхэн тайвшруулж мөн тусалж байсан бэ? Та хэзээ Сүнсэнд ойр байгаагаа мэдэрсэн бэ? Та ямар туршлагаасаа залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдэд Ариун Сүнсний бэлэгтэй холбоотой туршлага байгаа юу? Тэд Ариун Сүнсгэй байхын тулд юу хийх ёстойгоо мэддэг үү?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногт уг долоо хоногийн хичээлтэй холбогдох ямар туршлага тохиолдсон тухайгаа хуваалцахад нэг залуу эрэгтэйг урь.
- Хамгийн сүүлд хэн нэгнийг гишүүнээр батлуулахыг харсан

тухайгаа бодохыг тэднээс хүс. Энэхүү ёслолын үед ямар үгс хэлсэн бэ? “Ариун Сүнсийг хүлээн авах” гэдэг нь юу гэсэн үг вэ? Залуу эрэгтэйчүүдийг хичээлийн турш энэхүү асуултыг тунгаан бодоход урь.

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь Ариун Сүнсийг хэрхэн хүлээн авахыг ойлгоход нь чуулгын гишүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Таны хамтрагч Ариун Сүнс” хэлсэн үгээс Ариун Сүнтэй хэрхэн байнга нөхөрлөж болох талаар ойлгоход туслах мэдэгдлүүдийг хайж олоход урь. Яагаад Ариун Сүнсийн нөхөрлөл хэрэгтэй болох талаар мөн Түүний өдөөлтийг хүлээн авахад хэрхэн хариу үйлдэх ёстой талаар бодоход тэднийг урамшуулан дэмж. Залуу эрэгтэйчүүдийн өдөр тутам харж, бодож, хийж байдаг зүйлс нь тэдний Сүнс мэдрэх чадварт хэрхэн нөлөөлдөг вэ? Тэднээс амьдралдаа өөрчлөх хэрэгтэй байгаа зүйлсийн талаар тунгаан бодохыг хүс. Хүсэж байвал тэднийг бодол санаагаа хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдээс дор бүрдээ 1 Нифай 2:9–19 ба 1 Нифай 15:1–11-ийг уншихыг хүс. Чуулгын нэг хэсэг гишүүдээс Нифай Ариун Сүнсийг хүлээн авахын тулд юу хийсэн болохыг олж мэдэн, энэ талаар хэлэлцэхэд урь. Нөгөө хэсэг гишүүдээс Лемел, Лемүел хоёр Ариун Сүнсийг хүлээн авахад юу саад болсныг олж мэдэн, энэ талаар хэлэлцэхэд урь. Уншсан зүйлийнхээ талаар самбар дээр бичихийг тэднээс хүс. Залуу эрэгтэйчүүд эдгээр жишээнээс Ариун Сүнсийг амьдралдаа хүлээн авахад туслах юуг сурсан бэ?

- Залуу эрэгтэй бүрд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* ном байгаа

Заахад туслах арга

“Ариун Сүнс та нарын зааж байгаа хүмүүсийн нэг, хоёрт нь бусдынхаа сонсох хэрэгтэй зүйлийг нэмж хэлэхэд нөлөөлж болох юм. Зарим нэг хүнийг нэр цохон дуудах сүнслэг нөлөөг хүлээн авахад нээлттэй бай. Үзэл бодлоо илэрхийлэхийг сайн дураараа хүсээгүй хүн ч таныг гайхшируулсан оновчтой зүйлийг хэлж болно (*Teaching, No Greater Call* [1999], 63).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч эртний бошиглогч нартаа: “Би та нарыг тайтгаруулагчгүйгээр орхихгүй” хэмээн амласан (Иохан 14:18). Ариун Сүнс таныг дуудлагаа хийхэд зааж, удирдаж мөн тайвшруулна. Та Түүний нөлөөг эрэлхийлэхийн тулд юу хийж болох вэ?

эсэхийг магадал. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номоос нэг бүлгийг сонгон уншаад, Ариун Сүнсийг хүлээн авахын тулд хийх ёстой зүйлсийг зурж тэмдэглэхийг тэднээс хүс. Тэднийг уншсан бүлгээсээ Ариун Сүнсний тухай сурсан зүйлээ хуваалцахад урь. Энэ нь тэдэнд Ариун Сүнсийг амьдралдаа хүлээн авахад хэрхэн туслах вэ?

- Ахлагч Дэвид А.Бэднарн “Ариун Сүнсийг хүлээн авна уу” хэлсэн үгээс “Ариун Сүнсний бэлэг” гэсэн хэсгийн сүүлийн гурван догол мөрийг чуулгаараа хамт унш. Ахлагч Бэднарн хэлсэн гол санааг дүгнэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэй бүрд уг хэлсэн үгийн дараагийн гурван хэсгийг даалган өг. Дараах асуултуудын хариуг олоход урь: Бид хэрхэн Ариун Сүнсний нөхөрлөхүйц зохистой байх

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Ариун Сүнсийг хэрхэн хүлээж авч болохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулгын гишүүдийг бие даан суралцахдаа Сургаал ба Гэрээ 121:45–46-г уншаад дараагийн чуулгын цуглаанууд дээр Ариун Сүнсийг хүлээн авах талаар эдгээр

вэ? Ариун Сүнсийг хүлээн авахад бидэнд юу саад болдог вэ? Тэднийг уншсан зүйлийнхээ талаар хуваалцаж мөн ахлагч Бэднарн зөвлөгөөг даган хийх зүйлээ төлөвлөхийг хүс.

- Тэдэнд Лихай ба Лиахонагийн зургийг үзүүл (Сайн мэдээний уриан зургийн цуглуулга, 68-ыг үзнэ үү). Дараа нь тэднээс Лиахонагийн талаар мэддэг зүйлээ хуваалцахыг хүс. Чуулгын нэг хэсэг гишүүдээс 1 Нифай 16:14–29-ийг, үлдсэн гишүүдээс 1 Нифай 18:8–22-ыг уншаад, “Лиахона Ариун Сүнстэй юугаараа адил төстэй вэ?” гэдэг асуулгын хариуг олохыг хүс. Тэднийг бодол санаагаа хуваалцахад урь. Ариун Сүнсийг хүлээн авахад нь туслах юуг тэд Лихайн гэр бүлийн туршлагаас сурч болох вэ? Ярилцлагынхаа үеэр Алма 37:38–46-г хамтдаа унш.

шүлгээс сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцахад урьж болно.

- Ариун Сүнстэй нөхөрлөх илүү зохистой болохын тулд хийх нэг зүйл бодож олохыг тэднээс хүсэж болно.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Ариун Сүнсийг хүлээн авах нь,”
Ensign, 2010 оны 11-р сар, 95 эсвэл 2010 оны 10-р
сарын Ерөнхий чуулган, 105

Сүмийн шинэ гишүүнийг батлах, Ариун Сүнсний бэлэг хүртээх зэрэг нь энгийн бөгөөд гүн гүнзгий утга агуулгатай. Зохистой Мелкизедек санваартан гараа тухайн хүний толгой дээр тавин, түүнийг нэрээр нь дууддаг. Дараа нь ариун санваарын эрх мэдлээр болон Аврагчийн нэрээр тухайн хүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр баталж, “Ариун Сүнсийг хүлээн авна уу” хэмээх энэ онц ач холбогдолтой чухал үгийг хэлдэг.

Энэ ёслолын энгийн байдал нь биднийг түүний ач холбогдлыг анзаарахгүйд хүргэж мэднэ. “Ариун Сүнсийг хүлээн авна уу” хэмээх үг нь идэвхгүй мэдэгдэл бус, харин тэднийг санваарын тушаалтай дүйцэх өөрсдийн төлөө үйлдэх мөн өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүйг тунхаглах эрх мэдэлтэй сануулга юм (2 Нифай 2:26-г үзнэ үү). Бидний толгой дээр зөвхөн гар тавьснаар мөн дээрх

дөрвөн чухал үгийг хэлснээр Ариун Сүнс бидний дээр шууд хүчин төгөлдөр болохгүй. Энэ ёслолыг хүлээн авсан хүн бүр хүсэх, эрэлхийлэх, ажиллах, зохистой байдлыг амьдралынхаа хэв маяг болгох ариун нандин хариуцлагыг хүлээснээр “Ариун Сүнсийг авч,” хамт ирэх сүнслэг бэлэгнүүдийг авах амлалт авдаг. “Учир нь хэрэв түүнд бэлэг хүртээгдсэн байхад мөн тэрээр уг бэлгийг хүлээн аваагүй бол энэ нь хүмүүнд ямар ашиг тус авчрах билээ; Болгоогтун, тэрээр өөрт нь өгөгдсөн тэр зүйлд баясах нь үгүй, мөн уг бэлгийг өгөгч болох түүнд ч баясах нь үгүй болой” (С ба Г 88:33).

Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүний нөхөрлөлийг эрэлхийлэх хүндтэй сануулгыг амьдралынхаа бодит хэв маяг болгохын тулд бид юу хийх ёстой вэ? Би дараах зүйлсийг санал болгож байна. Үүнд: (1) Ариун Сүнсийг хүлээн авах үнэн хүсэлтэй байх, (2) өөрсдийн амьдралд Ариун Сүнсийг зохистойгоор урин оруулах, мөн (3) итгэлтэйгээр Бурханы зарлигуудад дуулгавартай байх зэрэг юм.



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Ариун сүмийн ёслолууд яагаад чухал вэ?

Ариун сүмийн ёслолууд нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд боломжтой хамгийн агуу адислал руу тэднийг хөтөлдөг. Эдгээр ёслол биднийг энэ амьдралын дараа Тэнгэрлэг Эцэг болон гэр бүлийнхэнтэйгээ мөнхөд амьдрахад бэлтгэдэг. Эдгээр нь мөнх бус амьдралын туршид биднийг сүнслэг хүч чадал, удирдамжаар адисалдаг. Ариун сүмд бид ёслолуудыг хүлээн авах боломжгүй байсан өвөг дээдсийнхээ өмнөөс амин чухал ёслолуудыг хүлээн авч болдог.

Ариун сүмийн ёслолууд таны амьдралыг хэрхэн чиглүүлж мөн адисалсан бэ? Эдгээр ёслолд оролцсон нь таныг Тэнгэрлэг Эцэгт хэрхэн ойртуулсан бэ?

Ариун сүмийн ёслолуудтай холбоотой ямар туршлагауд чуулгын гишүүдэд байгаа вэ? Ариун сүмийн ёслолуудын талаар судалж, гэрчлэлтэй болоход тэд бие биедээ хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлдэж байхдаа эдгээр судар, материалыг залбирч судлаарай. Залуу эрэгтэйчүүд ариун сүмийн ёслолыг хүлээн авахуйц зохистой байж, ариун сүмийн ёслолд оролцоход юу сүнслэгээр нөлөөлөх вэ?

С ба Г 84:19–22 (Санваарын ёслолуудад бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг)

Томас С.Монсон, Ариун сүмийн адислалууд, *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 77–79

С ба Г 131:1–4 (Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ)

Квинтин Л.Күк, “Үндэс ба мөчрүүд,” *Ensign* эсвэл 2014 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 63–67

Кэнт Ф.Ричардс, “Бурханлаг чанарын хүч,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган* дээр хэлсэн үгс, 107–110

“Ариун сүмүүд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 27–32

Видео бичлэг: “Ариун сүм бол гэрэлт цамхаг”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Ангид нэг эд зүйл эсвэл зураг авчран, энэ нь өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй ямар холбоотойг асуу. Өнгөрсөн долоо хоногт заасан сургаалыг хамтдаа дүгнэ.
- Нэг залуу эрэгтэйг ариун сүмийн зураг барьж зогсоод, ариун сүмийн ёслолууд түүнд яагаад чухал байдгийг тайлбарлахад урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр залуу эрэгтэйчүүдэд яагаад ариун сүмийн ёслолууд чухал болохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Залуу эрэгтэйчүүдийг дараах өгүүлбэрийг гүйцээгээд, хариултаа ангитайгаа хуваалцахад урь. “Би ариун сүмд орж байхдаа _____.” “Тэд ахлагч Кэнт Ф.Ричардсын “Бурханлаг чанарын хүч” хэлсэн үгэн дэх жагсаалтаас өөр ямар хариулт олсон бэ? Тэд мөн “Яагаад ариун сүмийн ёслолууд чухал вэ?” асуултын хариултыг олж мэдэхийн тулд уг хэлсэн үгээс хайж болно. Ариун сүмд саяхан орсон туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд ариун сүмийн ажлаас ямар ямар адислал хүлээн авсан бэ?
- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Томас С.Монсоны “Ариун сүмийн адислалууд” хэлсэн үгнээс ариун сүмд шүтэн биширснээр хэрхэн адислагддагийг олж мэдэхэд урь. Ариун сүмд орж, ёслолуудад оролцсоноор тэд хэрхэн адислагдсан бэ? Та мөн ариун сүмийн ёслолууд амьдралыг тань хэрхэн адисалсныг харуулж буй амьдралынхаа туршлагыг хуваалцаж болно.
- Ариун сүмийн өмнө зогсож байгаа гэрлэсэн хосын зургийг үзүүл (Сайн мэдээний уран зургийн цуглуулга, 120-ийг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдийг Сургаал ба Гэрээний 131:1–4-ийг хамтдаа уншаад, гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орж байгаа хүмүүст амлагдсан адислалыг олж мэдэхэд урь. Энэхүү гэрээнд ороогүй хүмүүст ямар адислал өгөгдөх боломжгүй вэ? Гэрлэлтийн талаарх Их Эзэний бодол дэлхийн үзэл бодлоос юугаараа ялгаатай вэ? Залуу эрэгтэйчүүд ариун сүмийн ёслолуудад оролцсоноор тэдний болон тэдний ирээдүйн гэр бүлийн авах боломжтой адислалын талаар гэрчлэлээ хуваалц.
- “Ариун сүм бол гэрэлт цамхаг” видео бичлэгийг үзүүлээд, залуу эрэгтэйчүүдээс яагаад Моу Тамын

Заахад туслах арга

“Бид сайн мэдээний сургаалуудаас суралцахаар цуглах үедээ хүндэтгэлийн сүнстэй байх ёстой. ... Бишрэл хүндэтгэлгүй байдал нь оюун санааны болон сүнсний хоёулангийнх нь илчлэлт авах нандин эмзэг сувгуудыг хааснаар эсрэг талын зорилгыг хангадаг” (Боид К.Пакэр, in *Teaching, No Greater Call* [1999], 82).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч ариун сүм дотор олонтоо заадаг байлаа. Тэрээр мөн хожмын үеийн бошиглогчдоороо дамжуулан ариун сүмийн ёслолууд биднийг Цагаатгалаар дамжуулан авах боломжтой хамгийн агуу адислал руу хөтөлдөг гэдгийг заасан. Та ариун сүмийн ёслолуудын ач холбогдлыг ойлгох тусам залуу эрэгтэйчүүдийг ариун сүмийн ёслолуудад бэлтгэхэд нь илүү үр дүнтэй дэмжиж чадна.

гэр бүл ариун сүм орохын тулд ийм агуу золиослолууд хийхэд бэлэн байсныг асуу. Тэд ариун сүмд орж, адислагдахын тулд ямар золиослол хийсэн, эсвэл хэн нэгэн ямар золиослол хийж байгааг харсан бэ?

- Чуулгыг хоёр бүлэгт хуваагаад, нэг хэсгийг нь нөгөө хэсгийнхээ нас барсан өвөг дээдэс хэмээн төсөөлөхийг хүс. Тэднийг баптисм хүртээгүй нас барсан ч сүнсний дэлхийд сайн мэдээг хүлээн авсан байгаагаар төсөөлөн бодоход урь. Тэдний хүн

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ариун сүмийн ёслолуудын ач холбогдлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Боломжтой бол чуулгаараа гэр бүлийнхээ гишүүдийн нэрсийг авч яван, ариун сүмд нас барагсдын өмнөөс баптисм хүртэх аяллын төлөвлөгөөг удирдаж болно. Мөн чуулгын гишүүдийг өнөөдөр сурсан

нэг бүрийг амьд байгаа үр удамдаа захиас бичээд, чуулгын нөгөө бүлгийн нэг залуу эрэгтэйд өгөхийг хүс. Чуулгын гишүүдээс захиас бүрийг чанга уншихыг хүс. Самбар дээр энэ хичээлийн гарчгийг бичээд, залуу эрэгтэйчүүдийг ахлагч Квинтин Л.Күкийн “Үндэс ба мөчрүүд” хэлсэн үгэн дэх “Гэр бүлийн түүхийн ажлыг хийх техник технологи” гарчигтай хэсгийн гурав, дөрөв дэх догол мөрийг уншингаа энэ асуултын тухай бодоход урь. Тэднээс санал бодлоо хуваалцахыг хүс.

зүйлээ хэрэгжүүлж, ариун сүмд орохоор бэлдэхэд нь урамшуулан дэмжиж болно.

- Өнөөдрийн сурсан зүйлээс тэд юу хийх ёстой гэж мэдэрснийг чуулгын гишүүдээс асуу.

Сонгосон материалууд

Квинтин Л.Кук, “Үндэс ба мөчрүүд,” Ensign, 2014 оны 5-р сар, 46 эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 65

Ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил зөвхөн бидэнд хамаатай зүйл биш юм. Та бүхэн хөшигний нөгөө талд буй, сүнсний шоронгийн хүлээсээс чөлөөлөх авралын ёслолуудыг хүлээж байгаа хүмүүсийн талаар бодоцгооно уу. Шоронг “хоригдох, эрх чөлөөгүй байх” [Merriam-Webster’s Collegiate Dictionary, 11 дэх хэвлэл (2003), “prison”] гэж тодорхойлсон байдаг. Эрх чөлөөгүй байгаа тэр хүмүүс л “одоо яах вэ?” гэж асууж байж магадгүй юм.

Нэгэн итгэлтэй эгч Солт Лэйкийн ариун сүмд байхдаа мэдэрсэн онцгой сүнслэг тохиолдлынхоо талаар надтай хуваалцсан юм. Батлах ёслолын

өрөөнд, нас барагсдын өмнөөс хийлгэх ёслолын үгийг хэлж дууссаны дараа тэр эмэгтэй “Шоронд хоригдогсод бүгд чөлөөлөгдөнө!” гэж хэлэхийг сонссон байна. Тэрээр өөрсдийн баптисм, баталгааны ёслолууд хийгдэхийг хүлээж байгаа хүмүүсийн өмнөөс энэхүү ажлыг яаравчлан хийх шаардлагатай байна гэдгийг мэдэрчээ. Гэртээ ирснийхээ дараа тэрээр дээрх сонссон үгсээ судраас хайж, Иосеф Смитийн “Зүрх сэтгэл чинь баясаг, мөн үлэмжийн баяртай байг. Дэлхий гэнэт дуу дуулж эхлэг. Дэлхий байхаас өмнө, тэднийг шоронгоос гэтэлгэх боломжийг бидэнд олгосон тэр зүйлийг тогтоосон Иммануелын Хаанд мөнхийн магтаалын сүлд дууллыг нас барагсад урагш өргөг; учир нь хоригдлууд чөлөөтэйгөөр явах болно” [С ба Г 128:22] гэж хэлсэн тунхгийг Сургаал ба Гэрээний 128-р хэсгээс олсон юм.



Санваарын тангараг ба гэрээ гэж юу вэ?

Бид ариун санваарыг “тангараг ба гэрээгээр” хүлээн авдаг. Энэ нь Тэнгэрлэг Эцэг биднийг дуудлагаа сайн хийж, тушаалуудыг итгэлтэйгээр сахин, Бурханы амнаас гарах үг бүрийн дагуу амьдрах юм бол санваарын хүч чадал ба адислалтай байж чадна хэмээн Өөрийн тангаргийг өгдөг гэсэн үг юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та санваарын гэрээнүүдийн тухай судраас мөн бусад материалаас судалж байхдаа залуу эрэгтэйчүүдэд өөрсдийн санваарын дуудлага ба үүрэг хариуцлагаа өсөн нэмэгдүүлэхэд нь туслах зүйлсийг эрж хайгаарай.

С ба Г 84:33–44 (Хүмүүн нь санваарын тангараг ба гэрээгээр дамжуулан мөнхийн амьдралыг авна)

С ба Г 121:34–40 (Яагаад олон хүн дуудагддаг ч цөөн хэд нь сонгогддог вэ?)

С ба Г 121:41–46 (Санваарыг зөвхөн зөв шударга үйлсэд ашиглах ёстой)

Хэнри Б.Аиринг “Итгэл болон санваарын тангараг ба гэрээ,” *Ensign* эсвэл *Лиахона* 2008 оны 5-р сар, 61–64

Антони Д.Пэркинс “Өөрсдийн талаар болгоомжтой бай” *Ensign* эсвэл *Лиахона* 2012 оны 11-р сар, 54–56

“Мелкизедек санваарыг хүлээн авахад бэлтгэх нь” Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 84–87

Видео бичлэг: “Өөрсдийгөө ариусга”

Та санваартны хувьд өөрийн дуудлагаа өсөн нэмэгдүүлсэн үеийнхээ тухай бод. Үүнийг хийснээр та ямар адислалуудыг хүлээн авсан бэ? Дуудлагаа өсгөн нэмэгдүүлэх хүслийг юу танд төрүүлдэг вэ?

Санваарыг хүлээн авахдаа хийсэн гэрээгээ сахихад залуу эрэгтэйчүүдэд юу саад болдог вэ? Та залуу эрэгтэйчүүд санваараа өсөн нэмэгдүүлж эсвэл ашиглаж байгааг хэзээ харсан бэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэй бүрээс өнгөрсөн долоо хоногт сурсан ямар нэг зүйлтэй нь холбоотой зураг зураад, энэ талаараа ангийнхантайгаа хуваалцахыг хүс. Тэд сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ?
- Чуулгын цуглаанд толь бичиг авчраад, тангараг ба гэрээ гэдэг үгсийн

тодорхойлолтыг олоход урь. Тэдний нэгийг самбар дээр тодорхойлтуудыг товчхон дүгнэн бичихийг хүс. Залуу эрэгтэйчүүд яагаад эдгээр үгс нь санваар хүлээн авахтай холбоотой гэж боддог вэ? (С ба Г 84:40–41-ийг үзнэ үү).

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь чуулгын гишүүдэд санваарын тангараг ба гэрээг ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Танай чуулгын зарим гишүүд Мелкизедек санваарыг авахын тулд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (84–86-р хуудсыг үзнэ үү) дэх үйл ажиллагааг гүйцэтгэсэн байж магадгүй юм. Хэрэв тийм бол тэднийг санваарын тухай сурсан зүйлээсээ чуулгын бусад гишүүддээ заахыг урь.
- Самбар дээр “Санваарын тангараг ба гэрээ” гэж бич. Үүний доор “Хүний амлалтууд” ба “Бурханы амлалтууд” гэж бич. Эрэгтэй хүн санваар хүлээн авахдаа Бурхантай гэрээ хийдэг гэдгийг тайлбарла. Чуулгын гишүүдийг С ба Г 84:33–44-өөс санваарын амлалтыг хүлээн авдаг хүмүүс юуг хүлээн авдаг мөн Бурхан хариуд нь тэдэнд юу амладаг тухай хэсгүүдийг олж, тэмдэглэхийг хүс. Тэмдэглэсэн зүйлээ самбар дээр зохих гарчгийн дор бичихийг

тэднээс хүс. Чуулгын гишүүдэд санваараа гүйцэлдүүлэхэд ирдэг адислалуудыг олж харахад нь туслахын тулд хувийн туршлагаа хуваалц.

- “Өөрсдийгөө ариусга” видео бичлэгийг үзүүлээд, залуу эрэгтэйчүүдээс санваараа итгэлтэйгээр ахиулах нь чухал болох тухай сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Бишопын зөвшөөрөлгүйгөөр цөөн хэдэн эгчийг чуулгын цуглаанд урьж, итгэлтэй санваартнууд тэдний болон тэдний гэр бүлийн амьдралд хэрхэн нөлөөлсөн тухай хуваалцахыг хүс.
- Залуу эрэгтэй бүрд ерөнхийлөгч Хэнри Б.Аирингийн “Итгэл болон санваарын тангараг ба гэрээ” хэлсэн үгийг хувиалан өгөөд, дуудлагаа итгэлтэйгээр гүйцэлдүүлдэг санваартнуудын хүлээн авдаг

Заахад туслах арга

“Буруу хариултуудад хүндэтгэлтэйгээр мөн эелдгээр хариул. Уг хүнийг хичээлд үргэлжлүүлэн оролцоход нь санаа зовохгүй байлгахад анхаар. Та хариуцлагыг өөртөө авахын тулд “Би асуултаа тодорхой тавиагүй юм шиг байна. Намайг уучлаарай. Би дахиад асууя даа” гэх мэтээр залруулж болно (Teaching, No Greater Call [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дэлхий дээр тохинуулах явцдаа Өөрийн дагалдагчдыг Түүний заасан итгэлийн дагуу үйлдэж, үнэний дагуу амьдрахыг урьсан. Өөрийн бүх сургаалдаа Тэр дагалдагчид нь бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Залуу эрэгтэйчүүдийг бүх зүрх сэтгэлээсээ санваарын тангараг ба гэрээг ойлгож, үүний дагуу амьдрахад нь туслах арга замуудыг бодож ол.

адислалуудыг олж мэдэхэд урь. Олж мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцахыг тэднээс хүс. Ерөнхийлөгч Аирингийн дурдсан ямар адислалыг тэд хүлээн авахыг хамгийн ихээр хүсч байна вэ? Яагаад?

- Ахлагч Антони Д.Пэркинсийн “Өөрсдийн талаар болгоомжтой бай” хэлсэн үгийн “Санваарын тангараг ба гэрээ” гэсэн гарчигтай

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд санваарын тангараг ба гэрээг илүү сайн ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Тэрээр санваар дахь дуудлага ба үүрэг хариуцлагаа өсгөн нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө чуулгын гишүүдэд хэлж, тэднийг мөн өөрийн гэсэн тийм төлөвлөгөө гарахыг урьж болно.
- Тэднийг санваарын үүргээ биелүүлэх үед Тэнгэрлэг Эцэг ямар арга замуудаар адисалдаг тухай бодохыг тэднээс хүсч болно.

хэсгээс хуваалц. Ахлагч Пэркинсийн дүрсэлсэн “селестиел замыг” самбар дээр зурах нэг залуу эрэгтэйг урь. Тэгээд залуу эрэгтэй бүрийг уг зам дээр санваартан хүний болгоомжлох ёстой, сүнслэг аюулын анхааруулах тэмдгийг нэмэхийг урь. Бид санваартнуудын хувьд эдгээр аюулаас зайлсхийхийн тулд юу хийж чадах вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Аиринг “Итгэл ба санваарын тангараг болон гэрээ” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2008 оны 5-р сар, 61–64

Та нар итгэлтэйгээр урагшилснаар хүлээн авах зарим нэг адислалуудын талаар би тайлбарлая.

Нэгдүгээрт, та нар тангараг болон гэрээг хийх боломжтой байгаа нь Бурхан та нарын хүч чадал, чадварыг мэдээд та нарыг сонгосон нь тодорхой билээ. Тэрээр сүнсний дэлхийд Түүнтэй хамт байхаас л та нарыг мэддэг байсан. Тэр та нарын хүч чадлыг урьдчилан мэддэг учраас та нарт Есүс Христийн үнэн сүмийг олж мөн санваарыг хүртэх боломжийг олгосон. Тэр та нарт итгэдэг гэдэг нь тодорхой учраас та нар ч өөртөө итгэлтэй байж болно.

Хоёрдугаарт, та нар гэрээнүүдээ сахихаар хичээх аваас Аврагч Өөрөө та нарт тусална хэмээн амласан. Та нар санваарыг хүндлэн урагшлах аваас Тэрээр: “Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн Миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн Миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” хэмээн хэлсэн. [С ба Г 84:88.]

Та бүхэнд заримдаа ариун санваарынхаа үүргийг гүйцэтгэх хүч чадал Надад байсны адил байх болно гэсэн баталгаа дахин хэрэгтэй болж магадгүй юм. Их Эзэн танд ийм баталгаа хэрэгтэйг урьдчилан харсан. Тэрээр “Учир нь Миний ярьсан энэхүү хоёр санваарыг хүртэхэд мөн дуудлагаа эрхэмлэн биелүүлэхэд итгэлтэй байдаг хэн ч

гэсэн, биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр ариусгагддаг бөлгөө” гэж хэлсэн билээ. [С ба Г 84:33.]

Та нар гэрчлэлээ хуваалцах хүч чадалтай байх мөн ингэх явцдаа цэвэршигдэж, өөрт тань амлагдсан мөнхийн амьдралд тэнцэхүйц байх болно хэмээх амлалтыг хүлээн авсан. . . .

Санваарын гэрээгээ дагах аваас та бүхнийг урамшуулах өөр нэгэн гайхалтай адислал байдаг. Санваарын үйлчлэл та нарыг мөнхийн гэр бүлд амьдрахад бэлтгэнэ. Энэ нь нөхөр, эцэг, хүү эсвэл ах, дүү байна гэдэг нь юу гэсэн үг болох талаарх та нарын ойлголтыг өөрчилнө. Мелкизедек санваараар дамжуулан мөнхийн амьдралыг авах болно гэсэн амлалт бодит болох ба итгэл чинь өсөх үед энэхүү өөрчлөлт зүрх сэтгэлд чинь бий болно. . . .

Би өөрөө итгэлтэйгээр үйлдэх санваарын үйлчлэл бидний зүрх сэтгэл ба мэдрэмжинд ихээр нөлөөлдөг гэдгийн нэгэн гэрч билээ. Өнөөдөр миний үгийг сонсож байгаа ямар ч залуу эрэгтэй өөрийн санваарт хүндэтгэлтэй хандсанаар бидний амьдардаг дэлхий дээр маш их тархсан бэлгийн харьцааны нүглийн уруу таталтаас хамгаалагдах болно гэдэгт итгэлтэй байж болно. Энэхүү үдэш намайг сонсож байгаа аароны санваартан нь мөнхийн санваараар дамжуулан мөнхийн амьдралын шагнал нь гарцаагүй байдаг гэдэгт итгэлээ нэмэгдүүлснээр Бурханы охидын жинхэнэ үнэ цэнийг олж харах мөн өсч үржих амлалтанд цэвэр, ариун байх шалтгаан байдаг гэдгийг мэдэх хүчтэй байх болно.



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь ямар утга учиртай вэ?

Баптисм хүртсэнээр бид өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авдаг. Бид ариун ёслолоос хүртэх бүрдээ энэхүү гэрээгээ шинэчилдэг (С ба Г 20:77-г үзнэ үү). Бид амьдралдаа Их Эзэнийг нэгдүгээрт тавьж, Түүний адил бодож мөн үйлдэхийг эрэлхийлэн, “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч” болох үед энэхүү гэрээгээ биелүүлдэг (Мозая 18:9).

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Христийн нэрийг өөрсөд дээрээ авсан гэрээгээ ойлгоход залуу эрэгтэйчүүдэд ямар судар ба материалууд туслах вэ?

Мозая 5 (Христийн нэрийг өөрсөд дээрээ авах нь яагаад чухал вэ?)

3 Нифай 27:27 (Бид Есүс Христ шиг байхыг хичээх ёстой)

С ба Г 20:37, 77 (Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь бидний баптисмын гэрээ ба ариун ёслолын нэг хэсэг юм)

Робэрт Д.Хэйлс “Илүү Христтэй адил Христийн шашинтан байх нь” *Ensign* эсвэл *Лиахона* 2012 оны 11-р сар, 90–92

Мэрвин Б.Арнолд “Та нар Миний нэрээр та юу хийсэн бэ?” *Ensign* эсвэл *Лиахона* 2010 оны 11-р сар

Видео бичлэг: “Ганцаар зогсох зоригтой бай”

Христийн нэрийг өөр дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг гэж та боддог вэ? Энэхүү гэрээгээ сахихын тулд та юу хийдэг вэ?

Тэд Христийн нэрийг өөрсөд дээрээ авснаар ямар сорилт ба адислалууд ирсэн бэ? Залуу эрэгтэйчүүд амьдралдаа Бурханыг нэгдүгээрт тавьдаг болоход та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс чуулгын цуглаан эсвэл сүмийн бусад ангиудад сурсан ямар нэг зүйлийг нь сануулсан саяхны туршлагаасаа хуваалцахыг хүс.
- Чуулгын нэг гишүүнийг ариун ёслолын талхны залбирлыг хэлэхэд урь (эсвэл С ба Г 20:77-оос унш). “[Есүс Христийн] нэрийг өөрсөд дээрээ авна” гэдэг нь юу гэсэн утгатай гэж тэд боддог вэ?

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь чуулгын гишүүдэд Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- “Ганцаар зогсох зоригтой бай” видео бичлэгийг үзүүл. Энэ видео бичлэгт ерөнхийлөгч Монсоны өгсөн гол захиасын талаар залуу эрэгтэйчүүд ямар сэтгэгдэлтэй байна вэ? Видео бичлэгт гардаг өсвөр үеийнхэн Аврагчийн нэрийг өөрсөд дээрээ авсан гэдгээ хэрхэн үзүүлсэн бэ? Залуу эрэгтэйчүүдийг үүнтэй ижил төстэй туршлагаасаа хуваалцахыг урь.
- Ерөнхийлөгч Хэнри Б.Аирингийн дараах үгийг хуваалц: “Бид Түүний нэрийг өөрсөд дээрээ авна хэмээн амладаг. Энэ нь бид өөрсдийгөө Түүнийх хэмээн үзэх ёстой гэсэн үг юм. Бид Түүнийг нэгдүгээрт тавина. Бид өөрсдийн хүсэл болон дэлхийн заадаг зүйлсийг биш харин Түүний хүссэн зүйлийг хүсэх болно” (“That

We May Be One” *Ensign* эсвэл *Лиахона* 1998 оны 5-р сар). Чуулгыг гурван бүлэг болгон хуваагаад бүлэг тус бүрээс дараах асуултуудын нэгийг хэлэлцэхийг хүс: Өөрсдийгөө Христийнх хэмээн үзэх гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид хэрхэн Аврагчийг нэгдүгээрт тавьдаг вэ? Аврагчийн хүссэн зүйлийг хүснэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Бүлгээрээ хэлэлцсэн зүйлээ бүлэг бүрээс нэг нь гарч чуулгатайгаа хуваалцахыг урь.

- Залуу эрэгтэйчүүдийг Мозая 5-ыг уншаад, “Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг вэ?” мөн “Христийн нэрийг өөрсөд дээрээ авах нь яагаад чухал вэ?” гэх мэт асуултад хариулт олохыг урь. Уншсан зүйлийнхээ талаар хуваалцаж мөн Аврагчийн нэрийг өөрсөд

Заахад туслах арга

“Суралцагчдаас зарчмуудыг өөрийнхөө үгээр илэрхийлэхийг хүс. Энэ нь танд тэд зарим нэг үгс эсвэл санааг ойлгосон эсэхийг хичээлийн эхэнд мэдэхэд тусална. Хэрэв тэд ойлгоогүй бол та тэдэнд тайлбарлаж өгөөд, үлдсэн хичээлээ тэдэнд илүү ойлгомжтой заахад тусална” (*Teaching, No Greater Call* [1999], 73).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ мэддэг байсан ба тэдний хэн болж чадахыг ч мөн мэддэг байсан. Зовж цөхөрсөн үед нь Тэрээр тэднийг хэзээ ч орхилгүй харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохиноулсаар байлаа. Та өөрийн заадаг залуу эрэгтэйчүүддээ хайр болон дэмжлэгээ хэрхэн үзүүлж болох вэ?

дээрээ авсан гэдгээ харуулан хийж болох зүйлсээ жагсаан бичихийг тэднээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдээс яагаад тэдний эцэг эхчүүд өөрийнх нь нэрийг өгөхөөр сонгосныг мэдэх үү хэмээн асуу. Тэдний нэр тэдний хэн болох мөн тэдний хэрхэн амьдрах хүсэлд нь хэрхэн нөлөөлдөг вэ? Хэсэг залуу эрэгтэйчүүдээс Хиламан 5:6–8-ыг харин үлдсэн хэсгээс нь ахлагч Мэрвин Б.Арнолдын “Та нар миний нэрээр юу хийсэн бэ?” хэлсэн үгийн эхний гурван догол мөрийг уншихыг хүс. Тус бүрийн уншсан зүйлээ нэг нэгэндээ товчхон ярьж өгөхийг тэднээс хүс. Нифай, Лихай, Жорж Албэрт Смит зэрэг хүмүүсийн нэр эдгээр хүмүүсийг зөв шударга амьдрахад хэрхэн сүнслэгээр нөлөөлсөн бэ? Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна хэмээх бидний гэрээ бидэнд хэрхэн сүнслэгээр нөлөөлдөг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг болохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Аврагчийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь юу гэсэн үг болох талаар үзэл бодлоо хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдийг өнөөдөр сурсан зүйл дээрээ үндэслэн амьдралдаа өөрчлөх ёстой ямар нэг зүйл байгаа эсэх талаар тунгаан бодоход урьж болно.

вэ? Уг хэлсэн үгийн сүүлийн хоёр догол мөрийг чуулгаараа хамт уншаад, ахлагч Арнолдын өгсөн уриалгыг хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцэхэд залуу эрэгтэйчүүдийг урь.

- Ахлагч Робэрт Д.Хэйлсийн дараах мэдэгдлийг хуваалц: “Христэд итгэгч гэдэг нь Христийн нэрийг өөрсөд дээрээ авсан гэсэн үг юм.” Ахлагч Хэйлсийн “Христтэй илүү адил Христийн шашинтан байх нь” хэлсэн үгийг хэсэгчлэн залуу эрэгтэйчүүдэд хуваан өг. Залуу эрэгтэй бүрийг авсан хэсгээ уншаад, “Христэд итгэгч байна гэдэг нь юу гэсэн үг вэ?” гэдэг асуултад хариулт олохыг хүс. Тэднээс уншсан зүйлийнхээ талаар хуваалцан, Христэд үнэн итгэгч хэмээн боддог өөрсдийн таньдаг хэн нэгний тухай жишээ татан ярихыг хүс.

Сонгосон материалууд

Роберт Д.Хэйлс “Христтэй илүү адил Христийн шашинтан байх нь” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2012 оны 11-р сар, 90–92

Түүний төгсөшгүй хайр ба нигүүлслээр дамжуулан бид Христтэй илүү адил Христийн шашинтан болж чадна гэдгийг би гэрчилж байна. Христийнхтэй адил зан чанаруудыг дагах талаар бодоорой. Тэдгээр чанарыг бид өөрсдөдөө хэрхэн хүчирхэгжүүлж байна вэ?

Христийн шашинтны хайр. Аврагч хүн бүрийг үнэлдэг байв. Бүгдэд эелдэг, энэрэнгүй Тэр нэгийг олохын тулд ерэн есийг орхисон [Матай 18:12–14-ийг үзнэ үү], 12 тийм ээ, Түүнд “[бидний] толгой дээрх үс бүр тоологдсон” [Лук 12:7].

Христийн шашинтны итгэл. Уруу таталт, зовлон шаналал, хавчлагуудыг үл харгалзан Аврагч Тэнгэрлэг Эцэгтээ итгэж, Түүний зарлигуудад дуулгавартай, итгэлтэй байхыг сонгосон.

Христийн шашинтны золиослол. Өөрийн амьдралын турш Аврагч Өөрийн цаг, Өөрийн хүч тэнхээг, бүр цаашлаад Бурханы бүх хүүхэд амилуулагдаж, мөнхийн амьдралыг өвлөх боломжтой болгохын тулд Цагаатгалаар дамжуулан Өөрийгөө өгсөн.

Христийн шашинтны халамж. Сайн Самари хүний адил Аврагч Түүний эргэн тойронд байгаа хүмүүсийг тэдний соёл боловсрол, итгэл бишрэл болоод нөхцөл байдлуудыг хайхралгүй аварч, хайрлаж, асран тэтгэхийн тулд байнга гараа сунгасаар байсан.

Христийн шашинтны үйлчлэл. Худгаас ус татах, загасаар хоол хийх эсвэл бохир хөлийг угаах байсан ч хамаагүй Аврагч Өөрийн өдрүүдийг бусдад үйлчлэхээр ядарч цуцсанд тусалж, сул доройг хүчирхэгжүүлэхэд зориулсан.

Христийн шашинтны тэвчээр. Өөрийн уй гашуу, зовлон шаналалд Аврагч Өөрийн Эцэгийн тусламжийг тэвчээртэйгээр хүлээсэн. Тэр биднийг зөвийг мэдэж, Түүн дээр, гэртээ ирэхийг маань тэвчээртэйгээр хүлээдэг.

Христийн шашинтны амар амгалан. Өөрийн номлолынхоо турш Тэрээр ойлголтыг өдөөж, амар амгаланг сайшаасаар ирсэн. Ялангуяа Өөрийн шавь нарын дунд Тэрээр Христийн шашинтан нь бусад Христийн шашинтнуудтай хоорондынхоо ялгааг үл харгалзан, тэмцэлдэж болохгүйг заасан.

Христийн шашинтны уучлал. Биднийг хараадаг тэднийг адислахыг Тэрээр бидэнд заасан. Түүнийг цовдолсон хүмүүсийг уучлахыг гуйсан залбирлаараа биднийг хавчдаг хүмүүсийг адислах жишээг үзүүлэн, Тэрээр бидэнд заасан.

Христийн шашинтны хөрвөлт. Петр ба Андрейгийн адил олон хүн сонсонгуутаа сайн мэдээний үнэнийг таньж мэддэг. Тэд тэр даруйдаа хөрвөгддөг. Бусад хүмүүсийн хувьд арай урт хугацаа шаардагдаж магадгүй. Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлтэд Аврагч “Бурханаас буй тэр нь гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг” [Сургаал ба Гэрээ 50:24] хэмээн заасан. Есүс Христ бол “гэрэл мөн дэлхийн Гэтэлгэгч; үнэний Сүнс”. [Сургаал ба Гэрээ 93:9.]

Христийн шашинтны эцсээ хүртэл тэвчих. Өөрийн бүхий л өдрүүдэд Аврагч маань Өөрийн Эцэгийн тааллын дагуу үйлдэхээс хэзээ ч шантраагүй, харин ч Өөрийн мөнх бус амьдралынхаа эцсийг хүртэл үнэн, зөв шударга, бурханлаг, нигүүлсэнгүй байсан.

Наймдугаар сар: Гэрлэлт ба гэр бүл

“Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Ensign эсвэл Лиахона, 2010 оны 11-р сар, 129).

Энэхүү бүлгийн тоймууд нь Аароны санваартнууд тэдний өөрсдийнх нь амьдралд ба Тэнгэрлэг Эцэгийн Өөрийнхөө хүүхдүүдийн төлөөх төлөвлөгөөнд гэр бүл нь чухал болохыг ойлгоход нь туслах болно. Энэхүү бүлэгт тэдний олж мэдсэн үнэнүүд нь чөтгөрийн дайралт болон заль мэхээс гэрлэлт, гэр бүлээ хамгаалахад нь тэдэнд туслах болно. Эдгээр үнэн гэр бүлүүдээ одоо хүчирхэгжүүлэхэд мөн Сионы зохистой нөхөр, эцгүүдийн хувьд зөв шударга гэр бүлүүдийг өсгөн хүмүүжүүлэхэд бэлтгэхийн тулд санваарын үүргээ биелүүлэхэд нь тэдэнд мөн туслах болно.

Ням гаргийн чуулгын цуглааны Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь хэсгийг биелүүлэхийн тулд энэ хэсгийг заах явцад Бурханы өмнө хүлээсэн үүргийн дараах тоймыг заах хэрэгтэй.

Энэ сард сонгох тоймууд:

Би гэр бүлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Ариун явдал яагаад чухал вэ?

Ариун сүмд гэрлэх нь яагаад чухал вэ?

Гэр бүл яагаад чухал вэ?

Болзох талаарх Сүмийн жишгийг дагах нь яагаад чухал вэ?

Зөв шударга нөхөр, эцэг хүн болохын тулд одооноос би өөрийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

Гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргүүд нь хэрхэн харилцан бие биенээ нөхөн гүйцээдэг вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм.
Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мюче-
лийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу
эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг
бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануу-
дыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн
зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлтэй холбоотой :

“Бусдад үйлчлэх нь,” 26–27, 50–51, 74–75 хуудас

“Сургаальг ойлго,” 18–20, 42–44, 66–68-р хуудас

“Гэр бүл ба найз нөхөд,” 79–83 -р хуудас



НАЙМДУГААР САР: ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би гэр бүлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?

Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай ... гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129). Бид эдгээр зорилгуудыг гүйцэлдүүлэхэд эцэг эхдээ туслах үед Тэнгэрлэг Эцэгийн бидэнд хүсдэг аз жаргалыг олж авахад нь гэр бүлүүддээ тусалж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, суралцах материалыг залбирч судал. Залуу эрэгтэйчүүдэд гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд юу тусална гэж та бодож байна вэ?

1 Нифай 8:12 (Лихай гэр бүлээ амьдралын модны жимснээс хүртээсэй хэмээн хүссэн)

1 Нифай 16:14–32 (Нифай гэр бүлээ хүчирхэгжүүлсэн)

2 Нифай 25:26 (Бид хүүхдүүддээ Христийн талаар заадаг)

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 26, 50, 74, 80-81

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11 сар, 129

Дийтр Ф.Угдорф, “Авран хадгалдаг тэднийг магтъя,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 60–63

Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 77–79

М.Рассэлл Баллард, “Аав хүү хоёр: Онцгой ойр дотно харилцаа,” *Ensign* эсвэл 2009 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 55–58; мөн “Эцгүүд болон хөвгүүд” видео бичлэгийг үзнэ үү

Видео бичлэгүүд: “Эв нэгдэлгүй ах дүү хоёр,” “Жижиг зүйлсээр дамжуулан”

Гэр бүлд тань аз жаргал авчирсан ямар туршлага танд байдаг вэ? Аврагчийн заасан зүйлсийг дагаснаар гэр бүлд тань ямар адислалууд ирэхийг та харсан бэ?

Та заадаг залуу эрэгтэйчүүдийнхээ гэр бүлийн амьдралын талаар юу мэддэг вэ? Та залуу эрэгтэйчүүдэд Аврагчийн заасан зүйлсийг дагах үед гэр бүлүүд илүү аз жаргалтай байдаг гэдгийг ойлгоход нь хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Хичээл эхлэхээс өмнө чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүнийг өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй холбоотой нэг дуулал сонгоход урь. Тэр залуу эрэгтэйгээр дууллын бадгаас уншуулж, чуулгын гишүүдээр энэ дуулал өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй ямар холбоотой байгааг хуваалцуул.
- Чуулгын нэг гишүүнээс судруудах нэг гэр бүлийн зургийг үзүүлэх эсвэл гэр бүлдээ аз жаргал эсвэл гай тогтор авчирдаг гэр бүлийн гишүүдийн үйлдлүүдийг хуваалцахыг хүс (Лихай, Иаков, Адам болон бусад гэр бүлийн талаар ярилцаж болно).

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөөнүүд

Чуулгын цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдэд *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ эсвэл Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь онлайн хувилбар дээр өөрсдийнхөө төлөвлөгөөг гаргах цаг гаргаж өг. Энэ төлөвлөгөө хувь хүнийх боловч чуулгын гишүүд бие биедээ төлөвлөгөөнийхөө талаар санал бодлоо хэлж болно.*

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго бол залуу эрэгтэй бүрийг гэр бүлээ хүчирхэгжүүлэх санваарын үүргээ биелүүлэхэд нь урамшуулан дэмжих явдал юм. Энэхүү хичээлийн нэг хэсэг болгон чуулгын гишүүд гэр бүлийн гишүүндээ үйлчлэх төлөвлөгөөг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээр гаргаж эсвэл “Гэр бүл ба найз нөхөд” төсөл дээр ажиллаж эхлэх ёстой. Чуулгын цуглаанаас өмнө Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо сүм дээр авчирч байхыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцдаа ямар туршлага хурилтлуулж байгаагаа чуулгын дараагийн цуглаанууд дээр хуваалцахад тэднийг урь.

- Ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорф “Авран хадгалдаг тэднийг магтя” хэлсэн үгэндээ гэр бүлийн тухай “Бид адилхан гентэй байж болох ч адилхан биш. Бид бүгдэд өөр өөр өвөрмөц сүнс байдаг. ... Бид өөрсдийн ялгаатай байдлаа баярлан тэмдэглэж болно” гэж заасан. Залуу

эрэгтэй бүрд ямар ямар онцлог зан чанар, хүчтэй тал байгаа вэ? Залуу эрэгтэй бүр гэр бүлээ адислахдаа энэ хүчтэй талаа хэрхэн ашиглаж болох вэ? Чуулгын гишүүд уг хэлсэн үгийг жижиг бүлгүүдэд хуваагдан, хэсэгчлэн судалж, онцгой санагдсан зүйлсээ хуваалцаж болно. Та мөн чуулгын гишүүдийг энэ тоймд байгаа видео бичлэгүүдээс нэгийг үзээд, тухайн гэр бүлүүд харилцаагаа сайжруулахын тулд юу хийснийг олж мэдэхэд урьж болно. Залуу эрэгтэйчүүд гэр бүлийнхнийхээ ялгаатай талыг хэрхэн тэмдэглэн өнгөрүүлж болох вэ? Тэд гэр бүлийн харилцаагаа хүчирхэгжүүлэх талаар ямар ямар санаа хуваалцаж болох вэ?

- Бонни Л.Оскарсон “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид” хэлсэн үгэндээ “эрэгтэй, эмэгтэй, өсвөр үеийнхэн болон хүүхдүүд, мөн ганц бие юм уу гэрлэсэн байхаас үл хамааран бүгд гэрийн эзэн эсвэл эзэгтэй байх боломжтой. Бид өөрийн ‘гэр орныг’ дэг журам болоод цэвэр ариун, аюулгүй газар болгох ёстой” (*Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 132-135) гэж заасан юм. Сүмийн гишүүд гэр бүлээ өөрөөр хэрхэн хамгаалж, хүчирхэгжүүлж чадна гэж Оскарсон эгч зөвлөсөн бэ? Залуу эрэгтэйчүүд гэр орноо дэг журамтай, ариун нандин, аюулгүй газар болгоход туслахын тулд одоо юу хийж чадах вэ?

- Чуулгын хэдэн гишүүнийг энэхүү хичээлийн нэг хэсгийг заахад урих талаар бодож үз. Жишээлбэл: тэд гэр бүл нь аз жаргалтай байхын тулд юу хийдэг талаар хуваалцаж

болно эсвэл доорх үйл ажиллагаануудаас нэгийг нь ашиглаж болно. Зарим прист *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* (80-82-р хуудсууд) номон дахь “Гэр бүл” үйл ажиллагааг гүйцээсэн байж болох ба туршлагауудаасаа хуваалцаж болно.

- Зарим гэр бүлийг илүү аз жаргалтай байхад нь саад болдог зүйлсийг бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Залуу эрэгтэй бүрд “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, 107-р хуудсыг үзнэ үү) хуулбарыг өг. Чуулгын гишүүдэд 7-р догол мөрийг унших хэдэн минут өгөөд, гэр бүлийн амьдралыг аз жаргалд хүргэх зарчмуудын доогуур зурахыг хүс. Залуу эрэгтэй бүрээс 1 Нифай 16:14-32-ыг уншаад, Лихайн гэр бүл эдгээр зарчмыг хэрэгжүүлсэн арга замуудаас хуваалцахыг хүс. Гэр бүлийн амьдралд нь эдгээр зарчмын ач холбогдлыг заасан туршлагауудаа хуваалцахыг тэднээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг “Гэр бүл” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос уншаад, гэр бүлээ хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж чадах талаараа хуваалцахад урь. Залуу эрэгтэй бүрийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын “бусдад үйлчил” хэсгийг гаргаж (дикон, 26; багш, 50; прист, 74), гэр бүлдээ үйлчлэх үйлчлэлээрээ дамжуулан тэднийг хүчирхэгжүүлэхийн тулд хийж чадах зүйлсээ бичихэд урь (“Үйлчлэл хийх миний хувийн төлөвлөгөө”-г үзнэ үү). Цөөн хэдэн залуу эрэгтэйгээс өөрсдийн төлөвлөгөөг чуулгынхантай хуваалцахыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа хайртай байсан бөгөөд тэдний төлөө залбирч, тэдэнд байнга үйлчилдэг байсан. Тэрээр тэдэнтэй хамт байх боломжийг ямагт олж мөн тэдэнд хайраа илэрхийлдэг байлаа. Тэр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан. Залуу эрэгтэйчүүдийг гэр бүлийнхээ бусад гишүүнд хайраа үзүүлэх болон үйлчлэх арга замуудыг олоход урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Санваартнуудын хувьд тэд гэр бүлээ хэрхэн хүчирхэгжүүлж чадахаа ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх* нь ном дээрээ гэр бүлийнхээ гишүүдтэй харилцаагаа хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж болох тухай бичихэд урьж болно (тэд үүнийг хараахан хийгээгүй бол; 82-р хуудсыг үзнэ үү).
- Чуулгын гишүүдийг гэр бүлүүдээ илүү аз жаргалтай байхад нь хэрхэн тусалсан тухай хуваалцахад урьж болно.
- Залуу эрэгтэй бүр гэр бүлдээ илүү аз жаргалтай байхад нь туслах ёстой чухал үүргийнхээ талаар гэрчлэлээ хуваалцаж болно.

Сонгосон материалууд

Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” *Ensign*, 2015 оны 5-р сар, 17 эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 134

Бидний зарим үед тоглоом тохуу маягаар хэрэглэдэг нэгэн нэр томъёог өндөрт авч үзэх хэрэгтэй байна. Энэ нь *гэрийн эзэн, эзэгтэй* хэмээх нэр томъёо юм. Бид эрэгтэй, эмэгтэй, өсвөр үеийнхэн болон хүүхдүүд, мөн ганц бие юм уу, гэрлэсэн байхаас үл хамааран бүгд гэрийн эзэн

эсвэл эзэгтэй байх боломжтой. Бид өөрийн “гэр орныг” дэг журам болоод цэвэр ариун, аюулгүй газар болгох ёстой. Бидний гэр орон Их Эзэний Сүнсээр бялхсан, судраас болон сайн мэдээнээс суралцдаг, мөн зааж сургаж, хэрэгжүүлдэг газар байх ёстой. Бүх хүн өөрийгөө зөвт байдлын өргөөг бий болгогч хэмээн харж чаддагсан бол энэ дэлхий хэрхэн өөрчлөгдөх бол? Бүгдээрээ өөрийн гэр орныг цэвэр ариун байдлаараа ариун сүмийн дараа орох газар болгон хамгаалцгаая.



Ариун явдал яагаад чухал вэ?

Ариун явдал бол бэлгийн харьцааны цэвэр ариун байдал ба ёс суртахууны хувьд бодол санаа, хэл яриа, үйлдлээрээ цэвэр байхыг хэлдэг. Бэлгийн харьцааны дотно байдал нь хүүхэд төрүүлэхэд болон эхнэр нөхрийн хоорондын хайрын илэрхийлэл байхаар Бурханаас заяагдсан юм. Гэрлэлтээс өмнө бэлгийн харьцаанд орохгүй байхыг Бурхан зарлигдсан. Бид бэлгийн харьцааны хувьд цэвэр ариун байснаараа Ариун Сүнсний нөхөрлөлд тохирохуйц болдог бөгөөд бэлгийн харьцааны гэм нүглээс үүдэх сэтгэл зүйн болон сүнслэг доройтлоос хамгаалагдаж, Их Эзэний санваарыг атгахуйц зохистой байдаг.

Ариун явдлын хуулийн дагуу амьдрах нь та нарыг хэрхэн адисалсан бэ?

Залуу эрэгтэйчүүдэд ариун явдлын ач холбогдлыг ойлгоход ямар сургаал хамгийн сайн туслах вэ? Тэд ариун явдлын ач холбогдлыг бууруулах ямар хуурмаг сургаалыг мэддэг вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр суралцах материалыг залбирч, судал. Та залуу эрэгтэйчүүдэд ариун явдлын ач холбогдлыг ойлгож, мэдрэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

Эхлэл 39:7–21 (Иосеф бэлгийн харьцааны гэм нүглээс зугтан гарав)

1 Нифай 10:21 (Бид Бурхантай хамт амьдрахын тулд цэвэр ариун байх ёстой)

Алма 39:1–13 (Бэлгийн харьцааны нүгэл бол жигшүүрт хэрэг юм)

Моронай 9:9 (Ариун явдал бол эрхэм бөгөөд нандин юм)

С ба Г 46:33 (Бурханы өмнө ариун журам ба цэвэр ариун байдлыг хэрэгжүүл)

Линда С.Рийвс, “Бидэнд амлагдсан адислалуудад зохистой байх нь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 9–11

Бойд К.Пакэр, “Аз жаргалын төлөвлөгөө” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 8-11

Дэвид А.Бэднар, “Бид ариун явдалд итгэдэг,” *Ensign* эсвэл 2013 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 50-53

Жэффри Р.Холланд, “Helping Those Who Struggle with Same-Gender Attraction,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 10-р сар, 42–45

“Хувцаслалт ба гадаад төрх,” “Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 6–8, 35–37

“Ариун явдал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 35–40

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар

(судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Хичээл эхлэхээс өмнө чуулгын гишүүдээс өмнөх чуулгын цуглаан дээрээс сурсан зүйлээ 2 минутанд багтаан дүгнэж хэлэхэд бэлтгэхийг хүс. Нэг залуу эрэгтэйд хичээлийн эхэнд дүгнэлтээ хуваалцах боломж өг.
- Нэг залуу эрэгтэйг Потифарын эхнэрийг эсэргүүцэж буй Иосефийн

зургийг гартаа барин (*Сайн мэдээний уран зургийн ном*, 11-г үзнэ үү) өөрийнхөө үгээр түүхийг ярихад урь. Иосефийн итгэлтэй байдлын үр дүнд яваандаа юу тохиолдсон бэ? Хэрэв тэрээр ариун явдлын хуулийг зөрчсөн бол юу тохиолдож болох байсан бэ? Ариун явдалтай хэвээр байх нь яагаад чухал байдаг вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь ариун явдлын хуулийг ойлгоход чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Чуулгын нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэр ариун явдлын хуулийн талаар судалж, заах Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ нэг хэсэг болгон үүнийг хийж болно (“Сургаальг ойлго” 18, 42, 66-р хуудсыг үзнэ үү).
- Залуу эрэгтэйчүүдийн заримыг ариун явдлын талаарх судруудыг уншихад (энэхүү тоймд санал болгосон судруудаас гэх мэт); нөгөө хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос “Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал”; үлдсэн хэсгийг *Итгэлдээ үнэнч байх*

нь номноос “Ариун явдал” хэсгийг уншихад тус тус урь. Тэднээс “Их Эзэнд ариун явдал яагаад чухал вэ?” гэсэн асуултын хариултуудыг хайж олоод, олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Эдгээр судар, материал дахь зарчмууд ариун явдлын талаар дэлхийн заадаг зүйлээс ямар ялгаатай байна вэ? Залуу эрэгтэйчүүд эдгээр материалаас дэлхийн үзэл бодлын худал хуурмагийг мэдэхэд тусалж болох юуг сурдаг вэ?

- “Ариун явдал: Хязгаарлалтууд нь юу вэ?” видео бичлэгийг үзүүл. Видео бичлэгийн дараа залуу

Заахад туслах арга

“Хичээл эхлэхээс өмнө самбар дээр бичсэн асуултууд суралцагчдад уг сэдвийн талаар бодож эхлэхэд тусалдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 93).

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр бүх талаараа тэдний үлгэр дуурайл мөн зөвлөгч нь байсан. Тэрээр тэдэнтэй хамт залбирч, хэрхэн залбирахыг заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шиг тэд ч бас бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр тэдэнд заасан. Түүний заасан арга барилаар хэрхэн сайн мэдээг заахыг Тэрээр тэдэнд заасан. Та залуу эрэгтэйчүүдэд ариун явдал ба ариун журмын жишээг хэрхэн үзүүлж болох вэ?

эрэгтэйчүүдээс чухам ямар ижил төстэй зүйлс (усны хүрхрээ, нисэх онгоц, газар уснаа явагч машин гэх мэт) ариун явдлын хуулийн талаар заадгийг тайлбарлахыг хүс. Энэхүү видео бичлэгээс тэд өөр бас юу олж мэдсэн бэ? Ариун явдал чухал гэдгийг заадаг өөр ижил төстэй зүйлсийн талаар тэднийг бодож, хуваалцахад урь.

- Чуулгын гишүүдийг бүлгүүдэд хуваа. Бүлэг бүрд ерөнхийлөгч Бойд К.Пакэрын “Аз жаргалын төлөвлөгөө,” ахлагч Дэвид А.Бэднанийн “Бид ариун явдалд итгэдэг” эсвэл Линда С.Рийвс эгчийн “Бидэнд амлагдсан адислалуудад зохистой байх нь” хэлсэн үгийн нэг хэсгийг өг. Авсан хэсгээ судлаад, “Яагаад бэлгийн харьцааны хувьд цэвэр ариун байх нь чухал вэ?” гэсэн асуултад хариулахыг бүлэг бүрээс хүс. Тэднийг утга учиртай эсвэл чухал гэж үзсэн мэдэгдэл эсвэл үнэнүүдээ хуваалцахад урь. Тэд яагаад ариун явдал тэдэнд чухал болохыг найзууддаа ойлгуулахын тулд олж

мэдсэн зүйлээ хэрхэн ашиглаж болох вэ?

- Залуу эрэгтэйчүүдээс *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номны “Хувцаслалт ба гадаад төрх хэсгийг ашиглан, “Даруу байдлын талаарх Их Эзэний жишиг юу вэ?” “Эдгээр жишгийг дагах нь яагаад чухал вэ?”, “Даруу байдал нь ариун явдлын хуультай харьцах хандлагад хэрхэн тусгалаа олж нөлөөлдөг вэ?” гэх зэрэг асуултаудад хариулахыг хүс. Тэднээс хариултуудаа хуваалцан, эдгээр жишгийн дагуу амьдрахын тулд юу хийж болох талаар тунгаан бодохыг хүс.

- Залуу эрэгтэйчүүдээс ижил хүйстэндээ сэтгэл татагддаг нэгэн найздаа хэрхэн туслах байсныг нь асуу. Тэднийг ахлагч Жэффри Р.Холландын “Helping Those Who Struggle with Same-Gender Attraction” хэлсэн үгээс санаа хайж олоход урь. Тэднийг найздаа тусалж болох захидал бичихэд урамшуулан дэмж. Тэд ахлагч Холландын нийтлэлээс өөр юу олж мэдсэн бэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд ариун явдлын хуулийг илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ариун явдлын ач холбогдлын талаар мэдэрч байгаа зүйлээ болон ёс суртахууны хувьд цэвэр ариун хэвээр үлдэхийн тулд юу хийх тухайгаа хуваалцаж болно.

- Чуулгын бусад гишүүнийг бодол, харилцаа, үйлдлүүдээрээ ариун байхад уриал.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Бид ариун явдалд итгэдэг,” *Ensign*, 2013 оны 5-р сар, 41–42 эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 50–51-ийг үзнэ үү

Өнөөдөр миний хэлэх үгс сүнслэг байдлын үндсэн зарчим болсон “Ариун явдлын хууль яагаад ийм чухал вэ?” гэсэн асуултад хариулах болно. Ариун Сүнс миний ярих чухал зарчмуудыг та бүхэнд батлаасай хэмээн би залбирч байна.

Эцэгийн аз жаргалын төлөвлөгөө

Өөрийн хүүхдүүддээ зориулсан Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөг бүрэн дүүрэн хүлээн авсан үед л ариун явдлын хуулийн мөнхийн ач холбогдлыг ойлгож чадна. “Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд тэнгэрлэг шинж чанар, хувь тавилантай юм” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign*, эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129). Бүх эрэгтэй, эмэгтэй хүн мөнх бус дэлхий дээр ирэхээс өмнө Түүний сүнсэн хүүхдүүд байхдаа Бурхантай хамт амьдарч байсан. Эцэгийн төлөвлөгөө Түүний сүнсэн хөвгүүд, охидод бие махбодыг хүлээн авч, дэлхий дээрх туршлагаудыг олж аван, өргөмжлөл хүртэхээр өсөж хөгжих боломж олгодог.

Бие махбодын ач холбогдол

Бидний бие махбод мөнх бус оршихуйн өмнөх дэлхийд байхдаа хүлээн авч чадахааргүй байсан туршлагаудыг өргөн хүрээнд, гүн гүнзгий, хүч чадалтайгаар олж авах боломжийг олгодог. Иймээс, бусад хүнтэй харилцах харилцаа, ялган таних ба үнэний дагуу үйлдэх, Есүс Христийн сайн мэдээний зарчим, ёслолуудыг дагах

чадварууд нь бидний бие махбодоор дамжуулан боломжтой болсон билээ. Мөнх бус амьдралд бид өрөвч зөөлөн сэтгэл, хайр, сайхан сэтгэл, аз жаргал, уйтгар гуниг, урам хугаралт, өвчин шаналал болон бие махбодын хөгжлийн бэрхшээл зэрэг зүйлсийг даван туулснаар мөнх амьдралд бэлтгэгдэж байдаг. Энгийнээр хэлэхэд, “махбодод оршсоны дагуу” (1 Нифай 19:6, Алма 7:12–13) гэж сударт бичсэнээр бидний сурах ёстой хичээл, олж авах ёстой туршлагауд гэж байдаг.

Нөхөн үржихүйн хүч

Дэлхий бүтээгдсэний дараа Адамыг Едений цэцэрлэгт байрлуулсан. Гэсэн хэдий ч Бурханы “хүн ганцаар байх нь сайн биш” (Моисе 3:18; Эхлэл 2:18-ыг үзнэ үү) хэмээн хэлсэн нь чухал бөгөөд Ева Адамын эхнэр бөгөөд туслагч нь болжээ. Эрэгтэй, эмэгтэй хүний сүнсний болон бие махбод, оюун ухаан, сэтгэл санааны өвөрмөц нэгдэл нь аз жаргалын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хэрэгтэй байсан. “Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм” (1 Коринт 11:11). Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биеэсээ суралцах, хүчирхэгжүүлэх, адислах, тусалж дэмжих мөн нэг нэгнээ төгс болгохын тулд бүтээгджээ.

Тэнгэрлэг эрх мэдлээр мөнх бус амьдрал бүтээгдсэн билээ. “Адам, Ева хоёрт өгсөн Бурханы анхны тушаал нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох явдал байсан юм” (*Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129). Өсөж үржин, дэлхийг дүүргэх тушаал өнөөдөр ч хэрэгжиж байгаа билээ. Тиймээс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь мөнх бус байдлын өмнөх оршихуйд буй сүнснүүдийг энэ амьдралд авчрахад зөвшөөрөгдсөн арга зам юм. Гэрлэхээсээ

Сонгосон материалууд

өмнө бэлгийн харилцаанд огт орохгүй байх болон гэрлэснийхээ дараа үнэнч байх нь энэхүү нандин сувгийн ариун байдлыг хамгаалдаг.

Үр удмаа үлдээх хүч нь сүнслэг ач холбогдолтой. Энэ хүчийг буруугаар ашиглах нь Эцэгийн төлөвлөгөөг болон бидний мөнх бус оршихуйн зорилгыг устгадаг. Бидний Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайрт Хүү хоёр бол бүтээгчид бөгөөд

Өөрсдийн бүтээлтийн хүчний нэгээхэн хэсгийг бидэнд өгсөн билээ. Амьдралыг бүтээгч энэхүү хүчийг зохистой ашиглах тодорхой удирдамж нь Эцэгийн төлөвлөгөөний үндсэн хэсэг болдог. Бидний тэнгэрлэг хүч чадлын талаар юу гэж бодож мөн хэрхэн ашиглаж байгаа нь бидний мөнх бус амьдралын аз жаргал ба мөнх амьдралын хувь тавиланг тодорхойлдог.



Ариун сүмд гэрлэх нь яагаад чухал вэ?

Тэнгэрлэг Эцэгийн маань аз жаргалын төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь энэ амьдрал ба мөнхийн амьдралд бие биентэйгээ лацдан холбогдох боломжтой. Ариун сүмд лацдан холбогдсон тэдгээр хүмүүс нь гэрээндээ үнэнч байвал тэдний гэрлэлт мөнхөд үргэлжилнэ гэсэн баталгаа байдаг. Тэднийг юу ч, бүр үхэл ч салгаж чадахгүй гэдгийг тэд мэддэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та ариун сүмийн гэрлэлтийн талаар эдгээр судар болон бусад материалыг судалж байхдаа Их Эзэний ариун сүмд гэрлэх нь хэчнээн чухал болохыг залуу эрэгтэйчүүдэд ойлгож мэдрэхэд нь туслах зүйлсийг хайж ол.

С ба Г 49:16–17 (Гэрлэлт Бүтээлтийн зорилгыг гүйцэлдүүлдэхэд тусалдаг)

Дэвид А.Бэднар, “Гэрлэлт бол Түүний төлөвлөгөөний чухал хэсэг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2006 оны 6-р сар, 82–87

С ба Г 131:1–4; 132:15–21 (Селестииел гэрлэлт өргөмжлөл хүртэхэд шаардлагатай)

Ричард Г.Скотт, “Гэрлэлтийн мөнхийн адислалууд,” *Ensign* эсвэл 2011 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 94–97

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129

“Гэрлэлт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 74–78

Л.Том Пэрри, “Яагаад гэрлэлт ба гэр бүл дэлхийн хаана ч чухал байдаг вэ,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 23–26

Ариун сүмд гэрлэх нь таны хувьд яагаад чухал вэ? Энэ ёслол танд болон таны гэр бүлд ямар адислалууд авчирсан бэ?

Залуу эрэгтэйчүүдэд ариун сүмийн гэрлэлтийн ямар зөв үлгэр жишээ байна вэ? Та тэдэнд ариун сүмд гэрлэх илүү их хүсэлтэй болоход нь хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэй бүрээс өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр хариулсан асуултуудын талаар бодоод асуултаа чуулгын бусад гишүүдээс асуухыг хүс. Асуултуудад хариулах хугацаа өг.
- Залуу эрэгтэйчүүдээр амьдралынх нь чухал шийдвэрүүдийг жагсаан бичүүл. Тэднээр мөнхийн хувь заяанд нь хамгийн их нөлөөлөх шийдвэрүүдийг таньж мэдүүлэн, эдгээрийг яагаад сонгосныг тайлбарлуул. Боломжтой бол өөрийнхөө болон эхнэрийнхээ ариун сүмд гэрлэсэн өдөр авахуулсан зургаа харуул. Ханьтайгаа ариун сүмд лацдан холбогдсон мөнхийн холболтынхоо ач холбогдлын талаар мэдэрч буй зүйлээ хуваалц.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь ариун сүмийн гэрлэлтийн ач холбогдлыг ойлгоход чуулгын гишүүдэд тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Эдэлгээний өөр өөр түвшинг харуулах (жишээ нь, хуванцар халбага болон төмөр халбага) хоёр юм уу гурван эд зүйлийг (эсвэл эд зүйлийн зургийг) авчир. Залуу эрэгтэйчүүдээс яагаад эдэлгээ сайтай эд зүйл нь эдэлгээ муутай эд зүйлээс илүү дээр байдаг талаар ярилцахыг хүс. Энэ нь гэрлэлттэй хэрхэн хамаатай байж болох вэ? Ахлагч Л.Том Пэрригийн “Яагаад гэрлэлт ба гэр бүл дэлхийн хаана ч чухал байдаг вэ” хэлсэн үгийн хэсгүүдээс уншиж, үзэж эсвэл сонсохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүдээс яагаад ариун сүмд гэрлэхийг хүсдэгийг нь асуу.
- Чуулгын нэг гишүүнийг энэ хичээлийн зарим хэсгийг заахад урь. Тэрээр мөнхийн гэр бүлийн талаар суралцаж, заахаар төлөвлөх Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ нэг хэсэг болгон үүнийг хийж болох юм (“Сургаалыг ойлго” 18, 42 эсвэл 66-р хуудсыг үзнэ үү).
- Ахлагч Дэвид А.Беднарын “Гэрлэлт бол Түүний төлөвлөгөөний чухал хэсэг” хэлсэн үг нь гэрлэлт яагаад чухал байдгийн хоёр шалтгааныг болон мөнхийн гэрлэлтийн сургаалын талаарх үндсэн гурван зарчмыг тодорхойлдог. Чуулгын гишүүн бүрд нэг шалтгаан эсвэл зарчмыг уншихыг, дараа нь хүн бүрийг чуулгын өөр хэн нэгэнд уншсан хэсгээсээ гэрлэлтийн тухай сурсан зүйлээ заахыг даалга. Тэд ахлагч Беднарын заасан зүйлсийн чухлыг харуулах ямар туршлага хуваалцаж болох вэ?

Заахад туслах арга

“Түүхүүд суралцагчдын сонирхлыг нэмэгдүүлж болно. Бид эхлээд түүхийг дүрслэн харуулсан байдлаар хуваалцвал ямар нэг зарчмыг илүү үр дүнтэй зааж чадна. Энэ нь суралцагчдад өдөр бүрийнхээ туршлагаас тухайн зарчмыг ойлгоход тусалдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 93).

- Чуулгаараа С ба Г 131:1-4 болон *Итгэлдээ үнэнч байх нь* товхимол дахь “Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ” (75-р хуудас) хэсгээс “Ариун сүмд гэрлэх нь яагаад чухал вэ?” гэсэн асуултын хариултуудыг хайж унш. Шаардлагатай бол залуу эрэгтэйчүүдэд танил бус ямар нэг үг, хэллэгийн утгыг ойлгоход тусал. Залуу эрэгтэйчүүдийг ариун сүмд гэрлэхэд нь саад болж болох зарим зүйлийг жагсаан бичихийг чуулгын гишүүдээс хүс. Тэд ариун сүмд баттай гэрлэхийн тулд одоо юу хийж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд ариун сүмд гэрлэхийн ач холбогдлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ариун сүмд гэрлэхийн ач холбогдлын тухай болон ариун сүмд гэрлэх хүслийнхээ талаар гэрчлэлээ хуваалцаж болно.

- Залуу эрэгтэй бүрд ахлагч Ричард Г.Скоттын “Гэрлэлтийн мөнхийн адислалууд” хэлсэн үгийн хуулбарыг өг. Ахлагч Скотт мөнхийн ханийнхаа талаар юу гэж боддог байсан бэ? Түүний эхнэртэйгээ харьцдаг харилцаанаас юу нь залуу эрэгтэйчүүдэд гүн сэтгэгдэл төрүүлж байна вэ? Тэднээс ахлагч Скотт болон Скотт эгч хоёрынх шиг харилцаанд хүрэхийн тулд юу шаардагдахыг тунгаан бодохыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дэлхий дээрх тохинууллынхаа үеэр шавь нараасаа тунгаан бодож, гүнзгий мэдрэмж төрүүлсэн асуултуудыг асуудаг байсан. Тэрээр тэдний хариултыг чин сэтгэлээсээ сонсож, итгэлтэй байдалд нь баясдаг байсан. Залуу эрэгтэйчүүдэд ариун сүмийн ёслолуудын талаар, ялангуяа ариун сүмд гэрлэх талаар тунгаан бодоход тусалж, гүнзгий мэдрэмж төрүүлэх асуултуудыг бод. Тэдний хариултуудыг анхааралтай сонсон, Сүнсээр өдөөгдөж, уриалгахан хариул.

Сонгосон материалууд

Ричард Г. Скоттын “Гэрлэлтийн мөнхийн адислалууд” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2011 оны 5-р сар, 94–97

1953 оны 7-р сарын 16-нд би хайрт Женинтэйгээ Ютагийн Мантай ариун сүмийн тахилын ширээний өмнө өвдөг сөхрөн суусан юм. Ерөнхийлөгч Луис Р.Андэрсон лацдан холбох эрх мэдлээр бид хоёрыг энэ амьдралд болон үүрд мөнхөд эхнэр, нөхөр болсныг зарласан. Их Эзэний өргөөнд, санваарын зохих эрх мэдлээр гүйцэтгэгдсэн энэхүү эрхэм нандин ёслолыг хүртэхдээ цаашид үргэлж зохистой амьдарвал хайрт Женин болон хүүхдүүдтэйгээ үүрд мөнх хамт амьдарна гэсэн баталгааг тэр мөчид үгээр илэрхийлэхийн аргагүй амар амгалан байдлаар би хүлээн авсан билээ.

Манай долоон хүүхэд ариун сүмийн нандин ёслолуудаар бидэнтэй холбогдсон. Миний хайрт гэргий Женин болон хоёр хүүхэд маань хөшигний нөгөө талд байгаа. Тэд маань зөв шударга амьдарснаар ариун сүмд амлагдсан мөнхийн адислалуудыг хүлээн авах болно гэдэгт манай гэр бүлийн үлдсэн бусад гишүүдийг зоригжуулдаг.

Тэнгэр дэх Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний амин чухал хэсгүүдийн хоёр нь гэрлэлт ба гэр бүл билээ. Гэр бүлд ан цав гаргах, гэр бүлийг үүрд мөнхөд холбох ариун сүмийн ёслолуудын утга учрыг бууруулах Сатаны оролдлогууд нь гэрлэлт

ба гэр бүл ямар чухал болохыг бидэнд сануулдаг. Амьдралын туршлага суух тусам ариун сүмийн лацдан холболт улам гүнзгий утга учиртай болдог. Энэ ёслол та нарыг хэзээ хэзээнээс илүү ойртуулж, мөнх бус амьдралд агуу баяр баясгалан, сэтгэл ханамжийг олоход тань тусална. . . .

Хайрт гэргий Женинийхээ тухай ярьж байгааг минь өршөөгөөрэй. Гэхдээ бид мөнхийн гэр бүл юм. Тэр үргэлж баяр баясгалантай, аз жаргалтай байсан. Тэрхүү аз жаргалын ихэнх нь бусдад үйлчилснээр ирдэг баяр баясгалан байлаа. Тэр маш хүнд өвчтэй байхдаа ч Тэнгэр дэх Эцэгээсээ өөрийн тусалж чадах хэн нэгэн рүү өөрийг нь хөтлөхийг гуйдаг байсан. Энэхүү чин сэтгэлийн гуйлт нь цаг үргэлж хариулагддаг байлаа. Тэрээр олон хүний ачааг хөнгөлж, амьдралыг нь гэрэлтүүлсэн. Тэр Их Эзэнээр удирдагдсан зэмсэг нь байхаар адислагдсан байв.

Эмэгтэй хүний үүргээ шударгаар биелүүлж, гоо үзэсгэлэн, энэрэл хайраар дүүрэн амьдарсан, Тэнгэр дэх Эцэгийн охиныг хайрлах нь ямар байдгийг би мэднэ. Ирээдүйд хөшигний цаана түүнтэйгээ уулзах үед бид нэг нэгнээ улам илүү хайрлах болсноо мэдэрнэ гэдэгтээ би итгэлтэй байна. Ийм учраас бид хөшигний хоёр талд амьдарсан цаг мөчүүддээ улам илүүтэй талархах болно.



Гэр бүл яагаад чухал вэ?

Гэр бүл нь Бурханаас томилогддог бөгөөд Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөө Түүний төлөвлөгөөн дэх гол цөм нь юм. Энэхүү тэнгэрлэг төлөвлөгөө нь хувь хүн бүрийг Түүний оршихуйд буцаж очих ба гэр бүлүүдийг мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судлаад, гэр бүл чухал болох шалтгааныг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд туслах хэсгийг сонго.

Ром 8:16–17; Еврей 12:9 (Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд)

Эхлэл 2:18–24; С ба Г 131:1–4; 138:48 (Гэр бүлийн талаарх сайн мэдээний үнэнүүд)

Мозая 4:14–15; С ба Г 68:25, 27–29; 93:40, 48–50 (Хүүхдүүд сайн мэдээг эцэг эхээсээ суралцдаг)

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129 (мөн *Итгэлдээ үнэнч байх нь* [2004], 65-ыг үзнэ үү)

Кэрол М.Стэфэнс, “Бурханы гэр бүл,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 129–131

Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 35–39

Л.Том Пэрри, “Сайн эцэг эх болох нь,” *Ensign* эсвэл 2012 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 31–34

Өсвөр үеийнхний уриа дуу: “Nothing Can Separate Us”

Яагаад гэр бүлүүд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний гол цөм нь гэж та бодож байна вэ? Та гэр бүлийн ач холбогдлыг хэрхэн мэдэж авсан бэ?

Залуу эрэгтэйчүүд гэр бүлийн ач холбогдлын талаар бошиглогчдын хэлсэнтэй зөрчилдөх дэлхийн ямар мэдээллийг авдаг вэ? Та гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдийг өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр сурсан зүйлээ болон түүнийг тэд амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж чадсаныг нь хуваалцахад урь.
- Чуулгын цуглааны өмнө залуу эрэгтэйчүүдийг гэр бүлийнхэнтэйгээ өнгөрүүлсэн дурсамжтай үеийг төлөөлөх нэг зүйл авч ирэхэд урь (гэр бүлийн уламжлал, амралт эсвэл бусад үйл ажиллагаанууд гэх мэт). Залуу эрэгтэй бүрийг энэ зүйлийнхээ талаар хуваалцахыг болон гэр бүл нь түүнд яагаад чухал байдгийг ярихад урь.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Зааж буй сэдвээр хэд хэдэн хүн саналаа илэрхийлэх хүсэлтэй байвал та ‘Бид эхлээд таны саналыг, дараа нь дараагийн хүний саналыг сонсьё’ гэж хэлж болно. Ингэж хэлбэл тэд саналаа хэлэх боломж гарна гэдгийг ойлгон, хичээл эмх журамтай болно” (*Teaching, No Greater Call* [1999], 69).

Дараах үйл ажиллагаа бүр нь гэр бүлийн ач холбогдлыг ойлгоход чуулгын гишүүдэд тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч Д.Тодд Кристоффersonы “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан” эсвэл ахлагч Л.Том Пэрригийн “Сайн эцэг эх болох нь” хэлсэн үгийн сүүлчийн найман догол мөрийг уншаад, “Гэр бүлүүд яагаад чухал вэ?” гэдэг асуулгын хариултуудыг хайж олоход урь. Чуулгын гишүүдийг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Тэд гэр бүлүүд чухал болохыг ойлгож мэдсэнээ харуулахын тулд юу хийж болох вэ? Гэр бүлүүд чухал болохыг ойлгож мэдсэн нь тэдний гэр бүлийнхэнтэйгээ харьцах арга барилд хэрхэн нөлөөлөх вэ?
- Чуулгыг дөрвөн бүлэгт хуваа. Бүлэг тус бүрийг Кэрол М.Стэфэнсийн “Бурханы гэр бүл” хэлсэн үгээс нэг хэсгийг (хэсэг бүр нь гэр бүлийн тухай үнэнийг тодруулснаар эхэлдэг) судлуул. Өөрсдийн хэсгээс олж мэдсэн зүйлээ бусад бүлэгт заахад бэлтгэхийг бүлэг бүрээс хүс. Тэд гэр бүлүүдэд болон олон нийтэд эдгээр үнэнийг хэрхэн зааж, үлгэр дуурайл үзүүлж чадах вэ?
- Энэхүү тоймд тусгагдсан видео бичлэгүүдээс нэгийг үзүүлэн, залуу эрэгтэйчүүдээс Тэнгэрлэг Эцэгийн бидэнд гэр бүл өгсөн шалтгаануудыг сонсохыг хүс. Залуу эрэгтэйчүүдээс “Би яагаад гэрлэх хэрэгтэй гэдгээ ойлгохгүй байна” эсвэл “Би нас биенд хүрэхээрээ хүүхэдтэй болохыг хүсэхгүй байна” гэх мэтийг ярьдаг хэн нэгэнд хэрхэн хариулах байсныг нь асуу. Тэд одоо гэр бүлийнх нь нөхцөл байдал тийм ч сайн биш байгаа найздаа юу хэлэх байсан бэ? (“Гэр бүл,” *Залуучуудын бат бөх байдал* (2011), 14–15-ыг үзнэ үү.)

- Залуу эрэгтэй бүрд энэ тойм дээрх судрын хэсгүүдийн нэгийг даалгаж өг. Чуулгын гишүүдийг “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг судалж, тэдгээрийн судартай хамааралтай хэсгийг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд гэр бүл чухал гэдгийг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бурханы төлөвлөгөөн дэх гэр бүлийн ач холбогдлын талаарх гэрчлэлээ хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдийг “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг гэр бүлийн гишүүнтэйгээ эсвэл найзтайгаа хуваалцахад урьж болно.

олохыг хүс. Залуу эрэгтэй бүрийг судрын эшлэл болон үүнтэй холбоотой тунхгийн хэсгээс хуваалцахад урь. Залуу эрэгтэйчүүдийг гэр бүлийн ач холбогдлыг харуулах туршлагаасаа хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нараа гэрчлэхэд урьсан бөгөөд тэднийг гэрчлэхэд Сүнс зүрх сэтгэлд нь хүрсэн юм. Та залуу эрэгтэйчүүдэд гэр бүл яагаад чухал болохыг заах үедээ Бурханы авралын төлөвлөгөөн дэх гэр бүлийн ач холбогдлын талаарх гэрчлэлээ хуваалцахад тэднийг урь.

Сонгосон материалууд

Л. Том "Перригийн "Сайн эцэг эх болох нь" хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2012 оны 11-р сар, 26–28

Манай гэр бүлүүдийн бат бөх соёл нь, бидний хүүхдүүдийг "дайсны галт сумнаас"(1 Нифай 15:24) тэрчлэн хүүхдийн нүдний өмнө байнга ил байдаг, үе тэнгийнхний соёл, зугаа цэнгэл ба оддын соёл, нэр хүнд ба үнэлэмжийн соёл, интернет ба мэдээллийн соёл зэргээс хамгаалах болно. Энэ нь манай хүүхдүүдэд "дэлхийнх биш" байж харин "дэлхийд амьдрахад" нь туслах болно (Иохан 15:19).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит ингэж сургасан юм: "Хүүхдүүд нь яагаад баптисм хүртэх ёстойг ойлгож, баптисмынхаа дараа Бурханы зарлигуудыг үргэлж биелүүлэх хүслийг зүрх сэтгэлдээ төлөвшүүлэхийн тулд, мөн Түүний дэргэд буцаж очин амьдрахын тулд, Есүс Христийн сайн мэдээний авралын зарчмуудыг хүүхдүүддээ заах нь эцэг эхчүүдийн үүрэг мөн. Хайрт ах, эгч нар минь ээ, гэр бүл чинь, хүүхдүүд чинь, бас та өөрөө эцэг эхтэйгээ лацдан холбуулахыг хүсдэг үү . . . ? Хэрэв үүнийг хүсдэг бол, үр хүүхдэдээ бүр багаас нь эхэлж заах ёстой. Та үйл хэргээрээ бас үлгэр жишээгээрээ тэдэнд заах хэрэгтэй." [Жозеф Фийлдинг Смит, Conference Report, 1948 оны 10-р сар, 153.]

Гэр бүлийн тунхагт ийн өгүүлсэн байдаг:

"Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан халамжлах ариун үүрэг хүлээнэ. 'Үр хүүхэд бол Эзэнээс ирдэг бэлэг мөн' (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана

ч амьдарсан хуулийг дээдлэн сахидаг иргэд байхыг зааж сургах ариун үүрэгтэй юм. . . .

. . . Тэнгэрийн загвараар эцэг нь, өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол, хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой." ["Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг" Лиахона ба Ensign 2010 оны 11-р сар, 129.]

Хойч үеэ өсгөн хүмүүжүүлж, тэдэнд заах эхийн үүргийг товойлгон тавьсан нь тэнгэрийн загвар гэдэгт би итгэлтэй байдаг. Гэвч хүүхдүүд болон ач зээ нартаа сайн нөлөө үзүүлж, тэдэнтэй харилцахдаа нөхөр, эхнэр хоёр эрх тэгш түншүүдийн ёсоор хамтран ажиллаж байгааг харахад үнэхээр гайхамшигтай байдаг.

Бусармаг нүгэл хилэнц манай хүүхдүүдийн эсрэг урьд өмнө үзэгдээгүйгээр илэрхий, улаан цайм, ичгүүр сонжуургүй, улангасан мэт дайран давшилж байна. Гэр бүлийн бат бөх соёлыг төлөвшүүлэх нь манай хүүхдүүдийг дэлхийн муу нөлөөнөөс тусгаарлах бас нэг хамгаалалт байх болно.

Сион дахь сайн аав, ээж та нарыг Бурхан адислах болтугай. Тэрбээр Өөрийн мөнхийн хүүхдүүдийг халамжлах ажлыг та нарт итгэл хүлээлгэн даатгасан юм. Эцэг эхчүүд бид Түүний ажил болон алдар суут, Түүний хүүхдүүдийн дунд тохиолгон авчрах үйлсэд Бурханы түншүүд, түүгээр ч зогсохгүй Түүнтэй нэгдэн нийлэгчид билээ. Энэхүү эрхэм үйлсэд чадах бүхнээ хийх нь бидний ариун үүрэг юм. Энэ тухай би Есүс Христийн нэрээр гэрчиллээ, амен.



НАЙМДУГААР САР: ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛ

Болзох талаарх Сүмийн жишгийг дагах нь яагаад чухал вэ?

Хожмын үеийн бошиглогчид сүнслэг аюулаас биднийг хамгаалах мөн ирээдүйд зохистой мөнхийн ханиа олоход бэлтгэхийн тулд болзооны жишгүүдийг өгсөн. Эдгээр жишигт 16 нас хүрэхээс өмнө болзохгүй байх, нэг хүнтэй байнга болзохоос зайлсхийх, ёс суртахууны өндөр жишигтэй хүнтэй болзох зэрэг ордог.

Та болзооны талаар Их Эзэний жишгүүдийг дагахын ач холбогдлыг заасан ямар туршлагуудыг харсан бэ?

Залуу эрэгтэйчүүдэд болзооны талаарх ойлголт төсөөллийг нь бий болгох ямар туршлага ба санаанууд байна вэ? Тэд ямар шахалтуудыг мэдэрч байна вэ? Их Эзэний жишгүүдэд үнэнч хэвээр үлдэхийн тулд тэд юу мэдэх хэрэгтэй вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судрууд болон материалуудыг залбирч судал. Залуу эмэгтэйчүүдтэй харьцаж эхлэхдээ залуу эрэгтэйчүүд юуг хамгийн сайн хэрэгжүүлэх ёстой гэж та мэдэрч байна вэ?

Дэд хууль 7:3–4 (Гэрээнээс гадуур бүү гэрлэ)

Сургаал ба Гэрээ 46:33 (Бурханы өмнө ариун журам ба цэвэр ариун байдлыг хэрэгжүүлэх)

“Болзоо,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 4–5

Гордон Б.Хинкли, “Ирээдүйд гэрлэх охиныхоо хувьд зөв зохистой амьдрах нь,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 49–51

Видео бичлэг: “Цоо шинэ 2010 он: Болзоо”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Нэг залуу эрэгтэйг өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тодорхойлох нэг үг хэлэхэд урь. Залуу эрэгтэйчүүдээс тэрхүү хичээлтэй холбоотой өнгөрсөн долоо хоногт тохиолдсон туршлагаасаа хуваалцамаар байгаа эсэхийг асуу.
- Залуу эрэгтэйчүүдээс болзооны талаарх Их Эзэний жишгүүдийн талаар мэдэж байгаа зүйлээ самбар дээр жагсаан бичихийг хүс. Хичээлийн үеэр тэднийг эдгээр жишгийн талаар илүү сурч мэдэж авсан зүйлээ жагсаалтандаа нэмж бичихэд урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа тус бүр болзооны талаар сүмийн жишгүүдийг чуулгын гишүүд ойлгоход нь тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохиорох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэй бүрийг ирээдүйн эхнэрээсээ хүсэж байгаа зан чанаруудын жагсаалт гаргахад урь. Залуу эрэгтэйчүүдийг боломжтой бол жагсаалтаа ангийнхантай хуваалцахад урь. Нэг залуу эрэгтэйгээс ахлагч Робэрт Д.Хэйлсийн хэлсэн дараах үгийг уншихыг хүс. “Хэрэв та эрүүл чийрэг, сэтгэл татам, үнэнч шударга, аз жаргалтай, ажилсаг, сүнслэг хүнтэй гэрлэхийг хүсэж байгаа бол өөрөө тийм хүн бай ” (“Өнөөгийн дэлхийн саад бэрхшээлтэй тулгарах нь,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 32). Залуу эрэгтэйчүүдийг гаргасан жагсаалтаа харж байх хооронд тэдний ирээдүйн эхнэр тэдэнтэй адил жагсаалт гаргасан байвал ямар санагдах байсныг асуу. Тэд ирээдүйн эхнэрийнхээ гэрлэхийг хүсэж байгаа хүн нь

байхын тулд яг одоо юу хийж байна вэ? Залуу эрэгтэйчүүдийг яг одоо хэрхэн эдгээр зан чанарыг хөгжүүлэхээ мөн эдгээр зан чанар болзох хүн нь ямар байхад хэрхэн нөлөөлөхийг ярилцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн “Living Worthy of the Girl You Will Someday Marry” хэлсэн үгийг унших эсвэл сонсохдоо таалагдсан зөвлөгөөгөө сонгон ярилцахад урь. Ерөнхийлөгч Хинкли залуу эрэгтэйчүүдийг болзоонд явахдаа хийх сонголтуудын талаар юу зөвлөсөн бэ? Тэднээс ирээдүйн эхнэртээ байлгахыг хүссэн шинж чанаруудыг бичиж аван жагсаалтаасаа тэдний ирээдүйд болохыг эрмэлзэж буй хамтрагчийн сайжруулах чадах ядаж нэг шинж чанарыг сонгохыг хүс. Тэдний

Заахад туслах арга

“Хэрэв хэн нэгэн хүн тэднээс хичээл дээр сурсан зүйлээс нь асуувал тэд юу гэж хариулах вэ? гэж заадаг хүмүүсээс асуу” (*Teaching, No Greater Call* [1999], 94).

болзооны туршлага нь хожим тэдний гэрлэх хүний шинж чанарт одоо хэрхэн нөлөөлж чадах вэ?

- “Цоо шинэ 2010 он: Болзоо” видео бичлэгээс үзүүлээд, тэдэнд хүмүүсийн дурдсан болзооны жишгүүдийг олж мэдэх цаг гаргаж өгөхийн тулд бичлэгийг түр зогсоо. Залуу эрэгтэйчүүдээс *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын “Болзоо” сэдвийг уншаад, видео бичлэг дээр дурдаагүй бусад жишгийг олж мэдэхийг хүс. Тэднийг дараахтай төстэй асуултуудад хариулахад урь. “Болзоотой холбоотой Сүмийн ямар ямар жишиг байдаг вэ?” “Эдгээр жишгийг дагах нь таны хувьд яагаад чухал вэ?” “Яах гэж болздог вэ?” Залуу эрэгтэйчүүдийг болзоотой холбоотой Сүмийн жишгүүдтэй зөрчилдөх ямар нэгэн зүйлийг хийх дарамт шахалт мэдрэх үедээ авах арга хэмжээний тухай ярилцахад урь. Болзоотой холбоотой Сүмийн жишгүүдийг дагаснаар

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд болзооны талаарх сүмийн жишгүүдийг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулгын гишгүүдийг болзооны талаарх Их Эзэний жишгүүдийг дагах зорилго тавихад нь урамшуулан дэмжиж болно.

хэрхэн адислагдсан тухай хуваалцаж, бусдыг мөн адил хуваалцахад урих талаар бодож үз. Залуу эрэгтэйчүүдийг эдгээр жишгийг дагахын тулд юу хийхээ хуваалцахад урь.

- Чуулгын гишгүүдийг “Болзоо” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос дахин уншаад болзооны талаар тэдэнд байгаа асуултуудаа бичихэд урь. Насаар ахмад, залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн зөвлөлийг тэдний асуултуудад хариулахаар урин болзооны талаарх жишгүүдийг ярилц. Зөвлөлийн гишгүүдийг болзоонд явж байхдаа тэд хэрхэн жишгүүдээ дагадаг байсан жишээнүүдийг ярилцлагандаа оруулахад нь урамшуулан дэмж. Жишээлбэл: даруу хувцаслалт, зохистой үйл ажиллагаануудад оролцох, өндөр жишигтэй тэдгээртэй болзох гэх мэт байж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ мэддэг байсан ба тэдний хэн болж чадахыг ч мөн мэддэг байсан. Тэднийг сурч мөн өсч хөгжихөд нь туслах, зөвхөн тэдэнд тохирсон онцгой арга замуудыг Тэрээр олсон юм. Зовж цөхөрсөн үед нь Тэрээр хэзээ ч тэднийг орхилгүй харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа. Мөнхийн ханиа хайх болон бэлтгэх талаар заах үедээ тэдэнд юу хэрэгтэй байгааг мэдэж болохын тулд заадаг залуу эрэгтэйчүүдээ таньж мэдэн хайрлахын төлөө залбир.



Зөв шударга нөхөр, эцэг хүн болохын тулд одооноос би өөрийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

“Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129). Бид санваарын үүргүүдээ итгэлтэй биелүүлэн, хувийн илчлэлт хүлээн авахад суралцаж, гэр бүлүүдээ хайрлан, тэдэнд үйлчилж, боловсрол эзэмшин, хөдөлмөрлөхийг сурснаар эдгээр үүрэгтээ бэлтгэж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Таны зааж байгаа залуу эрэгтэйчүүдэд хамгийн их хамааралтай зүйл юу байна гэж та бодож байна вэ?

Таны санваарын үйлчлэл залуу эрэгтэйн хувьд таныг зөв шударга нөхөр, эцэг хүн болоход бэлтгэхэд хэрхэн тусалсан бэ? Та бэлтгэхийн тулд өөр юу хийсэн бэ? Та өөр юу хийхийг хүсэж байна вэ?

Залуу эрэгтэйчүүдийг зөв шударга нөхөр, эцэг хүн болоход бэлтгэхэд туслах ямар туршлагаууд тэдэнд одоо байж болох вэ? Тэдний бэлтгэл тэдний ирээдүйн гэр бүлийг хэрхэн адислах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Абрахам 1:1–4, 18–19 (Абрахам амьдралдаа санваарыг хүртсэнээр өөрөө болон өөрийн хойч үеийнхний санваараас хүлээн авах адислалуудыг олж харсан)

1 Нифай 2:1–3 (Лихай Их Эзэнээс гэр бүлийнхээ аюулгүй байдлын төлөө илчлэлт хүлээн авсан)

1 Нифай 16:14–32 (Нифай гэр бүл нь аглаг буйдад өлсөж байх үед гэр бүлдээ тусалж, хүндэтгэлээ харуулсан)

С ба Г 42:22 (Нөхөр нь эхнэртээ итгэлтэй байх хэрэгтэй)

С ба Г 58:26–28; 107:99–100 (Судрууд ажиллаж хөдөлмөрлөхийн ач холбогдлыг тодорхойлдог)

Д.Тодд Кристоффэрсон, “Эцэг хүн,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 78–82

Л.Витни Клэйтон, “Гэрлэлт: Ажиглаад суралц,” *Ensign* эсвэл 2013 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 96–98

Ларри М.Гибсон, “Эцэг байх нь—Бидний мөнхийн хувь заяа” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 62–65

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа зүйлээ хоёр хоёроороо хуваалцахыг хүс.
- Чуулгын гишүүдээс Абрахам 1:1–2-ыг уншин эдгээр шүлэгт тэдний болохыг хүссэн нөхөр, эцэг хүний шинж чанарыг дүрслэн харуулсан өөрсдийн хувилбарыг бичихэд урь. Хэрэв тэд өөрсдөө хүсэж байвал бичсэн зүйлээ хуваалцахад урь. Хичээлийн туршид дүрсэлсэн зүйл дээрээ нэмж бичихийг нь урамшуул.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр чуулгын гишүүдэд хэрхэн зөв шударга нөхөр, эцэг хүн болохыг ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Эцэг хүн” хэлсэн үгийг уншаад, зөв шударга эцэг хүний зан чанаруудыг олж мэдэхэд урь. Залуу эрэгтэй бүрийг өөрийнхөө аавын эсвэл ахлагч Кристоффэрсоны хуваалцсан зан чанаруудаас үлгэрлэн харуулж байсан амьдралд нь үлгэр жишээ болдог аавын тухай бодоход урь. Та залуу эрэгтэйчүүдэд бодож олсон туршилагаа зураг болгон буулгаж, зургаа ангийнхантай хуваалцахад урь мөн эдгээр туршлагыг хуваалцахад тусалж болно. Та мөн ахлагч Кристоффэрсоны хэлсэн үгээс зарим өгүүлбэрийг самбарт бичиж, өгүүлбэрийн дунд зарим үгийн оронд хоосон зай үлдээж болно. Залуу эрэгтэйчүүдийг хоосон зайнд ямар үг байхыг таахад урь. Залуу эрэгтэйчүүд ахлагч Кристоффэрсоны

Заахад туслах арга

“Хариултыг нь судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын зөвлөгөөнөөс олох шаардлагатай асуултуудыг асуу” (Teaching, No Greater Call [1999], 62).

Видео бичлэгүүд: “Өсвөр үеийнхнийг ярилцахад бэлтгэх нь”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн шавь нарыг хайрлан, тэдний төлөө залбирч, үргэлжлүүлэн тэдэнд үйлчилдэг байв. Тэрээр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан. Та үйлчилж байгаа залуу эрэгтэйчүүдийнхээ талаар юу мэдэх вэ? Та тэднийг зөв шударга нөхөр, эцэг хүн болоход нь туслахын тулд юу хийж чадах вэ?

өгсөн зөвлөгөөг хэрхэн дагаж болох вэ? (Санаа авахын тулд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын “Ажил хөдөлмөр ба бие даах чадвар,” “Боловсрол” сэдвийг үзнэ үү.)

- Залуу эрэгтэйчүүдээр “Эцэг байх нь—Бидний мөнхийн хувь заяа” хэлсэн үгийн “Миний хайртай залуу эрэгтэйчүүд ээ” гэж эхэлдэг догол мөрөөс эхлэн уншуул (*Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 64). Залуу эрэгтэйчүүдийг Гибсон ахын жагсаасан санваарын үүргүүдээс нэгийг сонгоод, өөрсдийн гэр оронд тэр үүргээ хэрхэн биелүүлж болохыг жүжигчлэн тоглоход урь. Аароны санваарын үүргээ биелүүлэх нь тэднийг эцэг болохоор бэлтгэхэд нь хэрхэн туслах вэ? Гэртээ санваарын үүргээ биелүүлэх талаар нэг, хоёр тодорхой зорилго тавихад залуу эрэгтэйчүүдийг урамшуулан дэмж.

- Залуу эрэгтэйчүүдийг “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн 7-р догол мөрийг уншихад (эсвэл “Эцэг хүн гэр бүлээ адислахын тулд санваараа ашиглаж болно” видео бичлэгийг үз) мөн тэд нөхөр, эцэг хүн болох үедээ үүрэх үүрэг хариуцлага юу байхыг хайж олоход урь. Чуулгыг жижиг бүлгүүдэд хуваан, бүлэг бүрээс эдгээр үүрэг хариуцлагын нэгд нь бэлтгэж болох арга замуудын талаар бодохыг хүс. Бүлэг бүрийн нэг гишүүнээс бүлэг нь юуны талаар ярилцсаныг чуулгынхантай хуваалцахыг хүс.

- Лихайн Иерусалим дахь шударга бусчуудаас зугтах илчлэлт хүлээн авдаг 1 Нифай 2:1-3 дахь хэсгийг чуулгаараа унш. Залуу эрэгтэйчүүд зөв шударга эцэг хүн байх талаарх Лихайн жишээнээс юу сурдаг вэ? Лихайд байсан шинж чанаруудыг хөгжүүлэхийн тулд тэд одоо юу хийж чадах вэ? Залуу эрэгтэйчүүдээс 1 Нифай 16:14-32-ыг уншин, Нифай гэр бүлдээ хэрхэн ханддаг байсныг хайж олохыг хүс. Энэ нь Нифайг нөхөр, эцэг хүний үүрэгтээ бэлтгэхэд хэрхэн тусалсан бэ? Залуу эрэгтэйчүүдээс нөхөр, эцэг хүн болоход бэлтгэхийн тулд одоо гэр бүлдээ юу хийж байгааг нь асуу.

- Залуу эрэгтэй бүрд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номоос “Ажил хөдөлмөр ба бие даах чадвар” эсвэл “Боловсрол” хэсгээс нэг догол мөрийг уншихыг эсвэл “Ажил урагшилж байна” видео бичлэгийг үзэхийг даалга. Залуу эрэгтэйчүүд сайн нөхөр, эцэг хүн болоход нь туслах эдгээр материалаас юу сурдаг вэ?

- Чуулганы гишүүн бүрд ахлагч Л.Витни Клэйтоны “Гэрлэлт: Ажиглаад суралц” хэлсэн үгэнд дүрсэлсэн хүчирхэг гэрлэлтийн таван зарчмын нэгийг оноож өг. Залуу эрэгтэйчүүд эдгээр зарчмаас ямар жишээ харж байна вэ? Тэд өөрсдийн дуурайхыг хүссэн хүчирхэг гэр бүлийн хосоос өөр юу олж ажигласан бэ? Залуу эрэгтэйчүүдэд эдгээр зарчмын дагуу амьдрахын тулд одоо юу хийж чадна гэж бодогдож байна вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Нөхөр, эцэг хүний хувьд ирээдүйн үүргүүддээ хэрхэн бэлтгэхийг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулгын гишүүдийг гэр бүлүүдээ хүчирхэгжүүлэх ямар нэг зүйл хийхэд урьж болно.
- Зөв шударга нөхөр, эцэг хүн болоход бэлтгэхийн тулд тавьсан зорилгоо хуваалцаж болно.

Сонгосон материалууд

Ларри М.Гибсон, “Эцэг байх нь бидний мөнхийн хувь заяа,” *Ensign*, 2015 оны 5-р сар, 79 эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 64

Миний хайртай залуу эрэгтэйчүүд ээ, та нар Мелкизедек санваарыг болон ариун нандин ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, бүрэн цагийн номлолд үйлчлэх үүрэг, *хариуцлага* бие-лүүлэхэд мөн дараа нь их удалгүй ариун сүмд Бурханы охинтой гэрлэж, гэр бүлтэй болоход бэлтгэж байгаа. Та нар гэр бүлээ Ариун Сүнсний удирдамжаар сүнслэг байдалд тийнхүү удирдах болно (С ба Г 20:44; 46:2; 107:12-ыг үзнэ үү).

Би дэлхийн өнцөг булан бүрд байдаг олон залуу эрэгтэйгээс “Та нар яагаад энд байгаа юм бэ?” гэж асууж байсан.

Одоогийн байдлаар хэн ч “Би Тэнгэрлэг Эцэгт байгаа бүх зүйлийг хүлээн авахад бэлтгэж, зохистой байж болохын тулд эцэг байхад суралцахаар энд байна” гэж хэлээгүй байна.

Сургаал ба Гэрээний 20-р хэсэгт тодорхойлсон Аароны санваарын үүргүүдээ бодож үз. Эдгээр үүргийг гэр бүлдээ үйлчлэх үйлчлэлтэй чинь холбох үед юу мэдэрч *байгаагаа* анзаараарай.

“Христэд ирэхэд [гэр бүлийнхнийгээ бүгдийг] урь” (59-р шүлэг).

“Тэднийг ямагт харж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх нь болой” (53-р шүлэг).

Гэр бүлийнхээ гишүүдэд “заах, тайлбарлах, ухуулах, мөн баптисм хүртээх . . . нь болой” (46-р шүлэг).

“Чанга дуугаар болон чимээгүй залбиралыг, мөн гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг тэдэнд ухуулах нь болой” (47-р шүлэг).

“[Гэр бүлд тань] алдас байхгүй, мөн бие биендээ хахир хатуу хандахгүй, мөн худал хэлэхгүй, хов жив хөөцөлдөхгүй, мөн шүүмжлэхгүй байхад анхаарах нь болой” (54-р шүлэг).

“[Гэр бүл тань] хамтдаа олонтаа цуглахыг . . . анхаарах нь болой” (55-р шүлэг).

Аавуудад патриархын үүргээ гүйцэтгэхэд тусал. Аав тань байхгүй үед ээжийгээ санваарын хүчээр тэтгэ (52, 56-р шүлгийг үзнэ үү).

Хэрэв та нар хүсвэл гэр бүлдээ “бусад санваартнууд, багш нар хийгээд диконуудыг томилж болно” (48-р шүлэг).



Гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргүүд нь хэрхэн харилцан бие биенээ нөхөн гүйцээдэг вэ?

Тэнгэрлэг загвараар Тэнгэрлэг Эцэг нөхөр, эхнэрийн харилцан бие биенээ нөхөн гүйцээх үүргээ биелүүлэхэд нь туслахын тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөр бэлгүүд болон чадваруудыг өгсөн. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129).

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Харилцан бие биенийхээ үүргүүдийг нөхөж байдаг эцэг, эхчүүдийн ямар жишээг та нар харсан бэ? Эдгээр мөнхийн үүргийн талаарх мэдлэг гэр бүлд тань хэрхэн нөлөөлсөн бэ?

Та залуу эрэгтэйчүүдэд ирээдүйн эцэг хүний бурханлаг үүргээ ойлгоход нь хэрхэн тусалж чадах вэ? Тэд энэ үүрэгтээ бэлтгэхийн тулд одоо юу хийж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Эдгээр судар болон бусад материалыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

С ба Г 121:41–43 (Санваарын зөв шударга ёсонд хэрэглэгдэх зарчмууд)

Мосе 3:21–24; 5:1–4 (Адам, Ева хоёр эрх тэгш хамтрагчдын хувьд хамтдаа хөдөлмөрлөсөн)

Линда К.Бертон, “Хамтдаа өсөж хөгжицгөө” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 12-15

Л.Том Пэрри, “Үүрдийн амар амгаланг олж, мөнхийн гэр бүлтэй болох нь,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 50-53

Д.Тодд Кристоффэрсон, “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч,” *Ensign* эсвэл 2013 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 33-37

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүдэд нэг зүйл эсвэл зураг харуулан энэ зүйл нь өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй ямар холбоотойг тайлбарлахыг тэднээс хүс.
- Нэг зорилгын төлөө хоёулаа ашиглагддаг хоёр зүйлийг ангидаа авч ир (харандаа, цаас ба алх, хадаас гэх мэт). Залуу эрэгтэйчүүдийг эдгээр хоёр зүйлийн хоорондох ялгааг болон хамтад нь хэрхэн ашигладгийг тайлбарлахад урь. Бурханы зорилгуудад хүргэхийн төлөө харилцан бие биенээ нөхөн гүйцээх ялгаатай үүрэг хариуцлагууд эрэгтэй, эмэгтэй хүмүүст өгөгддөг гэдгийг тайлбарла. Залуу эрэгтэйчүүдийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бие биенээ нөхөн гүйцээдэг хэдэн арга замуудыг дүрслэн ярилцахад урь.

Заахад туслах арга

“Ариун Сүнс та нарын зааж байгаа ганц хоёр хүнд бусдынхаа сонсох хэрэгтэй зүйлийг нэмж хэлэхэд нөлөөлж болох юм. Зарим нэг хүнийг нэр цохон дуудах сүнс-лэг нөлөөг хүлээн авахад нээлттэй бай. Үзэл бодлоо илэрхийлэхийг сайн дураараа хүсээгүй хүнээс асуух өдөөлтийг ч та хүлээн авч болох юм (Teaching, No Greater Call [1999], 63).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүлүүддээ харилцан бие биенээ нөхөх үүргүүдийг ойлгож мэдэхэд тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Дараах гарчгуудыг самбар дээр бич: *Эцгийн үүрэг хариуцлага* ба *Эхийн үүрэг хариуцлага*. Их Эзэний эцэг эхчүүдийн гүйцэтгэх ёстой гэж үздэг үүрэг хариуцлагуудыг жагсаахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Энэ жагсаалтыг гаргахад нь туслахын тулд тэднийг “Гэр бүл: Дэлхий

дахинаа өргөх тунхаг”-ийн 7-р догол мөрийг (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* 107-г үзнэ үү) мөн ахлагч Л.Том Пэрригийн “Үүрдийн амар амгаланг олж, мөнхийн гэр бүлтэй болох нь”, ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч” хэлсэн үгсийн зохих хэсгүүдээс судлахад урь. Тэд эдгээр эх сурвалжаас эцэг, эхчүүдийн тэнгэрлэг үүргүүдийн талаар юу сурч болох вэ? Энэ үүргүүд нь хэрхэн харилцан бие биенээ нөхдөг вэ? Эдгээр сургаал нь дэлхийн заадгаас юугаараа ялгаатай вэ? Эцэг эхчүүдийг харилцан бие биенээ нөхдөг үүргүүдээ биелүүлж байхыг нь харснаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг Мосе 5:1–12-ыг судлаад, Адам, Ева хоёрын хамтрагчдын хувьд хамтдаа хийсэн зүйлсийг самбар дээр жагсаан бичихэд урь (үзүүлэн болгон ашиглахын тулд *Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 5-ыг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдээс нөхөр, эхнэрүүд эрх тэгш хамтрагчийн хувьд хэрхэн хамтдаа ажиллаж болохыг жагсаалт дээрээ нэмж бичихийг хүс.

- “Бидний амьдрал дахь эмэгтэйчүүд,” эсвэл “Эр хүн шиг байцгаая” видео бичлэгүүдийг үзүүл. Залуу эрэгтэйчүүд нөхөр нь эхнэрээ хэрхэн адисалдаг тухай видео бичлэгээс юу сурсан бэ? Залуу эрэгтэйчүүдээс хэзээ нэгэн цагт ямархуу нөхөр болохыг хүсдэг тухай бодохыг хүс. Тийм хүн болохын тулд тэд одоо юу хийж чадах вэ?

- Чуулгын цуглаан дээр бишопын зөвшөөрөлтэйгөөр гэр бүлийн нэг хосыг урь. Линда К.Бертоны “Хамтдаа өсөж хөгжицгөө” хэлсэн үгээс “Харилцан бие биенээ нөхөх үүргүүдээ биелүүлэхдээ нэг нэгнээ өргөн дэмжиж, туслах нь” гарчигтай хэсгийг хамтдаа унш. Гэр бүлдэх эрэгтэй, эмэгтэйчүүд бие биенээ хэрхэн өргөн дэмждэг талаар залуу эрэгтэйчүүд юу олж мэдсэн бэ? Уригдаж ирсэн хосоос тус тусын үүргүүдээ биелүүлэхэд бие биендээ хэрхэн тусалдаг талаараа ярихыг хүс. Гэрлэлт нь танд эсвэл гэр бүлийн тань гишүүдэд илүү сайхан байхад хэрхэн тусалсан талаар хуваалцахыг бодож үз.

- Эмэгтэйчүүдэд сайн эх мөн сайн асран хамгаалагч байхад туслах зан чанаруудыг жагсаахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Сатан эмэгтэйчүүдийн нөлөөг сулруулах гэж хэрхэн хичээж чармайдаг вэ? Дэлхий дээр зөв шударга эмэгтэйчүүдийн үр нөлөөг урамшуулан дэмжиж, туслахын тулд залуу эрэгтэйчүүд юу хийж чадах вэ? Зөв шударга эмэгтэйчүүдийн нөлөө залуу эрэгтэйчүүдийг нөхөр, эцэг хүн болохоор бэлтгэхэд нь хэрхэн удирдан чиглүүлж болох вэ? Залуу эрэгтэйчүүд энэ ярилцлагын нэг хэсэг болгон, ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч” хэлсэн үгээс сонгосон хэсгүүдийг уншиж болно. Жишээ нь, эхний хоёр догол мөрийг болон эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүчийг сулруулдаг гурван чиг хандлагыг үзнэ үү.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нараа хайрлан, тэдний төлөө залбирч, үргэлжлүүлэн тэдэнд үйлчилдэг байсан. Тэрээр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан. Та үйлчилж байгаа залуу эрэгтэйчүүдийнхээ талаар юу мэддэг вэ? Ирээдүйн гэр бүлээ удирдах, хангах, хамгаалахад бэлэн байхад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд та өнөөдөр юу хийж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл дэх харилцан бие биенээ дэмжих үүргүүдийг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Эцэг эх нь тэнгэрлэг үүргүүдээ биелүүлсний учир адислагдсан тодорхой арга замуудын төлөө эцэг эхдээ талархал илэрхийлэхэд чуулгын гишүүдийг урьж болно.
- Залуу эрэгтэйчүүдийг гэр бүлдээ удирдах, хангах, хамгаалах ирээдүйн үүргүүдээ биелүүлэхэд нь туслах арга замуудыг олж мэдэхэд урьж болно.

Сонгосон материалууд

Д. Тодд Кристоффэрсоны “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Олон жилийн тэртээгээс аливаа улс нийгэм эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүчинд тулгуурласаар ирсэн билээ. Эмэгтэйчүүдийн ёс суртахууны суурь нь нийгэм дэх цорын ганц эерэг нөлөө биш боловч олон нийтийн эрх ашигт ер бусын ач тустай гэдэг нь нотлогдсон юм. Энэ нөлөө нь бидний амьдралд маш элбэг байдаг учраас эмэгтэйчүүдийн оруулж буй энэ хувь нэмэр ихэнхдээ тэр бүр талархал хүлээдэггүй байж магадгүй юм. Би сайн эмэгтэйчүүдийн нөлөөлөлд талархлаа илэрхийлж, эмэгтэйчүүдийн хүч болон байр суурь, дуу хоолойд заналхийлж буй зарим

гүн ухаан болон чиг хандлагыг тодорхойлон мөн өөрсдөдөө буй ёс суртахууны хүчээ өсгөн гордоосой хэмээн эмэгтэйчүүдээсээ хүсмээр байна.

Эмэгтэйчүүд энэ дэлхийд төрөхдөө тодорхой нэг сайн чанар-тэнгэрлэг бэлгийг өөрсөдтэйгөө хамт авчирдаг бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар эмэгтэйчүүд итгэл, эр зориг, өрөвч сэтгэл, өсөлт хөгжил зэрэг гайхалтай чанаруудыг хүмүүс хоорондын харилцаанд болон соёл иргэншил дотор маш чадамгай бий болгодог. Паул анх Тимотын “чин сэтгэлийн итгэл”-ийг олж хараад магтахдаа энэ итгэл нь “анх чиний эмэг эх Лой, чиний эх Юник нарт байсан” хэмээн тэмдэглэсэн байдаг [2 Тимот 1:5].

Есдүгээр сар: Зарлигууд

“Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай” (Мозая 2:41).

Энэхүү бүлгийн тоймууд нь залуу эрэгтэй бүрд Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахиснаар ирэх адислалуудын талаар сурахад туслах болно. Залуу эрэгтэйчүүд зарлигуудыг сахих, тасралтгүйгээр наманчлах үедээ Их Эзэнийг хайрлах хайраа үзүүлж мөн өөрсдийгөө дэлхийн нөлөөнүүдээс хол байлгах болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би энэ дэлхий дээр дэлхийнхнээс өөрөөр хэрхэн амьдрах вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Миний хэлж ярьж байгаа зүйл надад болон эргэн тойронд минь байгаа хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?

Би порнографыг хэрхэн эсэргүүцэж чадах вэ?

Бид яагаад мацаг барьдаг вэ?

Бидэнд яагаад хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгал хэмээн тушаасан бэ?

Бид яагаад аравны нэгийг төлдөг вэ?

Шударга байх нь яагаад чухал вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй холбон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм. Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мючелийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануудыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй холбоотой:

“Зохистой амьдар” 16–17, 40–41, 64–65-р хуудас

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

БУРХАНЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ НЬ

Би хэрхэн энэ дэлхий дээр дэлхийнхнээс өөрөөр амьдрах вэ?

“Нэгэн цагт сүмийн жишгүүд болон нийгмийн жишгүүдийн хооронд ялгаа төдийлөн байдаггүй байсан бол өнөө үед эдгээрийн хооронд том ангал бий болж, улам томорсоор байна” (Томас С.Монсон, “Санваарын хүч” *Ensign* эсвэл 2011 оны 4 сарын Ерөнхий чуулган, 66). Их Эзэн биднийг Өөрийнх нь жишгийг үнэнчээр дагаж, дэлхийн нүгэл хилэнцээс хүртэхгүй байгаасай хэмээн хүсдэг. Үүний зэрэгцээгээр Тэрээр биднийг өөрсдийн эргэн тойронд байгаа хүмүүст сайн нөлөө үзүүлээсэй хэмээн хүсдэг.

Сүмийн жишигт нийцэхгүй дэлхийн ямар жишгүүд байдаг вэ? Та Их Эзэний жишгийн дагуу амьдарснаар ямар адислалуудыг хүлээж авсан бэ? Жишгээ хадгалах нь хэрхэн эргэн тойрон дахь хүмүүст чинь нөлөөлдөг вэ?

Дэлхийнхэн хэрхэн залуу эрэгтэйчүүдийн Их Эзэний жишиг гэж үздэг замуудад нөлөөлөх гэж хичээдэг вэ? Залуу эрэгтэйчүүд нийгмийн жишиг доройтон буурсаар байгаа үед Их Эзэний жишгийг өндөрт хэвээр хадгалахын тулд юу хийж чадах вэ? Залуу эрэгтэйчүүд хэрхэн эргэн тойрныхоо хүмүүст сайнаар нөлөөлж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Таны зааж байгаа залуу эрэгтэйчүүдэд хамгийн их туслах зүйл юу байна гэж та бодож байна вэ?

“Зохистой амьдар,” *Бурханы өмнө-хүлээсэн үүргээ биелүүлэх нь* (2010), диконууд, 16–17; багш нар, 40–41; пристүүд, 64–65

Эхлэл 39:1–20 (Египетийн Иосеф Потифарын эхнэрийн сээтэгнэлийг эсэргүүцсэн нь)

Хаадын Дэд 6:14–17 (Елишагийн зарц, түүнийг ганцаар биш гэдгийг ойлгосон нь)

Матай 26:41; С ба Г 10:5 (Уруу татагдахгүйн тулд анхааралтай бай бас залбир)

Иохан 15:19; 1 Нифай 8:24–28 (Христийг дагалдагчдыг дэлхийнхэн олонтоо элэглэж мөн үзэн ядах болой)

1 Коринт 10:13 (Бид хэрээс хэтэрсэн зүйлд соригдохгүй)

С ба Г 3:6–8 (Хэрвээ бид хүмүүнээс илүүгээр Бурханд итгэх юм бол Тэр биднийг дайсны маань эсрэг дэмжих болно)

С ба Г 62:1 (Их Эзэн бидний султальг мэддэг бөгөөд уруу татагдсан үед маань бидэнд хэрхэн туслахаа бас мэддэг)

С ба Г 87:8 (Ариун газруудад зогсогтун)

Үлиссэс Соарэс “Тийм ээ. бид чадна Бас бид ялна!” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 59

Томас С.Монсон, “Ганцаар зогсох зоригтой бай,” *Ensign* эсвэл 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 60–67

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Цаасан дээр өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ нэг өгүүлбэрээр тодорхойлон бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс. Хэд хэдэн залуу эрэгтэйгээс бичсэн дүгнэлтээ уншихыг хүс.
- Чуулгын гишүүдэд жүрж жимсийг (эсвэл өөр нэгэн цитрус жимсийг) харуул. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номд гардаг жишгүүдийн заримыг нэрлэхийг тэднээс хүс. Тэднийг нэрлэх хооронд тэдгээрийг жүржин дээр бич. Тэгээд жүржийг савтай усанд хий (энэ нь хөвөх болно). Тэгээд жүржээ уснаас аваад хальсыг нь ав. Буцаагаад усанд хий, тэгвэл энэ нь живэх болно. Их Эзэний жишиг стандартын дагуу амьдрах талаар энэ нь юу зааж байгаа талаар хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Жишгээ хадгалсан нь амьдралыг тань хэрхэн адисалсан талаар тодорхой жишээг хуваалц.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөө

Ангийн цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ хийсэн төлөвлөгөөгөө бичих цаг гарга. Энэ төлөвлөгөө хувь хүнийх боловч чуулгын гишүүд төлөвлөгөөний талаар санаанууд олоход нь бие биедээ тусалж болно.

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго нь хэрхэн энэ дэлхийд амьдрах үедээ дэлхийнхнээс өөр байж болохыг мөн энэ нь хэрхэн санваарын хүчээ ашиглахуйц зохистой амьдрахад нь залуу эрэгтэй бүрд тусалдгийг ойлгоход нь туслах явдал юм. Энэ хичээлийн нэг хэсэг болгож, чуулгын гишүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ

биелүүлэх нь номондоо Залуучуудын бат бөх байдлын төлөө номон дахь жишгүүдийг судалж, тэдгээрийн дагуу амьдрах төлөвлөгөөг бичих хэрэгтэй. Чуулгын цуглааны өмнө залуу эрэгтэйчүүдээс Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь ба Залуучуудын бат бөх байдлын төлөө номоо сүмдээ авчрахыг хүснэ үү. Чуулгын цаашидын цуглаанууд дээр, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцдаа ямар туршлага хуримтлуулж байгаагаа хуваалцахад тэднийг уриарай.

- Энэхүү тоймд дурдагдсан судруудыг уншихыг залуу эрэгтэйчүүдээс хүсээд (чуулгаараа эсвэл хувь хувьдаа) мөн уруу таталтыг ялан дийлэх талаар сурсан зүйлийнх нь тухай ярилц. Дэлхийнхэн тэднийг өндөр жишигтэй хэмээн шоолж, жишгээ бууруулахад уруу татаж байгаа үед тэд хэрхэн Бурханы жишгийн дагуу амьдарч байна вэ? Их Эзэний жишгийн дагуу амьдарч, уруу таталтыг сөрөн зогссон үед тэдэнд ямар санагдсан бол? Тэдэнд хуваалцах туршлагаууд байна уу?

- Линн Г.Робинсын “Та хаашаа харсан байна вэ?,” Улиссэс Соарэсын “Тийм ээ. Бид чадна бас бид ялна!” зэрэг хэлсэн үгс нь энэ дэлхий дээр сөрөг нөлөөнд хариу үйлдэл үзүүлж байгаа хүмүүсийн тухай таатай болон таагүй жишээнүүдийг харуулсан байдаг. Залуу эрэгтэй бүрийг дээрх хэлсэн үгсийг олоод, өөрт таалагдсан жишээг сонгон, чуулгынхандаа түүхийг хураангуйлан ярьж өгөхөд урь. Сонгосон түүх нь энэ дэлхийд амьдрахдаа дэлхийн уруу таталтуудыг хэрхэн давах талаар юу зааж байгааг хуваалцахыг залуу эрэгтэй бүрээс хүс.

- Залуучуудын бат бөх байдлын төлөө номын сэдвүүдийг уншаад, ярилцахыг хүсэж байгаа нэгээс илүү жишгийг сонгохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэй бүрийг цөөн хэдэн минутанд сонгосон жишгээ судлаад, сурсан зүйлээ хуваалцахаар бэлдэхэд урь. Залуу эрэгтэй бүрээс Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо нээн, “Үйлдэх” гэсэн хэсэгт энэхүү жишгийг даган амьдрах төлөвлөгөөгөө бичихийг хүс (17, 41 эсвэл 65-р хуудас). Хэрэв зохимжтой бол, төлөвлөгөөгөө бие биетэйгээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ирэх долоо хоногуудад тэдний гаргасан төлөвлөгөө нь тэднийг “дэлхий дээр амьдрахдаа дэлхийнхэнтэй адил байхгүй байхад” тусалсан талаар хуваалцахад бэлдэж ирэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс (Иохан 15:19-ийг үзнэ үү).

- Чуулгаараа хамтдаа Сургаал ба Гэрээ 87:8-ыг уншаад, ариун газарт зогсоно гэдэг нь юу гэсэн утгатайг залуу эрэгтэйчүүдээс асуу. Гэр бүлээ болон сургуулиа эсвэл орчин тойрноо хэрхэн илүү ариун нандин газар болгож чадна гэж бодож байгааг нь залуу эрэгтэйчүүдээс асуу.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр ганцаар залбирч мөн мацаг барин, заахад Өөрийгөө бэлтгэдэг байв.

Тэрээр ганцаараа байх үедээ Тэнгэрлэг Эцэгийнхээ удирдамжийг эрэлхийлдэг байсан. Та залуу эрэгтэйчүүдэд заахаар бэлтгэх явцдаа, Их Эзэний жишгийг даган амьдарснаар ирэх адислалуудыг ойлгоход нь хэрхэн туслахаа мэдэхийн төлөө залбирч, Тэнгэрлэг Эцэгийн удирдамжийг эрэлхийлээрэй.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Санваартнуудын хувьд, тэд энэ дэлхийд амьдарч байгаа ч дэлхийнхэнтэй адил байх ёсгүй гэдгийг ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Их Эзэний жишгийн дагуу амьдрахын ач холбогдлын талаарх гэрчлэлээ хуваалцаж болох юм.
- Залуу эрэгтэйчүүдээс *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номынхоо “Зохистой амьдар”* бүлэгт өөрсдийн бичсэн төлөвлөгөөг биелүүлнэ гэсэн амлалт авч болно.

Сонгосон материалууд

Үлссэс Соарэс, “Тийм ээ. Бид чадна бас бид ялна!”
Ensign, 2015 оны 5-р сар, 70, 75 эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 59, 60

Хэчнээн хүнд нөхцөл байдалд орсон ч тулаанд ялан гарч байгаа хүмүүсийн талаар олон жишээ сударт байдаг. Эдгээрийн нэг нь Мормоны Номонд гардаг ахмад Моронай юм. Энэ гайхалтай залуу дөнгөж хорин таван насандаа нифайчуудын армийн удирдагч болдог. Нифай үндэстний оршин тогтноход аюул учруулж байсан дайсагнал, сөргөлдөөн, дайн тулааны үед тэр үнэнийг хамгаалах зоригтой байж чадсан. Моронай өөрийнхөө хийх ёстой зүйлүүдийг гайхалтай хийдэг байсан ч даруухан үлдэж чадсан билээ. Үүний зэрэгцээ өөр бусад зан чанар нь түүнийг тухайн үед Бурханы мутар дахь ер бусын онцгой зэмсэг болгож байжээ. Алмагийн ном дээр хэрвээ бүх хүмүүн Моронай шиг байсан бол “тамын чухамхүү хүчин чадал үүрд сэгсрэгдэн сулруулагдах сан; тийм ээ, хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг давах хүч чөтгөрт хэзээ ч байхгүй байх сан” [Алма 48:17] хэмээн тайлбарлажээ. Моронайн хийж байсан бүх л сайн үйлдэл нь түүний Бурханд болон Эзэн Есүс Христэд итгэх Агуу итгэлээс нь мөн Бурханы болон Түүний бошиглогчдын дуу хоолойг дуулгавартай дагана гэсэн түүний бат шийдэмгий байдлаас эхлэлтэй юм.

Зүйрлэвэл, бид амьдралд маань нөлөөлж буй чөтгөрийн тэр нөлөөтэй тэмцэж ялахын тулд орчин үеийн ахмад Моронай болон хувирах хэрэгтэй. Өөрийгөө орчин үеийн ахмад Моронай болгосон

нэгэн диконыг би мэддэг. Энэ залуу хүү эцэг эхийнхээ болон Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагахыг эрэлхийлэхийн хэрээр бага насандаа итгэл, зорилго нь өдөр бүр хүнд хэцүү сорилтод орж байдаг байлаа. Тэрээр надад нэг өдөр ангийнхантайгаа уулзахаар очихдоо тэднийг гар утсан дээрээ садар самууныг сурталчилсан зураг үзэж байхыг хараад, ихэд гайхсанаа ярьсан юм. Тэр маш хүнд сорилттой тулгарчээ. Яг тэр үед залуу хүүд ангийнхан дундаа нэр хүнд олж авах уу аль эсвэл зөв зохистой байдлыг сонгосон итгэл чухал уу гэдгийг сонгох хэрэг гарчээ. Дараагийн хэдхэн хоромд залуу хүү найзууддаа хийж байгаа зүйл нь буруу гэдгийг зоригтой хэлэх хүслээр дүүргэгдэв. Үүгээр ч зогсохгүй тэр найзууддаа хэрвээ хийж байгаа энэ үйлдлээ зогсоохгүй бол эцэстээ энэ зүйлийнхээ боол нь болдог юм шүү гэж хүртэл хэлсэн байна. Ангийнх нь ихэнх хүүхэд түүний зөвлөгөөг элэглэн шоолж, үүнд сүржигнэх юм ер байхгүй, энэ бол амьдралын нэг хэсэг гэж хэлж байлаа. Гэтэл тэдний дунд залуу хүүгийн зөвлөгөөг сонсоод, хийж байгаа зүйлээ зогсооё гэсэн нэг хүүхэд байв.

Энэ диконы зөв үлгэр жишээ нь ядаж нэг ч гэсэн хүүхдэд сайнаар нөлөөлж чадсан юм. Мэдээж, залуу хүү болон түүний найз ийм шийдвэр гаргасныхаа төлөө дооглуулж, хавчигдаж эхлэв. Гэхдээ нөгөө талдаа тэд Алмагийн өөрсдийн хүмүүст хандан “та нар бүгд, ёс бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, мөн та нар тусдаа байгтун, мөн тэдний цэвэр бус зүйлүүдэд бүү хүрэгтүн” [Алма 5:57] хэмээн хэлснийг дагасан юм.



Миний хэлж ярьж байгаа зүйлс надад болон эргэн тойронд минь байгаа хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?

Бидний бусадтай хэрхэн харьцаж байгаа нь Бурханы хүүхдүүдийн хувьд хэн бэ гэсэн ойлголтыг маань тусган харуулдаг. Бидний хэл яриа бусдыг урамшуулж эсвэл тэднийг гомдоож, шархлуулж чадна. Бид сайн хэл яриаг хэрэглэх үедээ Ариун Сүнсийг өөрсөдтэйгээ хамт байхыг урьдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бусадтай харилцахдаа хэрэглэх үгсийн чухлыг залуу эрэгтэйчүүд ойлгоход ямар судрууд болон хэлсэн үгс туслах вэ?

Сургаалт үгс 15:1–4; 16:24; 1 Тимот 4:12; Иаков 3:2–10; Алма 31:5; С ба Г 108:7 (Бидний үгс бусдад хүчит нөлөөг үзүүлж чаддаг)

Матай 12:36; 15:11; Ефес 4:29–32; Мозая 4:30 (Бид өөрсдийн хэрэглэж байгаа хэл ярианд болгоомжтой хандах ёстой)

Жэффри Р.Холланд “Тэнгэр элчүүдийн хэл” *Ensign* эсвэл *Лиахона* 2007 оны 5-р сар, 16–18

В.Крэг Звик, “Чи юу бодож байна?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар.

“Хэл яриа” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 20–21

“Бохир хэллэг” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 56

Та нарын хэрэглэх үг яриа таныг хэн болохыг хэрхэн илэрхийлдэг вэ? Урамшуулж, зааж, тайтгаруулж мөн харилцан ойлголцохын тулд та үгсийг хэрхэн ашиглаж байсан бэ? Амьдралын чинь туршид зөв зохистой үг хэл хэрэглэх дэлхийн жишиг стандарт хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Залуу эрэгтэйчүүдийн хэрэглэж байгаа хэл яриа бусдыг урамшуулж, өргөж байна уу эсвэл гомдоон, шархлуулж байна уу? Залуу эрэгтэйчүүд өөрсдийн эргэн тойрон дахь хүмүүсээ Сүнсийг урих үг хэл хэрэглэхэд нь хэрхэн дэмжих вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс юу сэтгэлд нь хоногшсоныг залуу эрэгтэйчүүдээс асуу.
- Дараах үгсийг самбар дээр бич: *Бидний унших үгс. Бидний сонсох үгс. Бидний бичих үгс. Бидний ярих үгс.* Залуу эрэгтэйчүүдээс Ефес 4:29–32-ыг уншихыг хүсч мөн энэ захиас

нь самбар дээр бичсэн дөрвөн зүйлтэй ямар холбоотой болохыг ярилц. Дараах асуултуудын талаар тунгаан бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс: Та нар өөрсдийн уншдаг, сонсдог, хэрэглэдэг хэл ярианы талаар ямар бодолтой байдаг вэ? Үгс нь Ариун Сүнсний удирдамжийг хэрхэн дэмжиж эсвэл холдуулж болох вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь зөв хэл яриа хэрэглэхийн чухлыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Самбар дээр “Хэрэв хүн өөрийн хэлийг захирч чадах юм бол, тэр _____ захирч чадна” гэж бич. Залуу эрэгтэйчүүдээс Иаков 3:2–10-ыг уншин, дутуу үгсийг нөхөж бичихийг хүс. Залуу эрэгтэй бүрээр Иаковын хэрэглэсэн адилгалуудын нэгийг оноон уншуул (морины амгайвч, 2–3-р шүлэг; усан онгоц, 4-р шүлэг; ой модны түймэр, 5–6-р шүлэг; хор, 7–8-р шүлэг; цэвэр цэнгэг булаг, 10–11-р шүлэг). Залуу эрэгтэйчүүдэд оноогдсон адилтгал нь хэл яриагаа захирах талаар юу гэж зааж байгааг ангийнхандаа заахад бэлтгэхийг хүс. Өөрсдийн хэл яриаг захирч сурахын тулд юу хийж болох талаараа хуваалцахыг тэднээс хүс.

- Өөрсдийн дуртай сүнслэг нөлөө бүхий эшлэлийг чуулгын цуглаанд авчрахыг залуу эрэгтэйчүүдээс хэдэн өдрийн өмнө хүс. Залуу эрэгтэй бүрээс өөрсдийн авчирсан эшлэлийг хуваалцахыг мөн энэ нь тэдний амьдралд ямар нөлөө үзүүлснийг тайлбарлахыг хүс. Бидний хэлдэг үгс бусдад эерэгээр хүчтэй нөлөөлж байгааг харуулдаг судруудын жишээг хайж олохыг чуулгын гишүүдээс хүс (жишээлбэл, Ахмад Моронай болон эрх чөлөөний туг [Алма 46:11–22-ыг үзнэ үү], Аврагч ба завхайрч байгаад баригдсан эмэгтэй [Иохан 8:1–11-ийг үзнэ үү], Абинадай ба Алма [Алма 5:9–12-ыг үзнэ үү]). Тэдний хэл яриа бусдад хэрхэн хүчтэй нөлөөлж

Заахад туслах арга

“Та заахаар бэлтгэх үедээ залбирвал зарим нэг зарчмууд дээр онцгой анхаарал хандуулах хэрэгтэй хэмээн сүнслэгээр нөлөөлөгдөж болох юм. Тодорхой санаануудыг хэрхэн хамгийн үр өгөөжтэй заах талаар ойлголттой болж болно. Хичээл заахад тань туслах жишээ, үзүүлэнт хичээл, сүнслэг нөлөө бүхий амьдралын энгийн түүхүүд таны санаанд орж ирж болно. Хичээлд тань туслах хэн нэгэн онцгой хүнийг урих санаа төрж болно. Хуваалцаж болох хувийн туршлагаа та нар санаж болно” (*Teaching, No Greater Call* [1999], 48).

Аврагчийн арга барилаар заах нь

Бүхий л нөхцөлд, Аврагч маань бидний жишээ мөн багш байсан юм. Тэдэнтэй хамтдаа залбирснаар тэдэнд залбирахыг Тэрээр заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шигээ бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр тэдэнд заасан. Өөрийн заасан аргаар сайн мэдээ заахыг Тэрээр тэднээс хүссэн. Заахаар бэлтгэх явцдаа, бусдыг өргөж, урамшуулах мөн Ариун Сүнсний нөхөрлөлийг урих аргаар Их Эзэн хэрхэн харьцдаг байсныг мөн бид хэрхэн харьцаж болох талаар бодож үзээрэй.

Болох талаар эдгээр жишээ нь залуу эрэгтэйчүүдэд юу зааж байна вэ?

- Энэхүү тойм дахь судрын эшлэлүүдийн эхний хэсэгт дурьдсан судруудаас өөр өөр судрыг залуу эрэгтэй бүрээр уншуулахаар оноо. Судрын шүлэг дээрх захиасыг төлөөлөх зураг эсвэл диаграм зурахыг тэднээс хүс. Түүнийг зургаа үзүүлж, чуулгын бусад гишүүдийг бусадтай харьцах харьцааны талаар энэ нь юу зааж байгааг таахыг хүс. Судрын шүлэг дэх захиастай холбоотой сэтгэгдлээсээ хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Залуу эрэгтэй бүрд ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн “Тэнгэр элчүүдийн хэл” үгийн хэсгийг өгч, тэднээс уг хэсгийн гол захиасыг тодотгохыг хүс (залуу эрэгтэйчүүдэд уг хэлсэн үгийн гарчгийг битгий өгөөрэй). Өөрсдийн тодотгосон зүйлсээ самбар дээр бичихийг мөн учрыг нь тайлбарлахыг залуу эрэгтэй бүрээс хүс. Тэдний тодорхойлсон гол захиасууд дээр үндэслэн уг хэлсэн үгийн гарчиг юу байж болох талаар саналаа хэлэхийг чуулгын гишүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүд өөр нэгэнд урамшуулах үгс хэлсэн үе байвал эсвэл хэн нэгэн өөрсдийг нь урамшуулсан үе байвал тэр талаараа хуваалцахыг тэднээс хүс.

- Энэхүү тоймд тусгагдсан видео бичлэгүүдээс нэгийг үзүүлээд, видео бичлэгээс юу суралцсанаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Их Эзэний Сүнсийг урихуйц арга замаар харилцахад нь бусдад нөлөөлөхийн тулд хийж чадах зүйлээ тунгаан бодоход тэднийг урь. Жишээлбэл, тэд бүдүүлэг үг хэлдэг зуршилтай найздаа хэрхэн тусалж болох вэ? Эсвэл тэд бусдыг өргөж, урамшуулахын тулд цахим харилцааг хэрхэн ашиглаж болох вэ? Тэднийг эдгээрийн хариулыг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номын “Хэл яриа” хэсгээс уншиж байхдаа олж мэдэхэд урь. Тэднээс санал бодлоо хуваалцахыг хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг 1 Нифай 5:1–7-г уншаад, бидний хэлэх үгс бусдад хэрхэн нөлөөлж болдог талаар Лихай, Сариа хоёрын жишээнээс сурсан зүйлээ хуваалцахыг урь. Ахлагч В.Крэг Звикийн “Чи юу бодож байна?” хэлсэн үгээс энэ түүхийн талаар хэлсэн үгсийг нь уншихыг тэднээс хүс. Энэ хэлсэн үгээс тэд өөр ямар ойлголтыг олж авсан бэ? Гэр бүлийн гишүүд болон бусадтай харьцахдаа Лихайгийн жишээг дагаж болох арга замуудын талаар хуваалцахад тэднийг урамшуул.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаараа хуваалцахыг хүс. Цэвэр, урамшуулах үг яриаг хэрэглэх нь чухал болохыг тэд ойлгож мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлагатай уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Зөв зохистой үг хэллэг хэрэглэн ярих нь бусдыг хэрхэн урамшуулж, Ариун Сүнсний нөхөрлөлийг урьдаг талаар гэрчлэлээ хуваалцаж болох юм.
- Залуу эрэгтэйчүүдээс Аароны санваартны хувьд ариун нандин дуудлагыг нь илэрхийлэх үг хэллэг хэрэглэхийг хүсэж болох юм.

Сонгосон материалууд

“Хэл яриа” Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 20–21

Та нарын бусадтай хэрхэн харилцаж байгаа нь Бурханы хөвгүүд, охид болохыг тань харуулж байх ёстой. Цэвэр боловсон үг яриа нь эрүүл саруул оюун ухаантайн шинж юм. Сайн сайхан үг яриа нь бусдыг урамшуулан дэмжин, сайшаадаг бөгөөд Ариун Сүнснийг та нартай хамт байхад урьдаг. Бидний үг хэл, ажил үйлс маань итгэл, найдвар, энэрлээр дүүрэн байх ёстой.

Зөв боловсон хэл яриатай найз нөхдийг сонгож нөхөрлө. Өөрсдийн үлгэр жишээгээр хэл яриагаа хөгжүүлэхэд нь бусдад тусал. Эргэн тойронд чинь байгаа хүмүүс зохисгүй хэл яриа хэрэглэвэл эелдгээр холдох юмуу эсвэл ярианы сэдвийг өөрчлөх хүсэлтэй бай.

Бусдын талаар найрсаг, өөдрөг зүйлсийг ярь. Тоглоом шоглоомоор ч гэсэн битгий бусдыг дорд үзэж доромжил. Аливаа хов живээс холуур байж, уур уцаартай ярихаас зайлсхий. Ямар нэгэн хатуу эсвэл бусдыг гомдоох үг хэлмээр санагдвал бүү хэл.

Бурхан болон Есүс Христийн нэрийг үргэлж хүндэтгэл, бишрэлтэйгээр хэрэглэ. Бурханы нэрийг буруугаар хэрэглэх нь нүгэл. Та нар залбирахдаа Тэнгэр дэх Эцэгтэйгээ хүндэтгэл бишрэлтэйгээр ярь. Аврагч залбирахдаа хүндэтгэлийн үг хэллэгийг ашигладаг байсан (Матай 6:9–12 -ыг үзнэ үү). Гутаан доромжилсон, бүдүүлэг, балмад хэл яриа, дохио зангаа бүү ашигла. Мөн ёс суртахуунгүй тоглоом шоглоом болон үйлдлүүд бүү хий. Эдгээр нь Бурхан болон бусад хүмүүсийг гомдоосон хэрэг юм.

Гар утсаар мессеж бичих болон интернетээр бусадтай харилцах зэрэг харилцааны бүх хэлбэрийг ашиглахдаа хэл ярианы эдгээр жишгийг үргэлж дагахаа санаж бай.

Хэрэв та нар эдгээр жишгийг дагадаггүй, хараал хэлж, хов жив хөөцөлдөх юмуу уур уцаартайгаар ярьдаг бол үүнийгээ орхиж чадна. Тусламж гуйн залбир. Зөв зохистой үг хэл ашиглах хүслээ дэмжихийг гэр бүл, найз нөхдөөсөө хүс.



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

Би порнографыг хэрхэн эсэргүүцэж чадах вэ?

“Порнограф нь бохир заваан байдлаараа аймшигт усны эргүүлэг мэт дэлхийг хамарч байна. Энэ бол хор. Түүнийг бүү үз, бүү унш. Хэрэв та нар үүнийг хийх аваас энэ нь та нарыг устгах болно. Энэ нь та нарыг өөрийгөө хүндлэхгүй байхад хүргэнэ. Энэ нь та нарын амьдралын гоо сайхныг мэдрэх мэдрэмжийг алдагдуулах болно. Энэ нь та нарыг хилэнцэт бодол, магадгүй бүр хилэнцэт үйлдлийн намаг руу татан живүүлэх болно. Үүнээс хол бай. Бохир өвчнөөс зайлсхийхийн адил өөрсдөдөө бүү ойртуул, учир нь энэ нь бас үхлийн аюултай (Гордон Б.Хинкли, “Some Thoughts on Temples, Retention of Converts, and Missionary Service” *Ensign*, 1997 оны 11 сар, 51). Бид “Бурханы бүрэн хуяг дуулгыг өмссөнөөр” (Ефес 6:11–17-г үзнэ үү) мөн Их Эзэний хүч чадал дээр тулгуурласнаар өөрсдийгөө ариун журмын эсрэг дайрах дайсны дайралтаас хамгаалж, бодол санаа, үйл хөдлөлөө цэвэр ариун байлгаж чадна.

Та нар порнографт уруу татагдахгүйн тулд амьдралаа ямар сайн, өөдрөг зүйлсээр дүүргэсэн бэ? Порнографт уруу татагдахгүй байснаар санваартны хувьд болон нөхөр хүний хувьд мөн эцэг хүний хувьд ямар адислал авчирсан бэ?

Залуу эрэгтэйчүүд ямар замуудаар порнографыг олж мэддэг вэ? Энэ нь тэдний санваарын хүчинд хэрхэн нөлөөлдөг вэ? Порнографт уруу татагдахгүй байхад туслах ямар сайн, өөдрөг зүйлсийг та санал болгож болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, суралцах материалыг залбирч судал. Та порнографыг эсэргүүцэхэд нь залуу эрэгтэйчүүдийг хэрхэн дэмжиж болох вэ?

Эхлэл 39:7-21; Ром 12:21; 2 Тимот 2:22; Алма 39:9; Моронай 10:30; С ба Г 27:15–18; 121:45–46 (Бид шунах уруу таталтаас даруй зайлсхийж, харин оронд нь өөрсдийн оюун санааг цэвэр ариун бодлоор дүүргэх ёстой)

Исаиа 1:18; Хиламан 12:23; С ба Г 58:42–43 (Хэрвээ бид наманчлах аваас өршөөгдөж чадна)

Матай 5:27–28; Ром 6:12; Алма 39:9; С ба Г 42:23 (Эмэгтэй хүний араас шунах нь ноцтой үр дагавартай нүгэл юм)

1 Нифай 17:3; Мозая 24:14; Алма 26:12 (Зарлигуудыг сахих бидний хичээл зүтгэлийг Бурхан хүчирхэгжүүлэх болно)

Жэффри Р.Холланд, “Бодгальд минь дайсанд өгөх зай үгүй,” *Ensign* эсвэл

2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 51 мөн “Алхам бүрээ хяна” видео бичлэгийг үзнэ үү.

Квинтин Л.Күк, “Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” *Ensign* эсвэл 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 5

Линда С.Рийвс, “Христэд төвлөрсөн гэр орон—порнографын эсрэг хамгаалалт,” *Ensign* эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 29

Бодол санааг тань ариун журам чимэн гоёг (2006)

“Порнограф,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 151–152

“Үзвэр үйлчилгээ ба мэдээллийн хэрэгсэл,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 11–13

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс нэг холбоо үгийг самбар дээр бичээд, нэг залуу эрэгтэйгээс энэ нь түүний хувьд ямар утга учиртай болохыг асуу.
- Цагаан даавуу (бээлий эсвэл гарын алчуур) мөн жижиг саванд шавар хийж авчир. Цагаан даавуугаа шаварт дүрэх юм бол юу болох талаар залуу эрэгтэйчүүдтэй ярилц. Шавар заваан болох уу эсвэл цагаан даавуу бохир болох уу? Бидний оюун ухаан болон сүнсэнд порнограф ямар нөлөө үзүүлдэг вэ? Энэ хичээлийн эхэнд байгаа ерөнхийлөгч Хинклигийн хэлсэн үгсийн талаар ярилц.

Хамтдаа суралц

Порнографын уруу таталтад хэрхэн орохгүй байхад суралцахад нь дараах үйл ажиллагаанууд залуу эрэгтэйчүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- “Дээш харах нь” видео бичлэгийг үзүүлэх үедээ Давид өөр сонголт хийж болох байсныг харуулж буй хэсэг гарах тутамд бичлэгийг түр зогсоо гэж хэлэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Энэ явдлын дараа Давид хаанд юу тохиолдсон бэ? (2 Самуел 11–12) Энэ нь түүний гэр бүлд хэрхэн нөлөөлсөн бэ? Порнографыг үзэх нь яагаад аюултай вэ? Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 39:7–21-ийг уншуулаад мөн адил төстэй нөхцөлд Иосеф хэрхэн хандсаныг анхаарахыг хүс. Давид хаан болон Иосефын үйлдлийн үр дүнг товчхон харьцуулж дүгнүүл. Порнографыг үзэх нь яагаад Бурханы эсрэг нүгэл вэ? Порнографас

Заахад туслах арга

“Таны гол санаа тавих зүйл бол бусдад сайн мэдээнээс суралцахад туслах явдал юм. Харин сэтгэл хөдөлгөм танилцуулга хийх нь таны зорилго биш. Үүнд суралцагчдын бие биедээ заах боломжууд багтдаг” (Teaching, No Greater Call [1999], 64).

зайлсхийхийн тулд ямар хамгаалалтыг залуу эрэгтэйчүүд эсвэл бусад хүн хэрэглэдэг вэ? Зохисгүй бодол санааг хөөн зайлуулахын тулд ямар сайн үйл ажиллагаа, бодол санаагаар орлуулж болох вэ?

- Порнограф нь яагаад бодгальд хөнөөлтэй гэж бодож байгааг нь залуу эрэгтэйчүүдээс асуу. Чуулгаараа хамтдаа Итгэлдээ үнэнч байх нь номоос *порнографын* талаар бичсэн хэсгийг унш. Догол мөр бүрийг дуусгасны дараа, өөр өөрсдийн уншсан зүйлийн ач холбогдлыг ярилцах цаг гаргаарай. (Жишээлбэл, залуу эрэгтэйчүүд порнографыг харж болох газрууд болон нөхцөл байдлын талаар тэдэнтэй ярилц. Порнографт уруу татагдахгүй байхын тулд тэд юу хийж болох вэ? Тэд порнографыг санамсаргүй үзэх юм бол юу хийхээр төлөвлөж болохыг тэднээс хүс.) Гурав дахь догол мөрийн дараа Цагаатгалын хүч чадлын талаар ярилцаж, бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч нь наманчлалын үйл явцад хэрхэн оролцдогийг ярилц. Хэрэв залуу эрэгтэйчүүд порнограф үздэг бол бишоптойгоо уулзахыг тэднээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг ирээдүйд 12 настай хүүтэйгээ порнографыг ямар хор хөнөөлтэй мөн үүнээс хэрхэн зайлсхийх талаар ярьж байгаагаар төсөөлөхийг хүс. Чуулгынхны нэг хэсэгт ахлагч Жэффри Р.Холландын “Бодгальд минь дайсанд өгөх зай үгүй!” хэлсэн үгээс, нөгөө хэсэгт Линда С.Рийвс эгчийн “Христэд төвлөрсөн гэр орон-порнографын эсрэг хамгаалалт”

хэлсэн үгээс түүнтэй хийж буй энэ ярилцлагад тус болох мэдээлэл хайж олох даалгавар өг. (Тэд энэ тоймд агуулагдсан видео бичлэгүүдээс нэгийг үзэж болно.) Тэднийг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Порнографыг үзэх эсэх талаар тэдний одоо хийх сонголт нь хожим нөхөр, аав болсных нь дараах ирээдүйн аз жаргалд хэрхэн нөлөөлөх вэ?

- Залуу эрэгтэйчүүдэд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын хэн нэг гишүүнд, порнографын талаар өсвөр үеийнхэнд одоо тулгарч байгаа бэрхшээлийн талаар хэлэх боломж гарч байна хэмээн төсөөлөн бодохыг тэднээс хүс. Тэд түүнд юу гэж хэлэх бол? Ахлагч Квинтин Л.Күкийн “Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” хэлсэн үгийн “Бэлгийн ёс суртахуунгүй харьцаа ба цэвэр бус бодол санаанууд” гэж эхэлсэн догол мөрөөс эхлээд 6 догол мөрийн хуулбарыг залуу эрэгтэй бүрд өг. Ахлагч Күк 15 настай хүүгээс юу сурсныг уншаад мөн хуваалцахыг чуулгын гишүүдийн нэг хэсгээс хүс, нөгөө хэсгээс нь ахлагч Күкийн өгсөн зөвлөгөөг олж хуваалцахыг хүс. Гэр орноо порнографтаас зайлсхийж “хоргодох газар” болгоход нь залуу эрэгтэйчүүд хэрхэн тусалж чадах вэ?

- Порнограф үздэг нэг найз байдаг гэж төсөөлөн бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд түүнд хандан юу гэж хэлэх байсан бэ? Залуу эрэгтэй бүрээс *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дээрх “Үзвэр үйлчилгээ ба мэдээллийн хэрэгсэл”-ийг эсвэл *Бодол санааг тань ариун журам чимэн гоёг*

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийнхөө дагагчдыг итгэлээр үйлдэж, Өөрийн заасан үнэний дагуу амьдрахад уриалдаг. Өөрийн бүх сургаалд Тэрээр дагалдагчдадаа бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Залуу эрэгтэйчүүдийг хийсэн гэрээнүүдээ ойлгож, бүхий л зүрх сэтгэлээрээ гэрээгээ даган амьдрахад нь та тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

ЗӨВЛӨХӨД ХАНДАХ ҮГС: Олон залуу эрэгтэй өөрсдөө эсвэл найз нөхөд, гэр бүлийн гишүүнээр дамжуулан порнографын нөлөөг мэдэрч байгаа. Чуулгын цуглаан дээр порнографын талаарх туршлагаас хуваалцах юм уу буруугаа хүлээх хэрэггүй. Энэ хичээлийг заах гэж байгаагаа эцэг эхэд нь мэдэгдэж мөн энэ ярилцлагыг гэр орондоо үргэлжлүүлэхийг тэднээс хүсэх талаар та бодож үзээрэй. Хэрвээ нэг залуу эрэгтэйд тусламж хэрэгтэй бол түүнийг эцэг эхтэйгээ эсвэл бишоп юм уу салбарын ерөнхийлөгчтэйгээ ярилцахыг хүс.

товхимлын “Нүглээ хаях хүч чадлыг олж авах нь” нэртэй хэсгийг уншихыг хүс. Залуу эрэгтэйчүүд найзтайгаа энэ хэсгээс юу хуваалцаж болох вэ? Порнографтаас салж чадахгүй байгаа хүнд өөр ямар судар тусалж болох вэ? (Жишээ нь, энэ тоймд зөвлөмж болгосон судруудыг үзнэ үү.)

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаараа хуваалцахыг хүс. Порнографын эсрэг хэрхэн сөрөн зогсож болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Зохисгүй зүйлсийг харахаас зайлсхийхийн тулд юу хийж байгаагаа хуваалцаж болно.
- Порнографтаас зайлсхийж, хол байхын тулд хувийн төлөвлөгөө гаргахыг чуулгын бусад гишүүнд уриалж болно.
- Хэрвээ чуулгын гишүүдээс порнограф үзэж байгаа хүн байгаа бол бишоп болон салбарын ерөнхийлөгчтэй уулзахад урьж болно.

Сонгосон материалууд

Квинтин Л.Кук “Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” *Ensign* эсвэл Лиахона 2012 оны 11-р сар, 6–9

Бэлгийн ёс суртахуунгүй харьцаа ба цэвэр бус бодол санаанууд нь Аврагчийн бий болгосон жишигтэй харшилдаг. [Алма 39-ийг үзнэ үү.] Бэлгийн ёс суртахуунгүй харьцаа нь бидний хамгийн том саад бэрхшээл байх болно гэдгийг энэ эрин үеийн эхлэлээс л бидэнд анхааруулсан. [Эзра Тафт Бэнсоны “Cleansing the Inner Vessel” хэлсэн үгийг үзнэ үү. *Ensign* 1986 оны 5-р сар, 4.)] Наманчлахгүй байх нь сүнслэг байдлын ган гачиг ба тууштай бус байдлын үндэс болдог. Кино, зурагт ба интернетээр ихэвчлэн хор хөнөөлтэй захиас болон дүрсүүдийг нэвтрүүлэн дамжуулж байна. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф бид хоёр саяхан Амазоны ширэнгэн ой дахь тосгонд очиж, жижигхэн энгийн урцанд хүртэл хиймэл дагуулын антен байхыг харлаа. Энэ алслагдсан газарт мэдээллийн хэрэгсэл ашиглаж байгаад бид баярлаж байлаа. Бид мөн дэлхий дээр бузар булай, ёс суртахуунгүй мөн бэлгийн дур хүслийг өрнүүлсэн дүрс бичлэг хүрээгүй газар гэж үгүйг анзаарсан юм. Энэ нь яагаад порнограф өнөөгийн гай гамшиг, аймшигт тахал болсны нэг шалтгаан юм.

Би саяхан 15 настай Аароны нэгэн санваартантай гайхалтай яриаг өрнүүлж билээ. Тэр надад интернет хэрэглэдэг залуучууд санамсаргүйгээр, хэрхэн маш хялбархнаар цэвэр бус тэр бүү хэл порнографын дүрс бичлэг үзэж болдгийг тайлбарласан. Тэр Сүмийн заадаг ихэнх зарчмуудыг гуйвуулж мөн тамхи татах, мансууруулах бодис болон согтууруулах ундааг хэрэглэх нь эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг сүйтгэх нөлөөтэйг нийгэмд тодорхой түвшинд ойлгосон байгааг онцлон хэлсэн. Гэвч порнограф эсвэл ёс суртахуунгүй байдлын талаар ямар нэгэн анхааруулга байхгүй байгааг тэр мөн анзаарсан гэдгээ надад хэлсэн.

Хайрт ах эгч нар минь, энэ залуугийн дүгнэлт зөв юм шүү. Хариулт нь юу вэ? Олон жилийн турш бошиглогчид ба төлөөлөгчид гэр орондоо шашны зан үйлийг сахих нь ач холбогдолтой гэдгийг заасаар ирсэн.

Сүмийн цуглаанууд болон хөтөлбөрүүдэд гэр бүлээрээ тогтмол, идэвхтэй оролцох нь маш их ач холбогдолтой ч хүүхдүүддээ ёс суртахуунтай, өв тэгш амьдрах мөн Их Эзэний өмнө үнэнч шударга алхахыг заах нандин үүрэг хариуцлагаа гүйцэлдүүлэхэд хангалттай биш болоод удаж байна. Ерөнхийлөгч Монсоны энэ өглөөний мэдэгдлээс харахад нинжин сэтгэл, уучлал, үнэн ба зөв шударга байдлыг орон гэртээ итгэлтэйгээр төлөвшүүлдэг байх нь маш чухал байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ үзэж сонсдог интернет, зурагт, кино болон дуу хөгжмийг хянах буюу тохиргоо хийх зоригтой байх хэрэгтэй. Эцэг эхчүүд үнэнийг хамгаалж, хүчирхэг гэрчлэлээ хуваалцан үгүй гэж хэлэх зоригтой байх ёстой. Хүүхдүүд тань та нарыг Аврагчид итгэх итгэлтэй, Тэнгэрлэг Эцэгээ хайрладаг мөн Сүмийн удирдагчдыг дэмждэг гэдгийг тань мэддэг байх хэрэгтэй. Гэр оронд тань сүнслэг боловсрол олгогддог байх ёстой. Энэ ерөнхий чуулганаас хүн бүр өнөөгийн ёс суртахууны асуудлуудын талаар гэр бүлээрээ хэлэлцэх ёстой гэдгээ ухамсарлан гарна гэдэгт би итгэж байна. Бишоп, санваартан ба туслах бүлгийн удирдагчид гэр бүлүүдийг дэмжиж, гишүүдийн гэр оронд сүнслэг зарчмууд заагдаж байгаа эсэхэд анхаарах шаардлагатай. Гэрийн болон айлчлагч багш нар эцэг эхчүүдэд ялангуяа хүүхэдтэй ганц бие эцэг, эхчүүдэд туслах ёстой.

Миний дээр дурдсан хөвгүүн порнограф ба цэвэр бус бодол санаануудын эсрэг хамгаалах сургалтыг хэзээ зааж эхлэх ёстойг Төлөөлөгчид мэддэг эсэхийг чухалчлан асуусан юм. Зарим нэг газруудад бүр Хүүхдийн хэсэгт энэ тухай зааж эхлэх нь зүйтэй гэдгийг ч тэр онцлон хэлсэн.

Сонгосон материалууд

Бага наснаасаа ёс суртахуунгүй дүрс бичлэгийг үзсэн залуус номлолын үйлчлэл болон нандин гэрээнүүдийг хийхэд өөрсдийгөө аль хэдийнээ зохисгүй болсон гэж эмээдэг. Үүний үр дүнд тэдний итгэл маш их сулардаг. Залуучууд аа, наманчлалаар дамжуулан тэнгэрийн

бүх адислалыг хүлээн авч чадна гэдгийг Алма заасан. [Алма 13:27–30; 41:11–15-ыг үзнэ үү.] Аврагчийн Цагаатгалын утга учир үүнд л оршдог юм. Эцэг эх эсвэл итгэдэг зөвлөгч болон бишоптойгоо зөвлөлдөн, тэдэнтэй ярилцаарай.



Бид яагаад мацаг барьдаг вэ?

Мацаг барих гэдэг нь тодорхой хугацааны туршид сайн дураараа хоол идэхгүй, юм уухгүй байхыг хэлдэг. Чин сэтгэлээсээ залбирч мацаг барих нь таныг болон бусдыг Бурханы адислалуудыг хүлээн авахад бэлтгэхэд тусалж чаддаг. Түүнчлэн хэрэгцээтэй хүмүүст туслахын тулд мацаг барилтын өгөөмөр өргөл өгөх нь мацаг барилтанд багтдаг. Аароны санваартнуудаас мацгийн өргөлийг цуглуулахад нь бишопт туслахыг хүсч болох юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Мацаг барих талаар болон үүнээс ирэх адислалуудыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд ямар судар, материалууд туслах вэ?

Естер 4:10–17; Матай 4:1–11; С ба Г 59:12–14 (Мацаг барих нь сүнслэг хүч чадлын эх үүсвэр юм)

Исаиа 58:3–12; Матай 6:16–18 (Зөв зохистой мацаг барих тухай болон үүнд мацгийн өргөл багтдаг болохыг Их Эзэн тайлбарласан)

Матай 17:14–21 (Залбирч, мацаг барих нь эдгээх илүү их хүч чадлыг өгдөг хэмээн Есүс дагалдагчдадаа хэлсэн)

Мозая 27:18–24; Алма 6:6 (Мацаг барих нь бусдыг адислахад тусална)

Алма 5:45–46; 17:1–3, 9; Хиламан 3:35 (Мацаг барих нь гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд тусалдаг)

Хэнри Б.Айринг, “‘Үүний тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу?’” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 3

Л.Том Пэрри, “Та юуг эрэлхийлнэ вэ?” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 84-87

Дийн М.Дэйвийс, “Мацгийн хууль: ядуус хийгээд гачигдагсдыг халамжлах хувь хүний үүрэг хариуцлага,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 63

“Мацаг барих болон мацгийн өргөл,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 120-123

Та ямар шалтгаанаар мацаг барьж байсан бэ? Мацаг барьсны үр дүн нь юу байсан бэ? Та мацаг барихыг утга учиртай болгохын тулд юу хийдэг вэ?

Мацаг барихын зарчмуудыг ойлгох нь залуу эрэгтэйчүүдэд яагаад чухал вэ? Мацаг барьснаар ирэх бүрэн дүүрэн адислалыг эдлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд тулгардаг хамгийн том саад бэрхшээл юу вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдийг өнгөрсөн долоо хоногийн чуулгын цуглаанаас санаж байгаа судраа хуваалцахад урь.
- Өөр сүсэг бишрэлтэй нэг найз нь мацаг барина гэдэг нь ямар учиртай болохыг мөн яагаад тэд мацаг барьдаг болохыг мэдэхийг хүсч байна хэмээн төсөөлөн бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд хэрхэн мацаг барилтын зарчмын талаар найздаа тайлбарлах вэ? Мацаг барих болон зүгээр л өлсөх хоёрын хоорондын ялгааны талаар ярилц.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь мацаг барихын утга учрыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Залуу эрэгтэйчүүдийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Үүний тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу?” хэлсэн үгийг бүлгээрээ унших эсвэл видео бичлэг үзэхэд урь Тэднийг хэсэг бүрийг уншиж эсвэл үзэж байхдаа “Мацаг барих нь ямар утга учиртай вэ?”, “Мацаг барихын зорилго юу вэ?”, “Мацаг барьснаар ямар ямар адислал ирдэг вэ?” гэх мэт асуултуудын хариултыг олж мэдэхийг хүс. Залуу эрэгтэйчүүдийг мацаг барьснаараа амьдрал нь хэрхэн адислагдсаныг болон илүү сайн мацаг барихын тулд юу хийх талаар хуваалцахад урь.
- Цаасан дээр гурван багана бүхий хүснэгт зурж, багануудыг “Бид юу хийх ёстой вэ?” “Бид юу хийхээс татгалзах ёстой вэ?” болон “Бурхан ямар адислалуудыг амладаг вэ?” гэж гарчиглахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Исаиа 58:3–12-оос мацаг барих талаар олж мэдсэн хариултаа бичихэд тэднийг урь. (Хэрэв шаардлагатай бол, мацгийн өргөл нь бидний “өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваах” нэг арга бөгөөд залуу эрэгтэйчүүд мацгийн өргөлийг өгч болно гэдгийг тайлбарлаж өгөөрэй.) Их Эзэний арга замаар мацаг барьснаар ирсэн адислалуудаа болон хариултаа хуваалцахад тэднийг уриал.

Заахад туслах арга

“Аль нэг асуултад ... хэрхэн хариулахаа мэдэхгүй үе танд тохиолдож болно. Ийм үед зүгээр л мэдэхгүй гэдгээ мөн хариултыг олохын тулд хичээх болно гэдгээ хэлж болно. Эсвэл асуултын хариултыг олоход суралцагчдыг урьж, олж мэдсэн зүйлээ дараагийн хичээл дээр илтгэхэд тэдэнд цаг гарган өгч болно” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

- Хэрвээ танай тойргийн залуу эрэгтэйчүүд бишоптоо мацгийн өргөлийг цуглуулахад тусалдаг бол (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*, 26-г үзнэ үү) хэрхэн энэхүү үүрэг хариуцлагаа Бурханы таашаалд нийцүүлэн гүйцэтгэх тухай ярилцлагыг чуулгын ерөнхийлөгчөөр удирдуулан явуулах талаар бодно уу. Жишээлбэл, чуулгын ерөнхийлөгч мацгийн өргөлүүд юунд зориулагддаг болохыг болон чуулгын гишүүд энэ үүрэг хариуцлагыг гүйцэтгэхдээ хэрхэн биеэ авч явах ёстойг мөн бусдад үйлчилснээр ирэх адислалуудын талаар ярилцаж болох юм. Энэхүү ярилцлагын нэг хэсэг болгож, бишоп

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Мацаг барина гэдэг нь ямар утга учиртай болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлөнө. Тэрээр:

- Мацаг барих үедээ мэдэрсэн сэтгэгдлээ хуваалцаж болох юм.
- Мацгийн өргөл өгөхөд залуу эрэгтэйчүүдийг урьж болох юм.
- Өнөөдөр сурсан зүйлээ дараа нь мацаг барихдаа хэрэгжүүлэхийг чуулгын гишүүдээс хүсч болно.

Дийн М.Дэйвийсийн “Мацгийн хууль: Ядуус хийгээд гачигдагсдыг халамжлах хувь хүний үүрэг хариуцлага” хэлсэн үгээс Аароны санваартнуудад өгсөн зөвлөгөөг унших талаар бодоорой. (*Ensign* эсвэл *2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 63-ыг үзнэ үү). Бишопын зөвлөлийн нэг гишүүнийг мацгийн өргөл нь хэрхэн тусламж хэрэгтэй хүмүүст болон ядууст туслахад зарцуулагддаг талаар тайлбарлахад урь. Мацгийн өргөлийг цуглуулах санваарын үүрэг хариуцлагын талаар Хүүхдийн хэсгийн ангид чуулгын гишүүдээр заалгах тухай бодож үзээрэй.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр ганцаар залбирч, мацаг барин, заахад Өөрийгөө бэлтгэдэг байв. Та хэрхэн залуу эрэгтэйчүүдэд мацаг барих талаар заахын тулд өөрийгөө бэлтгэж болох вэ?

БАГШИД ХАНДАХ ҮГС: Эрүүл мэндийн байдлаас хамаараад, зарим залуу эрэгтэй мацаг барихгүй байж болно. Мацаг барснаас ирэх адислалуудыг хүлээж авах өөр арга замууд байж болохыг санал болго (жишээлбэл, мацгийн өргөлийг өгөөмрөөр өгч болно)



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

Бидэнд яагаад хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгал хэмээн тушаасан бэ?

Их Эзэн хүндэтгэлийн өдрийг бидний ашиг тусын тулд өгсөн ба энэ өдрийг ариунаар хадгалахыг тушаасан. Хүндэтгэлийн өдрийг сахих нь биднийг гэр бүлд маань болон Их Эзэнд илүү ойртуулдаг. Энэ нь бидэнд аливаа зүйлсийг мөнхийн талаас харахад тусалж, сүнслэг хүч чадлыг өгөх болно. Мөн хүндэтгэлийн өдөр нь бидэнд биеийн хөдөлмөрөөсөө амарч, Их Эзэнийг шүтэн бишрэх боломжийг олгодог.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон суралцах материалуудыг залбирч судлан, тэдэнд хүндэтгэлийн өдрийн талаар заахад хамгийн тохиромжтойг нь сонго.

Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалснаар та ямар адислалуудыг хүртдэг вэ? Хүндэтгэлийн өдөр юу хийвэл зохистой эсвэл зохисгүйг та хэрхэн мэддэг вэ?

Бидэнд хүндэтгэлийн өдөр өгөгдсөн шалтгааныг залуу эрэгтэйчүүд ойлгох нь яагаад чухал вэ? Хүндэтгэлийн өдрийг сахих хүсэлтэй болоход нь та тэдэнд хэрхэн тусалж болох вэ? Хүндэтгэлийн өдөр ямар үйл ажиллагаануудыг хийх нь зохистой болохыг шийдэхэд та залуу эрэгтэйчүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Эхлэл 2:2 (Хүндэтгэлийн өдрийн үүсэл)

Египетээс гарсан нь 20:8–11 (Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахь)

Марк 2:27 (Хүндэтгэлийн өдөр нь хүмүүнд зориулагдсан юм)

С ба Г 59:9–13 (Хүндэтгэлийн өдрийг сахих нь биднийг бохирдсон дэлхийгээс хол байхад тусалдаг)

Рассэлл М.Нэлсон, “Хүндэтгэлийн өдөр нь баясгалант өдөр билээ,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 112

Томас С.Монсон, “Гурван сонголт,” *Ensign* эсвэл 2010 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 70

Кэвин С.Хамилтон, “Тууштай зууран барих нь,” *Ensign* эсвэл 2013 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 114

“Хүндэтгэлийн өдөр” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 217–219

“Хүндэтгэлийн өдөр баримтлах зүйл,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 30

Видео бичлэг: “Тэр өсвөр насандаа нинжин сэтгэлтэй байхад суралцсан”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс нэг зураг юм уу үзүүлэнг залуу эрэгтэйчүүдэд үзүүлж, өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлтэй нь ямар холбоотой болохыг тайлбарлахыг тэднээс хүс.
- Хүндэтгэлийн өдөрт тохирохгүй зүйлийг ням гарагт хийхийг хэн нэгэн найз нь хүсч байсан эсэхийг залуу эрэгтэйчүүдээс асуу. Хүндэтгэлийн өдрийг яагаад ариунаар хадгалдаг болох талаараа тэд найздаа хэрхэн тайлбарлаж өгсөн бэ? Энэ тоймын эхэнд байгаа догол мөрөөс, хүндэтгэлийн өдөр хэр чухал болохыг бусдад хэрхэн тайлбарлах бусад саналыг чуулгатай хуваалц.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь хүндэтгэлийн өдрийн зорилгыг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- “Хүндэтгэлийн өдөр нь баясгалант өдөр билээ” хэлсэн үгийг гурав эсвэл дөрвөн хэсэгт хуваа. Залуу эрэгтэйчүүдийг хэсгүүдийг бүлгээрээ эсвэл ганцаараа уншихад урь. Тэд Хүндэтгэлийн өдрийг хэрхэн баясгалант болгох талаар ямар зүйл олж мэдсэн бэ? Хүндэтгэлийн өдөр залуу эрэгтэйчүүдийн биеэ авч яваа байдал нь тэднийг баяр баясгалантай байлгаж байгаа эсэхийг тэд хэрхэн мэдэж болох вэ?
- Залуу эрэгтэйчүүдийг хоёр, хоёроор нь хуваа. Хос бүрээс нэг залуу эрэгтэйгээс С ба Г 59:9–15-ыг уншиж, хүндэтгэлийн өдөр биднээс юу хийхийг хүсдэгийг жагсаан бичихийг хүс. Нөгөө залуу эрэгтэйгээс 16–19-ийг судлан, хүндэтгэлийн

Заахад туслах арга

“Судруудаас заахдаа тодорхой нэг зүйлийг олж харахыг мөн олж сонсохыг суралцагчдаас хүсэх нь тустай байдаг” (Teaching, No Greater Call [1999], 55).

өдрүүдийг ариунаар хадгалснаар бидэнд ирэх амлагдсан адислалуудыг олж мэдэхийг хүс. Олж мэдсэн зүйлээ бие биетэйгээ хуваалцаж, хүндэтгэлийн өдрийг сахих нь яагаад чухал болох талаар хоорондоо ярилцахыг тэднээс хүс. Их Эзэн бидэнд яагаад хүндэтгэлийн өдрийг өгсөн талаар ярилцахыг чуулгаас хүс. Өөрсдийнх нь амьдралд хүндэтгэлийн өдрийг сахих талаарх Их Эзэний хүсэл биелэгдэж байгааг бататгахын тулд тэдний хийж болох зүйлийг залуу эрэгтэй бүрээс асуу.

- Хүндэтгэлийн өдрөөр ямар нэг үйл ажиллагаа хийхэд зохистой эсэхийг тэд хэрхэн шийдэхийг нь залуу эрэгтэйчүүдээс асуу. Сургаал ба Гэрээ 59:9–13 болон *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (30–31-р хуудсууд) номоос тэдэнд тусалж болох зарчмуудыг хайж олохыг мөн олж мэдсэн зүйлсээ самбар дээр бичихийг тэднээс хүс. Залуу эрэгтэй бүрээс ням гарагт хийдэг зүйлсийнхээ талаар бодож, тэдгээр нь энэхүү зарчмуудтай тохирч байгаа эсэхийг өөрсдөө шийдэхийг хүс. Хүндэтгэлийн өдрөөр хийдэг зүйлсээ өөрчлөх хэрэгтэй гэж тэдэнд санагдах юм бол тодорхой зорилго тавихад залуу эрэгтэйчүүдийг уриал.

- Ахлагч Кэвин С.Хамилтоны “Тууштай зууран барих нь” хэлсэн үгээс түүний аавын тухай түүхийн

эхний хоёр догол мөрийг үзүүл эсвэл ярьж өг. Залуу эрэгтэйчүүд хүндэтгэлийн өдрийг сахихын ач холбогдлын талаар энэ түүхээс юу сурсан бэ? “Бидний хүн нэг бүр олон сонголт хийх хэрэгтэй болдог” гэсэн өгүүлбэрээр эхэлсэн ахлагч Хамилтоны хэлсэн үг бүхий догол мөрийн хуулбарыг залуу эрэгтэйчүүдэд өг. Уг догол мөрийг уншаад хоёр, хоёроороо хамтран ажиллаж, хүндэтгэлийн өдрийн “сайн,” “илүү сайн,” “хамгийн сайн” үйл ажиллагаануудын жагсаалт хийхийг тэднээс хүс. Жагсаалтаа ангийнхантай хуваалцахад тэднийг урь.

- “Хүндэтгэлийн өдөр” хэсгийг *Итгэлдээ үнэнч байх нь* номоос уншихдаа ням гарагт хийхэд зохистой үйл ажиллагаануудын жишээг олж сонсохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ням гарагт хийж болох үйл ажиллагааны талаарх дэлхийнхний санаа бодол биднийг хийгээсэй хэмээн Их Эзэний хүсдэг зүйлсээс юугаараа ялгаатай вэ? Зарим үйл ажиллагаанууд нь хүндэтгэлийн өдрийн сүнсэнд хэрхэн нөлөөлж болох талаар бодохыг тэднээс хүс. Тэдний хийж байгаа зүйлс хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад тохирч байгаа эсэхийг тэд хэрхэн мэдэх вэ? Хийж байгаа зүйл нь хүндэтгэлийн өдөрт тохирч байна гэж хэзээ тэдэнд санагдаж байсан бэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Хүндэтгэлийн өдрийн зорилгыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлөнө. Тэрээр:

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалах нь хэр чухал болох талаар гэрчлэлээ хуваалцаж мөн үүний дагуу амьдарснаар амьдрал нь илүү сайхан байгааг тайлбарлаж болох юм.
- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих сайн жишээг үзүүлснээр эргэн тойрныхоо хүмүүс мөн гэр бүлээ хүчирхэгжүүлэхийг чуулгын гишүүдээс хүсч болох юм.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийнхөө дагалдагчдыг итгэлээр үйлдэж мөн Түүний заасан үнэний дагуу амьдрахад уриалсан. Өөрийн дагалдагчдыг бүхий л зүрх сэтгэлээрээ сайн мэдээг дагахад нь туслахад Тэр анхаардаг байсан. Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалснаар ирэх адислалын талаар гэрчилж мөн хүндэтгэлийн өдрийг итгэлээр сахин, өөрсдөө сурч авахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

Сонгосон материалууд

Томас С.Монсоны “Гурван сонголт” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2010 оны 11-р сар, 67–70

Бага насандаа амьдралынхаа зорилгыг тууштайгаар тавьсан нэг хүний жишээг би та нартай хуваалцмаар байна. Би Харвардын Бизнесийн Их Сургуулийн бизнесийн удирдлагын профессор, сүмийн гишүүн Клэйтон М.Кристэнсэний талаар яримаар байна.

Кристэнсэн ах 16 настай байхдаа гаргасан шийдвэрүүдийн нэг нь ням гарагт спортоор хичээллэхгүй байх шийдвэр байсан юм. Олон жилийн дараа тэр Английн Оксфордын Их Сургуульд элсэж, сургуулийнхаа сагсан бөмбөгийн багийн төвийн тоглогчоор тоглох болжээ. Тэр жил тэдний баг Их Британы их сургуулиудын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд нэг ч хожигдолгүй тоглож байв.

Тэд тэмцээнүүдэд өрсөлдөгч нараа хялбархан буулгаж авсаар шөвгийн дөрөвт тунаж үлджээ. Тэр үед Кристэнсэн ах сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн нь ням гарагт болохоор төлөвлөгдсөнийг хараад ихэд сандарчээ. Тэр мөн түүний баг нь энэ амжилтад хүрэхийн тулд маш шаргуу хөдөлмөрлөсөн бөгөөд тэр өөрөө гарааны тавын төвийн тоглогч нь байлаа. Тэрээр энэ асуудлаа дасгалжуулагчдаа хэлэв. Дасгалжуулагч нь огтхон ч авч хэлэлцэлгүй, Кристэнсэн ахыг тоглох хэрэгтэй хэмээн хэлжээ.

Гэхдээ аваргын төлөөх тоглолтын өмнө хагас шигшээ тоглолт бас байлаа. Харамсалтай нь тэр тоглолтонд орлон тоглогч нь мөрөө мулталсан тул Кристэнсэн ахын аваргын төлөөх тоглолтод

оролцох шаардлага улам нэмэгдэв. Тэр зочид буудлынхаа өрөөнд очоод, өвдөг сөгдөн суугаад ганцхан энэ удаа ням гарагт сагсан бөмбөг тоглож болох уу? хэмээн Тэнгэрлэг Эцэгээсээ асуужээ. Тэрээр хэлэхдээ: залбирлаа дуусгахаас өмнө би хариултаа хүлээн авсан бөгөөд энэ нь: “Клэйтон чи үүнийг надаас юунд асууна вэ? Чи хариултыг нь өөрөө мэднэ шүү дээ” гэсэн байв.

Тэр үүний дараа дасгалжуулагч дээрээ очоод аваргын төлөөх тоглолтод оролцож чадахгүйгээ хэлээд хүлцэл өчсөн юм. Тэгээд тэр ням гарагийн цуглаанд очиж харин баг нь түүнгүйгээр тоглосон. Тэр тэдний амжилтын төлөө залбирч, баг нь хожсон билээ.

Энэхүү хэцүү бөгөөд чухал сонголтыг гуч гаруй жилийн өмнө хийсэн. Кристэнсэн ах хэлэхдээ цаг хугацаа өнгөрөн одсон ч эргэн харахад энэ нь түүний амьдралдаа хийсэн хамгийн чухал шийдвэрүүдийн нэг нь байсан юм гэжээ. “Ер нь хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих нь зөв, гэхдээ энэ онцгой нөхцөл байдлаас болж зөвхөн энэ удаа зөрчих нь зүгээр байх” гэж өөртөө хэлэхэд амархан л байсан байх. Гэвч тэрээр хэлэхдээ: “Амьдралынх нь турш үүнтэй адил тушаалыг зөрчихөөр нөхцөл байдлууд зогсолтгүй урган гарч ирж байсан бөгөөд хэрвээ тэр удаад зөрчсөн бол дараа дараагийн удаад зөрчих нь улам хялбар болох байсан” гэжээ. Энэ үйл явдлаас тэрээр зарлигуудыг зуун хувь дагах нь ерэн найман хувь дагахаас илүү амар байдаг гэдгийг сурчээ. [[Клэйтон М.Кристэнсэн, “Миний талархаж явдаг шийдвэрүүд”-ээс үз (Бригам Янгийн Их Сургууль–Айдахо онцгой цугларалт, 2004 оны 6-р сарын 8), www.byui.edu/presentations.]

Сонгосон материалууд

Кэвин С. Хамилтоны “Тууштай зууран барих нь” хэлсэн үгээс эш татав, *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар

Аав маань түүний гэр бүл—эцэг, эх, 4 хүүхдийн— хамт сүмээ орхиод ихэнх нь энэ амьдралд дахин хэзээ ч эргэж ирэхгүйгээр холдон одсон тэр өдрийг, бүр яг цагийг нь ч санадаг байсан. Түүнийг 13 настай дикон байхад тухайн үед Ням гарагийн анги өглөө эхэлж, ариун ёслолын цуглаан нь үдээс хойш болдог байжээ. Хаврын нэгэн сайхан өдөр ням гарагийн өглөөний цуглаанаасаа гэртээ ирээд гэр бүлээрээ хамтдаа үдийн хоолоо идэж байх үеэр ээж нь “Хонгор минь, үдээс хойш бүгдээрээ ариун ёслолын цуглаанд очих уу эсвэл гэр бүлээрээ хөдөө салхинд гарах уу?” гэж ааваас нь энгийнээр асуужээ.

Аав маань өсвөр насны ах, эгч нартайгаа ариун ёслолд маш анхааралтай суудаг байсан бөгөөд

өөр тийшээ явна гэсэн санаа хэзээ ч төрж байгаагүй аж. Тэр ням гарагийн үдээс хойших аялал нь гэр бүлийн зугаатай үйл ажиллагаа байсан байж болох ч тэр санаандгүй шийдвэр нь эцэстээ түүний гэр бүлийг хамгаалалт, аюулгүй байдал, адислалуудынх нь хамт сүмээс холдуулж, өөр зам руу хөтөлсөн байна. . . .

Бид хүндэтгэлийн өдрийг хэрхэн ариунаар нь сахих талаар олон сонголттой байдаг. Бидэнд үргэлж “сайн” гэж хэлж болох зүйлс гардаг ч илүү сайн сонголт болох сүмийн цуглаандаа явахын тулд үүнийг золиосолж болно. Үнэндээ энэ нь дайсан “[бидний] бодгалийг хуурч, мөн [биднийг болгоомжтойгоор] там уруу удирддаг” [2 Нифай 28:21] аргуудын нэг юм. Тэрээр “сайн” зүйлсээр “илүү сайн” эсвэл бүр “хамгийн сайн” зүйлсийг орлуулахдаа ашигладаг [Даллин Х. Өүкс, “Сайн, илүү сайн, хамгийн сайн” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 11-р сар, 104–8].



Бид яагаад аравны нэгийг төлдөг вэ?

Аравны нэг төлнө гэдэг нь ариун нандин эрх юм. Бид аравны нэг төлөх үедээ Бурханы бидэнд өгсөн бүхний төлөө талархлаа үзүүлдэг бөгөөд өөрсдийн хүлээж авсны нэг хэсгийг Түүнд буцаан өгдөг. Аравны нэг нь ариун сүм, цуглааны байр барих, судруудыг орчуулж, хэвлэх, номлолын ажил хийх болон гэр бүлийн түүхийн ажлыг гүйцэтгэх, түүнчлэн энэ дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах өөр бусад олон ажилд ашиглагддаг юм.

Аравны нэгийг төлснөөр хүлээн авсан сүнслэг ба материаллаг адислалуудынхаа талаар бод. Залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж болох ямар туршлагууд танд байна вэ?

Аравны нэгийг төлөх нь залуу эрэгтэйчүүдийн хувьд яагаад чухал вэ? Аравны нэгийн хуулийг сахих нь чухал болохыг та тэдэнд хэрхэн зааж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бид яагаад аравны нэгийг төлдөг болохыг залуу эрэгтэйчүүд ойлгоход нь ямар судар болон материалууд туслах вэ?

Малахи 3:8–10; 3 Нифай 24:8–10; С ба Г 64:23 (Аравны нэгийн амлагдсан адислалууд)

С ба Г 119 (Аравны нэгийн хууль илчлэгдсэн нь)

Дэвид А. Бэднар, “Тэнгэрийн цонхнууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар

Хэнри Б. Айринг, “Аравны нэгийн адислалууд,” *Лиахона*, 2011 оны 6-р сар, 4–5

Карл Б. Пратт, “Их Эзэний хамгийн үнэ цэнэтэй адислалууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 101–3

“Аравны нэг,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 21–22

“Аравны нэг ба өргөлүүд,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 38–39

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлийн асуултыг самбар дээр бич мөн өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлээ ашиглан уг асуултанд хариулахыг залуу эрэгтэйчүүдийн нэгнээс хүс.
- Самбар дээр “Та яагаад аравны нэг төлдөг вэ?” гэж бич. Өөр шашин

шүтлэгтэй нэг найз нь өөрсдөөс нь энэ асуултыг асууж байгаагаар төсөөлөхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд юу гэж хариулах вэ? Аравны нэгийн өргөлтэй холбоотой туршлагыг тэр өөрөө эсвэл гэр бүл нь туулсан бол түүнийгээ хуваалцахыг тэдэнд уриал.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь залуу эрэгтэйчүүдэд аравны нэгийн хуулийг ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Малахи 3:8–10 болон С ба Г 64:23-р шүлгүүдийг судлахыг мөн аравны нэгийг төлөгчдөд амласан амлалтуудыг хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. С ба Г 119-ийг уншсанаар Их Эзэн биднээс аравны нэгийн өргөлд юу төлөөсэй хэмээн хүсдэгийг олж мэдэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс (“ашиг” гэж бидний жилийн “орлогыг” хэлж байгаа болохыг тайлбарлаж өг). Аравны нэгийн өргөлийн хуудсыг тараагаад залуу эрэгтэйчүүдээр нэг нэгэндээ тэдгээрийг хэрхэн ашиглахыг тайлбарлуул. Аравны нэгийг төлснөөр та хэрхэн адислагдсан тухайгаа хуваалц.
- Самбар дээр гурван багана зураад дараах гарчгуудыг бич: *Адислалууд, Энэхүү санг юунд зарцуулдаг вэ?* болон *Хандлага*. Чуулгыг жижиг

бүлгүүд болгон хуваагаад бүлэг бүрд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номын “Аравны нэг ба өргөлүүд” хэсгээс нэг, нэг сэдвийг судлуулахаар хуваарил. Өөрсдийн олж мэдсэн зүйлийг самбар дээр зохих баганад бичихийг тэднээс хүс. Аравны нэгийн хуулийн талаар гэрчлэлээ хуваалцахыг цөөн хэдэн залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Ахлагч Праттын “Их Эзэний хамгийн үнэ цэнэтэй адислалууд” хэлсэн үгээс өвөөгийнх нь түүхийг уншиж өгөх мөн үзүүлж эсвэл ярьж өгөөрэй. Уг хэлсэн үгийн хуулбарыг залуу эрэгтэй бүрд тарааж өгөөд тэднээс ахлагч Праттын өвөөгөөсөө сурсан зүйлсээс нэгийг олохыг мөн түүнийгээ чуулгатай хуваалцахыг хүс. Залуу эрэгтэйчүүдийг аравны нэгээ төлснөөр өөрсдийг нь болон

Заахад туслах арга

“Буруу хариултуудад хүндэтгэлтэйгээр мөн эелдгээр хариул. Уг хүн нь дахин оролцохдоо санаа зовохгүй байх байдлыг бий болго” (*Teaching, No Greater Call* [1999], 69).

Видео бичлэг: “Үйлдэхэд урих нь”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэж, тэднийг бэлтгэж, заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг тэдэнд оноосон. Залуу эрэгтэйчүүдэд итгэж байгаага та хэрхэн харуулж, бусдад заах боломжийг тэдэнд хэрхэн олгох вэ?

гэр бүлийг нь хэрхэн адисалсан тухай туршлагаасаа хуваалцахыг хүс (эсвэл хувийн туршлагаасаа хуваалц).

- Чуулгыг хоёр бүлэг болгон хуваа. Нэг бүлгээс Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Аравны нэгийн адислалууд” өгүүллийг, нөгөө бүлгээс ахлагч Дэвид А. Бэднарын “Тэнгэрийн хүчнүүд” хэлсэн үгийн 2–13-р догол мөрүүдийг уншихыг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаараа хуваалцахыг хүс. Аравны нэгийг яагаад төлдөг болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Аравны нэгийг төлөх нь яагаад амьдралынх нь чухал хэсэг болохыг хуваалцаж болох юм.
- Чуулгын гишүүдийг аравны нэгээ байнга төлдөг байхад уриалж болно.

Сонгосон материалууд

Дэвид А. Бэднарын “Тэнгэрийн цонхнууд” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Бэднар эгчийн ээж нь итгэлтэй бөгөөд сүнслэг гэрийн эзэгтэй юм. Тэрээр гэрлэлтийнхээ эхэн үеэс л гэр бүлийнхээ санхүүгийн тооцоог хийж иржээ. Олон жилийн турш тэрээр энгийн тооцооны дэвтрийг ашиглан, гэр бүлийнхээ орлого, зарлагыг тооцоолсоор ирсэн юм. Түүний энэ олон жилийн туршид цуглуулсан мэдээллүүд нь нарийн дэлгэрэнгүй бөгөөд тун их утга учиртай байв.

Бэднар эгчийг залуу байхад ээж нь гэр орондоо ариг гамтай, ухаалаг, хэрсүү амьдрах арга ухааныг зааж ойлгуулахдаа тооцооны дэвтэртээ бичиж тэмдэглэсэн мэдээллээ ашигладаг байжээ. Нэгэн өдөр тэр хоёр олон төрлийн зардлаа хамтдаа эргэн хянах явцад ээж нь нэг сонирхолтой загварыг олж харсан байна. Тэдний гэр бүлийн эмнэлэгт үзүүлж, эм тарианд зарцуулсан зардал бодож байснаас нь хамаагүй бага гардаг байжээ. Тэрээр энэ анзаарсан зүйлээ Есүс Христийн сайн мэдээтэй холбож, охиндоо хүчирхэг нэгэн үнэнийг заасан юм. Бид аравны нэгийн хуулиар амьдрах үед хэдийгээр бидний хүсэн хүлээж байгаатай адилгүй мөн амархан үл ойшоогдож болох ч чухал хийгээд чимээгүй адислалуудыг хүлээн авдаг ажээ. Тэдний гэр бүлд гэнэтийн эсвэл илт тодорхой ямар нэгэн орлого нэмэгдээгүй байв. Үүний оронд хайрт Тэнгэрлэг Эцэг маань ердийн мэт санагдах энгийн адислалуудаар адисалжээ. Хуучин Гэрээний бошиглогч Малахийн амласан тэнгэрийн цонхнуудаар дамжин ирдэг тусламжийн талаар ээжийнхээ заасан энэ чухал хичээлийг Бэднар эгч үргэлж санасаар ирсэн билээ (Малахи 3:10-ыг үзнэ үү).

Бид аравны нэгийн хуулийн тухай зааж мөн гэрчилж байхдаа үүнээс хүлээн авдаг гэнэтийн эсвэл агуу том, амархан олж харах боломжтой материаллаг адислалуудаа тодруулан ярьдаг. Иймэрхүү төрлийн адислалууд үнэхээр тохиодог. Гэхдээ энэ зарлигт дуулгавартай байснаар олж авдаг янз бүрийн адислалуудын зарим нь чухал хийгээд чимээгүй байдаг юм. Бид тэдгээр адислалуудыг сүнслэг байдлын хувьд соргог мэдрэмжтэй, ажигч байх үедээ л ялган таньж чаддаг (1 Коринт 2:14-ийг үзнэ үү).

Малахийн ашигласан тэнгэрийн “цонхны” дүрслэл бол хамгийн сургамжтай нь юм. Цонх нь барилга байгууламж дотор байгалийн гэрэл орох боломжийг олгодог. Үүнтэй адилаар, бид аравны нэгийн хуулийг хүндэтгэх аваас сүнслэг тусгал мөн ирээдүйн төлөв нь тэнгэрийн цонхоор бидний амьдралд асгаран ирэх болно.

Жишээ нь, бидний хүлээн авдаг чухал мөртлөө агуу адислалуудын нэг бол хүслээ хазаарлаж, байгаа зүйлдээ талархах хүчийг өгдөг сүнслэг бэлэг юм. Талархалтай хүн нь сэтгэл ханамжаар баян байдаг. Талархалгүй хүн сэтгэл дундуур байдлын төгсгөлгүй ядууралд зовдог (Лук 12:15-ыг үзнэ үү).

Бид сайн ажил хайж, үүнийхээ төлөө залбирч байж болох юм. Бидэнд бусад хүмүүс үл ойшоож болохуйц ажил эрхлэлтийн олон боломжийг олж харах илүү сүнслэг бэлгийг таних эсвэл бусад хүмүүс дуртайяа хийх ажлаас илүү өөрийн хүсэж болох албан тушаалын төлөө илүү хичээнгүй, урт хугацаанд зүтгэх тууштай байдлаар адислагдах зэрэг итгэлийн нүд, чих (Ифер 12:19-ийг үзнэ үү) хэрэгтэй байдаг. Бидэнд ажлын санал ирэхийг хүсэж эсвэл хүлээж байж болно, гэсэн ч хэн нэгэн эсвэл ямар нэг зүйл бидний нөхцөл байдлыг өөрчлөхийг хүлээж суухаас

Сонгосон материалууд

илүүтэйгээр өөрийн нөхцөл байдлаа өөрчлөх мөн үйлдэх илүү чадамж нь адислал болж, бидэнд тэнгэрийн цонхоор дамжин ирж байж болно.

Бид амьдралын хэрэгцээгээ илүү сайн хангахын тулд цалингаа нэмэгдүүлэхийг хүсэж, үүний төлөө ажиллаж болно. Өөрсдийн сүнслэг болон материаллаг чадамжийнхаа дагуу бид бага зүйлээр ихийг хийж чадахаа анзаарах (Лук 2:52-ыг үзнэ үү), нэн чухал хэрэгцээгээ эрэмбээр

нь жагсаах, чадвараа сайжруулах, одоо байгаа материаллаг зүйлсээ илүү сайн тооцоолох зэрэг итгэлийн нүд, чих бидэнд шаардлагатай. Магадгүй бид их хэмжээний цалин авахыг хүсэж эсвэл хүлээж байж болох юм. Гэвч хэн нэгэн эсвэл ямар нэг зүйл бидний нөхцөл байдлыг өөрчлөхийг хүлээж байхаас илүүтэйгээр, өөрсдийн нөхцөл байдлаа өөрчилж чадах илүү их чадвартай болох нь бидэнд тэнгэрийн цонхоор дамжин ирдэг адислал ч байж болно.



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

Шударга байх нь яагаад чухал вэ?

Шударга байна гэдэг нь ямар нэгэн байдлаар худлаа хэлэх, хулгай хийх, хууран мэхлэхгүй байна гэсэн үг юм. Бид шударга байснаар, Бурхан болон бусдад агуу их үйлчлэл үзүүлэгч байх зан төлөвийг эзэмшдэг. Бид амар тайван бодол санаа болон өөрийгөө хүндлэх байдлаар адислагдаж мөн Их Эзэн болон бусдын итгэлийг хүлээх болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба материалаудыг залбиралтайгаар судлаад, залуу эрэгтэйчүүдэд шударга байдлын талаар заахад хамгийн тохирох хэсгүүдийг сонго.

Дуулал 101:7 ; Сургаалт үгс 12:22; 2 Коринт 4:2; Ефес 4:29; Алма 27:27; Итгэлийн Тунхаг 1:13 (Бүх зүйлд шударга мөн зөв шулуун байх)

Үйлс 5:1–10 (Бид Их Эзэнд худлаа ярьж болохгүй)

2 Нифай 9:34; Алма 12:1–6 (Худал хэлэх нь ноцтой үр дагавартай нүгэл юм)

Иосеф Смиг— Түүх 1:21–25 (Иосеф мөрдлөг хавчлагатай тулгарах үедээ шударга байсан тухай)

Томас С.Монсон “Бэлтгэснээр адислалууд ирдэг” *Ensign* эсвэл *Лиахона* 2010 оны 5 сар, 64–67

Робэрт С.Гэй “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” *Ensign* эсвэл *Лиахона* 2012 оны 11-р сар, 34–36

Ричард С.Эджли, “Гурван алчуур ба 25 центний сонин ” *Ensign* эсвэл *Лиахона* 2006 оны 11-р сар, 72–74

“Үнэнч Шударга Байдал,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө*(2011), 19

“Шударга байдал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 223

Видео бичлэг: “Шударга байдал: Итгэсэн нь дээр”

Бүх зүйл дээр шударга хандана гэдэг нь юу гэсэн үг гэж та бодож байна вэ? Та яагаад шударга байх нь чухал гэж бодож байна вэ? Таны таньж мэддэг хэн нэгэн эсвэл та өөрөө, бусдын шударга эсвэл шударга бус шийдвэрийн нөлөөг хүртэж байсан уу?

Шударга байдлын ямар шалгуурууд залуу эрэгтэйчүүдийн амьдралд тулгарч байна вэ? Ямар ч үед шударга байснаар адислал ирэх болно гэдгийг ойлгоход та хэрхэн тэдэнд тусалж болох вэ? Шударга сонголтуудыг гаргах зоригтой байхад нь тэдэнд та хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлтэй холбоотой туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Шударга бус байдалд уруу татагдаж болох хэд хэдэн нөхцөл байдлыг жижиг цаасан дээр (нэрээ бичилгүйгээр) бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс (тэд санаа авч болохын тулд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номон дахь жишгүүдийг харж болно). Цааснуудыг цуглуулан, чуулгатай хэд хэдэн нөхцөл байдлыг хуваалц. Эдгээр нөхцөл байдалд тэд юу хийх вэ? Шударга эсвэл шударга бус байдлын үр дүн нь юу вэ?

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Та заадаг хүмүүсийн хээ асуулт, санал бодолд уриалгахан хариулах юм бол тэдэнд хичээл, ярилцлаганд оролцох өөрсдийн чадварын талаар илүү итгэлтэй болоход нь туслах болно. Жишээ нь та “Хариулсанд баярлалаа. Энэ бол чухал санаа байна”... гэх буюу “Энэ бол маш сайн жишээ”, “Өнөөдөр та нарын хэлсэн бүх зүйлд би баярлан талархаж байна” гэхчилэн хэлж болно (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Зөв шударга байх нь яагаад чухал болохыг чуулгын гишүүдэд ойлгуулахад дараах үйл ажиллагаанууд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг “Шударга байдал: Итгэсэн нь дээр” видео бичлэгийг үзэж эсвэл ахлагч Роберт С.Гэйн “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” хэлсэн үгээс киноны билет худалдан авч байгаа түүхийг уншихыг хүс. Шударга бус байдлын уруу таталтыг ялан дийлэхийн тулд одооноос бэлтгэж болох арга замуудаа бичихийг тэднээс хүс. Бодол санаагаа чуулгын бусад гишүүдтэй хуваалцахыг тэднээс хүс.
- Чуулгаараа хамтдаа “Үнэнч шударга байдал” бүлгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номоос унш. Зөв шударга байснаар ирэх адислалуудыг тодорхойлохыг залуу эрэгтэйчүүдээс хүсээд, тэдгээрийг самбар дээр жагсаан бич. Бусдын төлөө болон Их Эзэний төлөө сайн сайхныг үйлдэх чадварт нь зөв шударга байдал хэрхэн нөлөөлдөг вэ? Санваарыг атгагчийн хувьд, хүү, ах дүү, найз, удирдагч эсвэл ажилчны хувьд зөв шударга байх нь тэдэнд яагаад чухал вэ?
- Иосеф Смит —Түүх 1:21–25 хэсгийг чуулгаараа хамтдаа уншаад, энэ түүхээс шударга байдлын талаар юу сурсныг нь залуу эрэгтэйчүүдээс

асуу. Иосеф өөрийн туулсан туршлага мөн Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн өөрөөс нь хүссэн зүйлд үнэнч байснаас тэд хэрхэн адислагдсан бэ? Зөв шударга байх нь залуу эрэгтэйчүүдээс зоригтой байхыг шаардаж байсан удаа бий юу? Зөв шударга байсныхаа төлөө тэд хэрхэн адислагдсан бэ?

- Самбарын голоор босоо зураас зур. Нэг талд нь “Хэрвээ би шударга байх юм бол ...” гэж бичээд нөгөө талд нь “Хэрвээ би шударга бус байх юм бол ...” гэж бич. Итгэлдээ үнэнч байх нь авлагын “Шударга байдал” бүлгийг мөн ерөнхийлөгч Томас С.Монсоны “Бэлтгэснээр адислал ирдэг” хэлсэн үгээс шударга бус оюутны түүхийг залуу эрэгтэйчүүдээр уншуулаад дээрх өгүүлбэрүүдийг төгсгөж болох арга замуудыг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Шударга байх нь хэр чухал болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй чуулганыг өндөрлөнө. Тэрээр:

- Өнөөдөр хичээл дээр сурсан зүйлийнхээ талаар гэрчлэлээ хуваалцаж болох юм.
- Залуу эрэгтэй бүрийг бүх зүйл дээр шударга хандахыг уриалж болох юм.

хайхыг хүс. Өөр ямар санааг тэд нэмж болох вэ? Залуу эрэгтэйчүүд амьдралдаа эдгээр зүйлийг хэрхэн олж харснаа хуваалцахыг тэднээс хүс. Хүмүүс шударга бус байдлаа заримдаа хэрхэн зөвтгөдөг талаар хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс. Шударга байдлынхаа шалтгааныг тэд бусдад хэрхэн тайлбарладаг вэ?

- Энэ хичээлийн судрын хэсгүүдээс залуу эрэгтэй бүрд хуваарилж өгнө. Тэдэнд хуваарилагдсан шүлэгт шударга байдлын талаар юу гэж зааж байгааг нэгээс дөрвөн үгэнд багтаан бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс. Залуу эрэгтэйчүүдийг бичсэн зүйлсээ мөн шударга байдлын талаар сэтгэгдэл, туршлагаа хуваалцахыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч үлгэр жишээгээр дамжуулан заадаг байсан. Тэрээр тэдэнтэй хамт залбирснаар, хэрхэн залбирахыг тэдэнд заадаг байв. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шигээ бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр тэдэнд заасан. Өөрийн зааж байгаа аргаар сайн мэдээгээ заахыг Тэрээр тэдэнд заасан. Таны зааж байгаа зүйлс болон хэрхэн шударга байдлаар амьдарч байгааг залуу эрэгтэйчүүд хараад, хүчирхэгжих болно.

Сонгосон материалууд

Робэрт С.Гэй “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2012 оны 11-р сар, 34–36

Аврагч Өөрийн шавь нараас “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” хэмээн асуусан байдаг. [Матай 16:26.]

Энэ асуултыг аав маань олон жилийн өмнө надад анхааралтайгаар тунгаан бодохыг заасан юм. Бага байхад аав ээж маань надад гэрийн ажлыг даалгаж, хариуд нь надад багахан хэмжээний мөнгө өгдөг байлаа. Би долоо хоногт 50 цент гаруй мөнгө авдаг байсан бөгөөд тэрхүү мөнгөөрөө ихэнхдээ кино театрт кино үздэг байсан юм. Тэр үед 11 настай хүүхдийн тасалбар 25 цент байсан болохоор надад цаана нь 25 цент үлддэг байлаа. Би үлдсэн мөнгөөрөө нэг ширхэг нь 5 центийн үнэтэй 5 шоколад авдаг байсан. 5 шоколад бас кино! Үүнээс илүү сайхан юм гэж юу байхав.

Намайг 12 нас хүртэл бүх зүйл ийм сайхан хэвээрээ байлаа. Нэгэн өдөр би киноны тасалбар авахаар зогсож байхдаа 12 настай хүүхдийн тасалбар 35 цент болохыг анзаарлаа. Энэ нь хоёр шоколадны мөнгө хасагдана гэсэн үг байлаа. Би энэхүү золиослолыг хийхэд бэлэн биш байсан учраас өөртөө “Чи долоо хоногийн өмнөх шигээ л харагдана шүү дээ” гэж өөртөө шалтаг олсон юм. Би урагшилж, 25 центийн тасалбар өгөхийг хүслээ. Тасалбар зардаг хүн анзаарсангүй, би ч гурав биш харин урьдын адил таван шоколад худалдан авлаа.

Өөрийнхөө хийсэн зүйлд баяртай байсан болохоор би аавдаа өөрийнхөө том амжилтыг хэлэхээр гэр рүүгээ яарч билээ. Намайг бүх зүйлийн талаар нэг бүрчлэн хэлэхэд аав маань юу ч хэлээгүй юм. Намайг ярьж дууссаны дараа тэр над руу хараад “Хүү минь, чи өөрийнхөө амийг таван центийн зоосоор солих байсан уу?” гэж асуусан юм. Энэ нь надад хэзээ ч мартагдахааргүй сургамж болсон билээ.

Аравдугаар сар: Христтэй илүү адил болох нь

“Би бол зам, үнэн, амь мөн” хэмээн Есүс түүнд хэлсэн” (Иохан 14:6).

Энэхүү бүлгийн тоймууд нь Христийнхтэй адил зан чанаруудыг сурч мөн хөгжүүлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд туслах болно. “Би, эсвээс тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг төгс байгаасай хэмээнэ би” гэж Есүс Христ бид бүгдэд зарлигласан юм (3 Нифай 12:48-ыг үзнэ үү). Христийн зан чанаруудыг хөгжүүлэх нь Түүний ариун санваарыг эзэмшигчдийн хувьд үүргээ биелүүлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд туслах болно. Бэрхшээлт цаг үед тулгарах зовлонг туулж, бүрэн цагийн номлогчоор үйлчлэхээр бэлтгэж мөн ирээдүйд шударга гэр бүлийг өсгөж хүмүүжүүлэхэд нь эдгээр зан чанар хэрэг болох болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би бусдад хэрхэн үйлчлэх вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Би хэрхэн Христтэй илүү адил болох вэ?

Би Христийнхтэй адил хайрыг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

Би хэрхэн илүү тэвчээртэй байж сурах вэ?

Талархалтай байх нь яагаад чухал вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй холбон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан үйл ажиллагааны сайт танд туслах боломжтой юм. Эдгээр тоймд багтсан олон үйл ажиллагааг Мючелийн үйл ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу эрэгтэйчүүдийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг бататгахын тулд тохиромжтой үйл ажиллагаануудыг сонгон, төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй холбоотой:

“Зохистой амьдар” 16–17, 40–41, 64–65-р хуудас

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би бусдад хэрхэн үйлчлэх вэ?

Есүс Христ бусдыг хэрхэн хайрлаж мөн тэдэнд үйлчлэх төгс жишээг үзүүлсэн юм. Санваар атгагчдын хувьд бид бусдад үйлчлэх үүрэгтэй. Санваарын ёслолуудыг гүйцэтгэх, бусадтай сайн мэдээг хуваалцах, өдөр тутмын энгийн найрсаг үйлдлүүдийг гүйцэтгэх гэх мэт олон арга замаар бид Аврагчийн адил бусдад үйлчилж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Үйлчлэлийн талаар судар болон бусад материалаас суралцах үедээ Христийнхтэй адил үйлчлэлийг үзүүлэхэд залуу эрэгтэйчүүдийг урамшуулах зүйлсийг эрж хайгаарай.

Матай 25:31–46; Мозая 2:17 (Бид бусдад үйлчилж байхдаа Бурханд үйлчилж байдаг)

Иохан 13:34–35 (Аврагч биднийг хайрладаг шиг бид бусдыг хайрлах ёстой)

Иаков 1:27 (Эцэггүй болон бэлэвсэн хүмүүсийг эргэж тойрох нь цэвэр шүтлэг юм)

1 Нифай 2:16–18; 3:1–7, 28–31; 4:1–2; 17:7–19, 50–51; 18:1–4 (Даалгавар хүлээн авсан Нифай, Лемен, Лемүел нарын хандлага)

Мозая 18:8–10 (Бид тайтгарал хэрэгтэй хүмүүсийг тайтгаруулахад бэлэн байх ёстой)

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 26, 50, 74

Хэнри Б.Айринг, “Тэдний шархыг боо,” *Ensign* эсвэл 2013 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 69-72

“Үйлчлэл,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 32–33

Видео бичлэгүүд: “Тусламж хэрэгтэй тэдгээрийг аврах нь,” “Дэйтоны хөл,” “Хэрвээ бид өөрсдийгөө мартаж юм бол,” “When Ye Are in the Service—YM”

Бусдад үйлчилж байсан туршлагынхаа талаар бодоорой. Таны үйлчлэлийн үр дүн юу байсан бэ? Залуу эрэгтэйчүүдэд үйлчлэл чухал гэдгийг мэдрэхэд туслах ямар туршлагыг та хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдийг бусдад үйлчилж байхыг та хэзээ харж байсан бэ? Залуу эрэгтэйчүүд ямар туршлагуудыг бие биедээ хуваалцаж чадах вэ? Христтэй адил үйлчлэлийг хэрхэн үзүүлэхийг сурах нь яагаад чухал вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлийн гарчгийг самбарт бичээд уг хичээлээс сурсан эсвэл хэрэгжүүлсэн зүйлээ хурдхан бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс.
- Бусдад үйлчилсэн саяхны туршлагаасаа хуваалцахад (боломжтой бол Бурханы өмнө хүлээсэн үүргийнхээ төлөвлөгөөний нэг хэсэг болгон, хувиараа эсвэл чуулгаараа биелүүлсэн үйлчлэлийн төслийн талаар хуваалцахыг тэднээс хүс) залуу эрэгтэйчүүдийг урь. Энэхүү үйлчлэл нь тэдэнд ямар нөлөө үзүүлсэн бэ? Бусдад ямар нөлөө үзүүлсэн бэ? Залуу эрэгтэйчүүдээс тэд хэцүү цаг үед бие махбодоороо аврагдаж байсан эсэхийг нь асуу. Тэдэнд тусалсан хүний талаар ямар мэдрэмж төрсөн бэ? “Тусламж хэрэгтэй хүмүүсийг аврах нь” видео бичлэгийг үзээд, Аврагчтай адил бусдад үйлчлэх талаар ерөнхийлөгч Монсоноос юу сурснаа ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго нь бусдад үйлчлэх санваарын үүргээ хэрхэн биелүүлэх талаар ойлгоход нь залуу эрэгтэй бүрд туслах явдал юм. Энэ хичээлийн нэг хэсэг болгож, чуулгын гишүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номондоо энэ үүргээ биелүүлэх төлөвлөгөөг гаргах хэрэгтэй. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо сүм дээр авч ирж байхыг чуулгын цуглаанаас өмнө залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх талаар ямар туршлага хуримтлуулж байгаагаа чуулгын цаашидын цуглаанууд дээр хуваалцахад урь.

- Дараах судруудыг залуу эрэгтэйчүүдэд хуваарилж өг: Матай 25:31–46; Иохан 13:34–35; Мозая 2:17; Иаков 1:27; Мозая 18:8–10. Эдгээр шүлгээс бусдад үйлчлэх тухай олж уншин, сурсан зүйлээ бичиж авахыг тэднээс хүс (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь 26-р хуудсыг үзнэ үү). Эдгээр шүлгээс өөрсдийн олж мэдсэн зүйлийг хуваалцсаных нь дараа, бусдын үйлчлэлээр дамжуулан хэрхэн адислагдаж байсан тухай хувийн туршлагаасаа хуваалцахад тэднийг урь.
- Чуулгын гишүүдийг дараах шүлгүүдийг уншихад уриад, даалгавар хүлээн авсан Нифайн хандлага юугаараа Лемен, Лемүел

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөө

Чуулгын цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдэд Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө гаргах цаг гаргаж өг. Энэ төлөвлөгөө хувь хүнийх боловч чуулгын гишүүд төлөвлөгөөнийхөө талаар бие биедээ санал бодлоо хэлж болно.

хоёрынхоос ялгаатайг байсныг асуу: 1 Нифай 2:16–18; 3:1–7, 28–31; 4:1–2; 17:7–19, 50–51; 18:1–4 (тэднээс хариултаа самбар дээр бичихийг хүсэх талаар бодож үз). Тэд бусдад үйлчлэх сүүлчийн боломжийнхоо талаар ямар хандлагатай байсан тухай бодохыг тэднээс хүс. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын 50-р хуудас дээрх тусгай зайд санваарын үүргээ биелүүлж байхдаа бид ямар хандлагатай байх ёстойг заасан хэд хэдэн үг бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг эсвэл хоёуланг нь үзүүлж, чуулгын гишүүддээ болон бусдад үйлчилснээр ирдэг адислалуудыг эрж хайхыг залуу эрэгтэйчүүдээс хүс. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номоос

Залуу эрэгтэйчүүд дээрх үйл ажиллагаануудаас нэгийг юм уу түүнээс олныг гүйцэтгэсний дараа дараах зүйлсийг хий:

- *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын “Бусдад үйлчил” хэсгийг эргэж харахад чуулгын гишүүдийг урь ([дикон] 26–27, [багш] 50–51, [прист] 74–75-р хуудсууд). Чуулгын гишүүн бүрийг үйлчлэл үзүүлэх хувийн төлөвлөгөө бичихэд урь. Жишээлбэл: Тэд ахлагч Рассэл М.Баллардын зөвлөгөөг даган, бусдад үйлчлэх боломжийн төлөө өдөр бүр залбирах

Аароны санваартнуудын хувьд бусдад үйлчилж болох арга замуудыг хайж олохыг чуулгын гишүүдээс хүс ([дикон] 23, [багш] 47, [прист] 71-р хуудсуудыг үзнэ үү). Үйлчлэлээрээ дамжуулан өөрсдийн чуулгыг бэхжүүлэх арга замуудын талаар тунгаан бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Хэнри Б.Айрингийн залуу эрэгтэй байсан үеийнх нь зургийг үзүүл. Пристийн хувьд бишоптойгоо хамт гишүүдийн гэрт айлчилж очдог байсан Ерөнхийлөгч Айрингийн туршлагаудыг унш. Ерөнхийлөгч Айрингийн туршлагаудаас залуу эрэгтэйчүүд бусдад үйлчлэх талаар юу сурч болох вэ? Үүнтэй төстэй ямар туршлагыг тэд амьдралаасаа хуваалцаж болох вэ?

төлөвлөгөө гаргаж болох юм (“Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь”, *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 11 сар, 35–38-ыг үзнэ үү). Бусдад үйлчлэхийн тулд чуулгынхан юу хийж болох талаарх ярилцлагыг удирдахад чуулгын ерөнхийлөгчийг уриад мөн энэ төлөвлөгөөгөө номондоо бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ дэлхий дээрх тохинууллынхаа туршид Өөрийн эргэн тойронд байгаа хүмүүст үйлчлэн, туслахад Өөрийн цагийг зарцуулдаг байсан. Христийн үнэн дагалдагчид мөн ийн үйлддэг. “Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:35) хэмээн Аврагч хэлсэн билээ. Та залуу эрэгтэйчүүдэд зааж байхдаа тэднийг бусдад хэрхэн үйлчилсэн талаар мөн үйлчлэл хийх урмыг хаанаас авсан тухай хуваалцахад урих боломжуудыг эрэлхийлээрэй.

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Хэн нэгэнд үйлчлэх өөрийн төлөвлөгөөг хуваалцаж, залуу эрэгтэйчүүдийг төлөвлөгөөгөө биелүүлэхэд урьж болно.
- Чуулгын гишүүдийг ирэх долоо хоногуудад бусдад үйлчилсэн туршлагаасаа хуваалцахад урина гэдгээ тэдэнд тайлбарлан хэлж болно.



Би хэрхэн Христтэй илүү адил болох вэ?

Есүс Христ бидэнд төгс жишээг үзүүлсэн бөгөөд Тэрээр биднийг Өөртэйгээ адил болохыг зарлигласан. Тэрээр итгэл, найдвар, энэрэл болон тэвчээртэй, даруу, цэвэр ариун, хичээнгүй, дуулгавартай байдал зэрэг зан чанаруудын жишээг бидэнд харуулсан. Бид Түүний талаар сурч мөн зан чанаруудыг нь өөрсдөдөө хөгжүүлэх явцдаа Түүний мөн Тэнгэрлэг Эцэгийн маань хүссэн шиг санваартнууд болох болно.

Есүс Христийн зарим зан чанарууд юу вэ? Эдгээр зан чанараас алиныг нь та голчлон хөгжүүлэх хэрэгтэй байгаа вэ? Эдгээр зан чанарын жишээг үзүүлдэг ямар хүнийг та хардаг мөн мэддэг вэ?

Та өөрийн заадаг залуу эрэгтэй бүрээс Христийнхтэй адил зан чанаруудын алийг нь олж хардаг вэ? Тэд илүү итгэлтэй санваартнууд болохын тулд одоо ямар зан чанаруудыг хөгжүүлэх хэрэгтэй байгаа вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Матай 26:36–45; Лук 7:11–15; 23:33–34; Иохан 13:4–10 (Аврагчийн амьдралаараа үлгэрлэн харуулсан зан чанарууд)

Мозая 3:19 (Бид Есүс Христийн Цагаатгалаар гэгээнтэн болж чадна)

3 Нифай 27:27 (Христтэй адил болохыг бидэнд зарлигласан)

Стифэн В.Өвэн, “Агуу удирдагч агуу дагалдагч байдаг,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 57–59

Ричард Ж.Мэйнс, “Христ дээр төвлөрсөн амьдралаар амьдрахын баяр

баясгалан,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 11–13

М.Рассэлл Баллард, “Залуучуудын хамгийн агуу үеийнхэн,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 55–58

Томас С.Монсон, “Хөлийнхөө доорх замыг хар,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 97–100

“Христийнхтэй адил зан чанаруудыг би хэрхэн хөгжүүлэх вэ?” *Миний сайн мэдээг номло* (2004), 131–144

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын түслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүн бүрийг өнгөрсөн долоо хоногт сурсан сургаалын талаарх нэг судрыг олоод, өөр нэг чуулгын гишүүнтэй хуваалцахад урь.
- *Миний сайн мэдээг номло* номын 143-р хуудас дээрх зан чанарын үйл ажиллагааны хуулбарыг өгөөд,

цөөн хэдэн минутын дотор хувийн дүгнэлтээ хийж дуусгахыг хүс. Энэ үйл ажиллагаанаас сурсан зүйлээ хуваалцахыг залуу эрэгтэй бүрээс хүс. Чуулгынхаа хүндэлж явдаг нэг гишүүнд эсвэл гэр бүлийнх нь нэг гишүүнд байдаг Христтэй адил зан чанарын талаар хуваалцахыг цөөн хэдэн залуу эрэгтэйгээс хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд Есүс Христийн зан чанаруудын талаар суралцахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Та өөрсдийн амьдралыг Есүс Христ дээр төвлөрүүлэх ёстой шалтгааныг ойлгоход залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд ямар нэгэн зүйлийг төвд нь байрлуулж тоглодог тоглоомд тэднийг урь (цагираг шидэх, блокуудыг тэнцвэртэйгээр өрөх гэх мэт). Ахлагч Ричард Ж.Мэйнсийн “Христ дээр төвлөрсөн амьдралаар амьдрахын баяр баясгалан” хэлсэн үгийн эхний дөрвөн минутыг үзүүл. Тэд өөрсдийн амьдралыг Аврагч дээр төвлөрүүлэхийн ач холбогдлын талаар юу сурсан бэ? Чуулгын гишүүдийг

хос хосоороо хуваагдан, хамтран ажиллаад, өөрсдийн амьдралыг Христ дээр төвлөрүүлснээр хүлээн авах адислалуудын тухай өгүүлсэн түүхийг уг үгээс олохыг хүс. Тэд өөрсдийн амьдралыг Аврагч дээр болон Түүний сургаал дээр илүү их төвлөрүүлэхийн тулд юу хийж болох вэ?

- Ахлагч Рассэлл М.Баллардын “Залуучуудын хамгийн агуу үеийнхэн” хэлсэн үгэн дэх залуу эрэгтэйчүүдэд тавьсан 9 асуулт бүхий хэсгийг тэдэнд хувилж өг (эсвэл

Заахад туслах арга

“Богино, товч, шулуухан гэрчлэл хамгийн хүчтэй байх нь олонтоо”.

ахлагч Баллардын асуулт тавьж буй хэсгийг сонсгож болно). Тэднийг эдгээр асуултад хэрхэн хариулах талаар тунгаан бодоход урьж мөн амьдральнхаа сайжруулж чадах ямар нэг хэсгийг бодож үзэхийг хүс. Эдгээр асуулт нь Христийн ямар зан чанаруудыг хөгжүүлэхэд тэдэнд тусалж чадах вэ?

- *Миний сайн мэдээг номло* номын 6-р бүлгийн хуулбар залуу эрэгтэй бүрд байгаа эсэхийг бататгаарай. Залуу эрэгтэйчүүдийг энэ бүлэгт дүрсэлсэн Христийнхтэй адил зан чанаруудаас өөрсдөдөө хөгжүүлмээр байгаа нэг зан чанарыг сонгоход урь. Сонгосон энэ зан чанар нь тэдэнд яагаад чухал болох талаар хуваалцахыг хүс. Миний сайн мэдээг номло номын 140–141-р хуудас дахь “Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэх нь” гарчгийн дор байгаа саналуудын дагуу сонгосон зан чанарынхаа талаар суралцах цагийг чуулгын цуглаан дээр гаргаж өгөөрэй.

- Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Хөлийнхөө доорх замыг хар” хэлсэн үгэндээ дурдсан замуудаас нэгийг сонгоход залуу эрэгтэй бүрийг урь. Энэ замын талаар ерөнхийлөгч Монсон юу гэж хэлснийг дүгнэн хэлэхийг мөн тэрхүү зам дээр Аврагч хэрхэн жишээ үзүүлсэн талаар товчхон үг хэлэх тойм бэлтгэхийг түүнээс хүс. Тэр тоймдоо судар, хувийн туршлага хийгээд гэрчлэлээ багтааж болно. Бэлдсэн үгээ мночелийн нээлтийн үйл ажиллагаа, ариун ёслол, чуулгын цуглаан зэрэг дээр эсвэл гэртээ хэлэх төлөвлөгөө гаргахад нь залуу эрэгтэйчүүдэд тусал.

- *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номонд жагсаасан санваарын үүрэг хариуцлагуудыг олж (23-р хуудас [дикон], 46–47-р хуудас [багш], 70–71-р хуудас [прист]), эдгээр үүрэг хариуцлагаа биелүүлэх өөр өөр нөхцөл байдлуудын талаар ярилц (жишээлбэл, сайн мэдээг хүлээж авдаггүй гэр бүлд гэрийн багшаар очих эсвэл Их Эзэний жишгийг хамгаалах). Эдгээр нөхцөл байдалд Христийн зан чанарууд хэрхэн залуу эрэгтэйчүүдэд туслах вэ? Тэд чуулгын нэг гишүүнийг эдгээр зан чанараас үзүүлж байгааг хэзээ харсан бэ? Залуу эрэгтэйчүүд Стивэн В.Өвэний “Агуу удирдагч агуу дагалдагч байдаг” хэлсэн үгийг уншаад, амьдралдаа харж байсан санваарын удирдлагын жишээнүүдийн тухай ярилцаж болно. Христ хэрхэн удирдлагын хамгийн сайн үлгэр жишээ болдог вэ? Бид санваарын үүргүүдээ биелүүлснээр хэрхэн Христтэй адил удирдагч болдог вэ?

- Энэ тоймд санал болгосон судруудын нэгийг бие даан уншаад, Аврагчийн зан чанаруудын заримыг илэрхийлж буй үг, хэллэгүүдийг тэмдэглэхэд чуулгын гишүүдийг урь. Тэднийг “Христийнхтэй адил зан чанарууд” видео бичлэгийг үзэж байхдаа эдгээр болон өөр бусад зан чанарыг хайж олоход урамшуулан дэмж. Аврагчийн талаар болон Түүний үлгэрлэн үзүүлж байсан зан чанаруудын талаар сэтгэгдлээ хуваалцах цагийг тэдэнд гаргаж өг. Тэд хэрхэн эдгээр зан чанарыг өөрсдийн амьдралд хөгжүүлж болох вэ? Мөн тэд Христийнхтэй адил зарим зан чанарыг өөрсдөдөө хөгжүүлсэн хүмүүсийн жишээнүүдийг хуваалцаж болно.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Христтэй хэрхэн илүү адил болох талаар тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Одоо мөн ирээдүйд санваарын үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах Христийнхтэй адил зан чанаруудыг хөгжүүлэх нь чухал болох талаар гэрчлэлээ хуваалцаж болох юм.
- Христийнхтэй адил нэг зан чанарыг хөгжүүлэх зорилго тавьж, төлөвлөгөө гаргахад залуу эрэгтэйчүүдийг урьж болно. Тэрээр Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйхад тэднийг урамшуулж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Бүхий л нөхцөлд Аврагч бидний жишээ мөн багш байсан юм. Түүнтэй илүү адил болж, Түүний зан чанаруудыг хөгжүүлэхийг хичээх нь илүү сайн багш болоход тань туслах болно. Заахад бэлтгэж байхдаа залуу эрэгтэйчүүдэд заахын тулд өөрт тань хэрэг болох Христийнхтэй адил зан чанаруудын талаар бодоорой.

Сонгосон материалууд

Ричард Ж.Мэйнс, “Христ дээр төвлөрсөн амьдралаар амьдрахын баяр баясгалан,” Ensign, 2015 оны 11-р сар, 27–28 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 11–12

Японы Шикоку дахь жижиг уулархаг тосгонд амьдардаг Далын ахлагч Таийчи Аобагаас өсвөр үеийнхний чуулган дээр нэгэн ангид заахыг хүсжээ. Чуулганы сэдвийг “Ариун газруудад зогсогтон та нар” гэдгээр сонгосон байжээ. Энэ сэдвийг болон юу заахаа хэсэг бодсоны дараа ахлагч Аоба мэргэжлээ заах арга хэрэгсэл болгохоор шийдсэн байна. Тэр вааран эдлэл урладаг ажил хийдэг.

Ахлагч Аобаг бараг л ид шидээр юм шиг шавар дүрснүүдийг хэрхэн гараараа таваг, сав, аяга болгож байгааг анги дүүрэн өсвөр үеийнхэн хараад, ихэд сэтгэл нь хөдөлж байсан гэж тэрээр өгүүлсэн билээ. Үзүүлбэрийнхээ дараа тэр тэднээс оролдож үзэхийг хүсэж байгаа эсэхийг асуужээ. Тэд бүгд гараа өргөсөн юм.

Шинэ сонирхлоо туршиж үзэхээр хэд хэдэн өсвөр үеийнхэн ахлагч Аобагийн өмнө урагш гарч ирэв. Түүний хийхийг харсныхаа дараа тэд үүнийг маш хялбар гэж таамагласан бололтой. Гэсэн ч тэдний хэнийх нь ч, бүр энгийн сав хийх оролдлого нь ч гэсэн амжилттай болоогүй юм. Тэд “Би үүнийг хийж чадахгүй байна!” “Энэ яагаад ийм хэцүү байгаа юм бэ?” “Энэ маш хэцүү байна” гэгцгээж байлаа. Эдгээр тайлбарыг шавар өрөөний эргэн тойронд цацагдах үед хэлжээ.

Тэр өсвөр үеийнхнээс шаазан эдлэл хийх нь яагаад ийм хэцүү байгааг асуув. Тэд “Надад ямар ч туршлага байхгүй,” “Надад огт зааж байгаагүй” эсвэл “Надад ямар ч авьяас байхгүй” гэх мэтээр янз бүрийн хариулт өгч байлаа. Үр дүнгээс харвал, тэд бүгд үнэн хэлж байсан ч тэдний бүтэлгүйтлийн хамгийн чухал шалтгаан нь шавраа дугуйн төвд төвлөрүүлээгүй байсан явдал юм. Өсвөр үеийнхэн шаврыг төвд нь байрлуулсан гэж бодож байсан ч мэргэжилтний зүгээс бол энэ нь яг төвдөө байж чадаагүй. Тэрээр тэдэнд “үүнийг дахиад нэг оролдоод үзье” гэж хэлжээ.

Энэ удаад ахлагч Аоба шавраа яг дугуйн төвд байрлуулаад, дугуйгаа эргүүлэн шавар дунд нүх гаргаж эхэлжээ. Цөөн хэдэн өсвөр үеийнхэн дахин оролдож үзэв. Энэ удаад тэднийг “Хөөх, энэ чичрэхгүй байна,” “Би үүнийг хийж чадна” эсвэл “Би хийчихлээ” гэж хэлэхэд нь бүгд алга ташиж эхэлсэн юм. Мэдээж, хэлбэр нь төгс байгаагүй ч, үр дүн нь анхны оролдлогоос огт өөр байлаа. Тэдний амжилтын шалтгаан нь шаврыг дугуйны яг голд тавьсан явдал байв.

Бидний амьдарч буй дэлхий ваарчны эргэлддэг дугуйтай адил бөгөөд дугуйны хурд улам бүр нэмэгдсээр байна. Ваарчны дугуйн дээрх шаврын адил бид ч бас төвлөрөх ёстой. Есүс Христ болон Түүний сайн мэдээ бидний амьдралын төв байх ёстой билээ. Христ дээр төвлөрсөн амьдрал гэдэг нь бид Есүс Христ, Түүний сайн мэдээний талаар суралцаад, дараа нь Түүний үлгэр жишээг дагаж, зарлигуудыг яв цав сахина гэсэн үг юм.



Би хэрхэн Христийнхтэй адил хайрыг хөгжүүлж чадах вэ?

Христийн цэвэр хайр буюу энэрэл нь хамгийн дээд, эрхэм, бат бөх хайр бөгөөд бодгальд хамгийн их баясгаланг авчирдаг юм (1 Нифай 11:23-ыг үзнэ үү). Есүс Христ энэрлийн төгс жишээ мөн. Тэрээр зуурдын амьдралынхаа тохинууллын үед ядуу, зүдэрсэн, зовсон хүмүүсийг өрөвдөн “сайныг үйлдэн явдаг байсан” (Матай 4:23; Үйлс 10:38-ыг үзнэ үү). Христийнхтэй адил хайрыг эзэмшихийн тулд бид үүнийг эрэлхийлж, үүний төлөө залбирч мөн өөрсдийн бодол, үг яриа, үйл хөдлөлдөө Аврагчийн жишээг дагах ёстой.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судлан, залуу эрэгтэйчүүдэд хамгийн их тохирохыг нь сонгоорой.

Бусад хүн танд хэзээ Христийнхтэй адил хайрыг үзүүлж байсан бэ? Энэ нь танд хэрхэн нөлөөлсөн бэ? Та хэзээ Христийнхтэй адил хайрыг мэдэрсэн бэ? Бусдыг хайрлах Христийнхтэй адил хайрыг та өөртөө хэрхэн хөгжүүлдэг вэ?

Христийнхтэй адил хайрыг харуулах ямар боломжууд залуу эрэгтэйчүүдэд байдаг вэ? Тэдэнд Христтэй адил бусдыг хайрлаж сурах нь яагаад чухал вэ?

1 Самуел 16:7 (Эзэн хүмүүний зүрхийг хардаг)

Лук 10:30–37 (Сайн самари хүний сургаалт зүйрлэл); мөн түүнчлэн “Сайн самари хүний сургаалт зүйрлэл” Библийн видео бичлэгийг үзнэ үү.

Лук 23:33–34 (Есүс Өөрийг нь цовдолсон Ромын цэргүүдийг өршөөсөн)

Иохан 15:9–13 (Бидний төлөө амиа өгснөөр Христ хайраа харуулсан)

1 Иохан 4:7–11, 18–21 (Бурхан бол хайр юм)

Моронай 7:45–48 (Христийн цэвэр хайр болох энэрлээр дүүргэгдэхийн төлөө бид залбирч чадна)

Томас С.Монсон, “Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 91–94

Дийтр Ф.Угдорф “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 70–77

Даллин Х.Өүкс “Бусдыг хайрлаж, өөр үзэл бодол бүхий хүмүүстэй зэрэгцэн амьдрах нь,” *Ensign* эсвэл *Лиахона* 2014 оны 11-р сар, 25–28

“Энэрэл,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004)

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс хэрэгжүүлсэн нэг зүйлийнхээ талаар бодож, чуулгатайгаа эсвэл жижиг бүлэг дотроо түүнийгээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- Цөөн хэдэн жижиг цаасан дээр “Би _____ үедээ хэн нэгний

хайрыг хамгийн ихээр мэдэрч байсан” гэж бич. Уг жижиг цаасаа чуулгын цуглаан эхлэхээс өмнө залуу эрэгтэй бүрд тарааж өгөн, хоосон зайн дээр нь юу гэж бичих талаараа бодохыг хүс. Хичээлийг эхлүүлж, бодлоо хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Сонсох нь хайрын илэрхийлэл юм. Энэ нь ихэнхдээ золиослолыг шаарддаг. Бид бусдыг чин сэтгэлээсээ сонсохдоо тэдэнд өөрсдийгөө илэрхийлэх боломж олгохын тулд хэлэхийг хүсэж байгаа зүйлсээ хэлэлгүй үлддэг” (*Teaching, No Greater Call* [1999], 66).

Дараах үйл ажиллагаа бүр нь хэрхэн Христийнхтэй адил хайрыг хөгжүүлэх талаар суралцахад нь чуулгын гишүүдэд туслах юм. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Чуулгын нэг гишүүнийг Моронай 7:45-ыг ангийнхандаа чанга уншиж өгөхийг хүс. Бусад залуу эрэгтэйг судраа дагаж уншаад, дурдагдсан зан чанаруудаас өөртөө хөгжүүлмээр байгаа нэг зан чанарыг олохыг хүс. Сонгосон зан чанарынхаа талаар мөн яагаад үүнийг сонгосон тухайгаа хуваалцахыг хүн бүрээс

хүс. Тэгээд залуу эрэгтэйчүүдээс 47–48-р шүлгийг хамтдаа уншин, эдгээр зан чанарыг хөгжүүлж эхлэхийн тулд юу хийх ёстой талаар Моронайн хэлсэн зүйлийг сонсохыг хүс. Илүү үр дүнтэй санваарын үйлчлэгчид болоход нь эдгээр шинж чанар хэрхэн тэдэнд туслах вэ?

- Дараах судруудаас нэгийг уншихыг залуу эрэгтэйчүүдээс хүс: Иохан 15:9-13; 1 Иохан 4:7-11; 1 Иохан 4:18-21. Тэд эдгээр шүлгээс Христийнхтэй адил хайрын талаар юу сурч байна вэ? Аврагчийн хайрыг харуулсан судрын түүхүүдийг олоход залуу эрэгтэйчүүдийг урин, тэдгээр түүхээ нэг нэгэнтэйгээ хуваалцахыг тэднээс хүс. Мөн тэд ерөнхийлөгч Томас С.Монсоны “Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим” хэлсэн үгэн дэх түүхүүдийг уншиж мөн ярилцаж болох юм. Тэд өөрсдөө эсвэл тэдний мэдэх хэн нэгэн нь Христийнхтэй адил хайрын үйлдлээр дамжуулан адислагдаж байсан тухай хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг Лук 10:25-29-ийг уншин, Аврагчаас хуульчийн асуусан асуултуудыг олохыг хүс. Эдгээр асуултын хариулт болгож, Аврагч сайн самари хүний сургаалт зүйрлэлийг хэлсэн болохыг тайлбарла. Сургаалт зүйрлэл дэх дүрүүдээс заримыг төлөөлүүлэхээр хэд хэдэн залуу эрэгтэйд оноогоод, уг түүхийг хамтдаа унших явцдаа жүжиглэхийг тэднээс хүс (30-35-р шүлгүүд). Үе үе завсарлан, леви, санваартан, самари хүмүүсийг төлөөлж байгаа тэднээс яагаад ийм үйлдэл хийсэн болохыг нь асууж, хариултуудыг чуулгаараа хэлэлц. 36-37-р шүлгээс Аврагчийн уг хуульчид өгсөн зарлигыг уншин, залуу эрэгтэйчүүдэд тулгарч болох сургаалт зүйрлэлтэй төстэй нөхцөлдүүдийг хуваалцахыг тэднээс хүс.

- Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг олж авна” хэлсэн үгийг эсвэл ахлагч Даллин Х.Өүксийн “Бусдыг хайрлах ба өөр үзэл бодол бүхий хүмүүстэй зэрэгцэн амьдрах нь” хэлсэн үгийг чуулгаараа унш, үз эсвэл сонс. Хүнд хэцүү нөхцөлд ч бусдыг хайрлахад нь тэдэнд туслах зөвлөгөөг хайж олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Өөрсдийнхөө дургүй байдаг хэн нэгний талаар болон Христийнхтэй адил хайрыг хэрхэн тэр хүнд үзүүлж болох арга замуудын талаар чимээгүйхэн тунгаан бодоход залуу эрэгтэйчүүдийг урь.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэг юм уу хэдийг үзүүл. Христийнхтэй адил хайрын талаар эдгээр видео бичлэгээс залуу эрэгтэйчүүд юу сурч байна вэ? Эрэгтэй хүн ямар байвал зохистой талаарх энэ видео бичлэгүүд дээрх захиасууд нь дэлхийн заадгаас ямар ялгаатай байна вэ? Хэн нэгний үйлчлэл нь Аврагчийн хайрыг мэдрэхэд тэдэнд тусалсан жишээнээс хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Уг жишээ тэдэнд Есүс Христийн талаар юу заасан бэ? Их Эзэний хайрыг мэдрэх хэрэгтэй байж болох өөрсдийн таних хэн нэгнийг бодоход залуу эрэгтэйчүүдийг урь. Тэр хүнд туслахын тулд тэд юу хийж чадах вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч үлгэр жишээгээр дамжуулан заадаг байсан. Тэрээр тэдэнтэй хамт залбирснаар залбирахыг заасан. Тэрээр Өөрийн зааж байгаа аргаар сайн мэдээгээ заахыг тэдэнд заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шигээ бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр тэдэнд заасан. Тэдний төлөөх Христийнхтэй адил хайрыг тань залуу эрэгтэйчүүд мэдрэх үед та багшийн хувьд илүү үр нөлөөтэй байх болно.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд Христийнхтэй адил хайрыг өөртөө хэрхэн хөгжүүлэхийг ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Христийнхтэй адил хайр нь санваарын үйлчлэлээ биелүүлэхтэй ямар хамааралтай болох талаар санаа бодлоо хуваалцаж болно.
- Христийнхтэй адил хайрыг хөгжүүлж, бусадтай харьцаагаа сайжруулах талаар чуулгын цуглааны явцад мэдэрсэн бодлынхоо дагуу үйлдэхэд залуу эрэгтэйчүүдийг урьж болно.

Сонгосон материалууд

Дийтр Ф.Угдорф “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрийг хүлээн авна”, хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2012 оны 5-р сар, 71–81

Хамгийн чухал санаа

Бусдыг шүүмжлэх талаар нэгхэн үгтэй зааврыг өгч болно. Хэн нэгнийг үзэн ядаж, муугаар хэлж, доромжилж, атаа хорсол санаж, хорлохыг хүсэх үедээ дараах зөвлөмжийг дагаарай:

Зогсоо!

Энэ үнэхээр энгийн арга. Бид зүгээр л бусдыг шүүмжлэхээ больж, шүүжлэлийн бодол санааг Бурхан болон Түүний хүүхдүүдийг хайрлах хайрын мэдрэмжээр сольж болно. Бурхан бол бидний Эцэг. Бид бол Түүний хүүхдүүд. Бид бүгд ахан дүүс. *Бусдыг шүүмжлэхгүй* байх энэхүү чухал санааг би хэрхэн илүү сайн, тодорхой, мартагдагдахааргүй тайлбарлахаа мэдэхгүй байна. Би судрын эшлэл татаж, сургаалыг тайлбарлах бөгөөд саяхан миний харсан машины ар талд наалттай байсан үгээс эш татъя. Жолооч нь ширүүн дориун харагдаж байсан ч машиных нь ард байсан зураг ухаалаг санааг илэрхийлж байлаа. Энэ нь “Би чамаас өөр нүгэл үйлддэг учраас намайг бүү шүү”

гэсэн байв. Бид бүгд төгс биш бөгөөд Бурханы өмнө гуйлгачид гэдгээ санах ёстой. Бид бүгд хэзээ нэгэн цагт өршөөлийн суудалд хүрч ирж, нигүүлслийг хүлээн авахыг гуйж байгаагүй гэж үү? Бид гаргасан алдаа, хийсэн нүглүүдээсээ уучлагдахын тулд сүнснийхээ бүх хүчээр нигүүлслийг эрээгүй гэж үү?

Бид бүгд Бурханы нигүүлслийг хүсдэг учраас тэрхүү ач ивээлийн өчүүхэн хэсгийг ч гэсэн бусдад өгч болохгүй гэж үү? Хайрт ах эгч нар минь ээ, бид уучлагдахыг хүсдэг шигээ бусдыг уучлахгүй гэж үү?

Бурханы хайр

Үүнийг хийхэд хэцүү юү?

Мэдээж, хэцүү.

Өөрсдийгөө болон бусдыг уучлах нь амар биш. Үнэндээ, бидний ихэнх нь өөрсдийнхөө зан авирт болон бодол санаандаа чухал өөрчлөлтүүдийг, бүр зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хийх шаардлагатай байдаг. Гэхдээ надад нэг сайн мэдээ байна аа. Энэ зүрх сэтгэл дэх “хүчит өөрчлөл” [Мозая 5:2] нь Есүс Христийн сайн мэдээний авчирдаг үр дүн юм.

Үүнийг хэрхэн гүйцэлдүүлэх вэ? Бурханы хайраар.

Бидний зүрх сэтгэл Бурханы хайраар дүүрсэн үед ямар нэгэн сайн сайхан, цэвэр ариун зүйл бидэнд тохиолддог. Бид “Түүний тушаалуудыг сахих нь Бурханы хайр мөн. Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ. Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг ялдаг.” [1 Иохан 5:3–4.]

Бид хэдий чинээ Бурханы хайранд оюун бодол, зан авираа захируулна төдий чинээ Тэнгэр дэх Эцэгээ хайрлах хайрыг зүрх сэтгэлдээ өсгөж бусдыг Христийн цэвэр хайраар хайрлаж чадна. Хайраараа биднийг дүүргэхийг Бурханд зөвшөөрснөөр бид зэвүүцэл, атаа хорслоосоо салж чадна.

Христ үргэлж бидний үлгэр жишээ байсаар ирсэн. Тэрээр Өөрийн сургаал болоод амьдралаараа бидэнд замыг харуулсан. Тэрээр сул доройчуудыг, ёс бусчуудыг, бүр Өөрийг нь зовоож, тарчлаахыг хүссэн хүмүүсийг уучилсан юм. . . .

Христийн цэвэр хайр бусдыг шүүмжлэхэд нөлөөлдөг үзэн ядалт, атаа хорслын мэдрэмжийг арилгаж, Тэнгэрлэг Эцэг биднийг төсөөлөх чадвараас маань илүү дээгүүр мөн чадавхтай төгс бус эгэл хэмээн хардгийн адилаар бусдыг харах боломжийг бидэнд өгдөг. Бурхан бидэнд маш их хайртай учраас бид ч гэсэн бие биеэ хайрлаж, уучлах ёстой.



Би хэрхэн илүү тэвчээртэй байж сурах вэ?

Тэвчээр гэдэг нь саатал, бэрхшээл, сөргөлдөөн буюу зовлонг уурлаж, бухимдахгүйгээр эсвэл сандрахгүйгээр тэсэж өнгөрөөх чадавхыг хэлдэг. Бурхан бидэнд өгсөн бүх амлалтуудаа биелүүлэх болно гэсэн итгэлтэйгээр, Түүний хүссэнийг хийхээр эрэлхийлж, Түүний цаг хугацааг хүлээн зөвшөөрснөөр бид тэвчээртэй байдлыг хөгжүүлж чадна. Бид жижиг зүйлүүдэд тэвчээртэй байж сурснаар том бэрхшээлүүдийг тэвчээртэйгээр даван туулахад өөрсдийгөө бэлтгэдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч уншаарай. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Иов 1; 19:25–26 (Иовын жишээ)

Дуулал 37:7–9; Лук 21:19; Еврей 10:35–36; Мозая 23:21–22; Алма 26:27; С ба Г 24:8 (Тэвчээртэй тэдэнд адислалууд ирдэг)

Ром 5:3; Иаков 1:3 (Бэрхшээл нь тэвчээрийг бэхжүүлдэг)

Дийтр Ф. Угдорф “Тэвчээрээр үргэлжлүүл,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5 сар, 56–59; мөн түүнчлэн “Тэвчээрээр үргэлжлүүл” видео бичлэгийг үзнэ үү.

Робэрт С. Өүкс “Тэвчээрийн хүч чадал,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2006 оны 11 сар, 15–17

Ямар үйл явдлууд (маш том сорилт болон ноцтой бус бэрхшээлийн аль алиныг оролцуулаад) танд тэвчээрийн талаар зааж байсан бэ? Тэвчээрийг хөгжүүлэхэд танд юу тусалсан бэ? Тэвчээр таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?

Өнөөдрийн нийгэмд тэдний тэвчээрийг алдагдуулах нөлөө бүхий ямар зүйлстэй залуу эрэгтэйчүүд тулгарч байдаг вэ? Залуу эрэгтэйчүүд тэвчээртэй зан чанарын талаар юу ойлгох хэрэгтэй вэ? Энэ нь тэдний ирээдүйд хэрхэн тус болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээр сурсан зүйлийг нь дүгнэх нэг өгүүлбэр самбар дээр бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс.
- Энэ хичээлийн гарчгийг самбарт бичээд, энэ тоймын эхэнд байгаа догол мөрийг унш. Залуу эрэгтэйчүүдийг амьдралд нь тохиолдож болох тэвчээр шаардагдах нөхцөл байдлуудын талаар хуваалцахад урь

(боловсрол, гэрлэлт эсвэл ажил гэх мэт). Амьдралдаа тэвчээр үзүүлэх хэрэгтэй байсан үеийг тань төлөөлөх хэд хэдэн зүйлсийг тэдэнд үзүүл (жишээлбэл, коллежийн диплом, хуримын бөгж эсвэл номлогчийн нэрийн тэмдэг гэх мэт). Эдгээр зүйлс нь тэвчээртэй ямар хамааралтай талаар тэднээр таалгаад, туршлагаасаа хуваалц.

Хамтдаа суралц

Тэвчээртэй байх нь яагаад чухал болохыг чуулгын гишүүдэд ойлгуулахад дараах үйл ажиллагаа бүр туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Самбар дээр “Тэвчээр” болон “Тэвчээргүй байдал” гэсэн гарчгуудыг бич. Залуу эрэгтэй бүрд энэхүү хичээлд санал болгосон тэвчээрийн тухай судруудын нэгийг өг. Өөрсдөд нь оноогдсон судруудыг ээлжлэн чангаар уншаад, түүнд зааж байгаа зүйлийн талаар ярилцаж, мөн тэвчээртэй байдлаас ирэх адислал ба тэвчээргүй байдлын үр дагаврыг самбар дээр бичихэд залуу эрэгтэйчүүдийг урь. Өөр ямар адислал болон үр дагавруудыг тэд уг жагсаалт дээрээ нэмж болох вэ? Тэвчээр шаардах нэг нөхцөл байдлыг цаасан дээр бичихэд

залуу эрэгтэй бүрийг урь (ноцтой бэрхшээл төдийгүй, өдөр тутмын бухимдал ба түвэгтэй байдлыг ч бас багтаахад тэднийг урамшуул). Цаасаа өөр нэгэн залуу эрэгтэйтэй солилцож, тэвчээр үзүүлэх тухай хариулт бичээд, өөрийн бичсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахыг хүс.

- Ахлагч Роберт С. Өүксийн “Тэвчээрийн хүч чадал” хэлсэн үгээс нэгэн эцгийн тэвчээрийн талаарх түүхийг хуваалцаад, тэвчээртэй холбоотой өөр ямар нэг түүх хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Уг

Заахад туслах арга

“Та ярьж буй хүндээ сонсож байгаа гэдгээ харуулахын тулд сонирхож байгаагаа харуулах ёстой. Та хичээлийн материал эсвэл анги доторх аливаа зүйлс рүү биш харин ярьж буй хүн рүүгээ харах хэрэгтэй. Ярьж байгаа хүний яриаг таслахгүйгээр бодол санаагаа илэрхийлэхэд нь та урамшуулан дэмжих ёстой. Та түүнийг сонсож дуусгалгүйгээр зөвлөгөө өгөх эсвэл шүүмжлэхээс зайлсхийх хэрэгтэй” (Teaching, No Greater Call [1999], 66).

хэлсэн үгээс тэдэнд хэрэгтэй гэж бодож байгаа богино хэсгийг залуу эрэгтэй бүрд өгөөрэй. Түүнийгээ уншин, чуулгынхандаа дүгнэн ярихад урь. Тэд Их Эзэнд болон Түүний цаг хугацаанд итгэх урам төрүүлэхүйц ямар зүйлийг энэ ярианаас сурч байна вэ? Биднийг тэвчээргүй болгодог ямар шалтгаанууд байдаг вэ? Бид энэ байдлаа хэрхэн ялан дийлж чадах вэ?

- *New Era* эсвэл *Лиакхона* сэтгүүлүүдийн сүүлийн дугааруудаас хэд хэдэн мормон сурталчилгааг залуу эрэгтэйчүүдэд үзүүл. Чуулгыг жижиг бүлгүүд болгон хуваарилан, тэвчээр гэсэн сэдвээр өөрсдийн мормон сурталчилгааг зохиоход тэднийг урь. Тэд эхлээд тэвчээрийн талаар бичигдсэн судар олоод (энэ тоймд жагсаагдсан судрууд гэх мэт) мөн үзүүлэн дээр харуулах бүтээлч аргыг бодож олж болох юм. Өөрсдийн үзүүлэнг чуулгатай хуваалцаж, тэвчээр нь тэдний хувьд ямар утга учиртай болохыг тайлбарлахыг тэднээс хүс. (Энэ ярилцлагын нэг хэсэг болгож энэ тоймын эхэнд байгаа тэвчээр гэдэг үгийн тодорхойлолтыг чуулгатай хуваалцахыг та хүсч болох юм).

- “Тэвчээрээр үргэлжлүүл” видео бичлэгийг үзүүлэн, хөөсөнцөр чихрийн туршлагаас сурсан зүйлээ ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Залуу эрэгтэйчүүдэд тэвчээр алдах ямар нөхцөл байдалууд тохиолддог вэ? Ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын “Тэвчээрээр

үргэлжлүүл” хэлсэн үгийн нэг хэсгийг залуу эрэгтэй бүрд уншуулахаар өгөөд, өөрсдийн уншсан хэсгээсээ сурсан зүйлээ чуулгынхандаа дүгнэн хэлж өгөхийг тэднээс хүс. Ерөнхийлөгч Угдорфын зөвлөгөө залуу эрэгтэйчүүдэд илүү тэвчээртэй байхад нь хэрхэн туслах вэ?

- Иовын түүхийг ярьж өгөхийг чуулгын нэгэн гишүүнээс хүс (Иов 1-ийг үзнэ үү). Иов өөрт нь тулгарсан бэрхшээлийг яагаад тэвчээртэйгээр туулж чадсан гэж залуу эрэгтэйчүүд бодож байна вэ? Түүний Аврагчид итгэх итгэл нь түүнд хэрхэн тусалсан бэ (Иов 19:25–26-г үзнэ үү)? Иовд тулгарсан шиг хүнд бэрхшээлийн үед мөн өдөр тутмын шалгуурт ч тэвчээргүй байдлыг ялан дийлэхийн тулд хийж болох тодорхой зүйлс санал болгоход чуулгын гишүүдийг урь.

- Чуулгаараа Ахлагч Роберт Д. Хэйлсийн “Эзэнийг хүсэн хүлээ: Таны хүсэл биелэг” хэлсэн үгийн 9-17 дугаар догол мөрүүдийг уншихдаа “Их Эзэнийг хүлээнэ гэдэг нь юу гэсэн үг вэ?” хэмээх асуултын хариултыг эрэлхийлээрэй. Илүү ойлголт авахын тулд Ахлагч Хэйлсийн эш татсан судруудыг уншиж мөн эдгээр судрууд тэвчээрийн талаар юу зааж байгаа талаар хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Итгэл найдвараа алдаж буй хэн нэгэнд туслахын тулд Ахлагч Хэйлсийн үгс болон эдгээр судруудыг залуу эрэгтэйчүүд хэрхэн ашиглаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд тэвчээртэй байдлын чухлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлөнө. Тэрээр:

- Тэвчээрийн талаар сэтгэгдлээ хуваалцаж, ирэх долоо хоногт гэр бүлдээ илүү их тэвчээр үзүүлэхэд чуулгын гишүүдийг урьж болно.
- Тэвчээртэй байхыг сануулж болох газарт тэвчээрийн тухай судар, үгсийг (эсвэл өөрсдийн зохиосон мормон сурталчилгааг) байрлуулахад бусад чуулгын гишүүдийг урьж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч тунгаан бодож, гүн гүнзгий мэдрэхэд хүргэдэг асуултуудыг асуудаг байсан. Тэрээр тэдний хариултыг чин сэтгэлээсээ сонсож, итгэлтэй байдалд нь баясдаг байсан. Тэрээр тэдэнд асуулт асуух боломж олгож мөн сэтгэгдлийг нь сонсдог байв. Залуу эрэгтэйчүүдэд гүн гүнзгий мэдрэмж төрүүлэхэд туслах ямар асуултыг та асууж болох вэ? Тэдний хариултыг сонирхож байгаагаа хичээлийн явцад та хэрхэн харуулж болох вэ?

Сонгосон материалууд

Роберт Д.Хэйлс “Эзэнийг хүсэн хүлээ: Таны хүсэл биелэг” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2011 оны 11-р сар, 71-74

Их Эзэнийг хүлээнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Судруудад хүлээх гэдэг үг нь найдах, хүлээх, итгэх гэсэн утгатай байдаг. Их Эзэнд итгэж, найдахын тулд итгэлтэй, тэвчээртэй, даруу байж зарлигуудыг дагаж, эцсээ хүртэл тэвчих хэрэгтэй.

Их Эзэнийг хүсэн хүлээнэ гэдэг нь итгэлийн үрийг суулгаж, түүнийгээ “агуу шаргуу итгэл хийгээд . . . тэвчээрээр” арчлахыг хэлдэг [Алма 32:41]

Энэ нь Аврагч “Таны хаанчлал ирэх болтугай. Хүсэл тань биелэгдэх болтугай” гэж бидний Бурхан, Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсны адил залбирахыг хэлнэ [Матай 6:10; Лук 11:2]. Энэ нь Аврагч, Есүс Христийн нэрээр бүх зүрх сэтгэлээрээ бидний өргөдөг залбирал юм.

Их Эзэнийг хүсэн хүлээнэ гэдэг нь “хийвэл зохих тэр бүх зүйлийг” мэдэж болохын тулд зүрх сэтгэлдээ тунгаан бодож, Ариун Сүнснийг хүлээн авах гэсэн үг юм [2 Нифай 32:5].

Бид Сүнсний өдөөлтийг дагаснаар “зовлон зүдгүүр нь тэвчээрийг бий болгодог” [Ром 5:3] болохыг ойлгож, “төгөлдөржих хүртлээ [бид] тэвчээрт үргэлжлүүлэх” хэрэгтэйг сурдаг [Сургаал ба Гэрээ 67:13].

Их Эзэнийг хүсэн хүлээнэ гэдэг нь итгэлдээ “найдварын төгс гэрэлтэй”, “тууштай зогсож” мөн “урагш тэмүүлж” байхыг хэлдэг [2 Нифай 31:20].

Энэ нь “Христийн сайн үйлсийн дээр л тулгуурлах” [Моронай 6:4] ба “Таны үг гүйцэлдэх ёстой. Биднийх бус, харин Их Эзэн таны таалал гүйцэлдэх болно хэмээн [биднийг хэлэхэд] нь тэдэнд [Өөрийн] ач ивээлээрээ дэм үзүүлэх” гэсэн утгатай [Сургаал ба Гэрээ 109:44].

Бид Их Эзэнийг хүлээн байхдаа “зарлигуудыг дагахдаа хөдөлшгүй мөн гуйвшгүй” [Алма 1:25] байж, “нэгэн өдөр [бид] бүх зовлонгуудаасаа амарна” гэдэгтээ итгэдэг [Алма 34:41].

“[Бидний] зовж зүдэрсэн бүх зүйл [бидний] сайн сайхны төлөө ажиллах” учраас “итгэлээ бүү хаягтун” [Еврей 10:35], [Сургаал ба Гэрээ 98:3].



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Талархалтай байх нь яагаад чухал вэ?

Их Эзэн биднийг хийж, хэлж байгаа бүх зүйлдээ талархлын сүнстэй байгаасай гэж хүсдэг. Бид талархалтай байгаа үедээ амьдралдаа илүү их баяр баясгалантай, сэтгэл хангалуун байх болно. Бид Их Эзэний нөлөө болон адислалуудыг олж харах болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч судал. Талархалтай байдлаа хөгжүүлэхэд нь залуу эрэгтэйчүүдэд юу тусална гэж та бодож байна вэ?

Лук 17:11–19 (Есүс Христ уяман өвчтэй арван хүнийг анагаасан ба нэг нь л Түүнд талархахаар эргэж ирсэн)

Мозая 2:20–24 (Хаан Бенжамин бид яагаад Их Эзэнийг магтаж мөн талархаж байх ёстойг заасан)

С ба Г 59:7, 15–21 (Бид бүх зүйлд талархаж байх ёстой)

Томас С.Монсон “Талархлын тэнгэрлэг бэлэг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 87–90

Дийтр Ф.Угдорф, “Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар

Рассэлл М.Нэлсон “Бурхандаа талархъя,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 77–79; мөн түүнчлэн “Талархал илэрхийлэх нь” видео бичлэгийг үзнэ үү

“Талархал,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 18

“Адислал бүрээ тоол,” *Сүмийн дуулал*, х. 7

Таны хамгийн их талархаж байдаг зарим зүйл юу вэ? Талархалтай байдал тань хэрхэн таньг илүү аз жаргалтай болгосон бэ?

Талархалтай байдлаа хөгжүүлэхийн тулд залуу эрэгтэйчүүд юу хийж чадах вэ? Талархалтай байдал нь одоо мөн ирээдүйд тэдэнд ямар адислал болж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногт сурсан зүйлийг нь сануулах зургийг самбарт зурахыг нэг залуу эрэгтэйгээс хүс.
- Залуу эрэгтэй бүрд цагаан толгойн нэг үсэг оноогоод, тэр үсгээр эхэлсэн өөрсдийн бодсон адислалуудыг жагсаан бичих нэг минутын хугацаа ангийнханд өг. Их Эзэний өгсөн жижиг адислалуудыг яагаад бид заримдаа ажиглахгүй өнгөрдөг вэ? Чуулгын нэг гишүүнээс Сургаал ба Гэрээ 46:32 эсвэл 59:21-ийг уншихыг хүс. Бид “аливаа адислалаар адислагдсаныхаа төлөө” хэрхэн илүү талархал үзүүлж чадах вэ?

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Ур чадвартай багш ‘Өнөөдөр би хичээл дээрээ юу хийх билээ?’ гэж боддоггүй, харин ‘Өнөөдөр суралцагчид маань хичээл дээр юу хийх билээ?’ гэж асуудаг. ‘Өнөөдөр би юу заах билээ?’ гэдэггүй харин ‘Би хэрхэн суралцагчид даа мэдэх ёстой зүйлсээ олж мэдэхэд нь туслах вэ?’ гэж асуудаг”.

Доорх үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдэд талархлын чухлыг ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгандаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг Лук 17:11–19-ийг уншин, уяман өвчтэй арван хүний ес нь Аврагчид яагаад талархал илэрхийлээгүй талаар бодлоо хуваалцахад урь. Талархлаа илэрхийлэхэд маань саад болдог ямар зүйлүүд байдаг вэ? Хүлээн авсан боловч зохистойгоор талархал илэрхийлээгүй байж магадгүй адислалынхаа талаар бодоход залуу эрэгтэйчүүдийг урь. Баярласнаа илэрхийлэх нь яагаад чухал вэ? Тэд талархлаа үзүүлэхийн тулд юу хийх вэ?
- Ахлагч Рассэл М.Нэлсоны “Бурханд талархъя” хэлсэн үгээс загасны түүхийг ярьж эсвэл уншиж өг. Талархал авалгүйгээр бусдад тусалж байсан эсэхийг нь (энэ түүхэн дэх асрагч шиг) залуу эрэгтэйчүүдээс асуу. Хэлсэн үгийн үлдсэн хэсгийг сэдвийн гарчгаар нь хуваан, залуу эрэгтэй бүрд нэг хэсгийг уншуулахаар өгнө. Залуу эрэгтэйчүүдээс талархлын талаар сурсан зүйлээ болон түүнтэй холбоотой судрыг (гэд сэдэвчилсэн удирдамжийг ашиглаж болно) бичиж авахыг хүс. Өөрсдийн бичсэн зүйлсээ хуваалцаж, Бурханы өгсөн бэлгүүдээс нэгнийх нь төлөө талархаж байсан үеийнхээ тухай ярих боломжийг залуу эрэгтэйчүүдэд олгоорой.
- Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Талархлын тэнгэрлэг бэлэг” хэлсэн үгээс Гордон Гриний гэр бүлийн түүхийг уншиж эсвэл ярьж өг. Уг гэр бүлийг талархалтай болгосон зүйлсийг олж сонсохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Уг түүхийн туршид

энэ гэр бүлийн хандлага яагаад өөрчлөгдсөн бэ? Дараахтай адил асуултуудыг тунгаан бодоход залуу эрэгтэйчүүдийг урь: “Талархалгүй байсан гэм буруу надад байгаа юу?” “Би өөрөө анзаараагүй тийм адислалууд надад байна уу?” “Талархалтай байх нь хэрхэн надад адислал болох вэ?” Тэдний цөөн хэдийг бодлоосоо хуваалцахад урь.

- Чуулгын гишүүн бүрд ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн “Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь” сэдэвт үгээс гарчгийг нь өгөлгүйгээр нэг нэг хэсгийг хуваарилан өгч, үүнээс суралцахыг хүс. Өөрсдийнхөө сурсан зүйлийг нэгтгэн дүгнэх холбоо үг, өгүүлбэрээр өөрсдөө гарчиг өгөхийг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаараа хуваалцахыг хүс. Тэд талархал нь чухал гэдгийг ойлгож мэдсэн үү? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Залуу эрэгтэйчүүдийг талархдаг зүйлийнхээ талаар хуваалцаж, талархаж байгаагүй ямар нэгэн зүйлийн төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархахад урьж болно.

тэднээс хүсээрэй. Тэднийг өөрсдийнхөө өгсөн гарчгийг болон ерөнхийлөгч Угдорфын талархлын талаар өгсөн зөвлөгөөнөөс сурсан зүйлээ хуваалцахад урь. Ерөнхийлөгч Угдорфын дүрслэн хэлсэн талархалтай байдлыг хөгжүүлэхийн тулд тэд юу хийж чадах вэ?

- Чуулгаараа энэ хичээлд өгөгдсөн талархал, магтаалын судрын шүлгүүдийг уншиж мөн дуулуудыг дуул. Тэд өөрсдөө ч бас талархаж эсвэл магтаж байгаа тэдгээр үгсийг олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Сонгосон үгсийнхээ талаар хуваалцаж, яагаад эдгээр үгсийг сонгосноо тайлбарлан, талархсан сэтгэлээ илэрхийлэхэд тэднийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдыг итгэлээр үйлдэж мөн Түүний заасан үнэний дагуу амьдрахад уриалдаг. Тэрээр тэдэнд хүчирхэг туршлагуудаар дамжуулан суралцах боломж олгосон. Талархлын хүч чадлыг амьдралдаа олж харахад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд та юу хийж чадах вэ?

Сонгосон материалууд

Томас С.Монсон “Талархал бол бурханлаг бэлэг”
хэлсэн үгээс эш татав. Ensign ба Лиахона, 2010 оны
11-р сар, 95–99

Гордон Канадын нэг ферм дээр хэрхэн өссөн тухайгаа өгүүлжээ. Хичээлийн дараа бусад хүүхдүүд бөмбөг тоглохоор юм уу усанд сэлэхээр явдаг байсан бол Гордон болон дүү нар нь гэр рүүгээ яардаг байлаа. Аав нь тэдний ажил ямар үнэ цэнэтэйг ойлгуулахдаа чадварлаг нэгэн байсан гэдэг. Ургац хураалтын дараа гэр бүлээрээ тэмдэглэдэг Талархлын баярын өдөр аав нь тэдэнд өөрсдөдөө байгаа бүх хоол хүнсээ тоолдог байсан нь түүнийхээ төлөө талархал илэрхийлэх зорилготой байжээ. Тэр өөрсдөдөө байгаа бүхэнд бүртгэл хийдэг байв.

Талархлын өглөө тэр хүүхдүүдээ зооринд дагуулан орж, алимтай торхнууд, хувинтай чихрийн манжин, элсэнд булсан лууван, шуудайтай төмс, тавиур дүүрэн вандуй, эрдэнэ шиш, шош, жимсний цэлцэгнүүр, гүзээлзгэнэ, бусад дармал жимс, ногоонуудыг үзүүлдэг байлаа. Тэр юм бүхнийг хүүхдүүдээрээ анхааралтай тоолуулдаг байжээ. Дараа нь тэд амбаар руу очиж, тэнд хэчнээн тонн өвс, үр тарианы агуулахад хэчнээн торх тариа байгааг тоолдог байв. Тэд үхэр, гахай, тахиа, цацагт хяруул, галуунуудыг тоолно. Аав нь хүүхдүүддээ хэчнээн хэмжээний хүнс, бусад хэрэгцээт зүйлс байгааг мэдэхийг хүсдэг гэж хэлдэг байсан ч, үнэндээ бол Бурхан тэднийг ажлынх нь төлөө хэчнээн ихээр адисалж, шагнасныг талархлын тэр өдөр хүүхдүүд нь ойлгоосой гэж хүсдэгийг тэд мэддэг байлаа. Эцэст нь тэд ээжийнхээ бэлтгэсэн баярын ширээнд суух үед ямар нэг адислалыг мэдэрдэг байв.

Харин тэдэнд талархах юм бараг байгаагүй тэр нэгэн жил Талархлын өдрөөр хамгийн их талархалтай байсан тухай санадгаа Гордон өгүүлжээ.

Тэр жил уг нь дажгүй эхэлсэн аж. Тэдэнд нэлээд өвс, маш их хэмжээний үр, дөрвөн тоорой байлаа.

. . . Тариа дөнгөж соёолж эхэлтэл бороо орж эхлэх нь тэр. Эцэстээ ус татрахад соёолж байсан тариа урссан байв. Тэд дахин тариалсан ч бүр их бороо орж, соёолж байсан тариа газарт налж, төмс нь шаварт шигдэн ялзарсан гэнэ. Тэд өсгөн үржүүлэх гэж байсан хоёр үнээ, бүх гахай, бусад малаа маш хямдхан заржээ. Учир нь хүн бүр л ингэж малаа зарахаас аргагүйд хүрсэн байв. Тэр жил тэдний хураасан бүх ургац гэвэл бороон шуургыг яаж ийгээд тэсч гарсан багахан манжин л байлаа.

Тэгтэл Талархлын өдөр дахин болох нь тэр. “Энэ жил энэ өдрийг мартвал дээр биш үү. Бидэнд ядахдаа ганц галуу ч үлдсэнгүй шүү дээ” гэж ээж нь хэлжээ.

Гэвч Талархлын өдрийн өглөө Гордоны аав нэг молтогчин туулай авчраад, туулайн махаар хоол хийхийг эхнэрээсээ хүсэв. Туулайн мах хатуу, хоол хийхэд их хугацаа шаардагдах учраас тэр ажлаа дурамжхан эхэлжээ. Туулайн махыг манжинтай хамт ширээн дээр тавьсан ч хүүхдүүд нь идсэнгүй. Гордоны ээж уйлахад, аав нь нэгэн сонин зүйл хийжээ. Тэр дээврийн хонгил өөд гарч, дэнлүүг авчран, ширээн тавьж асаагаад, цахилгаан чийдэнг унтраа гэж хүүхдүүддээ хэлжээ. Зөвхөн дэнлүү үлдсэн үед тэд өмнө нь хэчнээн харанхуй байсанд итгэж ядан байлаа. Тэд

Сонгосон материалууд

цахилгаан гэрэлгүйгээр өмнө нь юм бүхнийг яаж харж байсандаа гайхжээ.

Хоолоо адисалсны дараа бүгд нөгөө туулайны махаа идлээ. Хооллож дуусаад, бүгдээрээ чимээгүй сууцгааж байв. Гордон бичихдээ:

“Тосон дэнгийн даруухан бүдэг гэрэлд бид юм бүхнийг дахин тод харж байлаа. . .

Хоол сайхан болсон байлаа. Молтогчин туулайн мах цацагт хяруулын мах шиг сайхан амттай, манжин хэчнээн зөөлхөн байсан гээч.

. . . [Манайх] гэдэг айл юм юмаар дутагдаж байсан ч бидэнд бол баян л байлаа” гэжээ. [Х.Гордон Грийн “Миний мартагдашгүй Талархлын баяр”-хэлсэн үгээс засч оруулав, *Reader's Digest*, 1956 оны 11-р сар, 69–71].

Арваннэгдүгээр сар: Сүнслэг ба материаллаг байдлын хувьд бие даах нь

“Хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө сонгогчид юм” (С ба Г 58:28).

Энэ бүлгийн тоймууд нь сүнслэг ба материаллаг байдлын хувьд бие даахын чухлыг ойлгоход нь Аароны санваартнуудад туслах болно. Хэдий тэд өсвөр насныхан ч эдгээр залуу эрэгтэй сонгох эрх чөлөөгөөр адислагдсан ба өөрсдийн замыг хэрхэн гаргахыг мөн Есүс Христийн сайн мэдээнээс асуудлууддаа хариулт хэрхэн олохыг сурч байгаа юм. Тэд бие даах тусам илүү их эрх чөлөөг эдлэх болно. Тэд санваарын дуудлагаа биелүүлж, гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд мөн нөхөр, аав хүн болох ирээдүйн үүргээ биелүүлэхдээ илүү бэлтгэгдсэн байх болно.

Энэ сард сонгох тоймууд:

Боловсрол эзэмшиж, ур чадвараа хөгжүүлэх нь яагаад чухал вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Бие даасан байдалтай байна гэдэг нь юу гэсэн үг вэ?

Би хөрвөгдөж байгаа эсэхээ хэрхэн мэдэх вэ?

Ажиллаж хөдөлмөрлөх нь яагаад сайн мэдээний чухал зарчим болдог вэ?

Их Эзэн яагаад намайг эрүүл байгаасай хэмээн хүсдэг вэ?

Ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг хангах Их Эзэний арга зам юу вэ?

Би тулгарсан бэрхшээл, асуудлуудаа шийдэх арга замыг хэрхэн олох вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны вэбсайт танд туслах болно. Эдгээр
тоймд багтсан олон үйл ажиллагааг мючелийн үйл
ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу эрэгтэйчүү-
дийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг бататгахын
тулд тохиромжтой үйл ажиллагаануудыг сонгож
мөн төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн зөвлөл-
тэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас

“Боловсрол” 55–59-р хуудас



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Боловсрол эзэмшиж, ур чадвараа хөгжүүлэх нь надад яагаад чухал вэ?

Түүнтэй илүү адил болоход тусалдаг Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд боловсрол чухал байр суурийг эзэлдэг. Боловсрол эзэмших нь биднийг бие даасан байдлаа хөгжүүлэхэд туслан, гэр бүлээ тэтгэн, сүм болон дэлхийд илүү их үйлчлэл үзүүлж болох ойлголт болон ур чадвараар хангадаг.

Таны амьдралын турш-
лагуудад боловсрол тань
таньг хэрхэн бэлтгэж
тусалсан бэ? Танд болон
таны гэр бүлд ямар
мэдлэг, боловсрол болон
ур чадвар хамгийн ашиг
тустай байна вэ? Та өөр
ямар зүйл сурахыг хүсч
байгаа вэ?

Боловсрол болон сурал-
цах талаар залуу эрэгтэй-
чүүд ямар хандлагатай
байна вэ? Боловсрол
тэднийг одоо болон
ирээдүйн хариуцлагад нь
хэрхэн адислах вэ?

Заах болон суралцах
бусад санаануудыг
хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судал. Боловсролын ач холбогдлыг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд юу туслах вэ?

2 Нифай 9:29 (Хэрэв тэд Бурханы зөвлөмжийг анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг)

С ба Г 88:76–80 (Сүнслэг болон зуур-
дын зүйлсийн талаар бид сурч мөн
заах ёстой)

С ба Г 88:118 (Судлахаар мөн итгэ-
лээр суралцагтун)

С ба Г 90:15 (Бид сайн ном уншиж,
хэл сурч, хүмүүстэй танилцах
хэрэгтэй)

С ба Г 130:18–19 (Бид энэ амьдралд оюун билгийн ямар ч түвшинд хүрлээ гэсэн, энэ нь амилуулалтанд бидэнтэй хамт сэргэн босох болно)

Д.Тодд Кристоффэрсон “Ах нар аа, бидэнд хийх ажил байна,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 11-р сар, 47–50

“Боловсрол,” *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* (2010), 55–59

“Боловсрол,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 9–10

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах

ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өмнөх хичээлүүдээс сурсан зүйлсээ хэрэгжүүлэхдээ хуримтлуулсан туршлагаасаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь (жишээлбэл, тэд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номондоо гаргасан төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд юу хийж байгаагаа хуваалцаж болно).
- Төсөөлөхөд залуу эрэгтэйчүүдийг урь. Залуу эрэгтэйчүүд түүнийг сургуульдаа үргэлжлүүлэн сурахад нь хэрхэн дэмжиж болох вэ? Хариултуудаа цаасан дээр бичихийг тэднээс хүс. Цааснуудыг цуглуулан, хариултуудыг уншиж, ангийнхантайгаа ярилц. Хичээлийн төгсгөлд хичээллэх явцдаа сурсан зүйл дээрээ үндэслэн хариулт нэмэх боломжийг тэдэнд өгөөрэй.
- Нэг найзыгаа сургуулиа орхих гэж байна гэж хэлж байгаагаар

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго нь ирээдүйн гэр бүлээ тэжээхэд нь тэднийг бэлтгэхэд туслах ур чадварыг хөгжүүлэх эсвэл боловсролоо дээшлүүлэх төлөвлөгөө гаргахад нь залуу эрэгтэйчүүдэд туслах явдал юм. Энэ хичээлийн нэг хэсэг болгож чуулгын гишүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын “Боловсрол” хэсэгт төсөл зохиож эхлэх хэрэгтэй. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоо сүм дээр авчирч байхыг чуулгын цуглаанаас өмнө залуу эрэгтэйчүүдээс хүс. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх талаар ямар туршлага хуримтлуулж байгаагаа чуулгын хойшдын цуглаанууд дээр хуваалцахад тэднийг урь.

- Залуу эрэгтэйчүүдийг Сургаал ба Гэрээ 88:77–80, 118 болон Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь “Боловсрол” хэсгийг судлахад урь. Залуу эрэгтэйчүүдийг (а) Их Эзэн тэднийг юу сураасай гэж хүсч байгааг, (б) Тэр тэднийг яагаад сурахыг хүсч байгааг болон (в) Тэр тэднийг хэрхэн сураасай гэж хүсдэгийг мэдэхийг хүс (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь 55-ыг үз). Бурханы өмнө хүлээсэн үүргээ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төлөвлөгөөнүүд

Чуулгын цуглааны төгсгөлд залуу эрэгтэйчүүдийг Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө гаргах цаг гаргаж өгөөрэй. Энэ төлөвлөгөө нь хувь хүнийх боловч чуулгын гишүүд төлөвлөгөөнд оруулах зүйлсийн талаар бие биедээ санал бодлоо хэлж болно.

биелүүлэх нь номын 56–58 дахь хуудсыг нээж, боловсролоо дээшлүүлэх талаар сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслах төсөл зохиоход залуу эрэгтэйчүүдийг урь. Чуулгаараа боловсролоо дээшлүүлэхийн чухлын талаар ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд туслах мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

- Энэ хичээлд өгөгдсөн судруудаас нэгийг чуулгын гишүүн бүрд хуваарилж, үүнийг уншаад уг сударт мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар юу гэж заасныг олохыг хүс. Өөрийн сурсан зүйлээ чуулгын өөр нэг гишүүнтэй хуваалцахад залуу эрэгтэй бүрийг урь. Өөрсдийн хүсч байгаа мэргэжлүүдийг самбар дээр бичихийг залуу эрэгтэй бүрээс хүс. Эдгээр мэргэжилд бэлтгэхэд нь туслах ямар зүйлүүдийг тэд уг судруудаас сурч авсан бэ?

- Чуулгаараа “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг уншихдаа нөхөр болон эцэг хүнийг дүрслэн илэрхийлдэг үгсийг хайхыг хүс (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын 107-р хуудаснаас уг тунхагийг олж болно). Дараах асуултуудын хариултыг самбар дээр бичихийг тэднээс хүс: (а) Боловсрол эзэмших болон нөхөр ба эцэг хүний хувьд үүргээ гүйцэтгэх чадвартай байх хоёрын хоорондох холбоо нь

юу вэ? (б) Эдгээр үүргийг ойлгох нь мэргэжлээ сонгоход чинь хэрхэн нөлөөлж байна вэ? (с) Мэргэжилтэй болохын төлөө чи одоо юу хийж чадах вэ? Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын 56–58 дахь хуудсыг нээж ирээдүйнхээ мэргэжлийн талаар судалж эхлэх нэг төсөл зохиохыг урь. Чуулгаараа мэргэжлийн талаар судлахад залуу эрэгтэйчүүдэд туслах мючелийн үйл ажиллагааг төлөвлө.

- Бишопын зөвшөөрөлтэйгөөр чуулгын зарим гишүүдийн аавыг урьж, гэр бүлээ тэтгэхийн тулд хэрхэн боловсрол эзэмшиж эсвэл ур чадварт суралцсан талаараа хуваалцахад урь. Тэд ямар золиослоудыг гаргасан бэ? Тэд өөрсдийн туршлагыг амжилттай болгохын тулд юу хийх хэрэгтэй байсан бэ? Тэдэнд арай өөрөөр хийсэн бол гэж хүсдэг зүйл байдаг уу?

- Ахлагч Д.Тодд Кристоферсоны “Ах нар аа, бидэнд хийх ажил байна” хэлсэн үгийн 6-8 дахь догол мөрийг уншихад залуу эрэгтэй бүрийг урь. Боловсрол яагаад чухал болох талаар сурсан зүйлээ чуулгатайгаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Боловсролын талаар одоо гаргаж байгаа шийдвэр ирээдүйд нь хэрхэн нөлөөлөх вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Боловсрол яагаад чухал болохыг тэд ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заасан тэдгээр хүмүүсээ мэддэг байсан. Тэрээр тэдэнд өсч хөгжихөд нь туслах онцгой арга замуудыг ашигладаг байсан. Боловсрол чухал болох талаар ойлгоход нь залуу эрэгтэй бүрд туслахын тулд та ямар онцгой арга замуудыг олж чадах вэ?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Сургуульдаа илүү амжилттай сурахын тулд хийж болох зүйлүүдийн жагсаалтыг гарган, ирэх долоо хоногийн туршид тэдгээрийг хийж эхлэхэд залуу эрэгтэйчүүдийг урьж болно.
- Залуу эрэгтэйчүүдийг номлолд болон ирээдүйн боловсролдоо зориулан мөнгө хадгалж эхлэхэд уриалж болно.
- Энэ хичээлд багтсан боловсролын талаарх судруудыг хувийн судрын цагаараа судалж, хойшдын чуулгын цуглаан дээр сурсан зүйлээ хуваалцахад гишүүдийг урьж болно.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Бие даасан байдалтай байна гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бид бие дааж чадсан үед Бурханы бидэнд өгсөн адислал, чадварыг өөрсдийгөө болон гэр бүлүүдээ хангах, халамжлахад ашиглаж, тулгарсан бэрхшээлт асуудлуудаа шийдэх арга замыг олдог. Бид бие даах чадвартай болсноор бусдад үйлчилж, тэднийг халамжлах илүү боломжтой болдог. Их Эзэн биднийг сүнслэг болон материаллаг байдлын хувьд бие даасан байлгахыг хүсдэг.

Бие даасан байдалтай байна гэдэг нь таны хувьд юу гэсэн үг вэ? Бие даасан байдал нь таныг болон гэр бүлийг тань хэрхэн адисалсан бэ?

Залуу эрэгтэйчүүд яагаад бие даасан байдлын талаар сурах хэрэгтэй вэ? Бие даасан байдалтай болоход нь тэдэнд юу саад болж болох вэ? Бие даасан байдал нь саад бэрхшээлтэй үеийг даван туулахад тэдэнд хэрхэн туслах вэ? Энэ нь тэдний ирээдүйн гэр бүлийг хэрхэн адислах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та эдгээр судар болон бусад материалыг судлах явцдаа бие даасан байдал чухал болохыг залуу эрэгтэйчүүдэд хэрхэн заах талаар мэдэхийн тулд Сүнсний удирдамжийг эрэлхийлээрэй.

Матай 25:1–13 (Арван онгон охины сургаалт зүйрлэл)

Лук 2:52 (Есүсийн бие болоод мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ)

1 Тимот 5:8 (Хүмүүс өөрсдийгөө тэтгэх ёстой)

С ба Г 83:2, 4 (Эмэгтэйчүүд нөхрөөрөө, хүүхдүүд эцэг эхээрээ тэтгүүлэх эрхтэй)

Хэнри Б.Айринг, “Сүнслэг байдлын бэлтгэл: Эртнээс эхэл, тууштай бай,” *Ensign* эсвэл *Liahona*, 2005 оны 11 сар, 37–40

Робэрт Д.Хэйлс, “Материаллаг болон сүнсний зүйлст ухаалгаар

арвиан хэмнэгч байх нь,” *Ensign* эсвэл 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 6; түүнчлэн “Гэр бүлээ бие даан хангах нь” видео бичлэгийг үзнэ үү.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Liahona*, 2010 оны 11 сар, 129

“Бие даасан амьдралтай болох нь,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 210–211

“Бие даах чадвар,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 6.1.1

Робэрт Д.Хэйлс, “Өнөөгийн дэлхийн саад бэрхшээлтэй тулгарах нь,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 30

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өмнөх долоо хоногийн хичээлээр сурсан зүйлээ хэрэгжүүлэхдээ олж авсан туршлагаасаа хуваалцаж, зааж мөн гэрчлэхэд залуу эрэгтэйчүүдийг урь.
 - Самбар дээр “бие даасан байдал” гэж бичээд, бие даах гэдгийг ямар утгатай гэж бодож байгаа талаар залуу эрэгтэйчүүдээс асуу. Тэдэнд бодож, хариулах цаг өгөөрэй.
- Чуулгаараа “Итгэлдээ үнэнч байх нь” товхимлын 210–211-р хуудсан дээрх “Бие даасан амьдралтай болох нь” хэсгийг унш. Тэд өөрсдийн уншсан зүйлд үндэслэн бие даасан байдал гэдэг үгийн тодорхойлолтод юу нэмэх вэ? Тусдаа амьдарч, нөхөр мөн аав болох үедээ биеэ даасан байхад бэлтгэхийн тулд тэд одооноос юу хийж чадах талаар залуу эрэгтэйчүүдээс асуу.

Заахад туслах арга

“Шилдэг багш нар зааж байгаа хүмүүсийнхээ сурсан зүйл, өсөлт хөгжилтийг өөрсдийн зааснаас болсон хэмээн үздэггүй. Тэд үр суулгаж, арчилдаг цэцэрлэгч адил сурах хамгийн сайн нөхцөл байдал бий болгохыг л хичээдэг. Дараа нь заасан хүмүүс нь ахиц дэвшил гаргахад тэд Бурханд талархлаа илэрхийлдэг юм” (Teaching, No Greater Call [1999], 62).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд бие даасан байдлын талаар суралцахад чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Залуу эрэгтэйчүүдийг бүлгүүдэд хуваарилаад, бүлэг бүрд боловсрол, санхүү, харилцаа холбоо, сүнслэг хүч чадал зэрэг бие даасан байдлын хэсгүүдээс нэгийг оноож өг. Бүлэг бүрийг эдгээр сэдвийн талаар дурдсан ахлагч Робэрт Д.Хэйлсийн “Өнөөгийн дэлхийн саад бэрхшээлтэй тулгарах нь” хэлсэн үгийг хэсэгчлэн судлахад урь. Залуу эрэгтэйчүүдийг юу сурснаа мөн эдгээр хэсгийн аль нэг дээр илүү бие даахын тулд юу хийхээ хуваалцахад урь.

- Жижиг цааснууд дээр тус тусад нь бие даасан байдалтай холбоотой дараах сэдвүүдийг бич: *эрүүл мэнд, боловсрол, ажил төрөл, гэрийн хүнсний нөөц, санхүү* болон *сүнслэг хүч чадал*. Залуу эрэгтэй бүрийг өөрсдийн сонирхсон сэдвийг сонгон, *Гарын Авлага 2-ын 6.1.1* (36–37 дахь хуудас) хэсгээс уг сэдвийн талаар уншихад урь. Ангийнхандаа өөрийн сурсан сэдвийн талаар, энэ нь бие даасан байдалтай ямар холбоотой талаар мөн энэ тал дээр бие даахад бэлтгэхийн тулд юу хийж чадах талаараа товчхон зааж өгөхийг залуу эрэгтэй бүрээс хүс. Залуу эрэгтэйчүүдийн өсвөр насандаа гаргаж байгаа хичээл зүтгэл нь тэднийг ирээдүйд нөхөр, эцэг хүн болох үед гэр бүлийг нь хэрхэн адисалж болох вэ?

- Чуулгын цуглааны өмнө чуулгын нэг эсвэл түүнээс дээш гишүүнийг ахмад Моронай өөрийн их цэргийг леменчүүдтэй байлдахад нь хэрхэн бэлдсэн талаар заахад бэлдэхэд урь (Алма 46–49-ийг үзнэ үү). Энд бие махбодын (Алма 43:18–21, 37–39; 48:8–9-ийг үзнэ үү) болон сүнслэг бэлтгэлийг багтааж болно (Алма 46:11–21, 48:7, 11–13-ыг үзнэ үү). Нифайчууд өөрсдийн амь нас, эрх чөлөө болон гэр бүлээ хамгаалахад энэхүү бэлтгэл нь ямар ялгаатай байсан бэ? Энэ жишээ нь залуу эрэгтэйчүүдэд бие даасан байдлын талаар юу зааж байна вэ? Хойшид тулгарч болох бэрхшээлүүдэд бэлдэхийн тулд залуу эрэгтэйчүүд одоо юу хийж болох вэ?

- Самбарын зүүн талд “Тэжээлгэгч”, баруун талд нь “Бие даасан амьдралтай болох нь” гэж бич. Уг

хоёр үгийг тодорхойлохыг залуу эрэгтэйчүүдээс хүс (хэрвээ тэдэнд тусламж хэрэгтэй бол “Итгэлдээ үнэнч байх нь” товхимлын 210–211 дахь хуудсыг үзнэ үү). Бусдаар тэжээлгэж байгаа арга зам, бие даасан байдлаа жагсаан бичихийг тэднээс хүс. Их Эзэн биднийг яагаад бие дааж сураасай хэмээн хүсдэг вэ? “Гэр бүлээ бие даан хангах нь” видео бичлэгийг үзүүл (эсвэл ахлагч Робэрт Д.Хэйлсийн “Материаллаг болон сүнсний зүйлст ухаалгаар арвилан хэмнэгч байх нь” хэлсэн үгэн дэх түүхийг уншихад залуу эрэгтэйчүүдийг урь). Хэрхэн бие даах талаар ахлагч Хэйлсийн заасан зүйлсийг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүсээд, хариултуудыг нь самбар дээр бич. Ирээдүйн гэр бүлээ тэтгэхийн тулд одооноос хийж хэвшвэл зохих дадал, хэвшлийнх нь талаар залуу эрэгтэйчүүдээс асуу. Тэд ямар зан ааштай байхаас зайлсхийх хэрэгтэй вэ? Энэ ярилцлагын нэг хэсэг болгож ахлагч Хэйлсийн хэлсэн үгийн 3-р догол мөрийг уншихад та тэднийг урьж болно.

- Залуу эрэгтэйчүүдийг хоёр хоёроор нь эсвэл жижиг бүлгүүдэд хуваана. Бүлэг бүрд энэ тоймд санал болгосон бие даасан байдлын талаарх судруудыг хуваарил. Залуу эрэгтэйчүүдийг оногдсон судрын шүлгээ уншаад, бие даасан байдлын талаар мормон сурталчилгаа гаргахад урь. New Era эсвэл *Лиахона сэтгүүлээс мормон сурталчилгааны жишээг үзүүлж болох юм*. Залуу эрэгтэйчүүдэд өөрсдийнхөө зохиосон мормон сурталчилгааг ангийнхантайгаа хуваалцах боломж олгоорой.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэдэг байсан бөгөөд тэднийг бэлтгээд, заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал хариуцлагуудыг тэдэнд оноосон. Түүний зорилго нь бусдад үйлчлэх үйлчлэлээр дамжуулан хөрвөгдөхөд нь тэдэнд туслах явдал байв. Дуулгавартай байдал хийгээд үйлчлэл нь тэднийг бие даасан байдалтай болоход бэлтгэхэд нь туслах болно гэдгийг олж харахад залуу эрэгтэйчүүдэд тусал.

- Залуу эрэгтэйчүүдээс тэд өөрдсөө болон гэр бүлийнхэн нь байгалийн гамшигт (газар хөдлөлт, хар шуурга гэх мэтэд) бэлтгэлтэй байхын тулд юу хийдгийг асуу. Ангиараа ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Сүнслэг байдлын бэлтгэл: Эртхэн эхэл, тууштай бай” хэлсэн үгийн эхний гурван догол мөрийг унш. Бидэнд

тулгарч болох зарим “сүнслэг байдлын гамшиг” эсвэл бэрхшээл юу вэ? Сүнслэг байдлын хувьд бэлтгэхийн тулд бид юу хийж чадах вэ? Ерөнхийлөгч Айрингийн хэлсэн үгээс үлдсэн хэсгийг залуу эрэгтэй бүрд өгөөд, эдгээр асуултын хариултыг хайхыг тэднээс хүс. Тэднийг уншсан зүйлээсээ хуваалцахад урь.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Тэд бие даасан байдлын талаар хэн нэгэнд тайлбарлаж чадахаар ойлогож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бие даасан байхын ач холбогдлын талаарх гэрчлэлээ болон энэ хичээл дээр хийхээр өдөөгдсөн зүйлийнхээ талаар чуулгынхантай хуваалцаж болно.

- Чуулгын залуу эрэгтэйчүүдийг хэрхэн илүү бие даасан болох талаар чуулгын цуглааны туршид мэдэрсний дагуу үйлдэхэд уриалж болно.

Сонгосон материалууд

“Халамжлах нь,” Итгэлдээ үнэнч байх нь (2004), 210–11

Нийгэм, сэтгэл санаа, сүнслэг байдал, бие махбодын болон эдийн засгийн хувьд сайн байх нь юуны түрүүнд таныг, хоёрт гэр бүл, гуравт Сүмийг сэтгэл амар байлгадаг. Их Эзэний бурханлаг нөлөөллийн дор болон мөн өөрийн ажил хөдөлмөрөөр дамжуулан та өөрийгөө болон гэр бүлээ сүнсний болон дэлхийн амьдралын шаардлагуудаар хангах нь зүйтэй.

Биеэ даасан амьдралтай байснаар та өөрийгөө болон гэр бүлээ харж хамгаалах чадвартай байх болно. Та хэцүү үед бусдаас хамааралгүй эцсээ хүртэл тэвчихээр бэлтгэгдэх ёстой.

Та (1) боловсрол эзэмшсэнээр; (2) хүнс тэжээл болон эрүүл ахуйн сайн нөхцөлд амьдарснаар; (3) боломжийн ажилд бэлтгэх болон ажилтай болсноор; (4) хуулийн дагуу хоол

хүнс, хувцас нөөцлөн бэлтгэсэнээр; (5) өөртөө байгаа нөөц баялгаа ухаалгаар зохицуулж, аравны нэг, өргөлүүдийг төлж, өрнөөс зайлсхийснээр; (6) сүнсний, сэтгэл санааны болон нийгмийн хүч чадлаа хөгжүүлснээр та биеэ даасан амьдралтай байж чадна.

Биеэ даасан амьдралтай болохын тулд та хөдөлмөрлөх хүсэлтэй байх ёстой. Их Эзэн биднийг хөдөлмөрлө хэмээн зарлигласан (Эхлэл 3:19; С ба Г 42:42-ыг үз). Чин шударга ажил нь аз жаргал, өөрийгөө үнэлэх, мөн дэвжин дээшлэхийн үндэс юм.

Хэрэв та өөрийн хүчин чармайлт эсвэл гэр бүлийнхээ гишүүдийн дэмжлэг туслалцаагаар дамжуулан өөрийн үндсэн хэрэгцээг хангах чадваргүй байвал Сүм танд тусалж болох юм. Эдгээр нөхцөл байдлуудад, Сүм ер нь таныг болон танай гэр бүлийг дахин биеэ даасан болгохоор амьдралыг дэмжих нөөцөөр хангадаг.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би хөрвөгдөж байгаа эсэхээ хэрхэн мэдэх вэ?

Хөрвөлт нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Христтэй илүү адилхан болох амьдралын турш явагдах үйл явц юм. Энэ нь зөвхөн бидний зан байдлын өөрчлөлтийг төдийгүй хүсэл сонирхол, эгэл байдлаа өөрчлөхийг хэлдэг. Энэ нь дахин төрөлт, зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт гэж Их Эзэний нэрийдсэн чухал өөрчлөлт юм (Мозая 27:25; Алма 5:14). Бид нүгэл хийх хүслээ хаяж, хайраар дүүргэгдэж, бусадтай сайн мэдээг хуваалцахыг эрэлхийлэх үедээ өөрсдийгөө Их Эзэнд хөрвөгдөж байгааг мэдэж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ямар судар болон суралцах материалууд чуулгын гишүүдэд Их Эзэнд хөрвөгдөж байгаагаа мэдэхэд туслах вэ?

Инос 1:1–19, 26–27; Мозая 5:1–5; 27:23–37; Алма 23:6–7; Хиламан 3:35; 4 Нифай 1:1–4, 15 (Хөрвөлтийн жишээнүүд)

Доналд Л.Холлстром, “Бид ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар, 53-55

Бонни Л.Оскарсон, “Бид итгэдэг үү?” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 71–73

Бонни Л.Оскарсон, “Хөрвөгдөцгөө, та нар минь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 11-р сар, 76–78

Дэвид А.Бэднар, “Их Эзэнд хөрвүүлэгдэв,” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 11-р сар, 106–109

“Хөрвөлт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 212–216

Ямар туршлагууд таны хөрвөлтийг гүнзгийрүүлсэн бэ? Та сайн мэдээний дагуу амьдрахын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөснөөр ямар өөрчлөлтүүдийг амьдралдаа харсан бэ?

Та залуу эрэгтэйчүүдийн хөрвөгдөж байгаа ямар жишээнүүдийг харсан бэ? Тэд хөрвөлтийн талаар юу ойлгох хэрэгтэй байна вэ?

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сурах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж буй ямар нэг зүйлийг хуваалцахыг хүс. Тэд яагаад үүнийг санаж байна вэ?
- Залуу эрэгтэйчүүдийг цагийн явцад хувирч өөрчлөгддөг зүйлсийг

жагсааж бичихэд урь (мод болон ургадаг үр эсвэл мэлхий болон хувирдаг шанаган хорхой байж болно). Тэд эдгээр зүйлийг бусдад хөрвөлтийн талаар заахдаа хэрхэн ашиглаж болох вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр чуулгын гишүүдэд хөрвөлтийн талаар суралцаж, өөрсдөдөө бий болж буй хөрвөлтийн нотолгоонуудыг харахад туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Хичээл орохоос цөөн хэдэн өдрийн өмнө чуулгын нэг гишүүнийг хүү Итан нь хүндээр өвдөх үед Мишээл Карнэсэскагийн туулсан туршлагыг Бонни Л.Оскарсоны “Би итгэдэг үү?” хэлсэн үгээс хуваалцах бэлтгэлтэй ирэхэд урь. Та самбар дээр “Би итгэдэг үү эсвэл итгэдэггүй юү?” гэсэн асуултыг бичиж болно. Чуулгынхныг Оскарсон эгчийн бидний итгэдэг зүйлийн талаар хэлсэн тодорхойлолтыг уншиж байх үед залуу эрэгтэйчүүдийг энэ асуултыг тунгаан бодоход урь. Чуулгын цуглааны дараа залуу эрэгтэйчүүдэд энэ үгэнд дурдсан өөрсдийн итгэдэг сайн мэдээний сургаалын тухай гэрчлэлээ хуваалцах боломж гаргаж өг. Тэд эдгээр зүйлд хэрхэн итгэдэг болсон бэ?
- *Хөрвөлт* гэж самбар дээр бичээд, залуу эрэгтэйчүүдээс хөрвөлт гэж

юу болохыг ойлгоход туслах үг, хэллэгүүдийг Мозая 27:25–26-аас олоход урь. Тэднийг эдгээр үг, хэллэгээс сурсан зүйлсээ хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдийг энэ тоймд санал болгосон хэлсэн үгсээс аль нэгийг сонгож уншаад, олсон мэдээллээ ашиглан “Би хөрвөгдөж байгаа эсэхээ хэрхэн мэдэх вэ?” асуултад хариулах зурагт хуудас хийхэд урь. Залуу эрэгтэйчүүдээс нэг нэгэндээ хөрвөлтийн тухай заахад зурагт хуудас болон судалсан хэлсэн үгээ ашиглахыг хүс.
- Залуу эрэгтэйчүүдийг Итгэлдээ үнэнч байх нь товхимол дахь “Хөрвүүлэг” хэсгээс суралцаж эсвэл энэ тойм дахь судруудыг судалж, өөрсдийнхөө хөрвөлтийн үйл явцыг үнэлж дүгнэх асуултуудыг жагсаан бичихэд урь. Чуулгын гишүүдэд уг

Заахад туслах арга

“Сонсох нь хайрын илэрхийлэл юм. Энэ нь ихэнхдээ золиослолыг шаарддаг. Бид бусдыг чин сэтгэлээсээ сонсохдоо тэдэнд өөрсдийгөө илэрхийлэх боломж олгохын тулд хэлэхийг хүсэж байгаа зүйлсээ хэлэхээ больдог” (*Teaching, No Greater Call* [1999], 66).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагчдадаа бусдад заах, үйлчлэх мөн бусдыг адислах чухал үүргүүдийг даалгасан. Түүний зорилго нь бусдад үйлчлэх үйлчлэлээрээ дамжуулан хөрвөгдөхөд нь тэдэнд туслах явдал байв. Та зааж буй Аароны санваартнууддаа үйлчилж, өсөж хөгжиж болох ямар боломжуудыг өгч чадах вэ?

жагсаалтандаа юуг, ямар учраас оруулснаа хуваалцах цагийг гаргаж өг. Эдгээр асуултад хэрхэн хариулж болох талаар бодож тунгаахад тэднийг урь.

- Энэ тоймд байгаа видео бичлэгүүдийн аль нэгийг үзүүлж,

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэд амьдралдаа хөрвөлтийг хэрхэн таньж мэдэхийг ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Удирдаж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлүүлнэ. Тэрээр:

- Илүү гүнзгий хөрвөгдөхийн ач холбогдлын тухай мэдрэмжээ хуваалцаж болно.
- Чуулгын гишүүдийг хөрвөлтөө гүнзгийрүүлэхэд нь туслах онцгой ямар нэгэн зүйлийг сонгон хийхэд урьж болно.

Сонгосон материалууд

Итгэлдээ үнэнч байх нь номны “Хөрвүүлэг” хэсгээс эш татав. (2004), 212–15

Хөрвүүлэгдсэн хүмүүсийн онцлог шинж

Их Эзэнд хөрвүүлэгдсэн хүмүүсийг Мормоны Номонд дүрслэн үзүүлдэг:

Тэд сайныг үйлдэх хүсэлтэй байдаг. Хаан Бэн-жаминь хүмүүс “Төгс хүчит Их Эзэний Сүнс ... бидэнд хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидэнд өөрөөр хэлбэл бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн” хэмээн тунхаглажээ. (Мозая 5:2) “Жигшлээс өөрөөр нүглийг үзэж эс чадах болсон” хүмүүсийн тухай Алма өгүүлсэн байдаг (Алма 13:12).

Тэд Их Эзэний эсрэг босдоггүй. Мормон, ёс бус хийгээд цусанд шунасан байсан боловч “Их Эзэнд хөрвүүлэгдсэн” хэсэг бүлэг леменчүүдийн тухай ярьсан (Алма 23:6). Эдгээр лемен хүн нэрээ Антай-Нифай-Лихайчууд болгон өөрчилж, “зөв шударга хүмүүс болсон билээ; тэд Бурханы эсрэг бас ах дүүсийнхээ хэнийх нь ч эсрэг дахин тулалдахгүйн тулд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан билээ” (Алма 23:7).

Тэд сайн мэдээг хуваалцдаг. Инос, Алма, залуу Алма, Мозаягийн хөвгүүд, Амюлек болон Зиезром нар Их Эзэнд хөрвүүлэгдсэний дараа өөрсдийгөө сайн мэдээг номлоход зориулсан юм (Инос 1:26; Мозая 18:1; 27:32–37; Алма 10:1–12; 15:12-ыг үзнэ үү).

Тэд хайраар дүүргэгдсэн байдаг. Амилсан Аврагч Америкт буй хүмүүст хүрч ирсний дараа, “Уг хүмүүс, нифайчууд болон леменчүүд аль аль нь Их Эзэнд хөрвүүлэгдэв, мөн тэдний дунд зөрчилдөөн мөн арцалдаан байсангүй, мөн хүмүүн бүр нэг нэгэнтэйгээ шударгаар харьцаж байлаа... .

“Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн зүрх сэтгэлд орших Бурханы хайрын учир, уг нутагт зөрчилдөөн огт байсангүй.

“Мөн атаа жөтөө, бас хэрүүл маргаан, бас үймээн, садар самуун ч, худал хэлэх нь ч, аллага ч, ямар ч төрлийн шунал тачаал байсангүй; мөн Бурханы мутраар бүтээгдсэн бүх хүмүүсийн дунд илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм.

“Дээрэмчид ч, алуурчингууд ч, бас леменчүүд ч, бүр ямар ч -чууд байсангүй, харин тэд, Христийн хүүхдүүд, мөн Бурханы хаант улсын өв залгамжлагчид гэгдэн нэг болсон байв” (4 Нифай 1:2, 15–17).

Агуу их хөрвүүлэгт хичээх нь

Та нар өөрсдийнхөө хөрвүүлэгт юуны түрүүнд хариуцлага хүлээнэ. Хэн ч та нарын оронд хөрвүүлэгдэхгүй бөгөөд хэн ч чамайг хөрвүүлэхээр хүчилж чадахгүй. Гэсэн хэдий ч, бусад хүн хөрвүүлгийн үйл явцад тань тусалж чадна. Гэр бүлийн гишүүд, Сүмийн удирдагчид болон багш нар, мөн судар дээрх эрэгтэй, эмэгтэйчүүдийн зөв шударга жишээнээс суралц.

Зүрх сэтгэлийн хүчтэй өөрчлөлтийг амсах боломж тань Аврагчийн төгс төгөлдөр жишээг дагахыг хичээхэд өсөн нэмэгдэх болно. Судраас суралц, итгэлээр залбир, зарлигуудыг дага, мөн Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг эрэлхийл. Хөрвүүлгийн үйл явцаа цаашид үргэлжлүүлбэл Сүнс “[тэдний] зүрх сэтгэлд нь хүчирхэг өөрчлөлтийг авчирсан” үед Хаан Бэнжаминь хүмүүсийн үйлдсэнтэй адил “хэмжээлшгүй их баяр баяслыг” та хүлээн авна (Мозая 5:2, 4 үзнэ үү). Та нар Хаан Бэнжаминь “Та нар үүрдийн аврал хийгээд мөнх амьдралыг авч болохын тулд, та нар тэнгэрт авчрагдаж болохын тулд, Христ, Төгс Хүчит Их Эзэн Бурхан та нарыг өөрийнх байлгахар лацдаж болохын тулд, та нарыг хичээнгүй мөн гуйвшгүй байж, сайн үйлүүдээр үргэлж бялхаасай” хэмээх зөвлөгөөг дагах чадвартай байх болно (Мозая 5:15).



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Ажиллаж хөдөлмөрлөх нь яагаад сайн мэдээний чухал зарчим болдог вэ?

Их Эзэн бидэнд бүү залхуур хэмээн тушаасан. Ажиллах хүсэл болон чадвараа хөгжүүлэх нь амьдарч байгаа дэлхийдээ хувь нэмэр оруулахад маань бидэнд тусалдаг. Энэ нь өөрсдийгөө үнэлэх мэдрэмжийг маань нэмэгдүүлдэг. Энэ нь одоо ч, ирээдүйд ч биднийг болон гэр бүлийг маань адисалдаг.

Та ямар нэг зүйлийг авахын төлөө ажиллаж байсан уу? Энэ нь таныг болон таны гэр бүлийг материаллаг ба сүнслэг байдлын хувьд хэрхэн адисалсан вэ?

Шаргуу хөдөлмөрлөснөөр сэтгэл хангалуун байдлыг залуу эрэгтэйчүүд хэзээ мэдэрч байсан бэ? Ажил хөдөлмөрийн олон адислалуудыг таньж мэдэн мөн хөдөлмөрлөх хүслийг хөгжүүлэхэд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судал. Ажиллахад юу таныг урамшуулдаг вэ?

Эхлэл 3:19 (Бид өөрсдийгөө хангахын тулд хөдөлмөрлөх ёстой)

Матай 25:14–30 (Талантын тухай сургаалт зүйрлэл)

Галат 6:3–5; 1 Тесалоник 4:11;
Мозая 10:4–5 (Бидэнд ажиллахыг зарлигласан)

Алма 38:12; С ба Г 58:27; 60:13; 75:29;
107:99–100 (Бүү залхуур)

Дийтр Ф.Угдорф “Эдийн засгийн хоёр зарчим,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2009 оны 11 сар, 55–58

Х.Дэвид Бэртэн “Ажил хөдөлмөрөөс ирэх адислалууд,” *Лиахона*, 2009 оны 12 сар, 36–40

“Ажил хөдөлмөр ба бие даах чадвар,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 40–41

Видео бичлэг: “Ажил урагшилж байна”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Самбар дээр өмнөх хичээлээс хоёр асуулт бичээд, залуу эрэгтэйчүүдээс түүнд хариулахыг хүс.
- Олж авахаар шаргуу ажилласан ямар нэг зүйлийн талаар ярихыг нэг залуу эрэгтэйгээс хүс. Тэр ямар золиослолуудыг гаргах хэрэгтэй байсан бэ? Тэр зорилгодоо хүрээд, ямар сэтгэгдэлтэй байсан бэ? Тэр энэ туршлагаас юу сурсан бэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдийг хөдөлмөрийн үнэ цэнийн талаар сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- “Би юу сурсан бэ?” “Энэ нь яагаад чухал вэ?” “Би юу хийж чадах вэ?” зэрэг асуултуудыг самбар дээр бич. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* авлагыг залуу эрэгтэй бүрд тараан, “Ажил хөдөлмөр ба бие даах чадвар” хэсгээс догол мөр бүрийг уншуулахаар хуваарил. Өөрт оногдсон догол мөрийг судалж, самбар дээр байгаа гурван асуултад хариулахад бэлдэхэд тэднийг урь. Ажил хөдөлмөрийн чухлыг ойлгуулсан амьдралынхаа туршлагаас хуваалцаарай.
- Залуу эрэгтэй бүрд энэхүү хөтөлбөрт санал болгосон судруудаас нэгийг уншихыг даалга. Түүнийг ангийн урд гараад, (а) судраас сурсан зүйлээ, (б) энэ нь яагаад чухал болохыг, (в) сударт заадаг зүйл бүхий өөрийн харж байсан жишээнээсээ хуваалцахыг хүс.
- Чуулгаараа Матай 25:14–30-ийг унш. Ажиллаж хөдөлмөрлөх мөн түүний үр дүнтэй холбоотой үгсийн доогуур зурж, залхуурах болон ажил хийхгүй байхын үр дүнтэй холбоотой үгсийг дугуйлахыг залуу эрэгтэйчүүдэд санал болго. Олж мэдсэн болон шаргуу ажилласан туршлагаасаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь. Тэдний хичээл зүтгэлийн үр дүн нь юу байсан бэ?
- Ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын “Эдийн засгийн хоёр зарчим” хэлсэн үгийн “Эхний зарчим: Ажил хөдөлмөр” хэсгийг унш. Ажиллаж хөдөлмөрлөх хичээл зүтгэлээс урам авахын тулд уг хэлсэн үгээс мартаггүйгээр санах эсвэл өдөр бүр уншиж байх үгсийг сонгохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. “Ажил урагшилж байна” видео бичлэгийг үзүүлж, ерөнхийлөгч Угдорфын заасан

Заахад туслах арга

“Хариултыг нь судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудаас олж болох шаардлагатай асуултуудыг асуу” (*Teaching, No Greater Call* [1999], 62).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа ойлгуулахын тулд энгийн түүх, сургаалт зүйрлэл, амьдралд тохиолдсон жишээнүүдээс хуваалцаж байлаа. Тэр тэдэнд туршлагаууд дээрээ үндэслэн сайн мэдээг нээж илрүүлэхэд нь тусалдаг байсан. Та ажил хөдөлмөрийн талаар ямар бодит жишээг хуваалцаж чадах вэ? Ажил хөдөлмөрийн талаар залуу эрэгтэйчүүд юу сурсан бэ?

зүйлсийн жишээг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд Тайлерын жишээнээс ажиллаж хөдөлмөрлөх талаар юу сурч чадах вэ? Тэд

өөрсдийнхөө зорилгод хүрэхийн тулд түүний хийсэн зүйлийг хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Тэд яагаад ажил хөдөлмөр чухал болохыг ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Өнөөдөр сурсан зүйл дээрээ үндэслэн юу хийхээр мэдэрсэн талаараа хуваалцаж болно.
- Бишопын хэлсэн, тойрогт байгаа зарим хэрэгцээ шаардлагын талаар чуулгатай хуваалцаж, эдгээрийг хангахад туслах чуулгын үйл ажиллагааг төлөвлөж болно.

Сонгосон материалууд

“Ажил хөдөлмөр ба бие даах чадвар,” Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 40–41

Ажил хөдөлмөр бол нэр төрийн хэрэг юм. Та нар хөдөлмөрлөх чадвараа хөгжүүлснээр амьдарч буй дэлхийдээ өөрийн хувь нэмрээ оруулах болно. Энэ нь та бүхэнд өөрийгөө үнэлэх хүчтэй мэдрэмжийг авчрах болно. Энэ нь та нарыг болон гэр бүлийг тань одоо мөн ирээдүйд адислах болно.

Хөдөлмөрлөж сурах нь гэр бүлээс эхэлдэг. Гэр орныхоо ажилд өөрийн хүслээрээ оролцож, гэр бүлийнхэндээ тусал. Залуу байхаасаа мөнгөө зөв зарцуулж, зээл тавилгүй амьдарч сур. Аравны нэгээ төлөн, зээл авахаас зайлсхийж, мөнгөө хадгалж сурах талаар заасан бошиглогчдын үгсийг дага.

Өндөр зорилгууд тавьж, тэдгээрийг биелүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөх хүсэлтэй бай. Сахилга баттай, хариуцлагатай бай. Сүмийн дуудлагууд, хичээл сургууль, ажил төрөл болон үр ашигтай ажилд хамгийн сайнаараа ажилла. Залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолд үйлчлэхийн тулд хэрэгтэй бүх бэлтгэлийг хийх хүсэлтэй байх ёстой. Тэнгэрлэг Эцэг та бүхэнд авьяас чадвар хайрласан бөгөөд та нарын боломжийг сайн мэддэг. Зорилгууддаа хүрэхийн тулд Түүний тусламж болон удирдамжийг эрэлхийл.

Их Эзэн биднийг бүү залхуур хэмээн тушаасан. Залхуурал нь зохисгүй ааш авир, бүтэлгүй харилцаа болон нүглүүдэд хөтөлдөг. Залхуурлын нэг шинж нь интернет, видео тоглоом болон зурагт үзэх зэрэгт дэндүү их цаг заваа зарцуулж, цагийг үр бүтээлгүй өнгөрөөх юм.

Мөрийтэй тоглоомонд цаг болон мөнгөө бүү үр. Мөрийтэй тоглоом бол цагаа зугаатай өнгөрүүлэх хэлбэр биш юм. Энэ нь хүмүүнийг донтуулдаг бөгөөд боломжуудаа алдахад хүргэж, айл гэр, амьдралыг сүйрүүлдэг. Хөдөлмөрлөхгүйгээр мөнгөтэй болно гэж итгэх нь бүтэшгүй юм.

Ажил хөдөлмөрөөс ирдэг адислалуудын нэг нь бие даах чадвараа хөгжүүлэх болно. Та нар бие даах чадвартай байхад өөрийгөө болон гэр бүлээ тэжээн тэтгэх Бурханы өгсөн адислалууд ба чадваруудаа ашиглаж, тулгарсан асуудлыг шийдвэрлэх гарцыг олдог. Бие даах чадвартай байна гэдэг нь бүх зүйлийг ганцаараа хийх чадвартай байна гэсэн үг биш ээ. Жинхэнэ ёсоор бие даах чадвартай болохын тулд бусадтай хамтарч ажиллахыг сурч, Их Эзэнд хандан, Түүний тусламж болон хүч чадлыг эрэлхийлэхийг хэлнэ.

Та нарт зориулсан агуу ажил Бурханд байдаг гэдгийг санаарай. Тэрхүү ажлыг гүйцэлдүүлэхээр хичээн чармайхад Тэрээр та нарыг адислах болно.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Их Эзэн яагаад намайг эрүүл байгаасай хэмээн хүсдэг вэ?

Эрүүл мэндийн хувьд сайн байх нь бие даасан байдлын чухал хэсэг нь юм. Эрүүл мэндээ хамгаалах нь тэнгэрлэг чадавхаа дайчилж, бусдад илүү үр дүнтэйгээр үйлчлэх боломжийг бидэнд олгоно. Бид биеэ хэрхэн тордож байгаа нь сүнслэг эрүүл мэнд болон Ариун Сүнснээс удирдамж хүлээн авах чадварт маань нөлөөлдөг. Эрүүл мэндээ хамгаалахын тулд бид мэргэн ухааны үгийг дагаж, тэжээллэг хоол идэн, тогтмол дасгал хийж мөн хангалттай унтаж байх хэрэгтэй.

Бие махбодын болон сэтгэл санааны эрүүл мэнд мөн сүнслэг эрүүл мэндийн хоорондох холбоо нь юу вэ? Эрүүл мэндээ хамгаалах нь Их Эзэнд хэрхэн илүү үр дүнтэй үйлчлэх боломжийг танд олгосон бэ? Эрүүл амьдралаар амьдрахыг хичээх явцдаа та өөр ямар адислалуудыг хүлээж авсан бэ?

Залуу эрэгтэйчүүд өөрсдийнх нь бие махбодын болон сэтгэл санааны эрүүл мэндийг хохироох ямар уруу таталттай тулгардаг вэ? Их Эзэний эрүүл мэндийн хуулийг сахиснаар ирэх адислалуудыг олж харахад та тэдэнд хэрхэн туслах вэ? Эдгээр хуулиудыг сахих нь тэдний санваарын үйлчлэлд хэрхэн нөлөөлөх вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Мэргэн ухааны үгийн талаар судрууд болон бусад материалуудаас судлахдаа оюун санаа болон бие махбодоо сайн арчлахын чухлыг мэдрэхэд нь залуу эрэгтэйчүүдэд туслах зүйлсийг мөн Их Эзэн тэднийг яагаад тийн үйлдээсэй хэмээн хүсдэг талаар эрж хайгаарай.

Даниел 1:3–20 (Даниел, түүний найзууд зарим хоолны талаарх Еврейн хуулийг дагаснаар адислагдсан нь)

С ба Г 88:124 (Бидний ажиллах ба унтах хэвшлийн талаар Их Эзэн зөвлөсөн нь)

С ба Г 89 (Их Эзэн мэргэн ухааны үгийг болон үүнийг дагаснаар ирэх адислалуудыг илчилсэн нь)

Боид К.Пакэр “Мэргэн ухааны үг: Зарчим ба амлалтууд,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 17–19

М.Рассэл Баллард “Хилэнцэт нэгний залт төлөвлөгөө,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 108–10;

түүнчлэн “Та чөлөөлөгдөх болно” видео бичлэгийг үзнэ үү.

“Бие махбод ба сэтгэл зүйн эрүүл мэнд,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 25–27

“Мэргэн ухааны үг,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 128–129

Видео бичлэг: “Бурхан тэдэнд мэдлэгийг өгсөн”, түүнчлэн *Old Testament Visual Resource DVD*-г үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлийн гарчгийг самбар дээр бичээд, санаж байгаа зүйлээсээ хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг урь.
- Самбар дээр “Их Эзэн яагаад биднийг эрүүл байгаасай хэмээн хүсдэг вэ?” гэж бич. Хичээлийн туршид боломжтой хариултуудыг хуваалцаж мөн нэмэлт хариулт олоход залуу эрэгтэйчүүдийг урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдийг Их Эзэний эрүүл мэндийн хуулийг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын 31–32 дахь хуудсыг нээж, чуулгаараа алхам 1 ба 2-ыг биелүүлэхэд залуу эрэгтэйчүүдийг урь. Биеийн эрүүл мэндээ хамгаалахад туслах өөрсдийн хувийн төслүүдээс гадна чуулгаараа хийх төсөл төлөвлөхөд тэднийг урамшуул. Өөрсдийн төлөвлөгөөний дагуу амьдрах нь тэдэнд хэрхэн нөлөөлсөн талаар хуваалцахыг төсөл хэрэгжүүлсэн залуу эрэгтэйчүүдийн нэгээс хүс. Дараагийн хэдэн долоо хоногт төлөвлөгөөгөө хэрхэн хэрэгжүүлж байгаа туршилага хуваалцахыг тэднээс хүсэх болно хэмээн залуу эрэгтэйчүүдэд хэл.
- Боломжтой бол загасны өгөөш эсвэл ялаг чуулгын цуглаанд авчрах юм уу тэдгээрийн зургийг үзүүл эсвэл “Та чөлөөлөгдөх болно” видео

Заахад туслах арга

“Та шаардлагагүй зүйлс нурушин ярьж, өөрийн бодол санааг хэт их илэрхийлэхгүй байх ёстой. Эдгээр үйлдэл нь суралцагчдын сонирхлыг бууруулдаг юм. Зааж буй хүмүүсээ зөв чиглэлд явуулах зөвлөгөө өгдөг, суралцах аяны хөтөч хэмээн өөрийгөө бод (Teaching, No Greater Call [1999], 64).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дэлхий дээр тохинуулах явцдаа Өөрийн дагалдагчдыг Түүний заасан итгэлийн дагуу үйлдэж, үнэний дагуу амьдрахыг урьсан. Өөрийн бүх сургаалдаа Тэрээр дагалдагчдаа бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Үүнийг биелүүлэхийн тулд Тэр тэдэнд зориулан үр нөлөөтэй туршлагаудаас суралцах боломжуудыг өгсөн. Та залуу эрэгтэйчүүдэд зааж байхдаа мэргэн ухааны үгийн дагуу амьдарсан туршлагаасаа хуваалцахад тэднийг уриарай.

бичлэгийг үзүүл. Загасыг мэхлэхэд өгөөш болон ялааг хэрхэн ашигладаг талаар залуу эрэгтэйчүүдээр тайлбарлуул. Мэргэн ухааны үгийг зөрчүүлэх гэж Сатан ямар аргаар залуу эрэгтэйчүүдийг хуурч мэхэлдэг вэ? Чуулгыг хоёр бүлэг болгон хуваарил. Нэг бүлгээр нь Сургаал ба Гэрээ 89:5–15-ыг уншуулж, Их Эзэний биднээс бага ашиглахыг хүссэн буюу ашиглахыг хориглосон зүйлсийг олж мэдэхийг хүс. Нөгөө бүлгээр нь шүлэг 10–20-ийг уншуулж, Их Эзэн хүмүүнд хэрэглүүлэхээр юу өгснийг олж мэдэхийг хүс. Мэдэхгүй үгсээ тодорхой болгох юм уу эсвэл мэдэж ав (“Итгэлдээ үнэнч байх нь номын “Мэргэн ухааны үг”-ийг үз 128–129). Мэхлэгдэж эсвэл уруу татагдаж болох орчноос зайлсхийхийн тулд юу хийж чадах талаараа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Самбар дээр хоёр гарчиг бич: “Сүнслэг байдлын адислалууд” ба “Бие махбодын адислалууд”. Залуу эрэгтэйчүүдийг С ба Г 89:18–21-ийг уншин, адислалуудыг олж, самбар дээрх тохирох гарчгийн дор жагсаан бичихэд урь. Эдгээр адислалуудын талаар залуу эрэгтэйчүүд юу ойлгож байна вэ? Самбар дээр бичсэн адислалуудаас алийг нь залуу эрэгтэйчүүд хүлээж авсан бэ? (Эдгээр амлалтуудыг ойлгоход тэдэнд тусламж хэрэгтэй бол ерөнхийлөгч Боид К.Пакэрийн “Мэргэн ухааны үг: Зарчим ба амлалтууд” хэлсэн үг дэх тайлбарыг лавлан үзэхийг тэдэнд санал болго).

- “Бурхан тэдэнд мэдлэг өгсөн” видео бичлэгийг үзүүлээд, Даниел болон түүний найз нар эрүүл мэндийн хуулийг сахиснаараа адислагдсан арга замуудыг эрж олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. (Залуу эрэгтэйчүүд тэдгээрийг олох бүрд нь видео бичлэгээ түр зогсоон ярилцаж болох юм.) Мэргэн ухааны үгийг дагаснаараа та хэрхэн адислагддаг вэ? гэх мэт асуултуудыг асуу. Мэргэн ухааны үгийг дагах нь санваарын үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чинь хэрхэн туслах вэ? Мэргэн ухааны үгийг дагахыг хичээж байхдаа өнөөдөр өсвөр үеийнхэн ямар бэрхшээлүүдтэй тулгардаг вэ? Тэд эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд юу хийж чадах вэ? Өөрийн амьдралд Сүнсийг байлгахын тулд мэргэн ухааны үгийг дагах нь яагаад чухал болох талаар гэрчлэлээ хуваалцаарай.

- Залуучуудын бат бөх байдлын төлөө номоос “Бие махбод ба сэтгэл зүйн эрүүл мэнд” хэсгийг уншихыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Өөрсдийнх нь олсон хэд хэдэн зөвлөгөөг зарим залуу эрэгтэйчүүдээр самбарт бичүүлж, бусдыг нь энэхүү зөвлөгөөг дагаснаар тэдэнд амлагдсан адислалуудыг жагсаан бичихийг хүс. Биеэ яаж тордож, асарч байгаа нь сүнсэнд хэрхэн нөлөөлдөг талаар ярилцахыг тэднээс хүс. Өөрсдийн жишгийг өөр шашинтай найзууддаа тайлбарлахын тулд самбар дээрх жагсаалтыг тэд хэрхэн ашиглаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр юу сурсан талаараа хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Их Эзэн яагаад тэднийг эрүүл байгаасай гэж хүсдэгийг тэд ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Ирэх долоо хоногийн туршид мэргэн ухааны үгийг даган амьдрахдаа ажигласан зарим адислалынхаа жагсаалтыг гаргахад залуу эрэгтэйчүүдийг урьж болно.
- Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номондоо эрүүл байхад туслах төсөл зохиоход (хуудас 31–34-ийг үзнэ үү) мөн уг төслөө хэрэгжүүлэхэд тохиолдсон туршлагаа хуваалцахад залуу эрэгтэйчүүдийг уриалж болно.

Сонгосон материалууд

Бойд К.Пакэр, “Мэргэн Ухааны Үг: Зарчим ба амлалтууд” хэлсэн үгээс эш татав Ensign, 1996 оны 5-р сар, 17–19

Мэргэн ухааны үгийн зарчмыг хүндэл. Тэгснээрээ та нар амлагдсан адислалуудыг хүлээн авах болно. “Бүх гэгээнтнүүд” “зарлигуудад дуулгавартай байдалд алхан, эдгээр айлдваруудыг санаж мөн хэрэгжүүлдэг бүх гэгээнтнүүд хүйсэндээ эрүүл энхийг хийгээд яснууддаа чөмөг хүлээн авах болно, мөн гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно” (С ба Г 89:18, 20) хэмээн илчлэлтээр амлалт өгөгдсөн.

Мэргэн ухааны үг та нарыг төгс эрүүл мэндтэй байлгана гэж амладаггүй, харин энэ нь сүнсний өдөөлтийг мэдрэх оюун ухаантай, хамгийн сайн нөхцөл байдалтай төрсөн та нарын бие махбодыг хэрхэн хамгаалахыг зааж өгдөг. . . .

Мөн тэгээд Мэргэн Ухааны үгэнд илүү адислал амлагдсан байдаг. Үүнийг дуулгавартай дагадаг тэдгээр нь “мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно” (С ба Г 89:19) гэсэн амлалт байдаг. Энэ бол далд байгаа сүнслэг аюултай зүйлсийг олж илрүүлэх хувийн илчлэлт юм. . . .

Энэ илчлэлтэд сүүлчийн нэгэн амлалт байгаа. Зарлигуудыг дуулгавартай дагадаг тэдгээрт хандан Их Эзэн хэлэхдээ: “Устгагч тэнгэр элч, Израилын хүүхдүүдийн дэргэдүүр өнгөрсний адил тэдний дэргэдүүр өнгөрч, мөн тэднийг хөнөөхгүй байх болно хэмээх амлалтыг . . . бибээр тэдэнд өгч байна” (С ба Г 89:21) гэжээ. Энэ бол үнэхээр гайхалтай амлалт.

Үүнийг ойлгохын тулд бид Мосегийн цаг үе рүү очих хэрэгтэй. Израилчууд 400 жилийн турш боолчлолд байв. Мосе тэднийг чөлөөлөхөөр ирсэн. Тэр Египетэд тахал тараав. Фараон Израилчуудыг чөлөөлнө гэдгийг байнга

зөвшөөрдөг байсан ч тэр хэлсэн амлалтаасаа байнга л буцдаг байв. Эцэст нь, “Эзэн Мосед, Би бас нэг гамшгийг Фараон хийгээд Египет дээр авчирна; Үүний дараа л тэр та нарыг эндээс явуулна. . . . Египетийн газрын бүх анх төрөгсөд үхэх болно” (Ег.гарсан нь 11:1, 5).

Мосе израилчуудад хандан “нэг хурга . . . авч . . . өө сэвгүй, нэг настай эр хурга байх ёстой. . . . Та нар ямар ч ясыг нь хугалж болохгүй” (Ег. гарсан нь. 12:3, 5, 46; Иохан 19:33-ыг үзнэ үү).

Тэд бас цуснаас нь авч, тэрхүү хургыг идэх айлын хаалганы баруун зүүн хатавчинд ба тотгонд цуснаас нь нялах ёстой. . . . Би тэр шөнө Египет орон даяар явж, Египетийн нутаг дахь уугануудыг, хүн, мал гэж ялгалгүй бүгдийг цохиж . . . Би Египет газрыг цохих үед цусыг хараад, та нарын дээгүүр өнгөрөх учир сүйрлийн ямар ч гамшиг та нар дээр буухгүй. . . . Мөн энэ өдөр . . . улиран үргэлжлэх зарлиг болгон . . . тэмдэглэ” (Египетээс гарсан нь. 12:7, 12–14) “Та нарын хүүхдүүд энэ . . . ямар учиртай юм бэ? гэж хэлэх үед, . . . та нар Энэ бол Эзэний Дээгүүр Өнгөрөх баярын тахил юм, гэж хэл” (Ег.гарсан нь 12:26–27).

Мэдээж, Залуу хүмүүс, та нар Дээгүүр Өнгөрөх баярын бошиглосон бэлгэдлийг харж байгаа. Христ бол сэвгүй, ууган, эр “Бурханы Хурга” (Иохан 1:29, 36). Хэдийгээр цэргүүд түүний ясыг хугалахаар ирсэн боловч Тэрээр ясаа гэмтээлгүйгээр амь үрэгдсэн байв.

Бид бүгд л үхлийг үзэх учраас хэрэв бид эдгээр зарлигуудад дуулгавартай байх аваас Дээгүүр өнгөрөх баяраар дамжуулан өршөөгдөх нь мөнх бус биеийн үхлээс өршөөгдөх тухай биш юм. Харин зовох шаардлагагүй сүнслэг үхэл гэж бий. Хэрвээ та нар дуулгавартай байвал “Христ ч гэсэн [бидний төлөө] тахил болсон” хэмээн илчлэлт заадаг тул сүнслэг үхэл та нарын дээгүүр өнгөрөх болно (1 Кор. 5:7).



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг хангах Их Эзэний арга зам юу вэ?

Есүс Христ энэ дэлхий дээр ирээд, Өөрийн тохинууллын ихэнх хугацааг ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахад зориулсан юм. Их Эзэн Өөрийн сүмээр дамжуулан тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг халамжлах арга замыг бэлдсэн. Өөрөөс нь хүлээн авсныхаа дагуу харамгүйгээр өгөхийг Тэрээр биднээс хүсдэг. “Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах Их Эзэний арга зам нь дэлхийн арга замаас өөр юм. Их Эзэн “[Ядуу хүмүүсийг халамжлах нь] миний өөрийн замаар хийгдэх ёстой” гэж хэлсэн. [Сургаал ба Гэрээ 104:16; мөн түүнчлэн 15-р шүлгийг үзнэ үү.] Тэр бидний одоогийн хэрэгцээг сонирхоод зогсохгүй, мөнхийн хөгжил дэвшлийн маань талаар бас санаа тавьдаг. Энэхүү шалтгаанаар ядуусыг халамжлагаас гадна хөршдөө үйлчилж мөн бие даасан байдалтай байх нь Их Эзэний арга замд багтсаар ирсэн юм” (Дийтр Ф.Угдорф, “Их Эзэний арга замаар хангах нь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2011 оны 11-р сар, 54).

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Их Эзэн ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хэрхэн хангадгийг ойлгоход ямар судар ба материалууд залуу эрэгтэйчүүдэд туслах вэ?

Та бусдын хэрэгцээг хангахдаа Аврагчийн жишээг дагахыг хэрхэн эрэлхийлдэг вэ? Та ямар туршлагаасаа залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүд Их Эзэний арга замаар хангах ямар зарчмуудыг ойлгох хэрэгтэй вэ? Эдгээр зарчмыг ойлгох нь санваартнуудын хувьд үйлчлэл хийхэд хэрхэн нөлөөлөх вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Исаиа 58:6–11; Малахи 3:8–10; Матай 25:35–40; С ба Г 82:18–19 (Ядуусыг халамжлах арга замууд)

Иаков 1:27; Мозая 18:27–28; С ба Г 42:29–30 (Ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах нь чухал)

Алма 34:27–28; Мормон 8:35–37; С ба Г 56:16–18; 70:14 (Их Эзэн ядуусыг халамжилдаггүй хүмүүст сэрэмжлүүлсэн)

С ба Г 104:15–18 (Их Эзэний замаар ядуусын хэрэгцээг хангах)

Патрик Кийрон, “Шуургуанаас хоргодох газар,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 99–102

Линда К.Бертон, “Намайг харь хүн байтал,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 125–128

Жэффри Р.Холланд, “Бид бүгд гуйлгачид бус уу?” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 46–49

“Ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, үйлчлэхэд гишүүдийн тавих хүч чармайлт,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 6.1.2

“Үйлчлэл,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 32–33

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлээр сурсан зүйлийг нь сануулсан саяхны тохиолдлоос хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Бишопыг чуулгын цуглаанд ирж, мацгийн өргөл болон хүмүүнлэгийн тусламж, Тасралтгүй Боловсролын Сан гэх мэт Сүмийн ариун санг хэрхэн ашигладаг талаар залуу эрэгтэйчүүдэд тайлбарлахад урь (Гарын авлага 1: Гадасны ерөнхийлөгч ба бишопууд [2010], 14.4-ийг үзнэ үү). Тусламж хэрэгтэй хүмүүсийг илүү бие даасан байдалтай болоход нь хэрхэн тусалдаг талаараа ярьж өгөхийг түүнээс хүс.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

Хэн нэг нь асуулт тавихад та өөрөө хариулахын оронд бусад хүнд хариулах боломж олгоорой. Жишээлбэл, та “Энэ маш сонирхолтой асуулт байна. Бусад нь юу гэж бодож байна вэ? эсвэл “Энэ асуултанд хариулах хүн байна уу? гэж асууж болох юм. (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Доорх үйл ажиллагаа бүр нь ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах Их Эзэний арга замаас суралцахад залуу эрэгтэйчүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Ахлагч Патрик Кийрон “Шуурга-наас хоргодох газар” хэлсэн үгэндээ “Өнөөдөр дэлхий даяар ойролцоогоор 60 гаруй сая дүрвэгч байгаа... Үүнд хамааралтай тоонуудыг авч үзээд, мөн хувь хүн бүрийн амьдралд энэ нь юу гэсэн үг болохыг бодоход л цочирдмоор байна” гэж хэлжээ. Залуу эрэгтэйчүүдэд дүрвэгчдэд тулгараад буй гамшгийг мөн тэдэнд хэрхэн туслахаа ойлгоход нь туслахын тулд энэ тойм дахь видео бичлэгүүдээс нэгийг эсвэл түүнээс олныг үзүүл. Тэд дүрвэгчдэд тулгарч буй бэрхшээлийн талаар ямар мэдрэмжтэй байна вэ? Та чуулгын

гишүүдийг жижиг бүлгүүдэд хуваарилан, ахлагч Кийроний хэлсэн үгийг эсвэл Линда К.Бертон эгчийн “Намайг харь хүн байтал” хэлсэн үгийг уншаад, дүрвэгчдэд туслахын тулд юу хийж болохоо олж мэдэхэд урь. Залуу эрэгтэйчүүдэд эдгээр зөвлөмжийг үйлдэл болгох төлөвлөгөө гаргахад тусал.

- Чуулгын гишүүдийг “Залуучуудын бат бөх байдлын төлөө” товхимлын “Үйлчлэл” хэсгийг хамтдаа уншаад, Их Эзэн биднээс яагаад үйлчлэхийг хүсдгийг олж мэдэхэд урь. Та мөн чуулгын гишүүдээс “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” номын “Бусдад үйлчил” хэсгийг (26, 50, 74-р хуудас) судлаад, энэ хэсэг дэх суралцах үйл ажиллагаан дээр тулгуурлан ярилцлагыг удирдан явуулах бэлтгэлтэй ирэхэд урьж болно. Залуу эрэгтэйчүүдэд чуулгын цуглааны үеэр тусламж хэрэгтэй хэн нэгэнд туслах хувийн болон чуулгын төлөвлөгөө гаргах цаг гаргаж өг. Чуулгын хойшдын цуглаанууд дээр төлөвлөгөөгөө биелүүлэх явцад олсон туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг хоёр хоёроор нь хуваарил. Хос болгоны нэгэнд ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангах нь чухал болох талаарх судрыг, нөгөөд нь тэднийг хайхардаггүй хүмүүст өгөгдсөн сэрэмжлүүлгийг судруудаас уншуулахаар хуваарил (санаа авахын тулд энэхүү тоймд санал болгосон судруудыг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдийг өөрсдөд нь оногдсон судруудын захиасыг сурч, хамтрагчтайгаа сурсан зүйлээ хуваалцахад урь. Ядуу болон

тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах нь Тэнгэрлэг Эцэгт яагаад чухал байдгийг тэднээс асуу. Гэр бүл, тойрог, орон нутагтаа тусламж хэрэгтэй байгаа хүмүүст тусалж болох арга замуудын талаар ярилцахад залуу эрэгтэйчүүдийг урь.

- Чуулгын гишүүдэд “Бид бүгд гуйлгачид бус уу?” хэмээх ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн үгийн хуулбарыг тарааж өг. Ахлагч Холландын ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүст туслах талаар дурдсан судрын эшлэлүүдээс нэгийг сонгохыг тэднээс хүс. Сонгосон судрын эшлэл болон энэ нь түүний хувьд юу гэсэн утгатай болохыг хуваалцахыг залуу эрэгтэй бүрээс хүс. Чуулгаараа ахлагч Холландын зөвлөгөөг дүгнэн ярилц. “Та нар өөрсдөдөө тусалдаггүй эсвэл туслах чадваргүй хүмүүст тусан, тэднийг дэмжих тус тусын үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байгааг би мэдэхгүй. Гэхдээ Бурхан үүнийг мэддэг бөгөөд Тэр шавь байх энэрэнгүй үйлсэд тань та нарыг удирдах болно гэдгийг би мэднэ.” Ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг харж хандаасай хэмээн Бурханы хүсэж буй арга замуудын талаар бодоход чуулгын гишүүдэд цаг гарга. Аврагчийн тухай мэдэрдэг зүйлсийнхээ тухай хуваалцахад тэднийг урь.

- Хүмүүст байж болох материаллаг ба сүнслэг хэрэгцээний заримаас жагсаахыг чуулгын гишүүдээс хүс. Самбар дээр “Их Эзэн ямар арга замаар ядуу болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжилдаг вэ?” гэж бич. Энэ тоймын эхэнд байгаа ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч жишээ үзүүлэгч мөн багш байсан. Тэрээр тэдэнтэй хамт залбирснаар залбирахыг заасан. Тэрээр тэднийг хайрлаж, үйлчилснээр бусдыг хайрлаж, үйлчлэхийг тэдэнд заасан. Тэрээр Өөрийнх нь зааж байгаа аргаар сайн мэдээг заахыг тэдэнд заасан. Та Түүний жишээг хэрхэн дагаж чадах вэ?

хэлсэн үгийг залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж, самбар дээрх асуултын хариултыг олж сонсохыг тэднээс хүс. Тэднийг олж мэдсэн зүйлээ

хуваалцахад урь. Ядуу, тусламж хэрэгтэй хүмүүсийг бие даах чадвартай болоход нь бид хэрхэн тусалж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэд Их Эзэний арга замаар тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах гэдэг нь ямар утгатай болохыг ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Бурханы хүүхдүүдэд үйлчилж, тэднийг өргөх санваарын үүргийнхээ талаар гэрчлэлээ хуваалцаж болно.

- Ерөнхийлөгч Томас С.Монсоны “эргэн тойрныхоо хүмүүсийн хэрэгцээг олж мэдэх сүнсний

удирдамжийн төлөө залбирч, тэдэнд туслахаар урагшилсгаая” хэмээх урилгыг хүлээж авахад чуулгын гишүүдийг урьж болно (“Биднийг дахин уулзтал Бурхан та нартай хамт байх болтугай,” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 11-р сар, 110).

Сонгосон материалууд

Ахлагч Жэффри Р.Холланд, “Бид бүгд гуйлгачид бус уу?” Ensign, 2014 оны 11-р сар, 40-41 эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 46–47-гоос эш татав

Дэлхий дээрх тэгш бус байдлыг даван туулахад асар их бэрхшээл тулгарч байгаа өнөө үед ганц эрэгтэй эсвэл ганц эмэгтэй хүн юу хийж чадах билээ дээ? Эзэн Өөрөө энэхүү асуулгад хариу өгсөн байдаг. Хүмүүс Есүсээс урваж, Түүнийг цовдлогдохын өмнө Мариа Түүний тэргүүнийг оршуулгад хэрэглэгддэг их үнэтэй тосоор тослоход Искарриотын Иудас үнэтэй тос ашигласныг нь эсэргүүцэж, “тэр эмэгтэйд дургүйцсэн” гэдэг [Марк 14:3–5; мөн Матай 26:6–9; Иохан 12:3–5-ыг үзнэ үү].

“Түүнийг орхи.

Та нар юунд түүнд төвөг удна вэ?” . . .

“Тэр хийж чадахаа л хийсэн.”

“Тэр эмэгтэй хийж чадахаа л хийсэн” гэж Есүс хэлжээ. Ямар оновчтой, товч тодорхой тайлбар вэ? Нэгэн сэтгүүлч Калькута хотын Тереза гэгч эхээс хотын үгээгүй ядуусыг аврах гэсэн бүтэшгүй үйл хэргийнх нь талаар асуужээ. Сэтгүүлч тоо баримтад тулгуурлан ярьсан бол Тереза эх ямар ч асуудлыг шийдвэрлээгүй тухай ярьжээ. Тэрхүү гайхалтай, жижигхэн эмэгтэй өөрийнх нь хийж буй үйлсэд тоо чухал биш, харин хайр чухал хэмээн эрс шийдэмгий хариулсан юм. Хүч чадлаас нь *ахадсан* хэтэрхий олон ядуу хүн байсан ч, тэрээр тусламж үзүүлэх *боломжтой* хүмүүст чадах бүхнээрээ тусалснаар Бурханыг болон бусдыг хайрла гэсэн зарлигийг дагах болно гэдгээ хэлжээ. Өөр нэгэн үед тэрээр “Бидний үйл хэрэг далайд дусал мэт өчүүхэн зүйл юм, гэхдээ бид үүнийг хийхгүй бол далай нэг

дуслаар дутна шүү дээ” гэж хэлсэн байна [Mother Teresa of Calcutta, *My Life for the Poor*, ed. José Luis González-Balado and Janet N. Playfoot (1985), 20]. Тийнхүү уг сэтгүүлч Христийн шашинтан байх нь огтхон ч тооны хойноос хөөцөлдсөн хэрэг биш гэсэн дүгнэлтэд хүрчээ. Хэрвээ диваажинд нүглээ наманчлах шаардлагагүй ерэн есөн хүнээс нүглээ наманчилсан нэг хүний төлөө илүү баярлана гэж үзвэл Бурханд тоо огт чухал биш болох нь тодорхой юм гэж тэрээр тайлбарласан юм [Малколм Магтэридж, *Something Beautiful for God* (1986), 28–29, 118–119; мөн Лук 15:7-г үзнэ үү].

Тэгэхлээр бид хэрхэн “хийж чадахаа хийх вэ?”

Нэгд, Бенжамин хааны заасанчлан, бид ядуусыг өөрсдийн золгүй нөхцөл байдлыг өөрсдөө л бий болгосон гэж үзэн, тэдэнд туслахаас татгалзах ёсгүй. Магадгүй зарим нь өөрөө өөртөө хүндрэл бэрхшээл бий *болгосон* байж болох ч бид тэдэнтэй адил зүйл хийдэггүй гэж үү? Тийм учраас л тэрхүү өрөвчхөн сэтгэлт удирдагч биднээс “Бид бүгд гуйлгачид бус уу?” [Мозая 4:19] хэмээн асуугаагүй гэж үү? Бид тусламж, итгэл найдвар, залбиралдаа хариу авах гэж гуйдаггүй билүү? Бид гаргасан алдаа дутагдал, учруулсан гай зовлонгоо уучлаач хэмээн гуйдаггүй гэж үү? Ач ивээл нь бидний сул дорой байдлыг нөхөж, нигүүлсэл нь шударга ёсыг ялан дийлээсэй хэмээн бид хүсдэггүй бил үү? Бид Бурханаас зөвхөн гуйдаг, Тэрээр харин биднийг өрөвдөн хайрлаж, хариулдаг учраас л бид нүглүүдийнхээ уучлалыг *хүлээн авдаг*. Гэсэн хэдий ч бид өөрсдөөсөө гуйх ядуусыг өрөвдөж хайрлан, тэдэнд тусалснаар л гагцхүү нүглүүдийнхээ уучлалыг *хадгалж* үлддэг хэмээн Бенжамин хаан хэлсэнд гайхах зүйл үгүй юм [Мозая 4:11–12, 20, 26-г үзнэ үү].

Сонгосон материалууд

Бид тэдэнд энэрэнгүй сэтгэлээр хандахаас гадна тусламж хэрэгтэй хүмүүсийн төлөө залбирах ёстой. Зорамчууд болон бусад цугларагсад тэднийг судрын хэллэгээр “бузар,” “новш” хэмээн үздэг байсан учраас тэд “хувцасныхаа муугийн учир” залбирлын өргөөнүүдээсээ хөөгдсөн аж. Мормоны хэлснээр тэд “дэлхийн зүйлүүдээр ядуу байв; мөн . . . зүрх сэтгэлдээ ч ядуу байсан” [Алма

32:2–3] нь үргэлж зэрэгцэн оршдог материаллаг ба сүнслэг байдлын ядуу тарчиг нөхцөлд амьдарч байсных ажээ. Алма, Амюлек хэмээх номлолын хоёр хамтрагч хувцас муутайн улмаас хөөгдсөн тэр хүмүүст та нар ямар ч нөхцөлд байсан талбайдаа болон гэр орондоо, гэр бүлтэйгээ болон зүрх сэтгэлдээ хүссэн үедээ залбирч болно гэдгийг хэлж өгдөг [Алма 34:17–27-г үзнэ үү].



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би тулгарсан бэрхшээл, асуудлуудаа шийдэх арга замыг хэрхэн олох вэ?

Тулгарсан бэрхшээл, асуудлуудаа шийдэх арга замыг олох чадвар нь бие даасан байдалд багтдаг. Эдгээр шийдлийн ихэнх нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнээс олддог. Тэнгэрлэг Эцэг маань бидэнд тулгардаг бэрхшээлүүдийн талаар мэддэг. Тэр бидэнд хайртай бөгөөд туслахыг хүсдэг. Бид судрууд болон бошиглогч, төлөөлөгчдийн үгсээс тулгарсан бэрхшээлүүдийнхээ хариултыг хайж байхдаа удирдамжийн төлөө залбирч байх хэрэгтэй.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Залуу эрэгтэйчүүдэд амьдралын бэрхшээлүүдээ даван туулахад нь сайн мэдээ хэрхэн тусалдгийг ойлгоход ямар судар, материалууд туслах вэ?

Сургаал үгс 3:5–6; Матай 11:28–30; Марк 4:36–39; Алма 7:11–13; Алма 37:35–37; 38:5 (Бэрхшээл, асуудлууд тулгарах үед Их Эзэний тусламжийг эрэлхийл)

Ричард Г. Скотт, “Итгэлээ ашиглахыг эн тэргүүнд тавь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 он 11-р сар, 92–95

Жэффри Р. Холланд, “Бие биендээ энэрэнгүй хандацгаая,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар, 40–42

“Бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэнд,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2012), 25–27

Бэрхшээл тулгарсан цаг мөчид сайн мэдээ танд тайвшрал өгөх болон шийдвэр гаргахад хэрхэн тусалж байсан бэ?

Ямар асуудал, бэрхшээлүүд залуу эрэгтэйчүүдэд тулгардаг вэ? Тэд ирээдүйд ямар бэрхшээлүүдтэй тулгарч болох вэ? Сайн мэдээний ямар зарчмууд нь эдгээр бэрхшээлийг амжилттай даван туулахад тэдэнд туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Бие даасан байдлын талаар энэ сарын туршид сурч байгаа зүйлийн дагуу амьдрахаар хичээх явцдаа өнгөрсөн долоо хоногт тохиолдсон туршлагаасаа хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Тэдний үе тэнгийн өсвөр насныханд тулгараад байгаа зарим бэрхшээл, асуудлыг нэрлэхэд залуу эрэгтэйчүүдийг уриад, тэдний хариултыг самбарт бичээрэй. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд өсвөр үеийнхний хийж болох буруу, үр дүнгүй ямар зүйлс байдаг талаар хэлж өгөхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Хичээлийн туршид тусалж чадах сайн мэдээний үнэний арга замуудыг эрэлхийлэхэд залуу эрэгтэйчүүдийг урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр тулгарсан бэрхшээлүүддээ хэрхэн шийдэл олох талаар сурахад нь чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өнөөгийн өсвөр үеийнхэнд тулгардаг нэг бэрхшээл юм уу асуудлын талаар бодоход залуу эрэгтэйчүүдийг урь. Хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы материал болон *Ensign* эсвэл *Лиакхона* сэтгүүлийн дугаараас уг асуудлыг шийдэхэд туслах сэдэв хайж, сэдвийн индексийг үзэхийг тэднээс хүс. Тухайн сэдэвтэй холбоотой хэлсэн үгсээс нэгийг сонгон, бэрхшээлээ даван туулахад нь хэн нэгэнд туслах талаар ангийнхантайгаа хуваалцахад урь. Тулгарч байгаа бэрхшээлүүддээ тусламж олохын тулд сэдвийн индексийг ашиглахад нь залуу эрэгтэйчүүдийг урамшуулаарай.
- Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлын “*Бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэнд*” хэсгийн сүүлийн хоёр догол мөрийг уншиж, өөрсдөд нь болон тэдний мэдэх хүмүүст тусалж болох зөвлөгөөг хайж олоход залуу эрэгтэйчүүдийг урь. Бид асуудалтай тулгарах үедээ эрэлхийлбэл зохих “эрүүл шийдэл гаргах аргуудын” ямар жишээнүүд байна вэ? Есүс Христийн сайн мэдээ нь шийдэх ямар аргуудыг санал болгодог вэ? Сайн мэдээ нь тодорхой нэг асуудал эсвэл бэрхшээлд хариулт өгч, тусламж болж байсан амьдралынхаа туршлагаас хуваалцаарай. Залуу эрэгтэйчүүдийг үүнтэй төстэй туршлагаасаа хуваалцахад урь.
- Ерөнхийлөгч Томас С.Монсоны дараах үгсийг хуваалцаарай: “Ах эгч дүү нар минь, өөрсдийн амьдрал

Заахад туслах арга

“Бэлтгэсэн бүх зүйлээ зааж танилцуулахын тулд сайхан өрнөж буй ярилцлагыг хурдан дуусгах гэж бүү яар. Хэдийгээр бэлтгэсэн материалаа заах нь чухал ч гэсэн, суралцагчид сүнсний нөлөөллийг мэдэрч, асуултдаа хариулт олж, сайн мэдээний талаарх ойлголтоо нэмэгдүүлж, зарлигуудыг сахих амлалтаа гүнзгийрүүлэх нь илүү чухал” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

болон зүрх сэтгэлдээ Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авах нь ямар их адислал билээ. Энэ нь амьдралын агуу асуултуудад хариулт өгдөг. Энэ нь бидний амьдралд утга учир, зорилго хийгээд найдварыг өгдөг. Өнөөдөр бид бэрхшээлээр дүүрэн цаг үед амьдарч байна. Тэнгэрлэг Эцэг маань бидэнд тулгарч байдаг бэрхшээлүүдийг мэддэг гэдгийг би та нарт баталъя. Тэр бидний хүн нэг бүрд хайртай, биднийг адисалж мөн бидэнд туслахыг хүсдэг” (“Бид энэ хуралдааныг өндөрлөх агшинд,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 5 сар, 115). Энэ тоймд буй судруудаас нэгийг уншихыг мөн өнөөдөр өсвөр үеийнхний дунд түгээмэл тохиолддог бэрхшээл, асуудалтай хэн нэгэнд энэхүү судар нь хэрхэн тусалж болох талаар хуваалцахыг залуу эрэгтэй бүрээс хүс. Тусламж хэрэгтэй үед Их Эзэнд найдах эсвэл Христэд ирэх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Залуу эрэгтэйчүүд тодорхой бэрхшээл эсвэл асуудалд туслах өөр бусад судрыг мэдэж байна уу?

Өнөөдөр сурсан зүйлсийнхээ талаар хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэд амьдралын бэрхшээлүүдийн шийдлийг Есүс Христийн сайн мэдээнээс хэрхэн олох талаар ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг өндөрлөнө. Тэрээр:

- Сайн мэдээг ойлгож, түүний дагуу амьдрах нь бэрхшээлүүдийг даван туулахад нь түүнд хэрхэн тусалдаг талаар хуваалцаж болно.

- Сэтгэцийн эсвэл сэтгэл санааны хувьд асуудалтай тулгараад байгаа өөрсдийн таньдаг хэн нэгэн хүнийхээ талаар бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ахлагч Жэффри Р.Холландын “Бие биедээ энэрэнгүй хандацгаая” хэлсэн үгийн хуулбарыг залуу эрэгтэй бүрд өг. “Та эсвэл таны хайртай хүмүүс сэтгэцийн эсвэл сэтгэл санааны хямралд орох үед та хэрхэн хандах вэ?” хэмээх түүний асуултын хариултыг олохыг тэднээс хүс. Залуу эрэгтэйчүүдийг сурсан зүйлүүдээ хуваалцаж, тэдний бодож байгаа хүнд эдгээр сургаал хэрхэн тусалж болох талаар бод.

- Чуулгын гишүүдийг өөрсдөд нь тулгарч байгаа сорилт, бэрхшээлүүдийн талаар бодож үзэхийг хүс. Ахлагч Ричард Г.Скоттын Итгэлээ ашиглахыг эн тэргүүнд тавь хэмээх хэлсэн үгэндээ дурдсан дөрвөн арга замыг самбар дээр жагсаан бичиж, сорилт бэрхшээлүүдийг даван туулахад нь тэдэнд тусалж чадна гэж бодсон нэг арга замыг сонгон судлахыг чуулгын гишүүдээс хүс. Ахлагч Скоттын зөвлөгөөнөөс сурсан зүйлээ хуваалцахад тэднийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн дагалдагчдаа судруудын талаар бодож мөн өөрсдийн асуултад хариулт олж байхыг заасан. Та залуу эрэгтэйчүүдийг амьдралын бэрхшээлүүд дэх хариултыг судрууд болон бошиглогчдын үгээс хайх хүсэлтэй байхад нь хэрхэн тусалж болох вэ?

Арванхоёрдугаар сар: Хожмын өдрүүдэд Бурханы хаант улсыг байгуулах нь

“Бурханы хаант улс урагшилж, тэнгэрийн хаант улс ирэх болтугай” (С ба Г 65:6).

Танай чуулгад харьяалагдах Аароны санваартнууд нь Аврагчийн Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэхэд туслахаар тодорхой энэ цаг үед дэлхий рүү илгээгдсэн юм. Бурханы хаант улсыг байгуулж сайн мэдээг түгээхэд ашиглаасай хэмээн Их Эзэний хүсдэг онцгой бэлэг болон авьяас тэдэнд бий. Эдгээр хичээл тэднийг сүмийн болон Бурханы хаант улсын удирдагч, багш нар болохоор бэлтгэхийн тулд сүнс-лэг бэлгүүдээ хөгжүүлэхэд нь туслах болно.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг ням гаргийн чуулгын цуглааны нэг хэсэг болгохын тулд та доорх “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” тоймыг энэ бүлэгт багтаан зааж болно.

Энэ сард сонгох тоймууд:

Би одоо хэрхэн номлогч байж чадах вэ? (Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь)

Би хэрхэн илүү сайн гэрийн багш болох вэ?

Тэнгэрлэг Эцэг намайг сүнс-лэг бэлгүүдээ хэрхэн ашиглаасай гэж хүсдэг вэ?

Би Христэд төвлөрсөн гэр оронтой болохын тулд хэрхэн бэлтгэх вэ?

Би сүмийн шинэ гишүүдэд туслахын тулд юу хийж чадах вэ?

Би идэвх султай найз нартаа сүмдээ эргэн ирэхэд нь хэрхэн туслах вэ?

Сион гэж юу вэ?

Би Их Эзэний ажлыг яаравчлуулахад хэрхэн оролцож чадах вэ?

Мючел

Өсвөр үеийнхний суралцаж байгаа зүйлтэй хол-
бон үйл ажиллагаануудыг хэрхэн төлөвлөж болох
талаар бодож үзээрэй. Өсвөр үеийнхэнд зориулсан
үйл ажиллагааны вэбсайт танд туслах болно. Эдгээр
тоймд багтсан олон үйл ажиллагааг мючелийн үйл
ажиллагаанд бас ашиглаж болно. Залуу эрэгтэйчүү-
дийн ням гарагт суралцдаг зүйлүүдийг бататгахын
тулд тохиромжтой үйл ажиллагаануудыг сонгож
мөн төлөвлөхдөө ангийн ерөнхийлөгчийн зөвлөл-
тэй хамтран ажилла.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номын
дараах хэсгүүд энэ бүлгийн хичээлүүдтэй
холбоотой:

“Сургаалыг ойлго” 18–20, 42–44, 66–68-р хуудас

“Христэд ирэхэд бүхнийг урь” 28–29, 52–53, 76–77-р
хуудас



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь

Би одоо хэрхэн номлогч байж чадах вэ?

Христэд ирэхэд бүхнийг урь гэсэн үүргийг Аароны санваартан бүрд Их эзэн өгсөн билээ (С ба Г 20:59-ийг үз). Түүнчлэн Их Эзэний бошиглогчид сүмийн зөв зохистой, үйлчлэх боломжтой залуу эрэгтэйчүүдийг бүрэн цагийн номлолд үйлчил хэмээн урьсан. Бид Христэд ирэхэд бүхнийг урь гэдэг Аароны Санваарын үүргээ биелүүлэх нь ирээдүйн бүрэн цагийн номлолын үйлчлэлд бэлтгэхэд бидэнд тусалдаг. Ийм замаар бид Бурханы хаант улсыг байгуулахад тусалдаг.

Танд сайн мэдээг бусадтай хуваалцсан ямар туршлагауд байгаа вэ? Бусад хүн тантай сайн мэдээг хэрхэн хуваалцсан бэ? Хэрэв та бүрэн цагийн номлолд үйлчилсэн бол номлолд явахад бэлтгэхийн тулд чухам юу хийсэн бэ? Эргээд бодоход, та номлолд бэлтгэхийн тулд өөр юу хийх байсан бэ?

Сайн мэдээг хуваалцах нь залуу эрэгтэйчүүдэд ямар нөлөө үзүүлэх вэ? Та номлолын ажилд одоо болон ирээдүйд бэлтгэхэд нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 28–29, 52–53, 76–77

Алма 17:2–3 (Мозаягийн хөвгүүд мацаг барьж, залбирч, судруудыг хичээнгүйлэн судалснаар номлолдоо бэлтгэсэн)

Үйлс 2, 16; Мозая 18 (Петр, Паул, Алма нар бусдыг Христэд ирэхэд урьсан нь)

М.Рассэлл Баллард, “Их Эзэнд итгэл найдвараа тавь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар, 43–45

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Дэвид А.Беднар, “Номлогч болох нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 11-р сар, 44–47

Дэвид А.Беднар, “Ирээд, хар,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 107-110

Видео бичлэгүүд: “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь,” “Номлогчийн сэтгэлгээ,” “Санваарын үүрэг: Сайн мэдээг номлох нь”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ ашигласнаар олж авсан туршлагаа хуваалцаж, зааж, гэрчлэхийг хүс.
- Залуу эрэгтэйчүүдээс Христэд ирэхэд урьж болох найз, гэр бүлийн гишүүд болон идэвх султай чуулгын гишүүний талаар залбиран бодож үзэхэд урь. Тэдгээр нэрсээ Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номондоо бичихэд урь (хуудас 28–29, 52–53, 76–77-г үзнэ үү). Хичээлийн үеэр тэдгээр хүмүүстэй сайн мэдээг хуваалцахын тулд юу хийвэл зохих талаарх бодол сэтгэгдлүүдэд хянамгай байхыг залуу эрэгтэйчүүдэд урамшуул.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Бэлтгэсэн бүх зүйлээ зааж танилцуулахын тулд сайн ярилцлагыг хурдан дуусгах гэж бүү яар. Хэдийгээр бэлтгэсэн материалаа заах нь чухал ч гэсэн суралцагчид Сүнсний нөлөөллийг мэдэрч, асуултдаа хариулт олж, сайн мэдээний талаарх ойлголтоо нэмэгдүүлэн, зарлигуудыг сахих амлалтаа гүнзгийрүүлэх нь илүү чухал” (Teaching, No Greater Call [1999], 64).

Энэ хичээлийн зорилго нь залуу эрэгтэйчүүдийг амьдралынхаа туршид номлогч байх үйлчлэлд нь бэлтгэхэд туслах явдал юм. Чуулгын цуглааны үеэр Бурханы өмнө хүлээсэн үүрэг номон дээрээ төлөвлөгөө бичих цагийг залуу эрэгтэйчүүдэд гаргаж өгөөрэй. Тэднийг бие биетэйгээ төлөвлөгөөгөө хуваалцахад урамшуулж, мөн хойшдын чуулгын уулзалтуудад номлолын үйлчлэлд бэлтгэж, бусдыг Христэд ирэхэд урихдаа ямар туршлагатай болсноо хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдэд чемодан үзүүлж, номлолдоо юу авч явах хэрэгтэй талаар ярилцахад тэднийг урь (цагаан цамц, хослол, гутал гэх мэт). Тэднээс номлолдоо авч явах хэрэгтэй ч чемоданд хийж болохгүй зүйлсийн жагсаалт гаргахыг хүс. Тэднээс Алма 17:2–3 ба Сургаал ба Гэрээ 4-өөс олсон хариултаа жагсаалтдаа нэмэхийг хүс. Номлолын үйлчлэлд бэлтгэх явцаа эдгээр зан чанарыг хөгжүүлэхийн тулд залуу эрэгтэйчүүд юу хийж болох талаар асуу.
- Чуулгын цуглаан эхлэхээс өмнө залуу эрэгтэй бүрийг сайн мэдээ амьдралыг нь адисалсан нэгэн арга замыг төлөөлж буй ямар нэг зүйл, эсвэл зураг авчрахад урь. Ахлагч Дэвид А.Беднарын “Ирээд, хар” хэлсэн үгэн дэх хөвгүүдийнх нь түүхийг чуулгын цуглааны үеэр хамтдаа унш. Дүү нь яагаад найзуудынхаа гарыг боож өгөхдөө тийм их урам зоригтой байсан бэ? Залуу эрэгтэйчүүдээс авчирсан зүйлүүдээ, эсвэл зургуудаа хуваалцаж, эдгээр зүйлийг төлөөлж буй адислалуудыг дүрслэн хэлэхийг хүс. Эдгээр адислалыг хүлээн аваагүй байгаа, таньдаг хүмүүсийнхээ талаар бодоход нь урамшуулан дэмжиж, тэдэнтэй сайн мэдээг хуваалцах төлөвлөгөө гаргахад тэднийг урь.
- Залуу эрэгтэйчүүдийг ахлагч М.Рассэлл Баллардын “Их Эзэнд

итгэл найдвараа тавь” хэлсэн үгэн дэх урилгыг (Бурханаас сүнслэгээр нөлөөлөгдөн, Түүнээс удирдамж хүсэх нь хамгийн чухал алхам гэж эхэлсэн эхний хоёр догол мөрөнд байгаа) чуулгаараа уншихад урь. Энэ урилгыг хүлээн авахдаа мэдэрсэн туршлагаа хуваалцаж, мөн залуу эрэгтэйчүүдийг туршлагаа хуваалцахад урь. Хүрч ирэхэд, мөн Христэд ирэхэд урьж чадах хэн нэгний талаар бодоход тэднийг урь.

- Самбар дээр “Бүрэн цагийн номлолд үйлчлэхэд хамгийн сайнаараа бэлтгэхийн тулд би юу хийж чадах вэ?” гэж бич. Залуу эрэгтэйчүүдээс үүнд хариулах хариултуудаа санал болгохыг хүс. Тэднийг ахлагч Дэвид А.Бэднар “Номлогч болох нь” хэлсэн үгэндээ уг асуултад хэрхэн хариулсныг олоход урь. Тэднээс энэ хэлсэн үгийг судалж, номлолд гарахаасаа өмнө номлогч болж чадах

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд номлолын үйлчлэлд одооноос бэлтгэхийн тулд юу хийж чадах талаар ойлгосон уу? Тэдэнд ямар нэмэлт бодол, сэтгэгдэл байна вэ? Энэ сургаал дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Залуу эрэгтэй бүрийг, хэн нэгнийг Христэд ирэхэд урихын тулд хийх зүйлээ *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номондоо бичихэд (28–29, 52–53, 76–77 хуудсыг үзнэ үү), дараа нь чуулгын хэдэн

арга замуудыг эрж олохыг хүс. Энэ хичээлийн тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, эдгээртэй адил туршлагауд нь тэднийг номлолын үйлчлэлд бэлтгэхэд хэрхэн туслах талаар хуваалцахыг чуулгын гишүүдээс хүс.

- Залуу эрэгтэйчүүдийг чуулгын хичээл эхлэхээс өмнө номлолын ажлын жишээг судруудаас олж, хуваалцахаар бэлдэж ирэхэд урь (энэхүү тоймд санал болгосон судруудаас сонгож болно). Тэднийг түүхүүдээ ярьж байхад нь сайн мэдээг бусадтай хуваалцах талаар юу сурсныг асуу. Түүхүүдэд дурдагдсан хүмүүс сайн мэдээг хуваалцахын тулд юу хийсэн бэ? Тэдний зааж байсан зүйлс бусдад хэрхэн нөлөөлсөн бэ? Залуу эрэгтэйчүүд эдгээр номлогчийн үлгэр жишээг дагахын тулд юу хийхээр өдөөгдсөн бэ?

гишүүнийг бичсэн зүйлсээ хуваалцахад урьж болно.

- Бүрэн цагийн номлолын үйлчлэлд бэлтгэхийн тулд юу хийхээр төлөвлөж байгаагаа хуваалцаж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрч болохын тулд, Аврагч бусдыг сурсан үнэнээ гэрчлэхэд урьдаг байсан. “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” гэж Түүнийг асуухад “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” гэж хариулснаар Петрийн гэрчлэл өссөн (Матай 16:15–16). Сайн мэдээг хуваалцах нь чуулга дахь залуу эрэгтэйчүүдийн гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би хэрхэн илүү сайн гэрийн багш болох вэ?

Санваартны хувьд бид “[өөрсдийн] үүргээ мэдэж” мөн “бүхий л хичээл зүтгэлээр ажилла” хэмээн зарлигдуулсан (С ба Г 107:99). Аароны санваартнуудын хамгийн чухал үүргүүдийн нэг нь бүх хүмүүнийг Христэд ирэхэд урих юм (С ба Г 20:59-ийг үз). Прист болон багш нар нь “гишүүн бүрийн гэрээр айлчлах” мөн “сүмийг ямагт харж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх” гэсэн нэмэлт үүрэг хариуцлагуудтай (С ба Г 20:47, 53). Эдгээр үүргээ биелүүлэх нэг арга зам бол гэрийн багшаар үйлчлэх юм. Бид заахаар томилогдсон хүмүүсээ хайрлаж, харж хандан, хүчирхэгжүүлснээр хамгийн үр дүнтэй гэрийн багш нар болно.

Чи илүү сайн гэрийн багш болохын тулд юу хийсэн бэ? Гэрийн багшлалт чиний болон бусдын амьдралыг хэрхэн адисалсан бэ? Та ямар туршлагаасаа залуу эрэгтэйчүүдтэй хуваалцаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүд гэрийн багшлалтын талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Тэд бие биентэйгээ юу хуваалцаж болох вэ?

Тэмдэглэл: Хичээлийн бэлтгэл болгож, та гэрийн багшаар үйлчилж буй чуулгын гишүүдээс гэрийн багшийн хамтрагчаа энэ хичээлд суухад урьж, хэрхэн илүү сайн гэрийн багш нар болох талаар ярилцахыг хүсэж болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон материалуудыг залбирч судал. Залуу эрэгтэйчүүдийг илүү сайн гэрийн багш болоход нь юу нөлөөлж, туслах вэ?

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь (2010), 28–29, 52–53, 76–77

Алма 18:12–40; 22:4–18 (Аммон болон Аароны жишээнүүд)

С ба Г 20:46–59 (Аароны санваартнууд Христэд ирэхэд бүхнийг урих үүрэгтэй)

Томас С. Монсон, “Жинхэнэ хоньчид,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2013 оны 11-р сар

“Гэрийн багш нарын үүрэг,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 7.4.1

“Гэрийн багшлалтын заах хэсэг,” *Teaching, No Greater Call* (1999), 145–46

Видео бичлэг: “Гэрийн багшлалт: Аароны санваартнуудыг дэмжих нь”

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр өгсөн даалгаврыг биелүүлэхийн тулд юу хийсэн талаар нь асуу.
- Залуу эрэгтэйчүүдээс гэрийн багшийн хувьд тохиолдсон эсвэл

гэрийн багш нар гэрт нь ирсэн тухай туршлагаасаа хуваалцахыг хүс. Их Эзэн яагаад санваартнуудыг гэрийн багш нар болж гэр бүлүүдэд айлчлаасай хэмээн хүсдэг вэ?

Хамтдаа суралц

Энэ хичээлийн зорилго бол залуу эрэгтэй бүрийг илүү сайн гэрийн багш болохоор төлөвлөхөд нь туслах явдал юм. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дээрээ төлөвлөгөөгөө бичих цагийг чуулганы цуглааны үеэр залуу эрэгтэйчүүдэд гаргаж өгөөрэй. Гаргасан төлөвлөгөөгөө бие биетэйгээ хуваалцахад урамшуул. Тэднийг ирээдүйд болох чуулгын хичээлүүд дээр гэрийн багшийн туршлагаасаа хуваалцахад урь.

- Залуу эрэгтэйчүүдээс хамтдаа Сургаал ба Гэрээ 20:53-ыг уншиж, гэрийн багш нар “сүмийг ямагт харж хандан, тэдэнтэй хамт байж, бэхжүүлж” чадах арга замуудыг жагсаан бичихийг (эсвэл зураг зурахыг) хүс. Залуу эрэгтэйчүүд гэрийн багшийн хувьд хэрхэн сайжирч чадах вэ? Бишоп, дээд пристүүдийн бүлгийн удирдагчийг эсвэл ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийг урьж, хэрхэн сайн гэрийн багш болж чадах талаар чуулгын гишүүдэд хандан, яриулж болно. (*Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* 52, 76-г үзнэ үү). Тэдгээр удирдагчдаас гэрийн багшлалтын талаар асуух асуултууд бодож ирэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* номын (53 болон

73-р хуудсууд) “Ажилла” хэсэг рүү орж, илүү сайн гэрийн багш болох төлөвлөгөө гаргахыг хүс.

- Залуу эрэгтэй бүрээс ерөнхийлөгч Томас С.Монсоны “Жинхэнэ хоньчид” хэлсэн үг дэх түүхүүдээс нэгийг уншихыг хүс. Хүн бүрийг самбарын өмнө гарч, түүхийг өөрийн үгээр ярьж, энэ нь илүү сайн гэрийн багш байхад хэрэгтэй юуг түүнд зааж байгааг хуваалцахыг хүс.
- Чуулгыг хоёр бүлэг болгож, бүлэг тус бүрээс гэрийн багшийн хувьд хэрхэн сайжирч болох арга замуудыг жагсаан бичихийг хүс. Хэдэн минут өнгөрсний дараа нэг бүлгээс *Teaching, No Greater Call*, 145–46 номын “Гэрийн багшлалтын заах хэсэг”-ийг уншуулж, жагсаалтдаа

Заахад туслах арга

“Та заадаг хүмүүсийнхээ асуулт, санал бодолд уриалгахан хариулах юм бол тэдэнд хичээл, ярилцлаганд оролцох өөрсдийн чадварын талаар илүү итгэлтэй болоход нь туслах болно. Жишээ нь, та “Хариулсанд баярлалаа. Их ухаалаг хариулт байна” эсвэл ... “Маш сайн жишээ байна шүү,” “Өнөөдөр та нарын хэлсэн бүх зүйлд би их талархаж байна” гэхчилэн хэлж болно (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Аврагчийн арга барилаар заах нь

Ямар ч тохиолдолд Аврагч заасан хүмүүстээ төгс үлгэр жишээ нь мөн зөвлөгч нь байсан юм. Залуу эрэгтэйчүүд та нарын болон бусад Мелкизедек санваартнуудын үлгэр жишээнээс гэрийн багшийн үүргээ гүйцэтгэх явцдаа хэрхэн суралцаж чадах вэ?

нэмэхэд урь. Нөгөө бүлгээр Гарын авлага 2-ын 7.4.1 хэсгийг уншуулж, жагсаалтдаа нэмэхийг хүс. Бүлгүүдийг жагсаалтаа хуваалцахад уриад залуу эрэгтэй бүрийг дараагийн цуглаанаас өмнө хийх нэг зүйлээ уг жагсаалтаас сонгоход урамшуул. Гэрийн багшийн айлчлалын талаар үр дүнтэй жүжиглэн бэлтгэхийг чуулгын гишүүдээс хүс.

- “Гэрийн багшлалт: Аароны санваартнуудыг урамшуулан дэмжих нь” видео бичлэгийг үзэн, Аароны санваартнууд хэрхэн гэрийн багш хийх арга замуудыг эрж олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Видео бичлэгт үзсэнтэй ойролцоо ямар туршлагаудыг залуу эрэгтэйчүүд хуваалцаж болох вэ? Залуу эрэгтэйчүүд гэрийн багшийн хувьд

сайжрахад нь туслах ямар зүйлсийг уг видео бичлэгээс суралцаж болох вэ?

- Чуулгын гишүүдийн хагасаас нь Алма 18:12–40 дэх Аммоны тухай түүхийг, нөгөө хагасаас нь Алма 22:4–18 дахь Аароны тухай түүхийг уншихыг хүс. Тэднийг илүү сайн гэрийн багш нар болохын тулд туслах Аммон болон Аароноос олж сурсан зүйлсээ хуваалцахад урь. Жишээ нь, Сүнсээр мөн хайраар заах арга, хэрэгцээнд нь тохируулан заах зүйлсээ өөрчлөх, гэрчлэлээ хуваалцах, судруудыг ашиглах, асуулт асуух зэрэг байж болно. (Энэ үйл ажиллагааг *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 219-р хуудсан дахь хувиараа суралцах үйл ажиллагаанаас авав).

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд хэрхэн илүү сайн гэрийн багш болох талаар ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулгын гишүүдийг өнөөдөр сурсан зүйлс дээрээ үндэслэж, гэрийн багшлалтын талаар богино хэмжээний танилцуулга бэлтгэхэд нь тусалж болно. Тэд ирэх чуулгын цуглаанаар бэлтгэсэн танилцуулгаа

ахлагчдын чуулгатай хуваалцаж болно.

- Олж буй туршлагаасаа ирэх долоо хоногуудад хуваалцахад тэднийг урих болно гэдгийг тайлбарлан хэлж болно.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Тэнгэрлэг Эцэг намайг сүнслэг бэлгүүдээ хэрхэн ашиглаасай гэж хүсдэг вэ?

Сүнслэг бэлгүүд нь Ариун Сүнсний хүчээр өгөгдсөн адислалууд буюу чадварууд юм. Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн хувьд бидэнд бүгдэд нь сүнслэг бэлгүүд бий. Бид бусдад үйлчилж мөн Түүний хаант улсыг байгуулахад тусалж болохын тулд Бурхан тэдгээр бэлгийг бидэнд өгдөг. Тэрээр бидэнд сүнслэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийлж, хөгжүүлэхийг зарлигласан.

Танд ямар сүнслэг бэлгүүд байдаг вэ? Тэдгээр нь таныг болон бусдыг ялангуяа таны санваарын үйлчлэлийг хэрхэн адисалсан бэ? Бусдын сүнслэг бэлгүүд таныг хэрхэн адисалсан бэ? Та өөрийнхөө сүнслэг бэлгийг хэрхэн таньж мэдсэн бэ?

Залуу эрэгтэйчүүд сүнслэг бэлгийнхээ талаар мэдэж байх нь яагаад чухал вэ? Тэд санваарын үүргээ биелүүлэхдээ сүнслэг бэлгүүдээ хэрхэн ашиглаж болох вэ? Энэ нь тэднийг ирээдүйн үүрэг хариуцлага, гэр орон, гэр бүлдээ бэлтгэхэд нь хэрхэн туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрыг болон сүнслэг бэлгийн талаарх бусад материалыг судлах үедээ залуу эрэгтэйчүүдэд бэлгээ илрүүлж, бусдын амьдралыг адислахаар ашиглахад нь туслах арга замуудыг эрж ол.

1 Коринт 12:3–27; Моронай 10:8–18; С ба Г 46:8–29 (Сүнсний бэлгүүд)

“Сүнслэг бэлгүүд,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 186–88

Дэвид А. Бэднар, “Ажиглахдаа түргэн бай,” *Ensign*, 2006 оны 12-р сар, 31–36; эсвэл *Лиахона*, 2006 оны 12-р сар, 14–20

“Сүнсний бэлгүүд,” *Сайн мэдээний зарчмууд* (2009), 137–44

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэй бүрээс өнгөрсөн долоо хоногийн хичээлийг хамгийн сайнаар илэрхийлж чадах нэг өгүүлбэр бичиж, түүнийгээ чуулгын гишүүдтэй хуваалцахыг хүс.
- Дотор нь “Сургаал ба Гэрээ 46:8–9”-ийг бичиж хийгээд бэлгийн боолтоор боосон хайрцаг ангид авчир. Хайрцаг дотор юу байж болох талаар төсөөлөхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Тэдний нэгээс хайрцгийг онгойлгож дотор нь байгаа судрыг уншихыг хүс. “Хамгийн шилдэг бэлгүүд” нь юу вэ? Тэднийг хүлээн авахын тулд бид юу хийх ёстой вэ? Залуу эрэгтэйчүүдээс энэ хичээлийн туршид эдгээр асуултыг тунгаан бодож байхыг хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь чуулгын гишүүдийг Сүнсний бэлгүүдийн тухай сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгын гишүүдийг бүлгүүдэд хуваан, энэ зааварт жагсаасан судруудаас бүлэг бүрд нэг нэг судрыг өг. Оноогдсон судруудад дурдагдсан сүнслэг бэлгүүдийг жагсаан бичиж, Бурхан бидэнд яагаад сүнслэг бэлгүүдийг өгдөг болохыг тодорхойлохыг хүс. Бүлэг бүрийн нэг залуу эрэгтэйг бүлгээрээ олсон зүйлээ хуваалцахад урь. Эдгээр бэлгээс аль нь ангийн залуу эрэгтэйчүүдэд байдаг вэ? (Патриархын адислалаа авсан залуу эрэгтэйчүүд байвал дараа нь адислалаа уншиж, тэдэнд ямар сүнслэг бэлэг өгөгдсөнийг олж мэдэхийг санал болго.) Тэд ямар бэлэгтэй байхыг хүсдэг вэ? Санваарын үүрэг хариуцлагаа илүү үр дүнтэй биелүүлэхэд нь тэдгээр бэлэг хэрхэн тусалж чадах вэ?
- Залуу эрэгтэйчүүдээс 1 Коринт 12:8–10; Моронай 10:9–16; С ба Г 46:13–25-д байдаг сүнслэг бэлгүүдийг уншиж, илүү ихийг сурах хүсэлтэй байгаа тэрхүү бэлгээ олохыг хүс. Сайн мэдээний зарчмууд номоос “Сүнсний бэлгүүд” (137–44 хуудас), Итгэлдээ үнэнч байх нь номоос “Сүнслэг бэлгүүд” (186–88 хуудас) эсвэл Сэдэвчилсэн удирдамж зэрэг материалуудыг ашиглан, сонгосон бэлгээ судлах хугацаа өг. Тэднээс ойлгосон зүйлсээ хуваалцахыг хүс. Бурханы хаант улсыг байгуулахад эдгээр бэлгийг хэрхэн ашиглаж болох вэ?
- Залуу эрэгтэйчүүдээс спортын багт байдаг өөр өөр үүргүүдийг жагсаан бичихийг хүс (хөл бөмбөгийн баг эсвэл бэйсболын баг гэх мэт). Тоглогч бүр багаа хожиход хэрхэн

Заахад туслах арга

“Хэн нэг нь асуулт асуух юм уу санал бодлоо илэрхийлэх үед түүнийг шоолж эсвэл шүүмжилж огт болохгүй, харин ч хайраар хийгээд эелдэг дөлгөөн байдлаар хамгийн сайнаар хариулахыг хичээ. Хүмүүс өөрсдийнх нь санал зөвлөгөөг үнэлж байгааг мэдэрсэн үедээ туршлага, бодол, гэрчлэлээ илүү чөлөөтэй хуваалцах болно” (Teaching, No Greater Call [1999], 64).

хувь нэмрээ оруулдаг вэ? Паул Сүмийг бие махбодтой харьцуулсан судар болох 1 Коринт 12:12–21-ийг уншихыг тэднээс хүс. Бид сүнслэг бэлгээ Бурханы хаант улсыг байгуулахад хэрхэн ашиглаж болох талаар эдгээр зүйрлэл залуу эрэгтэйчүүдэд юу зааж байна вэ? Та чуулгын гишүүдээс анзаарсан сүнслэг бэлгүүдээс жишээ болгон хуваалц (Жишээ нь, 8–10-р шүлгүүдийг эсвэл ахлагч Дэвид А. Бэднарын “Ажиглахдаа түргэн бай” хэлсэн үгийн эхэнд байгаа жагсаалтыг үзнэ үү). Бусдад үйлчилж, Бурханы хаант улсыг байгуулахад туслахдаа чуулгын гишүүд бэлгүүдээ хэрхэн ашиглан, хамтдаа ажиллаж чадах талаарх ярилцлагыг удирдахыг чуулгын ерөнхийлөгчөөс хүс.

- Залуу эрэгтэй бүрийг Итгэлдээ үнэнч байх нь номын *187–188-р хуудсыг* дахин уншиж, хөгжүүлэхийг хүсэж буй нэг юм уу түүнээс олон сүнслэг бэлгээ сонгоход урь. Тэднээс тэдгээр бэлгийг яагаад сонгосноо тайлбарлахыг хүс. Бид сүнслэг бэлгүүдээ яаж хөгжүүлдэг вэ? Залуу эрэгтэйчүүдийг С ба Г 46:7–12 болон Сайн мэдээний зарчмууд номын

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд сүнслэг бэлгүүдийн талаар илүү сайн ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Энэ долоо хоногт өөрсдөд нь байдаг сүнслэг бэлгээ ашиглан, таньдаг хэн нэгнээ адислахад залуу эрэгтэйчүүдийг урьж болно.

142–43-р хуудсан дахь “*Бид өөрсдийн бэлгүүдийг хөгжүүлж чадна*” гэсэн хэсгийг судлахад урь. Тэднээс ойлгосон зүйлсээ хуваалцахыг хүс. Сургаал ба Гэрээ 46:9-д бэлгүүдийг хэн авч чадах талаар залуу эрэгтэйчүүдэд юу зааж байна вэ?

- Энэ тоймд байгаа видео бичлэгүүдийн нэгийг үзүүлэн, залуу эрэгтэйчүүдийг чуулгын гишүүн нэг бүрд байдаг авьяасын талаар бодож, хуваалцахыг хүс (залуу эрэгтэй бүрийн сайн сайхан зан чанарын талаар хуваалцсан байхад анхаар). Залуу эрэгтэйчүүдийг Матай 25:14–30-ийг уншихад эсвэл чуулгын нэг гишүүнийг талантын тухай сургаалт зүйрлэлийг уншихад урь. Энэхүү сургаалт зүйрлэл нь Бурханы бидэнд өгсөн бэлгүүдтэй ямар хамаатай вэ? Бид санваартнуудын хувьд өөрсдийн санваарын үүрэг хариуцлагыг биелүүлэхэд мөн бусдад үйлчлэхэд авьяас чадвараа хэрхэн ашиглаж чадах вэ? Залуу эрэгтэйчүүдийг өөрсдийн бодол санааг бичихэд уриад, цөөн хэдээс нь бичсэн зүйлсээ чуулгатай хуваалцахыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нараа мэддэг байсан. Тэрээр суралцаж, өсч хөгжихөд нь тэдэнд туслах онцгой арга замуудыг мэддэг байсан. Зовж цөхөрсөн үед нь Тэрээр хэзээ ч тэднийг орхилгүй харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа (Марк 9:24-ийг үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдэд тэдний хэн болох мөн тэдэнд ямар бэлгүүд байгааг ойлгоход нь тусал. Тэдгээр бэлгээ бусдад үйлчлэхийн тулд ашиглах арга замуудыг эрж олоход урамшуул.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Ажиглахдаа түргэн бай” хэлсэн үгээс эш татав *Ensign*, 2006 оны 12-р сар, 31–36

1987 оны 10-р сард Арванхоёр Чуулгын гишүүн, Ахлагч Марвин Ж.Аштон ерөнхий чуулган дээр сүнслэг бэлгүүдийн талаар ярьсан. Тэр үед надад гүнзгий нөлөө үзүүлсэн түүний захиасыг би санаж байдаг бөгөөд түүний заасан тэдгээр зүйлс өнөөдөр ч гэсэн надад нөлөөлсөөр байна. Ахлагч Аштон хэлсэн үгэндээ олон хүмүүс сүнслэг бэлэг хэмээн авч үздэггүй тэдгээр бага мэдэгдэм сүнслэг

бэлэг—зан чанар, чадваруудын талаар жагсаан хэлсэн. Жишээлбэл: Ахлагч Аштон асуух, сонсох, намуун зөөлөн дуу хоолойг сонсож ашиглах, уйлж чаддаг байх, маргаанаас зайлсхийдэг, хүлээн зөвшөөрч чаддаг, хоосон давталтаас зайлсхийдэг, зөв шударгыг эрэлхийлдэг, Бурханаас заавар авахаар эрэлхийлдэг, шавь байдаг, бусдыг анхаардаг, тунгаан бодож чаддаг, хүчирхэг гэрчлэл хуваалцдаг, Ариун Сүнсийг хүлээн авч чаддаг байх бэлгүүдийг тодруулсан (“There Are Many Gifts,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 20-ийг үзнэ үү).



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би Христэд төвлөрсөн гэр оронтой болохын тулд хэрхэн бэлтгэх вэ?

Бурханы хаант улсыг байгуулах нь зөв шударга гэр орон, гэр бүл зохиохоос эхэлдэг. Гэр бүл нь сүмийн хамгийн чухал нэгж билээ. Сүмийн гишүүдийн хувьд бид Ариун Сүнс оршихуйц гэр орон байгуулах хэрэгтэй. Христэд төвлөрсөн гэр орон нь бидэнд нүглээс хамгаалах газар, дэлхийгээс орогнох орон, өөрсдийгөө зориулж мөн чин сэтгэлийн хайрыг мэдрэх газар болдог. Гэр маань том, жижгээсээ үл хамааран бидний “залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, суралцах өргөө, алдар суугийн өргөө, дэг журмын өргөө, мөн Бурханы өргөө байж чадна” (С ба Г 88:119).

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Залуу эрэгтэйчүүд Христэд төвлөрсөн гэр оронг бий болгохоор бэлтгэхэд ямар судар мөн хэлсэн үг тус болох вэ?

1 Нифай 1:1; Инос 1:1–3; Мозая 27:14 (Зөв шударга эцгүүдийн нөлөө)

Дуулал 127:3; Мозая 4:14–15; С ба Г 68:25–28; 88:119; 93:40 (Хүүхдүүдээ зааж, тэднийг хүмүүжүүлэхийг эцэг эхчүүдэд зарлигласан)

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129

Хэнри Б. Айринг, “Ач, зээ нартаа захих үгс,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар

Ричард Г. Скотт, “Гэр орон дахь амар амгалангийн төлөө” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 5-р сар, 29–31

Дэвид А. Бэднар, “Тэнгэрийн хүчнүүд” *Ensign* эсвэл *Лиахона* 2012 оны 5-р сар, 48–51

“Гэр бүл,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 14–15

Видео бичлэгүүд: “Эцэг хүн,” “Хүмүүжүүлэх нь: Өсвөр үеийнхний зүрх сэтгэлд хүрэх нь”

Та гэр орноо нүглийн эсрэг хамгаалалт, дэлхийгээс орогнох газар болгохын тулд юу хийдэг вэ? Та хүүхдүүд болон гэр бүлдээ сайн мэдээг заахын тулд юу хийдэг вэ?

Залуу эрэгтэйчүүдийн амьдардаг гэр орны талаар эргэцүүлэн бод. Тэднийг өөрийн зөв шударга гэр бүлтэй болоход нь туслах ямар туршлагауудыг тэд одоо сурч байна вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа

хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Өнгөрсөн долоо хоногийн хичээлийн сэдвийн асуултыг самбарт бичиж залуу эрэгтэйчүүдээс хэрхэн хариулах талаар асуу.
- Хэрэв хэн нэгэн хөгжимд (эсвэл кино, спорт) хайртай бол түүнийг гэр ямар байх талаар дүрслэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүд тэндээс юуг олж харж чадах вэ? Тэд тэнд байхдаа юу мэдрэх вэ? Тэднээс Христэд төвлөрсөн гэр ямар байх талаар юу гэж бодож байгааг нь асуу. Энэ нь юугаараа өвөрмөц байх вэ? Тэд тэндээс юуг олж харж чадах вэ? Тэд тэнд юу мэдрэх вэ? Тэднээс “Христэд төвлөрсөн гэр оронтой болохын тулд би хэрхэн бэлтгэх вэ?” гэсэн асуултад хариулахыг хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд хэрхэн Христэд төвлөрсөн гэр орон бий болгохыг ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгадаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Чуулгаараа Мозая 4:14–15-ыг хамтдаа уншаад эдгээр шүлгүүдэд гардаг Христэд төвлөрсөн гэр орон бий болгоход нь залуу эрэгтэйчүүдэд туслах зарчмуудыг олж, самбарт жагсааж бич. Энэхүү тоймд жагсаан бичсэн видео бичлэгүүдээс нэгийг эсвэл хоёуланг нь үзүүл. Үүнийг үзэхдээ өөрсдийгөө аав болчихсон байна гэж төсөөлөхийг залуу эрэгтэйчүүдэд санал болго. Бичлэг бүрийн дараа залуу эрэгтэйчүүдийг уг бичлэгийн үндсэн захиас нь юу байсныг, Христэд төвлөрсөн гэр орон бий болгоход нь туслах ямар нэмэлт зарчим сурснаа ярилцахад урь. Самбар дээр байгаа жагсаалтад эдгээр зарчмуудыг нэмж болох талаар бодолцож үзээрэй. Тэднийг эдгээр зарчмуудын жишээ болгож, өөрсдийн гэр бүл эсвэл бусдын гэр бүлийн туршлагаас хуваалцахад урь.
- Нэг залуу эрэгтэйг Сургаал ба Гэрээ 88:119-ийг чангаар уншиж, самбар дээр зөв шударга гэр бүлийн зарчмуудыг бичихэд урь. Залуу эрэгтэйчүүдийг эдгээр зарчмуудаас нэгийг сонгож, тэр зарчим нь хэрхэн зөв шударга гэр бүлд байж болох талаар бодож буй зүйлээ хуваалцахад урь. Тэднийг үзсэн туршлагаасаа хуваалцахад урамшуул. Залуу эрэгтэйчүүд тэдгээр зарчмуудыг одоогийн амьдарч буй

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал нь сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад амархан татан оруулдаг ач холбогдолтой” (*Teaching, No Greater Call* [1999], 72).

гэртээ болон ирээдүйд зохиох гэр бүлдээ ашиглахын тулд юу хийж чадах вэ? Уг ярилцлагын нэг хэсэг болгож, залуу эрэгтэйчүүдийг ахлагч Дэвид А. Бэднарын “Тэнгэрийн хүчнүүд” хэлсэн үгийн “Нөхөрт минь ойлгоход нь туслаач” хэсгээс уншихад урь. Залуу эрэгтэйчүүдээс гэртээ санваарын удирдагч байна гэдэг нь юу гэсэн үг болох талаарх бодлыг нь асуу.

- Мормоны Номон дахь хүчирхэг нөлөө үзүүлсэн эцгүүдийн үлгэр жишээнээс бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс (зарим жишээг энэ тоймд санал болгосон судруудаас үзнэ үү). Залуу эрэгтэйчүүдийг үлгэр дуурайл авахыг хүсдэг өөрсдийн эцгийн эсвэл өөр эцэг хүний зарим зан чанаруудаас жагсаахад урь. Бурханы хаант улсыг байгуулахад эцэг хүний үүрэг юу вэ? Эдгээр эцгүүд хүүхдүүддээ сайнаар нөлөөлөх ямар зүйлсийг хийсэн бэ? Залуу эрэгтэйчүүд тэдний жишээг дагахын тулд юу хийж чадах вэ?
- Гэрлэх гэж буй хосод өгөх хамгийн сайн зөвлөгөөнүүдээ самбарт

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд Христэд төвлөрсөн гэр орон хэрхэн бий болгохыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Христэд төвлөрсөн гэр оронтой болохын тулд хэрхэн бэлтгэж байгаа талаараа хуваалцаж болно.
- Гэр бүлийг нь хүчирхэгжүүлэх ямар нэгэн зүйл хийхэд чуулгын гишүүдийг урьж болно.

жагсаан бичихийг залуу эрэгтэйчүүдээс хүс. Ерөнхийлөгч Хэнри Б. Айрингийн “Ач, зээ нартаа захих үгс” хэлсэн үгийг залуу эрэгтэйчүүдэд уншуулахаар хэсэгчлэн хуваарил. Ерөнхийлөгч Айрингийн хэлсэн үгээс олсон зөвлөгөөнүүдээ самбар дээрх жагсаалтдаа нэмээд Христэд төвлөрсөн гэр орон бий болгохын тулд хэрхэн бэлтгэх талаар ярилцахыг тэднээс хүс.

- Чуулгыг бүлгүүдэд хувааж, ахлагч Ричард Ж. Скоттын “Гэр бүлийн амар амгалангийн төлөө” хэлсэн үгийг хуваарилж өг. Бүлгүүдийг уг хэлсэн үгээс оногдсон хэсгээ судлахад нь урамшуулж, тэндээс Христэд төвлөрсөн гэр орны дүрслэл болон онцлогийг эрж олоход урь. Тэднээс Христэд төвлөрсөн гэр ямар байдаг талаар олж мэдсэн зүйлсээ зургаар дүрсэлж, илэрхийлэхийг хүс. Залуу эрэгтэйчүүд одоо байгаа гэр орноо илүү Христэд төвлөрсөн гэр орон болгохын тулд юу хийж, тусалж чадах вэ? Ирээдүйд Христэд төвлөрсөн гэр орон бий болгохын тулд тэд хэрхэн бэлтгэх хэрэгтэй вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийнхөө дагалдагчдаас гүнзгий бодол төрүүлж, гүн сэтгэгдэл үлдээх асуултуудыг асуудаг байв. Тэр тэдэнд итгэж мөн тэднийг бэлтгэж байв. Залуу эрэгтэйчүүдэд зөв шударга үр удмыг өсгөж, Христэд төвлөрсөн гэр бүл зохиох нь ямар чухал болохыг ойлгоход нь хэрхэн туслах талаар бод.

Сонгосон материалууд

Хэнри Б. Айрингийн “Ач, зээ нартаа захих үгс”
хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013
оны 11-р сар

Тэнгэрлэг Эцэг бидний хүн нэг бүрийг өөр өөрөөр бүтээсэн. Бидний амьдралын туршлага өөр хэн нэгнийхтэй яг адилхан байдаггүй. Түүнчлэн ямар ч хоёр гэр бүл хоорондоо адилгүй байдаг. Тэгэхээр гэр бүлийн амьдралд хэрхэн аз жаргалыг сонгох тухай зөвлөгөө өгөхөд хэцүү байх нь гайхах зүйл биш юм. Гэхдээ бидний хайрт Тэнгэрлэг Эцэг бүх хүүхдүүддээ аз жаргалд хүрэх нэг ижил замыг бэлтгэсэн байдаг. Бидний зан чанар, амьдралын туршлагаас үл хамааран аз жаргалын ганцхан л төлөвлөгөө байдаг юм. Тэрхүү төлөвлөгөө нь Бурханы бүх зарлигуудыг дагах явдал билээ.

Гэрлэх талаар бодож байгаа ач, зээ нарыг минь оролцуулаад бид бүгдэд зориулсан нэг онцгой чухал зарлиг байдаг. Сорилт бэрхшээлүүдийг даван туулахад бидэнд тусалж, аз жаргалтай гэр бүлийг бий болгон төлөвшүүлэхэд хөтөлдөг нэгэн онцгой чухал зарлиг байдаг. Мөн энэ нь нөхцөл байдлаас үл хамааран бүх төрлийн харилцаанд хэрэгждэг бөгөөд судруудад болон орчин цагийн бошиглогчдын заасан зүйлст давтагдсан байдаг. Хайраар дүүрэн, аз жаргалтайгаар үүрд хамт амьдрахыг хүсдэг хүмүүст өгсөн Их Эзэний дараах зөвлөгөө Библид байдаг:

“Тэдний нэг болох хуульч Түүнийг сорьж

“Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ?
хэмээн асуудаг.

“Есүс түүнд, Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун
ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

“Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал
мөн.

Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн-
тэй адил юм.

“Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш
үзүүлэгчид тулгуурладаг юм” гэлээ (Матай
22:35–40).

Энэхүү энгийн үгүүдээс харвал, ямар сонгол-
тууд гэр бүлийг аз жаргал руу хөтөлдөг талаар
сурсан бүх зүйлээ нэгтгэн дүгнэхэд тийм ч хэцүү
биш юм. Би үүнийг “Ямар сонголтууд намайг
өөрийн Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх
оюун ухаанаараа хайрлахад хүргэдэг вэ?” гэсэн
асуултаар эхэлье. Миний хувьд энэ нь Их Эзэний
Цагаатгалаар дамжуулан өршөөгдөхөөс ирдэг
баяр баяслыг мэдрүүлдэг сонголтууд юм.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-аас эш
татав Ensign, 2010 оны 11-р сар, 129

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй
хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөв-
лөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Үр хүүхдүүд
нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа
үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй.
Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн
гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз
жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл,
залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр
энэрэл, өрөвч сэтгэл, хөдөлмөр ба гэр бүлээрээ
үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин
амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ
хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удир-
даж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж, гэр
бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг
нь хүүхдүүдээ хайрлан өсгөн хүмүүжүүлэх явдал
юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг
эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах
ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад
иөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох
шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэг-
тэй үед туслан дэмжвэл зохино.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би Сүмийн шинэ гишүүдэд туслахын тулд юу хийж чадах вэ?

Олон хүний хувьд Сүмийн гишүүн болох нь том сорилт байж болох юм. Үүнд хуучин найз нөхдөө орхиж, шинэ амьдралын хэв маягт дасан зохицох зэрэг нь ордог. Шинэ гишүүн бүрд найз нөхөд нь хариуцлагатай хандаж, “Бурханы сайн үгээр” тэжээх хэрэгтэй (Моронай 6:4). Бид шинэ гишүүдтэй гэрчлэлээ хуваалцаж, найзалж, хамт үйлчилснээр тэдэнд тусалж чадна.

Та шинэ гишүүдийг хүчирхэгжүүлэхэд туслахын тулд юу хийсэн бэ? Таныг баптисм хүртсэний дараа бусад хүн танд хэрхэн тусалсан бэ?

Танай чуулгад Сүмийн шинэ гишүүн залуу эрэгтэйчүүд байдаг уу? Тэд Сүмийн гишүүний амьдралд хэрхэн дасан зохицсон бэ? Бусад залуу эрэгтэй тэдэнд хэрхэн тусалсан бэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар, материалуудыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юу хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Лук 22:32; Ром 15:1–2; Моронай 6:4–5; С ба Г 81:5; 108:7 (Гэгээнтнүүдийг хүчирхэгжүүлэх)

Нийл Ф.Марриот, “Бид одоо яах вэ?” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 122–124

Нийл Л.Андэрсэн, “Хэн энэ хүүхдийг хүлээн авна, тэр нь Намайг хүлээн авдаг,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 35–38

“Найз нөхөд,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 16–17

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Залуу эрэгтэйчүүдийг хоёр хоёроороо баг болж, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа зүйлээ бие биетэйгээ хуваалцахад урь. Нэг багийг санаж байгаа зүйлсээ чуулгын гишүүдтэй хуваалцахад урь.
- Залуу эрэгтэйчүүдээс хичээлийн эхний өдөр, ямар нэг клуб болон багт элсэх, эсвэл шинэ ажилд орох зэрэг аливаа шинэ туршлагын үед төрдөг сэтгэгдлээ дүрслэхийг хүс. Тэдгээр сэтгэгдэл мэдрэмж нь Сүмийн шинэ гишүүний туршлагатай хэрхэн адилхан байж болох талаар ярилцахыг хүс. Тэднийг шинэ гишүүний хувьд эсвэл бусад шинэ гишүүнтэй харилцаж байсан тиймэрхүү туршлагаасаа хуваалцахад урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь чуулгын гишүүдэд хэрхэн шинэ гишүүдийг хүчирхэгжүүлэх талаар сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, чуулгандаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Залуу эрэгтэйчүүдийг өөрөөс нь өөр орчноос ирсэн шинэ хөрвөгчдөд хүрч тусалдаг Сүмийн нэг гишүүнийг төсөөлөх эсвэл бодоход урь. Уг Сүмийн гишүүний шинэ хөрвөгчийг халуун дотно хүлээн авахын тулд хийж болох эсвэл хийхгүй байж болох зүйлсийг залуу эрэгтэйчүүд самбар дээр жагсаан бичиж болно. Ахлагч Нийл Л.Андэрсэн “Хэн энэ хүүхдийг хүлээн авна, тэр нь Намайг хүлээн авдаг” хэмээх хэлсэн үгэндээ шинэ гишүүдэд хүрч тусалдаг хүмүүсийн тухай цөөн хэдэн түүх ярьж өгсөн бөгөөд Нийл Ф.Марриот эгч “Бид одоо яах вэ?” хэмээх хэлсэн үгэндээ шинэ хөрвөгч байхдаа нөхрийнх нь хойд эмээ өөрийг нь халуун дотно хүлээн авахад төрсөн мэдрэмжийн тухай ярьсан. Залуу эрэгтэйчүүд эдгээр түүхээс жагсаалтандаа нэмж болох ямар ямар зүйлийг сурч мэдэж болох вэ?
- Самбар дээр бусад гэгээнтнийг хүчирхэгжүүлэх үүрэг хариуцлагын талаар өгүүлсэн судрын эшлэлүүдийг (энэхүү тоймд жагсаасан судрууд зэрэг) бич. Залуу эрэгтэй бүрийг судрын нэг хэсгээс уншихад урьж, Сүмийн шинэ гишүүнд хэрхэн хамаарч болох талаар бодохыг хүс. Залуу эрэгтэйчүүдээс уншсан шүлгээ хураангуйлж самбарт бичин, зааж буй зарчимтай нь холбоотой жишээ хуваалцахыг хүс. Залуу эрэгтэйчүүдээс Сүмийн шинэ гишүүдийг хүчирхэгжүүлэх нь яагаад чухал болохыг асуу.

Заахад туслах арга

“Хичээл эхлэхээс өмнө нэг юм уу хоёр хүнийг сонгож, тэднийг нийт хичээлийг эсвэл хичээлийн гол чухал хэсгийг хураангуйлахад туслах үүднээс анхааралтай сонсож мөн бэлтгэхэд томил” (*Teaching, No Greater Call* [1999], 94).

- “Номлолын ажил ба сүмд үлдээх нь: Жеоржиа Элиас” видео бичлэгийг үзүүлж, үүнээс Жеоржиаг баптисм хүртсэний дараа түүний шинэ тойргийнхон сайн мэдээнд хүчирхэг хэвээр үлдэхэд нь туслахын тулд түүний төлөө юу хийж байгааг олж харахыг хүс. Тэд Жеоржиагийн туршлагаас шинэ гишүүдийг хүчирхэгжүүлэхэд туслах өөр юуг сурч болох вэ? Залуу эрэгтэйчүүдийг тойргийнхоо шинэ гишүүдийн талаар бодоход урь. Тэдэнд ямар асуулт байж болох вэ? Чуулгын гишүүд тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? “Шинэ гишүүдийг ариун сүм рүү нэрс авч явахад нь туслах” видео бичлэгийг энэ хичээлийн нэг хэсэг болгон үзэж, ярилцаж болно.

- Залуу эрэгтэйчүүдийг Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлын “Найз нөхөд” хэсгийг

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд шинэ гишүүдийг хэрхэн хүчирхэгжүүлэх талаар ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Шинэ гишүүдтэй найзалж, нөхөрлөхийн ач холбогдлын талаар гэрчлэлээ хуваалцаж болно.
- Залуу эрэгтэйчүүдийг *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь*

уншиж, “Жинхэнэ найз байна гэдэг нь юу гэсэн үг вэ?” гэсэн асуултын хариултыг эрж олоход урь. Тэднээс олсон зүйлээсээ хэн нэгэн тэдний жинхэнэ найз нь байсан туршлагыг хуваалцахыг хүс. Ялангуяа Сүмийн шинэ гишүүдийн сайн найз байх нь бидний хувьд яагаад чухал байдаг вэ? Залуу эрэгтэйчүүдийг өөрсдийн мэдэх шинэ гишүүдийн жагсаалтыг гаргаж, *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд заасан зөвлөгөөг хэрхэн ашиглах талаар ярилцахыг хүс.

- Чуулгын гишүүдээс *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 253-р хуудасны дараах суралцах үйл ажиллагаанаас нэгийг хийж дуусгахыг хүс. Тухайлбал: “Хувиараа суралцах” үйл ажиллагаа ба “Хамтрагчтайгаа суралцах” үйл ажиллагаа.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийнхөө дагалдагчдад хүчирхэг туршлагаудаараа дамжуулан суралцах боломжуудыг олгож байв. Тэрээр нифайчуудад айлчлах үедээ тэднийг Өөрийг нь харж, мэдэрч, мэдэж болохын тулд нэг нэгээрээ ирэхийг урьсан. Залуу эрэгтэйчүүдэд заах үедээ тэднийг шинэ гишүүдийн найз нь болох, тэдэнд үйлчлэх, мөн тэдэнтэй гэрчлэлээ хуваалцах арга замуудыг эрж олоход урь.

Сонгосон материалууд

Нийл Ф.Марриот, “Бид одоо яах вэ?” Ensign, 2016 оны 4-р сар, 10 эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 122–123

Намайг төрөхөд эцэг эх минь гэрийн ард талын цэцэрлэгт замбага цэцгийн мод тарьсан бөгөөд өвөг дээдсийнхээ Протестант сүмд хийх хуримын ёслол дээр замбага цэцэг дүүрэн байгаасай хэмээн төлөвлөж байлаа. Гэтэл хуримын өдөр миний хажууд эцэг эх минь ч, замбага цэцэг ч байгаагүй. Сүмд ороод нэг жил болсон хөрвөгчийн хувьд би ариун сүмийн хишгээ хүртэж, сүйт залуу Дэвидтэйгээ лацдан холбогдохоор Юта мужийн Солт Лэйк хот руу аялсан юм.

Би Луизана мужаас гараад, Юта руу дөхөх үед өөрийн гэх гэр оронгүй мэт мэдрэмжинд эзэмдүүлж билээ. Хуримынхаа өмнө би үеэл эгч Кэрол гэж хайрлан дурсдаг Дэвидийн хойд эмээгийн гэрт үлдэх байсан юм.

Ютаг мэдэхгүй би танил бус нэгэн гэр бүлтэй мөнхөд лацдан холбогдохынхоо өмнөхөн үл таних нэгний гэрт хонох гэж байв. (Би ирээдүйн ханиа болон Их Эзэнийг хайрлаж, тэдэнд итгэдэг байсан нь ямар сайн хэрэг байсан гээч.)

Үеэл эгч Кэролийн үүдэнд очоод зогсож байхад надад нуугдмаар санагдаж байлаа. Хаалга нээгдэх үед би аймхай туулай шиг зогсож байсан ба үеэл эгч Кэрол нэг ч үг хэлэлгүй гараа дэлгэн, намайг тэврэв. Өөрийн гэх хүүхэдгүй тэр эгч надад өөрийн гэх хүн хэрэгтэй байсныг хайр халамжаар дүүрэн зүрх сэтгэлдээ мэдэрсэн байлаа. Тэр мөч ямар их тайвшрал, тааламжтай мэдрэмжийг авчирсан гэж санана! Миний айдас замхарч, сүнсэлэг байдлын хувьд аюулгүй газар бөхлөгдсөн мэт сэтгэгдэл төрсөн юм.

Хайр гэдэг нь яг л үеэл эгч Кэрол шиг өөрсдийн амьдралд хэн нэгэнд зориулан зай гаргахыг хэлдэг.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би идэвх султай найзуудаа Сүмдээ эргэн ирэхэд нь хэрхэн туслах вэ?

Санваартан бидний үүрэг хариуцлагын нэг хэсэг нь Сүмдээ ирэхгүй байгаа чуулгын гишүүд, найзууддаа туслах явдал юм. Ерөнхийлөгч Монсон биднийг “явж бусдыг авар” гэж үргэлж захидаг (“Аврах нь,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2001 оны 5-р сар, 48). Бид идэвх султай найзууддаа чин сэтгэлийн хайр халамжийг мэдрүүлж, үйлс болон үгсээрээ гэрчлэлээ хуваалцаж, үйл ажиллагаануудад урьж оролцуулснаар тэдгээр найздаа тусалж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон бусад материалыг залбирч судал. Та залуу эрэгтэйчүүдтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Лук 15 (Алдагдсан хонь, зоос болон үрэлгэн хүүгийн тухай сургаалт зүйрлэл)

Алма 31:34–35; С ба Г 18:10, 14–16 (Бодгалиудын үнэ цэн агуу юм)

С ба Г 20:46–47, 53–55 (Аароны санваарын үүрэг хариуцлагууд)

Мэрвин Б.Арнолд, “Аврах ажил: Бид үүнийг хийж

чадна,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 39–41

Томас С.Монсон, “Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2012 оны 11-р сар, 68–71

Дийтр Ф.Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2013 оны 11-р сар

Танд идэвх султай хүмүүст тусалж байсан ямар туршлага байгаа вэ? Та тэдгээр туршлагаасаа залуу эрэгтэйчүүдийг идэвх султай найзууддаа хүрч туслахад нь тус болох юуг сурч авсан бэ?

Чуулгын ямар гишүүд тогтмол ирдэггүй вэ? Чуулгын гишүүд тэдний талаар юу мэдэж байгаа вэ? Та чуулгын гишүүдийг тэдэнд хүрч туслахад хэрхэн нөлөөлж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршлагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү.

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр өгсөн даалгаврыг биелүүлэхийн тулд юу хийсэн талаар асуу.
- Энэхүү тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, идэвх султай найз юм уу гэр бүлийн гишүүнийг сүмд эргэн ирэхэд тусалсан талаарх туршлагаа хуваалц. Залуу эрэгтэйчүүдээс Алма 31:34–35 болон Сургаал ба Гэрээ 18:10, 14–16-г уншихыг хүс. Эдгээр түүх болон судар нь Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүдийн талаар юу мэдэрдгийг хэрхэн зааж байна вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь идэвх султай найзаа хэрхэн хүчирхэгжүүлэхэд суралцахад нь чуулгын гишүүдэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу, түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

Заахад туслах арга

“Сонсох нь хайрын илэрхийлэл юм. Энэ нь ихэнхдээ золиослол шаарддаг. Бид бусдыг чин сэтгэлээсээ сонсохдоо, тэдэнд өөрсдийгөө илэрхийлэх боломж олгохын тулд хэлэхийг хүсэж байсан зүйлээ хэлэлгүй үлддэг” (Teaching, No Greater Call [1999], 66).

- Залуу эрэгтэйчүүдийг үнэ цэнтэй ямар нэгэн зүйлээ алдаж байсан үеэ бодоход урь. Түүнийгээ олохын тулд тэд юу хийсэн бэ? Лук 15-д гарч буй гурван сургаалт зүйрлэлээс нэг нэгийг уншихыг чуулгын гишүүдээс хүс. Сургаалт зүйрлэлийг өөрийн үгээр тайлбарлаж, Аврагчийн зааж буй зүйлийг хураангуйлсан өгүүлбэрийг хуваалцахад тэднийг урь. Залуу эрэгтэйчүүд эдгээр сургаалт зүйрлэлд гарч буй хоньчин, эмэгтэй, эцэг гурвын үйлдлээс юу сурч авсан бэ? Залуу эрэгтэйчүүд чуулгаас нь “алдагдсан” хэн нэгэнд туслахдаа тэдний үлгэр жишээг хэрхэн дагаж чадах вэ? Идэвх султай байсан хэдий ч Сүмдээ эргэж ирсэн найзын юм уу, гэр бүлийн гишүүдийн талаар ямар нэг туршлага байвал хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.
- Залуу эрэгтэйчүүдээс Сургаал ба Гэрээ 18:10–13-ыг уншиж, энэ өгүүлбэрийг хэрхэн гүйцээн бичиж болох талаар асуу: “Бодгалийн үнэ цэнэ агуу, учир нь ...” Залуу эрэгтэйчүүдээс Сургаал ба Гэрээ 20:46–47, 53–55-ыг судалж, санваарын үүрэг хариуцлагынх нь талаар дүрсэлж буй үг, хэллэгийг самбар дээр жагсааж бичихийг хүс. Эдгээр үгээс чухам аль нь идэвх султай чуулгын гишүүнд туслах арга замуудыг дүрсэлж байна вэ? Залуу эрэгтэйчүүд идэвх султай чуулгын гишүүнд хүрч туслахын тулд юу хийж чадах талаарх ярилцлагыг удирдан явуулахыг чуулгын ерөнхийлөгчөөс хүс.
- Чуулгын нэг гишүүнийг урьдчилан Ахлагч Мэрвин Б.Арнолдын “Аврах ажил: Бид үүнийг хийж чадна” хэмээх хэлсэн үгийг уншихад

урь. Түүнээс онцгой сэтгэгдэл төрүүлсэн нэг эсвэл хоёр түүхийг хуваалцах бэлтгэлтэй ирэхийг хүс. Залуу эрэгтэйчүүдийг эдгээр түүх нь хэрхэн тэдэнд чуулгын гишүүдийн хувьд хамааралтай болохыг ярилцахад урь. Тэд сүмд ирэхгүй байгаа хэнийг мэддэг вэ? Тэр хүнийг Аврагчид ойртон ирэхэд туслахын тулд тэд чуулгаараа хэрхэн хамтран ажиллаж чадах вэ? Та мөн залуу эрэгтэйчүүдийг Ахлагч Арнолдын хэлсэн үгэн дэх дөрвөн үндсэн зарчмыг олж мэдэхэд урьж болно. Тэд эдгээр зарчмыг үлгэрлэн харуулдаг хүмүүсийг мэдэх үү? Тэд энэ хүмүүстэй адилхан байхын тулд юу хийж болох вэ?

- Хүмүүсийн Сүмд ирэхгүй байгаагаар тайлбарладаг зарим шалтгааныг самбар дээр бич. Жишээ нь: “Би Сүмийн сургаалуудын талаар эргэлзэж байна,” “Би Сүмийн хүмүүстэй таарахгүй,” “Би өөрийгөө Сүмийн жишгүүдийн дагуу амьдарч чадна

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд идэвх султай найзуудаа хүчирхэгжихэд хэрхэн туслах талаар ойлгож, мэдэж авсан уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Идэвх султай гишүүдийг сүмийн болон мючелийн үйл ажиллагаанд урих тодорхой арга замуудын талаар чуулгын гишүүдтэй ярилцаж болно.

гэж бодохгүй байна,” “Би Сүмийн хоёр нүүртэй, нэг гишүүнийг мэддэг” гэх мэт. Залуу эрэгтэйчүүдээс ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Ирж, бидэнтэй нэгд” хэлсэн үгээс эдгээр асуудлын талаарх түүний хариултуудыг хайж олохыг хүс. Хэрэв тэдний найзад эдгээр асуудлын аль нэг нь тохиолдсон бол тэд хэрхэн хариулж болох талаар жүжигчлэн үзүүлэх боломжийг залуу эрэгтэйчүүдэд олго.

- Залуу эрэгтэй бүрийг ерөнхийлөгч Томас С.Монсоны “Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур” хэлсэн үгэн дэх түүхүүдээс аль нэгийг уншиж, идэвх султай найзаа Сүмдээ эргэж ирэхэд нь хэрхэн туслах талаар уг түүх түүнд юу зааж байгааг хуваалцахад урь. Ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг хэрэгжүүлж болох арга замын талаар ярилцахыг чуулгын гишүүдээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа хайртай байсан бөгөөд тэдний төлөө залбирч, тэдэнд байнга үйлчилдэг байсан. Танай чуулгын хэнд илүү анхаарал, хайр, залбирал хэрэгтэй байгаа вэ? Та тэдэнд хүрч туслахын тулд юу хийж чадах вэ?

Сонгосон материалууд

Томас С. Монсон, “Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур,” *Ensign*, 2012 оны 11-р сар, 68–69 эсвэл 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 79–80.

Эдүгээ багахан итгэлтэй эсвээс огт итгэлгүй үй түмэн хүн байна. Хэрвээ бид тэдэнтэй гэрчлэлээ хуваалцаж, өөрчлөгдөхөд нь туслах талаар хүчин чармайлт гаргавал тэд бат бөх гэрчлэлтэй болж чадна. Зарим тохиолдолд *бид* хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөхөд урам дэм өгч чадна. Би сайн мэдээнд бүрэн дүүрэн итгэлтэй болж хараахан амжаагүй байгаа гишүүдийн талаар эхлээд ярья.

Олон жилийн өмнө Финляндын Хельсинкид болсон бүсийн чуулганы ээж, охидын хуралдаан дээр би нэгэн гайхалтай, сэтгэлд хоногшин үлдсэн, сүнслэг үгийг сонсож билээ. Түүнээс хойш бараг 40 жил өнгөрсөн ч би тэр захиасыг огт мартдаггүй. Үг хэлэгч тэр эмэгтэй олон үнэний тухай ярьсан. Тэрээр бас бусад хүнийг эмэгтэй хүнд хандаж, өөрт нь тэр бол сайхан, нүдэнд дулаахан эмэгтэй, нийгэмд үнэ цэнтэй хүн гэж хэлж байх хэрэгтэй гэж хэлж билээ.

Ах нар аа, эрчүүд энэ талаараа эмэгтэйчүүдтэй их адилхан гэдгийг би мэднэ. Эрэгтэйчүүд ч бас нийгэмд үнэ цэнтэй, чадварлаг, чухал хүмүүс хэмээн хэлүүлэх хэрэгтэй байдаг. Эрэгтэйчүүд бидэнд үйлчлэх боломж олгох хэрэгтэй. Бид идэвхгүй эсвэл дахин идэвхтэй болох талаар эргэлзэж байгаа гишүүдэд туслах арга замыг залбирч эрэлхийлэх ёстой. Боломжтой үйлчлэл хийхийг тэднээс хүсэх нь дахин идэвхтэй болоход нь тэдэнд хэрэгтэй хөшүүрэг байж болно. Гэвч энэ талаар тусалж чадах удирдагчид заримдаа ийнхүү туслахдаа дурамжхан байдаг. Хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг бид байнга санах хэрэгтэй. Тэд муу зуршлаа орхиж чадна. Тэд гэм нүглээ наманчилж чадна. Тэд санваараа зохистой авч явж, Их Эзэнд хичээнгүйлэн үйлчилж чадна. Би хэдэн жишээ дурдъя.

Би анх Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болоод ерөнхийлөгч Дэвид О.Маккэйн зөвлөх, ерөнхийлөгч Н.Элдон Таннэрыг Канадын Альбертад болсон нэгэн гадасны чуулганд дагалдан явсан юм. Хуралдааны үеэр гадасны ерөнхийлөгч ахлагчаар томилогдох шаардлага хангасан дөрвөн ахын нэрийг уншлаа. Эдгээр эрэгтэй ерөнхийлөгч Таннэрын таньдаг хүмүүс байв. Учир нь тэр энэ нутагт хэсэг зуур амьдарч байсан ажээ. Гэвч ерөнхийлөгч Таннэр тэднийг урьд нь ямар байсныг санаж байсан ч, харин тэдний амьдрал өөрчлөгдөж, ахлагч болох шаардлагыг бүрэн хангасан гэдгийг мэдээгүй байжээ.

Гадасны ерөнхийлөгч эхний хүний нэрийг хэлээд, түүнийг босно уу гэв. Ерөнхийлөгч Таннэр “Түүнийг хар л даа. Би түүнийг ингэж өөрчлөгдөнө гэж хэзээ ч бодоогүй” гэж надад шивнэн хэллээ. Гадасны ерөнхийлөгч хоёр дахь хүний нэрийг дуудахад тэр хүн бослоо. Ерөнхийлөгч Таннэр намайг аяархан ёворч, мөн л гайхсанаа илэрхийлэв. Энэ нь дөрвөн ахын бүгд дээр давтагдлаа.

Хуралдааны дараа эдгээр дөрвөн ахад баяр хүргэх завшаан ерөнхийлөгч Таннэр бид хоёрт олдсон билээ. Хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг тэд үнэхээр харуулсан юм.

1940, 1950-иад оны үед Америкийн шоронгийн харгалзагч Клинтон Даффи шоронгийнхоо хоригдлуудыг ердийн амьдралд дасгах хүч чармайлтаараа нэрд гарч байлаа. Түүний санаачлагыг шүүмжлэгч нэгэн “Ирвэс толбоо арилгаж чаддаггүй гэдгийг та мэддэг байлгүй дээ” гэхэд

харгалзагч Даффи “Би ирвэсүүдтэй ажилладаггүй. Би хүмүүстэй ажилладаг, хүмүүс өдөр бүр өөрчлөгддөг гэдгийг та мэдвэл зохино” гэж хариулсан гэдэг [in Bill Sands, *The Seventh Step* (1967), 9].



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

СИОН ГЭЖ ЮУ ВЭ?

Их Эзэн бидэнд “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн” хэмээн зарлигладаг (С ба Г 6:6). Сион гэдэг нь нэг зүрх сэтгэл, нэг оюунтай зөв шударга байдалд оршин суудаг Их Эзэний хүмүүс юм. Бид гэр орон, тойрог, салбар, оршин суугаа газрынхаа хамт олны дунд эв нэгдэл, сүнслэг байдлыг хөгжүүлснээр Сионыг байгуулж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалуудыг залбирч судал. Сионыг байгуулахын тулд залуу эрэгтэйчүүдэд юу нөлөөлөх вэ?

Мозая 18:21; С ба Г 38:27 (Бид нэгдмэл байдлыг эрэлхийлэх хэрэгтэй)

4 Нифай 1:1–18 (Нифайчууд болон Лэмэнчүүд Сионы адил хамт амьдарч байв)

С ба Г 6:6; 11:6; 12:6; 14:6 (Сионы ашиг сонирхлыг төлөвшүүлэхийг эрэлхийл)

С ба Г 97:21; Мосе 7:18 (Сион гэж юу вэ?)

Хэнри Б.Айринг, “Бидний зүрх сэтгэл нэг болж холбогдсон”

Ensign эсвэл *Лиахона*, 2008 оны 11-р сар, 68–71

Д.Тодд Кристоффэрсон, “Сионд ирэгтүн,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 11-р сар, 37–40

“Сион,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 173

Видео бичлэгүүд: “Дэйтоны хөл,” “Христийн гэрлийг хуваалцах нь”

Та амьдралдаа болон гэр бүлдээ Сионы зарчмуудаар амьдрахын тулд хэрхэн хичээдэг вэ? Та гэр бүлдээ эсвэл тойрогтоо хэзээ нэгдмэл байдлын сүнсийг мэдэрсэн бэ?

Чуулгын тань залуу эрэгтэйчүүд нэгдмэл байдаг уу? Сионыг байгуулахын тулд тэд юу хийж чадах вэ? Ямар саад бэрхшээлтэй тэд тулгарч магадгүй вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Суралцах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Чуулгын гишүүн бүрийг “Миний хувьд өнгөрсөн долоо хоногт суралцсан зүйлс маш чухал байсан учир нь ...” гэсэн өгүүлбэрийг гүйцээж бичихэд урь:
- Сион гэж самбар дээр бичээд залуу эрэгтэйчүүдээс Сионы талаар бодох үед тэдний бодолд юу орж ирдгийг жагсаан бичихийг хүс. Тэднээс Итгэлдээ үнэнч байх нь номны 173-р хуудсыг уншихыг хүс. Сионыг байгуулахад санваартнууд бидний үүрэг юу вэ?
- Сион гэж самбар дээр бичээд залуу эрэгтэйчүүдээс Сионы талаар

Хамтдаа суралц

Доор өгөгдсөн үйл ажиллагаанууд чуулгын гишүүдийг Сионы талаар сурахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, чуулгандаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Мосе 7:18–19-ыг хамтдаа уншиж, Сионы өөр нэгэн нэрийг ол. Залуу эрэгтэйчүүдээс “Ариун хот” нь ямар байж болох талаар төсөөлөхийг хүс. Одоо бидний амьдарч байгаа дэлхийгээс юугаараа өөр байж болох вэ? Ариун хотод байхааргүй зүйлс болон ариун хотод байх тэдгээр зүйлсийг самбарт жагсааж бичихийг тэднээс хүс. 4 Нифай 1:1–18-аас уг жагсаалтад нэмж болох зүйлсийг олохыг урь. Сионыг байгуулахын тулд хувь хүний талаасаа, гэр бүл болон чуулгадаа бид юуг өөрчлөх шаардлагатай вэ?
- С ба Г 6:6; 11:6; 12:6; 14:6-г уншиж, шүлэг бүрд гарсан адилхан хэллэгийг олохыг залуу эрэгтэйчүүдээс хүс. Залуу эрэгтэйчүүд Сионы ашиг сонирхлыг төлөвшүүлэх гэсэн нь юу гэсэн утгатай болохыг хэрхэн ойлгож байна вэ? Энэ зааварт санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг нь үзүүлж, чуулгын гишүүдээс уг бичлэгт гарч буй залуу эрэгтэйчүүд хэрхэн Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлж байгаа арга замуудыг эрж олохыг хүс. Тэдгээр залуу эрэгтэйчүүдийн хандлага болон хүсэл нь тэдэнд ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ? Тэд Сионыг төлөвшүүлэхэд туслахын тулд эдгээр залуу эрэгтэйчүүдийн үлгэр жишээг хэрхэн дагаж чадах вэ?
- Чуулгаараа ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Сионд ирэгтүн” хэмээх хэлсэн үгийн эхний таван догол мөрийг уншихдаа “Вавилоноос зугтаж Сионд ирэх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?” гэсэн асуултад хариулт эрж хай. Чуулгыг гурван бүлэг болгож, бүлэг бүрд уг хэлсэн үгийн “Эв нэгдэл,” “Ариун байдал,” болон “Ядуусыг халамжлах нь” гэсэн хэсгүүдийг уншихыг даалга.

Заахад туслах арга

“Бид ямар нэгэн тодорхой эх үүсвэргүй үг хэллэгийг сүмийн удирдагчид хэлсэн мэт тайлбарлаж болохгүй. Судраас эш татах үедээ бид тэдгээр судруудын заалт нь бидний ашиглаж буй хэрэгцээтэй нийцэж байгаа эсэхэд анхаарах ёстой. (Teaching, No Greater Call [1999], 53).

Чуулга болон гэртээ Сионыг барьж байгуулахын тулд эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд хийж чадах зүйлсээ бүлгээрээ ярилцахад урь. Ярилцсан зүйлсээ чуулгын бусад гишүүдтэй хуваалцахад урь.

- Чуулгыг хоёр бүлэг болго. Нэг бүлэгт нь Мозая 18:21 болон С ба Г 38:27, нөгөө бүлэгт нь С ба Г 97:21, Мосе 7:18-ыг уншиж ярилцахаар даалга. Бүлгүүдийг судраас сурсан зүйлсээ ангийн бусад гишүүдтэй хуваалцахдаа үзүүлэн ашиглахаар төлөвлөхөд тусал (тэдэнд тусламж хэрэгтэй бол Teaching, No Greater Call -ын 163–64-аар хуудасны “Comparisons and Object Lessons” хэсгийг хуваалц). Тэднээс санаануудаа өөр хоорондоо хуваалцахыг хүс. Гэр бүлээрээ, чуулгаараа, тойрог буюу салбараараа нэгдмэл байхын адислалууд нь юу вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд Сион гэж юу болох талаар ойлгож мэддэг үү? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Чуулга эсвэл найз нөхдийнхөө хүрээнд хамрагдахгүй байгаа мэт байдаг хэн нэгнийг олж үйлчлэхийг чуулгын гишүүдээс хүсч болно.

- Чуулгаараа С ба Г 38:27-г хамтдаа унш. Их Эзэн биднээс яагаад нэгдмэл байгаасай хэмээн хүсдэг вэ? Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Бидний зүрх сэтгэл нэг болж холбогдсон” хэлсэн үгийг залуу эрэгтэйчүүдэд хэсэг болгон хуваан өгч, тэднээс гэр бүл болон чуулгадаа илүү эв нэгдэлтэй байхад туслах ерөнхийлөгч Айрингийн заасан зарчмуудыг олохыг хүс. Залуу эрэгтэйчүүдийг олж авсан зарчмуудаа самбарт бичихэд урь. Залуу эрэгтэйчүүдэд эв нэгдэлтэй байхад саад болдог ямар бэрхшээлүүд байдаг вэ? Тэд тэдгээр саад бэрхшээлийг хэрхэн даван гарч чадах вэ? Гэр бүлдэх нэгдмэл байдлаа өсгөхийн тулд эдгээр зарчмуудаас нэгийг нь хэрэгжүүлэх хувийн зорилго тавихад нь залуу эрэгтэйчүүдийг урамшуул. Чуулгаараа илүү нэгдмэл байхын тулд ижил зорилго тавьж хамтдаа ажилла.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заахаар бэлтгэхдээ залбирал болон мацаг барихад цаг гаргаж, Тэнгэрлэг Эцэгийн зааврыг эрэлхийлдэг байв. Та залуу эрэгтэйчүүдэд гэр бүл, чуулга, орон нутагтаа Сионыг байгуулах тухай заахаар бэлтгэхдээ Аврагчийн үлгэр жишээг хэрхэн дагах вэ?



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би Их Эзэний ажлыг яаравчлуулахад хэрхэн оролцож чадах вэ?

Бид Их Эзэн Өөрийнхөө амлалтыг биелүүлж буй эцсийн өдрүүдэд амьдарч байна: “Болгоогтун, бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” (С ба Г 88:73). Аароны санваартнууд энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Бид сайн мэдээг хуваалцаж, Христийнхтэй адил үйлчлэлийг үзүүлж, санваарын ёслолуудыг зохистой гүйцэтгэн, шинэ гишүүдийг хүчирхэгжүүлж, идэвх султай гишүүдийг аварч, нас барагсдын төлөөх авралын ёслолуудыг гүйцэтгэснээр бүх хүнийг Христэд урин, уг ажилд оролцож чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ямар судар болон суралцах материалууд залуу эрэгтэйчүүдийг Их Эзэний ажлыг яаравчлуулахад оролцоход нь урамшуулан дэмжих вэ?

Исаиа 11:9; 1 Нифай 13:37; 14:14 (Их Эзэний ажлын тухай бошиглолууд)

Мозая 28:1–3 (Мозаягийн хөвгүүд сайн мэдээг заах хүсэлтэй байв)

Мосе 1:39 (Бурхан Өөрийн ажлыг тодорхойлдог)

С ба Г 20:46–60 (Аароны санваартнуудын үүргүүд)

С ба Г 138:56 (Бурханы итгэлтэй хүүхдүүд Сүнсний дэлхийд байхдаа Их Эзэний талбайд хөдөлмөрлөхөөр бэлтгэгдсэн)

Томас С.Монсон, “Бусдад үйлчлэх хүсэлтэй, мөн зохистой байх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 66–69

Дийтр Ф.Угдорф, “Та сэргээлтийн ажлын үеэр унтаж байна уу?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 58–62

С.Гиффорд Нийлсэн, “Их Эзэний тоглоомын дүрмийг яаравчлан дага,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар, 33–35

Авралын ажлыг яаравчлуулах нь

Өнөө үед Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулж байгаа ямар нотолгоог та харсан бэ? Залуу эрэгтэйчүүдийг энэ ажилд идэвхтэй оролцоход нь урамшуулан дэмжиж болох ямар туршлагауудыг та хуваалцаж чадах вэ?

Та Их Эзэний ажилд илүү үр дүнтэй оролцоход туслах ямар авьяас, чадварыг залуу эрэгтэйчүүдээс олж харсан бэ? Тэд энэ ажилд оролцохын тулд юуг хийгээд эхэлчихсэн байгаа вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Залуу эрэгтэйчүүдээр удирдуул

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн (эсвэл санваарын чуулгын бишопын туслах) цуглааныг удирдана. Тэд залуу эрэгтэйчүүдтэй чуулгын ажил хэргийн талаар хамтдаа зөвлөлдөж, тэдэнд санваарын үүрэг хариуцлагын талаар (судруудаас болон Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номоос) заах ба Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ туулсан туршилагаасаа хуваалцахад урьж мөн зөвлөхийг эсвэл чуулгын өөр гишүүнийг сайн мэдээний хичээл заахад урина. Чуулгын цуглааны хөтөлбөр хуудсыг ерөнхийлөгчийн зөвлөлийн цуглааны үеэр бөглөснөөр бэлдэж болно.

Сурах үйл явцаа эхэл

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийг тоймлон дүгнэхийн хамт энэ долоо хоногийн хичээлийг заахдаа доорх санаануудаас сонгох юм уу өөрийн санааг хэрэглэнэ үү:

- Залуу эрэгтэйчүүдээс өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ ашигласнаар олж авсан туршлагаа хуваалцахыг мөн зааж, гэрчлэхийг хүс.
- Самбар дээр *Их Эзэний ажил гэж юу вэ?* гэж бич. Чуулгын гишүүдийг самбарын дэргэд хүрч ирэн, уг асуултад тохирох хариултуудыг бичихэд урь. Тэднийг уг хичээлээс сурсан зүйлээ энэ жагсаалтад нэмэхийг урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр залуу эрэгтэйчүүдэд *Их Эзэний ажлыг яаравчлуулахад хэрхэн оролцож болохоо олж мэдэхэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:*

- *Яаравчлуулах* гэдэг үгийг самбар дээр бичиж, хэн нэгнээс Сургаал ба Гэрээ 88:73-ыг уншихыг хүс. Чуулгыг ямар нэгэн зүйлийг яаравчлуулах гэдэг нь юу гэсэн утгатай болохыг хоорондоо ярилцахад урь (хэрэв шаардлагатай бол тэд толь бичгээс энэ үгийг харж болно). Яагаад Их Эзэний ажлыг энэ үед яаравчлуулах ёстойг залуу эрэгтэйчүүдээс асуу.
- Тэднийг хариултаа уг тоймд санал болгосон судруудаас эсвэл өөр судруудаас олоход урь.
- Залуу эрэгтэйчүүдээс LDS.org дахь Авралын ажлын яаравчлуулах нь хэсэгт зочилж, тэнд байгаа зарим эх сурвалжийг үзэхийг хэдэн өдрийн өмнөөс хүс. Тэднийг чуулгын уулзалтад ирэхдээ Их Эзэний ажилд илүү бүрэн дүүрэн

Заахад туслах арга

“Танд хандан ярьж буй хүнд та сонирхон сонсож байгаагаа харуулах ёстой. Та хичээлийн материал эсвэл анги доторх аливаа зүйлс рүү биш харин ярьж буй хүн рүүгээ харах хэрэгтэй. Ярьж байгаа хүнийхээ яриаг таслахгүйгээр бодол санаагаа бүрэн илэрхийлэхэд та урамшуулан дэмжих ёстой. Та түүнийг сонсож дуусалгүйгээр зөвлөгөө өгөх эсвэл шүүмжлэхээс зайлсхийх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 66).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч дагалдагчдаасаа тунгаан бодож, гүнзгий мэдрэмж төрүүлэх асуултуудыг тавьдаг байсан. Түүнийг өөрсдөд нь хайртайг мэддэг байсан учраас тэд бодол санаагаа нээлттэй хуваалцдаг байв. Та чуулгын гишүүдийн бодол санаа, хариу-туудыг чин сэтгэлээсээ сонсож, мөн анхааралтай сонсож байгаагаа тэдэнд харуулснаар Аврагчийн хайрыг мэдрэхэд нь тэдэнд туслах болно.

оролцоход тэднийг урамшуулан дэмжсэн зүйлсийг энэ сайтаас хуваалцах бэлтгэлтэй ирэхэд урь.

- Залуу эрэгтэйчүүдийг уг тоймд байгаа чуулган дээр хэлсэн үгсээс аль нэгийг уншиж, тэднийг Их Эзэний ажилд илүү бүрэн дүүрэн оролцоход урамшуулан дэмжсэн хэсгийг олоход урь. Тэднээс олсон зүйлсээ хуваалцаж, яагаад тэднийг урамшуулсныг тайлбарлахыг хүс.

Залуу эрэгтэйчүүдээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд юу мэдэрч, ямар сэтгэгдэлтэй байна вэ? Тэд Их Эзэний ажлыг яаравчлуулахад хэрхэн оролцохоо ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хөтөлж байгаа залуу эрэгтэй цуглааныг хаах болно. Тэрээр:

- Их Эзэний ажилд оролцох нь түүний гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлсэн мөн уг хичээлийн үр дүнд юу хийх өдөөлт хүлээн авснаа чуулгатай хуваалцаж болно.

- Чуулгаараа ахлагч С.Гиффорд Нийлсэний “Их Эзэний тоглоомын дүрмийг яаравчлан дага” хэлсэн үгийг уншаад, түүний тодорхойлсон тоглоомын дүрмийг ол. Чуулгын ерөнхийлөгчийг сайн мэдээг хуваалцаж, чуулгын гишүүдийг аварч, ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажлыг хийх зэрэг Их Эзэний ажилд илүү бүрэн дүүрэн оролцоход чуулгын гишүүддээ туслахын тулд “тоглоомын дүрмийн” тухай ярилцахад урь.

- Чуулгын гишүүдийг Их Эзэний ажлыг яаравчлуулахын тулд чуулгаараа болон хувиараа ямар нэгэн онцгой зүйлийг хийхийг сонгоход урь.

Сонгосон материалууд

Ахлагч С.Гиффорд Нийлсэн “Их Эзэний тоглоомын дүрмийг яаравчлан дага!” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Би америк хөл бөмбөг тоглодог байхдаа аливааг тоглоомын дүрэмтэй холбон боддог байж билээ. Бид зөв дүрмийн дагуу тоглоомонд оролцох юм бол хожих нь гарцаагүй гэдэгт би хэзээ ч эргэлзэж байгаагүй. Энэ бол агуу мэдрэмж. Гэтэл саяхан би Бригам Янгийн Их Сургуулийн домогт дасгалжуулагч Лавэлл Эдвардстай тоглоомын дүрмийн талаар ярилцаж байхад тэрээр “Оноо авч л байвал та нар тоглоомын аль дүрмийг ашиглах нь надад огт сонин биш байсан!” гэж хэлж билээ. Түүний багийн ахлагч байсны хувьд би түүнтэй санал нийлээгүй ч түүний нэрээр нэрлэгдсэн цэнгэлдэх хүрээлэн байдаг нь энэхүү энгийн хандлагатай нь хамааралтай байж болох юм гэж бодогдсон билээ.

Бид бүгдээрээ Их Эзэний багт тоглодог. Иймээс хожил авчрах тоглоомын дүрэм бидэнд байна уу? Сүмийн гишүүдийн хувьд бид гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагсаддаа үнэхээр хайртай л юм бол сэргээгдсэн сайн мэдээний талаарх гэрчлэлээ тэдэнтэй хуваалцахгүй байж чадна гэж үү? ...

Амьдралын туршлагуудаа эргэн санаж, залбирч мөн *Миний сайн мэдээг номло* гарын авлагын 13-р бүлгийг уншиж байхдаа хэрэгжүүлэх ёстой хэмээн мэдрэмж авсан ялалтад хүргэх хувийн тоглоомын дүрмийнхээ талаар та бүхэнтэй хуваалцахыг надад зөвшөөрнө үү? Би та бүхнийг

өөрсдийнхөө дүрмийг гаргахдаа гурван зүйлийг анхаарахад урьж байна.

Нэгд, өдөр бүр хэн нэгнийг Аврагч болон Түүний сайн мэдээнд авчрах талаар тодорхой залбир. Ингэхийн тулд бид хүн болгоныг бие биедээ гэртээ харихад нь туслахыг зорьж байгаа Бурханы хөвгүүд мөн охид шиг харж сурах хэрэгтэй. Ингэснээр хэчнээн олон, шинэ найз нөхөдтэй болж болохоо бодоод нэг үз.

Хоёрт, танайд үйлчилж байгаа номлогчид болон тэдний сонирхогчдын нэрийг нь хэлэн, залбирах хэрэгтэй. Үүнийг зөвхөн тэдэнтэй мэндэлж, нэрийн тэмдгийг нь уншиж, тэднийг нэрээр нь дуудаад зааж байгаа хүмүүсийнх нь талаар асууснаар л гүйцэтгэж болно. Ахлагч Рассэлл М.Нэлсон: “Хүний нэр, царайг нь мэдэхгүй бол Их Эзэн та нарт тэр хүний зүрх сэтгэлийг мэдэхэд тусалж чадахгүй” гэж тун мэргэн хэлсэн билээ.

Баптисм хүртэж байгаа нэгэн гайхалтай эгч гэрчлэлээ хуваалцах үед би тэнд байлаа. Түүний “Өмнө нь миний төлөө ийм олон хүн залбирч, би ийм их хайрыг мэдэрч байгаагүй! Энэ ажил үнэн гэдгийг би мэднэ!” гэж хэлснийг нь би үргэлж санах болно.

Гуравт, найзаа ямар нэг үйл ажиллагаанд урих явдал юм. Аль нэг газар очиж, ямар нэгэн зүйл хийхээр төлөвлөхдөө хамт явчихаж болох хүний талаар бодож, Сүнсээр Их Эзэний удирдамж танд ирэхийг сонс.

Сурах болон заах санаанууд

Аврагч Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэрээр хүмүүст өөрсдөд нь зориулсан судруудын талаар тунгаан бодож, асуултынхаа хариултыг судруудаас олохыг заасан. Тэрээр өөрсдийнх нь туршлагаар болон эргэн тойронд нь байгаа зүйлсийг жишээ болгон авч, сайн мэдээний хичээлийг ойлгоход нь хүмүүст тусалдаг байсан. Тэднийг бусдад зааж мөн гэрчилснээр Түүний сургаалын гэрч болохыг Тэрээр хүсдэг байв. Ингэснээр сургаалын талаарх тэдний ойлголт улам гүнзгий болдог байв.

Аврагч өөрийн үлгэр жишээгээр харуулсан зарчмуудыг дагахад нь туслах суралцах үйл ажиллагаануудыг бэлтгэх нь өсвөр үеийнхний багш таны үүргийн чухал хэсэг юм. Бошиглогчдын үгсийг судлан, сурсан зарчмуудынхаа жишээнүүдийг ойлгож, сайн мэдээг бусадтай хуваалцахад нь өсвөр үеийнхэнд туслах болно гэж өөрийн бодсон заах бусад санаануудыг эсвэл энэхүү хавсралт дахь санаануудыг ашиглаарай. Та эдгээр санаануудыг аль ч хичээлийн сэдэвт тохируулан өөрчилж болно.

Үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө өсвөр үеийнхнийг сурсан зүйлсээ бусадтай хуваалцахад урамшуулан дэмжих нь хамгийн чухал зорилгуудын тань нэг юм гэдгийг санаарай. Тэд сургаалын үнэнийг илэрхийлэх үед тэдгээр үнэн нь Ариун сүнсний хүчээр тэдний зүрх сэтгэл, оюун санаанд нь батлагдаж байдаг. Сайн мэдээг бусадтай хуваалцсанаар өсвөр үеийнхэн нэг нэгнээ хүчирхэгжүүлдэг. Үе тэнгийнхнээсээ сайн мэдээний үнэнийг сонсох нь зарим үед удирдагч, багш нараасаа сонсохоос илүү хүчтэй байдаг.

Сургаалыг танилцуулах үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд нь:

- Өмнөх хичээлээс сурсан **сургаалыг давтан судалж**, зөв ойлгосон эсэхээ батлахад тусална.
- Өсвөр үеийнхэн анги эсвэл чуулгын цуглаан дээрээ сурах **сургаалыг танилцуулна**.

Тэд эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, анги эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд танд ирэх болно гэдгийг санаарай.

Сургаалыг давтан судалж, зөв ойлгосон эсэхээ батлахад нь тэдэнд туслах

Санаж байгаа зүйлээ хуваалцах

Тэднээр өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан эсвэл санаж байгаа зүйлийг нь хуваалцуул.

Самбарт ямар нэгэн тайлбар бичих

Сурсан зүйлийнхээ талаар товч тайлбар самбар дээр бичихийг тэднээс хүс.

Сурсан зүйлээ зурах

Сурсан зүйлээ самбар дээр зурахыг тэднээс хүс.

Таныг юу гайхшируулсан бэ?

Хичээлийн юу нь тэднийг гайхшируулсан талаар хуваалцахыг хэдэн суралцагчаас хүс.

Нэг үг эсвэл өгүүлбэрээр товчлон дүгнэх

Сурсан зүйлсээ нэг үг эсвэл өгүүлбэрээр товчлон дүгнэхийг тэднээс хүс.

Зураг эсвэл бодит зүйлтэй харьцуулах

Зураг эсвэл ямар нэгэн зүйл харуулж, энэ нь өмнөх хичээлтэй хэрхэн холбогдож байгааг асуу.

Хэрэгжүүлсэн талаараа хуваалцах

Өнгөрсөн долоо хоногт заасан хичээлийг хэрэгжүүлэхийн тулд юу хийсэн тухайгаа хуваалц. Өсвөр үеийнхнээс хийсэн зүйлээ хуваалцахыг хүс.

Асуултууд асуух

Өнгөрсөн долоо хоногийн хичээлийн үеэр асууж байсан асуултуудад хариулахыг тэднээс хүс.

Судруудаас хуваалцах

Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс санаж байгаа судраа хуваалцахыг тэднээс хүс.

Мэддэг зүйлээ заах

Өсвөр үеийнхнийг ангийн эсвэл чуулгынхаа нэг гишүүнийг сонгож, өнгөрсөн долоо хоногт үзсэн хичээлээс санаж байгаа зүйлээ заахад урь.

Хэллэгийг тайлбарлах

Өнгөрсөн долоо хоногийн хичээлээс нэг хэллэгийг сонгон самбар дээр бичээд, тайлбарлахыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхэн ангидаа эсвэл чуулгын цуглаандаа үзэх сургаалыг танилцуулах

Судруудаас уг сургаалыг олох

Хичээлийн сургаалыг зааж байгаа шүлгийг судруудаас хайж олохыг тэднээс хүс.

Асуулт асуух

Сургаалын талаарх асуултад хариулахыг тэднээс хүс.

Дууллыг дуулах

Сургаалтай холбогдолтой дууллыг дуулахыг тэднээс хүс.

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултад хариулах

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултыг самбар дээр бичээд, уг асуултад хэрхэн хариулах талаар тунгаан бодохыг тэднээс хүс.

Дүр бүтээх

Хэн нэгэн тэднээс сургаалтай холбогдолтой асуулт асууж байгаа нөхцөл байдлыг жүжиглэн үзүүлэхийг тэднээс хүс. Тэд хэрхэн хариулах вэ?

Мэддэг зүйлээ тайлбарлах

Сургаалын талаар мэддэг зүйлсээ тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс.

Сургаалыг хэсгүүдэд хуваах

Сургаалыг хэдэн хэсэг болгон хувааж, хэсэг бүр ямар утгатай болохыг ангийн өөр гишүүдээр тайлбарлуул.

Зураг эсвэл бодит зүйлийг тайлбарлах

Энэ долоо хоногийн хичээлтэй холбогдолтой зураг эсвэл ямар нэгэн зүйлийг харуулж, тэдгээрийг тайлбарлахыг тэднээс хүс.

Зураг зурах

Ярилцах гэж байгаа сургаалын тань талаар өсвөр үеийнхэн ямар ойлголттой байгааг харуулах зураг зурахыг тэднээс хүс.

Судрууд олж хуваалцах

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултад хариулахад туслах судар олохыг тэднээс хүс.

Мэдэж байгаа зүйлээ дүгнэх

Уг сургаалын талаар тэд юу мэдэх болон ямар туршлагатай гэдгээ цөөн үгээр эсвэл хэллэгээр дүгнэн хэлэхийг тэднээс хүс.

Нэрээ бичих шаардлагагүй судалгаа

Уг сургаалын талаарх мэдрэмж болон туршлагынх нь талаар асуусан богино, нэрээ бичих шаардлагагүй судалгааг тэдэнд тарааж өг.

Шалгалт

Тэд уг сургаалын талаар юу мэдэж байгааг мэдэхийн тулд товч шалгалт ав.

Үгсийн жагсаалт гаргах

Ярилцах гэж буй сургаалтай холбоотой үгсийн талаар бодохыг тэднээс хүс. Тэдэнд аль үг эсвэл хэллэгийн талаар асуулт байна вэ?

Хамтдаа суралцахад зориулсан үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэнд тусалж болно:

- Судрууд болон бошиглогчдын үгсийг **судалж**, тэдгээрийн утгыг эргэцүүлэн бодох.
- Уг сургаалын талаарх тэдний бодол санаа болон мэдрэмжүүдийг бусадтай **хуваалцуулах**.
- Ярилцаж буй сургаалынхаа талаар **жишээнүүд үзэх**.

Өсвөр үеийнхэн эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, ангиараа эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд таны толгойд орж ирэх болно гэдгийг санаарай.

Судрууд болон бошиглогчдын үгсийг судалж, тэдгээрийн утгыг эргэцүүлэн бодох

Асуултуудын хариултыг олох

Сургаалын талаар тэдэнд байгаа эсвэл таны тавьсан асуултуудын хариултыг олохыг тэднээс хүс. Олсон хариултынх нь талаар ярилц.

Үгс болон хэллэгүүдийг олох

Сургаалыг ойлгоход нь туслах үгс, хэллэгүүд болон жишээнүүдийг олохыг өсвөр үеийнхнээс хүс.

Цөөн үгээр дүгнэлт хийх

Судар болон бошиглогчийн хэлсэн үгсийг цөөн үгээр дүгнэн хэлэхийг тэднээс хүс.

Жагсаалт гаргах

Өсвөр үеийнхнийг судар болон бошиглогчдын үгсээс суралцсан сургаалын тухай түлхүүр санаануудыг олж, жагсаан бичихийг хүс. Тэднийг олсон зүйлээ хуваалцахад урь.

Шүлгүүдийг тохируулах

Тэдэнд хэдэн судрын эшлэл, судар бүрийн зааж байгаа зүйлийг дүгнэсэн товч агуулгыг өг. Судруудыг уншаад, товч агуулгатай нь тохируулахыг хүс.

Зурагтай нь тохируулах

Зурагнуудыг судрын үйл явдалтай тохируулахыг өсвөр үеийнхнээс хүс. Үйл явдал болон зурагнуудаас олж авсан бодлоо хуваалцахад урь.

Хоосон зайг бөглөх

Самбар дээр судрын агуулгыг бичихдээ зарим үгсийг нь орхин бич. Тэрхүү агуулгыг гүйцээж бичихэд шаардлагатай үгс болон хэллэгүүдийг судраасаа хайж олохыг тэднээс хүс.

Жишээнүүдийг харьцуулах

Судраасаа хоёр болон түүнээс дээш түүх, үйл явдлыг уншин, тэдгээр нь сургаалын талаар юу зааж байгааг харьцуулахыг хүс.

Зураг зурах

Судрууд болон бошиглогчдын үгсээс сурсан зүйлсээ зурахыг өсвөр үеийнхнээс хүс.

Судар олох

Уг сургаалын талаар заадаг судрын үйл явдлыг олж, ямар утгатай болохыг тайлбарлахыг тэднээс хүс.

Холбогдолтой судруудыг холбох

Тухайн сургаалтай холбогдолтой судруудын жагсаалтыг гарган, тэдгээрийг уншиж, судар дээрээ тэмдэглэгээ хийхэд нь өсвөр үеийнхэнд тусал.

Дууллыг олж, дуулах

Сургаалтай холбогдолтой дууллыг олж, хамтдаа дуулахыг тэднээс хүс.

Зааж буй сургаал болон зарчмынхаа талаар жишээнүүд үзэх

Бусадтай ярилцах

Уг сургаалтай холбогдолтой туршлагынх нь талаар бусадтай ярилцахыг өсвөр үеийнхнээс хүс.

Судрууд дахь жишээнүүдийг харах

Судрууд дахь уг сургаалын дагуу амьдарч байсан хүмүүсийн тухай уншиж эсвэл сонсохыг тэднээс хүс.

Бусад хожмын үеийн гэгээнтний жишээнүүдийг харах

Тухайн сургаалын дагуу амьдардаг бусад хожмын үеийн гэгээнтний тухай уншиж эсвэл сонсохыг өсвөр үеийнхнээс хүс.

Жишээнүүд хуваалцах

Та эхлээд сургаалын дагуу амьдардаг хүмүүсийн талаарх өөрийн жишээг хуваалцсаны дараа тэднээс жишээ хуваалцахыг хүс.

Түүх ярилцах

(Судрууд болон бошиглогчдын үгсээс) уг сургаалыг түүхэн жишээнүүд хэрхэн нотолдог талаар тайлбарлахыг тэднээс хүс.

Оюун ухаандаа төсөөлөх

Сургаалын дагуу амьдардаг хэн нэгний талаар оюун ухаандаа төсөөлөн бодохыг тэднээс хүс.

Дүр бүтээх

Сургаалыг үзүүлсэн нөхцөл байдлуудыг төсөөлөн бодох юм уу дүр бүтээн үзүүлэхэд урь.

Мэдээллийн хэрэгсэл, дүрс бичлэг үзэх

Өсвөр үеийнхнийг сүмээс гаргасан мэдээллийн хэрэгсэл, дүрс бичлэгийг (DVD бичлэг, LDS.org сайт дахь видео бичлэг зэрэг) үзэхэд урь.

Мэргэжлийн хүний хэлсэн үгийг сонсох

Өсвөр үеийнхэнтэй ярилцаж, тэдний асуултад хариулахаар зөвшөөрөгдсөн зочдыг урьж оролцуул.

Зочны яриаг сонсох

Уг сургаалын дагуу ярилцах зөвшөөрөгдсөн үг хэлэх хүнийг урь.

Уг сургаалын талаарх тэдний бодол санаа болон мэдрэмжүүдийг бусадтай хуваалцуулах

Хэлэх үгээ бэлдэх

Уг сургаалын талаар үг хэлэхээр бэлдэхийг өсвөр үеийнхнээс хүс.

Хичээл заах

Ангийн эсвэл чуулгын нэг гишүүнийг хичээлийн хэсгээс заахад урь.

Өөр ангид заах

Сургаалын талаар богино хичээл бэлдэж, өөр ангид заахыг (бишоп зөвшөөрсөн тохиолдолд) өсвөр үеийнхнээс хүс.

Хэн нэгэнд заах

Өөр хэн нэгэнд сургаалыг хэрхэн зааж болох тухай санаануудыг бодож олоход нь өсвөр үеийнхэнд тусал.

Сургаалыг гэрчлэх

Сургаалын талаар гэрчлэлээ хуваалцахыг ангийн эсвэл чуулгын гишүүдээс хүс.

Сургаалын талаар бичих

Ангийн гишүүдийг юу сурсан болон сургаалын талаарх өөрсдийн бодол санаа, мэдрэмжээ хуваалцахад урь.

Утгыг нь тайлбарлах

Тэдний хувьд уг сургаал ямар утгатай болохыг өсвөр үеийнхнээс асуу.

Асуултуудын талаар ярилцах

Сургаалын утга учир, ач холбогдлын тухай асуултуудыг хэлэлцэхийг өсвөр үеийнхнээс хүс.

Асуултууд асуух

Сургаалын талаар бодож, үүнтэй холбогдолтой асуулт асуухыг тэднээс хүс. Хамтдаа тэдгээр асуултад хариул.

Зураг эсвэл бодит зүйлийг тайлбарлах

Зураг эсвэл бодит зүйл нь уг сургаалыг хэрхэн харуулж байгааг тайлбарлахыг тэднээс хүс.

Зураг зурах

Тус сургаалыг тайлбарлах зураг, диаграм зурах эсвэл ханын сонин гаргахыг тэднээс хүс.

Хувийн хөгжил дэвшил эсвэл Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номыг бөглөх үедээ олж авсан туршлагаа хуваалцах

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь болон Хувийн хөгжил дэвшил номтой ажиллаж байхдаа сурсан уг сургаалтай холбогдолтой ямар нэгэн зүйлээ хуваалцах эсвэл энэ талаар хичээл заахыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхнийг үйлдэхэд урих үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд сайн мэдээ амьдралд нь хэрхэн хэрэгжиж байдгийг харахад нь өсвөр үеийнхэнд тусална. Ерөнхийдөө, сурсан зүйлсээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрсдөө гаргахад нь тэднийг урамшуулах хэрэгтэй. Эдгээр үйл ажиллагаанууд тэдэнд энэхүү ойлголтыг өгөхөд тусална.

Өсвөр үеийнхэн эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, ангиараа эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд танд ирэх болно гэдгийг санаарай.

Сургаалын дагуу амьдрах төлөвлөгөө гаргах

Юу хийхээ тунгаан бодох

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийж чадах талаар тунгаан бодохыг өсвөр үеийнхнээс хүс.

Юу хийхээ бичих

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийхээ бичихийг тэднээс хүс.

Анги эсвэл чуулгын гишүүдтэй зөвлөлдөх

Сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар анги эсвэл чуулгаараа хамтдаа зөвлөлдөхөд тэднийг урь.

Мэдрэмж болон гэрчлэлээ хуваалцах

Сургаалын талаар мэдрэмж болон гэрчлэлээ хуваалцаж, энэ нь тэдний хувьд яагаад чухал болохыг тайлбарлахыг тэднээс хүс.

Заах тоймоо гаргах

Бусдад сургаалыг заах тойм гаргахыг тэднээс хүс.

Сургаалын чухал ач холбогдлын талаар ярилцах

Тэдний амьдралд сургаал ямар ач холбогдолтой талаар ярилцахад урь.

Гэрчлэлээ бичих

Сургаалын талаар гэрчлэлээ бичихийг тэднээс хүс.

Бусадтай ярилцах

Өсвөр үеийнхнийг бусадтай ярилцаж, сургаалын талаарх тэдний бодол санаа, туршлагын талаар олж мэдэхэд урь.

Жагсаалт гаргах

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлснээр ирсэн адислалуудаа жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс.

Сорилт бэрхшээл эсвэл асуудлыг даван туулах

Тэдэнд тохиолдсон сорилт бэрхшээл, асуудлуудыг хуваалцахад урь. Дараа нь тэдгээрийг даван туулахад сургаал болон судрууд хэрхэн тусалж болохыг хуваалц.

Хэрэгжүүлэх

Судрууд эсвэл бошиглогчдын үгсээс ямар нэгэн зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэхийг тэднээс хүс.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номон дахь үйл ажиллагаануудыг хийх

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номон дахь нэг үйл ажиллагааг хийхийг тэднээс хүс.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

